


Морь
унасан
толгойгүй
ХҮН



Майн Рид

Морь унасан толгойгүй хүн

Томас Майн Рид

The Headless Horseman

Thomas Mayne Reid

Оршил

Өндөр ургасан шимт ногоотой америкийн тал нутаг шөнийн анир чимээгүй дунд зүүрмэглэн байсан Техасын буга морин төвөргөөн соносоод дахийн цуочсон боловч ногоон хэвтрээ хаяж зугадах байтугай боссон ч үгүй. Сайхь уужам тал нь ганц түүнд оногдох бус, бас зэрлэг адуу шөнийн цагаар бэлчээрлэх нь бий. Буга зөвхөн гоо сайхан толгойгоо өргөс хийж% өндөр ногоон дээгүүр эврээ сэрийлгэн, чимээ дахин гарах нь уу гэж чагнана.

Морин төвөргөөн дахин сонсогдсон боловч өөр маягтай байжээ. ган болдоор чулуу дэлсэх төмрийн дуун шиг шинэ авиа ялгаран сонсдов.

Энэ авиа нь тайван хэвтсэн бугыг үргээжээ. Буга огло харайн босч, тал дундуур давхилаа. гэвч төдөлгүй зогсоод шөнийн нам тайван байдлыг хэн эвдчих вэ? гэсэн мэт эргэж харав. Буга өмнө зүгийн шөнийн тэнгэрийн сарны хурц гэрэлд, өөрийн нь аюулт дайсан, хүн байхыг таньжээ. Тэр хүн, морьтой айсуу явна.

Буна төрөлхийн зөнгөөрөө ухасхийн зугадахад бэлэн байсан боловч, морьтой хүний гайхмаар дзүрийг хараад зогссон газраасаа хөлдөлж ч чадсангүй. айн ширвээсэндээ, хойд хөл дээрэ бохирх нь холгүй суун тусч толгойгоо гэдийлгэн ширтэхэд том бор нүдэнд нь айсан, гайхсаан шинж илэрхий.

Ямар юмыг тэр буга тэгтлээ удаан ширтэхэд хүрэв?

Морийг уу? Үгүй тэр бол ердийн л нэг эмээл хазаартай морь байв. харваас аймаар, гайхмаар юм огт алга. Буга, тэр морийг унаж яваа хүнээс айсан баж магадгүй юэ? Тийм ээ, и тэр хүн д түүнийг айлган хирдхийлэгжээ. Дүрс нь нэг л хачин жигтэйхэн, нүдэнд нь эвгүй байлаа.

Тэнгэрийн аврал! Тэр морьтой хүний толгой нь алгаа! Адгуус амьтанд хүртэл нэг л жигтэй харагджээ. Өнөөг буга урьд өмнө үзэгдээгүй, тэр хачин амьтан юу болохыг мэдэжавах гэсэн шиг айсаан нүдээрээ хэсэгхэн зуур ширтсэнээ ухаан алдатлаа айн ухасхийн одлоо. тэгээд Леон голын усыг туулан, хүчит урсгал нь нөгөө морь унасан жигтэй хүнээс тусгаарлалал нэг я зогссонгүй давхив.

Морь унасан толгойгүй хүн бугыг айлгасныг ч хайхрах нь байтугай түүний байсныг нь анзаараагүй юм шиг явсаар ажээ.

Тэр хүнба л голын тийш явж байсан боловч огт яаралгүй аажим тайвнаа, бараг ёслолын байдалтай явж байлаа.

Бодолд дарагдан яваа юмуу даа гэмээр жолоогоо сул тавьсан учир морь нь замын хажуугийн өвс ногоог үе үе зулгаан гэлдрэнэ. Морь нь чоноос ургаж хамраа дуугарган, толгойгоо өргөн хухираад зоомол юм шиг чг зогсчиход, түүнийг явуулах гэж дуугарах нь үгүй, давирах я үгүй ажээ.

Тэр хүн ямар нэг гүн бодолд бэрнээ автаад, орчин тойрныг юмыг огт анзаарахгүй байгаа мэт тэр нууцаа ганц , үгээр тэр байтугай шивнэх төдий ч цухуйлгахгүй ажээ.

Зугтан одсон буга, чоно, морь, шөнийн тэргэл сар энэ хэд л түүний чимээ имээгүй бодлынх нь гэрч болно.

Нөмөрсөн серапэ нь салхины аясаар сөхөгдөж, биеийн нь хагасыг ил гаргана. Америкийн цоохор барын арьсаар хийсэн урт түрийтэй гутал өмсжээ. ийнхүү хаоуун орны аадар бороо, шөнийн чийг нойтноос хамгаалагдсан тэр хүн, дээр нь жирвэлзэн байгаа од мичид шиг чив чимээгүй, өвсөн дотуур үсэрч яваа жирхэрээ, хувцас хунары нь нугалаа хуниасаар сэрвэлзүүлэн багаа хээр талын салхи шиг санаа амар явж байв.

Тэгсэн чинь гэнэт ямар нэг юм тэр хүнийг санашралаас нь ангижруулах шиг болж, морь нь хурдлан алхадж толгой хаялан янцгааснаа хүзүүгээ сунган хамраа сартайлган хатирснаа аажмаар цогиж эхлэв. Ус ойртсон учир хурдаа нэмсэн юмсанжээ.

Морь голын тунгалаг усанд орохоос нааш зоссонгүй. Унаж яваа хүн нь хамт өвдгөө тултал усанд орчихов. Морь нь ховдоглон ууж, цангаагаа гаргаад, усны цаад талд хөвж гарч голын налуу эргийг дага явлаа. Морь унасан толгойгүй хүн эрэг дээр гараад морио шилгээн усаа сэгсэрхий нь хүлээв, манан дунд цахилгаан нүргэлэх мэт тоног дөрөө харшилдсанаа морь унсан толгойгүй хүн маанв дахин цааш явлаа.

Цнасан хүн нь давируулаар шавдуулан залж яваа юм шиг морь замаасаа дахин хазайсан ч уушгүй мэддэг зөргөөрөө явах мэт итгэлтэйгээр ургаш алхална.

Эргэн тойрон хязгааргүй тал нутаг цэлийж, зах хязгаар нь тэнгэрийн хаяатай нийлсэн мэт. Кентаврын гэлийсэн баримал лугаа адил жигтэй битүүлэг дүрс номин тэнгэрийн хаяанд тодпрон, сарны гэрлийн нууцлаг харанхуйн дунд холдон холдсоор далд орлоо.

I. Цурам болсон тал

Испанийн эртний хот Сан-Антониогоос урагшаа зуу орчим бээрийн тэртээ байдаг Техасын нүд алдам хөндийг үдийн нар хурц гэрлээрээ гийгүүлнэ. Ганц ч үүлгүй номин тэнгэр цэлийнэ.

Нарны алтан шаргал туяан дотор, зэрлэг талд зуршил болоогүй хэсэг юмсын бараа хэрэгдэх нь амьд амьтныг бараа үзэгдэхгүй газар хүн амьтны оромж байгааг гэрчилнэ. Тэртээ холоос харахад л ээ бол дээгүүр нь цав цагаан даавуугаар бүтээсэн, тал цагираг бүрхүүлтэй бүхээгт тэрэгнүүд гэдэг нь мэдэгдэж байв.

Тийм тэрэг дөнгөж аравхан байсан нь худалдаачдын жингийн цуваа буюу засгийн газрын хөсөг гэхэд нь дэндүү цөөхөн учир, ямар нэг нүүдэлчин, Леон голын эрэг дээрх шинэ суурингуудын нэг рүү очихоор явах замдаа тэр буудаллаад хөдөлсөн нь энэ ажээ.

Бүхээгт тэрэгнүүд аагим талын дундуур урт гэгч цувран маш удаан гэлдрэх тул тэдгээрийн хөдөлгөөн бараг үл ажиглагдана. Хооронд нь сүүтгэхэнл бараан дүрс нь морьд хөдөлжээ гэдгийг гэрчилнэ.

Зөвхөн үргэн зугадаж байгаа оронго, хашхиран нисч байга суусгалжин хоёр л хөсөг осолдолгүй хөдөлж байгааг гэрчилнэ. Амьтан шувуу хоёр тэдний онгон зэрлэгш эзэмшилд нь юу гээчийн хачин амьтан гараад ирэв хэмээн гайхан эргэлзэнэ.

Энэ жин үдийн цагаар, тал нутгийн хаана ч гэсэн нисч байгаа шувуу, давхиж яваа гөрөөс эс үзэгдэн, цөм сүүдэр газар хоргоджээ. Гагцхүү олз омог хөөцөлдөж яваа хүн л халуун орны тал хээрийн хуулийг зөрчин шатам халуун нарыг тоохгүй явж чадах билээ.

Хөсгийн эзэн ч бас жин үдийн нарыг үл тоон замаа хөөж яваа нь энэ ажээ

Тэдгээр шилдэг сайн бүхээгт тэрэг бүрт элдэв янзын идэж, уух юм, үнэтэй цэнэтэй тэр ч бүү хэл баян тансаг гэрийн тавилга, хар арьст шивэгчин хүүхнүүдийг хүүхдийнх нь хамт ачжээ. Эрэгтэйчүүд нь хөсгийн хажуугаар явган дагаж, зарим нь эцэж ядарсан шинжтэй хөсгийн хойноос уван цуван явна. Хөсгийн түрүүнд кентуксийн хангал луус хөлөглөж сүйх тэрэг явж байв. хөтчийн суудал дээр суусан зарцын хувцастай дэлбэгч негрхалууцан бухимдана.

Энэ бүхнээ үзэхэд хойд муж улсын нүүдэлчин яюуу хүн, шинэ гал голомт эрж бэдэрч яваа, биш харин өмнө зүгийн баян хүн аль хэдийн эдлэн газар болгож авсан нутаг руугаа нүүж явааг илэрхийлнэ.

Үнэндээ энэ бол тариалангийн эзэн Вудли Пойндшкстерын хөсөг бөгөөд тэргэр бүлийнхнийгээ авч Матагордын булангийн эрэг дээрх Индианолийг дайран их тал нутгийн туулж, шинэ эзэмшил газар руугаа явж байгаа ажээ

Эзэн өөрөө хөсгийн түрүүнд морьтой явна. Тавь орчим настай, өндөр нуруутай, туранхай биетэй, үл мэдэг цайвар шар царайтай, омог бардам, догшин ширүүн байдалтай хүн юм. Тэр ноосон даавуун хүрэм, хар торгон хандааз, дорно зүгийн даавуун өмд өмсөж, цирийн боловч

чанартай эдээр хувцаслажээ. Хантаазны нь задгай энгэрээр, зааманд нь хар тууз зангидсан нимгэн даавуу цамц цухуйж харагдана. Өргөн хүрээтэй сийрсэн малгай нүүр царайг ньөмнө зүгийн шатаам халуун нарнаас хамгаалжээ.

Хоёр морьтой хүн түүний баруун, зүүн талд зэрэгцэн явна. Тэр хоёрын нэг нь дөнгөж хорь хүрч яваа залуу, нөгөө нь түүнээс долоо ах ажээ.

Нэг дэх нь Пойндекстерийн хүү бөгөөд түүний хөгжилтэй талбиухан царайг, ялангуяа нөгөөх морьтой хүний уйтгартай төрх болон догшин ширүүн аавтай нь эрэгцүүлж харвал аргагүй нүд булаам ажээ.

Тэр залуу, хөвөн цаасан нэхмэл эдээр хийсэн тэнгэрийн номин өнгөтэй дэлбэгэр малгай өмсжээ. Хувцас нь залуугийн дүр байдалд зохисноор барахгүй өмнө зүгийн уур амьсгалын шаардлагад бас тохирчээ.

Гурав дахь хүн нь бол газрын эзний зээ, сайн дурын цэргийн албанаас чөлөөлөгдсөн офицер ажээ. Тэр хүн хар хөх цэмбээр хийсэн цэрэг маягийн өмд цамц, цэмбэн малгай өмссөн байлаа.

Тэндээс зайдуухан, хөсгийн хажууд бас нэг морьтой хүн явж байв. тэр хүн цагаан арьстан боловч хөрзгөрдүүрэ царайтай өгөөд царай зүс нь ширүүн, бусдаасаа өөр энгийн хувцас өмссөн ташуураараа сүрхий сурмаг ташуурдаж байгаагийн нь харвал газрын эзний боолуудын захирагч гэж шууд хэлж болох ажээ.

Чухам тэр нь гээд нэрлэчихэж боломгүй хоёр хүүхэн сүйх тэргэн дотор сууж явна. Тэдний нэг нь нүд гялбам цав цагаан, нөгөө нь бүр бараан аж. Цагаа хүүхэн нь Пойндекстерын ганц охин, нөгөөх нь шивэгчин хүүхэн нь юм.

Энэ нүүдэлчин Луизиан мужийн Миссисипи мөрний тэндээс гарчээ. Эзэн нь өмнө зүгийн энэ мужийнх биш бөгөөд нүүр царайг нь харваас креол' хүн биш нь мэдэгдэж байв. Хүүгийн царайд, ялангуяа сүйхний цонхны хөшигний цаанаас байн байн цухалзах охины нь сайхан царайгаар Атлантын далайг зуугаас доошгүй жилийн өмнө гаталсан франц цагаачдын удам гэдэг нь тодхон харагдана.

Вудли Пойндекстер бол өмнө зүгийн чихрийн тариалангийн томоохон эздийн нэг. Тэр их цамаан задгай амьдарч байсан бөгөөд энгүй зочломтгой нэрд гарчээ. тэгээд сүүл сүүлдээ хоосроод Луизиан дахь эдлэн газраа орхиж, гэр бүлд үлдсэн хэдэн хар арьстныхаа хам баруун хойд Техасын зэрлэг тал нутагт шилжин суухаар яваа нь энэ ажээ, Бараг жин үд боллоо. Нүүдэлчинд сүүдэр туссан зүг рүүгээ алгуурхан сажилна. Аагим халуунд ядарсан цагаан арьст хүмүүс морин дээрээ чимээгүй дүнхийнэ. Ган халуунд дассан негрүүд хүртэл эцэж цуцаад, есөн шидийн юм ам булаалдан ярилцахаа больж нэгш долр бөөгнөрцгөөн бүхээгт тэрэгнүүдийн хойноос үг дуугүй дагаж явав. Хүн оршуулж яваа юм шиг анир чимээгүй, хааяа нэг негр хөтчидийн чимээ өгөх, буу дуугарах мэт шилбүүрийн тас хийх чимээ нозоорон чимээ аниргүй байдлыг эвдэнэ. Хөсөг нь тэмтэрч байгаа юм шүиг аажуухан хөдлөнө. Үнэндээ жинхэнэ зам гэхээр юм алга байв. Урьд өмнө үүгээр явж өнгөрсөөн тэрэгний мөр, налж дагтаршсан ногоогоор л зам нь дөнгөж ялгарсан байлаа.

Хэвийгээр дөнгөн данган сажилж байгаа ч тэргэнд хөллсөнө луусууд тэнхээгээ үавхан зүтгэнэ. Зорьсон газартаа хүртэл хориод бээрийн зай байна гэж эзэн бодоод, шөнө болохоос өмнө хүрэхээр төлөвлөжээ. Тэгээд үдийн халууныг хайхаралгүй яваад байх тушаал өгсөн нь энэ ажээ.

Зуугаад метрийн өмнө явж байсан захирагч гэнэт саадтай тулгарсан мээ жолоогоо татан, бусаддаа дохио өгч хөсгөө зогсоого буцан давхилаа. Гараа занга., дохиж байгаагий нь харвал сандарч тэвдсэн бололтой.

Юу болох ньэнэ вэ?

Индианчууд дайралдсан юм биш байгаа? Тэднийг энэ хавиар үзэгдэх болсон тухай аймшигтай цуу үг олонтаа дуулддаг болжээ.

Юу болов, мистер Сансом? Гэж түүнийг ойртож иэхэп эзэн асуулаа.

-Цурам харагдаж байна. Талд түймэр гаргчээ гэхэд

-Түймэр гасран ий? Хаана? Утаа түймэр гарчээ гэхэд харагдахгүй байна шүү дээ хэмээн сэтгэл нь озвсон байдалтай сүүх рүү хяламхийнгээ асуув.

-Үгүй, эрхэм минь. Би зөвхөн талд түймэр гараад гэлийн арав шиг нэлэнхүйдээ харлачихаж гэж хэлэх гэсэн юм.. гэж хий дэмий үймүүлчихсэнээ ойлгосон захирагч яаран хэлэв.

-Энэ бол зовох юм биш! Бид ногоон тал дундуур явж байгаа шигээ хар тал дундуур санаа амар аялж болно гэж би бодож байна.

Пойндекстерын зээ нь ярианд оролцож:

-Джон Сансом, юун балай ярийа дэлгэж хүн амьтныг дэмий айлгаад байгаа юмбэ? ... Хөөя , хар солигнуудаа, олигтойхон хөдлөөд өг! Урагшаа! Гуядаад бай! Гуядаад бай! гэхэд

-Ахмад Клхаун минь, бид одоо замаа яаж олох билээ? гэж захирагч асуув.

-Зам эрж яах юм бэ? Балай юм! Бид замаа алдаагүй байгаа биз дэ?

-Замаа алдчихлаа гэж айж байна. тэрэгний мөр өвүстэй хамт шатчихаад огт үзэгдэхгүй байна.

-Тэгээд яагаа вэ? мөр хөөлгүйгээр шатсан газрыг туулж болохгүй юм шиг Ярих юм. Бид шатсан газкрын нөгөө талд гараад үамаа олно гэхэд зүүн мужийн хүн боловч талыг бөөруун хязгаарыг сайн мэддэг захирагч:

-Тиймээ, хэрэв нөгөө тал нь шатаагүй үлдсэн бол олдоно. Би шатаагүй газрыг морин дээрээсээ огт харагүй байна гэж хайхрамжгүйгээр хариулав.

-Гуядаад бай, негрүүдээ ! Гуядаад бай! гэж Колхаун яриаг таслан хашгираад, мориой давирч

ургагш сугаран хөдөлсөн нь тушаалг биелүүлэх ёстой гэдгийг харуулсан нэрэг байлаа.

Хөсөг хөдөлсөн боловч шатсан талын захад хүрээд гэнэт дахин зогсов.

Морьтон хүмүүс цаашид яах тухайгаа ярилцахаар хажуу тийшээ явцгаалаа. Өмнө нь ц элий цурам болсон хязгааргүй уудам талыг хараад байдал хүндэрснийг цөм ойлгою. Цурам болсон тал бараантан мэлийнэ. Тэнд нэг ч амьд ургамал, нэг ч ногоон өвс, навч үзэгдсэнгүй. Зуны цаш ногооны сөл гүйцсэн үед түймэр гарчээ. Энэ гунигт үзэгдэл гурван зүгт энгүй алс тэртээ хязгааргүй үргэлжилжээ. Хөх тэнгэрийн тодхон өнгө хүротэл бараан хар юм шиг, нар үүлэнд халхлагдахгүй бловч гэрэл гэгээ цацруулахыг хүсэхгүй, гунигт газар руу хөмсөг зангидан харж байгаа юм шиг санагдана.

Энд ямар нэг юмны ул мөр үлдсэнгүй, цөм өвс ногоотой цуг шатжээ гэж Сансомын хэлсэн үнэн байв.

-Одоо яацгаах билээ? гэж эзэн тэвдсэн дуугаар асуув.

-Яах билээ, Вудли ахаа? Яваад л байсан дээр дээ. Шатсан газрын тэртээ талд гол байх ёстой хэрэв байдлыг харгалзаж голоо өгсөж юмуу, эсвэл урудаж явна. Тэгвэл учир нь олдох биз.

-Тэгвэл Кассий минь, бид зүг чигээ бүрмөсөн алдаж магадгүй яа даа!

-Арайч дээ. Шатсан газар төдий л их биш байх гэж би бодож байна Бид замаасаа жаахан гажлаа ч гэсэн% гайгүй, тэртээ тэргүй эрт орой алин боловч голд хүрэхээс хойш.

-За тийм бол сайн, найз минь. Чи сайн мэдэх болохоор би чамд итгэж дагач.

-Ах минь, битгий зов, энүүнээс хэцүү юманд ч би орж явлаа... Урагшаа, харууд аа! Миний хойноос ! гэж хэлээд өнөөх халагсдан офицер ссүүх тэрэгний зүг ойртон маягтай харав. ҮЙмээн сандраанаас болж ялимгүй түгшсэн боловч сайхан булбарай царай хөшигний цаанаас харагдана. Холхаунморио давирч итгэлтэйгээр ургаш давхив.

Тэгээд тушуурын дуу зэрэг зэрэг тас нясхийх, наян луусыг туурайн чимээ, дугуйны эд бүгд холилдон нижигнэсэн дуу гарч хөсөг дахин замдаа оров.

Лууснууд хурдлан шогшлоо. Нүдэнд дасаагүй хар газар тэдгээр адгуусын айлгах мэт. Нурманд дөнгөж хөлөө хүргэнгүүт татан авч, залуу лууснууд нь айсандаа хуухирна.

Тэгээд аажимдаа хөгчүүлдээ харан харан номхорч жигдхэн алхах боллоо.

Жингийн цувуу энэ бээр орчим яваад бас зогсов. Газарчин үүргийг өөртөө авсан хүн сайх тушаалыг өгчээ. Жолоогоо татан зогсч буй түүний харахад нөгөөх биедээ эрэмших нь алга болжээ. Хаашаа явахаа мэдэхгүй мэгдсэн нь үзтэл илт.

Газрын байдал өөрчлөгдөж, тэгэхдээ муу тал руугаа өөрчлөгдөн хувирав. Цурам болсон тал нөгөө л хэвээрээ үргэлжилнэ. Харин тэгш тал газар маанв гүвгэр түвгэр болж уулсыбн сэрвэн, жижиг толгод тал хөндийтэй нийлэн үргэлжлэх болов. мод гэж нэрлэхийн төдий юм

харагдаж байсан учир, мод огт ургаж байгаагүй гэж хэлж болохгүй. Энэ газарт Мексикийн намхан хуйс ганц нэгээрээ буюу хэсэш бөөнөөрөө ургажээ. тэр моднуудын сэгсгэр навчис ор мөргүй алга болж, хуйхлагдсан иш, харласан мөчрүүд нь баргар хар хэлхээ яс мэт ёрдойно.

-Чи минь замаа алдчихав уу? гэж эзэн зээлгийнхээ дэргэд яаран лчиж асуулаа.

Үгүй ахаа, одоохондоо үгүй. Би эрэгцүүлэн харах гэж зогссон юм.

Доошоо, тэр хөнлий дунд л зам байх ёстой. Бид зөв явж байна. хөсөг явж л байг Хариуцлагы нь би хүлээнэ.

Дахиад л хөдөллөө. Уулын хажуу руу уруудан хөндий дундуур, явж дараа нь өөр нэг уулын хажуу өөд өгсөж, дээр нь гарааддахин зогслоо.

Кассий, чи ер нь замаа алдчихав аа даа? гэж эзэн бас зээгийнхээ дэргэд очиж дахин асуув.

Чөтгөр аваг! Тэгэв үү гэж айж байна. Ер нь энэ тамын орон дотроос ясмар шулам нь зам олж чаддаг болоо?... гэснээ Колхаун сүүх тэрэг ойртон ирэхийг хараад - Үгүй, үгүй! хэмээн сандарч байгаагаа мэдэгдэхгүйн тулд үгээ үргэлжлүүлэн - Одоо надад цөм тодорхой боллоо. Тэр зүгт л гол байх ёстой. Урагшаа! Гэж хэлэв.

Гэвч ахмад үнэндээ хаашаа явахаа мэдэхгүй байгаа нь илт морио давирч, түүний хойноос хөсөг дагаж хөдлөв. Колхауны сандарч тэвдсэн байдал, хөсгийнхний нүднээм далдуур өнгөрсөнгүй. Хөсөг нь шулуун үямаар ыиш шатсаан тал, товцог толгод, хуйхлагдсан бут сөөгний хооронд эргэлдэж байыгааг тэд мэджээ.

Гэхдээ удирдагчийн урамтай сайхан үг, тэдний сэтгэлд их итгэл төрүүлжээ. Кэрэг зэрэг өнгөрсөн ташуурын тас няс хийх, чимээ баярлан хөөрсөн хүмүүсийн хашгираантай хольцолдон сонсогдлоо.

Аянчид дахин зам дээр гарч ирэхэд тэдний өмнөхөн явсан баймаар морины туурай, тэрэгний дугайн цоо шинэ мөр цурам дээр үзэгдэв. Тэдний хөсгийн дайтай өөр ямар нэг хөсөгш тун саяхан нурам дундуур явж өнгөрсөн нь илт ажээ. Тэр цуваа тэдний адил Леон голыг чиглэн явсан нь зайлшгүй бөгөөд Инж цайз руу явж байгаа засгийн газрын хөсөг байж магадгүй байлаа. Тэгэхээр түүний мөрөөр явах хэрэгтэй. Цайыз бол яг тэдний явах замын дагуу байдаг бөгөөд зорьсон газар нь ч тэднээс холгүй ажээ

Үүнээс өөр өөдтэй юм олдохгүй байлаа. Колхауны сэтгэл дахин сэргэж, өөртөө эрдэн дур зоргоороо цааш ява тушаал өглөө.

Хөсөг өнөөх дайралдсан мөрөөр нэг бээр хэртэй, магадгүй илүү ч явчихаж бололтой. Тэгэхдээ чигээрээ биш, харин хуйхлагдсан бутнуудыг тойрон эргэлдэж байв. Кассий Колхауны ихэмсэг дүр урам хугарч гутарсан байдлаар алгуурхан солигдо. Тэдний дагаж яваа дугуйны мөр өөрсдийнх нь хөсгийн мөр гэдгийг Колхаун мэджээ.

II. Бугуйлын мөр

Вудли Пойндекстерийн хөсөг өөрийнхөө мөрөөр яваад байсан нь гарцаагүй болжээ.

-Манай мөр байна! гэж Колхаун, чи тэгээд юу гэх гэв? Бид тэгээд ... зүгээр л яваад байсан хэрэг үү?

-Өөрсдийнхөө мөрөөр л яваад байж. Тиймээ, тэгсэн байна. Бид тойроод л яваад байж. Миний морины тал тахтай хойд туурайны мөр байгааг хар л даа. Бас энд негрүүдийн мөр байна. Түүнээс гадна би явсаг газраа таньж байна. Сүүлийнхээ зогсолтын дара билний урудаж явсан өнөөх толгод энэ байна. тун золгүй хэрэг боллоо. Хий дэмий хоёр бээр орчим явчихлаа!

Энэ бүгдийн дээр бас хэтэрхий биедээ эрэмшин газарчин үүргийг өөртөө авсан зэрэг нь эзний зээг айхавтар ичээжээ. Сүүх тэрэг ойртон ирж, түүн дотроос гайхаж, зэмлэсэн янзтай сайхан нүд ширтэхэд ахмадын царай улам жигтэйхэн барайв.

Пойндекстер юм ч асуухаа больж, тэд замаасаа гарчихсан нь хүн бүхэнд илэрхий болжээ. хөл нүцгэн таврагчид нь хөлийнхөө мөрийг таньж нэг замаар хоёр дахин явж байгааг ойлгов.

Жингийн цуваа бас л зогсчихлоо Морь унасан цагаан арьст хүмүүс дуу шуу болцгоон сандран зөвлөлдөнө. Байдал хэцүү болжээ. Харанхуй болохоос өмнө зорьсон газартаа хүрнэ гэж бодож байсан эзний найдвар тасарлаа. Хамгийн гол гай нь ганц энэ биш байв. Өөр бас юу ч хүлээж байгаа юм билээ хэн мэдэх билээ? Шатсан тал тэр чигээрээ аюул. Тэд цурам болсон тал дунд хонох хрэг гарвал лууснуудаа услах ус ханаас ч олохгүй н мэдээж. Тэгээд бас ганц хоноод ч зогсохгүй юм билүү? хэн мэдэх вэ?

Ер нь тэгээд замаа яаж оох билээ? нар хэдий эрт боловч хэлбийж эхэлжээ. Мөдхөн нар орох зүгээр чигээ гаргаж болох байв. Тэгээд яах ч юм билээ? Баруун, зүүн% урд% хойд зүг хаана байгааг мэдэж авлаа ч гэсэн өөрсдөө аль зүг явахаа мэдэхгүй байгаа улс чинь яах ч вэ дээ?

Колхаун болгоомжилдог болж, удирдагч болохгэж тэймүүлдгээ бүр байчихлаа. Энэ ичмээр бүтэлгүй явдлын дараа зориг нь мохжээ. Арваад минут ярилцсан боловч нэг ч хүн олигтой санал гагасангүй. Хүн бүр цөхрөнгөө барж, тэнгэр нарыг бүү хэл, дотор нь гишгэсэнг хүний царай зүсийг хүртэл хар нурам бүрхэх нь энэ хар талаас яаж гарахыг хэн ч мэдэхгүй байлаа.

Тэртээ тэнгэрт олон нөмрөг тас нисэж яваа үзэгдэнэ. Тэд улам бүр ойртсоор, зарим нь газар бууж, зарим нь төөрсөн хүмүүсийн толгой дээгүүр эргэлдэв.Шувууны нисэх байдал цаанаа л нэг зэвүүн байв.

Бас дахуин гунигт арван минут өнгөрлөө. Гэтэл гэнэт сэтгэл сэргэх нэг шинэ явдал болж тэртээ алсаас нэгэн морьтой хүн гарчирээд шууд хөсөг рүү чиглэн айсуу харагдав.

Яасанн санамсаргүй тохиолдол аз завшаан бэ? ийм газар хүнтэй дайралдана гэж хэн санах билээ! Аянчид ойртон ирж яваа хүнийг хараад аюврагчаа гэж бодохоос нүдэнд нь итгэл найдврын гэрэл дахин туслаа.

Тэр хүн үнэхээр манайхн руу айсуй гэж үү? Гэж эзэн нүдэндээ итгэлгүй асуув.

-Нээрээ, ааваа, шууд наашаа айсуй гэж Генри хэлээд малгайгааг авч даллан тэрхүү үл таних хнийг дуудав.

Гэвч тэр хүн, тэртэй , тэргүй когсож байгаа чаа хөсгийг харжээ. Тэгээд шууд давхисаар хөсөгний хажуугаар өнгөрч, эзэн болоод түүнийг дагалдагчийн дэргэд очию.

Мексик хүн юм гэж Генри тэр танихгүй хүний хувцсыг хараад шивнэн хэлэв.

Тийм тусмаа л сайн. Замыг арван хуруу шигээ мэдэж байгаа гэж эцэг нь бас аяархан хариулав.

Өмссөн хувцаснаас нь өөр, мексик хүн гэхийн шинж огт алга. Би одоо мэдээд орхиё ... гэж хэлээд Колхаун - Buenos dias, cavallero! Esta Vuesta Mexicano? Гэж тэр танихгүй хүнтэй испани хэлээр мэндлэв.

Үгүй ээ гэж тэр хүн инээмсэглэн хэлээд- Би мексик хүн огт биш, хэрэв хүсвэл та бзхэнтэй испаниар ярьж чадна. Гэвч англиар яривал та нарт илүү ойлгомжтой байх болов уу? гэж санаж байна. Англи хэл бол танай төрлөх хэл байхаа? гэлээ.

Колхаун хэлсэн өгүүлбэртээ ямар нэг алдаа гаргачихна , эсвэл буруу дуудлаа гэж бодоод хариу үг хэлэхээ түдгэлзэв.

-Бид америк хүмүүс шүү! гэж Пойндекстер бардам хэлснээ өнөөх тусламж горьдож байсан хнийхээ дургүйг хүргэчих бий гэж айсан мэт- Бид цөм өмнөд муж улсын америкчууд л даа гэж нэмж хэлэв.

-Тийм болох нь хөсөг хөтлий чинь харваас амархан танигдаж байна гэж тэо хүн үл мэдэг дооглосон байртай инээмсэглэн , негр аргц нарын зүг харж хэлээд,

-Энэ зэрлэг тал дундуур анх удаа аялж байгаа тань ч мэдэгдэж байна. Та нар замаасаа төөрчихөө юу? гэж асуув.

-Тэглээ. хэрэв та сайн санааны үүднээс эс тусалбал, бидэнд замаа оох горьдлого алга.

Сайн санаасаад байр юу байх вэ! Би тал дундуур давхиж яваад санаандгүй та нарын мөрийг харлаа. Тэгээд төөрч гэж мэдээд туслах гэж давхин ирсэн минь энэ.

-Та их сахан сэтгэлтэй хүн юм. Бид таньд маш их баярлаж басйна. Тантай танилцъя. Би бол Лиузиан нутгийн Вудли Пойндекстер гэдэг хүн. Инж цайзын ойролцоох Леон голын эрэг дээр эдлэн газар худалдаж авсан юм. Бид тэр газартаа гэгээ тасрахаас өмнө хүрэх гэжбодсон юм. Амжих болов уу , ту юу гэж бодож байна?

-Миний хэлснээр л явбал амжиж хүрнэ дээ гэж хэлээд тэр үл таних хүн хажуу тийшээ жаахан хазайж, толгод өөд давхилаа.

Тэгээд аянчдын аль чигээо явбал зүйтэй ы болохыг олох гэж толгод дээрээс эржгэн тойрны

гакар оныг ажиглаж байгаа нь илт болов.

Тэр морьтой хүний дүр тэнгэрийн өнгөн дээр тод сайхан харагдаж байв.

Үүлдэр сайтай ганган хээр морь унажэ. Арабын эзэн хаанч гэсэн тийм морь унахаасаа ичихгүй бизээ! БӨргөн цээжтэй , сүмб шиг тэгшхэн хөлтэй уужим сахану хондлоотой, өтгөн сахан сүүлтэй сайхан морь ажээ, Унаж яваа хүн ь аятайхан царайтай, гоолиг биетэй, хорин тав орчим настай залуу эр байв. Тэр залуу хлэн хүрэм, хочр талаараа үдээстэй өмв, одсыг ширээр хийсэн гутал, алтан саагаар чимсэн гялгар бзрх малгай өмсөж, хятад эдээр хийсэн ув улаанбүс жавхайтал ороосон нь мексик маягийн өнгө тохирсон сайхан гоёл ажээ. Тэгээд энэ айхан эр маанв мексик дарчуудын хийсэн конквистадоруудын хэрэглэж байсантай ойролцоо хээ угалз гаргасан ширэн гөлөмтэй уужим эмээл дээр суусан байна гэж бодоод үз.

Аянчдын цөмийнх нь анхаарлыг өөрийн эрхгүй татсан мрөбтон маань ийм хүн байлаа.

Сүүх тэрэгний цонхныхөшигний уаанаас бас нэг хүний харц тэр морьтон хүн дээр тусжээ. Тэр харц маш өөр онцлог сэтгэгдлийг илэрхийлж байв. луиза Пойндекстер авхай үнэхээо хүсэжө мөрөөддөг сэтгэлдээ зохицсон хүнийг амьдралдаа анх удаагаа олж харжээ. Залуу кроел хүүхний сэтгэл тэгж доглолн байгааг тэр үл таних хүн мэдсэн бол сэтгэл нь ханах байлаа. Гэвч үүнийг яаж мэдэх билээ дээ? Тийм авхай байгааг ч зүүдэлсэнгүй. тоос шороонд дарагдсан сүүх тэрэгийг дөнгөж халт хараад өнгөрчээ. Дотор нь үнэт сувд байгаа анзаарахгүй өөдгүйхэн хясааг л ийнхзүз ихайхрамжгүй хардаг явдал олонт тохиолддог. Өнөөх хүн хөсгийг эзэн рүү эргэж:

-Би та нарт өөрсдөө шууд яваад зорьсон газартаа оччихоорбаримжаа болгочих юм зааж өгч чадахгүй нь ээ! Би уг нь замы нь мэднэ. Та нар Леон голд цайзаас таван бээр доогуур хүрэх болно. Харин би яг түүгээр гол гатлах учраас миний морины мөрөөр явж болно. за баяртай эрхмүүдээ! гэж хэллээ. танихгүй хүн ингэж нэгэнт салах ёс гүйцэтгээд морио гуядаж давхин одлоо.

Үл таних хүний тэр хачин жигтэй зан байдлыг хараад эзэн болоод түүнийг дагалдагчид ихэд гайхацгаажээ. гэтэл тэднийш үг ч дуугарч амжаагүй байтал буцаад ирэв. Яагаад буцаж ирэх болсны нь хэн чойлгосонгүй.

-Миний морины мөр та нарт олигтой тус болохгүй байх гэж би айж байна. Түймрийн дараа үүгээр мустанг явжөнгөрчээ. тэд олон мянган мөр үлдээсэн байна. гэвч миний морь тахтай , гэсэн ч тэр толно мөрний дотроос та нар шиг мөр ялгаж дадаагүй улс миний мөрийг олоход хэцүү болно. тэгээд бас хуурай үнсэн дээо морь бүхни мөр бараг адилхан байдаг юм гэв.

-Тэгвэл бид яах билээ? гэж эзэн цөхөрсөн дуугаарасуув.

-Эрхэм Пойндекстер , би та нарт газарчилахаар үлдэж чадахгүй их харамсаж байна. Би цайзад нэг чухал баримт бичиг яаралтай хүргэж өгөх ёстой. Хэрэв миний мөрийг алдчихвал нар баруунаас тусаж, сүүдэр чинь үргэлж зүүн талдаа буухаар, явж байгаа чиг сүүдэр хоёрынхоо хооронд арван таван градусын өнцөг барьж яваарай. Тэгж таван бээр хэртэй явтал чинь өндөр агарын орой харагдана. Яг тэр молдыг чиглэн яваарай. Тэр мод голын эрэг дээр

гарамнаас холгүй байгаа юм.

Залуу эр явахыгш завдаснаа нэг юм хараап мориныхоо жолоог тата.в тэр зал сүүх тэрэний хөшгийн цаанаас ширтэн байгаа гялалзсан хар нүдийг харчихжээ Анх олж харж байгаа нь л энэ. Хэдийгээр бие нь сүүх тэрэгний харанхуй бүхээг дотор далдлагдаж байгаа боловч залуу эр дээр тусаж байгаа хоёр нүд нь хүүхэн хний ер бишийн гоо сайхан царайг чимэглэж байгаа нь мэдээж. Түүнээс гадна хүүхний нүд өөр дээр нь тусч шохоорхон харж байгаагаар ч барахгүй, эелдэг зөөлөн шинж илэрхий.

Залуу , хүүхний өөдөөс баясангуй нүпээр харсан боловч эвгүй, байдал үзүүлчих вий гэж зовон өөрт нь халуун талархал илэрхийлсэн эзэн рүү мориныхоо амыг огцом эргүүлж:

-Би та нарын талархалг хүлээх юм хийгээгүй , хувь заяанд тань даатгаад орхих боллоо. Харамсаоцлтай нь бт даанч яараад байна гэж хэлэв.

Тэгээд ганцаараа явах болсондоо харамсаж багаа мэт цаг руугаа харлаа.

-Та их сайн санаатай хүн юм. таны зааснаар яваад л бавал замаа алдахгүй байх гэж би итгэж байна. нар бидэнд туслах байх гэж эзэг хэллээ.

-Тэнгэр аягүйтэх гэж байна. Хойд зүгүүл хцралдаж байна. Нэгц аг болоод тэнгэо бүрхэж ч мэднэ... Ямар ч гэсэн та нарыг агар модны бараа харагдах газар хүрэхээс чинь өмнгө тэнгэр бүрхэнэ... Би та нарыг ийм байдалтай орхиж чадахгүй нь ... гээд залуу хэсэш зуур бодолхийлэн..- Надад нэгш санаа төрлөө. та нар миний ыбугуйлын мөрийг дагаад яв! гэж хэллээ.

тэгээд эмээлийнхээ бүзүрэгнээс эвхээстэй бугуйлаа тайлж нэг үзүүрий нь газар хаяж, нөгөө үзүүрий нь ганзагнаасаа бэхлэн уяв. Тэгээд малгайгааг дэгжин нь аргагүй өргөж бараг сүүх тэрэгний зүг бөхөсхийн ёслоод, морио давирч зэрлэг талын дундуур давхин одлоо.

Морины хойноос чиргүүлсэн бугуйл та нутгийн цурман хөрсөн дээгүүр могойн мөр шиг курвас үлдээн мушгирна.

-Сонин хүү байна шүү. нэрий нь асудаг байж гэж эзэн, хар тоосон дунпуур тэр дорхиноо алга болж байгаа морьтон хүний хойноос харж хэлэв.

-Онгиороо, сагсуу эр л байна гэж үл таних хүнийг сүүх тэрэг рүү анхааран харахыг хажугаас нь харчихсан Колхаун хэлээд - тэрний нэрийг мэдэж яах гэсэн юм? тэртээ тэргүй санаанаасааа худлаа эр зохиогоод л хэлчихнэ. Тийм хээнцэр залуус Техаст зөндөө бий. тэд энэ газар уршиг тарьж байх гэж, адал явдал хайж , жинхэнэ нэрээ нууж явцгаадаг юм гэв.

-Кассий, чи худал хэлж бана. Тэр чинь боловсорл мэдлэгтэй, төлөв томоотой, ариун шудрага, нэр төртэй хүн шиг надад санагдаж байна гэж залуу Пойндекстер татгалзан хэлэв.

-Чи түүнийг сайн язгууртан хүн гэж бодож байна уу? За яах вэ, уучлаарай, мексик хувцас өмссөн өөдтэй хүн байхыг би ер үзээгүй юм даг. Залтхайамьтны нэг гэж мөрий нь тавихад

бэлэн байна. гэж Колхаун хэлэв.

Тэдний тийнхүү ярилцаж б айх куур үзэсгэлэн рггоо креол хүүхэн сүүх тэрэг дотроос, холдон байгаа морьтон хүнийг нүдээрээ үзэж байлаа.

Колхауны хорон үгийн учир нь энд байгаа юм биш биз?

Лу юу болов? гэж сүүхэнгдп тулж очингоо бараг шиюнэн асуугаад- Чи их яарч байгаа юм биш биз? тэр заваагүй эрийг гүйцэж очих юмсан шэж бодоогүй биз? Хожимдоогүй байна шүү. Би чамд мортио өгье гэю.

Түүний хэлсэн үг% дууны өнгөнд эюгүй нь хүрсэн залуу хүүхэн суудлынхаа түшлэгийг налаад, уурласнаа мэдэгдсэн ч үгүй, хариу маргалдсан ч үгүйы , харин дургүй бүр ч хорслонтойгоорилэрхийлэн тачигнатал инээв

-Тийм бий, Би чамайг хараад ямар нэг юм болж гэж босон юм. тэр золбоотой яаруу элчийг хараад сэтгэл чинь хөдөлсөн шиг байна. тэр хүн гоё сайхан хувцсаараа дуры чинь булаагаа юу? Гэвч тэр чинь тогосын өдөөр чимсэн хар хэрээ шэж мэд. Харин түүний тэр хиймэлд өд сөдийгхэсэш арсьтай нв хуутгаж, хуурамч царайгий нь илрүүлэх цаг нададп ирж л таарна _

-Кассий, чи яасан ичдэггүй хүн бэ? Юу ярьж байгаагаа бодооч!

-Харин чи өөрийнхөө ямаршуухан байгааг бодох ёстой доо. Чи ямар нэг зүсээ хувиргасан үл бүтэх амьтныг анхааралдаа авна гэдэг юу гэсэн хэрэг вэ! Тэр чинв, цайзынофицерын хөлсөлж авсан жирийн нэг зарлагша мөн гэдэгт би эргэлзэхгүй байна.

-Чи түүнийг зарлага гэж бодож байна уу? Тэгвэл би тийм зарлагын гараас дурлалн захидал авах юмсан гэж яасан их хүсч байна вэ!

-Тэгвэл энэ тухайгаа бушуухан очиж хэл, миний морь бэлэн байна.

-Ха-Ха-Ха! Чи мөн ч ухаангүй амьтан юмаа даа! Би тал нутгийн тэр шуудан хргэгчийг гүйцэж очих гэж үнэхээр бодлоо ч гэсэн чиний энэ хашин хэдрэгээр яваад бүтэхгүй байх л даа! тэр хүн чамайш мориноосоо бууж надад эмэл солихос чинв өмнө бараа турааүй алга болоо өгнө. Өө үгүй! Би түүний хойноос гүйцэж очихыг хичнээн хүсэвч над шиг нь гүйцэгддэг нь биш.

-Чиний энэ үгийг аав чинь л бүү дулаг!

-Чинийхийг л бүү дуулчихаасай билээ! гэж хүүхний үеэл ах мөн ч гэсэн, аав чамайг эрхэ дээд хүн гэж үздэг ч гэсэн, би чамайг өөрөөр үзнэ. Би үүнийг чамаас нуух ч үгүй, нууж ч байгаагүй, тийм биздээ?

Колхаун энэ үнэн санасанаа хэлсэн, хорон гашуун үгийг сонсоод хариуд нь зөвхөн хөмсөг зангидаю.

Кроел хүүхэн урьд нь түүнтэй ярилцаж эхэлсэн нь тоглоом толхуу хийсэн дуугаа эрс өөрчилж

ХЭЛСЭН НЬ:

Чи бол миний зөвхөн үеэл ах , ахмад Кассий Колхаунаас өөр юм байхгүй, харин миний зөвлөгч болох гэж битгий оролд. Би зөвхөн нэг л хүнтэй зөвлөн ярилцаж, түүний зэмлэлийг хүлээх үүрэгтэй гэж өөрийгөө үздэг, тэгэхээр намайг зүгээр байлгаж үзээч, гэж би гуйя, мастер Каш. Би сэтгэлдээ тохирсон хүнийг олохоос нааш хэнд ч өөрийнхөө үйл, явдалд , бодол санааг хэлэхгүй. Тэгэхдээ миний сонгож вах хүн нь ч чи биш юм шүү гэв.

Ингэж хэлээд сүүх тэрэгнийхээ түшлэгийг дахин налж, түүнтэй дахин ярихыг хүсэхгүй байгаагийн тэмдэг болгож сүүхнийхээ хөшгийг хаав.

Хөтчидийн хашгираан ахмдыг гайхаж гөлөрсөн байдлаас сэргээв. Колхауныг санаанаас арай ч харгүй бол уу гэмээр хар тал дундуур хөсөг хөтөл дахин хөдөлжээ.

Ш. Зам заагч сум

Аянчид замын тухай санаа зовохоо больжээ. Бугуйлын мөр могой явсан юм шиг тасралтгүй тахирлан зурайж, хүүхэд ч тэр мөрөөр явахад төөрөхөөргүй тодхон харагдаж байв.

Тэр мөр чигээрээ биш бутны хоорондуур сүлжин явжээ. Мод бут ч үгүй газраар хүртэл хааяа хажуу тийшээ гарсн байв. Энэ нь санамсаргүй тэгсэн хэрэг биш ажээ. Тийм газар нь гүн гүнзгий гуу жалга зэрэг бартаа дайралдаж байлаа. Бугуйлын мөр тэр бүхнийг тойрч гарсан нь аянчдыг бартаат замаар саадгүй явах боломжтой болгоно.

-Мөн ч хянуур залуу юм даа! Түүний нэрийг мэдэж аваагүйдээ үнэхээр их харамсаж байна. хэрэв тэр залуу цайз хавиар байдаг бол уулзалдах байгаа гэж Пойндекстер хэлэв.

-Эргэлзээгүй! Түүнтэй дахин уулзана гэдэгт би итгэж байна гэж Генри хэлэв.

Энэяриаг Луйза дуулжээ. Тэр хүүхэн юу ч хэлээгүй боловч Генрийн тэр горьдлогыг чин сэтгэлээсээ хуваалцаж байв.

Хэцүү бэрх аяллаа түргэн дуусгаж, наран жаргахаас өмнө шинэ эзэмшил газраа үзэх бололцоотой болсондоо баярласан эзэн сайхан зантай байлаа. Бардам баян маань гэнэт халамж үзүүлэн, зсахирагчтай аяндаа элдэв юм ярьж, цэврүүтсэн хөлөө арайхийн зөөн алхаж яваа Сцилион өвгөнтэй тоглоом тохуу хийлцаж, хүүхэд тэврэн зүдэрч яваа Хлоя авгайн дэргэд очиж сэтгэлийн нь засч явав.

"Гайхалтай! Ер нь эцсийн эцэст боолыг эздийн уламжлалт ёс заншил гэдэг сайхан эд! Тэгээд энэ маань бид боолчлолыг устгахын тулд ярьдгаа ярьж хийдгээ хийсний дараа шүү! Энэхүү эрт цагийн барилга байшинг нураана гэж оролдох нь энэрэлтэй хнүн болж овилготүйтэх илүүдээ гарсан өрөвч зан мөн. Боолчлолыг устгана хэмээн дон шүгэлсэн амьтдыг дээ! Яагаад боолчлолыг эсрэг босов оо? Зарим нь зовж зүдэрч, ажиллаж өлсөж , нөгөө үзарим нь тарган цоатгалан гараа эвхээд суух жамтайг та нар мэдэхгүй гэж үү дээ!" хэмээн чөтгөрт биеэ худалдсан эрээчигч нарын тэгтлээ сайрхан магтсан зүйлд төөрөлдсөн хөндлөнгийн хүн дуу алдаж болох л юм.

Сая сая хүнд зовлонг авчрагч иймэрхүү үг сүүлийн үед байнга дуулддаг боллоо. Үүнийг хэлж байгаа хүн, түүний нь сонсож байгаа үндэстэн хөөрхий еэ!

Эзнийхээ сайхан аашийг Колхаунаас бусад нь хуваалцаж явав. Пойндекстерыг өөрсдийнхөө жаргал зовлонгийн эх булаг, бараг бүхнийг чадагч бурхан хэмээн үздэг боолчуудын нүүрэн дээр энэ нь илхэн байлаа.

Вудли Пойндекстерыг бусад боол эзэмшигч нартай зүйрлүүлбэл хатуу ширүүн эзэн гэж хэлж болохгүй боловч негрүүд түүнд хайртай ч учиргүй их айдаг байв. тэр боолуудаа зодохдоо бахаа хангадаг хүн биш. харин гэдэс цатгалан, мөр бүтэн байгааг нь хараад бах нь ханадаг байлаа. Боолуудынх нь ямраар эзнийх нь чинээлгийг мэдэх юм чинь. Эзэн, боолуудаа хааяа

нэг сургаж ташуурдах боловч боолуудын биед шарх сорви огт байдаггүй байлаа. Миссип мужийн боол эзэмшигч болгон ч өөрийнхөө иймэрхүү гэж сайрхаж чадахгүй бизээ.

Эзэн , сайхан зантай байхаар хамт яваа хүмүүс ч бас сайхан зантай болж, хэцүү бэрх аяллаа удахгүй төгсгөж амрана гэ итгэцгээж байлаа. Эцэж ядарсан негрүүд нь хүртэлд эсэн бусыхн юм хөгжилдөн ярьж яваа нь гайхалтай бишээ!

Гэвч баяр хөөр нь тэгтлээ удсангүй. тэдний буруугаас ч биш, тэдэнд огтын хамаагүй зүйлээс болж баярласан сэтгэл нь гэнэт түгшүүртэй болов.

Агар мод харагдахаас өмнө тэнгэр бүрхэнэ байх гэж өнөөх танихгүй хүний хэлсэн нь үнэн байлаа.

Гэвч үүгд сэтгэл зовох хэрэггүй байлаа. Бугуйлын мөр түрүүчийнх шигээ тод сайхан үзэгдэж байгаа болохоор, тэнгэр бүрхэх ч гайгүй хэрэг байв. харин наран үүлийн цаагуур орсон нь хүмүсийн сэтгэл санаанд муу нөлөө үзүүлнэ.

-Наран шингэж шөнө болж байна гэж бодохоор болчихлоо гэж хэлээд, эзэн алтан цагаа гаргаж харснаа азаар тэртанихгүй хүн тусаллаа. хэрэв тэр хүн байгаагүй бол бид наран жаргатагч энэ цурам болсон тал дундуур төөрч тэнэх байлаа. тэгэд бүр энэ үнсэн дээр ч хоноглоход хүрэх байсан байх гэв.

-Хар хэвтэш дээр л хажуулах байж дээ! гэж Генри яриаг хөгжилтэй болгохын тул хэлээд- Хэрэв ийм хар газар дээр унтвал би мөнч аймаар зүүд зүүдлэх байх аа! гэв.

-Би ч гэсэн ... гээд эгч хүүхэн нь тэрэгний хөшигний цаанаас цухуйж орчин тойрныг хараад- Тамын орны Плутон, Прозерпина хоёрыг зүүдлэх байсан байх гэж хэлэв.

-Хи-Хи-Хи! Энэ хар талын дунд Лиу авхай намайг үзэж зүүдлэх нь бөайна. Мөн ч жигтэйхэн сонин зүүд байх нь ээ! Хи-Хи-Хи! Хэмээн Пойндекстерын Плутон гэж бүртгэлд тэмдэглэсэн негр хөтөч шүдээ яралзуулан инээв.

-Дэндүү эрт инээд ханиад болж байгаа юм биш үү гэж Колхаун дөхөж ирэнгээ хэлээд - харцгаа л даа, үнэндээ бид энэ зэрлэг хар талд хонохгүй гээд яах юм билээ. Өөр л муу юм нэрмэчихгй бол сайнсан гэж хэлэв.

-Чи юу гэх гээд байгаа юм бэ, Каш? Гэж Пойндекстер асуулаа.

Ах минь, тэр залуу, биднийг мэхэлчихсэн байх гэж бодогдоод байна. Би энэ хэлснээ дүүрэн баталж чавахгүй ч гэсэн хэрэг явдал муугаару эргэж магадгүй. Бид таван бээр гаруй, бараг зургаан б ээр явчихлаа. Өнөөх яриад байсан агар мод маань хаана байна? Миний хараа сайн, тэгээл алсыг хичнээн ширтэвья модны бараа огт харагдахгй байна.

-Тэр хүн яалаа гэж биднийг хуурах юм бэ?

-Юун “яагаад”! Биднийг хуурах олон янзын шалтгаан тэр хүнд байж болно.

-Тэр шалтгаануудыг нь нэгийг ч болов бидэнд хэлээд аль даа! Бидэнд сонин байна гэж сүүх тэргэн дотроос жингэнэсэн дуу гарав.

-Энэ хүү этгээдтэй холбогдсон бүх зүйлийг чи их л сонирхон сонсох байх гэдгийг би мэдэж байна гэж Колхаун тохуурахсан байдалтай хариулаад- Хэрэв би бодожбайгаага хэлчихвэл чи лав худлаа гэх байх гэв.

-Чиний юу гэж хэлэхээс л болно доо, мастер Кассий. Миний бодлоор бол чи л биднийг сорьж үзмээр юм даа. Цэрэгт явсан, жуулчилж сурсан чам шиг ийм туршлагатай хүнийг худаол хуурмагаар хүмүүсийг үймүүлэн сандаргана гэж бид хаанаас бодох вэ! дээ.

Колхаун тэр хүүхний хортойгоор дайрч ддоромжилж байгааг ойлгож, цааш нь тайлбарлан ярихаа болих гэсэн боловч эзэн түүнийг шаардсан убир тэгж адсангүй.

-Кассий, чи учрыг нь хэлээд аль. Чиний хэлсэн үг бидэнд сүрхий сэжиг төрүүлж байна. тэр танихгүй хүн бидэнд ямар санаатай буруу зам зааж өгсөн байх нь вэ? гэж эзэн шаардангуй асуув.

Ах минь, би чухам тийм санаатай гэж хэлж чадахгүй... Зөвхөн бодож байгаагаа л хэлж байна гэж Колхаун түрүүчийн бардам дуугаа өөрчлөн хэлэв.

-Чухам юу юм бэ дээ?

-Юу ч тохиолдож болно шүү дээ! Энэ зэрлэг тал дунд манайхан байтугай манайхаас ч хүчэй ачаа хөсөг рүү дайран, жинчдийг талж дээрэмдэх явдал цэвхэнгүй тохиолддог.

-Яасан аймшигтай юм бэ! гэж луиза айсан мэт царай гарган дуу алдав.

-Индианчууд довтлоно гэж үү? Гэж Пойндекстер асуув.

-Заавал индианчууд ч биш заримдаа цагаан арьстнууд ч индианчуудын адил хувцаслаад дээрэмддэг, ганц мексикчууд ч бас биш шүү. Индиан хүн болоход зөвхөн бараан будаг, адууны ёүүлээр хийсэнг хиймэл үс, малгайдаа хатгах хэдэн өд, ахиухан шиг жудаггүйтэх л хэрэгтэй. Тэгээд л гүйцэх нь тэр дээ. Хэрэв нэг бус удаа тохиолддгчлон “цагаан индианчуудын” бүлэг биднийг дээрэмдвэл огт танихгүй хүнд итгэж, гэнэ алдсан бөөрсдийгөө л зэмлэх хэрэгтэй болохоос өөр хэнийг ч зэмлэх хэрэггүй болно.

-Бурхан минь! Яасан айхтар зэмлэл билээ? Чи тэр танихгүй хүн, тэр зарлагыг биднийг занганд оруулах гэж байна гэж хэлэх гээ юу?

-Тэгж л байгаа юм ыиш л дээ ах минь. Гэвч тийм явдал тохиолддог гэдгийг би мэдэж байна. тэр хүн ч энэ талаар авьяастай байж мэднэ.

-Тийм ч байж болно. гэхдээ үнэмшихийн аргагүй юм гэж сүүх тэргэн дотроос шоолж ёжилсон хорон дуу гарав.

Үгүй дээ, Зкассий чиний сэжиглэдэг үндэсгүй юм. Энэбол гүтэглэг гэдгийг би нотлоод өгь?.

Чи наашаа хар гэж түрүүлэн явж байсан авч яриаг бүглийг чагнасан залуу Генри ярианд оролцов.

Тэгээд морио зогсоож бугуйлын мөрний тээр үзүүрт тодхон харагдаж байгаа ямар нэг юмыг заав. Тэр нь өнөдр угасан аршийн нудрага бөгөөд, түүний шүим шүүстэй ногоон иш нь галд бүтэн үлджээ.

Генри хамт яваа улсдаа тэр ургамлын биш, түүний нэгэн өргөсөнд хатгасан жижигхэн цагаан цаасы зааж үзүүлэв. Соёл иргэншилтэй нийгмийн заншлыг мэдэх хүн бол түүнийг нэрийг хуувас гэдгийг төвөггүй таньж болох байлаа.

-Тэрүүн дээр юу бичсэнийг үзэцгээе шээд залуу ойртож харснаа “Агар харагдаж байна” гэнэ гэж хэлэв.

-Хаана ? гэж Пойндекстерасуулаа.

-Энэ цаасан дээр хуруугаа гозойлгосон нэг гар зураастай байна. Энэ бол агар руу зааж байгаа нь мэдээж хэрэг гэж Генри хэдэхэд, цөм тэр заасан дээрх хурууны заасан чигт харцгаалаа.

Хэрэв нартай байсан бол хамагц л агар үзэгдэх байжээ. гэтэл цэнхэр огторгуй, хөх саарал өнгөтэй болчихсон байсан уир яаж лхичээгээд моднй орой гэмээр юм ялгарач харагдах аргагүй байлаа.

-Тэнд юу ч алга. Энэ бол тэр тэнэмэл амьтан биднийг дахин нэг ддоромжлох гэснээс өөр юм биш гэж бодож байна хэмээн Колхаун итгэлтэй дуугаар хэлэв.

-Кассий чи, энүүрч байна хэмээн цэргийн даргатай байнга зөрчилдөж байдаг нөгөө дуу гараа- Дурангааар хар. Чиний өнөөх сүрхий хараа чинь муудчихаагүй юм бол тэртээ алс тэнгэрийн хаяанд модорхуу нэг ттом юм байгааг хар л даа. Тэр лав агар мөн байх. Би Лиузианы намагт агар үзээгүй болохоор мэдэхгүй юм гэв.

луиза үнэн хэлж байгаа Колхаун мэдсэн учир үеэл дүүгийнхээ гараас дурангий нь авч хэрэггүй юм хийгээд яахав гэж бодов.

Тэгэхээр нь Пойндекстер дурангий нь авч хараа муутай нүдэндээ барьж зэрлэг тал дээрх өнчин ганц агарыг олж үзэв.

-Нээрэн агар харагдаж байна. тэр залуу шудрага сайн хүн байна. харин Колхаун чи түүнийг дэмий хилсдүүлжээ. Түүнийг биднээр тэгж хатуу тоглохгүй гээгт би итгэж байсан юм ... За явцгаая! Эрхэм Сансом, хөсөг хөдлөх тушаал өг гэж хэлэв.

Колхаун морио давирч зэрлэг тал дундур давхин одлоо. Түүнд хамт яваа хүмүүстэй ярьж, хамт үлдэх хүсэл б айсангүй.

-Алив, Генри, наад цаасаа напад аваал өгөөч, бдэнд тус болсон тэр сумы нь үзмээр байна.н Бид модоо олж авснаа мэдсэнээс хойш тэр цаасыг энэ аршийн дээр үлдээгээд яах вэ. Аваад яьбя гэж луиза шивнэн хэлэв.

Эгчийгий цаасег яагаад авах гэж байгаа юм бол гэж Генрибодсон ч үгүй, түүнийг аршийн нудраганаас салган авч луизагийн өвөр дээр шидэв.

-Морис Жеральд ! гэж креол хүүхэн цаасны ар дээр бичсэн нэрийг харж шивнэн хэлэд, өнөөх цаасаа өвөртөө хийж-Морис Жеральд! Гэж давтан хэлээд

-Чи хэн ч байлаа гэсэн, хаанаас ч ирсэн байлаа гэсэн, хаашаа ч явж байлаа ч гэсэн, юу ч хийдэг байлаа гэсэн өнөөдрөөс эхлээд бид хоёрын хувь заяа нэг. Би үүнийг мэдэж байна. Өөрийн толгой дээрх цэлмэг тэнгэрийг харж байгаа шиг тов тодхон мэдэж байна! Ямар аймаар тэнгэр вэ? Миний хувь заяа энэ тэнгэр шиг болчихгүй байгаа дээ? гэж сэтгэл догдлон шивнэв.

IV. Умрын хар салхи

луиза сайхан бодолдоо автан алмайранмууж байв. турьхан гараараа шанаагаа илэн базалж байх нь өнгөрсөн явдлыг тунгаан хэвийн явдлыг тааварлдан мэдэх гэж сэтгэл санааныхаа хамаг хүч чадлыг шавхаж байгаамэт ажээ. гэтэл ажуугийн нь хүмүүсийн дотор ямар нэг түшгүүртэй шинэ явдал үүсч луизагийн бодлыг төдхөн сарниулав.

-Аваа, хаана байна? гэж эцэг нь асуув.

-Тэнд, хөсөгнийхойно байна... Та одоо харж б байна уу?

-Нэг л юм харагдаж байна. Чухам юу болохы нь мэдэхгүй байна. тэр чинь... юутай ч төсөөтэй юм бэ дээ гэж хэлээд Пойндекстер сандран хэсэг зуур дуугүй байснаа- юу юм болохыг үнэндээ ыби мэдэхгүй байна гэв.

Хачин үзэгдлийг хараад бусадтайгаа нийлэхээс өөр замгүй болсон Колхаун

-Усан хуй юу даа? Бид далайгаас хол байгаа болохоор ийм байж боломгүй юм. тал газар үзэгддэш гэж дуулаагүй всм байна гэв.

-Мөн ч биш ч байлаа гэсэн хөдлөөд л байлаа. Хараач! Хоорондоо нэг ойртсоноо дахайд холдох юм. хэрэв ингэж хөдлөхгүй бол хар гантиган аврага том багана гэмээр юм гэж Генри хэлэв.

-Аврага амьтан ч бай, чөтгөрч бай, энэхүү аймаар талаар зугаалъя гэж босон үлгэрийн мангас юм гэж Колхаун инээн байж хэлэв.

Чөлөөнд гарсан ахмад өөрийгөө албадан байж тоглох аядсан нь энэ. Бусадтайгаа адилдхан, нэг л муу юм ёрлоод байлаа.

Ингэлээ гээд гайхах юм алга.

Гэнэт хойд зүгээс зэрлэг талын дээгүүр хэд хэдэн тас хар хуй бослоо. Тэр хуй тодорхой хэлбэр дүрсгүй бөгөөд хэмжээ, хэв маяг нь тасралтгүй өөрчлөгдөү нэг хэсэг ньтүр зуур тогтож, нөгөө хэсэг нь тэшүүрээр гулгаж байгаа аврага биет амьтан шиг цурам босон газар дээгүүр гулгаж, заримдаа бие бие рүүгээ хуйлран бөхийж гайхалтайгаар нийлэн уугулох нь ямар нэг аймшигтай бижиг хийх мэй. Техасын өргөн талд галзуу юм шиг догшноор бүжиглэж байсан гэгдэх домгийн аймшигт аврага амьтныг бодоод үз лдээ.

Тийм ер бусын гайхалтай үзэгдлийг анх удаа үзсэн хүмүүс маш их сандарч тэвдэх нь аргагүй юм. Бүгд л байгалийн ямар нэг гамшиг тохиолдох нь гэж мэджээ.

Тэр үзэгдлийн гарч ирэнгүүд хөсөг зогсчихлоо. Явган нүцгэн унаатай унаагүй цөм л айн дуу алдаж, морьд үргэн хулмалзаж, лууснууд хачин хачин орилолдов.

Гэтэлд боссон хуй шорооны тэндээс цсны хүрхрээ шиг ямар нэг нижигнэсэн чимээ сонсдож,

бууны дуу буюу алсад нижигнэсэн байгаа аянгын чимээ шиг үе үе тасалдан нүргэлэсэн дуу гарав.

Тэр чимээ шуугиан улам улам тод сонсдож, үл ойлгогдох аюул ойртсоныг айсуу.

Хүмүүс айснаасаа хөшсин юм шиг зогсцгоож, Колхаун ч бусдыг хэлэлтгүй тоглоом шоглоомообольжээ.

Бүгд л тэнгэрийг бүрхсэн бараан үүлс, өөрсдийг нь няц дарахаар ойртон иирж буй хуй салхийг ширтэнэ.

Энэ хүнд бэрх үед гэнэт ар талаас нь хүн хашгирах нь сонсдов. Энэ дуунд хэдийгээр сандарч тэвдсэн шинж илэрхий боловч аюулд хэлмэгдсэн тэдгээр хүмүүсийн сэтгэлийг сэргээжээ. Аянчид эргэж харахад нэгэн сортой хүн тэднийгчиглэн хар хурдаараа давхиж байв.

Хүн морь хоёр хэдийгээр хар хөө тоосонд дарагдсан боловч бугуйлынхаа мөрийг үлдээсэн өнөөх танихгүй хүн болохыг тэд танив.

Сүүх тэргэн дотор явсан залуу хүүхэн түүнийг хамгийн түрүүнд таньжээ.

-Яваад байгаарай! Аль болохоор түргэн явцгаа! Гэж тэр үл таних хүн хөсөг ойртож ирмэгцээ хашгиран хэлэв.

-Юу боло вэ? Бидэнд аюул учрах уу? гэж эзэн сэтгэл уймран асуулаа.

-Тиймээ, би та нарыг орхиод явахдаа ийм болно гэж огт мэдсэнгүй. харин голын тэнд очмогцоо аюулын шинж тэмдгийг олж харав.

-Эрхэмминь, энэ юу вэ?

-Умрын хар салхи

-Та шуургыг тэгж хэлж багаа юм уу?

-Тийм ээ.

-Умрын салхи хуурай газарт аюултай байдаг гэж би ер дуулаагүй юм. Харин тэр салхи мэл их хүйтэн байдгийг би мэднэ. Гэвч... гэж Колхауныг хэлтэл

-Эрхэм минь, зөвхөн хүйтнээр барахгүй. Хэрэв түүнээс хурданзугтахгүй юм бол бүр ч муу юм болж мэднэ... гэж морьтон хүн хэлээд -Ноён Пойндекстер минь, та болоод танайхан цөмөөрөө аюулд учраадб айна. Умрын салхи бүхэн аюултай байдаг ыбиш. Гэлээ ч энэ салхи ... Тийш ээ хар л даа. та тэр харанхуй хуй салхийг харж байна уу? гэж тэсэж яван эзэгд шаардсан байдалтай хэлэв.- Бид хараап хараап чухам юу болохы нь мэдэхгүй байна.

-Энэ бол хар салхи болохын өмнөх дохой, энэ ч огт аюулшүй дээшэ хараач. Та тэнгэрийг бүрхэж байгаа хар үүлийг харж байна уу? таны айх л юм чинт тэр дээ. Би таныг дэмий

айлгахыг хүсэхгүй. гэлээ ч гэсэн энэ үүл үхэл авчирна гэдгийг хэлэх ёстой. үүл наашаа ншшж байна. одоо түргэн хөдөлбөл л амь гарна. Түргэлэхгүй бол оройтоно шүү. Үл арван минутын дараа энд ирнэ. Тэгэхэд ч... эрхэм минь бушуухан явахыг гуйя! Хөтөлчиддөө аль ы болохоор түргэн яв гэж тушаагаач. Тэнгэр өөрөө таныг яаруулж байна!

Эзэн энэ шаргуу шаардлагад автаж, хөсгийг аль байдгаараа түргэн явахыг тэр даруй тушаалаа.

Мал адгуус нь хүмүүс шигээ айж тэвдсэн учир ташуурдуулалгүй яьж байв.

Сүүх тэрэг, морьтой хүмүүс түрүүчийнх шигээ хөсгийн манайд явах бөгөөп өнөөх танихгүй хүн тэр жин хөсгийг заналхийлж байгаа аюулаас сэргийлэн хамгаалж багйаа мэт сүүлд нь явж байлаа.

Тэр хүн байн байн мориныхоо амыг татан эргэж харах болгондоо улам их сандарсан байдалтай болж байгааг эзэн ажиглаад хажууд нь очиж:

-Аюул бас л өнгөрөөгүй байна уу? гэж асуулаа.

-Би даанч таны санааг амруулмаар юм хэлж огт чадахгүй байна. Салхи эргэнэ гэж бодсон юмсан.

-Салхи гэнээ? Надад үер нь ямар ч салхи мэдэгдэхгүй байна.

-Энп ч ийм лбайна. Харин тэнд бол аюултай догшин шуурга дэгдэж байна. Бурхан минь, тэр шуурга жигтэйхэн хурпан ойртож байна шүү! Бид цухам болсон зэрлэг талыг салхинаас өмнө гаталу амжина гэдэгт би их эргэлзэж байна.

-Бид яах билээ? гэж эзэн айж тэвдэн асуув.

-Та нар лууснуудаа үүнээс хурдан явуулж болохгүй юу?

-Үгүй ээ, хүч чадал нь бүр барагдчихаад байна.

-Тэгвэл бид хар салхинаас гарч амжихгүй гэж би айж байна.

Залуу дахин эргэж хараад, цооглон эрочилж байгаа хар хуй хурдыг хэмжиж байгаа мэт ажиглан зогсоход түүний царайд сандарсан байдал илэрхий.

-За, хожимдож дээ! гэж тэр дуу алдаад- хар шуурга биднээс хурдан, маш хурдан явж байна.. Түүнээс зайлан гарах найдлага алга хэмээн хэлсэнд.

-Ээ, бурхан минь , тэгээд гарах арга алга гэж үү дээ? гэж эзэн асуув.

Танихгүй хүн тэр даруй нь хариу хэлэлгүй хэсэг зуур дуугүй болж гүн бодолд дарагдав. Тэнгэр өөд байн байн харахаа болиод хөсөгш руу харна.

-Аюулаас зайлах арга алга гэж үү дээ? гэ эзэн гайхаш барагдсан пуугаар хашгирлаа.

-Үгүй ээ, арга байна! гээд морьтой хүн ямар нэгэ мэргэн санаа олов бололтой баясан хариулаад -Горьдлого байна. Би урьд энэ тухай бодсонгүй. Бид шуурганаас зайлж амжихгүй, харин аюулаас зайлж болно. Бушуулаарай ноён Пойндекстер гуай! Морьд луснуудынхаа толгойг бо гэж хүмүүст тушаал өгчээ! тэгэхгүй бол энэ адгууснууд чинв сохорч сүйд болно. хөнжил, алчуур юу лб айдгаараа боож болно. Тэгж боосон хойноо цөмөөрөө тэргэн дотроо орцгоо. Саравчнууды нь тал бүрээс нь сайн битүүлэх хэрэгтэй

Сүүхийг би аргална.

Танихгүй хүн ингэж хэлээд Пойндекстер захирагч хоёр хөтөч нартаа зохих тушаал өгч байх хооронд урагшаа хатируулав.

Тэр сүүх тэрэгний дэргэд очоод:

-Эрхэм хатагтай, та хөгшүүлдээ цөмийг буулгаарай. Хөтөч тань ч сүүх тэргэндээ орж сууг гэж тухайн байдалд тохирсон аль болох эелдгээр хэлээд Генри Колхаун хоёрт , мөн Пойндекстерт хандаж- Та нарч гэсэн сүүх тэргэнд орцгоо. Суудаол хүрэлцэнэ. Зөвхөн түргэлэхий гуйя Битгий цаг гарзад хэдхэн хором болоод биднийг шуурга дайрна гэж хэлэв.

-Эрхэм минь, та өөрөө яах вэ? гэж ойртон ирсэн аюулаас аврахын тул чадлаараа тусалж байгаа залуу эрд үнэнээсээ санаа зовсон эзэн асуусанд

-Нададсанаа зовох хэрэггүй. Би яахаа мэднэ. Анх тохиолдож байгаа юм биш. Бушуухан сүүхэнд ороорой, танаас гуйя. Хором ч алдаж болохгүй. Тоосон хуй ирэхээс өмнө тэргэнд орж үз гэв.

Эзэн хүүтэйгээ хамт мориноосоо буун харайж, сүүх тэргэнд орлоо. Колхаун мориноосоо буухыг татгалзаж эмээл дээрээ суусан чигээрээ байв. мексик хувцастай, танихгүй энэ хүн ямар нэгэн үл үзэгдэх аюулаас бие хамгаалах гэж торолдоогүй байхад би яалаа гэж тэр аюулын өмнө бууж өгөх билээ. гэж Колхаун боджээ.

Танихгүй хүн эргэж, захирагчийг ойрхонбайсан тэргэн дотор ор гэхэд нь цаадахи нь түүний хэлснийг үг дуугүй дагав. Одоо өөрийнхөө тухай бодож болно.

Залуу эр серапэгээ шалмагхан дэлгэж мориныхоо толгой дээгүүр нөмөргөөд хүзүүгээр нь зангидав. Тэгээд хүзүүний хятад торгон ороолтоо маш шалмаг тайлж аваад малгай дээгүүрээ бүтээж, нэг үзүүрий нь бүчинд нь хавчуулж, нөгөө үзүүрий нь унжуула. Түүний нүүрэндээ зориулж нэгэн халхавч барив.

Тэгээд нүүрээ битүүлэхээс өнө сүүх тэрэг рүү дахин эргэж хартал Колхаун мориноосоош буугаагүй байхыг хараад гайхаж, дотроо дургүй нь хүэн.

-Та сүүх тэргэнд бушуухан оохгүй бол амь үрэгдэнэ шүү гэж дахин хэлэв.

Шуурганы аюул ойртон байгаа нь үзтэл илэрхий болсон учир Колхаун энэудаа түүний үгэнд

орж, сандраагүй мэт дүр үзүүлж мориноосоо аажуухан буугаад, битүү хөшгөөр халхлагдсан сүүх тэргэнд иорою.

Цаашаа ву болсныг бичихэд үнэхээо хэцүү юм. Байгалийн тэр аймшигт үзэгдлийг нэг чхүн зориглон харлаа ч гэсэн юу ч олж үзэхгүй өнгөрх байсан биз. Лууснуудын толгойг боосноос хойш тавхан минутын дараа хөсгий ньхаранхуй шуурга нөмрөн авлаа.

Аянчид тэр догшин шуурганы зөвхөөн эхний нь харцгаажээ. Нэг хэсэг хуй хөсөгт тулж ирээд өтгөн хар тоосроор энгэр бүрхэж, дарин мөнөдт орж байгаа мэт шороогоор булав. Энэ нь зөвхөн эхлэлт байлаа.

Дараа нь асар том зуухныб амаар савсан байгаа халун хий шиг юмаар тургиад, сүүлд нь мөс шиг хүйтэн салх үелэн шуугив.

Шуурга сүнгэнэх нь хар шуурганы хааныг залрахыг мэдэгдэн эола байдаг чадлаараа үлээж байна уу гэлтэй сүртэй тачигнана. Агшин зуурын дараа хар хуй хөсгийг бүрхэн халуун орны талод байгаа аянчдыг Хойд мөсөн далайн мөсөн уулс баринтаглав уу гэлтэй хүйтрэв.

Салхины исгэрэн шуугих дуу, битүү нүргээ, хөсгийн саравчны нажигнах чимээнээс өөр юу ч дуулдахгүй , юу ч үзэгдэхгүй байлаа. Лууснууд зөнгөөрөө буруу харан чив чимээгүй зогсож, догшин шуурганы шуугиан дунд хүмүүсийн ширвээтэн эмээсэн дуу замхарч байв.

Онгорхой нүх сүв бүрийн битүүлжээ. хэрэв л даавуун аравчнаасаа жаахан л цухуйх юм бол амьсгаа боогдон багтрах байлаа.

Цуарм болсон зэрлэг талаас эрчилж шуугин босож байгаа салхины аясаар дэгдсэн үхэл тарих хумхийн хар тоос агаар битүү дүүрчээ.

Тэнгэрт бөөн бөөн хар нурам нэг цаг хиртэй хөвөлзөн, манай аяны нөхөд гадагшаа ч харж зүрхлэхгүй сууцгаав.

Эцэст нь сүүх тэрэгний хөшигний яг дэргэд өнөөх танихгүй хүний дуу гарав. Тэр хүн нүүрээ бүтээсэн торгон ороолтоо аваад

-Одпоо та нар гарч болно. шуурга бас намдаагүй байна. хоёр гурав хоног үргэлжилнэ. гэвч одоо та нарт айх юм огт байхгүй. Хамаг үнс нурам хийсээд явчихсан. Тэр нурмын шуурга Рио Грондын тийш явчихсан болохоор та нар түүнийг гүйцэж очихгүй байхаа гэж хэлэв.

Эзэн сүүх тэрэгнээс яаран гарч ирээд

-Эрхэм минь, бид танд өртэй боллоо ... гэлээ.

-...Амь биеэрээ шүү ! гэж Генри эцгийнхээ санааг гүйцээн хэлээд-Эрхэм та бидэнд нэрээ хэлж гийгүүлэхсэн болов уу.

-Морис Жеральд гэдэг. Гэвч Морис-Мустангер гэвэл цайзныхны намайш андахгүй дээ гэж өнөөх хүн хэлэв.

-Мустангер гэнээ! гэж колхаун зөвхөн луизад дуулдах төдий аярахнаар зөвүүрхэн бувгнав.

Эзэн Пойндекстер энэ үгийг сонсоод “зөвхөн мустангер юм шив дээ” гэж нэлээд урамгүйхэн бодож зогсов.

-Би одоо та нарт хэрэггүй. та нар надгүйгээр зөмөө олно гэж зэрлэг адууны ангууя хэлээд-Агар харагдаж байна, яг түүнийг чиглээд яваарай. Та нарыг гол гатлахад чинь цайзан дээо намирч байгаа далбаа харагдана. Харанхуй болохос өмнө зорьсон газраа хрч амжина. Би та нарыг орхиод явалгүй болохгүй нь гэв.

Хэрэв бид тамын хөлөг унасан аймшигт эрийг төсөөлье гэвэл, хөсгийн аянчдыг хоёр дахь удаагаа орхин явж байгаасайхь залууг л сайтар бодох хэрэгтэй.

Танихгүй залуугийн царай үнсэнд дарагдаж хачин болсон ч гэсэн жирийн хар бол ажил эрхэлдэг чгэлээ зэрлэг морины ангуучийн луиза Пойндекстерын сэтгэлд таалагсдан жавхааг нь бууруулсангүй.

луиза түүний нэрийг сонсоод, нэрийн хуувсы нь зүрхэнпээ нааж зөвхөн өөрөөсөө бусдад сонсогдохгүйгээр :

-Морил мустангер, чи креол охины, зүрхийг булаажээ! бурхан, тэнгэр минь!
Люцифертэй дэндүү адилхан юм, гэхдээ би түүнийг үзэн ядаж чадна гэж үү! Гэж шивэгнэв.

V. Зэрлэг адууны ангуучны овоохой

Сагалгар модны салаалсан мөчир мэт олон зуун гол горхиноос эх авсан Рио-Де-Нуэсес гол урсдаг хөндий үнэхээр байгалийн үзэсгэлэнт газар билээ. Энэ дов толгодптой зэрлэг талд, царс самарт модны төрөл арал мэт хэсэг хэсгээр голын эрэг даган ногоорно.

Эргийн дагуу өтгөн ногоон ой үргэлжилж, хааяа өргөст сондуул байх бөгөөд хуайстай хамт аршийн нударга, анхилуун өвс, аврага алтаргана, зэрлдэг агар, цагаан цэнхэр цэцэгтэй, сайхан үнэрт гарден мод ургажээ. Цогон цэцэгт гэдэг гоолиг сайхан ургамал улаан цэцгээ далбаа мэт дэлгэн бут сөөгийн дээгүүр эзгэрэхэн цухуйна.

Энд ургамал судлагч болоод зэлүүд нутгийг сонирхогч хүмүүст сонирхолтой юм их ажээ. Эндхийн сондуул, өргөст ургамал бүхэн хахир хатуу хөрсөн дээр ургадгийг Пойндекстер сайн мэддэг учир тэр газар нутгийг ер анзаарсангүй.

Гэвч самарт мод, хайлс, хэд хэлдэн янзын царс ургадаг ба хааяа нэг агар, улиангар ургасан янз бүрийн ургамалтай үржил шимтэй газар ч дайралдана. Эндхийн гол горхины ус нь тунгадарг цэлмэг тэнгэрийг тольдон байх агаад, нар ёсар, оддыг халхалчихаар үүл бараг гарахгүй нь гайхалтай. Энэ ариун газар өвчин гээчийг мэддэггүй, ямар ч халдварт өвчин энд нэвтэрч байсан түүхгүй ажээ.

Энэ буйд нутагт боловсролтой хүн хараахан нэвтэрч ирээгүй бөгөөд зоманч гэдэг индиан дайнч аймгийнхан л ойн ээдрээтэй зөргөөр тэнэж хааяа нэг Доод Нуэс, Леоны суурингууд руу морь унан уулгалана. Зэрлэг ан амьтан эндхийн зэлүүд газрыг сонгож авсанд гайхалтгүй.

Та нэр эндих шиг буга, согоо ирвэс олноотой газрыг Техасын ханаас ч олохгүй. Чандага цаг үргэлж өмнүүр чавхдахаас гадна хааяа зкаримдаа зэрлэг гахай, өмхий хүрэн, зурам үзэгдэнэ.

Бие хараа, өнгө зүс сайта, гоё сайхан шувуунууд байгал нутгийг баясгана. Суусгалжнууд далавчаа сэржигнүүлэн өнпөр хөөрч, нөмрөг тас агаарт элэн халин, зэрлэг цацагт хяруул самарт модны төглийн захад гялалзан цээжээ аль байдгаараа нь дэлгэж наранд ээж хэвтэнэ. Сагалгар хуайсны пунпуур нутгийн анчид диваажингийн шуву гэж нэрлэдэг, хайч шиг урт салаа сүүлтэй уран шувууд жирэлзэнэ гүйнэ. Гоё сайхан эрвээхэйнүүд далавчаа өргөн гэгч дэлгэж нэг үе агаарт дэрвэлзэн , нэг үе цэцгэн дээр бууж, түүнтэй өнгө зүсээ хослуулан амарч сууна. Өрвийсөнтөм том зөгий өөрсөдтэйгээ бараг эн тэнцэхээр биетэй эрээн далт хэмээх жижиг шувуухайнуудтай амтат шүүс булууацалдсаар цэцэглэж байгаа бут сөөг дундуур дүнгэнэ явна.

Гэвч энэ үзэсгэлэнт сайхан байгаль дотор хүний рхортон дайснууд нуугдаж байдгийг мартаж болохгүй. Эндэхийн шиг урт биетэй дуут могой элбэгтэй газар умарт Америкийн хаанач байхгүй. Хорт цагаан тэмээ, хилэнцэт хорхой, жаран хөлт зэрэг хортой аалзнууд хүмүүсийг алхам тутамд нь үхлээр заналхийлж байна.

Голын эргийн модон дундуур Мексикийн оцелот, Амеикийн пума гэдэг зэрлэг муурнууд болоод тэндхийн ягуар хэмээх цоохор бар тэнэж явна. Энэ нутаг бол цоохор бар ихтэй газрын

хойд хязгаар юм.

Ойн чөлөөгөөр Техасын хэрзгэр чоно ганц нэгээрээ чимээ аниргүй гэтэж яваа нь үзэгдэнэ. Харин түүнтэй угсаа нэгт койот хэмээх чоно бол нүцгэн талын дундуур сүрэг сүргээрээ хэрэн тэнүүчилж явна.

Энэ зэрлдэг талын соргог бэлчээрт адгуусан амьтны дотроос хамгийн гайхамшигтай сайхан амьтан бөгөөд дөрвөн хөлтний дотроос хүнд хамгийн сайн нөхөр болсон адуу бэлчинэ. Тэр бол хний арга мээнд автаагүй, толгойдоо хазаар, нуруундаагохом хүргэж үзээгүй онгон зэрлэг адгуус юм.

Гэлээ ч гэсэн энэ алс бөглүү нутагт тэр адгууснууд хүртэл эрх чөлөөнгөө алддаг байна. хүн түүнийг барьж, гаршуулдаг болжээ. Эндхийн нэг сайхан мустангийг зэрлэг адуу баригч Морис-Мустангер барьж сургажээ.

Рио-Нуэсес голыг цутгалангын нэгэн болох Аламо голын эрэг дээр техаст олон байдаг ердийн боловч үзэсгэлэнт сайхан орон оромжуудын нэг оршино.

Энэ бол аврага том цэгийрмааг цуулж босоогоор нь газар суулгаж барьсан овоохой юм. Дээврий эь мөн тэр модны гурвалжин навчсаар бүрхжээ. Шургаагнуудын хооронд Техасын ёс заншлаар шавардаагүй, харин овоохойн дотор талаас адууны ширээр бүрхжээ. тэр хүнд ширнүүдийг хадаасныб оронд мексикийн зуун наст модны бөргөсөөр тогтоосон байв.

Голыг хөвөөлсөн хөндийд овоохой барихад барилдгын материал болдог ургамлын зүйлээр элбэг дэлбэг ажээ. тэнд цэгийрмаа, зуун наст зэрэг үр жимстэй ургамал байх бөгөөд түүнээс доош сайхан ой модоор бүрхэгдсэн үржилтэй хөндийд ямал, самарт мод, царс ургажэ. олыг эргийн орчим мексикийн “грам” гэж нэрлэдэг шүүлсэг өвс, ургамалбүхий нуга, бэлчээрийн соргог өвсөөр бүрхмэл хөндий тохойгоор оржээ. Бидний дээр өгүүлсэн бүдүүн бааз оромж тэдгээр хөндийн нэгний гүнп яг голын эрэг дээр хөх ногоон дотор байв.

Модны сүүдэр овоохойг халхалжээ. Энэхүү далд газрыг зүгээр нэг сонгож авсангүй. Түүнийг зөвхөн голынг эрэг талаас яг өөдөөс нь хараад зогсвол үзэж болохбайлаа. Энгийн бааз байдал, зэвэр даасан өнгө нь түүнийг улам ч ажиглагдамгүй болгожээ.

Тэр овоохой, маркатантуудын майхнаас томүй бөгөөд жижигхэн голомтын яндан цухуйсан газрыг эс тоолбол ганц сүв нь үүд юм. Модон жаазбг адууны ширээр бүрж, адууны суран гогцоогоор дээш сөхдөг өвөрмөц, авсаархан хаалга хийжээ.

Овойхоон ард хажуугийн нь моднуудад сургааг барьж боогоод шивээлэн хийсэн жижигхэн хашаатай, цэгийрмаагийн навчаар бүтээсэн саравч байна.

Овоохой эрэг хосрын хоорондохи дөрвөн мянган дөчин долоон хавтгай дөрвөлжин метр газар торйуулан бас нэг тийм хашаа оромж барьжээ. газар нь тамтаггүй тахлагдсаныг харваас зэрлэг адуу мустангийгш хашихад зориулсан нь илэрхий.

Үнэхээр ч хашаан дотор аваад адуу байна. тэр адуунуудыг саяхан барисан бөгөөд эрх чөлөөгүй байх нь бэсхүйеэ бэрх байгаа нь үргэмтгий зэрлэг нүд, давдганасан омголон хөдөлгөөний нь харваас илэрхий.

Овоохойн дотоод байдал нь дутуу хөтүү ювмгүй тохилог сайхан ажээ. хар, хээр, алаг, цав цагаан зэрэг олон зүсний харваас юм мэддэг хүний гараар цуглуулсан адууны гялалзсан зөөлөн үстэй ширнүүд хивс лугаа адил тасалгааг чимэглэжээ.

Тавил хэрэгсэл нь ихэд энгийн ажээ. Адууны ширээр хулдсан бандан ор, мөн тийм маягаар овоохойн эзний хийсэн авсаархан ширээ, байдаг нь энэ ажээ. Буланд нь бас адууны ширээр, бүтээсэн нэг ор дэвсгэрхүү юм харагдана.

Тавиур дээрх ном, шудангийн цаас, өдөн үзэг, бэх ширээн дээрх сонин энэ бүхэн нь бүдүүн бааз байдалтай овоохой дотор яагххд ч юм нүдэнп дулаахан харагдана.

Энэ бас их соёлтой газрын байдлыг санагдуулаад зогсохгэй гэрийн эзний нарийн зуршлыг харуулсан хэдэн зүйл ширэн авда, хоёр амтай буу, цутгамал мөнгөн аяга, гөрөөчний жимбүүр, мөнгөн шүгэл байна.

Ихэнхий н нимгэн төмрөөр хийсэн гал тогооны хэрэсэлүүд шалан дээр байна. Буланд нь Аламогийн уснаас арай ч хүчтэй ундаа хийсэн бололтой лонхтой бургасан сагс байлаа.

Бусад юмс нь овоохойн дотоод байдалд аятайхан зохицжээ. Мексикийн өндөр бүүрэгтэй эмээл, адууны хялгас томж хийсэн хазаар, ногт хоёр гурван серапэ, хэд хэдэн цагариг олс байв.

Мустангерын оромж, түүний байдалнь ерөнхийдөө иймэрхүү.

Тасалгааны гол дахь сандлуудын нэг дээр сууж байгаа хүн яагаад ч мустангер байлтгүй нэгэн ажээ. гэрийн эзэнтэй адилтгах юм юу ч байсангүй : Угийн номхон зөөлөн царай зүсээр нь зарц нь болохыг мэдэггүй хэлж болно. гэхдээ хувцас хунар сайтай, өлсгөлөн ч юмуу зовж зүдэрсэн царайгүй ажээ. Өрийсөн хонгор үстэй, час улаан арайтай тарган хүн бай в. Хилэн өмд, хилэг түрүүтэй оймс өмсжээ. хэзээ нэг цагт хар ногоон өнгөтэй байгаад гандаж хүрэн шахуу болсон хилэн өнгийн хүрэм нь энгэртээ том хармаатай аж. Хүрээгий нь дээш эргүүлсэг бүрх малгай хэлтгий тавьсаан нь түүний өмссөн хувцсан дээр дэгжин зохижээ. Бас арзгар даавуу цамцныхаа захыг тойруулан улаан эрээн алчуур хааш яаш зангидаж, сайхан ирланд шаахай өмсжээ.

Гэвч зөвхөн өмссөн хилэн өмд, шаахай төдийгүй уруул, ам нүдп, хөмсөг, төрх байдал нь түүний ирланд хүн болохыг харуулна.

Хэрэв хэн нэгэн хүн эргэлзвэл түүнийг үг ярьж эхэлмэгц л мхамаг учир нь олдоно. Түүний ярьж байгаа шиг тийм этгээлд хэлээр зөвхөн Ирландын Гальвийн гүнлэгт л ярьдаг юм. Урцанд өөрөөс нь гаднахэн яч байхгүй болохоор өөрөө өөртэйгөө яриад байна уу даа гэж бодмоор. үнэндээ бол тийм бишээ. Нэгэн том нохой тулганы дахь адууны адсаган дээр нурманд хошуугаа шургуулаад гулдайн хэвтэж байлаа. тэр нохой өнөөх тарган хүнийхээ

хэлийг мэддэг юм шиг санагдана. Ямар ч байлаа гэсэн тэр эр нохойг ойлгох юм шиг түүнд хандан:

-Эрдэнэ болсон тара минь чи, Баллибалд буцаж очихыг хүсэж байна уу? Шилтгээнийхээ цэвэрхэн хавтан дээгүүр гүйж явах мөн сайхан аа! тэнд очвол чамайг гомдоохгүй хооллохсон доо. Чи хараач. хэрзийсэн хавирганууды чинь тоолчихож болмоор байна. Найз минь, би ч гэсэн тийшээ явмаар байна. гэвч залуу эзэн биднийг аваад хэзээбуцахыг хэн мэдэх вэ дээ!

Яах вэ, Тара? Хөгшин минь, эзэн удалгүй суурин руу явах ёстой. Бид хоёрыг аваад явна гэсэн. Тэгвэл ч санаа амрана даа. Чөтгөр аваг! Би файзад очоогүй гурван сар боллоо. Тэнд очвол саяхан хүрч исэн цэргүүд дотроос хуучин танилудынхаа хэн нэгэнтэй нь уулзаж магадгүй юм. Тэгээд уулзахдаа балга юмгүй байж яаж болох вэ! Тийм үү, Тара? Гэж сэтгэл хөдлөн ярьж байв.

Нэрээ дуулсан нохой нь толгойгоо өндийлгөөд, хариу болгон чанга гэгч тургиад авав.

Ирланд хүн лонх руу шуналтай харж яриагаа үргэлжлүүлэн

-Би одоо хоолойгоо нэг норгохоос буцахгүйсэн. Гэтэл лонх маанв бараг хоосон болчихсон: Залуу эзэн мэдчихэж магадгүй. За тэгээд хэлэхгүй уучихна гэдэг ч дэмий юм болно доо. Тийм ээ, Тара? гэв.

Нохой нь дахиад л хоншоороо шантайлган найтаалгав.

-Чи түрүүн “тийм” гэгчхээд одоо бас адилхан хэлдэг чинь юу болж байна?

Нохой шуухнаа хүрснээс ч юсмуу, хамарт нь үнс орсноос ч юмуу дахиад л тургив.

Дахиад “тийм” үү? Хэлгүй адгуусны хэлэх нь энэ үү. Золиг минь, бүү ятга! Би зөвхөн бөглөөгий нь онгойлгоод л үнэрлэе. Эзэн юу ч мэдэхгүй биз. мэдлээ ч гэсэн уурлахгүй, үнэрлэхэд муу нь юу байхав.

Ирланд хн босч буланд байга а лонхтой юм руу явлаа. Тэгээд хаалга руу эргэж, чимээ чагнан хэсэг зуур зогссоноо өнөөх хорхойгий нь хүргэж байгаа савыг авч бөглөөгий нь мултлан амсры нь хамартаа хүргэв.

Ингэж жаахан зогсоход анир чимээгүйн дунд нохой тургихаас өөр юм сонсогдохгүй агаад түүний нь ирланп эр тээнгэлзсэнийхээ хариу гэж үзэж, хатуу архины үнэрийг ханатлаа үнэрлэв.

Гэвч тэр сэтгэлий нь удаан хангаж чадсангүй. Аажмаар лонх нь өргөдсөн амсар нь мөн д ангайсан ам руу ойртов.

Дахиад үүд рүү сэм харснаа :

-Чөтгөр аваг! Энэ гайхамшигт сайхан ундаанаас хэн буцах юм бэ? хэн ч буахгүй! хэлнийхээ үзүүрийг норгочихье гэж арга барагдсан бадалтай хэлэв.

Лонхны амсар түүний уруулд хүрч, хэлээ норгох нь бүү хэл, хоолойгоо норгохоор шийдэв бололтой шингэн юмны хоржигнох нь сонсогдлоо.

Ирланд хүн сэтгэл таатайгаар хэд тамшаалсанаа , лонхоо бөглөж байранд нь тавиад сандал дээр сууж

-Ээ, зальтай зөнөг Тара! Чи л миний хорхойг хүргэчихлээ шүү дээ. За яах вэ. Эзэн мэдэхгү, тэр чинь дорхиноол цайзад очоод шинэнөөцтэй болгочихно гэж хэлээд хэсэг зуур чимээгүй суув.

Тэр хүн буруу хэрэг хийснээ бодсон уу , зүгээр л архиндаа халаад тэгээ юу гэдгийг хэн мэдэх билээ дээ?

Удалгүй дахин л ярьсан нь:

-Манай эзэн яагаад суурин руу явах гээд байгааг би еер нь ойлгохгүй юм. Бидэрт мустангийг баримагц түүшээ явна гэжхэлсэн тэр морь яагаад эгэзнвл тэгтлээ гэнэт хэрэгтэй болсон юм бол? гурван ч удаа ойртоод бугуйлаа толгойд нь оруулж чадсангүй. Өөрөө хээр морио унаж байсан гэж байгаа. Айхтар амьтан аа! Энэ ч амаргүй л хэрэг шиг санагдах юм. Санасандаа хүрэхээс нааш хөөцөлдөөд л байна дээ гэж эзэн хэлсэн. Бушуухан шиг л бариасай. Тэгэхий бол чи бид хоёр энд “Галав юулэв” сууж мэднэ. ... Чш! Хэн ирэв дээ?

Тара хуцан хаалга руу ухасхийн нь ирланд эр уулга алджээ.

-Фелим!Фелим! гэж гаднаас дуудах нь сонсогдов.

-Эзэн ирлээ гээд Фелим сандал дээрээс босч нохойн араас үүд рүү очлоо.

VI. Бидэрт мустанг

Фелим өөрийн эзэн Морис Жеральдындууг эндүүрэлгүй таньжээ.

Ирланд эр гадаа гараад, усан хулгана болтлоо хөлөрч, хар шахуу болсон хүзүү хавиргаар нь хөөс цахарсан хээр морьтой мустангерийг харлаа.

Хээр морь нь ганцаараа биш бөгөөд нэг нөхрөө, нөхрөөч гэж дээ олзлогдогчийг эмэлийг бүүрэгнээс янгинатал уясан бугуйлын үзүүрт чирч ирэв.

Тэр нь туйлын содон өнгө зүстэй мустанг байлаа. Зэлүүд талд бэлчээрлэж байдаг асар олон зэрлэг адуун сүрэгт ч гэсэн тийм зүстэй адуу ховорхон. Цагаан толботой, хар хүрэн зүсний тэр мустанг яг л цоохор бар шиг юм. Гоё сайхан өнгө зүс нь түүний бие хараанд үнэхээр нийцжээ. Өргөн ханхар цээжтэй, бөмбийсэн бөөрөнхий биетэй, цэх нарийн хөлтэй их сайхан , ёстой л сайхан адууны жишээ болмоор адгуус ажээ. Английн жмирийн адуунаас хамаагүй бага биетэй, өөрийг нь гүйцдэг хээрээсч арай бага боловч зэрлэг адуу дотроо л томд орохоор ажээ. Сайхан амьтан маань Аломын булгийн орчим бэлчээрлэдэг сүрэгт явдаг гүү байв.

Морис мустангер энэ сайхан амьтныг барих гэж гурван удаа салахгүй махран хөөцөлдөөд чадаагүй байжээ. Тэгээд дөрөв дэх удаагаа хөөцөлдөж байж, гүйлгээ цагирагтай урт бугуйлын хүчээр барьж авч, санасан санаандаа хүрчээ. Чухамхүү түүнийг ббарьж авах гэж улайран шимтсэн шалтгааныг зөвхөн мустангераас өөр хэн ч мэдэхгүй байлаа.

Фелим эзнийгээ тийм баясгалантай байхыг нэг ч удаа үзээгүй бөгөөд эзэн нь анд яваад заримдаа тав зургаан морь бариад ирэхдээ ч гэсэн тийм баясганлантай байдаггүй байжээ.

Фелим ч өөрцгүй , сайхь ьидэрт гүү шиг сайхан амьтныг барьж авчирсныг үзсэн удаагүй. Балллахын шилгээний хөтөч, морь сайн мэддэг тэр ч байтугай нь дурыг нь булаамаар сайхан амьтан байлаа.

-Ээ,ээ ура! Бурхан минь, манайи эзэн бидэрт мустанг бариад авч! Яасан сайхан амьтан бэ? Эзэн минт ийм амьтныг хойноос хөөцөлдөх нь аргагүй байж. Чөтгөр аваг! Энэ мустанг манай Баллинослойн яармагт байсан болоосой. Тэгвэл бид дуртай үнээрээ худалдана даа. Үгүй мөн ч сайхан амьтанаа!... Хааш нь аваачих билээ? Морины хашаанд бусадтай нь хамт тавих уу? гэж фелим малгайгааг дээш чулуудан хашгичаж байв.

-Үгүй тэнд аюултай, морьд тангарч өшиглөж мэднэ. Бид энэ мустангийн саравчин дор уяа. Кастро маань зочломтгой эзний ёсоор үүнд байраа өгөөд өөрөө гадаа хоног. Фелим чи ер нь ийм сайхан адуу үзсэн үү?

-Үгүй, Морис гуай минь, би энүүн шиг морийг ерөөсөө үзээгүй. Би Баллибаллахад олон ч омголон аду үзэж билээ. хазаад авмаар сайхан амьтан юм. та үүнийг ер нь унаж үзээгүй биз?

-Үгүй, би зав гарахгүй л үүнтэй ноцолдоно доо. Аятаыхан оролдох хэрэгтэй. Энэ сайхан өнгө зүсий нь гутаачихвал балрах нь тэр. Би сууринд очсон хойноо үүнийг сургаж эхэлнэ.

-Та тийшээ хэзээ явах эгж байгаа юм бэ?

-Маргааш явна. Бид оройдоо цайзанп хүрэхийн тул үүрээр явах хэрэгтэй.

-Яасан сайхан юм бэ? Би зөвхөн өөрийнхөө төлөө биш, бас Морис гуай таны төлөө баярлаж байна. Архиа дуусах шүахсаныг та мэдсэн болуу? Америкийн энэ зальт янкуудыг чөтгөр аваачиих нь яанаа. Тэд мэхлэхдээ сайн юм. Архинп дандпаа юм холиод байсан мөртлөө, бас дүүргэхгүй шүү. тэднээс авсан архи удаан тэсдэггүй нь гайхалтай биш.

-Фелим, архины тухай битгий зов. Өнөө оройдоо уугаад, маргааш дашмагтаа хийж авч явахад хүрэхээр юм үлдсэн гэж бодож байна. Найз минь битгий гунь! Одоо явж зоёноо янзалъяа. Тэгээд сүүлд нь чиний үхтлээ дурладаг тэр архий ёинь худалдаж авах тадаар ярилцамз.

Морис мустангер зөвхөн инээмсэглээд мориноосоо үсрэн буув.

Бидэрт гүүг саравчинд оруулж, Кастрог модноос уялаа. Фелим түүнийг зохих ёсоор нь цэвэрлэж эхлэв.

Өдрийнхөө явдалд эцэж ядарсан мустангер орон дээрээ хэвтээд өглөө. Тэр хүн энэ барьж ирсэн адууны хойноос хөөцөлдсөн шигээ тийм удаан авд явж нэг насаар үзээгүй байжээ. тэгж цөхрөлтгүй хөөцөлдсөний учрыг өөрөөс нь өөр хэн ч Фелим, итгэлт хүлэг Кастро нь ч энэ орчлон дээр мэдэхгүй ажээ.

Морис мориноос буулгүй хэд хоногоор явчихдаг байсан боловч бидэрт гүүний хойноос зогсоо зайыгүй хөөцөлдсөн сүүлийн гурав хоногт жигтэйхэн ядарсан мөртлөө унтаж ёадахгүй байн байн болсч, нэг юманд ихэд сэтгэл хөдөлсөн бололтой овоохой дотуураа хойшоо урагш холхино.

Хэд хоногийн турш нойр нь хүрэхгүй эргэж хөрөвхөд нь Фелимээр тогтохгүй Тара нэрт нохой нь хүртэл гайхахад хүрчээ.

Хэрэв эзнийх нь тэсч ядан догдолсон баыдал бидэрт гүүг олж харахаас өмөн эхэлснийг мэдээгүй байсансан бол зарц нь эзнийгээ бидэрт гүүг л барих гэсэндээ тэсч ядаад байгаа гэж бодохоор байлаа.

Цайзаас ирснээсээ хойш хэд хоногийн дараа бидэрт мустанг нүдэнд нь өртсөн болохоор энэ түүний зан байдал өөөрчлөгдсөний шалтгаан болж чадсангүй.

Олсон амжилт нь түүний сэтгэлийг амраахыбн оронд харин ч зовоож байх шиг. Ямар ч байсан Фелим ингэж бодоод нэг тогооноос хоол иддэгийнхээ хувьлд түүний сэтгэл тайвангүй байгаагийн шалтгааныр мэдье гэж:

-Морис гуай та яагаа вэ? Юу болоо вэ? Бурхныг бодож надад хэлж өгөөч гэ асуув.

-Зүгээр ээ, Фелим минь, яагаа чүгүй. Яи юунд надаас ингэж асууж байна вэ?

-Асуулгүй яах вэ? та суурингаас хамгийн сүүлд буцаж ирсэн өдрөөс эхлээд ганц хоёрхон цаг ч дуг хийсэнгүй шүү дээ. Ямар нэг юм таны нойрыг хулжаачихжээ. хэн нэг “мучаче” гэж энд нэрлэдэг мексик хүүхнийг мөрөөдөөд байгаа юм биш биз? Тэгэхдээ би үүнд огт итгэхгүй, Жеральдын удмынханд энэ таарахгүй.

-За,за Фелим чи дэмий чалчихааболь. Дандаа л ямар нэг юм санаанаасаа зохиох юм. Алийв би юм идмээр байна. Өглөөнөөс хойш юу ч идээгүй шүү. Цаана чинь идэх юм байна уу?

-Үнэндээ таныг авд явснаас хойш гурав хоноход хоол унд нэмэгдээгүй болохоор манайх идэх уух юмаар барагтайхан бана шүү дээ. бугын жаахан хүйтэн мах эрдэнэ шишийн талх хоёр л байна. таныг идэх юм болд би одоо мах халаая.

-За тэг, би хүлээж байя

-Та урьдаар нэг хундага юм балгачихвал дээргүйюу?

-Тэгсэн ч яахав

-Дангаар нь уу? Ус холих уу?

-Нэг хундага хатуухан юм ууя. Харин чи горхиноос цэвэр ус авах ирээч

Фелим тавиур дээрээс мөнгөн цом аваад явах гэтэл тара гэнэт чанга хуцаж, үүд рүү ухасхийв. Фелим нэлээд болгоомжтойгоор хаалга руу явлаа.

Нойхойны хуцах нь баяслантай гиналтаар солигдож, найз

нөхдийнхөө хэн нэгэнд нь бачр хүргэж байх шиг болж хувирав.

-Өвгөн Зеб Стумп байна гэж фелим хэлээд тайван гарав. Эхлээд зочны өмрыг эрээд, дараа нь эзнийхээ тушаалыг биелүүлэхээр явав.

Саяын ирдэг хүн бол энэ овойхоод байдаг улсаас шал өөр маягийн хүн бөгөөд зургаан тохойгоос доошгүй өндөр юм. тэр хүнматрын арьсан гутлынхаа уужим түрийд нэхмэл эдээр хийсэн өмднийхөө шуумгийг чихжээ. Өмд нь хэзээ нэг цагт шаргал өнгөтэй байгаад хиро буртагтаа дарагдаж уул өнгөө ал хэдийн алджээ. Нүцгэн бие дээгүүр буган сармай цамц өмсөж, гадуур н нутгийн индиан нарын нэхсэн бүдүүлэг эдээр хийсэн бөгөөд будаг нь бараг гарч гүйцсэн ногоон хүрэм өмсжээ. Сүрхий үнгэгдсэн саарал бүрх малгай нь түүний өмссөн муу хувсанд чимэг болж байна.

Зеб Стумпийн агнуурын хэрэглэл нь хойд Америкийн ойн анчдынхтай адил мөртлөө өөрийн энх өмссөн хувцсанд аятайхан нийцжээ. Үрлдэн сумтай цүнх, даринь том цэвэр шах хоёр баруун талын нь мөрөвчинд зүүлттэй байв. Хүрэм дээгүүр бүсэлсэн өргөн суран бүсэнд хавчуулаастай хутганы ширэн хуйнаас агнуурын булиа хутганы бугын эвэр иш цухуйна.

Техасын ихэнх анчдаас ялгаатай нь тэрээр хэзээ ч угалзтай бойтог, цацгаар хөвөөлсөн бугын арьсан урт хүрэм ч юмуу шилбэвч өмсдөггүй балдаа. юм бүхэн нь жирийн бөгөөд бүдүүн

бааз нь Зеб Стумпын гоёж гангалах нь илүү зүйл гэж бодддогийн тэмдэгжээ.

Урдаа б арих гану зэвсэг б болсон буу нь хротэл нэг урт төмрийн хрэн модонд хүчлихсэн юм шиг харагдана. Түүнийгээ тудаал зогсоход мөртэй нь чацуурмаар урт ажээ.

Анчин тавь орчим настай аж. Бараан царайтай,, ширүүн харцтай боловч сайн ажиглавал битүүхэн шог байрын хүн шиг санагдана. Онигор бор нүдэнд нь гялалзар сэргэлэн байдал нь хөгшин анчин шог юманд дуртай, өөрөөч тоглоом хийхээс буцдаггүй шинжтэй.

Фелим түүний нэрийг хэлсэнчлэн танилуудынхаа дунд “Хөгийн Зеб Стумп” хэмээн нэрлэгдсэн Зебулоан Стумп биеэр байгаа нь энэ ажээ. хаана төрсний нь асуухад “Унасан газар, угаасан ус маань Кентукк” гэж хариулна.

Тэр хүн Кентуккийн муж улсад төрж, тэнд өсөөд, доорд Миссипийн аглаг ойн дунд ан гөрөө хийж, залуу насаа өнгөрүүлжээ. Одоо өвгөрөх тийшээ хандсан боловч баруун хойд Техасийн ширэнгэнд ан ав хийсээр ажээ.

Тара үсчиж цовхчиж саймшрах нт Зеб Стумп эзэн хочр нь анд найз болохыг гэрилнэ.

-Бей амгалан байна уу? гэж Зеб том биеэрээ овоохойны үүдийг халхлан зогсож, мустангерын амрыг эрэв.

-Мэндээ амар сайн уу Стумп гуйа? Орж суу л даа гэж гэрийн эзэн зочны өөдөөс босч хэлэв.

Анчин Стумп төдий ч гуйлгалгүй, овойхоон босго алхаж ороод Фелимийн сууж асан тогтворгүй сандал дээр эвгүйрэхэн суув. Суудал нь намхан учир Стумпийн эрүү өвдөг хоёр нийлчихлээ шахаж, буунынь ам толгойноос нь дээш жад шиг хэдэн тохой ёрдойж байв.

-Яасан өөдгүй сандал вэ? Энүүнд орохноо модны тайрдас дээр. Ядахнаа суусан хойно эвдэрчих вйи гэж зовохгүй хэмээн үглэж байхы нь харвал суудал нь эвгүйдээд тааламж муутай байгаа боллолтой.

-Дээр суугаад үз л дээ. Бөх эд шүү гээд гэрийн эзэн тасалгааны булан дахь ширэн авдаро руу заав.

-Өвгөн Зеб түүний шүгнээс гажилгүй авдар дээр шилжиж суулаа.

-Стумп гуай, бас л явган явж байна уу?

-Үгүй, муу хөгшнийхөө модноос уячихаад орж ирлээ. Би анд явж байгаа юм биш.

-Та ер нь анд унаатай явдаггүй шиг байх юм.

Тийм үү?

-Би чинь морь унаж анд явдаг тийм тэнэг хүн биш.

-Техасын цөмөөрөө морьтой явдаг шүү дээ.

-Цөмөөрөө ч байна уу, биш ч байна уу, мориор анд явна гэдэг чинь тэнэг залруу амьтны зан байгаа вч. Би хоёр зээрдээрээ нэг өдөр явахад морь унаж бүтэн долоо хоног явснаа илүү олоншувуу бууддаш. Мустанг барьдаг та нарт бол ч морь заавал хэрэгтэй л дээ. Гэвч та буга юмуу, баавгай, зэрлэг цацагт хяруул агнахдаа морь унаж явбал тэднийг үргээхээс өөр юм олохгүй. Би ч олдсон олзоо ачих л гэж муу хөгшин гүүгээ хөтөлж явдаг юм.

-Үгүй та гүүгээ гадаа орхилоо гэв үү! Фелим түүнийг саравчинв оруулдаг. Та манайд хоноод явна биз дээ?

-Үнэнээ хэлэхд тийи л санаатай ирлээ. миний унааны туха битгий сэтгэл зов. Түүнийг янгинатал уячихсан. Аяар сул тавимц

-Та юм идмээр байна уу? Фелим хоол хийж байна. Танд бугын махнаас өөр юм тавьж чадахгүй маань тоогүйеэ.

-Тарган бугын махнаас сайхан юу байа вэ! Ямар баавгайн мах биш. харин халуун цог дээр сайтар шарах хэрэгтэй. Алийв гал тогооны тань ажилд тусалъя. Фелимээ ажилд чинь саад болохгүй бол миний гүү рүү очоод ганзаганд байгаа цацагь хяруулыг аваад ирээч, би замдаа буудсан юм.

-Юун сайн вч бэ! Бид хоолоо бараг дуусчих шахсан. Би сүүлийн гурав хоногийн турш нэг сайхан мустангтай хөөцөлдөж яваад ирлээ. тэгэхдээ буу авч яваагүй юм. Фелим, тара бид гурав энэ хэд хоног золтой л өлбөрчихсөнгүй гшэ мустангер баярлан хэлэв.

-Юун мустангтай хөөцөлдөө вэ? гэж тэр анчин сүүлчийн нь үгийг анзаараагүй юм шиг дур үзүүлж шохоорхон асуув.

-Цоохор толботой хүрэгч гүү, сайхан амьтан шүү!

-Чөтгөр аваг? Тэгвэл ч миний энд ирсэн хэрэг бүтэх нь тэр

-Нээрээ юу? Яагаад тэр вэ!

-Би тэр мустангий чинь үзсэн юм. гүү гэж та хэлээ биз дээ. тэр чинь намайг хагас бээрч ойртуулдаггүй байсан болохоор гүү байсны нь мэдсэнгүй. талд явахы нь хэд хэдэ удаа хараад би таныг тэр мустангийг бариасай билээгэж бодож байваа. Яагаад тэгснээ хэлж өгье. тантай хамгийн сүүлд уулзасныхаа дараа би Леонд байж байлаа. тэнд нэг хүн очлоо. Би тэр хүнийг Миссипт байхы нь сайн танина. Тэр бол их хөлтэй хөдөлдөг, ялангуяа өгөөмөр сайхан найр наадам хийдгээрээ алдаршсан баян газрын эзэн. Би тэдний найрын ширээнд буга, хяруулыг олонч мах тавьсан дээ. нэрий нь Пойндекстер гэдэг юм.

-Пойндекстер гэнээ.

-Энэ нэрийг Орлеанаас аваад Сенлуис хүртэл Миссиппийн эрэг д даяар андахгүй. тэгэхэд их баян хүн байсан. Одоо чгэсэн элбэг зуун негр авч яваагий нь бодвол ядуу ч үгүй байх гэж

санаж байна. Бас Колхаун гэж садангийн нь нэг хүн тэдэнтэй цуг ирсэн байна. тэр нь мөнгөн ихтэй. Тэгээд мөнгөнөөсөө ахдаа л зээлүүлэхэс өөр яадаг ч үгүй. тэгэхдээ бас цаанаа бодолтой хөдөлж байга даг аа. найз минь би юунд чамтай уулзах гэж ирснээ одоо хэлж өгъ?. Газрын эзний хайртай ганц охин нь моринд их хорхойтой юм. тэр охин Лиузианд байхдаа аль л олсон догшин ёорийг унаж байсан юм. намайг өвгөнд бидэрт мустангийн тухай ярьж байхыг дуулчихжээ. Тэрнээс хойш аавыгаа амар заяа үзүүлэхэгүй шалсаар б айгаад тэр мустангийг барьсан хүнд мөнгө хайрлахгүй шан өгнө гэж ам алджээ. Газрын эзэн, бидэрт мустангийг барьсан хүн хоёр зуун доллар өгнө гэсэн. Үүнийг

эндхийн хамаг мустангео дуулчихаад тэр бидэрт мустангийн хойноос хөөцөлдөнө гэж мэдээд нэг ч хүнд хэлэлгүй муу хөгшин гүүгээ унаж, санд мэнд хүрч ирлээ. Бидэрт морийг барьчихвал хоёр зуун доллар хармаанд чинь орно. Зеб Стумп гуай, хоёулаа гарья! Гэж ирланд залуу хэлээд босч үүд рүү явав.

Санамсаргүй байтал тэгж уриалсандаа нэлээд гайхсан Стумп босч хойноос нь гарлаа.

Морис зочноо дагуулж, бидэрт мустанг уяатай байгаа саравчинд ороод:

-Стмуп гуай, энэ гүү таны ярьдаг мустангтай төсөөтэй байна уу? гэж асуув.

-Энэ хэрэв миний үзсэн тэр мустанг биш байвал намайг чөтгөр аваг! Хэзээний баригдчихаад байж байдаг байна шүү! Азтай байна, залуу минь, хоёр зуун доллар таных болж. тийм үнэнд хүрэхээс ч аргагүй амьтан юм! Мөн ч сайхан адуу юм даа! Пойндекстер авхай яасан их баярлах бол доо!

VII. Тавгүй шөнө

Бидэрт мустанг баригдсан ер бишийн явдал анч өвгөний сэтгэлийг их хөдөлгөжээ. Бас Фелимийн санаснаас илүү иих аирхитай үлдсэн өнөөх лонхны ёроолд хяруулаа идэхээс өмнө нэг “татах юм”, идсэнийхээ хойно даруулга болгож хоёр дахин хундаганаас гадна тамхи татах үедээ хэд хэдэн хундага тогтоочихоор юм үлдсэн байсан нь өвгөнийг багагүй баярлуулжээ.

Хоолны үзээр талын оршин суугчдын ззаншлаар ихэвчйлэн индианчуудын тухай, анд тохиолдсон явдлын тухай хөгжилтэй хүүрнэлдэв.

Зеб Стумп агнуурын явдлыг сайн мэддэг ангийн тайлбар толь шахуу болчихсон хн болохоор хэнэс ч илүү ярьж хачин сонин тохиолдлуудыг сонсоод Фелим гайхсандаа үе үе дуу алдана.

Гэвч шөнө дунд болохоос нэлээн өмнө яриа тасарлаа. Лонх хоосорсон нть тэдний амарья гэж бодохын гол шалтгаан ч болсон байж магадгүй. Гэвч түүнээс илүү нэг учир байсан нь мустангер маргааш Леон руу явахаар шийдсэнэс цөм өглөө эрт босож юмаа бэлдэх хэрэгтэйд байв.

Зэрлэг адуу тэгтлээ гаршаагүй учир замдаа зугтаачихгүйн тул хооронд нь холбохоос эхлээд мордохосоо өмнө хийх юм бишгүй байлаа.

Анч өвгөн урт аргамжаагаар гүүгээ аргамжаад, ганзаган дахь хуучирч шаралсан хучлага дэвсгэрээ тайлж авчирахад ,

-Миний орон дээр унт. Би адууны адсага дэвсээл шалан дээ унтана гэж гэрийн эзэн найрсагаар хэлэв.

-Үгүй, танай аль ч ор Зеб Стумпийн унатахд тохирохгүй. Би газар унтана. Газар унатахад хамгийн сайхан байдаг. Бас тэгээд орон дээрээс ойчно гэж айх юмгүй гэж зочин хариу хэлэв.

-Тэнд тэр нь дээр санагдаж байвал шалан дээр унт даа. Энд хэвт, би танд адсага дэвсээд өгье.

-Залуу минь, битгий сэтгэл зов. Дэмий цаг нөгцөөгөөд яах вэ. Би ямар ч шалан дээр унтаж сураагүй юм. Миний хэвтдэг газар чинь зэрлэг та нутгийн зүлэг ногоо байгаа юм.

Зочин хучлагаа мөрөн дээрээ тавиад үүд рүү явж байхыг мустангер хараад гайхаж:

-Та гадаа унтах гэж байгаа юм биш биз? гэж асуув.

-Тиймээ, тэгэх л гэж байна.

-Шөнө хүйтэн байдаг. Та умрын хар салхинд дайруулсан юм шиг бээрчихнэ дээ.

-Даарах ч яамай. Бүгчим саравчин дотор амьсгаа давхцаж хэвтэхээс жаахан бээрсэн нь дээр.

-Стумп гуай, та тоглож байна уу? -Залуу минь! Зеб Стумп сүүлийн зургаан жил нэг ч удаа үе мөчөө тэнийлгэж дээвэр дорхэвгтсэнгүй. Би дээр цагт Миссипт ямар нэг орон шуу юмны оронцог болсон нижир модны хонгилтой байсан юм. Чавганцаа амьд байхад түүнд зориулж тэр ормыг хадгалж байлаа. Түүнийг талийгаач болсон хойно Лиузиан очоод дараа нь энд ирсэн юм. Түүнээс хойш Техасын цэнхэр огторгуй д өдөр ч гэсэн шөнө ч гэсэн хоргодох ганц саравч минь болсон юм гэж анч өвгөн хэлэв.

-Та гадаа унтах гэж байгаа юм бл ...

-Тийм ээ, Би гадаа унтана гэ өвгөн товч хариулаад гарч горхи, овоохой хоёрын хоорондохи ногоон злэгрүү явлаа.

тэр хүн хуучин хөнжлөөсөө гадна бас адууны хялгас томж хийсэн дөрөв таван алд хэрийн урт аргамж авч явав. Тэр нь морь аргамждаг хэрэглэдэг ердийн л нэг дээс байв. Гэвч зарим үед өөр юманд бас хэрэглэдэг ажээ.

Анч өвгөн сарны гэрэлд ногоон зүлгийг сайн ажиглаж хараадп түүн дээр дээсээ цагариглуулан тавилаа.

Тэгээд тэр өвөрмөц хашлага дотроо орж, хөнжилдөө шургав. Зеб Стумп сэтгэл тайван хэвтээд, хэдэн мөчийн дараа бүрунтаад өгөх шиг болов.

Уртаар амьсгаа авч байгаагий нь үзвэл унтсан бололтой. Би сайтай, сэтгэл тайван бөбайдгийн ачаар дорхиноо унтдаг ажээ.

Гэвч удаан амарч чадсангүй. гайхсан хоёр нүд нь, анч өвгөний хөдлөх бүрий нь ажиглан харж байв. энэ бол Фелим О Нилийн нүд ажээ.

-Гэгээн Патрик минь, яах гэж өөрийгөө тойруулж аргамж цагираглуулан тавиа вэ? гэж фелим шивнэнэ.

Тэр ирланд хүний сонирхол нь эхлээд хүнийг хүндэтгэх этгэлтэй өрөслдөж байснаа дараа нь сонирхол нь дийлжээ. тэгээл өвгөнийг дөнгөж хурхирч эхэлмэгц анчны зүг сэмхэн гэтэж очоод, тааж мэдэшгүй асуултаа хариу абахаар түүнийг татаж сэрээжээ.

-Баларсан хар ирланд илжитг чамайг! Өглөө болчихож гэж боддлоо. Вунд өөрийгөө тойруулж аргамж тавьсан бэ гэлээ? Өөдгүй амьтан бүхнээс өөрийгөө хашиж хамгаалах л гэж тавьсан өөр яах вэ дээ? гэж Стумп илт дургүйцэн хэлэв.

Стумп гуай та ямар өөдгүй амьтны тухай ярьж байна? Могойг хэлж байгаа юм уу?

-Тийм ээ, тийм. Могойноос. Чамайг чөтгөр аваасай! Явж унтацгаа!

Фелим нэлээд ширүүн хариу сонссон боловч сэтгэл тааламжтайгаар овоохой руугаа буцаж явлаа.

-"Хэрэв индиануудыг тооцохгүй бол Техаст хорт могойноос өөр өөдгүй амьтанюу байх вэ.

Энд ирснээс хойш ганц ч шөнө тавтай унтаж чадсангүй. дандаа л могойны тухай бодож зүүдлээд байх юм. Патрик гэгээн өглөө ертөнцөд залрахаасаа өмнө энд ирээгүй нь тоогүйе” гэж Фелим өөрөө өөртэйгөө гүвтнэн ярьсаар явав.

Фелим , зэлүүд овоохой дотор, хн амьтантай уулазхгүй шахуу суусаар байгаад аргамжаа дээсний итд шидийг ч олж сонсоогүй байжээ. тэгээд саяныхаа мэдэж авсан аргыг бушуухан хэрэглэх гэ эзнээ сэрээлгүй сэмхэн орж хананд өлгөөстэй байсан аргамжийг авч гараад овойхойгоо тойруулаад тавилаа.

Тэгж тавьчихаад буцаж орохдоо

-За одоо Фелим О Нил ч Техаст могой байхгүй юм шиг санаа амар унтана даа гэж шивэгнэв.

Овоохой дотор огт чимээ аниргүй боллоо. гэгээн Патрикийн нутаг нэгтэн бурхны оронд орсон юм шиг болж адууны адсага дээр тарайж хэвтээд могойноос айлгүй тэр дороонтаад өгчээ.

Тара болоод баригдсан мустанг хүртэл цөм нэгш хэсэгтээ шөнийн амралтаа бахархан эдэлж бөайв. гагцхүү Стемкийн хөгшин гүү шөнийн бэлчээрт шимт ногоо зулцгааж, чимээ аниргүй байдлыг эвдэнэ.

Гэвч анч өвгөн унтаагүй байгаа нь мэдэгдэв. Тэр хүн тайван утахын оронд хоёр хажуугаараа ээлжлэн хэвтэж, ямар нэ улиг болсон бодол нойры нь хулжааж байх шиг байв. Стумп тэсч ядаад хөнжлөө ярж өндийж суугаап эргэн тойрон урамгүйхэн харж

-Ирландын энэ тэнэг амьтныг чөтгөр аваачаасай! Золиг чинь нойр сэргээчихлээ. сургамж болгон усруу чулуудах ёстой байсан юм, эзний нь бодоод л тэгсэнгүй. Тэглээ ч гэсэн би өглөө болтол унтаж чадахгүй л дээ гэж шүдзээ зууж хэлээд хөнжилдөө лдах н орж хэвтэв. Гэвч унтаж чадалгүй ийш тийшээ эргэж хөрвөөсөөр сүүлдээ дахин өндийж суугаад ганцаараа ярьж гарав.

Энэ удаа Фелимийг гол хаяна гэдэг сүрдүүлэг нь улам сүртэй шийдсэн янзтай дуулдлаа.

Анчин өөрийнх нь бодлыг гэнэт өөрчилсөн зүйлийг хараад эргэлзэх шиг болов. Сууж байгаа газраас нь арваад алхмын цаана нэг нарийхэн юм гулжилзан, сарны гэрэлд гялалзах нь мөлхөө амьтан гэдгийг төвөггүй хэлээд өгнө.

Тэр гулгаж яваа амьтныг хармагц :

-Могой ! гэж шивнэн хэлээд- хачин могой байна... Дуут могой гэхэд дэндүү том юм. үнэндээ энэ нутагт бараг үүний дайтай дут могой дайралддаг. Дэндүү цайвар хайрстай, нарийхан биетэй юм. үгүй энэ ч дуутмогой биш байна! Аа одоо л мэдлээ муу золигийг чинь. Энэ чинь өндөг хайж яваа “тахиахан” юм. Чи муу мунгинасан амьтан над руу мөлхөж яваа бий! Гэв.

Түүний дууны өнгөндю айсан шинж алга. могой аргамжин дээгүүр давахгүй, түүнд хүрмэгцээ галт гортигонд хүрсэн юм шиг буцаад явчихна гэж Зеб Стумп мэдэж байлаа. Тэр

могой хамгийн хортой могой байлаа ч гэсэн анч өвгөн түүний шидэт гортиг дотроосоо санаа амар хайж сууж болно.

Гэвч тэр нь хорт могой биш, хар ярианы хэлэнд “тахиахан” гэдүг нэртэй янз бүрийн могойн нэг, хамгийн хоргүй жирийн нэг могой байлаа. гэхдээ хойд Америкийн могойн дотор томд орно.

Зебийн царайдсонирхсон шинж илрэв. “Тахиахан ” аргамжинд яг тулж очимогц толгойгоо цогнойлгоод аргамж руу нэг мөргөчихсөнөө тэр дорхиноо буцаад мурилзан одов.

Анч өвгөн түүний явж байгааг сонирхон харж алчих уу орхичих уу гэдгээ шийдэж ядан байгаа боолтой. хэрэв дуут юмуу жадан толгойт байсан бол хүнд гутлын өсгийгөөр толгойи нь бяц гишгэх байлаа. гэвч хоргүй амьтныг хөнөөхийг хүссэнгүй.

-Хөөрхий амьтан! Яах вэ, мөлхөөд харьж үзэг. Үнэндээ энэ л цацагт хяруулын өндгийг сорчихоод байдгаас хяруул ховордоод багаа юм. гэвч ганц иддэг хоол нь юм хойно, би түүнд уурлаад ч яах вэ. хэрин нөгөө муу тэнэгийг бол чадчихаасаа сийхгүйсэн. Эзний нь бодоогүй бол муу золигийг чадмаар л байх юм ... Оллоо! Аа, бодож оллоо! Гэж нүүрэнд нь зальжин байдал тодорч гулжиилзан тодсон могойны араас алхан очоод хоёр гараараа шүүрэн авч мурилзууллаа.

-За эрхэм Фелим чи одоо үзнэ дээ гайгүй! Би чамайг өглөө хүртэл унтаж чадахгүй болтол чинь айлгаж өгөхгүй бол сар шувууг цацагт хяруулаас ялгаж ч чаддагүй эргүү амьтан болог. Хүлээж л бай! гэж хэлээд овоохой руу сэм гэтэж очоод Фелимийн овоохойгоо тойруулж нямбайхан тавьсан аргамжны дотор талд могойгоо тавилаа.

Анч өвгөн ногоон зүлгэн дээрээ буцаж очоод, дахэин хөнжилдөө орж, аман дотроо өгүүлсэн нь:

-Могой дээсэн дээгүүр давж чадахгүй юм чинь гарах нүх сүв хайж мөлхөх нь мэдээж. Хэрэв хагас цагийн дотор тэнэг болог... Байзаа! Юу болов? Чөтгөр а аваг чамайг, амжуулчихлаа гэж үү!

Хэрэв анчин өөр юм хэлье ч гэсэн сонсогдохооргүй байв.

Энэ үед тал бүр тийшээ хэд хэдэн бээр газрын хамаг амьтныш цочин сэрмээр жигтэйхэн муухай дуу гарав.

Эхлээд хүн орилох нь сонсдож, Целим О Нилийн хоолойноос адгуус аийтны дуу гарч, Фелимийн орилох нь адууны үүрсэн янцгаах, нохойн хуцах чимээтэй хослон хэдэн минут үргэлжлэв.

-Юу болов? гээд мустангер орноосоо босон харайж аюулд учирсан зарцаа тэмтрэн- Ямар байларсан юм нь чамайг хорлочихов? Чөтгөр шулмас зүүдэнд чинь орооо ву ? гэж асуув.

-Эрхэм Морис гуай минь чөтгөр шуламнаас долоон дор юм! намайг могой хатгачихлаа. Бүх

биен дээгүүр минь гүйгээд ... Бурхан минь би чинь үйлэнд учирч үхэх боллоо! Одоохон л үхэх байх!

-Могой хатгачихлаа гэнээ? хаана чинь хатгачихлаа вэ? гэж Морис яаран гэрэл асаангуут асуув.

Морис аль хэдийн овоохойд орж ирчихээд байсан анч өвгөнтэй хамт Фелимийн биеийгш үзэж эхэллээ.

Морис мустангер зарцаа тал бүр тийш харуулж, биеий нь нарийвчлан ажиглаж үзээд:

-Би л могойд хатгуулсан газры нь чинь олж үзэхгүй юм гэ хэлэв.

-Маажинхай я алга гэж Стумп товчхон хэлэв

-Хатгаагүй байна гэж үү? Тэгвэл ч аз ыболж харин тэр чинь миний ыби? Дээгүүр гүрэлзээд байсан. Одоо хүртэл хүйт оргиод байна.

-Нээрээ могой ман гэж үү дээ? Фелим, чи ер нь зүүдэлсэн байлгүй дээ? гэж Морис үнэмшээгүй байдалтай асуув.

-Морис гуайминь, юун зүүд байх вэ? Ёстой могой байсан. Нээрээ шүү.

-Могой байсан байж магадгүй. Ал вэ, харъя. Олдож мэднэ. Ер нь гайхалтай юм. танайхыг тойроод адууны хялгасан аргамж тавиастай байна билээ. түүнийг могой яаж давж гарда юм бол? ... гэснээ-Байзаарай. Тэнд байж байна шүү! гэж өвгөн хэлээд буланд цагариглан хэвтэж байгаа могой руу заав.

-Энэ чинь “тахиахан” гэдэг хоргүй могойл байна шүү дээ? хөөрхий гэмгүй амьтан багаа юм. хатгана гэж байхгүй. гэлээ ч гэсэн тонилгоё. Гээд Стумп смогойг барьж аваад газар гуядахад тэр нь хөдөлж чадахаа болилоо. Стумп могойн толгой дпээр хүнд гятлаараа гишгээд

-За, эрхэм Фелим минь, болох нь энэ. Одоо таныг могой үймүүлэхгүйгээс хойш, тавтай хэвтэж өглөө болтол нойрс гэж хэллээ.

Зеб Стумп үхсэн могойг хөлөөрөө өшиглөчихөөд овоохойноос нь гарч хөгжилтэйгөөр инээсэглэн. Тэгээд ногоон зүлгэн дээр ханхар том биеийнхээ хэрээр тэрийн хэвтээд нам унтав.

VIII. Жаран хөлт

Могойг тонилгосноос хойш цөм тайвшрав. Нохйо хуцах, фелим орилохоо болиод, мустангууд модны ёсүүдэрт нам тайван зогсч байлаа.

Овоохой дотор ч гэсэн чимээ аниргүйбболж , гагцхүү аргамжин хамгаалалтанд итгэхээ нэгэнт больсон Фелим л мустангийн арьстан дэвсгэр дээр байн байн эргэлдэж байгаа нь сонсогдлоо.

Овоохойны гадаа ч чив чимээгүй. гэвч нэг юмны дуу чимээ аниргүйг эвдэнэ. Энэ бол мэлхийний ыбаргиа дуу, матрын исгэрээн хоёрын аль нь биш. харин энэ дуу Зеб Стумпийн хамраас гарч байгаа болохоор нойрсож байгаа анчны хурхирахаас өөр юу ч байх билээ.

Энэ Зеб нам унтасныг гэрчилнэ. Нойроо сэрээснийх нь хариуг Фелимээс авсан нь түүнийг тайвшруулж санаа амар амарч буй нь энэ.

Тэр дуу бараг цаг шахам үргэлжилжээ. хааяа нэг шар шувуу хашгичих, чононцорын алсад гунигтай улих сонсогдоно.

Гэтэл дахиад л орилоон шуугианболж бас л Фелим түрүүчийн адил хашгирав.

-Амь авараарай! Гэгээн дарь эх минь! Арёчаагүй амьтныг өмгөөлөгч минь! Авраач намайг, авраач! Гэж Фелим зөвхөн эзнээ төдийгүй гадаа унтаж байгаа зочныг сэртэл гэнэт орилов.

Авраач гэнэ үү? Юунаас авраач гэж? Юу болов? гэж асуусаар Морис Жеральд орноосоо дахин босон харайж, яаран гэрэл асаав.

-Эрхэм минь өөр нэг могой! Пээ! Стумп гуай алсан могойноос долоон дор хортой могой байна. нээрэн шүү! Цээжин биеий минь хатгачихлаа. хамаг бие улайтгасан төмрөөр хайрсан юм шиг халуу оргих байна.

Зеб Стумп хөнжлөө нөмөрсөөр орж ирээд

-Чамайг чөтгөр авачаасай! Тэнэг чинь хоёр дахин намайг сэрээчихлээ! Эрхэм Жеральд, та намайш уучлаарай. Америкт ч Ирланд ч гээд орон бүхэн тэнэг амьтан зөндөөн байдаг нь мэдээж. Гэтэл би танай энэ усан танаг шиг амьтантай ер дайралдаж үзсэнгүй. Ёстой нэг тэнгэргүй амьтан байна даа!

Үүнийг аваачиж усанд хийхээс нааш бидөнөөдөр унтаж чадна гэж үү дээ! гэв.

-Эш Стумп гуай минь битгий тэгж яриарай! Энд могой байна гэж та хоёрт тангаргалай! Тэр могой одоо энэ овоохой дотор ыбий гэдэгт итгэж байна. гацхан минутын өмнө над дээгүүр явахы нь би мэдсэн.

-Чи зүүдлээ байлгүй? техасын ямар ч могой аргамж дээгүүр давдаггүй юм гэж би чамд хэлсэн шүү дээ. Түрүүчийн могой бол чамайг бугуйл тавьж амжихаас өмнө овоохой дотор

орчихоод байж байсан байх. Хоёр могой зэрэг орж ирэх нь юу д бол. Гэвч мэдэхэд амархан гэж анчин өвгөн нэлээд ивээлтэй, өршөөнгүй дуугаар хэлэв.

-Ёо,ёо авраач! Хавирган дээгүүр могойны мөр гарсныг хараач. Хоёр дахин байсан байх нь ! Нигүүлсэнгүй дарь эх минь, яадаг билээ? Гал дотор орсон юм шиг халуу шатаад байна! гшэж фелим цамцаа биенээсээ хуу татан хэлэв.

Стумп айсан Фелимд ойртон очиж дээр нь гэрэл бариад

-Могой гэнээ? Яалаа гэж могой байх вэ! Могой биш гэдгийг тангаргала, чөтгөр аваг! Энэ чинь могойноос дор амьтан байх чинь! гэв.

-Могойноос дор гэнээ? Стумп гуай та дор гэж хэлэв үү? Та үүнийг аюултай гэж бодож байна уу? гэж Фелим шалгаав.

-Чамд юу гэж хэлье дээ... надад ойр хавиас эм тан олдох эсэхээс бзх юм хамаарна. Хэрэв эс олдвол би үүнийг хариуцахгүй...

Стумд гуайминь намайг битгий айлгаач дээ!

Морис, Фелимийн цээжин дээрх улайсгасан зүүгээр хайрсан мэт дот улаан гуврууг хараад

-Яачих нь энэ вэ? гэж хэлээд анч өвгөнийг Фелимийн бие дээрх жигтэй сонин мөр рүү анхааралтай ширтэн харж байхыг ажиглаж, санпарч тэвдэн үгээ

үргэлжлүүлэ- Юу болох нь энэ вэ? Би ийм юм ерүзээгүй. Энэ таны сэтгэлийг

зовоож байна уу? гэв.

-Их зовоож байна. эрхэм Жеральд минь гэж хэлээд Стумп мустангертай хамт шивнэн ярилцсаар гадаа гарав.

-Энэ цтэргэнд яачихаа вэ? гэж Морис сэтгэлд зовсон байдалтай асуув.

-Хортой жаран хөлт биен дээгүүр нь явчихаж л дээ.

-Хорт жаран хөлт! Тэр чинь Фелимыг хазчихаж юм биш багаа?

-Үгүй, би тэгж өодохгүй байна. Заавал хазах ч албагүй, яваад л өнгөрөхд үхлийн аюултай ч байж болно.

-Ээ тэнгэр минь! тийм аюултай юм гэж үү?

-Тийм ээ эрхэм Жеральд минь. огтын эрүүл саруул хүн тийм гувруутай болчихоод диваажинв тноилж байхыг би зөндөө үзсэн. Хэрэв родоохон аргалахгүй бол цаадахи чин жигтэйхэн халуураад сүүлдээ галзуу нохойд уруулсан юм шиг болж ухаан алданаг харин түүнийг битгий айлга. Би тус дэм болмоор юмыг үзээд алдья. Энэ нутагт нэг ургамал байдаг юм. Би хэрэв

тэр ургамлыг түргэн олж амжвал Фелимийг эмнэхэдп амархан. Даанч сар шингэчихэж дээ. Би тэр ургамлыг тэмтэрч эрэхээс биш яахав. Эрэг гангаруу тэр ургамал их байдгийг мэднэ. Чи буцаж очоод цаад залуугаа тайтгаруулж бай. Би эрж үзье. Одоохон эргэж ирэмц...

Ийнхүү гадагшаа шивнэлдэн Фелимийг тайвшруулах н бүү хэл улам л мэдэгдүүлэн сандрагжээ. Анч өвгөнийг эмийн ургамал эрэхээр яьж амжаагүй байтал Фелим муухай орилон хашгирсаар овоохойноос гүйн гарч ирэв. морис хэдийгээр өөрөөитгэлтэй биш ч гэсэн, ямар ч гэсэн айх юм байхгүй гэж хууран арайхийн тайвшрууллаа.

Төдөлгүй Зеб Стумп орж ирэв. Түүний царайд эмийн ургамал олсон шинж илэрхий байсан учир эзэн зарц хоёрыг баярлуулжээ. Анч өвгөн шигүү, жигд ургасан хурц өргөстэй, хар ногоон өнгөтэй зууван наюч хэд хэдийг баруун гартаа барьжээ. тэрнавчнууд дотор өөрийн сайн мэддэг аршийн нудрага байхыг Морис таньжээ.

Эрхэм Фелим битгий ай! Гэж анч өвгөн овоохойны босго алхангуутаа хэлээд- Одоо айлтгүй болсон. Би чиний халууныг дарж, нүд ирмэхийн зуур өвчнийг чинь эдгээх болно. Чамайг хашгирахаа боль гэж байна шүү! Чи голоос дээш доошоо хорин бээрийн дотор байгаа ан амьтныгсэрээчихлээ. Хэрэв чамайг ингэж орилоод байх юм бол хамаг команчууд гүйлдээд ирнэ. Тэгвэл жаран хөлтнөөс долоон дор юм болно шүү дээ! Намайг эм бэлдэж байх хоронд нэг боох юм олоод ирээч гэв.

Анч өвгөн эхлээд навчны өргөсийг хутгаар авч дараа нь зузаан зузаан зүсэж түүнийгээ Фелимийн улаан гувруу гүйсэн биен дээо тавиад мустангерын бэлтгэсэн цэвэр алчуураар боов.

Аршийн шүүс хор дарахдаа сайн нь тэр дорхноо мэдэгдэв. Аюул өнгөрлөө гэж итгэсэн Фелимийн санаа амарч бас ядарсандаа болоод удалгүй унтаал өглөө. Оточ анч өвгөн могойг бодвол олсон дээгүүр ажиггүй давчихдаг нөгөө аюуль жаран хөлтийг олох гэж дэмий оролдож байснаа зүлгэн дээрээ буцаж очоод өглөө болтол тайван нойрсжээ.

Үүр хаяарах үед гурвуул босов. Фелим халуурч дагжихаа больж, нөгөө айдас нь ор мөргүй алга болжээ. тэд гурав цацагт хяруулын шарсан махны үлдэгдэл идээд явахад бэлтгэж гарлаа. Баллибаллахын хөтөч асан анч өвгөнтэй хамт зэрлэг адуунуудыг ихтал гаталган туухад бэлтгэн холбож эхлэв. Тэр үеэс Морис өөрийн морь, бидэрт гүүү хоёрыг аян замд зэхэв. Ялангуяа, баригдаж ирсэн сайхан гүүндээ их анхаарал тавьж дэл сүүлий нь сайхан гэгчсамнан түүнийг барьж авах гэж хичнээн хөөцөлдсөний гэрч болох гялалзсан сайхан арьсанд наалдсан муухай толбыг арилгав.

Зеб Мустангер өөд гайхсан байдалтай харж :

-Болиоч дээ. та тэгж оролдоод дэмий. Вудли Пойндекстер бол хэлсэн үгээ буцдаг тийм хүн биш. Миний нэр Зеб Стумп гэдэг нь үнэнтэй адилхан, таны хоёр зуун доллар авах чинь үнэн. Чөтгөр аваг. Энэ гүүнд тэр зэргийн үнэ байлгүй яахав? гэв.

Морис хариуд нь юм хэлээгүй боловч завьжаараа инээмсэглэж байгаагий нт харвал бидэрт мустангт онц анхаарал тавьж байгаагий нь учрыг Стумп ойлгоогүй юм байна гэж бодож

болох байлаа.

Морис мустангер хээр морио унаж, өнөөх сайхан гүүгээ бугуйлгаар оосролож хөтлөөд явснаас хойш цаг ч болоогүй байлаа. Фелим бусад мустангуудыг хөтлөөд араас нь хатриулан явна. Зеб Стумп хөгшин гүүгээ унаж, тэдний хойноос гүйцэж ядан давхина

Тара өргөстэй нуга дээгүүр болгоомжтойхон гишгэсээр араас нь яаралгүй шогшино.

Овоохой сахиж хэн ч хоцорсонгүй. зөвхөн зэрлэг тал нутгийн дөрвөн хөлт амьтныг оруулахгүйн тул адууны ширэн бүрээстэй үүдий нь л хаажээ. шар шувуу дуугарч, зэрлэг муур муухай орилон, өлөн чоно гиюүрэн ульж, эргэн тойрны чимээ аниргүй байдлыг эвдэнэ.

IX. Хилийн цайз

Инж цайзын дээр одогт далбаа намилзаж, ер бусийн өвөрмөц барилга дээр чичирхийлсэн сүүдрээ тусгана.

Энэ бол хагас зэрлэг, хагас боловсон бөгөөд хагас цэргийн байдалтай, хагас энгийн жинхэнэ хилийн амьдралыг дүр зураг ажээ. тэр зургийг отгон Вернэ л үнэндээ гаргаж чадах бизээ. Энд янз бүрийн хувцас хунар өмссөг бөгөөд нийгмийн дотор янз бүрийн байр сурь эзэлдэг, янз бүрийн мэргэжил боловсролтой хар, цагаан, арьстан хүмүүсийг үзэж болно.

Цайз ч гэсэн ямар нэгер бишийн байдалтай юм. Энэ хориглон хамгаалах, газар, нууц зам нүхэн саал, шороон хаалтны аль ч байхгүй бөгөөд хэрэм цайз гэж санагдахаар юм бараг байхгүй ажээ. халуун орны алгораб хэмээх модоор шивээлж барьсан хоёр зуун адуу багтах саравч байна. Тэр саравчны эргэн тойронд шавардсан сүлжмэл ханатай авсаархан барилга хэдэн арав байна. хамгийн том нь цэргийн хуаран_ хойд талаараа цэргийн эмнэлэг, агуулах гакартай бөгөөд нэг талд нв сахилга журмын шорон, нөгөө талд нь дарга нарын байр, хоолны газар байна. барилгууд нь цөм туйлын төв байдалтай мөртөө цэвэрхэн цэмцгэр. Жирийн шавардмал хануудыг нь цагаан шохойгоор буджээ. Их гүрний цэргийн хувцастай хүмүүс цувна. Инж цайзын байдал ийм ажээ.

Түүнээс жаахан зайдуухан байгаа хэсэг байшин нь цайз гэж нэрлэсэн хэсгээсээ бага юм. тэр байшингийн бас л америк далбааны дор нэрвэгдэж байдаг бөгөөд дээр нь америк далбаа шууд мандаагүй боловч тэдгээр байшин бий болж, оршин тогтох байгаа нь тэр далбаатай холботой м. Энэ бол ан америкийн уэргийн салбарын ойролцоо ердийн байдлаар бий болж сүүлдээ түргэн хөгжиж, жижиг том хот болно өргөжиж суурингуудын нэг юм.

Цэргийн хоол хүсний газарт үл хамаарах архи дарсний агуулах газартайжижиг барааны худалдагч, согтуу хүний хорхой хүргэж байх гэж шилтэй архинууд өрсөн дур булаам тавиуртай ,шалгүй , салбар мухлагийг харъяалсан дэн буудлын эзэн, нутгийн цэргийн ангийхны өврийг хоослогч мөрийтэй тоглоомчид ер бусын алдар цуутай босон хориод хар нүдтэй бүсгүй, мөн тийм тооны анчин, мустангеруудын болон ер нь тэгээд орон бүхний цэргийн хуаран бүрт заавал байдаг тодорхой албанд хамааралгүй хүмүүсээр тэр муурины хүн ам бүрдэл болжээ. Энэ бяцхан суурингийн байшингуд нь овоо замбараатай бөгөөд цөм нэг эзэн хүний өмч бололтой. Тэр байшингууд дагтаршсан газар дэр гэрдийн шил болоод баримлуудын оронд ёрдойж байгаа хатаж хувхайрсан заан мод, хэсэгш бут сөөгтэй бяцхан цэцэрлэгийг тойрон харагдана.

Леон гол энэ газарт горхи шиг болтлоо нарийсаж, цайз суурин хоёрын араар урсана. Урд талд нь хурц тод номин эрдэнийн өнгөт өвч ургамлаар бүрхмэл тал хөндий цэлийэ, алсад маш өтгөн ойн зцурвас зурайн харагдана. Тэнд аврага царс, самрын мод, хайлсууд нь заан модны өргөс цагдуул болоод ургамлыг судлагч нарт барагмэдэгдэхгүй ороонги, мацанги , сорогч янз ыбүрийн шимэгч ургамалтай холилдон амьдралынхаа төлөө тэмцэж байна. Горхины эргийн хойд зүүн хоёр талд тариалнганийн эздийн орон байр энд тэнд байрлажээ. Тэюгээрийн зарим нь нэлээд болхи бүдүүлэг бөгөөд шинэ тутм баригдсан, зарим нь овоо нарийн нямбай баригдсаныг харваас зэгсэн удаж байгаа бололтой. тэр байшингуудын

дотроос шүд мэт арзгар хүрээт хавтгай оройтой бөгөөд хана нь гурван талаасаа хүрээлэгдсэн ногоон ойн дэвсгэр дээр тодхон ялгарч харагддаг том барилга хүний атаархалыг гоц татна.

Энэ бол Каса-Дель-Корво гэдэг эзэмшил.

Хойшоо эргэж харвал тань гурвалжин хэлбэртэй өнчин уул таны өмнө дүнхийн харагдана. Тэр уул хэд хэдэн зуун тохой өндөрбөгөөд түүний хойд талын манан будан татсан тэртээ алсад Гвадалупын уулсын тахиралдсан үргэлжлэл нүд булааж харагдана.

Дээшээ харвал тань номин цэнхэр өнгөтэй тэнгэр хаагдана. Өдрийн цагт тэнгэрт үүлгүй цэв цэлмэг харин дээр нь гагцхүү алтан шаргал наран гийнэ. Шөнийн цагт бол хойцгүй ган болдоор давтаж хийсэн юм шиг одон мичид тэнгэрт түгэх бөгөөд тунгалаг тэргэл саран нь ёстой л мөнгөн юм шиг санагдана.

Сар шингэж одон мичид замхарсан хойно Матагордын булангас цэцгийн сйахан үнэр анхилуулсан салхин үлээх үесээр доошоо харвал тань бараг тодорхойлон бичих аргагүй тийм олоо янзын хувцас хунар, өнгө зүс төрх байдлаар баялаг хурц тод, аглаг эрээн зураг дүрсүзэгдэнэ.

Таны нүдэнд нэгдсэн улсын явган цэргийн цэнхэр хувцас, морин цэргийн ёслолын хөх хувцас буучдын бүдэг ногоон хувцас тусна. Зөвхөн жижүүрийн офицерууд, харуулын дарга, харуулынхан л бүрэн хувцастайгаа байхыг харна Тэдний нөхөд нь завтай цагтаа, улаан ногоон цамц, зөөлөн бүрх малгай, бохир гутал өмсч, адууны хашааны саравчин дор юмуу , муусайн модон байруудын хажуугаар сэлгүүцэж явна.

Тэд өвч энгийн хувцас өмсч хүмүүстэй элдвийн юм ярилцана. Тэдгээр хүмүүс бол бугын илгээр хийсэн халхгар хувцас, илгэн түрийтэй гутал өмссөн малчид, мексикийн серапэ тохож, истанийн самбреро гэдэг өргөн хүрээтэй гялгар хар бүрх малгай хааш яаш хэлтгий тавиад малчид болоод мустангеруудын юм. Офицерууд худалдааны хэргээр буюу эсвэл энх тайвныг сахих хэлэлцээр хийхээр цайзад ирсэн индианчуудтай ярилцана. Тэр индиан нарын майхнууд ойрхон харагдан. Өөрсдөө нэхсэн улаан, ногоон цэнхэр нөмрөг хэдэрсэн индиануудын байдал ер бишийн гоёмсог бөгөөд бараг дээд зээргийн гоё сайхан юм шиг санагдана. Арьсан дээрээ зурсан утга учиргүй зураг, хялгасан залгаатай хар гээзэгтний нь хир суусан зохиомж муутай чимэглэл хүртэл тэдний яв цав тохирсон үзэсгэлэнтэй байдлыг үл гутаана.

Цэргийн болоод янз бүрийн үндэсний хувцас өмссөн энэ алаг эрээнхүмүүсийг сэтгэлдээ дүрслэн бодож үзээд бас түүн дээр офицерын морь баригч хар арсыт негрүүд буюу зэргэлдэх суурингийн газрын эздийн зрц нарыг нэмж, тэд хэрхэн цөөн цөөнөөрөө цооглон зогсч, дэмий юм ярьцгааж байгаа буюу эсвэл бүхээгт тэрэннүүд болоод тэргэн дээр хос хосоороо зоосон том буунууд , унтахад дээр гэж офицеруудын шилж авсан, нэг хоёр цагаан майхан, цахлуулж тавьсан жадтай буу энэ бүхнийг бодоход тань боловсон гакар орны хязгаарт , Техасын хил дээр байдаг цэргийн цайзын жинэхэн дүр байдал таны нүдний өмнө босч ирнэ.

Вудли Пойндекстерыг Лиузианаас шинэ байшиндаа нүүж ирсэн хойш долоо хоногийн дараа Инж цайзын өмнөх ёслолын жагсаал хийдэг талбайдээр гурван офицер зогсоод Каса-Дель-Корво шилтгээн рүү харцгааж байв.

Тэд гурвуула залуу бөгөөд хамгийн ах нь гучаас хэтрээгүй ажээ. нэг нь погон дээрээ шовх өнцөгт нэг тэмдэгтэй ахлах дэслэгч, гурав дахь нь цулгүй погонтой учир бага дэслэгч гэдэг нь илэрхий.

Тэд албанаас чөлөөтэй байсан учир Каса-Дель-Корво шилтгээнд шинээр ирсэн хүмүүсийн тухай чрилцаж байв.

-Шинэ байранд орсны найр болох юм байх гэж ахмад нь гарнизоны бүх офицер урилга түгээсний санаж хэлээд-Эхлээд хоол иднэ. Дара нь бүжиг хийнэ. Ёстой сайхан юм болно доо! Тэгээд л бид язгууртан нартай, суурингийн хамаг сайхан хүүхнүүдтэй дайралдана гэв.

-Язгууртан нартай уулзана гэнэ ээ? гэж морин цэргийн хорооны дэслэгч инээмсэглээд-Энд ч тийм олон язгууртан байх нь юу л бол , сайхан хүүхнүүд бол бүр ч цөөхөн дөө гэв.

-Генкок чи эндүүрч байна. Леон голын эргээс тэдний аль алины нь олж болно. Нийгэмд нэдээд жинтй хүмүүс энд нүүж ирдэг юм шүү. Бид тэдэнтэй Пойдекстерын найр дээр уулзана гэдэгт би эргэлзэхгүй. Язгууртны хувьд гэвэл санаа ззоволтгүй, бүх зочид элбэг элээг хүрэлцэхээр язгуур сурвалж цаад эзэнд чинь бий. Сайхан хүүхнүүдийн хувьд гэвэл эзний ганц охиныг Сабинас голын энэ талын хамгийн шилдэг нь гэж мөрийцсөн ч болно. Бэлтгэлийн албаны даргын зээ хүүхэн ч тэрний дэргэд юу ч биш.

-Аа тийм бий! Пойндекстцр авхай чинь хачин сайхан хүүхэн байж таарах нь ээ гэж бууч ангийн дэслэгч сэтгэл хөдлөн хэлэв.

-Тэр авхай Лафуршийнд болсон бүжигь найр дээр сүүлчийн удаа харснаас минь дордчихоогүй л бол ер бишийн сайхан хүүхэн шүү. Тэр найр дээр байсан хэд хэдэн креол залуу түүнд дурлачихаад колтой л буудалцаагүй билээ.

-Аалигүй хүүхэн байж таарнаа даа? гэж бууч ангийн дэслэгч хэлэв.

-Кроссман минь, тэр хүүхэн хумсын төдий аалигүй зангүй, шал өөр зантай гэж би батлана. Тэр чинь илүү занд дургүй, ухантай хүүхэн байгаа юм. Эцгээсээ бардам зангий нь өвлөж авсан хүүхэн дээ. Энэ бол Пойндекстерын онцгой чанар байгаа юм.

-Миний сэтгэлд яг тарах хүүхэн байна гэж морин уцэргийн залуу эр хошигнон хэлээд- Хэрэв тэр хүүхэн ахмад Слоуман таны ярьж байгаашиг сайхан хүүхэн юм бол би завал дурлана. Миний зүрх сэтгэл аз болоход Кроссменыхыг бодвол илүү чөлөөтэй юмдаг гэв.

Генкок , би мөрийцөхдөө дургүй хүн, харин чи луиза Пойндекстерын үзсэнээсээ хойш, хэрэв нууж хаадаггүй л юм бол түүний тухай ийм үг лав хэлж чадахгүй гэдэгт хэдийг чя бол хэдийг тавихад бэлэн байнагэж ахмад хариу хэлэв.

-Слоуман минь, миний төлөө бүү сэтгэл зов! Сайхан хүүхнүүдийн оч шиг нүдэнд даанч олон удаа төөнөгдөж явсан болохоор тэрүүнээс төдий л их айхгүй байна.

-Гэхдээ тэр сайхнуудаас чинь өөр л дөө!

-Чөтгөр аваг гэм! Та чинь намайг ганч ч шүүээгүй хүнд дурлуулчихлаа шүү дээ. Таныхэож байгаагаар бол тэр хүүхэн чинь лусын дагина гэсэн үг юмаа.

-Тийм ээ, та андуурсангүй, Намайг хамгийн ёсүүлд харахад л тийм байсан юм.

-Түүнээс хойш удаж байна уу?

-Лафуршийн бүжигт наадам гэдэг чинь? За бодоодохье... Жил хагасын өмнө юм байна. Биднийг Мексикээс эргэж ирсний дараахан нь юмдаг. Тэгэхэд лдөнгөж нааш цааш явж үзэгддэг болсон юм. “Хурц гэрэл алдраараа дуурьсах шинэ од гялалзаа” гэж түүний тухай ярьж байсан даа.

-Жил хагас ч урт хугацаа шүү гэж Кроссмен хэрсүү маягаар хэлээд- Эмэгтэй хүн, ялангуяа креол бүсгүйн хувьд их хугацаа. тэднийг чинь арван зургаа биш арван хоёртойд нь нөхөрт гаргачихдаг юм. Гоо сайхан өнгөө хэдийнээ алдчихсан байж болох л юм.

-Өчүүхэн ч үгүй. Би тэднийхээр очиж харж болж л байна. гэхдээ одоо мэдээж гэр орны ажил ихтэй, зочид хүлээн авахтай манатай байгаа байх. Саявгар тэднийхээр ороод гарсан нэг хошууч Пойндекстер авхайтны үзэмж гоогийн тухай магтаж ярьсаарбайгаад золтой эхнэртэйгээ хэрэлдчихээгүй салсан шүү.

-Нэр төрөөрөө тангаргалая гэж морин цэргийн залуу дуу алдаад-Таны ярьснаас болоод би бараг дурлачихаад байна шүү гэлээ.

-Гэвч чамайг дурлаж сүйд майд болохоос чинь өмнө сарнай өргөстэй байдгийн адилаар чамд муу юм хийж чадахаар нэг хүн тэднийд байдаг гэдгийг би урьдхэлэх ёстой.

-Ах нь л биз дээ? Ах дүү улс заавал саад болдог юм.

-Тэр хүүхэн дүүтэй боловч уг хэрэг тэр хүнд хамаагүй юм. Тэр бол Пойндекстерынхны дотроос хамгийн даруу төлөв хүн байгаа юм.

-Тэгвэл дээгүүр санаатай аав нв саад хийнэ гэж үү? Генкоктой нэг гэрт амьдрахаасаа дургүйцнэ гэж боохгүй л байнашүү.

-Үгүй ээ... Генкокууд маань жинэхэн янк, охины эцэг өмнөд нутгийн хүн гэдгийг бүү мартаарай. гэхдээ би өвгөн Полйндекстерын яриагүй байна.

-Тэгээд тэр жигтэй хүн чинь өөр хэн байх билээ?

-Лиузиагийн үеэл ах Кассий Колхаун. Тун онц биш хүн дээ.

-Би энэ нэрийг дуулсан юм шиг байх чинь вэ.

-Би ч бас дуулсан юм байна гэж бага дэсмлдэгч хэлэв.

-Юутай ч л гэсэн, Мексикийн дайнд холбогдолтой буюу өөрөөр хэлбэл Скоттын аян дайнд оролцсон хүн бүхэн түүний нэрийг сонссон. Колхаун өөрөө нэрээ хугалсан хүн гэдгийг хэлэх хэрэгтэй. Миссип мужийн иргэнийхээ хувьд Миссипийн сайн дурбн цэргийн хорооны ахмад байв. харин хорооны штабт байхааса ар талд хөзөр тавьж суух нь их байдг байсан. Түүнийг нэг буюу хоёр я явдал хэрүүл зодоонд хүгэн алдаршуулжээ. Энэ алдрыг Мексикийн дайнаас өмнө олж авсан юм. Шинэ Орлеанп түүнийг аюултай хүн гэж цуу тарсан билээ.

-Тэгээд яагаа вэ? гэж морин цэргийн залуу эр нэлээн сөргөсөн дуугаар асуугаад “”4Кассий Колхаун гуай аюултай ч баг, аюулгүй ч байг хэнд ямар хүртээлтэй юм бэ? Үнэндээ энэ бол надад ялгаагүй хэрэг. Түүнийг луиза Пойндекстерын зөвхөн үеэл ах нь гэж та хэлсэн шүү дээ.

-Яг ч тийм биш ээ... тэр хүүхэнд сэтгэлтэй юм шиг надад санагдсан

-Тэгээд харилцан сэтгэлтэй хэрэг үү?

-Үүнийг би мэдэхгүй. Аавын л хайртай хүн бололтой: тэгж хайртай байдгийнх нь учрыг ч үнэндээ надад маш их нууцалж байж хэлсэн билэ. Энэ бол цөм мөнгөний эрхшээлд бий болсон жирийн явдал юм. Пойндекстерын урьдынхтайгаа адил баян биш болжээ. тэгээгүйсэн бол бид түүнийг энд огт олж үзэхгүй байх байсан...

-Хэрэв охин нь таны хэлсэнчлэн тийм сайхан амьтан юм бол Кассий Колхаун ч ббрцгүй мөдхөн энд ирэх юм ы байна даа.

-"Мөдхөн гэнэ шүү. танд мэдэгдмээр байгаа юм. энэ үү? Тэр чинь хэдийнээ энд ирдгэ ирчихээд байна. гэр бүлийнхэнтэйгээ хамт ирээд цугтаа төвхнөж авсан. Зарим хүмүүс тариалангийнхаа газрыг хамтдаа худалдаж авсан гэлцэхюм. Өнөөдөр өглөө зочид буудлын зоогийн газар харагдана билээ. Бахь байдгаараа л согтуурхан хүн болгонд үсчин, өөрийгөө магтаад л байна билээ.

-Бараан царайтай, гуч эргэм насны, хар үс, сахлтай, хагас цэргийн маягийн хөх фцэмбэн хүүрмтэй, “кольт” буу бүсэндээ хавчуулсан эр мөн үү?

-Яг мөн! Хүрэмний нь цагуур махир хутгатайгий нь яана. Яг биеэрээ байга нь тэр.

-Зэгсэн зэвүүн царайтай амьтан билэ. тийм сагсуу хэрүүлч юм бол гээдна байдлы нь лав хуурсангүй гэж их бууч хэлэв.

-Гадна байдал ямар хаматай юм ? гэж морин цэрэг уурлан дуу алдад- Сэм нагацын армийн дарга гагна өнгөнөөс айдаг нь гонж. Хэрүүлч амьтдаас өөрсдөөс ньч айх юм алга. хэрэв хэрүүл өдөөд үзвэл, өөрөөс нь түрүүнд гохонд хүрдгийг үзүүлэх юмсан.

Яг энэ үедл өглөөний үзлэг-Ёслолд цуглах дохионы жимбүүр дуугарлаа. тэр үзлэг нь армийн том нэгдэл ангийхантай адил энэ жижиг цайзад тийм нарийн чанд явагддаг байжээ. Тэгээд

гурван офицер цайзын дарга хошуучийн үзлэгт бэлтгэхээр ангианги руугаа явлаа.

Х. Каса-Дель-Корво

Каса-Дель-Корво гэдэг эдлэн газрын буюу шилтгээн нь Леон голын модорхог эргийн дагуу тал нутгийн зүг гурван бэр гаруйы үргэлжлэх бөгөөд өмнө тийшээ хоёр хувь илүү их газрын хамаарна.

Буруу ч гэсэн мөн ч шилтгээн гэж нэрлэдэг газрын эзний байшин нь Инж цайзаас их буууны буудлагын дайтайгазар байх бөгөөд тэндээм шилгээний нэг хэсэг цагаан ханууд үзэгдэнэ. Бусад хэсэг нь голын эргийг хашсан өндөр моддын сүүдэрт халхлагдан байв.

Шилгээн байгаа газар нь ер бусын агаад хамгаалах санаа агуулан шилж авсан нь илэрхий. Учир нь байшингийн суурь тавьж байсан тэр үед колонилогчид нь индианы уулгалахаас болгоомжилж байсан агаад одоо ч гэсэн тэр үед колонилогчид нь индианы уулгалаах болгоомжилж байсан агаад одоо ч гэсэн тэр аюул байсаар ажээ.

Эндэхийн гол нь морины тах шиг огцом тохойрчээ. Энэ учрас “Каса-Дель-Корво” (“тохой дээрх байшин”) гэж нэрлэгджээ.

Ордны нүүр тал нь түүний өмнө тэнгэрийн хаяанд хүртэл цэлийж байга номин хөх хивс мэт тэл нутгаас өөд харжээ. Энэ гайхамшигь хөндийн дэгэд хааны цэцэрлэгт хүрээлэн даанч жижиг харагдах ажээ.

Каса -Дель-Корво уран барилгын хэлбэр маяг нь Мексикийн бусад суурингийн барилгатай адил мавиратанмексик барилгуудын төрх байдлыг хадгалжээ. Сараалжин хүрээв, хавтгар дээвэртэй ганц дан байшинтай юм. Барилгын дотоод талд товхон чулуун шалтай усан оргилуурт талбай, тавцан өөд тавьсан шант байна. гол үүд нь болох том төмөр цуургатай, цул модон дааман хаалганы хоёр таолд төмөр сараалжин хамгаалалттай хоёр гурван цонх байна.

Ээ бол Мексикийн шилгээний онцлог шинж, Каса-Дель-Корво нь испанийн Америкийн өргөн уудам нутагт тархсан ийм мягий хуучин барилга байгууламж ялгарах юмаар бага байв.

Лиузианаас ирсэн газрын эзний саяхан олж авсан ордон гэвэл ийм байлаа.

Байшингийн гадна тал ч дотор нь ч хэрэв эзэмшигчдийг л ялгахгүй юм бол өөрчлөгдсөн юм алга.

Урьд нь зөвхөн цэвэр усны испаниуд хөлхөлддөг асан гудам, хашаагаар хагас англисаксон, хагас франц маягийн хүмүүс сүлжилдэн баялаг сонсголт, Андулиз хэлний оронд хагас тевтон мягийн гүдэс төвөгний авиа сонсдон, хаая нэг хөгжим мэт креол-Франц аялгуу гарна.

Дээр үед хар ажилчид амьдарч байсан цэгийрмаагийн навчаар далдалсан хананы цаана бүр ч ажиглагдам өөрчлөлт гарчээ.

Өргөн хүрээт хар бүрх тавьж, судалтай серапэ нөмөрчя дарвуулаа дуугарган талаар ихэмсэг алхалж байсан өндөр гулжгар малчны оронд хөх хүрэй ч юмуу цув нөмрөн ташуураа тачигнуулсан омгорхог харгалзагч алхах болжээ. хонины арьс нөмөрсөн ацтекуудын үр удам

болох улаан арьстнууд гунигтайгаар хөлхөлдөж байсан эр газраар одоо Этилпийн хар охид хөвгүүд боолчлол бол гай тоггор гэдэг болыг няцаах гэсэн мэт дуу аялан бүжиг хийж, элдвийг өөрөлдөнө.

Каса-Дель-Корво эдлэн дэхь сайхь өөрчлөлт нь сайн хэрэг гэж үү?

Энэ асуултанд англичууд “үгүй” хэмээн нэгэн санаагаар гал цогтойгоор тус тас хариулах байсан цаг бас байлаа.

Хүний эргэж хургамтгай, бялдууч зан гэдэг үү! Биний боолчуудыг тэгтлээ хайрладаг юм шиг байсан маань хуурамч зан ч байсан байна шүү дээ.

Олигархиудын аяар байдаг Англи нь (манай хуучин ямбатнууд ийм үл бүтэх юм хийж чадахгүй улс, харин төрийн толгойд гарсан хэдхэн хөрөнгөтнууд л) ардын эрхийн эсрэг хуйноалдгчдийн амаар, дуулиантайгаар тунхаглан зарласан зарчмыаасаа ухарч, бүх үндэстний өөрийн нь үзүүлсэн итгэлийг хөсөрдүүлж байна луиза Пойндекстер толины өмнө түшлэгтэй сандал дээр суугаад зочид хүлээж авахад бэлтгэн хувцас хунараа өмсүүлж үс гэзгээ самнуулаад карц хүүхнээ дуудуулахаар шал одоон юм бодож суув. Энэ бол шинэ сууринд ирснээ ёслох эзний цайллага боохоос барагцаалбал нэг цагийн өмнөх хэрэг билээ. залуу креол хүүххний сэтгэл баахан хөдөлчихсөн байх нь энэ цайллагаас болсон хэрэг биш байгаа даа? гэвч шивэгчин хүүхэн ньн энэ талаар нэг таамаглалутай багйаа нь тэдний хоородын ярианааё мэдэгдэнэ.

Үүнийг яриа хөөрөө гэж хэлж болмооргүй ажээ. Лицзаг зүгээр л бодсоноо амандаа шивнэж суухад карц нь түүний үгийг цууриа мэт давган хэлнэ. Залуу креол хүүхэн амьдралынхаа туршид шивэгчнээ , эд агуурс, тасалгааныхаа дотрхи ширээ сандал зэрэг тавилга засалалаас өөрцгүй санаж бодсоноо нуухгүй байдаг байю. Түүний шивэгчин Флоринда бол амьтай голтой бөгөөд асуусан юманд хариу хэлдэгээрээ л эд хогшлоос нь ялгаатай юм. Флоринда тасалгаанд орж ирснээсээ хойш арван минутын турш эрүү хамхилгүй элдвийн юм донгосоход луиза өөдөөс нь үгээ зөөж тавин зэмлэх төдийгөөр ярихад оролцож байв.

-Ээ, Лиу авхай, та мөн ч сайхан гэзэгтэйе! Испанийн агар зандан моднодп хөвсийж байдаг сахлаг хөвд шиг. Өнгө нь өөр юм. Яг л чихэр бурам шиг гялалзаж байна шүү гэж негр хүүхэн, залуу авхайн сайхан газгийг энхрийлэн самнангаа хэлэв.

луиза Пойндекстер бол кроел хүүхэн болохоор сайхан бараан гэзэгтэй байх нь аргагүй бөгөөд түүний гэзгийг Испанийн хөвд шиг гэж негр хүүхэн гэнэхнээр мэргэн зүйрлэжээ. гэвч тэр нь хар гэзэр биш байлаа. Түүний гэзэг сайхан элгэн хүрэн өнгөтэй юм. тийм өнгө яст мэлхий юмуу өвөл баригдсан булганыг өнгө зүс дотор хааяа дайралддаг.

-Ээш, энэ муу хонины ноос шигүсний оронд таны гоё сайхан гэзэг надад заяасан бол тэд цөм өлмийд минь сөгдөх байх даа гэж Флоринда үргэлжүүлэн ярив.

-Чи юу яриад байна вэ? Яалаа гэнээ? Чиний өлмийд сөгдөх гэнэ үү? Хэн тэр вэ? гэж залуу креол гэнэт сэрсэ юм шиг асуув.

-Та миний үгийг ойлгосонгүй гэж үү дээ?

-Нээрнээсээ ойлгосонгүй.

-Би тэднийг өөртөө дурлуулах байсан юм. Ингэж л хэлэх гэсэн юм даа.

-Үгүй, хэнийг тэр вэ?

-Бүх цагаан арьстан дээдсийг дурлуулах байсан юм. Залуу эзэн, цайзын офицерууд бүхнийг, бүгдий нь шүү! Би тань шиг гээгтэй бол цөмий нь сөндүүлэх байсан!

Флоринда над шиг гээгтэй бол ямаршуу харагдах бол гэж Луиза бодоод

-Ха,ха,ха гэж инээн алдан- Хэрэв миний гээг чамд байса бол ямар ч хархүү өмнө чинь зогсоо байж тэсэхгүй гэж чи бодож байна уу? гэв.

-Үгүй хатагтай, минь таны зөөлөн гээг төдийгүй, бас булбарай царай, гөлтгөнө шиг цагаан арьс, гоо сайхан бие танв надад байсан болоосой гэж бодож байна. Тэгвэл мөн ч сайхан байхсан даа! Ээш, Лиу авхай та тийм л гоо сайхан шүү дэ! Цагаан арьстан дээдсүүд л ингэж ярьж байхыг би сонссон юм. тэгэхдээ би өөрөө харж байгаа болохоор тэдний ярихыг сонсохын хэрэг алга.

-Флоринда, чи бас долигноод сурчихжээ.

-Хаанаас даа, авхай минь, би тийм үг хэлээгүй, нэгийг ч цухуйлгаагүй байна шүү дээ. танд тангараглая! Архад нарт тангараглая!

Луизаг ганц удаа ч бол харсан хүнд негр хүүхэн тэр тангараг дэмий илүү санагдсан билээ. Луиза Пойндшкетшрыг үзэсгэлэнтэй сайхан гэж хэлэх нь зөвхөн түүний хүрээлэн байгаа олонийтийн ерөнхий ойлголтыг баталж байгаа хэрэг юм. хэн бугайг ч анх харахад нь гайхуулах Лиузын үзэсгэлэн гоог үгээр хэлэхэд ч хэцүү. Үзгээр түүний үзэсгэлэн гаргахын аргагүй, тэр ч бүү хэл ямар ч уран зураач хүн түүний нүдэнд гэрэлтэж байгаа сацарсан туяаг дүрслэн зөвхөн бүдгээр дүрслэн үзүүлнэ.

Эмэгтэй хүний үзэсгэлэн гоогий дээд гэмээр, гэхдээ грекийн ямр ч бурхан түүнтэй адилгүй бөгөөд учир нь жирийн л хүнд илүү зохимжтой сайхан царайтай бүсгүй юм.

Тэр охин Флориндагийн үнэхээр батлан хэлсэн үгийн хариуд өршөөнгүйгээр инээмсэглэв. Гэвч тэр инээмсэглэлд нь эргэлзмээр юм огт байсангүй. Залуу креол хүүхэн өөрийгөө сайхан гэж магтуулахын хэрэггүй байжээ. Луиза өөрийн үзэсгэлэнтэнг мэддэг бөгөөд, шивэгчин нь түүний үсийг самнан хувцаслуулдаг толиныхоо өмнө зогсоод өөрийгөө ширтэн хардаг байлаа.

Негр хүүхний магтан хэлсэн үг түүний сэтгэлийг хавын нурууг эрхүүлж, илэхээс ихгүйгээр хөдөлөөнгүй бөгөөд тэр авхай дахин бодол санаашраолд оров. Энэ байдлаас нь шивэгчингийн яриа гарглаа.

Энэ нь Флориндыг тэвдүүлсэнгүй , харин ч ярьсан хэвээр. Ямарч гэсэн учры нь олчих юмсан гэдэг нууц түүнийг зовоогоод байгаа бололтой.

Негр хүүхэн өөрөө өөртэйгөө ярьж байгаа юм шиг үгээ үргэлжлүүлэн:

-Ээ дээ, хэрэв Флоринда завуу авхай зөвхөн тэн хагаёын дайтай сайхан байдагсан бол хэнийг ч тоохгүй, хэнийг ч мөрөөдөн санаашрахгүй байсан даа гэв.

-Санаашрах гэнээ? Чи юу гэж хэлэх гэж байна? гэж негр хүүхний шүгэнд гайхсан луиза асуув.

-Луи авхай минь, Флоринда чинь таны боддог шиг тийм тэнэг мангуу амьтан биш, таныг нэг газа чимээгүй сууга гүнээ бодол болоод л ингэтлээ санаа алдаад байдгий чинв аль хэдийн ажигласан. Биднийг луизанд байхад та огт ингэдэггүй байсан сан.

-Флоринда ! Би чамайг солиорч байна уу, аль эсхүл луизанд байхдаа солиорчихоо юмуу гэж айж байна. Чамд эндхийн газар таарахгүй байх шиг байна аа даа?

Луи авхай та энэ үгийг ёстой өөрөөсөө л асуумаар юм даа. Намайг ингэж өөртэйгээ хамаагүй ярилаа гэж битгий уурлаарай. Флоринда таны шивэгчин боловч, төрмөн дүү шигээ л хайрладаг. Таныг санаа алдахаар зовж гүйцэх юм. Та надад уурлахгүй биз дээ?

-Хаанаас даа, юу боллоо гэж би чамд уурлах юм бээ? Би уурлахгүй. Харин чи л шал худлаа юм ярьж байна. Чиний үзсэн, дуулсан бүхэн цөм санаанаас зохиосон зүйлс байна. Одоо баргий нь танихгүй зуу шахам зочин хүлээж авах гэж байхад бодол болж суухбн зав алдга. Юунд ч бодол болохбилээ. Бас тэгээд залуу эзэд, офицерууд ирнэ. Миний үс чамд байсансан бол чи тэднийг сөгдүүлсэнгүй. Ха-Ха-Ха! Над тэдний нэгний нь ч сэтгэлийг татах хүсэл алга, Тэгэхээр наад үсээ хурдхан шиг самнаадах

-Ээш, Луи авхай та үнэнээсээ хэлж байна уу? Энэ дээдсүүдийн нэг ч танд тоогдохгүй гэнээ ? Жигтэйхэн сайхансайхан эрчүүл ирнэ шүү дээ! Нөгөө залуу эзэн, бас өнөөх хоёр сайхан офицер ... Тэднийг мэдэж байгаа биз дээ? Тэд таныг тун их шохоорхоод байсан. Эрхэм авхай та тэдний хэний ч тухй санаашрахгүй гэж үнэн хэлж байна уу? гэж негр хүүхэн улам цайм шхоорхон асуув.

-Дахиад л өнөөх санаашрах руугаа орчихлоо! Гэж хэлээд луизад зориудаар инээмсэглэж-За,за боль Флоринада, бид цаг алдаж байна. Манайд том хүлээн авалдт болно. Тэгэхлээр гэрийн эзэгтэйн буурь суурьтай байхын тул жаахан тайвширахад минь дор хаяж хагас цаг хэрэгтэй гэдгийг битгий мартаарай гэв.

-Луи авхай битгий санаа зов. Бүү мэгд! Таны өмсгөлийг өмгөсөхд амархан. Танд ямарч хуюцас зохино. Тэр ч байтугай тарианы газар ажил хийдэг эмэгтэй хүний жирийн хувцас өмссөн ч гэсэн та мөн л тэргүүн зэргийн гоё сйхан хэвээрээ байна.

-Флоринда, чи ер нв хүнийг зусардаж сурчихжээ.

Чамд надаас нэг юм хэрэгтэй болоод байнаа даа гэж би сэжиглээд байна. Плуту, та хоёрыг

эвлэрүүлж өгөөчгэж хүсч байгаа юм биш биз дээ!

-Үгүй авхай минь Плуто хэзээч миний найу байгаагүй болохоосоо өнгөрсөн. тэр чинь биднийг өнөөх зэрлэг хар талд шуурганд дайралдаж байхад айж, хулчийж байсан шүү дээ! Ээш, Луи авхай, тэгэхэд хэрэв нөгөө хээр морьтой, дэгжин залуу ирээгүйсэн бол бид яаж ч чадахгүй байсан шүү!

-Хэрэв тэр залуу ирээгүй бол хонгор Флоринда минь, бидний хэн маань ч энд байхгүй байх байсан юм.

-Ээш авхай минь! Тэр мөн ч сайхан эр шүү дээ! Царай зүс нь таны санаанд орж байга биз? Өтгөн үс нь минийх шиг жахан буржгар болохоос яг л таных шиг өнгөтэйхөн. Ер нь тэгээд өнөөх залуу эзэн юмуу, офицертэй зүйрлүүлэх юм алга. _ Тэдний аль нь ч бараадахгүй. Негрүүд түүнийг цагаанарьстан тэнүүлч гэвэл гэж л байн. Ингэлээ гээд яах вэ дээ? Тэрүүн шиг сайхан эр дуртай хүүхнэ санаа алдуулна даа. Мөрөөдүүштэй ч эр билээ! гэв.

Энэ хүртэл залуу креол хүүхэн сэтгэл тайван байв.

Хойшид ч тайван бйхыг босон боловч чадсангүй.

Флоринда зориуд буюу санамсаргүй алин боловч залуу хатагтайн маш эмзэг нууц сэтгэлийг хөндчихжээ.

Луиза өөрийн нууцыг зарцдаа ч гэсэн илчлэхийг хүссэнгүй. харин тэр авхай чухам энэ агшинд хашааны тэндээс хүний чанга дуу гарахыг сонсоод баярлажээ. Тэр дуу бол гоёж гоодолтоо түргэн дуусгахыг зэрэгцээгээр цааш үргэлжүүлэх дургүй байгаа яриагаа төгсгөхөд нь Луизад тун сайхан шалтаг боллоо.

XI. Санамсаргүй гийчин

-Хөөе хар золигоо , эзэн чинь хаана байна?

-Эрхэм минь, Пойндекстер гуай юу? хөгшин нь үү? Залуу нь уу?

-Залуугаар нь би яах юм бэ? Би Пойндекстер гуайг асууж байна. тэр хаана байна?

-Тийм тийм эрхэх минь, тэр хоёр гэртээ бий. үгүй тэгэхдээ өвгөн эзэн , залуу Генри гуай хоёр хоёулаа одоогэртээ байхгүй. тэр хоёр доор горхины тэнд хашаа хороо яаж барьж байгааг харж байгаа. Та тэнд хоёуланттай нь дайралдаж болно.

-Доошоо горхины тэнд гэнээ ? Эндээс хол уу? чи юү гэж бодож байна.

-Ээш эрхэм минь, Их л хол доо, гурав дөрвөн бээр гэж негр би бодож байна.

-Гурав, дөрвөн бээр гэнээ? Тэгвэл чи чинь шал тэнэг амьтан байна дээ! Пойндекстер гуай эдлэн газар тийм их хэмжээтэй гэж үү? Уг нь тэр чинь бусдын газар дээр хашаа барьчихаар хүн биш л байлтайсан.Тэгээд чи түүнийг хэзээ ирнэ гэж бодож байгаагаа сайн хэлээдэх. Чамайг мэдэх ёстой гэж бодож байна, зөв үү?

-Тэр хоёр одоохон ирэх ёстой. Колхаун гуай ч бас ирнэ. Ээш, манай өнөөдөр их найр болно гэдгийг та гал зуухнаас гарч байгаа үнэр танараар мэдэж болно. тэгээд бас шарсан хайрсан, хуурсан гээд л дутуу хөтүү юмгүй шүү! Миссипд хийдгээс доргүй найр хийх болно ! Миссипид хийдгээс доргүй найр хийх болно! Пойндекстер гуай урт наслаг

Ёстой хэрэгтэй өвгөн дөө, танихгүй хүн минь. Таныг яагаад баярт уриагүй юм бол? Эсвэл та хөгшин эзний анд биш юм болов уу?

-Чамайг чөтгөр аваачаасай билээ. хар золиг минь намайг танихгнүй байга юм биш биз дээ, чи Би наад хөө шиг царайгий чинь хараад л чамайг таньж байна.

-Бурхан минь!Манай хуучин эдлэнд буга, харуул авчирдаг байсан Стумп ночн байх шив дээ. Үнэндээ негр чиньв таныг яг өчигдөр харсан юм шигсанаж байна. Та намайг үүгээр мэдээжээр намайг байхгүй байхад ирээ биз дээ. Би одоо хөтөч хийж байна. Эзний охин, гоо сайхан Луизиан сүүхийг барьж байгаа. Бурхан минь, түүнээс илүү хаанас чолохгүй. Флоринда түүний чигчийнд ч хүрэгүй гэж улс ярилцах юм... За Стумп гуай минь жаахан хүлээчих, эзэн одоохон хүрээд ирнэ.

-За яахав, хүлээхээс биш гэж анчин мориноос яарамгүй буунгаа хэлээд негр цулбуураа өгөнгөө-Хэдэн эрдэнэ шиш идүүлчихээрэй. танай эзэнд зүтгэх гэж хорь гаран бээрийг цахилга шиг л довтолж ирлээ гэв.

-Өө энэ чинь, Зебулон Стумп гуай, та байсан юм уу? гэ эелдэгхэн дуу сонсдоод, тавцан дээр Луиза Пойндекстер гарч ирлээ. тэгээд тэр авхай хайсны дэргэд очиж үгээ үргэлжүүлэн.

-Би тантай ийм хурдан уулзана гэж сансангүй боловч таныг ирж гэж бодлоо. Би таныг хол юманд явчихсан байх гэж бодсон юм. Гэвч би тантай энд уулзсандаа их баярлаж байна. Таны ирсэнд аав Гшри хоёр их баярлана даа? Плутто, чи Хло руу очоод Стумп гуайг пайдах юу байна асуугаад ир... Та рхоол идээгүй биз дээ ? хамаг юм чинь шороо тоос болчихоод, та холоос иржээ дээ? ... Флоринда чи гал тогоонд бушуухан гүйж очоод уух юм аваад ир. Өнөөдөр ийм халуун өпөр Стумп гуайн ам их цангасан байх ёстой... Та протейн, ерри , кларетын алины нь уумаар байна? аа тийм би одоо санала. Та чинь Моногахелийн виски архи уудаг хүн шүү дээ. Манай эндээс олдох байхаа. Флоринда гүйгээд, бушуухан олоод ир... Сиумп гуай тавцан дээр гарч суу л даа. та аавтай уулзах гээ юу! Аав ингэхийгээд ирэх ёстой. харин би аавыг иртэл таныг саатуулахыг хичээж байя гэв.

Хэрэв тэр охин яриагаа эрт төгсгөчихсөн ч гэсэн хариугий нь шууд сонсохгүй байсан билээ. Одоо ч гэсэн Стумпийг ярианд оролцохоос өмнө хэдэн хором өнгөрөв. тэр өвгөн Луизаас нүд салгалгүй ширтэн гайхаж бахадсанлдаа хэлгүй болчихсон юм шиг зогсоно.

-Луиза авхай минь, хурмаст хүчтэйеэ! Гэж Стумп эцэст нь хэлээд -Би Миссипт таныгхараад хорвоод хосгүй сайхан хүүхэн гэж бодож байж билээ. гэтэл одоо зөвхөн хорвоод төдийгүй тэнгэрт ч гэсэн хамгийн сайхан хүүхэн юм гэдэгт итгэж байна цгэв.

Хөгшин өвгөн дөвийлгөсөнгүй. Залуу креол хүүхний саяхан самнасан гээг нь үзэсгэлэнтэйе гялалзаж хүйтэн усаар угаасан хацар нь тодхон улайж байв.

Индиан сэрзгэр цагаан даавуу бошинз өмссөн гол шиг сайхан Луиза Пойндекстер үнэхээр ер бишийн үзэсгэлэн төгөлдөр ажээ.

-Тэнгэр минь ! гэж анчин дахин дуу алдаад- Цагтаа би сайхан хүүхнүүдийг харж л явла. Муу хөгшин маань ч гэсэн анх Кентукед танилцахад минь муугүй л байсан хөөрхий минь. гэвч тэд бүгдээрэнгийн гоо сайхнышг нийлүүлээ гэхэд тань шиг сахиусан тэнгэрийн мянганы нэгд ч хүрэхгүй гэж хэлэх байна гэв.

-Өө Стумп гуайминь, би танаас ийм үг дуулна гэж санасангүй. техас таныг усарч ярианд сургацхжээ.

хэрэв энэ чигээрээ байх юм бол урьдынхаа үнэнч хүн гэдэг нэрээ алдчих вий гэж би их айж байна. Би таныг ийм ярианыхаа дараа завал юм уудаг байх гэж бодож байна... Хөөе чи юунд зогсоод байна? Флоринд, бушуулаач! Та виски уумаар байна гэл үү?

-Би тэгж хэлээгүй ч гэсэн бодож л байна. Ер нь тэгээд хэлсэн бодсон хоёр ч бараг дүндээ дүн л дээ. За авхай минь би гадаадпын ямар ч архинаас нутгийн архиа илүүд үздэг хүн: Энэ талаар техас намайг өөрчлөөгүй шүү.

-Стумп гуай та архинда усхольж уух уу? гэж Флоринда тэхий дундуураа архитай шилэн аяга авчирангаа асуув.

-Үгүй хүү минь! Ус холиод яах вэ? Өнөөдөржингөө л ус уухаараа нэг боллоо. Би өглөөнөөс аваад ганц ч дусал юм уруулдаа хргэсэнгүй.

-Эрхэм Стумп гуай, вискийг тэгж уухын аргагүй биз дээ. хамаг ам хамры чинь түлчихнэ шүү дээ. Жаахан бурам юмуу, чихэр аваач дээ.

-Чанары нь алдагдуулчихаад яана. Виски гэдэг бол ялангуяа таныг харснаас чинь хойш тэр дарууллагүйгээр ма сайхан ундаа байгаа юм. Вискийг юм холихгүй дангаар ууж чадах эсэхий минь та одоо үзнэ. Аль вэ туршаад үзье!

Анчин өвгөн аягыг уруулдаа хүргэн гурав дөрөвхөн балгаж хоосолчихоод флориндад өглөө. Чанга тамшаалт нь залуу креол хүүхэн шивэгчин хоёрын өөрийн эрхгүй гайхан дуугарсан дууг бараг дарав.

-Та нар миний ам хамрыг түлэгдчихнэ гэл үү? Ярихгүй шүү. Ам зайлсан төдий л боллоо. одоо би аавтай чинь бидэрт мустангийн тухай ярихад бэлэн байна.

-Ээ нээрээ тийм үү? Би ор тас мартчихаж... үгүй бас ч тийм биш. Би зүгээр л таныг тэрний тухай харахан мэдэж амжаагүй байх гэж бодсон юм. тэр сайхан амьтны тухай ямар нэг сураг ажиг байна уу?

-Сайхан амьтан шүү? Үнэхээр сайхан.

-Та сүүлчийн удаа манайд байснаасаа хойш тэр мустангийн тухай ямар нэг шинэ юм сонсоогүй биз?

-Сонсох нь бүү хэл хараад, гараа хргэж үзсэн

-Нээрэн үү?

-Мустанг баригдсан.

-Тийм үү? Яасан сайхан хэрэг вэ! Би тэр сайхан амьтныг үзвэл ямар их баярлаж, түүнийг унаад давхивал утай сайхан байх болоо! Техаст ирснээсээ хойш ганц ч дөмөг морьтой болсонгүй. Аав тэр мустангийг над ямар ч үнээр хамаагүй авч өгн гэ амласан юм. тэгээд ямар азтай хүн түүнийг олоо вэ?

-Та хэн түүнийг бариа вэ гэж асуух гээ юу?

-Тийм, тийм хэн бэ?

-Мустангерл барилгүй яах вэ?

-Мустангер гэнээ?

-Тиймээ, түүнтэй эгнэх хүн энэ нутагт даар байхгүй. морь унах, мустанг бугуйлдахдаа хувьд ямар ч аавын хүү түүнд шон байхгүй. Тэгээд бас өөрсдийгөө мексик гэж онгирно шүү. Тэр залуу шиг морийг гаргууд эдэлдэг мексик хүнийг нэгийг ч үзсэнгүй. Гэхдээ түүнд мексикийн дусал ч цус байхгүй гэдгийг бөндгөрөөрөө андгайлъя.

-Тэр хүний нэрийг хэн гэдэг юм бэ?

-Нэрийг нь уу? Би түүний овгий нь ер сонсоогүй. Харин нэрий нь Морис гэдэг юм. Цайзын орчимд Морис мустангер гэж алдаршсан хүн.

Анч өвгөн Луизагийн сүүлчийн асуултанд илэрсэн гоц сонирхолы нь мэдэхээргүй тийм анзаараагүй хүн байв. Бас өвгөний хариу үгийг сонсоод тэр охины хацар хэрхэн гүйн улайсныг ч ажигласангүй.

Гэвч луизагийн тэр байдлыг Флоринда ажиглаж амжжээ.

-Ээ,Луи авхай, хар талын дунд биднийг аварсан өнөөх зоригтой залуу ноёныг тэгж нэрлэдэг шүү дээ! гэж негр хүүхэн дуу алан хэлэв.

-Тиймээ гээд анч өвгөн залуу бүсгүйг хариу хэлэхээс аварч Тэр хүн дөнгөж өнөө өгөөхөн энэ тухай налдад ярьман. Биднийг мордохоос өмнөхөн ярьсан. Тэр хүн биеэрээ мөн дөө. Тэр хүн чинь л бидэрт мустанг барьжээ.Одоо нааша ирж яваа, бидэрт мустангаас гадна арав гаруй адуу тууж яваа, бүрий болохоос өмнө танайд ирэх ёстой. Би бидэрт мустангийн тухай аавд чинь урьдчилан мэдэгдэх гэж муу хөгшин гүүгээрээ түрүүлж ирлээ. Луи авхай минь, би таны төлөө ингэж яваа юм шүү дээ. Бидэрт мустангийн тухай ярихад хэр их сонирхосон чинь санаж байна. Одоо санаа зоволтгүй бүх юм номоороо болно гэдэгт хөгшин Зеб Стумп дааж байна.

-Стумп гуай, та их сайхан сэтгэлтэй хүн юм! Би танд маш их баярлаж байна! Та одоо намайг уучлаарай! Би таныг түрхэн зуур орхиж явах хэрэг боллоо.

Аав удахгүй ирнэ.Манайд өнөөдөр цайллага болох гэж байгаа. Би юм төхөөрүүлэх ёстой. Флоринда Стцмп гуайд зоог барь. Бушуухан юм бэлдүүлээд ... За тэгээд Стумп гуайпд зоог барь гэж Луиза анчин руу дөнхөж, намуухан дуугаар үргэлжүүлэн-Хэрэв тэр залуу ... залуу женгельмен энд зочид байхад ирвэл мэдээжэ тэднийг танихгүй юм чинь та үүнийг зочлуулж үзээрэй:. Манай гонхон дээр архи, дэргэд нь зууш бий. та миний ярьж байгаа ойлгож байна уу, Стумп гуай?

-Луи авхай минь, хэрэв би ямар нэг юм ойлгож байгаа бол намайг чөтгөр аваг!Би уух идэх юмны тухай бол ойлгож байна. харин ямар залуу женгельмени тухай яриад байгаагий чинь мэдэхгүй юм.

-Та мэдэлгүй яах вэ? Өнөөх мустанг авчрах залуу.

-А-А Морис мустангер! Та түүний тухай ярьсан байж таарна л даа. Та түүнийг женгельмен гэсэн чинь яг онож , хэдийгээр ямар нэг мустангерийг тэгж дуудах нь ховор ч гэлээ, энэ залуу бол морь хөөдөг анячин, ирланд ч гэлээ гарал, төрөд хүмүүжил, байдлаараа ёстой тэр нэрэнд тохирох хүн.

Хөгшин анчны Морис мустангерийн тухайд хэлж байгаа үгийг сонсоод Луиза Пойндекстерийн нүд баярласандаа гялалзанбайв.

Ямар нэг юманд эргэлзсэн боолтой Зуб яриагаа үргэлжүүлэн.

-Харин тэр залуу өөр хүнээр дамжуулан зочилубол гомдчихно гэдгийг би танд нөхөрсөг ёсоор урьдчилан сануулах ёстой. тэрчинь миссипт бидний ярьдаг байснаар "Пойндекстер шиг бардам" хүн шүү. Намайг ингэж хэлсэнд уучларй. Энэ гэр бүлийн хамгийн бардам нь биш гэсэн хамгийн гоо сайханхүн Пойндекстер авхайтай ярьж байгаагаа мартчихаж.

-Өө Стумп гуай, та надад юу л дуртайгаа ярьж болно. Би танд, манай эрхэм аваргад , ер гомдохгүй.

-Мисс Луиз таныг гомдоомоор юм хэлэх хүн гэж хаана байх вэ?

-Баярлалаа, баярлалаа. Таны йсайхан сэтгэл, үнэнч занг би мэднэ. Яаж мэдэх вэ, хэзээ нэгэн цагт ... гэж шийдвэргүйхэн хэлснээ таны тусламж надад хэрэг болж магадгүй гэв.

-Хэзээ дуртай цагт тань би бэлхэн гэдгээ баталъя.

-Баярлалаа! Мянгантаа баярлалаа.. харин та өөр хүнээр зочлуулах тухай ярив уу даа?

-Тэгсээн

-Та юу хэлэх гэсэн юм бол?

-Би танай гэрт Морис мустангер архи уу гэх буюу хоол идгэх нь огт нэмэргүй болохгүй гэж хэлэх гэсэн юм. Хэрэв аавчинв л өөрөө эс зочилбол тэр юунд ч гар хүрэлгүй яваад өгнө. Лумза минь тэр хүн бол гал зуух руу явуулчихаж болдог улсын нэг биш гэдгийг ойлгоорой.

Залуу креол хүүхэн шууд хариу хэлэлгүй, ямар нэгэн юмны тухай бодлогширсон мэт болоод.

-Зүгээр Стумп гуай, энэ талаар та битгий зов. Та түүнийг битгий зочлоорой. харин ирэхээр нь л надад хэлээрэй. хэрэв яг хоолны үеэр ирчихвэл жахан саатуулж үзээрэй. Тэр хүн ч гарч ирэхгүйг ойлгоно. Тэгнэ биз? гэж эцэст ньхэлэх дууны өнгөөр эргэлзсэн б айдал нь ала болжээ гэдгийг тааварлаж болохоор байв.

-Таныг гуйж байгаас хойш тэгэлгүй яахав.

-Баярлалаа. харин ирэхийг нь заавал надад мэдэгдээрэй. Би өөрөө түүнд зууш баръя.

-Хэрэв та өөрөө зууш барьж түүнийг юм идэх дургүй болгочихно гэж би айж байна. Тэр ч байтугай гуриатсанчоно ч гэсэн таныг харж шингэн дуугий чинь сонсоод хоолд идэх хүсэлгүй болчихно. Би энд ирэхдээ бүхэл цацагт хяруул түүхийгээр нь залгичихмаар их өлсөж байсан. Гэтэл одоо тийм юманд хэрэг алга. Би одоо бүтэн сар ч мах идэхгүй байж чадна.

Хариуд нь Луиза тачигнатал инээж, хашааны нөгөө өнцөг рүү Флоринда царыбарьчихсан гарч ирж яваа гал зуухны халга руу Арас нь Плутон улам ч их юмтай цар барьжээ.

-Ээ, эрхэм аврага минь! гэж хөхүүнээр зэмлэн хэлээд-Таныг тийм амархан хоолонд дургүй

болчихно гэдэгт би итгэхгүй байна... за тэр, Плутон Флоринда хоёр айсуу! Тэдний авчирч байгаа юмс надас илүү зугаатай ханьв болох байв. Ийм болохоор таныг орхиё Баяртай Зеб гуай! Баяртай! Гэж ихэлд баясгалантайгаар хэлэв.

Лумза сэтгэл хөдлөн сэмхэн алхсаар тавцангаас бууж явав. Тэгээд тасалгаандаа орж ирээд дахин гүн бодолд дарагдав. "Энэ бол миний зол заяа, үүнийг би мэдэрч байна. тэр зол каяа, угтан очиход тун хэцүү байна. гэвч түүнээс зайлах чадал алга. Зайлж чадах ч үгүй, зайлахыг ч хүсэх үгүй!" гэж амандаа шивэгнэв.

ХII. Эмнэг мустанг сургав

Мексик байшингийн хамгийн тааламжтай хэсгийг асотей гэж нэрлэдэг. Түүний шал нь байшингийн дээвэр болж, дээвэр нь дээрх хөх тэнгэр болдог. Цаг агаарын байдал өлзийтэй сайхан байдаг болохоор асотейг зочдын өрөөнөөс илүүд үзнэ.

Үдийн хоолноос хойш жаргаж байгаа наран Оризаб, Попокатепетель, Талук уулсын цаст оргилуудыг улбар туяагаар гийгүүлэх үед, гоё сайхан хувцастай мексик залуу эр үзэсгэлэн гоо авхайн өмнө хээнцэрлэж, янжуурынха утааг нүүр өөд нь баагиулна. Хар нүдтэй авхай хайр дурлалынхаа үгийг номхон дуулгавартай сонсоно. Нээрээ сонсож, байна уу? Сонсоогүй ч байж магадгүй, харин дурласан залуугийнхаа суудаг алсмын шилтгээн тийш сэтгэл уйтгарласан харж байгаа ч байж болох юм.

Байшингийн дээвэр дээр гарч суугаад үдшийн бүрийг өнгөрүүлэх нь мексик байшинд суугаа хүн бүхний заншил билээ. Луизианы газрын эзний гэр бүл энэ аятайхан уламжлалаас татгалзахгүй нь зүйн хэрэг.

Тэгээд ч энэ орой хоол идэж ширээ хоосорсны дараа зрочид гэрийн эздийн хамт зочдын өрөөнд орохын оронд байшингийн дээвэр дээр гарцгаалаа. Каса-Дель-Корво асотей дээр хэзээ ч гэсэн цугларч байгаагүй болов уу гэмээр тийм хөгжилтэй , сайхан олныг шингээх нарны ташуу сацарсан туяа гийгүүлж байв. Дээр үед түрүүчийн нь эзэн нутаг орныхоо тайж нарыг цуглуулаад байхад ч хүртэл өнөө оройных шиг ийм сайхан хүүхэн, ийм цогтой эрчүүд байсангүй.

Вудли Пойндекстерыг шинэ сууринд нүүж ирсний нь тохиолдуулж баяр хүргэхээр Каса-Дель—Корво ирсэн зочдын дотор зөвхөн Леоны суурингийнхаа төдийгүй, тэрнээс хол газраас ирсэн хүмүүс байв. тэнд Гонсалес , Кастровилаас ирсэн зочид , бас Сан-Антониос эзний хуучин найзууд нь ирсэн байв. Тэд бас л Пойндекстер шиг баруун өмнөд Техаст нүүж ирсэн бөгөөд олон хүн энэ ёслолд оролцохоор зуу гаруй бээр газар мориор явж иржээ.

Эзэн найрын зохих ёсоор сайхан хийхийн тулд хүч хөрөнгө хайрласангүй. Цайзаас уригдаж ирsmэн офицеруудын ёслолын гялалзсан хувцас, цэргийн хөгжим, Каса-Дель-Корво зоорийн эртний сайхан дарсууд энэ бүхэн бол тэр найрыг урьд өмнө Леоны эрэг хавьд дулдаагүй тийм нижгэр сайхан болгожээ.

Гэвч олны дундаас онцлом сайхан нь эзний үзэсгэлэн гоогийн тухай алдар нь тэргүүн гоо хүүхэн гэж алдаршсан Луизианаас нь ирэхийн өмнө Техаст цууриатжээ. гэрийн залуу эзэгтэй уруул дээрээ хатан хааны инээд тодруулан зочдын дунд энд ч нэг гарч, тэнд нь нэг гарч явав.

Олон хүний нүд түүний зүг ширтэж , зарим нь гайханшагширч , зарим нь атаархан харна.

Гэвч тэр өөрөө аз жаргалтай байв уу?

Энэ асуулт хачин, бараг утгагүй юм шиг сангдаж магадгүй, Зарим нь аль хэдийнээс дурласан, зарим нь дурлаж эхэлж байгаа биширч найз нараараа хүрээлүүлчихээд тэр бүсгүй жаргалгүй ыбайж болох уу, даа? тэдний дугд залуу эзэд , өмгөөлөгч төрий зүтгэлтэнгүүд, зэр зэмсгээ

зүүсэн юм уу дөнгөж саяхан авчихаад байгаа Марсын хүүхдүүд байв. Креол бүсгүйн, тэр дундуу Луиза Пойндекстерын аашийг мэддэггүй гадны хүн л энэ асуултыг тавьж болхо юм.

Орло сайхан зочдын дунд нэг тэр хүүхнийг хэнээс чя илүү ажиглаж хөдлөх бүрий нь харж байв.

Тэр бол Луизагийн үеэл ах Кассий колхаун гэгч билээ. Луиза хашаа ч явсан түүний хараанаас эс зайлна. Гэхдээ яг сүүдэр шиг нь ойртон очихгүй сэмхэн нэг дээш гарч, нэг доош бууж, буланд очиж албаар жишимгүй дүр үзүүлэн зогсоно. Гэвч үзэсгэлэнт креол хүүхнээс тандуул шиг агшин зуур ч нүд салгахгүй байлаа.

Өөрий нь учир зүггүй магтаж, элдвийгн юм ярьж инээдий ньхүргэж байгаа харчуулыг өөдөөс тэр хүүхэн юу гэ хэлж байгааг нь Колхаун анзаарахгүй байгаа нь гайхалтай. тэр ч байтцугай морин цэргийн албаны дарг Генкокийн шаргуухан эргүүлэх нь ч гэсэн Колхауны сэтгэлийг зоюоохгүй байгаа бололтой. Энэ бүгдийг хэний ч сонирхол татмааргүй яриа чагнаж байгаа юм шиг л ажиггүй сонсоно.

Тэгээд зөвхөнбүх хүн аостей гарах үед Колхаун өөрийн илчилжээ. Хайсны тийш цувран очиж, алсын бараа харж байгаа хүмүүс Луизаг ширтэн харж байсан Колхауны тэр шаргуу, соримол харцыг анзаарахгүй өнгөрч хаанаас чадах аж. Ойрхон зогсч буй зочил ганц хацры нь бус, бас хөдөлгөөнийг нь харж байв.

Хэдэн минути тутамд залуу эмэгтнй хашлага налжирээд л ямар нэг юм хайх мэт талын дээгүү тэнгэрийн хаяаг ширтэнэ.

Луиза яагад ингээд байгааг хэнч мэдээгүй бөгөөд тэр явдал Колхаунаас өөр хэний ч сэтгэлийг хөндсөнгүй. Колхаунд бол энэ талар өөрийн нь тамлан зовоож байга сэжиглэлтэй бодол байса ажээ.

Тэгээд тал нутгийн дунд, шингэх нарны алтан туяа дотор ямарнэг хэсэг юмны бараа харагдахад асотей дээрээс харцгааж байсан хүмүс хэсэгш адуу ойртож айсуыг төдөлгүй ялган таньжээ. харин тууж яваа хэдэн морины манлайд хэн яваагш ахмад тамаглан мэдсэндээ огт эргэлзсэнгүй.

Харин зочид адуун сүргийг олж харахаас бүр өмнө Луиза тэнгэрийн хаяанд гарсан тэдний тоосыг ажиглан харжээ. Тэр нь үнэндээ үл ажиглагдам өчүүхэн жижиг байсан, тул адуун сүрэг гарад ирэхийг тэсч ядан хүлээж байсан хүн л түүнийг олж харж чадах байлаа.

Энэ мөчөөс эхлэн залуу креол бүсгүй найз бүсгүйчүүлтэй элдэв хөөрөлдөн, айсуы ява тоосыг сэмхэн харж, тэр нь юу болохыг тааварлан , зөвхөн өөрөө л энэ тухай мэдэж байгаа гэж бодож байв.

-Зэрлэгадуунууд байна! гэж цайзын дарга хошууч дурангаар харж хэлээд дахин дурандаж-Тэднийг нэг хүн хөтөлж явна. _ Аа! Одоо харлаа. Тэр чинь Морис мустангер байна. Тэр замдаа бидэнд морь авчирч өгдөг юм. Пойндекстер гуай, шууд наашаа ирж явах шиг байна шүү.

-Хэрэв таны хэлдэг залуу мөн бол наашаа ирэх ёстой гэж Каса-Дель- Корвын эзэн хариулаад -Надад хорь гучин морь авчирч өгнө гэсэн юм ... тэднийгээ аваад айсцй бололтой. Тиймээ, бид эндүүрээгүй шүү шиг байна гэж дурангаар хараад хэлэв.

-Тэр мөн байна ! Тэр морьтой хүн Морис Жеральд мөн гэж эзний хүү хэлэв.

Эзний охин ч мөн ингэж хэлж чадах байсан боловч энэ болж байгаа явдлыг өчүүхэн ч сонирхсон дүр үзүүлсэнгүй. Үеэл ах нь хилэнв харц өөөр дээр нь төөнөх мэт ширтэж ббайгааг тэр охин ажиглажээ.

Тэгтэл сүрэг адуу ойртон ирлээ. Түрүүнд нь нээрэн Морис мустангер явж байв. тэр, бидэрт мустангийгш бугуйлгаар оосорлон хөтөлжээ.

Ер бусын байдлаас хэрд хийсэн мустангийг байшингийн дэргэд авчрахад:

-Ямар сайхан амьтан бэ? гэж хэд хэдэн хүн дуу алдав.

-Энэ сайхан амьтныг чинь бууж хардаг хэрэг гэж хөхүүн сэтгэлтэй хошуучийн эхнэр хэлээд - Цөмөөрөө бууцгаавал яана? Пойндекстер авхай та юу гэж бодож байна? гэв.

-Хэрэв хүсч байгаа бол тэгэлгүй яахав? гэх залуу хатагтайн үг бусад олны шуугиан дундаас сонсогдов.

-Бууцгаая, алийв бууцгаая.

Хатад хошуучийн эхнэрийг дагаж чулуун шатаар бууцгаахад эрэгтэйёүүд тэдний хойноос явлаа. хэдэгн минут өнгөрөхөд мориноосоо бугаагүй байсан Морис мустангер баригдсан мустангтайгаа хамт гоёмсог олны дунд зогсож байв.

Генри Пойндекстер бүхний өмнө гарч ирээд мустангер нөхөрсгөөр талархар илэрхийлэв.

Луиза Мористой зөвхөн мэхэсхийн төдий мэндлээд. Адууны наймаачинд илүү анхаарал тавин, өөриймсөгөөр улам дотно мэндэлж болох байсан ч тэр нь олонд таалагдахгүйсэн билээ.

Хамаг хатдын дундаас ганцхан хошуучийн эхнэр л мустангерийн эелдгээр мэндэлсэн боловч дууны өнгө үл тоомсорлосон шинж илэрхий байв. талын салхин ирланд залуугийн царайг улаан болгожээ. Цамцны нь задгай энгэрээр наранд шарагдаж хүрэнтсэн лужир хүзүү цухуйж, залуу эрийн цог үзэсгэлэнг илэрхийлнэ.

Бүх байдлаараа нь түүний чадал, тэсвэртэйг харуулж байв. Цайзын даргын зээ , сайхан хүүхэн тэр залууг хараад бахархан инээжээ. Бас тэр даргын эхнэр Морис руу харсан гэж ярьцгаадаг боловч тэр нь эмчийн эхнэр бөгөөд цайзын хамгйн ховч эмийн тараасан гүтэглэг байжээ.

Пойндекстер, баригдсан мустангийг хараад:

-Энэ чинь, Зеб Сиумп гуайн надад хэлсэн өнөөх гүү мөн гэдэгт маргах юм алга гэж хэлэв.

-Тиймээ, тэр чинь дүрээрээ байж байна гэ анч өвгөн Морист туслахаар дэргэд нь очингуут хэлээд Пойндекстер гуай минь, яриагүй үнэн. Тэр гүү чинь мөн гэдэгт итгэж болно. Энэ залуу намайг өөртэйгөө ярилцахаас өмнө бариад авсан байсан билээ. тэгсэн ч гэсэн цагт нь амжуулсан миь сайн боллоо. Эн сайхан амьтан өөр хүний гарт орчихож мэдэх байлаа. тэгсэн бол Луиза авхай их гомдоох байсан юм гэв.

-Нээрээ тийм шүү, Стумп гуай. Та миний төлөө их чармайжээ. таны энэ сайхан ачийг хэзээ нэгэн цагт хариулж чаддаг болов уу гэдгээ үнэндээ мэдэхгүй байна гэж Луиза хэлэв.

-Ач хариулна гэнэ шүү! та надад ямар сайн юм хийх гэж хүсч байгаага л хэлэх гэж байгаа юм уу? Энэ ч танд амархан хэрэг. Би тал дундуур, л давхихаас өөр онц юм хийгээгүй. Ердөө л энэ дээ. харин тань шиг энэ сайхан амьтныг шохоорхоод , тэгээд бас таныг өдтэй бүрх, урт хормойтой банзлаа өмсөөд, энэ гүүг унаж явахыг харна гэдгийг хөлсөнд Хадат уулын царманд хүрчихээд буцсан ч Зеб Стумп зөвшөөрөх нь тэр!

-Өө, Стумп гуай та чинь хүнийг онгироохоо болихгүй юмаа. Эргэн тойрон хараач, надаас илүү сайхан хүүхнүүд олдоно шүү дээ

-За за! Энд олон сайхан хүүхэн байна гэдгийг би үгүйсгэхгүй, чөтгөр аваг, олон сайхан хүүхэн байна шүү! гэвч манай Луизазныхан ярилцдаг шиг Луиза Пойндекстер бол ганц юм шүү гэж Зеб тэнд байсан хатагтай нарыг ширвэж харангуут хэлэв.

Зебийн энэ эелдэг үгийн хариуд хүмүүс инээлддэхэд тэдний дунд цөөхөн хүүхний дуу сонсдою.

Эзэн, Морист хандаж, бидэрт мустангийг зааж

-Би танд хоёр зуун доллар өгөх ёстой. Энэ талаар тантай Стумп гуай ярилцсан байхаа? гэв.

-Би энэ хэлэлцээрт оролцоогүй. таны мөнгийг авч чадахгүй нь. Энэ гүүг худалдах юм биш гэж Морис учиртайхан инээмсэглэж хэлэв.

-Нээрээ гэж үү? Гэж эзэн ихэрхэн, болгоомжилсон байдалтай гэдрэг ухрав.

Эзний найзууд болоод цайзын офицерууд хязгааргүй гайхсанаа далдалж чадсангүй. Тэр үед эмнэг мустанг арваас хорин долларын үнэтэй байдг байхад хоёр зууг өгч байна! мустангер лав өөрийн ухаангүй байгаа байх гэж бодоугоожээ.

-Пойндекстер гуай та бусадл мустангт минь сайн үнэ өгсөн, тэр ч байтугай тэднийг барихаар өмнө үний нь төлдөг байсан. Тэгэхлдээр таны ачийг хариулан манай Ирландад ярьдагчилан “аз жаргалын” бэлэг өгөхийг минь зөвшөөрнө үү. Манай Ирланд ёсонд хэрэв мориний наймаа гэр оронд хийгвэдь хэлэлцээр хийсэн хүндэ биш , тэдний эхнэр юмуу охины нэгд бэлэг өгдөг юм. Би энэ ирланд ёсоо техастбаримталж болно биз дээ?

-Ямар ч яриагүй болох хэрэг! Гэ хэд хэдэн хүн хариу хэлэв.

Эзэн олны саналд автан түрүүчийн хэлж байсан үгэ буцаж:

-Эрхэм Жеральд би татгалзахгүй. Тааллаараа л бол гэж хэлэв.

-Баярлалаа ноёдоо , баярлалаа гэж Морис өөрөөс нь дээр гэж өөрсдийгөө тооцох цугларсан олны зүг мэхэсхийн ёслоод- Энэ морь маань “аз жаргалын” бэлэг болох юм. харин үүнийг Пойндекстер авхай хүлээж авахыг зөвшөөрвөл энэ зэрлэг адууны хойноос гурван өдөр зогсоо зайгүй хөөцөлдсөний минь төлөө шагнаснаас их юм гэж би бодож байна. Харин энэ гүү хамгийн муу санаатай, догшин амьтан байлаа ч гэсэн, энүүнээс илүү хялбар номхрох амьтан гэж байхгүй байхаа гэв.

-Эрхэм минь, би таны бэлгийг авна, баяртай хүлээж авна гэж залуу креол хүүхэн нүүрэмгийгээр ургаш гарч анх удаа ам нээн хэлээд -Харин надад... гэж мустанг руу заах зуураа Морис өөд асуусан харцаар харж үгээ үргэлжүүлэн- Надад таны энэ гүү чинь эмнэг юм шиг санагдаж байна. Мэдэгдээгүй ирээдүйн өмнөчирэн дагжиж, хэрэв хазаар нь эс таалагдвал , сэгсрээд хаячихыг хичээж байгаа бололтой. Тэгэхлээр чадал мөхөс би яах билээ? гэв.

Хошууч Луизагийн хэлсэн үгийн далд утгыг эс ойлгон, тэдгээр үгсийг зөвхөн ганцаараа ойлгож байгаа рэр хүн өөд хандаж:

-Пойндекстер авхайн хэлдэг зөв. Энэ чинь цоо шинэ эмнэг адуу юм гэдгийг нь хүн бүгд тодорхой байна. За аль вэ, эрхэм нөхөр минь наадхиа жаахан номхруулаадп өгөөрэй! Гэж хэлээд хажуугийнхаа хүмүүст надаж- Харууштай вь болно. Ялангуяа эмнэг адуу сургахыг үзээгүй улс үзүүшгэй юм шүү... Хөөш Морисоо, наадахи дээрээ мордоод тал нутгийн морьтон ямар авхаалжтай бидэнд үзүүлээч. Наадхийг чиньв харваас танд нэлээд хүнд сорилт тарав бололтой гэв.

-Нээрээ тийм шиг байна шүү, хошуучаа! гэж Морис баригдсан мустанг руу биш, харин залуу креол хүүхэн рүү зэрэвхэн харж хариу хэлэв.

Бүсгүй өөрийгөө илчлэхгүйн тулд гэдрэг ухран чиран байж олон зочдын дундуур цааш орлоо.

-Морисоо, зүгээр зүгээ, Наадхийн чигнь нүд чөтгөрийн гал шиг гялалзаж байвч таныг хаяж чадахгүй гэж мөрий тавья. Мордоод үз! гэ хошууч тайвшруулж хэлэв.

Морис , хошуучийн хэлсэн үгэнд орохгүй байж болохгүй балйаа. Мэргэжлийнх нь бардам зан үүнийг зөвшөөрсөнгүй. тэр үгст Морист моринд гарамгай, уран чадварыг уриалсан дуудолага болжээ. Техасын хөндийд үнэлэгдэнэ гэдэг тийм ч амар хэрэг биш.

Морис мориноосоо үсрэн бууж, Зеб Стумп цулбуураа өгөөд бидэрт мустангийгбарьж авч зам тавиарай гэж хэлснээр хошуучийн үгийг зөвшөөрснөө илэрхийлэв. Зочдын олонхи нь түний дотор эмэгтэйчүүд агшин зуурын дотор асотей дээрээ буцаж гарлаа.

Морис Жеральд бугуйлаараа мустангийш ногтолж аваад мордчихов.

Тэр зэрлэг адгуус ийм доромжлолыг анх удаа үзэж байгаа нь энэ вч. Түүний хорсолтой хяхарган ччарлалт нь эрх чөлөөндөө халдагч этгээдийн өөдөөс эррс эсэргүүцэж байгааг нь илэрхийлэл болно.

Мустанг цоройж хойд хоср хөөл дээрээ хэсэг зуур зогслоо. Морис сандарч тэвдэлгүй , хүзүүгээр нь тэвэрч аван, багалзуурыг нь янгинатал шахаж, биенд нь ягштал наалдав. Хэрэв тэгээгүй бол тэр адуу Морисыг унагаж няц дарах байлаа. Тэгээд мустанг ургаш тонгорч хойд хоёр хөлөөрөө яравчилж гарав. Ер нь эмнэг адуу бүр ийм явдал тохиолдоход дандаа тэгдэг юм. Энэ булигт Морисыг тун их сандаргаж, золтой л унагачихсангүй. Морисчадлаа мэдэх тул эмээл дөрөө хэрэглээгүй ажээ. хэрэв эмээд дөрөө хоёр байсан бол түүнд их л иус болох байсан билээ. гэвч эмнэг мустангрын эмээл хэрэглэн сургах аваас хүмүүс түүнийг ялалтыгэж үзэхгүй байлаа. Морь булгихал Мортс нуруун дээр нь агшин зуур эргэж хажуу талаас нь зуурч хүзүү рүү нь жийжээ.

Мустанг дээрх хүнэ унагах гэж хоёр гурав дахин оролдсон боловч тухай бүрдээ Морисын самбаа чдалд автав. Гаарсан адгуус өөрийнхөө оролдлогыг бүтэлгүйг аяндаа мэдээд цамнахаа больж ,Морисыг авч тал нутгийн зүг огло харайн даьхилаа.

Ийнхүү давхиж, давхиж зогсох нь эргэлзээгүй ч цугларсан улсад даанч харагдахааргүй учир зочид, Морисын буцаж ирэхийг хүлээж, дор дороо чимээгүй сууцгааж байв. Асотей дээр сууж байгаа тэдгээр хүмүүс Морисыг үхэж мэднэ. Наад зах нь нь бэртэнэ гэж ярьцгаааж байв. Тэдний дотор нэг хүн битүүдээ үүнийг хүсч байсан бөгөөд өөр нэгд Морис хэрэв осолдвол өөрөө үхэхтэй адил санагдаж байжээ. Чихрийн тариалангийн эрэхмсэг эзний охин, хамгийн нэр хүндьэй баян хүнд нөхөр гарч чадах цуутай үзэсгэлэнтэй Луиза Пойндекстер юунд Техасын ядуу анчинд дур татагдан, түүнийг хүсэмжлэх нь нууцлаг агаад хэдийгээр ухаантай сэргэлэн чүүнээ өөрөө ч тайлж чадахгүй байлаа.

Тэр нь хараахан хайр сэтгэлтэй болоогүй байж болно. Өөрөө ч ингэж бодоогүй байв. Өөртэй нь уулзаж байсан сайн улсаас шал өөр энэ ер бишийн хүнд шохоорхон ямар нэг гайхалтай сэтгэгдэл төрснөө Луиза мэджээ! Энэ сэтгэгдэл нь алга болохын оронд улам бүр өсөн нэмэгдэж байгааг ч бас мэдэрнэ.

Тэгээд Морисыг эмнэг биш, хэзээ язааны унуулж сургасан юм шиг болж номхорно морьтой дахин гарч ирэхэд нь Луизагийн зүрх уам хүчтэй цохилон. Унасан морь нь түүнийг булгиж хаяхыг оролдохоо байж ун зангүй номхроод, эзэндээ унуулж яваагаа сайын мэдсэн шинжтэй ажээ.

Залуу креол бүсгүй ч гэсэн хэнч таагаагүй өөрөө ч мэдээгүй авч мөн л иймэрхүү боджээ.

Морис, өөрийгөө угтаж багйаа хүмүүсийн нижигнэсэн алга ташилтыг эс хайхран, мориноос буун харайж.

-Пойндекстер авхай , та наашаа ирж энүүнийг хүзүүг бугуйлгаар оосорлож адууны саравч руу аваачихгүй вус? Хэрэв тэгвэл адуу таныг эзнээ гэж тооцон хожим танд дур зоригоор тань эдлэгдэж байх болно. Та зөвхөн хэн өнх номхруулан гартаа оруулсныг л сануулж явахад л гүйцээ.

Хэтэрхий ёсорхуу гоо сайхан хүүхэн бол ийм саалд зэбүү нь хүрэн, аальгүй нэг нь татгалзаж, номхон нэг нь айх байсан бизээ.

Гэтэл францийн цагаачдын үе удам болох Луиза Пойндекстер өчүүхэн зуурч тээнэгэлзэжмаягласан буюу айсан шинж гаргалгүй шууд босоод язгууртан найзуудаа орхин явлаа. тэр хүүхэн Морисын заасан ёсоор адууныб хялгасан аргамжаар мустангийн хүзүүгээр оосорлож Каса-Дель-Корвын адууны саравч руу хөтөлж авачна.

"Энэ адуу таныг эзнээ гэж тооцоод хожим дандаа таны дур зоригоор элэгдэж байх болно. Та зөвхөн хэн анх номхруулсаныг гартаа оруулсныг л сануулж явахад гүйцээ" гэж Морисын хэлсэн үг чихэнд нь рүргэлж хангинан, зүрх сэтгэл нь цууриалан байв.

ХШ. Хээрийн зугаалга

Ургах нарны улаан туяа Инж цайзын тугийг гийгүүлэн офицеруудын байрны өмнөх талбайд сулхан гэгээ тусчээ.

Нарны туяа дунд месикийн хоёр луус хөллөсөн жижгэвтэр бүхээгт тэрэг зогс байв. Лууснууд сүүлээ шарвалзуулан, чихээ хөдөлгөж, тогтож ядан газар цавчилж байгаагаар үзвэл, явах цагтаа хүлээж тэргэнд хөллөөстэй чигээрээ аль хэдийнээ эхлэн нэг газар зогссон бололтой. Бас тэгэд лууснуудын байдал нь анзаараагүй хүмүүсийг дэргэдээ ирж, өшиглүүлчихгүй байхыг сануулж байв.

Гэвч тэнз тийм ангалзуур байсангүй. харин бүрх малгайтай ханхар том биетэй ганц хүний барааг үүрийн бүдэг туяан дунд анч өвгөн Зеб Стумп гэж амархан таньж болохоор байлаа. тэр хүн өөрийнхөө муу хөгшин гүүг унасан бөгөөл гүү нь мексик луус, эзэн шигээ явахыг тэгтлээ хүсээгүй нь илт ажээ.

Гэтэл хамаг амьтныг зрогсоо зайгүйжолоогүй бужигналдаад, хойш урагшаа яарч тэврэн явцгаажээ. Бүхээгт тэрэгнээс байшин руу, байшингаас бүхээгь тэрэг рүү санд мэнд гүйлдэнэ.

Тэнд арваад хүн байлаа. тэр арьсы өнгө, өмссөн хувцсаараа бие биеэсээ ялгарана. Тэдний олонхи нь жагсалын бус цэрэг байв. Хоёр тогооч, бусад нь тэндэх офицеруудын дагуулууд бололтой.

Тэдний дундаас нэг хээнцэр негр, хойшурагаа ихэмсэг, алхана. Түүний өөртөө итгэлтэн царайгаар нь цайзын дарга хошуучийн барлагуудын нэг гэдэг нь илэрхий. Дүрмиын ёесоор ханцуй дээрээ гурван хадмал тэмдэгтэй нэг түрүүч, энэ хэсг хүмүүсийг удирдах үүрэг гүйцэтгэж байв. Бүхээгт тэргэнд төрөл ыүрийн архи, дарс, хоол хүнс ачуулах итгэмжлэл түүнд оногджээ.

Зугаалганд гар татаагүй нь тэргэнд ачиж буй элдэв янзын идэж уух юмнаас илэрхий байв. том жижиг сагстай юмнууд, арван хоёр шил шампунь дарстай хайрцаг, эрээн мяраан төмөө лаазтай идэх юм, сардин загастай хайрцаг хүртэл байгаа нь алс холоос Техаст авчирсан амттай иээ болохыг гэрчилнэ.

Тдэж уух м элбэг байса боловч зугаалгын юм бэлтгэж багаа нэгэн хүний сэтгэлханагүй байжээ. Зеб Стумп тааламж муутай байв.

-Ахлагчаа, энэ тэргэн дээр чинь нэг л юм дутаад байна даа. Харин хээр гарсан хойно, харв газрын “шампань” мэтийн юмыг таалахгүй ундаа нь дээр юм гэх хүн гарч мэднэ гэжээ санагдах юм гэж Зеб ахлагчид хандаж хэлэв.

-Ундааныг шампанскаас дээр гэх амьтан гарч мэднэ гэнээ? Стумп гуай та морины тухай ярьж байна уу?

-Чөтгөрийн чинь морины тухай байх вэ? Моринд өгдөг ундаа биш, би моногахелийн вискийг хэлж байна.

-Аа, одоо ойлголоо! Стумп гуай, архины тухай мартахгүй байдаг тав долоон зөв. Тэнд зугаалганд зориулсан нэг сав юм байхыг харсан шиг санаж байна гэхэд.

-Эрхэм түрүүчээ тэр чинь энэ байна гэж том лонх бариад бүхээгт тэрэг рүү явж байгаа хошуучийн зарц негрийн хэлэх нь сонсдов.

-Анч өвгөн, одоо төхөөрөх юм гүйцээ гэж үзээд явахыг яарч буй бололтой дөрөөгөө жийн.

-За ахлагчаа, бүх юм бэлэн зэвхэн боллоо биз дээ, хөдөлж үзэх юмсан гэв.

-Арай л гүйцээгүй байна. Стумп гуай, бас тахианы мах шарах хэрэгтэй гэж тогооч хэлж байна.

-Тэр тахиа чинь тогоочтойгоо цуг тонилог ! манай хээр талын цацагт хяруултай зэрэгцүлбэл юу ч биш! харин нар дээр хөөрчихсөн хойно буудуулдаг шувуу гэж хаана байна? хошууч ямар ч байсан нэш тарган цацагт хяруул ол гээд бадаг. Нар мандсан хойно санах юм ыбиш. Бас хойноос тэрэг чангаалдаад салахгүй шүү дээ. Шувууг цайзын цэргүүд шиг тэнэг юм гэж битгий бодоорой. Тал нутагт амьдарч хамаг амьтныг дотор хамгийн ухаантай нь зэрлэг фцацагт хяруул байгаа юм. түүнийг агнахын тул наана хаяж нарнаар, тэрнээс ч эрт босох хэрэгтэй.

-Зөв дээ , Стумп гуай. Таныг ан авд сайн гэж хошууч итгээл цацагт хяруулын мах илнэ гэж горьдож багааг би мэдэж байна.

-Үгүй ер өө! Хошууч чинь намайг зөвхөн хяруул алж өгөөд зогсохгүй , бас хорин жилийн өмнө алга болсон, Техас даяар хаанач байдаггүй үзэрлэг үхрийн хэл, гуяны нь зөөлөн мах гаргаж өгнө гэж горьдож байж магадгүй дээ! үнэнждээ евордыг зохиолчид тэр дундаа францчууд ном зохиолоо шал өөрөөр бичдэг гэж би дуулсан... Гэвч энэ бол тэдний санааны хэрэг юм. одоо энэ нутагт зэрлэг үхэр ор тас алга болжээ... Энд б айвгай, буга янгир бас цацагт хяруул их байдаг. Харин өдрийн хоолонд өангийн мах тавья гэвэл өглөөний хоолыг эртхэн идэх хэрэгтэй. тэгэхээр ахлагч минь, та хүндэт зочдодоо өнөөдөр цацагт хяруулын мах зооглуулахыг хүсвэл хөдлөх тушаал өг гэж Стумпхэлэв.

Анч өвгөний итгэлтэй үг түрүүчид нөлөө үзүүлж тэр одорахноо бүхээгт тэрэг, хөдлөн түүний хойноос хар, цагаан арьстай туслагчид нь дагаддан явцгаалаа.

Энэ цувааны манлайд хөгшин гүүгээ унасан Зеб Стумп явж байлаа. тэр өвгөн уул цувааг Леон, самарт гол хоёрынг ыббэлчирт байдаг өргөн хөндийг гаталган замд оруулж өглөө.

Хоолхүнс ачаа бүхээгт тэрэг яваад хориод имнут ч болоогүй байхад тэр тэрэгний байсан газар өөд хэсэг хүн цугларлаа.

Морь унасан хатагай нар, Англид ан хомрог болоход байдагчлан зарц нараа дагулсангүй харин өөрскийнг найз, харчуул, төрөл садныхаа дагуулж ирэв. шинэ байшингийн баяр дээр

Пойндекстерын байсан хүмүүс бараг цөмөөрөө энд цугларчээ.

Эзэн ч өрөө хүрч ирлээ. Бид түүний хүү Генри, охин Луиза заа Кассий Колхаун гурав ирэв. Луиза Каса-Дель-Корво болсон баяраар бүхний анхаарлыг татсан бидэрт мустанг унаж явав.

Зугаалгыг Пойндекстерын хүндэтгэлд зориулжээ. Хошууч болоод офицерууд зугаалгыг эрхэлж, эзэн, нөхөдтэйгээ зочин болж байв. зочдыг зугаалуулахыг тулд тийм ч олон хийдэггү, үлэмж сонин, зэрлэг адууны ан ав хийхээр урьдаас төлөвлөн боджээ.

Ийм авлалыг Инж цайзнаас өмнө зүгт хорин бээрийн тэртээх хээр талд гарч хийх учраас хүрэлцээтэй хоол хүнс авч, эртхэн хөдөлөх хэрэгтэй байжээ.

Леон голын шил толь шиг усан дээр нарны туяа тусмагц уул аялалынхаа хорин морин цэргээр хамгаалуулан хөдлөхөд бэлэн болов. Бүхээгт тэрэгтэй хамт түрүүчийн явсан хэсэгтэй адил, энэ хэсэг нь бас өөртөө газарчинтай байв. гэвч тэр газрын нь эсгий малгатай, гандмал тэрлэгтэй ойн анч өвгөн биш, харин мустангерийн өмсдөг гоё хувцастай, сайхан морь унасан, хүмүүсийг газарчилахад аргагүй тохирсон залуу эр байлаа.

-Хөдөлье, Морис гэж хошууёч, хүмүүс цугларч гүйцсэнийг харж хашгиранхэлээд, тэгд байгаа хүмүүст хандаж- Дээдэст, хатагтай нараа! Энэ залуу бол зэрлэг адуу сайн мэддэг, тэднийг барихдаа гаргууд хүн байгаа юм. хэрэв Техаст ямар нэг хүн, мустанг явж барьдгийг бидэнд үзүүлж ёадах хүн хэн бэ гэвэл тэр чинь ёстой л энэ Морис мустангер даа гэв.

-Хошууч минь, би тэгж магтуулахаархүн биш, би зөвхөн мустанг хаана бэлчиж байлдгийг та нарт зааж өгөх гэсэн юм гэж ирланд залуу хэлээд олны зүг эелдэгхэн мэхийж ёслов.

“Ямар их даруу зантай юм бэ” гэж итгэхээсээ ч аймаар нэг бодлоосоо болоод дагжталаа чирчирсэн Луиза бодлоо.

-Явцгаая гэж хошуучиыг зкомандлахад мустангераар толгойлуулсан хөгжилтэй цуваа хөдөллөө.

Техасынханд үдийн хоолны өмнө хорин бээр газар явна гэдэг бол ёстой тоглоом юм. Гурван цаг хүрэлгүй очих газраа хүрч, хүмүүссүүлдээ их өлсөж, цангасныг эс тооцвол уг аялал үнэхээр сайхан болжээ.

Аз болоход хүнс ачсан бүхээгт тэрэг хүлээгдсэнгүй. Зугаатай хэсэг хүмүүс үд болохоос аль өмнө Рио-Де-Нуэсесийн эрэг дээрх самар том модны сүүдэрт буудаллан, идэж уухаар төвхнөж авав.

Замд онц гойд юм юу ч тохиолдсонгүй. мустангер газарчийн ёсоор бүхний түрүүнд явжээ. Зугаарлахаар мордогсод нэг хоёр хүнээс бусад нь өөр хүмүүс гарам ч юмуу саадгыг тойрч гарч байхад залуу ирланд моринд гарамгайгаа үзүүлж гшорхи, жалган дээгүүр хөнгөхнөөр харайлган цочирдуулахаас өөр үед бараг түүнийг анзаарсангүй.

Өөрийгөө гайхуулах гэсэндээ албаар ингэж байна гэж бодож болохоор байлаа. Кассий Колхаун ийм саналаа хэлээд авчээ. Энэ удаа чөлөөнд гарсан ахмад үнэнийг хэлсэн байж болох л юм.

Гэвч ингэлээ гээд хэн мустангерийг буруушаах вэ? та хэзээ ч вм Англид тал бүрд л өд цацаг болсон бардам бүрх донхолзон морьт бүсгүйчүүдийн урт хормой ногоон дээгүүр чирэгдсэн анд явж үзсэн үү? Та үзсэн гэж хэлэх байх, тэгээд яагаад? Болгоомжлоорой, мустанг?рийг хий дэмий буруушаах хэрэггүй. Түүний биед хориод хос сайхан нүдний гал дор явж байгааг бодолцоорой. зари нь од мичдий шиг гялалзаж байв. тэдгээрийн дунд Луиза Пойндекстерын нүд ч явааг саначихвал, та мустангерын гайхуулах гэсэн хүмлсийг гайхаад байх нь юу л бол доо.

Зарим нь нэг морьтонгууд ч гэсэн түүнээс дутахгүй шургуугаар өөрийн эрмгий зоригийг харуулахыг хичээж явав. Залуу морин цэрэг Генкокк нэг бус удаа моринд муугүйгээ үзүүлэхийг хичээн, буудлагын цэргийн дэслэгч ч унаад гарамгайгаа харуулдахын тулд байсгээд л бэлтгэлийн албаны даргбн зээ хүүхнийг орхин явж, өөрт нь магтан шивнэлдэхийг сонсонгоо бүх хүний бодлоор зүрхээ өгсөн гшэж боддог тэр хүнийхээ зүг үргэлж харахгүй байлаа.

Ээ , Пойндекстерын охин гэж! Соёлжсон Луизианы зкочдын танхимд ч, зэрлэг Техасын тал нутагт ч бүхний анхаарлыг татах юм л даа. Чи хаана я явлаа гэсэн, амтат сайхан бодлыг төрүүлэн, тачааллыг оргилнуулам билээ.

XIV. Манада

Морис Жеральд талын бүрэн эрхт эзэн ч бай, бүх оршин суугчдын түүнд захирагддаг ч бай, аялагчдыг авч ирсэн газар шиг зэрлэг адуу барихад тийм тохиромжтой газрыг хаанас ч олж өадахгүй байсахсан билээ.

Сан -Антонигийн зоориноос авчирсан германы үнэтэй архи хөөсөрч, тэнгэрийн өнгө улам ч хөх болж өвч ногооны өнгө улам ч тол ногоон болсон шиг санагдан, хөөрөлдөн шуугицгааж байтал, хажуугийн толгой дээр харуулд гарсан мексик залуугийн “Mustenos” гэж хашгирах дуу сонсогдлоо.

Ширээнд зочноор уригдаад байсан Морис, хундагатайгаа бушуухан балгачихаад мориндоо үсрэн мордож

-Cavallada? Гэж хашгирав.

-Биш ээ, manada гэж мексик хүн хэлэв.

-Цаадуул чинь юу гэж донгосоод байна ? гэж ахмад Колхаун асуув.

-Mustenos гэж мексизээр мустангийг хэлдэг юм гэж хошууч хэлээд- Харин тэд зэрлэг гүүнүүдийг манада гэдэг юм. Энэ улиралд гүүнүүд азарганаас тусгаарлаж, сүрэглэн явцугаадаг юм. Хэрэь:::

-Юу хэрвээ гэж? хэмээн ахмад үший нь тасдан тэсээгүй асуув. Хэрвээ илжигнүүд тэдэн рүү дайрахгүй бол гэж хошууч гэмгүй царай гарган хариу хэлэв.

Цөм инээлдэв.

Тэд хоорондоо манада ойртож ирлээ.

-Мориндоо! Гэж тал бүрээс хашгирцгаав.

Эрдэнэ шишээ зажилж амжаагүй мориндоо хазаарлаж, бүгд мориндоо мордон ухасхийхэд бэлэн болох хоорондо зууч хүртэл тоолж амжихгүй байсан билээ.

Зэрлэг адуун сүрэг энэ үеэр харуул зогсож байгаа өндөрлөгийн хяр өөд шууд гарч ыирэв. Мэргэжлийн хувьд мөнч мустангер болох харуулын хшүн бугуйлаа бариад зэрлэг сүрэг Түүнийг бүчээл авах үед аль нэгийг толгод бугуйлаа углахаар зэхэв. Адуунууд муухай янцгаан, галзуу мэт давхилдан хойноосоо элдэн хөөж байгаа хорт амьтнаас амь зулбах мэт хулмалзан эргэн эргэн харж бүхээгт тэрэг болоод морьтой хүмүүсийг харсангүй.

Морис, тэдгээр адгуусны үргэн сандарч байгааг хараад

-Тэднийг ямар нэг амьтан үргэн сандарч байгааг харад

-Тэднийг ямар нэг амьтан хөөж байна Креспино, цаана ч нь юу болоод байнаа? Гэж адуун сүргийг ямар амьтан хөөж байгааг тэндээсээ харж болохоор байгаа мексик хүн рүү хашгирав.

Тэр хүний хариухэлэхрийг хүлээж цөм чимээгүй болов. хүмүүсийн царайд айж сандарсан шинж тодорно. Индиан нар мустанг хөөж яваа юм биш байгаа?

Un asino cimmaron гэж испаниар хариу хэлэх нь сонсогдоод - Un macho гэж Креспино нэмж хэллээ.

-За тэр дээ! тийм л байх ёстой. тэр мууг зогсоох хэрэгтэй. тэгэхгүй бол хамаг ан үргээчихдэг юм. тэр адуунууд зэрлэг илжгэнд нэг л хөөгдвөл яасан ч тогтдоггүй юм.. Цаад илжиг чинь хол байна уу?

-Энүүхэнд байна, Морис гуай шууд над руу давхиж айсуу.

-Бугуйлаа шидээдүз. хэрэв амжихгүй бол буууд. Цаадхий чинь учрыг нгь олох хэрэгтэй.

Зэрлэг гүүнүүдийг хойноос ямар гээч амьтан хөөж байгааг тэнд байсан хүмүүсийн бараг нь ч мэдсэнгүй. ганцхан Морис мустангер л “Un asino cimmaron” гэсэн үгийн утшыг ойлгож байв.

-Морисоо, юу болов оо, хэлж өгөөч гэж хошууч асуув.

-Тийшээ хараач гэж мустангер толгойн орой өөд заав. Энэ хоёрхон үг л хангалттай байв. Бүгд л удаан хөдөлгөөнтэй тэнэг амьтан тооцогдоог нэгэн амьтан, хэц дээр харвасан сум шиг харайн гарч ирэхийг харав.

Зэрлэг илжиг бол өөрийн мохоо төрөл гэрийн илжигнээс ондоо. Хойноос нт хөөж яваа мустангуудын дайтай биетэй ажээ. хэдийгээр тэр илжин хамгийн хурдан мустангийн дайтай хурдан давхихгүй чгэсэн тэднээс хоцрохгүй хөөж байв. Энэ явдалд нүд ирмэх зуур болж, харж байсан хүмүүсийг хэдэн үг сольж амжихын зуур зэрлэг гүүнүүд улаан дэргэд нь хүрээд ирлээ. тэгэнгүүтээ хэсэг морьтой хүмүүсийг дөнгөу сая хараадп хойноос нь хөөж яваа хорт амьтнаа мартчихаад хажуу тийш давхив.

-Эрхмүүдээ, дор дороо зогсож байгаарай! Гэж морьдоо тогтоон ядаж бөагаа морьтонгуудын Морис Жеральд хэлээд- Энэ адуунууд хаан очиж идээшлэх дуртайг ыби мэднэ. Одоо эд тэр рүүгээ явж байна. Цөмөөрөө хойноос нгь очиж сайхан авалцгаая. Харин одоо ангаа эхэлчихвэл цаадуул чиньв төгөл дундуур гүйгээд бидэнд огт харагдахгүй... Хөөе, эрхэм Креспино! Наад муу золигийгоо бууд. Буун сум газар байнашүү дээ гэв.

Тэр мескиз хүн эмээлийнхээ бүүрэгнээс оготор буугаа бушуухан авч зэрлэг илжиг рүү шагайн буудав.

Илжиш бууны дуу сонсоод орилсон нь зөвхөн итүүний эсэргүүцлийг илэрхийлжээ. илжиг огт гэмтсэнгүй. Креспино ононсонгүй.

-Түүнийг зогсоох жхэрэгтэй. Тэгэхгүй бол шөнө болтол мустангуудын хойноос хөөцөлдөөд байх болно. гэж Морис хэлэнгээ морио давирхад Кастроч мустангуудыг элдэж яваа

илжигний хойноос сум шиг дүүлэн одлоо.

хурдан хээр хэдхэн харайгаад илжигэнд бугуйл хүрэхээр ойртож, тэрхэн зуур илжигний урт чихэнлд дээгүүр бугуйлын гархи цахилгаан мэт уунгинав.

Морис бугуйлгаа хаяад урагш дүүлэхэд бүгд амьсгаагаа хураан байлаа. Илжиг ургаш ухасхийснээ бугуйлд ушз татагдаж цоройгоод зүрх рүүгээ хутгалуулсан юм шиг арзоогоороо пид хийтэл савж унав.

Илжиг амьтад байлаа. Хүзүүгээр нь чивчирсэн гогцоо хоолойг нь боон бахардуулжээ. Мексик эр хурц хутгаар хоолойг нь огтлов.

Энэ явдал ан эхлэхэлд саад болов.

Хүмүүс цөм Морис мустангер одоо яах бол гэж харж байлаа. Тэр мориноосоо буун харайж илжигний хүзүүнээс бугуйлаа мулталжавахаар очив Бас л ямар нэг юманд яаран тэюдсэн байдал түүний хөдөлгөөнд мэдэгдэж байлаа.

Тэгээд морь руугаа ухасхийлээ.

Тэнд байсан хүмүүсийн зарим нь түүний гэнэт яарсныг ажиглажээ. Ихэнх нь үргэж цочсон морьдтойгоо л ноцолдон байв.

Түүний яарч сандчихыг ажигласан хэд нь гайхаж байлаа. дөнгөу саяхан мустангер өөрөө хөдлөхгүй байхыг ятгаж байсан Луиза Пойндекстер л адууны араас бүгдийн түрүүнд оръч гэж шийдсэн юм шинг тэднээс салан давхисаар л болоогүй юм бол юундаа мустангер гэнэт ингэж хачин сандраа вэ гэж бодож байлаа.

Гэвч зэрлэг адууны анчин маань нэг л биү боллоо гэдгийг мэдэж байжээ. Эмэгтэний өөрөө ийм эелдэг бус зан гаргах нь юу л бол.

Бидэрт мустанг л түүнд илүү буруутай мэь. Энэ хурлдлан давхиж байгаа сүрэг бол тун саяхан бидэрт мустангийн нийлж явсан сүрэг мөн болохыг морис таньжээ. Бидэрт мустанг ижил сүргээ хараад түүнд нийлэх гэж унасанэзнээ аваад хадууран давхиж байгаа нь эргэлзээгүй ажээ.

Морис мустангер ч ингэж бодсон байжээ. Удалгүй бусад хүмүүёс ч бидэрт мустангийн санааг тааварлан мэдэв.

Баатарланг зоригийг гарган бараг бүх анчид бүсгүйн араас ухасхийлээ. Колхаун, Генкокк, Кроссман гурав түрүүлэн тэр гурвын хойноос газрын хойноос газрын эзэн, өмгөөлөгч шүүгч зэрэгу арваад хүн давхилаа. тэрдор бүгдээрээ бүсгүйг гүйцэн очиж баатар болохыг мөрөөдөх ажээ.

Гэхдээ Луиза Пойндекстерыг моринд гарамгүй сайн гэдгийг цөм мэддэг болохоор тэдний

бараг хэн нь ч ону их сэтгэл зовсонгүй. тэр хүүхний өмөн морин тойруулгын талбай шиг толигор өргөн тал цэлийж байв. мустанг нь эцтэлээ даьхиад л байх боно. Унаж яваа хүнээунагаж чадахгүй. Луизад төдий л сүрхий авул тохиолдохгүй байлгүй гэмээр.

Нэг л хүн энэ бодлыг хуваалцсангүй. тэр нь анхлан аюулыг гадарласан мустангер байлаа.

Мустангер сүүдэлж хөдөллөө. Тэр хооронд нөгөөдүүл нь өөрөөс нь нэлээд холдсон байв.

Түрүүнд нь морио ч өөрийгөө, хайрлахгүй дахих Колхаун, тэгээд морин цэргийн хүн бууч хоёр, жаахан хойнонь бусад хүн нь давхилдаж байв.

Морис унаж төдөлгүй хээр мориороо цөмийг гүйцэж түрүүлэв. Колхауныг ч гүйцэв. Хээр морь өмнө нь орж бидэрт мустангийг халхлах үед хорсож арга нь барагдсан Колхаун хараал тавин хоцорлоо.

Энэ ер бишийн үзэгдоийг үдийн нар гийгүүлж байв. зэрлэг адуун сүрэг өргөн талын дундуур жигүүртэн нисэхадил хурлдлан давхилдана. Бүсгүйн унасан эл сүргийн нэгэн адуу сүргийн хойно таван зуугаар алмын зайтай давхина. Өнгөлөг гоё сайхан мескиз хувцас өмсөж хээр унаса морь унасан хүн бас түүний хойно төдий хэр зайтай давхих бөгөөд араас нь цэргийн, энгийн хуцвастай бөөн морьтон цувралдан дахина. Хамгийн ард нь морин л дээрээ хөдлөлгүй, гар хөлөө гозолзуулан сэтгэл уймарсан хүүхэн, харчуулаас дөнгөж салсан, морьт сумангийн дарга хар хурдаараа давхина. Хориод минутын дараа байдал өөрчлөгдөв. Хүн, мал хуучин хэвээрээ боловч тэдний байрлалт нь ямар ч байлаа гэсэн хоорондох зай нь ххэсчээ. манада нв бидэрт мустангаас холдож бидэрт мустанг хээр мориноос холдож, харин бусад хүмүүс огт үзэгдэхээ больжээ. тэднийг зөвхөн номин хөх огторгуйн өндөрт нисэгч бүргэд л хурц нүдээрээ ячлган харж чадах байв.

Гагцхүү бидэрт мустангер унасан бүсгүй, хээр морьтой анчин залуу, зэрлэг адуунууд л уулам талын дунд хэдүүлэхнээ үлджээ.

XV. Хадуурч гүйцэгдлээ

Хөөцөлдөөн бас нэг бээр хяраатай онц өөрчлөлтгүй үргэлжлэв.

Зэрлэг гүүнүүд түрүүчийнх шигээ хурдан давхиж байв. Гэвч айж сандрахаа больж, унгалдаж чалрлалдахаа б айжээ. Ард нь бидэрт мустангийн тасалданги янцгаалт сонсдовч хуучин нөхөд нь түүнийг анзаарахгүй байгаа бололтойн Өнөөх хүүхэн сандарч тэвэрсэн шинжгүй тайван явж байв.

Хээр морь найдвар, цөхрөнгөө барж буй эзнээ бодвол тэгтлээ их сандарсангүй.

-Кастор , яваач! Гэж Морис тэсч ядан дуугаар хэлээд - Чи өнөөдөр яачихаа э? Эртээр чи түүнийг гүйцсэн шүү дээ. тэгэхдээ я зовж гүйцсэн нь үнэнэ. Гэлээ ч гэсэн одоо тэр чинь дээрээ хүнтэй явж байна. тэр унажяваа хүн нь надад энэ дэлхий дээр юунаас ч илүү унэтэй хүн бөгөөд түүний төлөө чиний болоод өөрийнхөө амийг ч өгөхөөс би буцахгүй. за хурдалж үзээрэй, бууулаарай! Хэрэв би түүнийг бараа туруугүй алдчихвал яана? тэгвэл тэр зайлүгүй аюулд орно. Бараагий нь балдвал балрана гэж б морис өөрөө өөртэйгөө ярингаа улам бүр холдож байгаа тэр хүүхнээс нүд салгалгүй давхиж, сандарсан харцаар, өмнөх газраа байн байн хэмжиж байв.

"Хойноос нь хашгирадаг юм билүү? миний дуу хүрч магадгүй. харин хэлсэн үг, зөвөлгөөг дуулах болов уу? Ээ дээ, энүүдн найдах хэрэггүй байх гэж бодов. Гэвч нэг талаа р хөөж гүйцэх, нөгөө талаар мустангийн үгээр биш аргаар л болохыг тэрхэн агшинд ухаарч, түрүүчийнхээ бодлыг орхижээ.

морис яаж ийгээд, тэр мустангшад ойртож, хүзүүгээр нь бугуйлдаж тогтоож болно гэж найдаж явав. Гэвч тэр найдлага нь аяндаа замхарчээ.

Манад эндэх тал нутгийг битүү бүрхсэн төгөл дундуур цухалзан яваа харагдана. Тэр төгөд карим нь газраараа үргэлжилсэн өтгөн ширэнгэтэй нийлнэ. Энэ нв мустангерын сэтгэлд бас нэг шинэ түгшүүр төрүүллээ. Мустанг унасан хүүхэн ширэнгэ лотор ороод махиралдсан зөргөөр үзэгдэхгүй болчихож мэдэх байлаа.

Зэрүлэг гүү бараг харагдахгүй байв. Өөрийн сүргээ гүйцэх нь юу л бол.

Ингэлээ гээд аюул багассангүй. Эмэгтэй төөрөх ч юм уу, эсвэл зэрлэг адуун дотор орлоо ч гэсэн адилхан аюултай байлаа.

Морисын сэтгэлд бүхнээс аймшигтай сэтгэл зовоосон бодол гэнэт орж ирлээ.

Тэнгэр минь! Энд азарганууд дахиад ирвэл яанаа? Энэ бол тэдний бэлчээрлэх дуртай газар шүү дээ. Долоо хоногийн өмөн энд б айсан. Одоо тэний яг л одоо ороод байж ядаж байгаа цаг!

Мустангер хээр морио дахин давирахад, хар хурдаараа давхиж байсан Кастор толгойгоо эргүүлж, эзнээсээ зэмлэсэн янзтай харж. Энэ үед зэрлэг гүүнүүдширэнгэ дотор далд орлоо.

Яг энэ эгзэгтэй үед хээр морь, эзэн залуу хоёр гүүний барааг, бидэрт мустангийн барааг алдчихав.

Энд ямар ч ид шидийн юм байсангүй. тэр ширэнгэнд далд оржээ.

Адуун сүргээ алга болсон явадл мустанг ид шидийн юм шиг нөлөө үзүлж, гэнэт алхаагаа аажруулсанаа нэг минутын дараа ыгүр зогсчихов.

Морис , хөөс цахартал хөлөрсөн морио давиран ойн дэргэд давхиж ирээд, модны чөлөөнд морин дээрээ өөрийг нь хүлээн байгаа мэт хээвнэг сууж байгаа Луизаг харжээ. Тэгээд дэргэд нь очиж :

Пойндекстер ахай минь! Морь чинь дахин номхорсондп би

их баярлаж байна. Мөн ч их сэтгэл зовлоо шүү гэв.

-Юунд тэр вэ? гэж тэр охин гайхан асуулаа.

-Танд учрах гэж байсан тэр аюулын төлөө гэж Морис нэлээд бодлогшрон хэлэв.

-Аа, эрхэм Жеральд танд баярлалаа Харин надад аюултай юм ер харагдсангүй. надад аюул учрах байсан гэж үү дээ?

-Аюул учрах гэнэ шүү! Эмнэг морть унаад ээрэм тал дундуур хадуурах давхих гэдэг чинь! Гэжирданд залуу улам гайхаж хэллээ.

-Энүүнд чинь аюултай юу байгаа юм бэ? та намайш мориндоо хаяулчихна гэж бодоо юу? Би чинь унаанд сайн, бас тэгээд энэ гүүнд хаяулчих ч үгүй л дээ.

-Тэр ч тийм бай. харин Техас нутгийн хүн ч гэсэн зам олоходоо тэвддэг энэ ширэнгэ дотор төөрчихвал яана. тэгвэл унаанд сайн чинь тус болохгүй шүү дээ.

-Өө, та намайг төөрчихнө гэж бодоо юу Ийм л аюул байсан юм уу?

-Зөвхөн тэр ч биш л дээ. та өнөө... юунуудтай дайралдаж болох байлаа шүү дээ.

-Өнөөх индиануудтай тулгарчихаж мэднэ гэж үү? Гэж мустангын үгийг бүтэн хэлүүлэлгүй Луиза асуугаад Хэрвээ тэгвэл яах вэ? Команчууд чинь одоо манайхантай энх тайван харьцаатай биз дээ? надад ямар ч хор хүргэхгүй байсан байх. хошууч надад тэгж хэлсэн. Дайралддаг юм б гэхэд би баярлах л байлаа. Ямар ч гэсэн үугтаахгүй л байсан гэдгээ танд амлая. Морин дэл дээгүүр төрлөх нутгаа дундуураа хөндлөн гулд давхиж явдан энэ сайхан онгон хүмүүсийг би харвал дуртай байна.

-Пойндекстер авхай минь, энэ сайхан хэрэг. Би таны зоригийг бахархаж байна. гэвч би таныг сэргийлэх үүрэгтэй гэж өөрийгөө үзэж байна. тиймээс ч улаан артыстнуудад болгоомжтой харьцаж байгаарай гэж нөхөр ёсоор зөвлөхий минь зөвшөөрнө байх гэж итгэж байна. "Эелдэг зэрлэгүүд" чинь тэгж ч үргэлж саруул ухаантай бадаг улс биү. таны боддог шиг сайхан ааулах

нь юу л блд. Харин та тэдэнтэй дайралдчихсан бол...

-... Тэд над руу дайрах гэж бодлоо ч гэсэн би хажуугаар нь сум шиг шүнгэнэтэл дахиж гараад нөхөд дээрээ очих байсан л даа. ХайртайЛуна шиг минь ийм хурвн морьтой явад хэн ч намайг гүйцэхгүй. Эрхэм Жеральд, та ч гэсэн өөрөө тийм ч амархан гүйцээгүй биз дээ? Тийм үү?

Морис гайхаж, бахархсан дүрэлгэр нүдээр креол хүүхнийг харлаа. Тэгээд нэлээд дуугүй байснаа:

-Та мустангаа өөрийн дураар зогсоож чадах байсан хэрэг үү? Мустанг чинь хадуурч давхисан хэрэг биш байх нь ээ тэгэхээр энэ чинь та өөрөө л ... гэтэл нь.

-Үгүй, үгүй гэж Луиза бушуухан хариу хэлээд Үнэндээ ч эхлээд мустанг маань намайг авч хадуурч давхисан юм. тэгээд би сүүлд нь жолооноос нь татаад зогсоочихож болно гэдгээ мэдсэн юм. ийм л юм болсон юм даа. та нар хараа биз дээ? гэж ялигүй ичсэн байдалтай хэлэв.

-Харин та тэрнээс өмнө зогсоочихож чадах байсан уу?

Энэ асуулт гэнэтийн таамаглалаас болж гарсан бөгөөд мустангер ч хариуг нгь тэсч ядан хүлээж байв.

-Магадгүй, магадгүй... жолоогоо л чангалах татчихвал болох байсан... гэвч эрхэм Жеральд минь, би их хурдпан давхихдаа дуртай. Ялангуяа талнутаг дундуур, давхихад бол ямар нэг гахай, тахиа дайруулчихна гэж айх юмгүй. Уудам сайхан ч байдаг юм... гэж хэлээд тэр охин үнэхээр даруу байдлаар үгээ үргэлжлүүлэн- Үнэндээ ч морь минь намайг авч хадуурч давхисанд би харамсахгүй. дэмий яриаг , эцэс төгсгөлгүй магтаал хүнийг залхаадаг юм. Тэгээд цэвэр агаар амьсгалж, ганцаараа явмаар санагдсан юм. эцсийн эцэст ноён Жеральд минь бүх юм аятайхан боллоо.

-Ганцаараа явмаар санагдсан гэнээ? гэж Морис урамгүй байдалтай асуугаад- Би таны тэр ганцаараа байх гэсэн хүсэлд чинв саад болсондоо их харамсаж байна. Пойндекстер авхай минь, танд аюул тохиолдлоо гэж бодсондоо л хойноос чинь явсан юм шүү.

-Эрхэм минь , та тун сайн хүн юм. үнэндээ аюул байсан байна гэдгийг одоо мэдээд танд улам их баярлаж байна. та индиан нарын довтолгоноос үнэхээр айсан уу?

-Үгүй индиануудын тухай бодсон юм биш

-Өөр ямар аюул байдаг билээ? та хэл л дээ. Би үүнээс хойш болгоомжтой байя.

Морис шууд хариу хэлсэнгшй , нэг юмны чимээ сонсоод түүний асуултыг сонсоогүй юм шиг эргэж харав.

Морисын анхаарал ямар нэг юманд татагдсаныг креол хүүхэн мэдээд бас чимээ чагнаж эхлэв. Тэдний ардп чимээ шуугиан гарч, улам улам ойртон сонсдож байснаа морин төвөргөөн

сонсогдлоо... Чимээ ихсэн, нам гүмийг цочоов.

Энэ чимээ бол мустангерт оньсого таавар биү бөгөөд түүний амнаас гарсан үг креол хүүхний асуултыг хариу болоо.

-Зэрлэг азарганууд! Тэд энэ ширэнгэнд байх чётойг би мэдэжбайсан юм ... гэж Морис сандарч тэвдсэн дуугаар хэлэв.

-Таны хэлсэн өнөөх аюул чинь энэ үү?

-Тиймээ

-Энэ чинь зүгээр л мустангууд биз дээ. тэднээс айх юу байгаа юм бэ?

-Уг нь айх ч юмгүй л дээ. Тэгэхдээ жилийн яг энэ үед тэд чинь барс шиг догшин, аюултай болдог юм. тэр ч байтугай ороо нь орсон азрага гэдэг нь чоно, ирүэс% баавгайнаас аюултайг та мэдэхгүйбайха л даа.

-Тэгвэл одоо яадаг билээ? гэж ЗЛуиза, өөрийгөө нэг удаа аюулаас аварсан хүн рүүгээ дөхөн нүүр өөд нв айсан үинжтэй харж хэлэв.

-Хэрэв азраганууд дайрвал бидэнд гарах арга хоёрхон бий. нэг нь бол өөрсдөө модонд авирч гараад морьдоо тэдэнд тасчуулах арга гэж Морис хэлэв.

-Нөгөөх нь гэж Луиза зүрх зоригтой, ямар ч сорилтыг тэсвэрлэн өнгөрөөхөд бэлэн байгаага илэрхийлсэн тийм тайванг дуугаар асуугаад - Морьдоо лд орхихгүй болямар ч юм байсан хамаа алг! Морьдоо орхино гэдэг зохисгүй арга эгж хэлэв.

-Энд авираад гарчихаар ганц мод байхгүй болохоор морьдоо орхихгүй. хэрэв дайраад орж ирвэл ганцхан морьдынхоо хурданд л найдаж болно гэж хэлээд Морис бидэрт мустанг, хээр морь хоёрыг ажиглаад хараад үргэлжүүлэн- Энэ хоёр маань өнөөдөр даанч их давхиад эцчихжээ. Энэ л харамсалтай байна. зэрлэг азарганууд ядраагүй байгаа гэв.

-Тэгвэл бид хөдлөх юм биш үү?

-Одоохондоо азная. Морьдоо хэдийчинээ амраавал, төдийчинээ сайн, азрганууд наашаа эргэхгүй ч байж мэднэ. Ирлээ чгэсэн бид хоёр өөд үууд дпайрахгүй гэсэн үг биш шүү. тэгэхдээ тэдний л байдлаас боно. Хэрэв хоорондоо ноцолдож явбал бидэнд аюул учирна. Ноцолдохоороо галзуу юм шиг болж хүнл унуулж явсан ч хамаагүй, ижил ханиа хүртэл дайрдаг юм... Ээ!.. Хоорондоо ноцолдож явна. Тэр унгалдаж, янцгаахыг нь сонсож байна уу? наашаа ирж явах шиг байна шүү! гэв.

-Эрхэм Жеральд минь, тэгвэ бид нөгөө зүг рүү нь давхивал яасан юм бэ?

-Одоо саналтгүй хэрэг. Бидний өмнө нуугдах газаргүй нүцгэн тал байна. Биднийг холдож амжаагүй бёбайтал азрганууд дорхиноо гүйцээд ирнэ. Бидний очууштай ганц аюулгүй газар өөр зүгт байгаа. Чимээгий нь сонсвол азрганууд яг тийшээ явах замы нь маань хачихлаа.

хэрэв бид дэндүү эрт явбал азргануудтай улаан тулгарч үхнэ. Азнаж байгаад араар нь сэмхэн өнгөрх хэрэгтэй. Бид Каса- дель-Корвогийн хашаанд орсноос ялгаагүй аюулгүй газар очно. Та мустангерыг дахиад гарч чадна гэж итгэж байна уу?

-Бүрэн итгэж байна гэж креол хүүхэн түргэн зуур хариу хэлэв.

XVI. Зэрлэг мустанганд хөөгдсөн нь

Тэр хоёр мориноосоо буугаагүй чигээрээ байв. Луиза мустангерт найдаж байсан учир сэтгэл нь цаадхийнхаасаа бага зовж байлаа. Чухам ямар аюул нөмрөөд байгаагийн нарийн учрыг олоогүй боловч Морис-Жеральд шиг тийм хүн л сандарч байгаа болохоор ямар нэг их аюул заналхийлж багааг мэдэрчээ Түүний сандарч, түгшүүртэй байгаа нь хүүхрний аюулгүй байх явдалтай холбоотой бөгөөд хэдий аймшигтай цаг байсан боловч зүрх нь сэтгэлд нь баяр хөөртэй байв.

Морис чимээ чагнан.

-Одоо азаа үзэхэд болмоор санагдаж байна. Азаргануудын бидний ухарч гарвал зохих өнөөх нууц чөлөөнөөс өнгөрчих шиг боллоо. хамаг ч чадал, жолоогоо үавхаж үзээрэй. Эмээл пээрээ бөх сууж, жолоогоо яанга бар. Болж л өгвөө надтай хамт давхиад байгаарай. Юу ч болсон гэсэн миний морины сүүлний дайтай газраас илүү хол битгий хоцор. Би замчлахын тулд өмнө чинв явна... За өнөөдүүл чинь, бидний байгаа чөлөө рүү яг чиглэн ирлээ захад нь бараг хүрээд ирлээ. Одоо цаг болсон шүү! гэж хэлэв.

-Тал нутгийн нам гүм чимээгүйн дунд, яг л галзуу хүмүүсийн орон байшингаас гарч байгаа вч шиг тийм чанга дуу шүшуугиан гэнэт оргилон гарлаа. зэрлэг азрганууд аяхаран янцгаалт нь солиотой хүний зэрлэг дуу санагдуулна. Гэвч энэ чимээ нь арав дахин чанга байлаа. Морин төвөргөөн, хугарч байгаа гишүү мөчрүүдийн тас няс, хийх чимээ, азргануудын шүдний хавиралд, зэрлэг чарлалдан гарна.

-Энэ гайхалтай дуу чимнн нь зкэрдэг азргануудын галзуутай ноцолдоон болж байгааг өгүүлж байлаа. Тэд харагдахгүй байгаа боловч хоорондоо хэмхэлдэн хэвээр ширэнгэ рүү орж ирж байгаа нь энэ ажээ.

Морисыг хөдлөх дохио өгмөгц, хоёр хэсэш шүгуйн хоорондох зураас замаар зэрлэг адуун сүрэг орж ирэн уулнаас буусан үерийн ус шиг, агшин зуурын дотор ойн чөлөө рүү давхин гарч ирлээ.

Энэ бол байгаль дээр хамгийн сайхан амьтдын амьд урсгал байлаа. хүн хүртэл түүнд байраа тавьж өгмөөр. Би соёлжсон ертөнцийн хэрзгэр нуруу, чөрийсөнм хөлтэй, зарц барлгуудын хайчинд сэглэгдсэн, туранхай, морьдыг ярийагүй байна, харин нүд алдам ногоон талдаа хээрийн цэцэг мэт дураараа өссөн, салхинаас өөр юм нуруундаа хүргэж үзээгүй зэрлэг адууг ярьж байна.

Тал дундуур давхилдаж байгаа зэрлэг хангал азраганы сүргнээс илүү сүртэй юм үгүй билээ. Энэ сайхан үзэгдэл хүмүүсийг айлгана, зүгээр хараад байхын аргагүй аюултай. Ялангуяа задгай газраас харна гэвэл өөрөө адууны хөлд гишгүүлэхэд хүрнэ.

Хээр морьтой залуу, бидэрть мустанг унасан бүсгүй хоёрт чухам ийм л аюул тулгараад байна. Ийм үед ямар аюул тохиолддогийг мустангер туршлагаараа мэдэж байв. Бүсгүй ч гэсэн гадарлаж байгаа бололтой.

-Наашаа яваарай! Гэж Морис хашгираад сүргийн ар талыг чиглэн морио лавирч -Аюул учирлаа! Биднийг азрагнууд харчихаж шүү! Бушуулаарай! Бушуулаарай!Амь өрссөн хэрэг боллоо шүү! гэв.

Гэвч энэ нь илүү үг байжээ Азрагнуудын байж байгааг нь зөвхөн хурдан хөдлөхөөс л бидэрт мустанг, бүсгүй хоёрын хувь заяа шийдэгдэнэ гэдэг нь илт байв.

Үзэрлэг азрганудын задгай газар давхин гарч морьтой улсыг хараад, хоорондоо ноцолдохоо гэнэт байчихлаа. тэд туршлагатай удирдагчаасаа тушаал авч цөм нэг эгнээнд зэрэгцэн, дайралтанд бэлэн болж байгаа суман шиг зогсцгоов. Тэдний хоорондын дайсагналцал нь мартагдан, нийтийн дайсны эсрэг дайрах чюмуу аюулыг хамтарн сөрөх гэж байгаа ч юм шиг санагдана. Ингэж зогссон нь тэдний гэнэт гайхсны илрэл байж магадгүй. Юутай ч гэсэн тэр зугадаж яваа хүмүүст аябайхан далим болжээ. тэр хоё, хэдхэн хормын самбаанд дайсныхаа ар хупрагаар орж, аврагдах зам дээрээ гарч авчээ.

гэлээ ч гэсэн тэднийг бас аюул заналхийлжбайв. хөөгчдөөсөө тасрах эсэхж нь мэдэгдээгүй бөайда. Учир нь нь зэрлдэг адунуд тэдний зкугтан зайлсныг мэдээд хуухчин янцгааж хойноос нь хөөн гүйцэхээр ухасхийлээ.

Энэ үеэс эхлээд сул адуу, дээрэ хүн унуулсан морьдын тогтоож хаахын аргагүй уралдаан эхэллээ.

Урьтаж хожсон нь зай нь багасаагүй боловч морис байн байн эргэж харах бөгөөд түрүүчийнхээадил сандарч тэвдэж байгаа нь түүний царайд илэрхий байв. хэрэв Морис ганцаараа яваа бол өчүүхэн зуур ч санаа зовохгүйёсэн билээ. хээр морь нь адилхан мустанг учир юунд ч гүйцэгдэхгүй гэдгийг мэдэж байв. харин бидэрт мустангийн эрч харьж байгаа нь гай болж байжээ.Тэр нь хөөгсдөөс тасрах дургүй байгаа юм шиг санагдана.

"Юу болох нь энэ вэ?" гэж Морис гайхан ядаад, хойноосоо явж байгаа Луизатай зэрэгцэх гэж мориныхоо амыг татав.

"хэрэв бидэнд саад учирвал балрах нь тэр. Бидэнд цаг мөч нэг бүр үнэтэй байна" гэж бодлоо.

-Азарганууд биднийг гүйцэхнгүй байх. тимй биз? гэж мустангерын санаа зовж байгааг ажиглаан Луиаз асуув.

-Одоохондоо үгүй. Бидний өмнө даанчтом саад багйаа нь харамсалтай. таныг унаанд сайн гэж би мэдэж байна, гэвч морь чинь нэг л биш. Би итгэхгүй байна. та түүнийг илүү сайн мэднэ. Тэр... юуг харайж чадах болов уу?

-Юуг?

-Та одоохон харнаа. Бид тэр газар ойртож явна. Тэд минутын дотор б ээр газрыг туулан зэрэгцэн давхив.

Мустангерын хэлснээр төдөлгүй нөгөө сааданд ойртож очив. энэ нь нүд алдам тал дунд онгойн харагдахжалга байлаа. Арван таван тохойгоос доошгүй өргөн, мөн тийм дайны гүнзгий, хоёр тийшээ эцэс төгсгөлгүй үргэлжилжээ. хэрэв хоёр тийшээ гарц хайж явах юм бол цаг алдан, азргануудад гүйцэгдэж магадгүй.

Энэ нь өөрсдийгөө ална гэсэн үг байлаа.

Жалгыг харайж гарахгүй бол зэрлэг адуунд гүйцэгдэх болно. Арван таван тохой хяраатай харайх лдтэднийг аврах байлаа. Хээр морь энэ зэргийн юм олныг үзсэн учир алзахгүй нь лав. Бидэрт мустанг л яах бол?

Жалганд тулан ирмэгцээ мустангер

-Энэ дээгүүр наадахи чинь болов уу ? гэж сэтгэл нь зовсон өнгөөр асуулаа.

-Эргэлзэхгүй байна гэж ДЛуиза итгэлтэйгээр хариулав.

-Гэвч та өөрөө тогтох уу?

Креол бүсгүй тас тас хөхрөн.

-Ирланд хүнд энэ чинь хачин асуулт байна. таны нутгийнхан чинь ийм үгийг доромжиллоо гэж үзэх байсан гэдэгт би итгэж байна. Намгархаг Луизанд төрсөн би хүртэл үүнийг чинь найрсаг гэж үзэхгүй л байна. Миний тогтох эсэхийг асууж багаа бол хаана ч аваачсан тогтонон гэдгээ хэлье.

-Гэвч мисс Пойнлдекстер гэнэт чадахгүй болбол яана. хэрэв жаахан ч гэсэн эргэлзэж байгаа бол түүнийг орхисон нь дээр биш үү? Миний морь хоёулангий маань ганганы цаана гаргачихаж уужуухан чадна.

Мустангийг золионд гаргаад бид аврагдана. Зэрлэг азрга гэдэг маань ... гэж бидэрт мустангийн хүчинд итгэж чадаагүй байгаа Морис хэлтэл Луиза үгий нь таслан.

-Лунаг орхих гэнээ? Түүнийг газолуусранг азргануудад хаяж өгөөд бариулчих гэж үү! Үгүй, тэгэхгүй шүү эрхэм Жеральд минь ! мжстанг минь наддаа даанч их үнэ цэнэтэй амьтан. Чадвал л хавцал дээгүүр цуг харайлгана даа. хэрэв харайж чадахгүй бол хамт л ганганы ёроолд унаж хүзүүгээ мултлана биз ...

За , сайн морь минь дүүлэн харайя! Чиний хойноос хөөн, чамайг барьж авч номхруулсан хүн ёинь энэ байна. Чи түүнд тэгтлээ номхроогүй гэдгээ үзүүлж хэрэв хэрэгтэй гэвэл найзархаг ч бай, дайсагнасан нь ч бай дарлалыг таягдан хаяж чадна гэдгээ үзүүлээдэх. Сүүлийн долоо хоногт бид байнга хийдэг байсан тэр үсрэлтийг нэгийг үзүүлээч. Алийв хонгор минь дүүлье! Гэв.

Тэгээд зоригт креол хүүхэн өөрийг нь дэмжсэн жишээ үзүлэхийг хүлээсэн ч үгүй хавцлыг ирмэг тийш тайван явж очоод, тэр саадгыг сүүлийн долоо хоногт банга хийж байсан харайлтаар даван гарав.

луизаг харж байсан Морист гурван янзын сэтгэгдэл төржээ. нэд гаргах, хоёрт биүрэх, гурав дахь нь харахан тодорхойгүй ажээ. Тэр сэтгэгдэл “Мустанг минь наддаа даанч их үнэ цэнэтэй амьтан” гэдгийг сонсоод төржээ. “Яагаад” хэмээн саад дээгүүр харайхдаа бодов.

Гэвч хавцлыг амжилттай гаталлаа. ч гэсэн тэр нь аюулгүй байдлыг хангасангүй.трэ ганга нь зэрдэг азаргануудад саад болж чадахгүйбайсан учир урьдахаасаа илүү сэтгэл зовон эргэж харав.

Аюул бүр ч их ширүүн болжээ. хавцал гатлах гэж мунгинасаар байх хооронд азрагнууд ойртоод ирсэн байжээ. Азарганууд тэднийг хөөж явахдаа энүүн шиг тийм ойрхон ирээгүй юм. тэд хавцал дээгүүр юунд торолгүй үсрэн гарав.

Тэгтэл юу болох нь энэ вэ? мустангер энэ асуултыгөөртөө тавиад хариу олж чадахгүйдээ хувхай цайв.

Саадыг харайж гараад мустангер нэг хором ч зосоолгүй цаашаа давхиахд, архан талд нь бүсгүй нөгөө л янзаараа хоцролгүй давхина. Ирландын хөдөлгөөнд түрүүчийнх шиг итгэлтэй байдал алга болон нэг юм шийдэж ядан тээнэгэлзэж байв.

Гуунаас жаахан холдоод Морис эргэж явахаар шийдсэн юм шиг гэнэт мориныхооамыг татаж зогсоогоод хажуугаар нь зэрэгцэн ирж байгаа залуу хүүхэнд хандаж:

-Пойндекстер авхай, та ганцаараа түрүүлээд яв гэлээ.

-Яагад? Гэж тэр хүүхэн зог тусан асуув.

-Хэрэв бид энэ чигээрээ салахгүй хамт явах юм бол азаргануудыг зогоох талаар ямар нэг арга хэмжээ авах хэрэгтэй. одоо нэг арга байна. бурхныг бодож битгий юм асуугаад байж үз! Арван хором өнгөрвөл л баларлаа. Урагшаа хараач. Усны мандал харагдаж байнаа биз? тэр чинь цөөрөм байгаа юм. тийшжж шалавхан яв. та танзд хоёр өндөр хашааны хоорондуур орчих. тэр хоёрын үзүүр нь цөөрмийн тэнд нийлдэг юм. тэнд орох хаалга, хажууд нь шургааг байгааг харагдана. Хэрэв намайг гүйцэж очихгүй бол тэр хашаан дотор шууд давхиж ороод, мориноосоо бууц, шургуугаар үүдийг нь хаачихаарай.

-Та яах вэ? та аюулд орно шүү дээ...

-Миний төлөө битгий ай. ганцаараа байхад ямар ч аюул байхгүй. хэрэв бидэрт мустангш бишсэн бол ... За бууулаарай. Цөөрмийн барааг битгий алдаарай. тэр цөөрөм таны замын тэмдэг болог. Хашааны үүд хаахаах мартуузай. Бууулаарай! Бушуулаарай!

Тэр хүүхэн, өөрий нь хамгаалж амь насандаа аюул учруулж байгаа хүнээсээ салж явах дургүй нэг хором өнгөрлөө.

Аз болоход тэр хүүхэн хэцүү үел яахаа алдаад өөрийгөө хамгаалагчийг зовлонд учруулагчихдаг тийм мунхга хулчгар хүүхэнүүийн нэг биү байжээ. Луиза зөвлөгчийнхөө эр чадал, түүний мэдэж байгаа юм, хийж байгаа үйлсэнд итгээд цөөрмийнзүг дуулгавартай

ухасхийн давхилаа. харин Морис морио эргүүлэн, дөнгөж саяхан харайж гарсан жалга руугаа буцан очив.

Морис хамт явсан хүүхнээсээ салаад ганзган дарв үуудай дотроос хэзээ нэгэн цагт тал нцтгийн амьтныг өөдөөс, нь индиан , зэрдэг сарлаг, баавгайн өөдөөс хамгаалах маягаар шагайж байсан буун дотроос хамгийн төгөлдөр боловсронгуй нь болох зургааүсэрдэг Кольт маягийн гар буугаа гаргав. Дина, Адамс зэрэг цирмээс гаргасан хуурамч, гял цал оргисон буу биш, жинэхэн “задийн эх орны” хийц “Хартфорд” хэмээх тамга тэмдэглэсэн буу байлаа.

"Бидний харайлгаж гарсан газраар азарганууд харайна. Хэрэв би тэднийг нэгийг унагаад авбал бусад нь зогсоод Луизагийн мустангид давхих самбаа олдоно. Удардагчид ннн тэр зээрл азарга бололтой. Тэр л эхэлж харайна даа. гар буу маанв зуун алхамд алдахгүй. Цаг болчихлоо шүү” гэж Морис ангалынцаанаас ирж яваа зэрлэг сүрэг рүү харангаа амандаа үгэлж байв.

Сүүлчийн үгээ хэлж, дуусав уу үгүй юу буу тасхийн. Азаргануудын дотроос хамгийн том биетэй нэг зээрд азарга, зовлогоороо зам татлан газар ойчив. Хойноос нь давхиж басан хэдэн азрага тэр дорхиноо зог тусч бусад нь цөм тэдний цаана зог тусав.

Морис тэдний у болсныг харсан ч үгүй, нэмж буудсан ч үгүй. тэдний самгардсаныг байдлыг ашиглан , самбаачилж баруун тийш эргэж, гялалзсан цөөрөмд ойртож яваа бидэрт мустангийн араас давхила.

Зэрлэг адуунууд , тэдний хойноос хөөхөө болив. Тэд удирдагчаа алуулсанд ара барагдсан ч байж болох, эсхүл түүний хүүр нь ганга дээгүүр харайж болмоор ганц замыг тагличихаад саад болсон ч байж магадгүй юм.

Морис бүсгүйн араас тайван шиг цогиулав.

Түүнийг цөөримийн тэнд хүрч очиход, Луиза аль хэзээний оччихсон байж байлаа. тэр, Морисын заасан бүхнийг яв цав биелүүлжээ. Тэгэхдээ гагцхүү хауаны хаалгыг хаагаагүй байв. Үүд нь задгай шуогаагнуудад нь газар хэвтэнэ. Луиза гүнээ баярлаж байгаага илэрхийлэн хэлж чадмааргүйсэтгэл нь догдлон хөдлөөд морин дээрээ чимээгүй сууж байлаа.

Аюул өнгөрчээ.

XVII. Зэрлэг мустангын занга

Тэдэнд айх аюулгүй болсон учир залуу креол хүүхэн эргэн тойрныг сонирхон харлаа. Нэг нуур, техасынхаар бол цөөрөм харагдлаа.

Цөөрмиын зах ирмэг нь адууны туурайнд онгилогдсон ажээ. Энэ бол адуу ус уухдаа таатай газар мөн нь үзтэл илэрхий. Хоёр жигүүр нь усны санг торйон тал дундуур нь алслан гарсан өндөр шургааган хагаа, юүлүүр мэт нарийсэн үзүүртээ орох хаалгаар дуусчээ.

-Энэ юу вэ? гэж Луиза хашааг зааж асуув.

-Зэрлэг адууны занга гэж Морис хэллээ.

-Зэрлэ адууны занга гэнээ?

-Зэрлдэг адууг хашиж байртдаг газар. таны харж багаа хоёр тийшээ алгуур дэлгэгдэн тал руугэртээ тийшээ гарсан цэлгэр жигүүр дундуур зэржлэг адуунууд идээшилдэг вь. тэд усанд татагдаж энд ирэх буюу эсхүл тэднийг мустангерууд энэ явцуу газар руу хөөж оруулдаг юм. тэгээд энэ цэлгэр хашаан дотор орж ирэхээр нь үүдий нь хаачихаад дараа нь барихад амархан байдаг юм

Хөөрхий амьтад! Энэ хашаа чинь таных уу? Та чинь мустангер, тиймээ, та тэгж хэлсэн шүү дээ?

-Тиймээ, би мустангер гэхдээ энэ аргаар ан хийдэггүй, би зэрлэг адуу барихдаа ганцаараа явах дуртай. Би, мустангеруудтай хамт ажиллах нь ховор. Наад зах нь хорин хүн шардагддаг энэ хашааг би хэрэглэдэггүй юм. Хэрэв бугуйлыг зэвсэг гэж нэрлэж болох бол миний зэвсэг энэ дээ.

-Та их сайн бугуйлч юм билээ, Би тэгж дуулсан, бас өөрөө ч харсан.

-Та юун найрсаг хүн юм, харин би таны магтсанд хүрэхгүй. Энэ зэрлэг тал нутагт мексикчүүд гэж төрөлхийн б угуйлч улс байваг юм. таны сайн бугуйлч гэж хэлээдбайгааг тэд бүгдээрээ л нэг боольхой эр гэж хэлнэ дээ.

-Эрхэм Жеральд таны даруу зан чинь өрсөлдөгчийнхөө хүртэл хэтэрхий үнэлэхэд хүргэж байх шиг санагдана. Харин би өөрөөр сонссон юм.

-Хэнээс?

-Таны танил Зебулон Стумп гуйгаас сонссон юм.

-Ха,ха! Өвгөн Зеб чинь бугуйлын талаар мэдлэг муутай хүн.

-Бич бас бугуйл сурмаар санагдах юм. гэвч энэ бол эмэгтэй хүний ажил биш гэгцгээх. Энд муу юм юу байгааг би ойлгохгүй юм гэж залуу креол хүүхэн хэллээ.

адилхан жирийн спорт шүү дээ. Би нэг жигтэйхэн сайн бугуйлч хүүхнийг танина.

-Тэр чинь америк хүүхэн үү?

-Үгүй, Рио-Грандын орчимд байдаг мексик хүүхэн. Леон руу , манайхаар хааяа ирдэг юм. Энд хамаатнууд нь амьдардаг юм.

-Залуу хүүхэн үү?

-Эрхэм Пойндекстер авхай таны л үеийн байх гэж бодож байна.

-Өндөр үү?

-Танаас жаахан намхан

-Тэгээд үнэнэдээ надаас хавьгүй сайхан хүүхэн биз дээ. Би, мексик хүүхнүүдийг манайы америк хүүхнээс хавьгүй сайхан гэж дуулсан юм.

-Креол хүүхнүүд, энэ зэрэгт багтахгүй гэж санаж байна гэж Морис ая засч хариулав.

-Би бугуйл хаяж сурах бол уу, үгүй бол уу? гэж залуу креол хүүхэн Морисын магтаал үгийг ан анзаараагүй юм шиг үргэлжүүлэн хэлээд-Би одоо сурч эхэлбэл хождоо бол уу? мексикчууд бугуйлыг хар багаасаа сонирхон оролддог боохоор тийм гоц сайн бугуйлч болцгоодог гэж би дуулсан юм.

-Үгүй, та огт хождоогүй байна. нэг хоёр жил дадлага хийгээд л сайн бугуйлагч болно. Жишээ нь , би энэ ажлаар гуравхан жил оролдоод ... Одоо бол гэснээ морис өөрийгөө магтлаа гэж хэлүүлэхийг хүссэнгүй учир дуугүй боллоо.

-Одоо бол та чинь техас даячар хамгийн сайн бугуйлагч биз дээ? гэж луиза Морисын хэлэх гэсэн үгийн санааг таамагдан хэллээ.

-Үгүй, үгүй! энэ бол үөхөн, миний чадварыг өөрийнхөөрөө дүгнэдэг өвгөөн Зебийн хэлсэн үг гэж Морис инээлд алдан хэлэв.

"Юунд ийм даруу зан гаргаж байгаа юм бо? Эсхүл энэ хүн намайг шоолоод инээж байгаа юм бол уу? Хэрэв тийм бол ч би залуурна шүү" гэж креол хүүхэн бодлоо.

Тэр хүүхэнд ямар нэг сэтгэл тогтворгүй болсоён шинж байгааг Морис ажиглаад:

-Та нөхөр рүүгээ буцмаар байна уу? таныг ийм удаан алга байхад аав чинь сэтгэл зовж байгаа байх. Бас таны дүү таны үеэл ... гэвэл.

-Нээрээ тийм, Би энэ тухай огт санасагүй. Ингэж сануулсанд чинь баярлала. Буцах хэрэгтэй гэж тэр хүүхэн даажигнасан ч юм шиг , гомдсон ч ввшиг дуугаар хэллээ.

тэр мориндоо дахин мордлоо. Тэр хүүхэн жолоогоо дуртай дургүй барьж, яагаад ч юм

дөрөөгөө аажуухан дөрөөлөөд ер нь энэ газраас холдох дургүй мэт балаа.

Дахиад л тал дунд орлоо. Морис өнөө хүхэнтэйгээ цуг хамгийн дөт замаар зугаалгын газар руу явлаа.

Тэдний буцах зам нь “хог ургамлын талыг” дайран гарна. Тэр газрыг Америкийн анхны золончлогчид төдий л их бодсонгүйгээр тэгж нэрлэжээ. Байгаль өөрөө тарьж ургуулсан бөгөөд тэнгэрийн хаяатай зах хязгаар нь нийлж, Луизиан нутгийн тэр хүүхний эгэн тойрон харагдаж байлаа.

Энэхүү байгалийн үзэсгэлэнт газар нь олон хүнд хамгийн бүдүүлэг хүмүүст хүртэл өөдрөг нөлөөг үзүүлж байдаг билээ. Би гоо сайхан гэдгийг хайхардаггүй нэгэн зэрлэг хөгшин эр ургамлын талд мөрий нь шүргэм өндөр цэцгэн дунд зогсоод нүд алдам цэлийх цэцэгсийг сонирхон зүрх нь уярч ббайхыг харж билээ...

-Ямар сайхан юм бэ! гэж тэр креол хүүхэн мориныхоо амыг өөрийн эрхгүй татаж сэтгэл догдлон хэллээ.

-Эрхэм Пойндекстер авхай, танд энэ газар сайхан санагдаж байна уу?

-Сайхан санагдах гэнээ? Энэ чинь ч бас таарахгүй үг. Учиргүй сайхан санагдаж байна. Байгалийн хамагл сайхан юмыг би үзэж байна. Ногоон зүлэг, ой, үугуй, цэцэг гээд бид бүгдийн зүдэрч ургуулсан маань энэний дэргэд юу ч биш, Байгалийн энэ хэсэг газарт юу ч нэмэхийн хэрэг алга. Тун ч сайхан онгон газкар юм даа!

-Энэ орон байх л дутуу юм.

-Гэвч байшингийн дээвэр, яндангийн нь байгалийн энэ үзэсгэлэнг гутаачих байх даа. Үзэсгэлэнт ой мод сайхнаа! Би модныб нөмөрт амьдрахсан, ттүүний нөмөрт...

Тэр хүүхний амнаас: “дурлалцахсан” гэсэн үг гарчих шахсан боловч гэнэт түгдрэн өөрөөч мэдэлгүй байтал нь тэр нь “үхэхсэн” гэсэн үгээр аяндаа солигдлоо.

Хүүхний сэтгэл ирланд үззалуугийн сэтгэлтэй нийлсэн, хэлсэн үг нь тэр залуугийн бодол санааны цууриа мэт санагдсанаа хүлээхгүй бол муухай хэрэг байлаа. Гэвч морис хүйтэн байдлаар хариу дуугаран:

-Орон гэргүй, үерхэх нөхөдгүй бас.. тийм амьдрал таныг дорхнноо залхаачихна байх гэж би айж байна гэв.

-Таны бол яах вэ? тийм амьдар таныг яагаа залхаагүй юм бэ? Таныг тийм байдлаар олон жил амьдарч багаа гэж танб найз Стумп гуай надад ярьсан юм. тийм үү?

-Яриагүй тийм Өөр амьдрал намайг татдаггүй юм.

аа! Би энэ үзэсгэлэнт байгалийн дунд байвал үүрлийн жагалаа эдэлнэ гэж боддог. Би тийм амьдралаас хэзээ ч уйлахгүй.

-Ганцаараа юу? Хань нөхөдгүйгээр үү? Тэр ч байтугай толгой хоргодох орон ч үгүйгээр амьдрана гэж үү?

-Би энэ тухай яриагүй... харин та өөрөө яаж амьдарч байдгаа надад яриагүй шүү дээ. та гэртээ биз дээ?

-Миний орон байр бол нэр зүүхээр юм биү Үнэндээ миний муу овоохой бол манай нутгийн хамгйн болхи орон байруудын нэг нь байгаа юм гэж морис инээн хэллээ.

-Тэр чинь хаана байлдаг юм бэ? Бидний өнөөдөр байсан газраас хролгүй , нэгтээ нь байдаг уу?

-Эндээс онц хол биү, нэг бээрээс хэтрэхгүй... Та тар баруунтай харагдаж байгаа моднуудын оройг үзэж байна уу? тэр модуудад миний овойхоог нарнаас халхалж , шуурганаас хамгаалж байдаг юм.

-Өө тийм бий! Би түүнийг үзэхийг яасан их хүсэж бана вэ? та жинэхэн овоохой гэж хэлэв үү?

-Тиймээ, жинэхэн овоохой

-Ганцхан овоохой ву?

-Ойр хавьд арван бээрийн дотор нэг ч орон байр байхгүй.

-Тэр овоохой чинь модон дотор бадаг юмуу?

Сайхан газар уу?

-Хэн юул гэж бодно тийм л газар даа.

-Юу байдгий нь очиж үзмээр л байна... Эндээс ганцхан бээр гэв үү?

-Очиход нэг бээр ирэхэд нэг, нийлээд хоёр бээр

-Тийм ч айхтар хол биш юм байна. хориод минут явахад л болно.

-Таны шадар хүмүүс тэсвэрийг алдуулахад хүрнэ гэж би айж байна.

-Бас таны зочломтогой занг ч гэсэн Эрхэм Жеральд, та энэ тухай бодоогүйгий минь уучлаарай гэснээ бүсгүйн царай ялимгүй барайж-Та гэртээ ганцаараа суудаг уу? таны овоохой бас ямар нэг хүн тантай цуг байдаг биз? гэж залуу хүүхэн үгээ үргэлжүүлэн.

-Өө тэгэлгүй яахав? Би ганцаараа биү. надтай цуг: “

Морисын хэлж лдуусахас өмнө Луизагийн сэтгэлд морисын найзын дүр урган гарчээ. Морисын найз бол “борхон царайтай, буйлс шиг нүдтэй насаар миний үе, сувднаас ч цагаан шүдтэй, ув улаан хацартай, Касторгийн сүүнээс урт гэсээгтэй, хүзүүндээ чимэгтэй, гар таа бугуйвчтай, сайхан хийсэн богинохон банзал, жижигхэн хөлдөө гутал өмссөн тийм хүүхэн байх ёстой” гэж Луиза бодов.

-Таны найз чинв ялангуяа гадны зочин очвол таашаахгүй байж магадгүй биз дээ?

-Хаанаас даа тэр маань шал танихгүй хүн байлаа ч ыгэсэн таньдаг нөхөр байлаа ч гэсэн айлчилж очиход дандаа б аярлаж байдаг юм. миний тэр хуурай ах бол их найрсаг хүн дээ. харин хөөрхий минь одоо хүн хартай уулзах нь ховор болж дээ.

-Таны хуурай ах гэнээ?

-Тийм. нэр нь Фелим Онил гэдэг юм. Бас л надтай адилхан Номин арлын

1

Голуэ гүнлэгийн ирланд хүн, харин яриа нь минийхээс ч их ирланд аялгуутай.

-Ээ, тар хүний юм ярихыг нь сонсох, юмсан! Тэр нутгийнхаа хэллэг их сонин байхаа. Тийм биз?

-Би өөрөө тэндхийн хүн болохоор тийм гэж хэлэхэд хэцүү байна. харин та Фелимээр хагас цаг үочлуулахбг зөвшөөрөх нь таны л дурмэдэх хэрэг.

-Тэгвэл ч гялайх нь тэр! энэ чинь надад үзэгдээгүй сонин хэрэг болно шүү! Аав энэ тэр хүлээж л байг. Би тэнд байхгүй ч гэсэн хатагтай нар байгаа юм чинь. Харин залуу харчуул нь бидний ул мөрийг эрж л байг. Энэ чинь мустанг авлана гэдгээс ч сонин байна. Битанб урьсныг баяртайгаар хүлээж авья.

-Би таныг даанч олигтой дайлж чадахгүй байх гэж айыж байна. Фелим гэртээ ганцаараа хоцроод хэд хонож байна. Ан гөрөө хийдэггү юмдаг. Лав л юу ч үгүы, хоосон сууж байгаа байх. харин мустангуудын хойноос давхихаасаа өмнө юм идэж амжсан тань сайн хэрэг...

мэдээж Фелимийн агуулахыбн тухай яриа Луиза Пойндекстерыг замынхаа чигийг өөрчлөхөд хүргэсэнгүй. Ирланд хүний муруй хазгай яриаг очиж чагнах гэж их шохоорохсонгүй. Бас Морисынг овоохойг үзэх гэсэн сонирхол ч түүнийг тийш нь хөтөлсөнгүй. гагцхүү тэсч давахын аргагүй өөрий минь хувь заяа юу даа жгэмээр нэгэн санаа Луизаг тийш нь маш хүчтэй түлхжээ.

Алмо дахь ганц овоохойг Луиза очиж, түүн дотор орж үзлээ. тэр хүүхэн, Морисын өвөрмөц орон байхрыг сонирхон үзэж, тэр овоохой дотор ном цаас, бичгийн хэрэгсэл зэрэг эзэн хүний боловсролтойг гэрчилсэн зүйлүүд байхыбг үзээд сэтгэлд ньв их таатай санагджээ. тэр хүүхэн, Фелимийн зугаатай үгсийг гоц сонирхон ёагнаж, бас түүнийг дайлсан архианаас бусад нь бүх

юмнаас нь дургүйцэлгүй амсч үзжээ. Тэгээд хөхүүн байдал дорхиноо амсч үзжээ. Тэгээд хөхүүн сэргэлэн буцаж явлаа.

Гэвч түүний хөхүүн байдал, дорхиноо өөрчлөгдөв. Шинэ юм үзэж төрсөн сэтгэдэл, өрнүүн хөгжилтэй байдал нь алга болжээ. тэр хүүхэн, цэцэг навчаар бүрхэгдсэн тал дунд дахин ормогцоо хүнл бодолд дарагдав. Нэгэн бодол зүрх сэтгэлийг нь зовооно.

Тэр , чив чимээгүй алга болоод аав, дүү, ойр дотно хүмүүс, найз нөхдийнхөө сэтгэлийг нь зовоож, удаан хүлээлгэсэндээ тэгж зовсон вч болуу? Эсвэл дэндүү хөнгөн хөдөлж гэж хүн хэлэхээс айгаа юу? Үгүй, үүнд Луизагийн сэтгэл зовсонгүй. Түүний царайг барайлгасан гуниг нь шал өөр юмнаас болжээ.

Бүхэл өдөржин цайзаас зугаалгын газар хртэл явж, ойн чөлөөнд уулзаж , зэрлэг азаргануудад хөөгдөөд Морисоос хамгаалуулж явсан, бас цөөрмийн дэргэд амарч, тал дундуур явж тэндээсээ буцаж овоохойд дотор сууж байсан энэ бүх хугацаанд түүний хамт явсан хүн нь эелдэгхэн загнан ёсыг нарийн баримталжбайснаас өөр юм байсангүй.

XVIII. Хардлага

Луизад туслахаар давхисан дөчин хүний дотроос хэдхэн нь уйгагүй хөөцөлдсөөр ихэд хлол явжээ. тэд зэрлэг адуун сүрэг, бидэрт мустанг ба мустангерыг бараагүй алдаад б ас бие биеэсээ төөрч эхэлжээ. тэгээлд тэр дорхиноо тал хөндийн дунд ганц нэгээрээ буюу хоёр гурваараа хэсэг бүлэг болон сарницгаав. Тэдний олонхи нь мөр хайж сураагүй учир манадын мөрийг алджээ. Тэгээд тэд мөнхүү сүргийн мөрыбайж болох боловч түрүүнд нь гарсан мөр хөөн давхилдаж замаасаа хазайжээ.

Уэст -Поинтийн цэргийн сургууль саяхан төгссөн офицероор удирдуулсан мроин цэргүүд сүргийн барааг алдаад тэдний хуучин үлдээсэн мөрөөр орж явахад нь зочдын ихэнх нь араа нь даган явжээ.

Тэд хаа нэг бут сондуул ургасан гүвээ, толгшод дундуур орж сүүлдээ бие биеийнхээ бараагч алдчихжээ. Хөөцөлдөөн эхэлснээс хойш хориод минутын дараа тэнхгэрт нисэгч яваа шувуу л тавиад морьтон эхлээд нэг газраас гарснаа сүүлдээ тал тал тийшээ давхихыг харж болоах байлаа.

Харин нэг хүн зөв чиг ирүү явж байлдаа. Тэр гойд сайхан биш боловч шөрмөслөг, хурдан хүрээ зүстэй, бяраа чадал ихтэй морь унажээ. Цэрэг маягийн цэнэхэр өмд цамц өмссөн, мөн тийм цэнхэр малгай тавьсаан нь морин цэргийн ахмад агсан Кассий Колхаунаас өөр хэнч биш гэдгийг гэрчилнэ. Морио байдгаар нь давирч, тагуурдан зөв мөрөөр мөшгин дахиж яваа ажээ. түүнийг өөрийг нь гэсэн хурц үзүүртэй давируул мэт бодол үгвдүүлэн зорилгодоо хүрэхийн тул хамаг тэнхээгээ шавхан дайчилж байлаа

Өөрөөч чухам энэ бүгд ву болж дуусахыг хэлж мэдэхгүй боловч хуйнаас цухуйсан гар бууныхаа бариул руу байн байн хялазах нь ямар нэг муу юм боджээ гэдгийг нь хэлээд өгч байв.

Хэрэв нэг учир байгаагүй бол Колхаун ч бас бусдын адил замаасаа төөрөх байжээ. хоёр морины сайтар мэддэг мөр л түүнийг дагуулсаар байв. Арай том мөрийг нь тэрээр зовууртайгаар тодхон санаж байв. нурам болсон тал энэхүү мөрийг харжээ. тэгэхэд яагад ч юм энэ мөрийг сайтар санаж авсан бөгөөд одоод түүнийг төвөггүйгээр таньжээ.

Ахмад Колхаун ширэнгэнд хүрээд тэр дорхиноо бидэрт мустангийн гэнэт зогссон өнөөч чөлөөнд гарч ирэв. Ахмад энд төдий л түдэггүй хүрч ирсэн боловч цаашаа мухарджээ. Зэрлэг адууны мөрөн дотор тахны мөр танигдахаар байсан боловч энд ирээд давхиагүй бололтой байлаа. морьтонгууд зкэрэгцэн зогссон байв.

Хаашаа явчихав? Манадын мөрөн дотор тахтай туурааныны мөр байхгүй болчихов. Хаанч байсангүй. эргэн тойрны газар нь хатуу хайрга чулуутай учир давхисан морины мөр гарна уу гэхээс хатирч яваа гарахааргүй ажээ.

Бидэрт мустанг, хээ морь хоёр эндээс зэрлэг морьд хаудаг газар руу хөдлөхдөө эхний зуун алхамыг зүгээр алхуулж явсан байв.

Колхаун ихэд мэгдлээ. мөрнүүдийг эргэн тойрон явж ажигдаж үзсэн боловч тахтай морьдын

явсан зүгийг олж чадсангүй.

Бүүр гайхаш тасраад байтал нэгэн морьтой хүн ирж явааг колхаун харлаа. Ханхалзсан том биетэй, урт сахалтай тэр хүний унасан адсага шиг морийг лав л зуун бээрийн дотор олно гэвэл хэцүү бизээ. Энэ нь хөгшин анчин болохыг төвөггүй таньж болох байв. Колхаун Зебулон Стумпын Техаст ирэхээсээхамаагүй өмнийн таньдаг байжээ.

-Колхаун та, залуу хатагтайн тухай юм мэдэв үү? Гэж анч өвгөн ер бишийн овжиноор асуугаад Колхауны арга нь тасрасан нүүр өөд харж, зохих дүгнэлт хийгээд үгээ үргэлжүүлэн- Үгүй та түүнийг гүйцсэнгүй дээ. Чөтгөр аваг гэм! Тэр муу золигийн гүү Луизаг хааш нь аваад явчихваа? Үгүй мөнсонин юмаа. Яагаад ийм хэрэг болчихоов. Пойндекстер авхай моринд их лсайн юмсанн 33а гайгүй, сүрхий аюул тохиолдохгүй байлгүй. мустангер лав тэр гүүг бугуйлдаад авах байх. харин та яагаад хоцорчихоов? Гэж асуув.

-Тэд хаашаа явцгаасныг би мэдэхгүй гайхаж байна. Энэ мөрний байдлаар үзвэл энд зогссон бололтой. Харин эндээсээ хаашаа явсны нь мэдэх юм алга.

-Тийм байна Колхаун гуай, таны хэлдэг зөв. Тэд энд зогсч байж тэр хосры бие биедээ их ойрхон зогсч байсан байна шүү. Энд хүрч ирээл зэрлэг гүүнүүдийн хойноос хөөхөө больж, яриагүй тэгж. Чухам хаашаа яваад өгөө юм бол.

Зеб Стумп асуултынхаа хариуг Колхаунаас биү тэндээс олох гэж байгааюм шиг харагдлаа.

-Би тэдний мөрийг ердөө олохгүй байна гэж ахмад хариу хэллээ.

-Та олохгүй байна гээ? Тэгвэл би харж байна. Наашаа хараач! Налчихсан өвсөн дээрх мөрийг үзэхгүй байна гэж үү?

-Үгүй

-Бас энд сайн хар л даа ? Том тахын мөр байна. бас хажууд нь жижиг, Энэ зүг яввчихаж. тэгэхээр тэд энэ хүртэл зэрлэг адууны араас явжээ. Мөрөөр нь явцгаая.

-Тэгье.

Зеб Стумп өөр юуч ячярилгүй бусад хүнд ажиглагдахгүй байж болох боловч өөрийн нь хараанаас мултрахгүй мөрөөр орж явлаа.

Төдөлгүй хамт яваа хүн нь ч ялгаж эхлэв. Энэ нь Морис Луиза хоёрын азарганаас зугтааж дахин давхиж эхэлсэн газар бөөгөөд өвсөрхөг газар тахын мөр тодхон гарсан байлаа. тэгснээ дахин мөрөө алдах шиг болж чухамдаа гэвэл ногоон дээр гэсэн олон зуун мөрийг алдалгүй таньдаг Зеб Стумп л арайхийн ялгаж байлаа.

-Хөөе!Энд юу болчихоо вэ? нэг л юм болж дээ ... гэж анч өвгөн гэнэт хашгирлаа.

-Би зөвхөн зэрлэг гүүнүүдийн мөрийг л харж байна. тэд энд хошууран тойрсноо эргээ д явчихсан юм шигбайна гэж ахмад хариу хэлэв.

-Хэрэв тэд ингэсэн юм бол морьтонгуудыг хажуугаараа өнгөрсний дара ингэх ёстой. хэрэг өөр тийшээгээ л эргэж байнаа даа.

-Та тэгээд юу гэх гэж байна?

-Тэр хоёр, гүүнүүдийн хойноос хөөгөөгүй, харин гүүнүүд нь тэдний хойноос хөөжээ.

-Та түүнийг яааж мэдэх вэ?

Та энэ тахнымөрийг зэрлэг адууны туурайн мөр гишгиснийг харахгүй байна уу? Энэ чинь юуных гүү байхав, том туухрайн мөр байна шүү дээ. Бүтэн ямхаар том юм гээч. Энд азарганы сүрэгб айж Иосафат минь! Азрага мөн гэж үү?

-“Азарганууд-Тэгээд яачихаа вэ?

-Бидэртийн араас хөөсөн байна. хэрэв тийм бол мисс Пойндекстерт аюул учирчээ. Цаашаа явцгаая.

Аняч өвгөн цааш тайлбар хэлэлгүй мөр дагаж явахад Колхаун хойноос нь дагаж эхлэв жорын юм шалгаана.

Гэвч Зеб “Би тун завгүй байна. Битгий шалаад бөай” г гэсэн шиг үөөлхөн гараараа дохино.

Түүний хамаг анхаарал мөрний учрыг олоход нэг хэсэггээ татагджээ. Азаргануудыг туураинд гишгидэж баларсан мөрнүүдийг дотроос тахтай морины мөрийг ялгаж танихад маш хэцүү байжээ. гэвч анчин энд тэнд гарсган мөрийг ажиглан аажуухан хатируулсаар ургашлав.

Тэгээд өнө гууны ирмэгт зуугаад алхам ойртож ирэнгээ Зеб мориныхоо амыг итатан нүүрнээс нь сандарч тэвдсэн байдал алга болж одоо л нэг учрыг нь тайлбарлаж болно гэж үзжээ.

-Өө, ийм хэрэг болсон юсм бий” гэж Колхаун өвгөний яриаг сонсч хэлээд харин та яагаал тэднийг аврагдлаа гэж бодож байгаа билээ ? гэв.

-Энүүнийг хараач!

-Алагдсан азрага байна.. саяхан буудуулсан бололтой... Энэ ямар учиртай юм бэ?

-Мустангер л алсан гэсэн үг дээ?

-Тэгээд энэ нь таныхаар бол бусдыг нь хөөхөө больтол нь айлгасан хэрэг үү?

-Хөөх нь хөөхөө больж л дээ, гэхдээ дуу биш энэ азарганб үхдэл нь тэднийг зогсоосон байна. Чөтгөр аваг гэж! Ямар гайхалтай харайгаа вэ?

-Та тэднийг энүүгээр харайлгаад гаргачихаж гэж бодоогүй биз? гэж Колхаун асуухад-Харайлгах аргагүй газар гэв.

-Ямар ч гэсэн эгэлзээгүй сум шиг дүүлээд гарчихаж. Гууны

цаад талд байгаа морины мөрийг харахгүй байна гэж үү? Тэгэхдээ Пойндекстер авхаы түрүүнд харайлгасан байна. Иосафь минь! -----Ямар айхавгархүүхэн бэ! Тэд азрагыг буудаж алахаасаа өмнө өөрсдөө энүүн дээгүүр харайлгаж гарах ёстой. Тэгэхгүй бол тэр хоёр гарч чадахгүй болчихно. Энд өөр гарах газар байхгүй. Морис сайн эр чинь энэ азаргыг яг газрын нь аман дээр унагачихсан. Ёстой сайн эр!

-Манай үеэл дүү тэр хоёрыг энэ ганган дээгүүр зэрэг харайлгасангэж та бодож байна уу?

-Яг зэрэг ч биш гэж өвгөн Колхауныг ямар учраас ингэж асууж байгааг сэжиглэлгүйгээр - Бидэрт мустанг нь эхлээд харайж гэж би хэлсэн шүү дээ. Тийшээ хараач, тэр талд мөр нь храгдаж байна гэв.

-Тиймээ, би харж бөайна.

-Бас тэр мөрөн дээр мустангерын морины мөр гишгэсэн байгааг та харахгүй байна гэж шш дээ?

-Тэгээд яачихаав?

-Азаргануудын нэг нь ч тэр тал дээр харайж гарсангүй. ийм л юм болж гэж би бодож байна. залуу хархүү ганганы цаана гараад энэ адгууст сум илгээжээ. Энэ бол хаалга хаасантай адил юм болжээ. Нөхрөө үхсэнд хэлмэгдэн сандарсан бусад азарганууд тэрхоёрыг хөөхөө больж, өөр тийшээ зугаджээ. Жалганы эх өөд чиглэн явсан мөртнүүд нь харагдаж байна.

-Тэд ангалыг өөр газраар гарчихаад тэр хоёрын хойноос хөөсөн юм биү биз дээ?

-Тэгсэн бол жалганы дээд тал руу таван бээр, буцахдаа таван бээ, ингээлд энд ирэхээсээ өмнө арван бээр явахад хүрэх байсан. Гэвч тийм хэрэгт огт болоогүй. Эрхэм Колхаун та бигий сэтгэл зов. Азарганууд, луиза авхайн хойноос дахиж хөөгөөгүй. Луиза энүүн дээр харайлгаж гараад Мористой зэрэгцэн тайван шиг давхиа биз. тэд аюулыг нэгэнт гэтэлсэн болохоор одоо нөгө илдэж уух юмтай тэрэгний тэнд аль хэдийнээ оччихсон байж байгаа.

-Явья гэж Колхаун өөрийн үеэл дүүг аюулд учирсан хэвээр байгаа юм шиг тэсч ядан хэлээд- Явья Стумп гуай, аль болохоор түргэн явья гэв.

Зеб Стумп мориноосоо бууж хутгаа гаргаад:

-Битгий яар! Намайг жаахан хүлээж бай гэв.

-Хүлээх ий? Яах гэсэн юм бэ?

-Би энэ азарганы арьсыг өвчиж авна. Мөнчсайхан эд байна дээ? Энүүнийг тосгондоо аваачихад лав таван доллар өгнөн дөө. таван доллар гэдгийг тал нутагт өдөр болгон олдог юм ыбиш.

-Энэ адсага та хоёрбг чөтгөр аваасай. Наадхиа хая, явья гэж Колхаун уурлан хэллээ.

-Тэр ч ярихгүй шүү. хэрэв хэрэгтэй бол Колхаун та яьж бай. харин Зеб Стумп энэ адууны ширийг хөгшин гүүнийхээ нуруун дээр тавихаас нааш явахгүй гэж хэнэггүй хэлээд Зеб үхсэн азарганы гэдсийг хцрц хутгаар ярав.

-Хүүе Зеб, би яах ёстой болж байна хэлээд аль? Намайг зама олохгүй гэдгийг та мэдэж байгаа шүү дээ.

-Энэ ч нээрэн үнэн байх шүү. Таныг зама олно гэж хэлсэн хүналга.

-Зөрүүд зөнөг минь хүний хэлэхийг сонс! Яг энэ үед миний хувьд цаг бол алт болоод байна. гэтэл та наад арьстайгаа ноцолдоод хагас ц аг лав болох шинжтэй.

-Сайн л бол хориод минут болно.

-За яахав хорьч байг. миний хувьд тэр чинь таван доллараас ч үнэтэй байна. та арьсийм үнэ хүрдэг гэсэн биз дээ. наадхиа орхи, би үний нь төлөмц.

-За тийм байдагб айж. их уудам сэтгэл. Тэгэхдээ би ячагаад ч юм таны хэлснийг биелүүлж чадахгүй нь дээ. ийм юмны төлөө нэг талаар танаас мөнгө авна гэдэг булай хэрэг, бас бид танил, хамт явж байгааг хэлэхүү. Нөгөө талаар намайг дахин энд иртэл тас шувуу зулгаагаад хаячихна гэдгийг ярилтгүй юм гэхэд таван долларын үнэ хүрэх энэ сайхан арьсыг энд ялзруулах хайран юм.

-Юугаа донгосоно вэ? Би тэгээд яах юм та нөгөө газраа их амархан олно. Тэр тэнгэрийн хаяанд байгаа өндөө улиангарыг харж байна уу?

-Харж байна

-За тэгэхээр... таньж байгаа биз? энэ гайхамшигт ургамал мод гэхээсээ илүү гонхонтойы адил харагддаг юм.

-За,за одоо о танилаа. Зэрдэг гүүнүүдийн араас хөөж явахдаа яг хажуугаар нь гарсан юм байна.

-Яг зөв. тэгэхээр та энэ замаараа улиангарын хажуугаар нөгөө гүүнүүдийн мөрийг сөрж явахад юу нь болохгүй байна? тэгээд л та цайлах газраа очиход чинь Мисс Пойндекстер болон хөгжилтэй бусад улс нөгөө францын үампань гэдэг усаа ууж байхад нь орчихон. Тэд уудгаа ууж л байг, харин виски архины талаар бодолцвол болох нь тэрг. Тэгэхгүй бол буцаж очоод хоолой норгох юм олдохгүй болчихно.

Колхаун хөгшин анчны сайхан яриаг хэдийнээ сонссонгүй. модыг заалгаж авмагц л буурал морио давиран ухасхийж, Зебийг орхин одов. Өвгөн толдгой өндийлгөн ахмадыг ор сураггүй алга болсныг хараад

-Иосафит минь! Ингэж галзуу солиотой юм шиг болдгийг учрыг ойлгож ядаад байх юм алга.

Би тийм таамтгай бич гэсэн мөр эрсэн жинэхэн хардлага гэдэг чинь л энэ байна даа гэв.

** **

Зеб Стумп андуурсангүй. хардах сэтгэл нь Кассий Колхауныг яаран буцахад хүргэжээ. тэр хардах сэтгэл нь цурам болсон тал дунд анх түүнийг зовоожээ. Түүнээс хойш хардлага улам гаарч, зөвхөн х харсан нь төдийгүй, ямар нэг юм болно гэж сэтгэлийн угт зөгнөн, эцэст нь өөр бусад бүх юмаа мартан байх газраа олохгүй болжээ. Мустангер Луизад бидэрт мустангийг бэлэглэн сургаж өгөхөд нь бүсгүй баялаж гялайснаа нуж хаалгүй илэрхийлжээ. үүнээс гадна бас бус юм ахмадад бодогдон, Морис мустангер бол өөрий нь гол өрсөлдөгч гэдэгт эргэлзэхээ больжээ.

Зэрлэг адуу барьж амьдрагчдийн ядуу зүдүү байдалтайг бодвол төдийлөн их зовоод хардаад байх хэрэггүй санагдана. Хэрэв Колхаун Луиза Пойндекстерын занг тэгтлээ сайнмэддэггүй байсансан бол мэдэж ийм байж болох байв. Луиза бол бага наснаасаа эхр дураараа өссөн бусад хүүхнүүдийг хулчийх зүйлийн өмнө зүрхшээн зогсохгүй зантай болохоор өөрийн зиндааны занулыг дагана гэдэг нь юу л бол доо гэж бодогдмоор.

Түүний зиндааны хүүхнүүдийг ихэнхэд нь анчин залуугийн ядуу, юм мэддэггүй нь бүр гэр бүлболохоо байг гэж бодоход ядахдаа хуумгай явдал гаргахад хүргүүлэхгүйээр хаалт болох байлаа. гэвч Колхаун өөрийн хартай сэтгэгдэлдээ луизагийн байдлыг бодохоос үүнд итгэж яагаад ч чадахгүй байв.

Өөрийнх нь хувьд муугаар эргэсэн өдрийн явдалд сэтгэл нь зовон бодолдоо дарагдсан Колхаун зугаалгын газар тийш давхин одлоо.

Гонхон шиг харагдах модноос нүд салгалгүй давхингаа, зэрдэг гүүнүүдийн мөрийг олж одоо нэгэнт ирсэн мөрөөрөө буцах болсон учир төөрөх аюул басангүй.

Тэр аль болох хурднаар , муу морь нь хүч хүрэхгүй шахам давхиж явлаа. түүнийг элдэв муу бодол зовооно. Ийнхүү зовсоор цаг илүү болж байгаа бөгөөд тийнхүү гуньсан нь түүнийг эргэн тойрны нам гүмийн дунд улам ч ганцаардуулна.

Алсад яваа өөрийнх нь явах үзүг рүү явж буй хоёр морьтой хнийг хараад ч тэр баяарласангүй. Колхаун тэднийг араас нь тээр холоос харсан ч дорхиноо таньжээ. тэнр бол Колхауныг зовлонд учруулсан буруутан хүмүүс ажээ.

Тэд ч мөн өөрцгүй нь адил зэрлэг гүүний мөрөөр хоорондоо ойрохн рөө нийлүүлэн явж байлаа. тэд ямар нэг сонирхолтой ярианд автаад Колхауныг ирж явааг назаараагүй бололтой.

Түүнээс ялгаатай нь зөөлөн явааг нь харвад олны зүш яаралгүй бололтойн. Бидэрт мустанг бүр ч аажуухан алхлана. Тэдний дөрөө зэрэгцэн орчныхоо юмыг огт анзаарахгүй бас яст мэлхий шиг удаан явж байгааг байдал нь Колхауныг сэжиглэлийг улам нэмэгдүүлнэ. Кольхаун бараг биеэ барьж ёчадахгүй болж байлаа.

Давхиж очоод дотно зугаалгы нь тасалдуулчихья гэсэн бодол юуны өмнө түүний толгойд

оржээ. тэгээд муу эцсэн морто дахин гуядав.

Тэгснээ хэдэн минутынг дараа шийдвэрээ өөрчилсөн юм шиг явдлаа удаашрууллаа. хоёр хүний хойно хоёрхон зуугаалд алхам ойртож очсон морины нт тууриан чимээ тэдэнд сонсогдохгүй байлаа. Кольхаун тэр ярианд гол суурь эзэлж байгаа бололтой үеэл дүүгийнхээ эелдэгхэн дууг сонслоо. Тэр хоёрын ву ярьж явааг дуулж болдогсон бол! Эхлээд ингэлээ гээд юу ч болох вэ дээ гэж бодмоор. Гэвч үзээд алдвал яадаг юм гэж бодогдов.

Тэд яриандаа улайрсан тул тэдний юу ярьж байгааг сонсож, болох бололцоотой ажээ. Зөөлөн ногоон зүлгэн дээр морины туурайн чимээ үл сонсогдлоо.

Колхаун тэсч ядсандаа морио алхуулалгүй, жаахан давирхад морь нь хөнгөхнөөр сайварлав. Ногоон дээгүүр огт чимээ гаргахгүй, мөлхөж байгаа юм шиг явсаар тэр хоёрт бараг тулж очлоо. Колхаун байдгаараа урагшаа зүтгэн чих тавина. Түүний байгаа байдлыг харахад байдгаар нь хараах ч юмуу, хутга, буундаа хүрэхнээн ч яахавгэсэн байдалтай ажээ. Чухам яах нь яриа дуулдах эсэхээс л шалтгаалж байв. гэвч яаж ч чадсангүй. Хоёр морьтон яриандаа халсан ч гэлээ морьд нь илүү сонор агаад Колхауныг морины туурайн чимээ гармагц бидэрт мустанг хээр морь хоёр толгойгоо өргөн чанга үүрэв. Ингээд Колхауныг төлөвлөгөө баларчээ.

-Аа үеэл ах Каш уу Чи энд байгаа юмуу? Аав, Генри бусад хүмүүс хаана байна? гэж Луизагийн дуунд гайхсанаасаа илүү халаглаж зэвүүцсэн шинж илэрхий байв.

-Лу чи юунд надаас асууж байгаа юм? Адилхан явж байж хэн нь хэнээсээ асуух вэ дээ.

-Тийм гэж үү? Биднийг л тосч явааа юм байх гэж бодлоо. Морь чинь усан хулгана болтлоо хөлөрчихөж Бидний давхисан шиг хол газар давхиж дээ.

-Тиймээ. Би бүр эхнээс нь аваад чамд туслах гэж хойноос чинь давхилаа.

-Тэгсэн гэж үү? Таныг бидний хойноос явж байсныг мэдсэнгүй. тэгвэл баярлалаа. Луна бид хоёрыг тун их муухай тохиолдол, аймшигт шхлээс биеэрээ аварсан эрхэм Морис Жеральд би дөнгөуж саяхан талархалаа илэрхийлээд байна. Та бод л доо, биднийг зэрлэг азарганууд хөөгөөд золтой л тасчиж хаясангүй шүү!

-Тиймээ, би мэдсэн

-Тэгвэл та бидний хөөгдөж явсныг харсан хэрэг үү?

-Үгүй ээ, би мөрөөр чинь мэдлээ.

-Мөрөөр гэнээ? Чи тэгээл учры нь оллоо гэж үү?

-Тиймээ, тэгглээ Зеб Стумпийн тайлбарлаж өгсний ачаар шүү.

-Аа! Стумп гуай чамтай хамт явсан юмуу? Та нар бидний хойноос ... аль хүртэл явав.

-Ганга хүртэл явсан. цЧамайгш тэрдээгүүр харайлган гарчихаж гэж Зеб Стумп надад хэлсэн. Нээрээ тэгсэн юмуу?

-Луна харайсан юм

-Тэгэлгүй яах вэ? Кассий чи ямар хачин юм асуудаг хүн бэ? эсвэл би чинийхээр бол сүүлнээс нь чаргуулдах сөстой байв уу? гэж Луиза инээмсэглэн хэлснээ гэнэт дуугаа өөр болгож-Чи бас харайлгаж гараад бидний мөрөөр явааюу? гэж асуув.

-Үгүй ээ, Лу минь, чамайг надаас түрүүлээд ирчих байх гэж бодоод жалганы тэндээс шууд наашаа эргэлээ. тэгээд уулзаж байгаа минь энэ.

Колхауны энэ хариултанд Луизы сэтгэл ханах шиг боллоо.

-Өө тийм үү! Би тантай уулзсандаа баярлаж байна. Бид аажуухан явж байсан юм. хөөрхий Луна минь эцчихжээ. Яаж харьцгадаг юм мэдэхгүй.

Морис , Колхаунтай дайралдсанаасаа хойш ганц яч үг дуугарсангүй. тэр, залуу креол хүүхнийг орхисондоо огтхон ч харамсаагүй юм шиг газарчийнхаа үүргийг дахин гүйцэтгэж, тэнд өмнө явж байв.

Хэдий тэгэвч Колхаун нүд салгалгүй түүнийг ширтэнэ. Мөн эр ззүгг рүү хандсан Луизагийн баясгалант харцыг Колхаун олж хармагц түүний нүдэнд хорсол занал гялалзлаа.

Энэ гурван хүн удаан хамт явбал эмгэнэлт төгсгөлд хүрч болох байв. Гэвч зугаалганд оролцогчид харагдсан учир тийм явдалд хүрсэнгүй. морь нь хадуурч давхисан хүүхэнд олон хүн зэрэг зэрэг баяр хүргэж унтсан нь өөр бодол санааг түр зуур боловч сарниулжээ.

XIX. Ус хольсон виски

Инж цайзын ойролцоох суурингийн зочид буудал нь хамгийн бараа сүртэй барилга юм. Энэ бол Техаст сүүлийн дөчин жилд барьж багаа хот суурины онцлог шинж ажээ.

Гагцхүү зарим нэг испани, мексик гаралтай хуучны хотуудын хэрэм цайз, сүм дуганууд нь бусад барилгуудаасаа өндөр сүндэрлэж байдаг ажээ. Гэвч өнгөрсөн үеийн тэр шүтээнүүдийн ихэнх нь бас л зочид буудал, гуанз болон хувирчээ.

Инж цайзын зочилд буудлын хэдийгээр тус суурингийн хамгийн том барилга боловч хэмжээгээрээ тийм том, үзэмжтэй сайхан нь биш ажээ. түүний гадаад байдал энэ уран барилгын ямар нэг хэв янзанд бараг үл тохирсон. Энэ бол “Т” үсгийн хэлбэртэй баригдсан дүнзэн барилга юм. Түүний хоёр жигүүрийг хүмүүсийн сууцны өрөөнүүд эзэлжээ. Урагшаа түрж гарсан гол хэсэгт нь Америкт баар гэж нэрлэдэг уудам таслагаатай байх бөгөөд тэнд хүмүүс ууж идэж, тамхи татан, шалан дээр хээв нэг нулимцгаана.

Зочид буудлын орох хаалганы өмнө талд царс модонд өлгөсөн хаяг дүүжигнэн байна. Хоёр талд нь энэ нутагт алдар нт мандан баатар генерал Захарий Тейлорын дүрийг силйж, дор нт “Үлдэх газар” гэсэн зочид буудлын нэрийг бичжээ.

Хэрэв та хэзээ нэгэн цагт Америкийн Өмнөл юмуу Баруун өмнөд мужаар явж байсан бол танд энэ зуушны газрын тухай тодорхойлох хэрэггүй юм. ийм бол гай нь ирэхэд ианы бууж мордсон зочид буудлын баар санаантахь илхэн байгаабизээ.Лангуу нь солнгоийн долоон өнгөнөөс гаргаж авч блоох бүх төрлийн өнгөтэй шингэн хийсэн шил сав, лонх өрлөсөн тавиур хананы дагуу өрөөнийхөө уртаар үргэлжилнэ. Лангууны ард дэгжин нь аргагүй бармен (Цэнгээний газрын эрхлэгч) үйлчилнэ. Түүнийгбуурчийн газрын эзэн гэж дуудах

л алдуузай. Тэгвэл лонхоор шүдээ булга цохиулах нь тэр. Тэр дэгжин залуу эр цэнхэр сатинан даавц гадуур цэамц чюмуу, эсвэл сүлжээсэн хүрээтэй цамц эс бөгөөс цагаан өргөн хүрэм өмссөгн байна. Тэр дэгжин залуу эр танд “Шерри кеблер” ундаа холингоо, нүд рүү чинь эгц ширтэн тантай улс төрийн талаар ярилцан, түүний хажуугаар мөс, дарс, усаа нэг аяганаас нөгөөд юүлэхэд нь түүний мөр, тосолсон үстэй толгойнх нь ар талд нэг ёсны солонгын туяа цацран гялалзах шиг болжээ. Хэрэв та Америкийн Өмнөд мужаар очиж байсан бол энэ бүгздийг мэдээж мартаагүй бизээ? Хэрэв тийм аваас миний үг танд түүнийг, хүрээлсэн байдлыг санагдуулж байгаа биз дээ.Түүний эрхэлсэн олон тавиур элдэв өнгийн лонх,лангуут нь, цагаан элс асгасан хаяа, элдэв янжуурын иш, нулимдас хөглөрсөн шалыг , гаа, нэрмэл архи, нимбэгний хальсний үнэрийг, хар ялаа, өтний ялааны дүгнэхийг, час хийтэл хазах шумуулы нь санаж байгаа биз дээ.

"Үдлэх газар" зочид буудлын нь Техасын бусад ийм газруудаасас ялгагдах юмгүй боловч муу ч гэсэн бас өөрийн онцлоготой ажээ. Түүний эзэн нь овжин янк биш бөгөөд хамгийн сайн бараа нийлүүлдэг хэмээн тооцогддог нутаг нэгтнийхээ нэрийг бүрэн хадгалахуйц нэгэн герман хүн байлаа.Тэр өөрөө үйлчилнэ. Таныг ороод очиход өтгөн үстэй хиазтай цамц өмссөн дэгжин залуу эрийн оронд үйллэгчээ дайлж байдаг сайхан үнэрт ундаа бөөний үнээр нь ууж болох байлаа ч амандаа хүргэдэггүй юмуу даа гэлтэй эв эрүүл_ намбатай төвшин

герман хүн ундаан бэлтгэж өгөх вий. Нутгийнхан түүнийг эх орондоо Обердофер гэж нэрлэдэг ч зүгээр л “Дофер” гэж дуудна.

Мөн ганц түшшнд ч байдагш бус нэг онцлог байна. Зочид буудао нь дээр хэлсэнчлэн “Т” үсгийн хэлбэртэй бөгөөд урагшаа түрж гарсанхэсэгт нь баар байх учир лангуу нь гол барилгад тулсан хананы дагуу үргэлжилнэ. Хоёр үзүүртээ талбай руу гарсан хоёр ч хаалгатай.

Хаалгыг ийнхүү гаргасан нь орон нутгийн цаг агаарбын байдлаас болжээ. Халуун хүйтний хэмжүүр жилийн зургаан сард нвь сүүдэрт байгаа мөртлөө 30 градусын дээш заадаг тийм газар агаар сайн солилцохыг бодолцох хэргэтэй.

Техасын зочид буудлууд Америкийн зочид буудлуудтай адилхан клуб, худалдаанбыбиржийн үүргийг хамь гүйцэтгэнэ. Буудлын тохь тухтай байдал, зүнэ хямдаас болоод Америкь клуб бараг байхгүй.

Тэр бүү хэл хотуулал ч клубын хэрэггүйгэж үзнэ. Буудлын хямд үнэ, сайн хоодл унд, дэгжин байдал нь Америкт дөнгөн данган байдал нь ер нь шоовдорлогдмол клубын хөгжилтөнд саад болно. Ийм байдал годлуу өмнөд, баруун өмнөдийнөөар, гуанз нь олны цугларан цаг нөхцөөх дуртай газрууд болдог хотуудад хамаарагдана. Энд зүсэн бүрийн улс цугларана. Хараа дээгүүр газрын эзэн ч дур гугаж зүрхлэхгүй учир, ихвэчйлэн мөн л өөртэй нь л адил бардамхаг байдаг ядуучуудтай хамт нэгэн өрөөнд архи ууна. “Үдлэх газар” зочид буудлын бааранд сууринд быайдаг бүх л анги давхрага, мэргэжлийн хүн цуглана. Тариачин гэж энэ хязгаарт байхгүй учир тарианчид л үзэгдэхгүй. Ер нь Америкийн Нэгдсэн Улсад ч Техаст ч байхгүй.

Доффер өвгөн анх удаагаа хаягаа зүүсэн цагас хойш түүний бааранд дээр өгүүлмсэн зугаалгын дараа түүнд оролцогчид инж цайзын буцаж ирсэн үдэш шиг тийм олон хүнтэй байж үзээгүй байх.

Хатагтай нараас бусад зугаалганд оролцсон бараг бүх, хүн тэрүшдшийг гуанзанд орж наргин хөгэжихийг зүй гэж үзжээ. олон өнгийн шил саван дундах голланд цагийн зүшү арван нэгэн цагт арай ч хүрээгүй явтал бааранд олон хүн орж ирэв. Цайзын офицерууд, тэндхийн газын эзэд, б элтгэн нийлүүлэгчид, жирийн нэг хэрэгтор дурлагчид цувран оржирцгээв. Ирсэн хүн бүр лангуу руу шууд очиж пуртай дарсаа хийлгэж аваад нөхөдтэйгээ нийлэн сууна.

Эдгээрийн дотрооснэгэн бүлэг хүн сүрхий анхаарал татна. Арван хүн байгаагийн тэн хагас нь цэрэг хувцастай ажээ. Тэдний дотор, уншигчид аль хэдийн таних босон морин цэргийн дэслэгч Генкок, буучийн ангийн дэслэгч Кроссмен, явган цэргийн ахмад ийм гурван офицер байна. Бас тэдэнтээ хамт цолоороо ч насаараа ч ахмад нэгэн хошууч байлцгаав. Инж цайзад хамгийн ахмад нь цолтой тэр хүн хотхамгаалах цэргийг командалдагийг хлэх юун. Тэд цөмөөрөө л ав адилхан залуу хүмүүс мэт нүүрэмгий хөөрөлдөнө. Ярианы нь сэдэв өнөөдрийн болсон явдал ажээ.

-Хлшуучаа, та Пойндекстер авхай хаанаа байсныг мэдээгүйй биз дээ? гэж Генклк асуулаа.

-Би яаж мэдэх вэ, эрхэм Кассий Колхаунаас асуу гэж цаадхи нь хариулав.

-Бид түүнээс асуугаад юу ч олж мэдсэнгүй. тэрчинв биднээс илүү мэдэхийг нь мэдээж хэрэг. Тэр хоёрыг буцаж явахад нь бидний буудалласан газрыг хавьд гүйцэж очсоо байлаа. Тэд маш уцдаан алга болсон. Тэгээд бас морьп нь хөлөмрснийг үзвэл учиргүй хол явсан бололтой. Энэ хооронд Рио-Гранд хүрэх юмуу тэрнээс ч хол явж болох байлаа.

-Колхауныг эргэж ирхэп царайгий нь ажсан уу? гэж явган цэргийн ахмад асуугаад -Аадрын үүл шиг баргар , ямар нэг юманд сэтгэл нь түшгсэн бололтой байсан гэв.

-Тийм ээ, золгүй явдал тохиолдсон шиг харагдсан шүү гэж хошууч хариулаад-Харин ахмад Слоумен та түүний тэр байдлыг ... гэтэл

-Хардлага уу? Тиймээ, тэгжбодож байна. Яалаа гэж дээ! Огт итгэхгүй байна.

-Яагаад тэр вэ?

-Эрхэм Слоумен минь, Луиза Пойндекстер авхай бол сурвалжит хүн, харин Морис Жеральд

-Боловсон хүмүүжилтэй ч хүн байж болох юм н Бид түүний тухай юу ч мэдэхгүй шүү д..

-Гайгүй байлгүй. Морины наймаачин! Хошуучийн хэлдэг зөв. тэгх ёстой гэж Кроссмен дургуйцсэн шинжтэй хэлэв.

Явган цэргийн офицер толгойгоо учиртайхан сэгсэрч

-Өө залуус минь! Та нар Пойндекстер авхайд дурлачихсан юм биш биз дээ? Тэгвэл та хэрэв зүрх нь л өөр хүн бодоогүй байдаг юм бол Генкок Кроссмен хоёрын нэгийг харвал дээр. Харин жирийн нэг мустангерт

-Тэр мустангер чинь ирланд хүн. тэгээд л би түүний ... юу гэж бодохүндэс байга аюм.

-Тэр ямар ч хүн байлаа гэсэн... гэснээ хошууч хаалга руу халыг харснаа -Ороод ирлээ... тэр өөрөө бидэнд хэлж өгөг. Хээгүй залуу байгаа юм. Түүнээс та бүгд тэгтлээ сонирхоод байгаа юмаа мэдэж авал даа гэв.

Генкок болон өөр болон гурван офицер хошуучийн зөвлөлгөөнийг дагаж мустангер руу дөхөжүед Слоумен.

-Юу л бол доо гэж амандаа бувтана.

Морис лангууны дэргэд дуугүй очиж, сул забий эзлэн зогсоод

-Устай виски нэг аягыг өгөөч гэж гуанзны эзэнд намуухан хэлэв.

-Ус хольсон виски? Та ус хольсон втскт уух юмуу? Нэг аяга нь хоёр пенни шүү дээгэж цаадхи нь хүйтнээр хэлэв.

-Би үний нь асуугаагүй, устай втскт нэг аяг агаач гэж байна.хэрэв танайд байвал шүү гэж

ширүүн хэлэхэд айсан гермэн худалдагч,

-Байлгүй яахав. Байлгүй яахав! Ус хольсон архи хичнээнийг авбал байна. Ав л даа ! гэв.

Буудлын эзнийг архи аягалж байх зуур Морис эелдэгхэнээр толгой дохих офицеруудтай хариу мэндлэв. Цайзад ажлаар байнга ирдэг болохоортэдний олонхитой нь танил байжээ.

Офицерүүд түүнээс сонирхосон юмаа асуух гэж байтал өөр нэг хүн орж ирсэн нт түшр ч болов асуухаа азнахаар блолоо. Энэ нь Кассий Колхаун байлаа. Түүний дэргэд шууд ярилцах нь эвгүй байлгүй яахав.

Кассий Колхаун хэзээ язааныхаараа ихэмсэг байдалтайгаар цэргийн энгийн нийслэл хэдэн хүмүүст дөхөж очоод бүхэл өдрийг хамт өнгөрүүлмсэн блоовч түрхэн зуур салж яваад ирсэн хүний мэндэлдэг ердийн ёсоор мэндлэв. Ахмад хэдийгээр шал согтоогүй боловч их л хөгжилтэй болчихсон байв. Тзүүний нүд гялалзаж , царай нь ердийн биш цонхийжээ. Хазгай тавьсан маогай дороос нь хэдэн туг үс ццухуйсан нь тэр хүн хэмжээнээсээ илүүхэн балгасан нь илт харагдана.

Тэгээд тэр м хошууч болон түүний хажуугийн улс руу хандау:

-Адъ вэ, ууцгаая. Буудлын эзэн, дэнгийн газр боллоо гэж хэлэхээргүйгээр цөмөөрөө дугараа барин ууцфгаая. Цөмийг чинь урьж байна гэв.

-Болж байна, зүйтэй! Гэж хэд хэдэнг хүн хэлэв.

-Хошууч та яах вэ?

-Ахмад Колхаун минь пдуртай зөвшөөрнө.

Тогтсон заншлаараа ухаар болсон бүх хүмүүсти лангууны хажууд цувран зогсож хүн бүр дуртай ундамндаа захилав. Хүн бүр өөр өөр архийг шилэн авчээ. Колхаун өөрөө.

-Бренди! Дээрээс нь виски холиоройгэв.

-Бренди, ювиски нь ночн Колхауны захиалга уу? гэж эзэн асуунгаа том эдлэнгийн эзэн хэмээгдсэнэрхэм рүү лагнууны цаанаас өбхөлзөв.

-Тэнэг герман минь хурдан хөдөл! Би бренди гэсэн

-Эрхэм минь одоохон. Бренпи ю виски, бренди вискитэй! Хэмээн дээрэлхүү үйлчлүүлэгчийн өмнө хэлсний нь т\ тавих зуураа эзэн хэлэв.

Хоёр гурваараа нийлсэн хошуучийн бүлэг лангууны дэргэд бараг зайүлдээсэнгүй.

Санаатай буюу санамсаргүй алин былоовч Колхаун захал зогсон , Морис Жеральдтай зэрэгцэн. Морис түүнийхажууд уишимгүй зогсч ус хольсон вискигээ ууж, ороомолнавчин тамхи татаж байв. Тэр хоёр бие биеэ үл ажигласан мэт ажээ.

-хундага барьцгаая! Гэж Колхаун лангуун дээрээс аягатайгааавч хашгиран хэллээ.

-Аль вэ , барьцгаая! Гэж хэд хэдлэн хүн хариу дуугарлаа.

-Америкчуудын тулд Америк мандтугай. харь газраас ирсэн тэнэмлүүд , ялангуяа муусайн ирландчууд сөнөтүгэй.

Колхаун ингэж хундага өргөнгөө гэдрэг ухран аягатайгаа уухаар завдан байсан Морисыг тохойгоороо явруод авав. Морисын архи цалгин цамцны нь халтартуулав.

Энэ бол санамсаргүй хэрэг үү? Гэвч тийм биш гэдэг хэн ч өчүүхэн төдий эгэлзсэнгүй. Тийм үг хэлж хундага өргөчихөөдингэжхөдлөнө гэдэг зориудаар , урьдаас бодсон зүйл байж таарна.

Одоо ч Морис доромжилсон хүн рүүгээ дайрах байх даа гэж тэнд байсан хүмүүс харцгаалаа. тэд Морисыг яаран хөдлөхгүй байхад урам нь хуцгарч, гайхацгааж байлаа. Тэгж доромжлуулчихаад дуугүй тэвчиж өнгөрөх нь гэж зарим нь боджээ.

-Хэрэв ингээд дуугүй өнгөрөх юм бол шилэнхүзүү рүү ньнудраадавмаар эр юм даа гэж Генкок, Слумены чихэнд шивэгнэв.

- Та сэтгэл бүү зов. Тэр чинь зүгээр өнгөрүүлэхгүй. Би мөрийцөх дургүй чи мэднэ шүү дээ. Гэвч Морисыг тшшнд амттайхан хариу өгөхгүй бол сарынхаа цалинг чамд өгье. Бастэрхэн зуур Морис доромжлогдсоноосоо илүү цамцандаа сэтгэл нь зовж байгаа юм шиг байсанч гэсэн тийм хүний өмнө Колхаун сайнаа үзхэгүй гэдэгт би эргэлзэхгүй. морис ч хачин самбаатай хүн шүү

гэж явган цэргийн дарга бас ло шивнэлдэж байхад морис лангууны дэргэд ажиг ч үгүй зогсч, хундагаа тавиал өврөөсөө торгон алчуур гаргаж цамцан дээрээ асгарсан архийг аряиж байв.

Жишэмгүй , тайван байдал нь түүүний айсны тэмдэг ч арай ч биш ажээ. Түүнийг яах болгэж эргэлзэж байсан хүмүүс андуурсанаа ойлгою. Чухам яахы нь хүлээж байлаа.

Гэтэл удаан хүлээсэнгүй. Бүх юм хориодхон хоромд болж өнгрлөө. Үүний дараа аянга буухын эхлэл болсон үг сонсогдлоо.

-Би Ирланд хүн гэж Морис алчуураа хармаандаа хийнгүүд хэллээ.

Энэ нь маш энгийн бөгөөд хожимдсёон хариулт мэт быоловчтүүний учир утгандхэн ч эгэлзсэнгүй. Хэрэв зэрлэг адууны ангууч Кассий Колхаун хамрыг чимхэд авсан бол энэ нь өдөөлтийг хүлээж авлаа гэсэн хэрэг биш байв. Энэ товчхон хариулт нь ноцтой хэрэг болохын тэмдэг ажээ.

Зулайгий нь хүртэл харж - Та юу? та ирланд хүн гэж үү? Үгүй байлгүй дээ. Би ер тэгж бодоогүй юм. Өмссөн хувас, цамцы чинь хээ угалзаар таныгы мексик хүн гэж санасан юм хэмээн үргэлжүүлэн хэлэв.

- Миний өмссөн хувцас эрхэм Колхаун танд ямар хамаатай юм. Харин та цамц руу минь архи асгуулсан болохоор мөн түүнчлэн хариулж таны цардмал захы нь угааж өгөхийг зөвшөөрнө үү?

Морис ингэж хэлмэгцээ аягаа шүүрэн авч ахмадыг эргэхийн завдалгүй , вискийнхээ шахрууг улаан нүүр лүү нь өөд нь цацав. Колхаун галзуу мэт тургиж, найтаан тэнд байсан улсын олонхийн бах тавыг хангав.

Өөрийн эрхгүй оргилон гарсан сайшаалын дуу, шуугиан тэр дорхиноо чим чимээгүй байдлаар солигдов. Шивэгнэлдэх дорхиноо замхран, яимээгүй болов. тэр хоёрын эхрүүл маргаан ноцтойгоор эргэснийшг цөм мэджээ. Энэ хэрэг ирүүл туласнаар төгсөх ёстой байжээ. үүнийг ямар чхүн эргүүлэн зогсоож чадахгүй бизээ.

XX. Аюултай байдал

Архиар цацуулсан Колхаун гар бугаа шүүрэн авч, гэрнээс нь сугалав. Гэхдээ өрсөлдөгч рүүгээ дайрахаас өмнө нүдээ арчив. Морис түүний ингэнэ гэж мэдээд адилхан буу гаргаж үзэлцэхээр бэлэн зогсов.

Тэнд үргэлж байдаг улсын аймхай нэг нь бие биенээ түлхэлцэн хаалга руу гүйж, зүрх , зоригтой зарим нь гүйх хоорондоо нуруундаа сум зоолгочихож магадгүй хэмээн хэрсүүлэн зориуд үлдлээ. Энэ бол хүмүүсийн бодол санаанышийдвэр нь бодит байдалд ороогүй хөдөлгөөнд орж байсан үе ажээ.

Тэр хоёроос өөр улс байсан бол энэ хэрэг түргэн шийдвэрлэгчид мэдэх байв. хэрэв туршлага багатай, омогтой хоёр хүн байсансан бол бууныхаа гохыг шууд л дарах байсан биз. харин колхаун Жеральд хоёр тийм биш байлаа. Алдаж онохын хор холбогдлыг гудамжны тулалдаанытуршлагаас мэддэг, түүнд оролцож байсан учир яарвал даарна гэдгийг анддаггүй ажэ. Аль аль нь буудахгүйг бодно. Ийм ч учираас удаашрах шиг санагджээ

Гадаа байсан хүмүс болоод бас хаалга руу шагайхыг зүрхлэхгүй байгаа улсад энэ хугацаа зовлонтой удаан санагдаж байлаа.

Хэзээ буун дуугарах бол гэхээс тэсч ядан. Тэгтэл хүмүүс буун дууны оронд хошуучийн чанга бөгөөд хүндтэй тайван дууг гэнэт сонслоо.

- Больцгоо! Гэж хошууч сэлмээ сугалан тэр хоёрын хоорондуур зааглан- Битгий бууд, би та хорёрт тушааж байна. Бугаа тат. Үгүй бол би хэн урьтаж гохондоо хүрснийг чинь гарыг тас цохино шүү! Боль гэж байна шүү! гэв.

-Яалаа гэж тэр вэ? Яагаад тэр вэ, хошууч Рингву Колхаун тэсгнэлгүй уурласандаа царай зүс нь хөхрөн хашгирлаа.

- Ахмад Колхаун та өдсөн шүү дээ.

биш. Замаас, зайл хошуучаа! Бидний хоорондын хэрүүл танд хамаагүй, та оролцох эрхгүй!

- Аа тийм бий?! Ха-ха! Слоумен! Генкок! Кроссман! Та нар сонсож байна уу ? Би оролцохгүй гэнэ шүшү... Ахмад Кассий Колхаун та хаана байгаагаа битгий мартаарай. та Миисип муж улсад “манайхны өмнөдийнхний ” дарлаж байдаг боолчуудын дунд байгаа гэж битгий бод. Эрхэм минь, энд чинь цэргийн дүрэмд захирагдах цэргийн цайз байна. Энэ цайзын даргаар таны дуулгавратай карц намайг томилсон юм. Энэ учраас бугуу хуучин байсан гзар нь хий гэж би танл тушааж байна. Эсхүл би таныг жагсаалын цэрэг шиг сахилга журмын гяндан руу одоохон явуулчихна шүү!

- Тэгнэ гэж үү! Та техасын яасан сайхан орон болгон хувиргах гэж бодно вэ? Хүн яаж доромжилсон ч хошууч Рингвуд таны зөвшөөрөлгүйгээр буудалцах эрхгүй гэсэн хэрэг үү? Эндэхийн хууль гэдэг чинв энэ үү? Гэж колхаун хэллээ.

- Огт тийм биш! Би бол бусдын хэрүүл маргааныг шудрагаар шийдвэрлэхэд саад тотгор тавьдаг тийм хүн биш. Хэрэв та нарт тэгж алалцах чинь сайхан байгаа б бол хэн ч хориглохгүй. харин одоо л битгий буудалц. Та хоёрын буудалцфах чинь түүнийг тэгтлээ соирхоогүй бусад улсын амь насанд аюуотайг эрхэм Колхаун та ойлгох байх. Би зр нвь өөр хүн рүү чиглүүлсэн бууны суманд өртөж хохирохыг бодохгүй байна. Биднийгаюулгүй газар очтол хүлээж бай: Тэгээд санааныхаа зоргоор буудаарай л даа. Одоо, ноёнтон та бах чинь ханаа биз дээ?

Хэрэв хошуучийн оронэд өөрямар нэгхүн байсан бол тэр тушаал ямар чя амжилт олохгүй байв. Гэвч хошууч бол зэвсэг сайн эзэмшдэгээрээ бүхэнд алдартай бөгөөд цайзын ахмадл , офицер , хүнтэй хүн учраас хэзээ нэг цагт түүний тушаалыг зөрчиж зүрхлэх хүн байдаггүй ба\ билээ. тэр сэлмээ хий дэмий сугалаагүй байв. Энэ бол жүжигт гарч байгааүзэгдэл биш гэдгийг бие биедээ дайсагнагч хоёр мэджээ. Тэд буугаа зэрэг шахас доош буулгасан боловч барьтсан хэвээрээ зогсоцгоов.

Колхаун цусанд уйлайрсан зэрлэг араатан шиг шүдээ хавирч цухалдан зоргсч байгаа нь дайрах гэсэн ан руу нь ухасхийын ороход саад болсон юм шиг байв. Морис гаднаа бачимдаж эсэргүүцэн шинжгүйгээр тушаалыг дагалаа.

-Та нарыг үзэлцэхээс буцахгүй байх гэж би бодож байна гэж найрамдуулах ямар ч төлөвгүйг мэдсэн хошууч хэлэв.

-Би заавал тэгэх юм алга. хэрэв ахмад Колхаун хийсэн, хэлсэндээ уучлал гуйвал гэж Морис төв даруухан байдалтай хэлэв.

-Колхаун эхлээд хэрүүл үүсгэсэн болохоор уучлал гуйх ёстой гэж тэнд байсан хэд хэдэн хүн яриагнд оролцов.

- Хол хэвтэнэ! Колхаун уучлал гуйж сураагүй юм. Тэгээд бас энэ хувцас өмссөн сармагчны өмнө шүү!

Боллоо! Гэж Морис маш их бачимдаж байгаагаа анх удаа илэрхийлэн хашгираад- Би түүнд амиа аврах бололцоо өгөхийг хүссэн юм. Гэтэл үүнээс татгалзаж байна ьгвэл одоо бид хоёрын хэн нэг нт эндээс амьд гарахгүйгэдгийг бурхны өмнө тангаргалая. Хошуучаа! Эндээс зайлахыг танд болоод танынөхдөд хичээнгүйлэн хүсь?. Би энэ доромжлолыг хойшид тэвчиж чадархгүй гэв.

-Ха,ха,ха! гэж Колхаун доогтой инээд сонсдоод “Амиа аврах бололцоо өгөх гэнэ шүү” Эндээс зайлцгаа, бүгдээрээ зайдцгаа! Би үүнд үзүүлээд өгье гэв.

- Байз Тэгж болохгүй э Амьтан зайлахаас өмнө та хоёр бууныхаа гоьыг дарчихаж мэднэ. Та нарыг буудалцаж эхлэхээс урьдаар бид гарах ёстой гэж хошууч буудалцах гэж байгаа хоёр хүмүүст хандаж үгээ үргэлжүүлэн- Тэрнээс гадна бид ирүүл тулааны цурмыг баримтлах ёстой. хэрэв энэ хоёр үзэлцэх гэж багаа юм ьол ёс горимоор нь буудалцаг. Юуны өмнө хоёулаа адилхан зэвсгээр кэюсэглэж, бүхнийг шудрагаар эхлэх ёстой гэв.

-Чухамаа таны хэлдэшг зүйтэй гэж тойрон зогсож байсан хүмүс хэлэв. Бүгд тэр хоср хэлснийгнь яаж хүлээж авах нь вэ гэж харж зогслоо.

- Та хоёрын хэн нь ч энэ саналаас зөрөхгүй биз дээ? гэж хоршууч хэлэв.

-Би шудрага шаардлагаас зөрж чадахгүй гэж ирланд залуу тайвнаар хэлэв.

-Би барьж байгаа зэвсгээрээ л үзэлцэнэ дээ гэж Колхаун хэгжүүрхэн хэлэв.

-Зүйтэй тэр чиньминий санаанд таарч байна гэж Морис түүнд хариулав.

Хошууч тэдний буу руу харж:

-Та хоёр хоёулаа кольт хоёр гэдэг зургаа үсэрдэг гар буутай юм байна. Одоохондоо цөм ёс журамаараа байна. та хоср адилхан зэвсэгтэй юм гэв.

Ахмадын цамцны хормой дор хутга байж магадгүй гэж Генкок хар аваад

-Эдэнд өөр ямар нэгэн зэвсэг байхгүйбиз? гэ' асуулаа.

-Надлад өөр ямар нэг зэвсэг байхгүй гэж Морис үнэнээ чухам хэлж байгаа нь харваас илтээр хариулав.

Хариу хэлэлгүй удаж байгаа Колхаун руу хүмүүсё цөм харцгаалаа. Колхаун үнэнээ хэлэх хэрэггүй гэж мэдээд:

- Мэдээжээрнадад бас хутга бий. та нар түүнийг авах гээгүй биз дээ? Бид хоёрын хэн нь гэсэн өөртөө байгаа зэвсгийг биедээ үлдээх эрхгүйгэж санагдаж байна гэв.

- Үгүй, цаад хүн чиньхутга байхгүй байна шүү дээ, ахмад Колхаун гуай. Хэрэв та түүнтэй энэ тэнцүү үзэлцэхээр хулчийгаагүйбьв хутгаа орхих ёстой гэж Генкок хэллээ.

- Тиймээ, орхих ёстой Тэгэх ёстой, ёстой гэж хэд хэдэн хүн хашгиралдав.

-Ахмад Колхаун, хутгаа аль гэж хошууч сүртэй хэлээд- Зургаа үсэрдэг гар буу бол эрүүл ухаантай ямар чхүний хэрэгцээгхангах ёстой. Та хоёрыг сумаа дуусаагүй байхад чинь нэг нь ... гэв.

- Энэ хутга далд орог цаашаа! гэж Колхаун цамцаа ярж хашгиран хутгаа гаргаж таслагааны булан руу шидээд- Энэ муу шувууны ангаахайтай үзэлүцэхэд надад хутгахэрэггүй. Би энэ муу ганцхан буудаад л унагана. Гэж өдсөн дуугаар хэлэв.

- Та хэлснээ хэрэг дээр нь үзүүлснийхээ дараа, _ ярих цаг бол олдоно. Эрхэм Колхаун та намайгф элдэв сайрхан үн\гээрээ айлгачихлаа гэж бүү бодоорой... Хурдлаарай, ноёдоо! Би энэ хорт үг, бардам хэрцгий занг төгсгөл болгох ёстой гэж Морис хэлэв.

-Нохой! Муу ирланд нохойг доо! Чамайг үүрэнд чинь аваачиж хуцуулна дээ. Би ... гэж

“Өмнөдийн эелдэг эр оиогдов.

- Ахмад Колхаун та ичээч” гэж хошууч олны жигшиж байхад түүний үгийг тасла ж хэлээд - Энэ бол шал хэрэггүй яриа. тэрнээс гадна дээдсийн хүрээлэн дотор ийм байдал гаргах чинь эвьгүй. ганц минут тэвчиж үз. тэгээд юу таалгдаж б айгаагаа ярина уу ... Одоо бас нэг болзол байна гээдтойрсон улс руу хандан- Биднийг эндээс зайлтал, буудалцахгүй гэсэн амы нь авах хэрэгтэй гэв.

Энэ болклыг хангахад нэн бэрх мэт ажээ. Ирүүл тулалдааныг яаж эхлэх вэ? Яахаас ч буцахгүй болсон ийм үед жирийн нэг амралт гэдэг багахэрэг байлаа. Адаглаад л өрсөлдөгчийнхөө аль нэг нь гох дарах зөвшөөрлийг хүлээлгүй буудчихаж мэдэх байв.

-Дохиогоор буудалцах хэрэгтэй. Харин та хоёрын хэн ч гэсэн дохио өгөөгүй байхад буудах ёсгүй.

Ямар дохио өгөх талаар хэн санал гаргах вэ ? гэж хошууч хэллээ.

- Надад санал байна гэж бодлоготой ахмад Слоумен хэлээд ЭрхэмКолхаун Жеральд хоёр бидэнтэй хамт яваг. Хэрэв та нар ажигласан бол энэ зочид буудлын өмнө талаас нь ордог хаалга бий. Энэ хоёр хаалга бол яг адилхан , эд энэ хоёр хаалгаар буцаад орог. Харин нэг нь нэг хаалгаар, нөгөө нь нөгөө хаалгаар орох хэрэгтэй. тэгэд л босго алхангуутаа буудалцаг гэв.

- Яриагүй зөв... Яг л тэгэх хэрэгтэй гэж хэд хэдэн хүн хэлэх нь сонсдов.

-Харин юугаар дохи өгөх хэргэтэй вэ? Буудаж өгөх үү? Гэж хошууч асуулаа.

-Үгүй ээ , зочид буудлын хонхоор өгье.

-Үүнээс өөр юм бодох хэрэггүй. Тэр чинь сайхан дохио болно гэж хошууч хэлээд албай ру угарсан үүд рүү явлаа.

- Майн готт! Хошуучаа, байзаарай! Гэж одоо хүртэл айснаасаа болоод ягнинатал хүлэгдчихсэн юм шиг зогсож байсан буудлынэзэн герман лангууныхаа араас гүйж ирээд - Эд миний бааран дотор буудалцах гэж байгаа юмуу? Ээ халаг! Хамаг лонх, сайхан толь , цэцгийн савы минь хагалчихана шүү дээ! Ээ бурхан минь, ээ бурхан минь! Хайран ч болор цагууд минь! Би зуу... хоёр зуу долларар явсан юмсан. Тэд хамаг сайн дарсы минь асгачихна. Ээ, хошууч минь! Би хоосорлоо шүү дээ. Яадаг билээ , энэ чинь?... гэж дуу тавилаа.

- Обердофер гуай битгий сэтгэл зов. Таны гарзадсан юм бүхэн чинь төлөгдөнө гэдэгт би эргэлзэргүй байна. ямар ч гэсэн та одоо аль нэг газар нуугдах хэрэгтэй. Хэрэв та баарандаа хоцрох юм бол бууны суманд заавал өртөгдөнө. Тэгвэл лонхуундаа хагалууласнаас долоон дор юм болно шүү гэж хошууч хэллээ. хошууч ингэжхэлээд мэгдэж сандарсан буудлын эзнийг орхиж гадагш гараад дөнгөу сая өөрөө хаалгаар гарч ирсэн өрсөлдөгчийг харлаа.

Обердофер нэг газраа удаан зогссонгүй хошуучийн ард гадна талын хаалга хаагдаж амжаагүй байтал буудлын эзний ард дотор талын өөр нэг хаалга тавьхийтэл хаагдав. Тэгээд мухлаг нь

солонгийн өнгө бүхнээр наадагч шил лонхууд дунл живж, тэдний дотор зөвхөн болор
бүрхүүлтэй цагийн жигт цохилт сонсдож байв.

XXI. Гуанзан дахь ирүүл тулаан

Хошууч гуанзнаас гарч ирээд дахин тэр хэсэгт оролцсонгүй. Ер нь тогтоогдсон шаардлагын хүрээнд буудалцах абйлаа ч гэсэн тэр хэргийг цайзын дарга өөгшүүлж байх нв эвгүй байжээ. Түүнийг зохион байгуулах үүрэг хүлээсэн залуу офицерүүд уул хэргийг үргэлжүүлэв.

Үүнийг гүйцэтгэхэд багахан цаг шаардагдаж байв. Болзлын аль хэдийн ярилцан тогтоожээ. Зөвхөн тэнд байгаа хүмүүсийн дундаас хэн нэг нь буудаж эхлэх дохио болох хонх цохих л хэрэгтэй байв.

Хэн хонх цохих нь гол биш учир амархан зүйл байлаа. Тэр бүү хэл хүүхэд байлаа ч гэсэн энэ айшигт тулаан эхлэх дохиог өгчихөу чадах байв.

Хэрэв гадны ямар нэг хүн энэ үеэр “Үдлэх газар” гуанз зочид буудлын өмнө талбай дээр ирвэл тэнд болж байгаа юмыг хараад сандрахаараа байлаа. шөнө зэгсэн харнхауй байсан боловч буудлын хажууханд ч цугларсан хүмүүсийг байлгаж танхимд хүрэлцэхүйу гэгээтэй байлаа. Ихэнх нь цэргийн хувцастай хүмүүс байв. Энд зөвхөн байрнаас агрч ирсэн офицерууд цуглараад зогссонгүй. Энэ хэргийнтухай мэдээ дорхиноо цайзад очсон байв. Бусад офицерүүд бас албанаас чөлөөтэй багйаа ццэргүүд ирцгээжээ. Энд бас нэлээд хэдэн хам хум хуцвасласан цэргийн эхнэр, угнаалагчийн болон зэгсэн сэжигтэй алдар бүхий хэдэн цовоо хүүхнүүд гудамжинд гүйн гарч юун, чимээ болоод байгааг өөрсдөөс нв түрүүлж ирэгспдээс шалгаана. Хүмүүс шивэгнэн ярилцана. Хошууч болон цайзын бусад эрхтэн дархтнууд талбайд байгаа нь үзэгчдийн бие барихад хүргэжээ.

Сонирхогч хүмүүс гуанзнаас зайдуухан зогсч байсан боловч тэд буудал руу маш анхааралтай ширтэнэ.иХүмүүс дүнзэн байшингийн баар байдг үзүүрийн хавьцаа байшингийн хоёр талод зогсч байгаа хоёрын хөдөлгөөнийг ажиглана. Тэр хоёр зузаан дүнзэнм ханаар тусгаарлагдан бие биенээ харахгүй ч гэсэн хөдөлгөөн нь адилхан байна. Аль аль нь ьталбайн хайрган дээр өргөн з зурювас татуулах хурц гэрэл туссан хаалганы хажууд тэгэхдээ яг хаалганы өмнө биш, гэрлээмс зайдуухан зогсжээ. Ухасхийхээр бэлдсэгн гүйлтйин хүн шиг ялимгүй бөхөсхийж зөвхөн цагны чаг-чхг хийх л сонсодно. Баарны хаалга руу ширьтэнэ. Тэдний байгаа байдлаар ухасхийн ороход бэлэн бөгөөд зөвхөн л дохио хүлээж байна гэдгийг тааварлаж болох ажээ.

Хувцсанд нь хөдөлгөөнд саад болох илүү дутуу юм ву ч байсангүй. хоёулаа малгайгүй, зөвхөн цамцтай байв. Нүүр царай, байр, байдал нь нэг юманд буцалтгүй шийдсэнийг илгэнэ.

Тэдний санааг таахад зовлонгүй. Буудлын өмнө санамсаргүй ирсэн хажуугийн хүн ч гэсэн ганц хараад л үхэх сэхэх тухайн хэрэг болж байгааг ойлгох байв. Гартаа бэлэн барьсан буу нь тэсч ядсан байдал нь сониуч хүмүүсийн чив чимээгүй байгаа нв эцэст бүх хүн тэр хосрыг анхааралтай ширтэх зэрэгнь энд аюултай юм болсныг хэлүүлэлтгүй ойлгуулна. Тоювчоор хэлэхэд үр уршиг нь үхэлд л хүргэх тулалдаан байлаа.

Шийдвэрлэх хором ирэв. Хоёр өрсөлдөгч орох ёстой боловч гарч ирэхгүй байж мэдэх хаалга руу тэсч ядан ширтлээ. Тэд аль нэгнийхээ, яаж мэдэх халз тулалдаанаа эхлэх босгыг алхахын тул зөвхөн дохиог л хүлээж байв.

-“Нэг-хоёр-гурав-буудаад!” гэдэг үгийг тэд хүлээж байвуу? Үгүй! Өөр дохио гаргахаар тохиролцжээ. Тэр нь ч цууриатав.

-Хонх цохиорой! Гэж хэн нэг хүний хангинасан дуу сонсдов.

Хонх өлгөөтэй байсан баганын дэргэд, гурав, дөрвөн бараан дүрсийг харж болох байв. Тушаалыгн дараа тэд х хөдөллөө. Харанхуйд дөнгөж ялгарах төдий гар нь хөдлөв үү, үгүй юу хонхны дуу цууриатлаа. Жирийнцагт баярт явдлыг тунхаглаж ард олныг хурим наадамд дууддаг хонхны дуу энэ удаа үхлийн тулааны дохио боллоо. Хонхны дуу удаан үргэлжилсэнгүй. Анхны цохидлтын дараа л олсыг тиатаж байсан хүмүүстэдний хэрэг цаашид алга гэдгийг ойлгов. Өрсөлдөгч хоёр гуанз рүү ухасхийн орж гар бууны дуу гаран хагарсан шил хангир жингэр дуугарахад ньдохио өгөгчид хий илүү чимээ гаргаад хэрэггүй ойлгожээ. Тэд ч олсоо орхичихоодп бусдын өдил чих тавин чагнав.

Буудалцах байгаа хоёроос бусад хэн ч гэсэн ирүүл тулалдаан яаж болж байгааг харах аргагүй байлаа. Хонхны анхны дуунаар өрсөлдөгчид баар руу оржээ. хэн нь ч орохдоо тээнгэлзсэнгүй. хэрэв чингэвээс айсан хэрэг болох байв. Зуузуун нүд харж байлаа. Бүгд л ирүүл тулааны болзлыг мэдэж байв. Босго алхахаас наана хэн ч буудах ёсгүй байв.

Тэр хоёр дөнгөж оронгуул анхны буун дуу гарчээ.

Тасалгаа дүүрэн утаа болов. Хоёулаа шархдсан боловч зогссоор байв. тэдний цус шалан дээр асгасан цагаан элсэн дээр дуслав.

Дараань хоёр талаасаа зэрэг хоёр дахин буудсан боловч утаа саад болоод таамгаар буудсан байжээ.

Бас нэг буудах сонсдон, төдхөн хариу буудах сонсдов.ТЭгээд гэв гэнэт яимээгүй болчихов.

Үүний өмнөхөн өрсөлдөгчид тасалгаан дундуур ялхахж нь дуулдаж байв. Одоо энэ чимээ гарахаа больжээ. Чив чимээгүй , нам гүм боллоо. Тэд бие биенээ адчихаа юу? Үгүй. Дахиад хос буудлага гарч байгаагийг нь үзвэл амьд байгаа нь илт. Тэд бие биенээ олох гэж утаан халхавчийг нэвт ширтэж , түр завсарласан байжэ. Хэн хэн нь байгаа газраа мэдэгдэхгүйн тул үг ч дуугарсангүй, хөдөлсөн ч үгүй байжээ.

Дахиад л чив чимээгүй болж, гэхдээ энэ удаа нэлээд удав. Тэгтэл ч дахин хос буун дуу гарснаа дууг дагалдан хоёр махбодв хүндээор пидхийтэл унав. Тэгээд хөлбөхлөх, онхолдох унаж байгаа сандлын чимээ сонсдоод , ганц буун дуу арван нэг дэх буудалт нвь гарлаа. Энэ нь суулийчийнх нь байлаа.

Сониучрах нь зогссон хүмүүс хаалгаар суунаглах даринь утааг, дэнлүүний гялбалзах гэрлийг үе үе гэрэл гялсхийх юм тас няс хийхээс өөр юм сонссонгүй. тэд чамлалтгүй их юм сонсчээ. хагарч буй шил савны жингэнэсэн, ноцолдоог дунд унаж байгаа тавилгын дуу, модон шалан дээр тожигнож хөлийн чимээ, байсгээд тасхийх буун дууг сонсож байв. Гэхдээ энэ тулалдаан хүргэсэн үзэн ядалтын эзэдл болох өөрсдийнх нь дуу сонсогдохгүй.

Зогсч буй улсын хэн ньч бааранд юу гэээ болсныг мэдсэнгүй. Зөвхөн буун дуун дуунаар л буудалцаж байгааг ойлгож байна. тэд арюван нэг буудахыг тоолжээ. Арван хоёр дахь буудлагыг бүгд амьсгаа дарж тэсч ядан хүлээж байлаа.

Буу дуугарахын оронд мустангшеруудын дуу гарлаа.

-Миний буу чамархайд чинь тулгаастай байна. шүү! Надад бас нэг сум үлдсэн. Уучлал, гуй эсхүл та үхнэ шүү! гэж хэлэх сонсогдов.

Тулалдаан төгсөх ойртсонбыг хүмүс ойлголоо. Зарим зүрхтэй нэг нь дотогшоо харлаа. тэд шал дээр алдлан хэвтэж байгаа хоёр хүн үзжээ. Хоёулаа шаррхдаж , хамаг хувцас нь цус болсон байжээ. Цагаан элс цусанд ыбудагджээ. Түүн дээо бие бие рүүгээ сүүлчийн удаа буудахын тулд мөлхөн дөхсний мөр тодорхой байв. Улхан бүстэй , тансар хилэн өмдтэй нэг нь нөгөөгийнхөө дээрээс бөхийж чамархайд нв буу тулгачихаад үхлээр заналхийлж байв.

Хүмүүст угаан халхавчийг салхи хөөсний дараа бараан дотор харагдсан юм ийм байлаа.

Яг энэ үед өөр нэг дуу гарсан нь Колхауны дуу байв. Дууны өнгө нь нөгөө дээрэлхүү байдал хэдлийнээалга болжээ.Энэ нь зүгээр л нэг гомдсон

-Боллоо!... Бугаа тат... Би уучлалыг гуйя... гэсэн шивэгнээн байв.

XXII. Жигтэй бэлэг

Техаст хүмүүсийн ирүүлд дуудан буудалцах нь гайхалтай хэрэгбиш. Гурав хоноход тэр тухай яриа болж долоо хоногийн дараа бол мэдээж түүнд оролцогч болон ойр дотныхоос нь бусад нь бүр дурсаж санахаа ч байчихдаг ажээ.

Ирүүл тулалдаанд нийгэм дээгүүр байр эзэлдэг хүндтэй хүмүүс оролцсон ч гэсэн ийм л байдаг байв. хэрэв буудалцсан хүмүүс нь ядуу юмуу явуулынх байвал ганц өдөр л амны зугаа болгоход хангалттай ажээ. Тэр тухай дурсамж нь зөвхөн өрсөлдөгчийнхөө , ихэвчлэн амьд үлдсэн ганцынх нь юмуу эсвэл өөрт нь зориулагдаагүй тэнэсэн сум ч юмуу хутганд өртсөн азгүй үзэгчийн л сэтгэлд үлдэнэ.

Нэг бус удаа миний бие шууд гүүрэн пдээр ч юмуу эхэлсэн гудамжны тулалдааны гэрч болж байсан бөгөөд заримдаа хажуугаар нь санамсаргүй өнгөрч явсан хүн тшшнд нь өртөн шархдаж, бүр энэхүү ер бусын ирүүл тулааны үр дүн болж амиа золиослохыг харж билээ.

Буруугүй нь ял шийтгэл хүлээх нь юмуу, мматериалаг хохирол төлсөн гэдгийгби хэзээ дуулж явсангүй. ийм явдлыг “золгүй тохиолдол” мэт үздэг билээ. Кассий Колхаун , Морис Жеральд адил сууринд нэлээн хожуу зүэгждэх болсон ч бас Морис хааяа цайзаар ирдэг байсан ч гэлээ , тэдний буудалцааныг хүмүүс ихэд сонирхон бүтэн ес хоногийн турш ярицгаалоаа. Колхауныг муухай, дээрэнгүй зан, мустангерийг тойрсон нууцлаг, битүүлэг байдал нь тэдний ирүүл т тулалдааныг онцгойлон сонирхох учир нь бож өгсөн бөгөөд тэр хоёрын тухай , сайн муу талынх нь тухай муудалцсанаас хойш олон хоног ярилцан, ялангуяа тэдний уцс урссан гуанзны бааранд улам ч ширүүн ярилцаж байв.

Ялагч бүхий хүндэтгэлийг хүлээж, олон шинэ нөхөдтэй болов. Түүний өрсөлдөгчийн талд цөөхөн хүн байлаа. Ихэнх нь ирүүл тулалдаанб үо дүндсэтгэл хангалттай байв. Хэдийгээр Колхаун энэ нутагт ирээд удаагүйч гэсэн, дээрэггүй бүдүүлэг зангаараа бааранд орогчдыг өөрийн эсрэг болгож дөнгөжээ.

Бүх хүн, залуу ирланд эр түүнийг сайн болгоод өглөө хэмээгн сайшаан янзтай ярилцана.

Өөрийн ялагдлыг Колхаун яаж тэсвэрлэж өнөгөрүүлсэнтйш хэнч мэдсэнгүй. “Үдлэх газар” буудлаао дахин үзэгдсэнгүй. Шалтгаан ньойлогомжтой абйлаа. Хүнд, бараг үүхлүүт шарх олсон нь түүний орон дээр удтал хөдөлгөлгүй хэвтүүлжээ.

Морисын шарх тийм онц аюултай биш байсан болов бас л орондоо хэвтэхэд хүрэв. Тэгээд Обердоферын буудалд нэгэн энгийн өрөөнд хэвжээ. Ялан дийлэгчдийн нэг хүнд ч буудлын эзний зүгээс түүнд жирийн нэг хааш яаш ханддаг хандлагыг өөрчилсөнгүй. Цус их алдсанаас болж буудалцсаныхаа дараа уаан алджээ. Түүнийг хаашаа ч хөдөлж авч явах аргагүй байв. Өөдгүй муу өрөөнд хэвтэж байхдаа өөрийнх нь өрсөлдөгчид тавьж байгаа анхаарал халаимжинд атаархан болох л байдаа. Аз болоход Фелим түүнтэй хамт байж байв. тэгээгүй бол түүнд тун муу юм болох байжээ. Түүний үнэнч зарц сүүрс алдаж:

- Гэгээн минь! Энэ ч ёстой булай юм! Ёстөртэй хүнийг ийм нохойн үүр шиг юманд чихэж

оруулна гэдэг ёстой шившиг! Тан шиг хүнийг шүү! Энд олигтой идэж уух юм юуч алга. Бидэнд өгч байгааг юмыг нь сайн бордсон ирландын гахай ч тоож шинжлэхгүй юмыг нь та юу гэж бодно.

- Би тийм тухай ямар ч төсөөлөл алга. тэгээд ч Фелим минь Обердоферын юу ярьж байгаа ч надад хамаагүй. харин чи цаадхидаа дуулдуулчих гээгүй юм бол дуугаа татаж үз. Энэ хана шиг юм нь нимгэн гэдгийг бүү мартаарай.

- Энэ ханыг чөтгөр аваачаасай! Өөрий чинь тухай юу ярих нь танд хамаагүй юм биз дээ ? тэгвэл миний юу ярих нь ямар хамаатай юмт. Энэнээс муу хандах гээд энэ муу герман яадаг юм. Би ямар ч байсан ярья. Та мэдэж авах хэрэгтэй юм.

-За яахав, цаадхи чинь юу ярьсан юм бэ?

- За ийм байна. Цаадхи чинь танаар зөвхөн байр, угаалга, хоол ундны хөлс төлүүлээд зогсохгүй бс тэрээр шөнө та нарын хагалж хэмхэлсэн лонх сав, шил толь зэрэг хамаг юмыг төлүүлнэгэж нэг хнүнд ярихы нь би сонслоо.

-Надаад төлүүлнэ гэнээ?

- Тиймээ эрхэм Морис танаар ганцаарангаар нь төлүүлэх гэнэ. Тэр муу янкаас сохор зоос ч нэхэхгүй байна. Ёстой гулдиггүй өөдгүй явдал! Хараал хүрсмэр герсан л ингэж боддог байых. Хэргийг өдсөн тэр хүн л төлнө үү гэсээх , Баллибаллахын Жеральдын удам,, татөлөх ёсгүй!

№-Яагаад хамаг мюмыг ганцхан надаар төлүүлэх гэж байгаагий нь учрыг чи сонссон уу?

-Сонсолгүй яахав! Таныг нэгэнт гартаа оруулж авсан хөхө бух гээд, хамаг юмаа төлүүлэхээс наау тавихгүй гэж тэр муу луйварчин хэлж байна билээ.

- За яах вэ, тэр хүн ялимгүй алдаж байгаагаа цдахгүй үзнэ дээ. тэнэгэр нисч яваа тогоргуунд ч тооцоогоо өгсөн нь дээр байлгүй. Би учирсан хохирлын тэн хагасыг төлнө. Тэрнээс илүүг чадахгүй. Энэ тухай яриа гарвал чи түүнд үүнийг хэлээрэй. үнэнээ хэлэхэд Фелим минь , би бүр үнийг нь ч гэсэн яаж төлөхөө мэдэхгүй баөйна. Тэнд хагарч хэмхэрсэн юм зөндөөн байгаа нь мэдээж. Бид хоёрыг тулаллаж эхлэхэд ямар нэгном сүрхий тачигнаж хагарсныг би санаж байн. Толь юмуу цаг, эсхүл шил тольой юм харагарх шиг болсон.

- Морис гуай, том толь нэг шилтэй цаг хочр хагарсан гэнэ. Тэр нь хоёр зуун долларын үнэтэй юм гэдэг шүү. Худалч амьтан! Тал хувиас гь ч илүү үнэ лав байхгүй.

-Тийм байлаа ч гэсэн надад одоо тун хүнд байна. Фелим минт чи Алома руу явж хамаг үнэтэй цаайтаа юмаа авчрах хэрэг гарах байх гэж айх юм паа н Энэ төлбөрийг төлнө гэвэл би хамаг давируулаа мөнгөн хундаганаасаа зайлүгүй салахад хүрнэ. Аягүй бол буунаасаа ч хагацаж мэднэ.

- Морис та буугаа л үлдээж үзээрэй. Түүнгүй бол яаж амьдрах юм бэ?

-Амьдрана дээ. Биданд бугуйл тус болно.

-Ай хөөрхий, зөнөг Дофферийн бантангаас л одргүй хоолтой болно доо. Энд хоол идэх бүрт л гэдэс маань өвдөх юм.

Энэ үед хаалга ямар ч чимээ аниргүй нээгдэж, эр эмий нь харангуут хэлчихээд хэцүү нэг хүнтасалгаан дотор орж ирлээ. Шандсархаг гартаа сүлжмэл сагс бартжээ.

-Гертуда, юу гэв? гэж зарцыбг таньсан Фелим асуусанд

-Нэгэн эрхэм , үүнийг та нарт өгөөтөхөөч гэж гуйсан юм гээд тэр хүүхэн сагсыг өгөв.

- Ямар залуу вэ? Гертуда?

-Би танихгүй юм. Урьд өмнө огт үзэж хараагүй хүн.

-Нэгэн эрхэм өгсөн гэнээ? Фелимээ, тэр чинь хэн байдаг билээ? Наад дотор чинь юу байна үз.

Фелим сагсыг онгойлгож үзлээ. Доторнь хэдэн шил дарс, сэрүүцүүлэх ундаан, бас үарсан хайрсан боов, хуушуур зэрэг, өчүүхэн зурвас байсангүй. Гэвч нарийн нямбай боож багалсан нь эмэгтэй хүний гараар хийснийг илтгэнэ.

Морис сагсан доторхийг цөмийг гарган сонирхолоо. Фелимийн бодлоор бол юу байгааг үзэх гэжээ. Гэвч үнэн хэрэгтээ бол мустангер үал өөр юм бодож, зурвас ахйж байжээ.

Гэвч сагсанд цаасны өөдөс, нэрийн хуудса ч байсангүй. Ёстой хэрэгтэй үед ирсэн энэ баргийн гар татаагүй харахад баячн хүнээс ирсэн нь тодорхой байв. гэвч хэн байж болох билээ? морисмыг энэ асуултыг өөртөө тавингуут түүний сэтгэлд нэгэн сайхан дүр бууж ирэв. Луиза Пойндекстерын бэлэг байлаа гэж үү дээ?

Тийм байж болохгүй тал байлаа ч тийм байгаасай билээ гэж итгэхийг хүсч байв.

Гэвч улам лавруулж бодох тусам түүний итгэлээс ердөө муу горьдлого төдий юм үлдэв.

"Ямар нэг эрхэм өөгчээ." гэж Фелимд өөртөө ч биү эзэндээ чбиш давтан хэлээд- Нэгэн эрхэм гэж Гертуда хэлсэн. Сайн хүн нь харваас илт байна. харин ингэхэд хэн байдаг билээ? гэв.

-Фелим минь , би ерөөсөө огт төсөөлөхгүй байна. Цөайзын офицеруудын нэг юм бол уу? гэхдээ тэдний хэн нь надад ийм халамуж тавьж болохыг мэдэхгүй юм.

- Үгүй ээ, тэд огт биү. Ер нь энэ бжэлгийг эрэгтэй хүн өгөөгүй.

-Яагаад чи тэгж бодов?

- Яагаад би тэгж бодов гэуж үү? Морис минь та ингэж асуух ч гэж дээ. Эмэгтэй хүнитй л гараар хийгдсэн зүйл байна. Энэ юмнуудыг яаж цомнож хийсний нь та харахгүй байна гэж үү

дээ? Яах араггүй эмэгтэй хн. Тэгэхдээ хатагтай байхаас зайлахгүй.

-Фелим минь чи тэнэглэж б айна! Намайг ингэж халамжлахаар ганц эмэгтэй хүн би танихгүй.

- Танихгүй гэнээ? За, хаанаас даа эрхэм морис ! Харин би ямар хүн ийм бэлэг явуулсныг мэдэж байна. хэрэв тэр хүүхэн ингэж санаа тавиагүй бол энэ чинь ёстой хүний мөсгүй юм болно. Тэр нэг өдөр та түүнийг амийг авраагү гэж үү?

-Фелим чи хэний тухай яриад байна?

- Эзэн минь та өөрөө санахгүй байгаа юм шигцарай гаргах юмаа даа! Би тантай хамт овоохойд маань очсон тэр нэг сайхан хүүхнийг хэлж байгаа юм. тэр хүүхэн таны бэлэглэсэн бидэрт мустангийг унаж очсон. та бидэрт мутангийнххаа оронд хэлтэрхий зкоос ч аваагүй шүү дээ. Эрхэм минь, төрсөн нутгаа ярихаар, тэндхийн хүмүүсийг санах юм. хэрэв энэ б элэг түүнийх биш бол Феоим О Нил Баллибаллахын хамгийн тэнэг нь болог... Цэнхэр нүдэт хөөрхөн хүүхэн, танд тохиоллдсон аюулыг мэдсэн бол юу гэж хэлэх байсан бол!

-Аюул ий? Бүгд өнгөрсөн юм шүү дээ. долоохон хоногйн дараа босно гэж доктор хэлсэн. харин найз минь чи бүү гунь!

- Үгүй би тэгж ахэлж байгаа юм биү. Аюулыг тухай яриагүй байна. миний юу бодож байгааг өөрөө мэдэж б айгаа шүү дээ. Таны зүрх үрхалчихаж байж мэднээ? Сайхан нүдний харц заримдаа пойлоосон сумнаас илүү аюултай шархдуулдаг юм. Таны нүждэнд ямар нэг хүн шархдсан байж ч магадгүй ? тийм болоод ч бидэнд энэ бэлэг явуулжээ.

- Феолим чи андуурч байна. Энэбэлгийг цайзын хэн нэг нь явуулсан б айж таарна. Харин хэн я явуулсан байг, бид яагаад энэ сагстай юманд гар хүрэхгүй ёсорхог ёстой билээ. За аль вэ, амтлаад үзье.

Сагсанд байгаа амттай идээ ундаа амтлан өвчтөн сэтгэл нь ханасан боловч улам ч сайхан бодол сэтгэлд нь санаагий нт сэргээнэ. Өөрт нь маш знэтэй тэр хүний халамжийг мөрөөдөн байлаа.

Энэ бэогийг Морисын хорт дайсны үеэл дүү, хүмүүсийн ярилцдагаас бол сүйт бүсгүй нь болох залуу креол хүүхэн явууллаа гэж үү? Дээ? Энэ таамаглалд итгэхэд хэцүү мэт санагдана. Гэвч тэр биш бол хэн байх билээ.

Хоёр ч хоног өнгөрсөн боловч өнөөх бэлгийн нууц тайлагдсанггүй.

Удалгүй авчтэй хүнд түрүүчийнх шшиг нтхоёр дахь бэлэг ирж баярлууллаа. Шинэхэн амтат идээ, савтай ундаа агуулсан , ибас л өнөөх сагс шиг сагс байлаа.

Сагстай бэлэг авчирсан өгсөн үйлчлэгч хүүхнээс бас л асуулаа. “Нэгэн эрхэм авчирч өгсөн юм. эртээрийн ирдэг өнөөх танихгүй хүн” гэсэн өнөөх л хариуг сонсжээ Бас “тас хар” хүн

байсан, гялалзсан бүрх өмсч, луус унаж зочид буудлын хүрч ирсэн гэж л үйлчлэгч хүүхэн нэмж хэлжээ.

Морис танихгүй өглөгчийн тухай энэ тодорхойлолтод сэтгэл ханаагүй боловч түүнийгээ бусдад тэр бүү хэл Фелимд ч мэдэгдсэнгүй. Энэ явдлаас хойш хоёр хоноод гялалзсан бүрх малгайтай өнөөх эрийн авчирсан гурав дахь бэлгийг аваад л Морисын өнөөх мөрөөдөл мартагдахаас өөр аргагүйд хүрэв. үүний учир нь түрүүчийнхээ яг адилхан идэх уух юмтай сагсанд биш түүний бариулд дшшжилсэн захианд хэгийн учир байжээ.

-Өө энэ чинь Исидорх л байж хэмээн гарын үсгий нь харангаа Морис бувтнав.

Дараа нь испаниар бичсэн захидлыг хайххамжгүйхэн дэлгэн унглаа.

Эрхэм минь!

Би , Сильво авгындоо долоо хоног айлчиллаа. Би таны шархадсан тухай болоод бас зочид буудлын газар таныг муу үйлчилж байгаа тухай сонслоо. надад үзүүлсэн тэр их ачийг чинь санаж илгээсэн энэ өчүүхэн бэлгийг хүлээн авна уу? Би Ром Гранд руу явахынхаа яг өмнөхөн, морин дээрээсээ энэ захидлыг бичиж байна,

Миний амь насыг аврагч... түүнээс ч илүү нэр төрийгминь аврагч ачит хүн минь!Салахын ёс гүйцэтгэе. Баяртай!

“Исдора Коварубио де Лос-Льянос”

- Баярлалаа хонгор Исдора минь, баярлалаа! Гэж Морис захидлыг эвхэж, хөнжил дээрээ хааш яаш тавиад- хэзээд сайхан сэтгэл, анхаарал халамжтгай байх юм чи ... Луиза Пойндекстер байгаагүй бол би чамд дурласан ч байж болох юм! гэжүивэгнэн хэллээ.

XXIII. Өшөө авах тангараг

Колхаун өрөөндөө шаналан хэвтэхийн ийн анхаарч байгаад төхөөрхөж болохоор байв. Хэдийгээр гэртээ баян тансаг зүйлсийн дунд боловч энэ хорвоо дээр өөрт нь ойр дотно хүн бий юм шүү нэдэг бодлоор өөрийгөө тайвшруулж чадахгүй байлаа. Дэндүү зожиг амиа бодсон хүн болох тэрээр нөхөрлөлд итгэдэггүй бөгөөд түүнд найз нөхөд гэж байсангүй. орондоо хадагдан шарх нт үхүүлж магадгүй гэхээс айн амьд үлдэнэ үү, үхнэ үү гэдэг бусад хүнд огтын хамаагүй гэж бодохоос сэтгэл нь хямарна.

Хэрэв түүнд ямар нэг анхаарал халамж тавьсан байлаа ч гэсэн тэру нь зөвхөн ураг төрөл гэсэндээ л тэгсэн хэрэг бөайлаа. өөрөөл байж болохгүй юм. Үеэл дүү нартаа гаргадаг зан авир нь тэл нарыг өөртөө ойртуулна жгэдэг юу л бол. Түүний нагау бардам зантай Вудли Пойндекстер айхгүй ч гэсэн арзайна гэгчээр зэвүүрхлэг байлаа.

Үнэнэдээ өвгөн дөнгөж саяхнаас тэгж харьдаг болжээ. Пойндекстерыг зээдээ өртэй хүн хүн гэж хэдийн өгүүлсэн билээ. Тэр өр шир нь үнэндээ Кассий колхауныг дуртай цагтаа Кас-дель-Корвыг өөрийнхөө болсон гэж зарлжу чадахб айлаа.

Колхаун тэр байдлаасаа далимдуулж Луизаг эхнэрээ болгож авах гэж сүүлийн үед хүчлэн оролдож байлаа. гэвч удалгүй луизагийн зүрх сэтгэлийг эзлэн авч чадахгүй нь гэдгээ ойлгосон бөгөөд Луиза ч түүний үхээлд байгааг тоодоггүй гэдгээ өөрөөс нь нуудаггүй байлаа.тэгэхлээр Пойндекстерыг эрхэндээ оруулж авсныг ухамсарч , түүгээр уламжлан сансандаа хүрэхээр шийджээ.

Колхауныг хүнд өвчтэй байхад нт түүнтэй харьцах шинэ харьцаа бий болж өөр нөхцөлд тавих байсан анхаарлаас бага анхаарах болсон нь гайхалтай биш юм.

Өвчтэй Колхаун үхлийн аюулыг мэдэрч байсан үедээ орчныхоо хүмүст уян зөөлөн юм шиг байжээ. гэвч тэр байдлаа нь удаан үргэлжилсэнгүй. Колхаун аюул өнгөрлөө гэж мэдэхтэйгээ зэрэг шившигтэй ялагдлаасаа болж улам нэмэгдсэн зан авирын хамаг хэрцгий дээрэнгүй шинж нь дахин сэргэж иржээ.

золхаун амьдралынхаа турш өөрийн хэт нүүрмгий зангаар хд хав болгон ойр хавийнхыгөөа толгойлохыг дурладаг хүн байлаа. Түүний баатарлаг явдалд цаауид итгэх хүн Техаст байхгүй гэж бодохоос байж ядталаа тарчлан зовно.

Бүх хүүхний өмнө ялангуяа өөрөө хайрлаж явдаг тэр хүнийхээ өмнө ялагдсанаа харуулдна гэдэг, тэгээд ийм байдалд хүргэсэн буруутан нь дурлалынхаа өрсөлдөгч гэж үздэг нэг муу зальтай этгээд гэдгийг ухамсарлана гэдэг санаанд нь багтамжгүй зүйл байв. тэр ч байтугай жирийн нэг хнүнд ч иймэрхүү сэтгэлийн дарамт хчнээн хүнл байх нь мэдээж золхаун байж суух газраа олж ядан байлаа.

Морис мустангер үхэх ёстой.

Хэрэв түүний гарт, Кассий колхауныг гарт эс үхсэн ч өөр нэг хүний гарт заавал үхэх ёстой. хань хамсаатан олно гэдэг тийм хүнд зүйл биү. техасын өргөн уудам тал нутгаас хөлсний

алуурчин олох гэдэг италийн хотуудаас олохооё амархан. Алуурчийн хутгыг алт чиглүүлж чаддаггүй өнцөг булан гэж орчлонд үгүй билээ. Колхаун бол ямар нэг өөдгүй амьтан элбэгхэн худалдаж авчихаад цаана нь илүү гарахаар алттай хүн.

Колхаун бөглүү тасалгаандаа шархаа эдгэрүүлэнгээ Морисыг алах төлөвлөгөө боджээ.

Тийм аюултай өрсөлдөгчтэй, бүр гэнэдүүлэн дайрах тохиолдолд гардаг юмаа ч гэсэн дахин уулзахаасаа айх учир өөрөө хийе гэж бодсонгүй. Ялагдал нь түүнийг аймхай болгосон учир, өөрийнх нь өмнөөс гар далайх хөлсний этгээдийг олохыг хүсчээ. Хаанаас түүнийг олох билээ? гэж бодов.

Гай болж даалгаварыг биелүүлж чадах нэг хүн санаанд нь оржээ. Тэр нь Морис шиг бас л мустангер , сууринд амьдардаг мексик хүн байв. гэхдээ залуу ирландын дөлж явдаг хүмүүсийн нэг байлаа.

Тийм өвөрмөц мэргэжилтэй хүмүүс жам ёсоороо Техаст муу нэртэй байжээ. Эдгээр нь ихэвчлэн соёлт нийгмийн шаар болсон хүмүүс байх агаад тэдний дотор ялт хэрэгтэнгүүд ч цөөнгүй байдаг байв.

Мустангерууд сууринд үзэгждэхээрээ үргэож зодоон цохио хийж, энгийн номхно игэдийг залхааж ббайдаг. Тэдэнтэф ээрэм талд уулзлаа гэхэд амь насанд халтай байх нь цөөнгүй тохиолдоно. Техасын түүхэнд бүлэг мустангерууд хулгайн бүлэг болон хувирч , индианчуудын хувцас өмсөн зүсээ хувиргаж аянчин жуулчин тонох явдал нэг бус удаа гарчээ.

Кассий Колхаун эдгээр танхай этгээдийн нэгийг нь дурсан санажээ. Түүнтэй зочид буудалд олонтаа дайралдаж өнөөх буудалцдаг үдэш түүнийг үзсэнээ саналаа. Гайтй хөөтэй буудалцааны дараа түүнийг дамнуурга дээр тавиад гэрт нь авчирсан хүмүүсийн нэг нь тэр мустангерын байжээ. тэр мексик хүн Морисын тухай я ярьж, түүнтэй найзгүй ханддаг нь илэрхий байсныг санажээ. дараа нь Колхаун мексик хүн, морисын өөртэй нь адил шахуу үзэж чаддаггүйг мэдэж авчээ. Колхаун түүнийг сонгож авахаар үийдэж гэртээ дуудаж ирүүлжээ. Түүнээс хойш олонот шийдэж гэртээ дуудаж байгаад юмьярдаг боллоо.

Үүнд орчны хүмүүсийн сэжиг төрсөнгүй. Ер нь Колхаун ч энэ талаар санаа зосьонгүй. Тэр хүн үхэр, адууны дпанзчин учир тэдний хооронд ажил хэргийн холбоо байж болох ажээ. ийм тайлбар нь бүрэн үнэмшихүйц байлаа. Мескик хүн ч гэсэн Колхаунтай уулздагаа энгийн нэг уулзалт гэж анхандаа боджээ. Учир нь эхний хэдэн уулзалтаар яриа нь ихэнхдээ ажил хэргийн шинжтэй байлаа. Өмнөд нутгийн зальт эр, муухан таньдаг хүндээ өөрийн санааг илэрхийлэхгүй байжээ. тэгээд нэгэн үдэш мексик хүнд ашигтай худалдааны хэлэлцээр хийж , сайхан архи дарсаар дайлсан хойноо л Колхаун Морис тэр хоёрын харьцааны тухай мэдэж авахыг болгоомжтойгоо оролдов.

Энэ хүнд бүрэн итгэж болох бөгөөд ямар ч тцус хүргэж чадах, бүр хүн алах хэрэгтэй болбол ч алах л эр юм гэдгийг уг яриа Колхаунд итгүүлжээ. Тэр мексик хүн Морисыг үзэн яддагаа нуусангүй. тэгж үзэн яддаг болсныхоо шалтгааныг хэлээгүй ч гэсэн Кассий Колхаун шалтгаан нь өөрийнхтэй нь ижил бүүр Трион үеэс байдаг асан, эрчүүлийг хооронд хагарал гаргадаг хүүхнээс л болжээ гэдгийг тавьжээ.

Энэ удаа үзэсгэлэнт Елена нь Морисын үе үе очдог хар нүдэт авхай байлаа. тэгээд тэр хүүхэн нь ирланд мустангерыг өөрийн нутгийн мустангераас илүүд үздэг байжээ. мексик хүн, тэр хүүхний нэрийг хэлээгүй бөгөөд Колдхаун, ч мэдэх гэж оролдсонгүй. Харин яриагүй нь сонсч байхдаа мексикийг тоодоггүй тэр хүүхэн өрсөлдөгчийн нь сэтгэлитийг булаасан байгаасай билээ гэж нууцаар найдаж суув.

Өвчингөө эдгэрүүлэнгээ Колхаун, мексик мустангшерын олонт уулзаж түүнтэй элэгсэг дотно байдлаар удаан ярилцдаг байсан нь тэд үйлдэх хэргийнхээ төлөвлөгөөг энэ хоорондо бүрэн боловсруулж эсэх, түүнийг бодож боловсруулагчид нь ямар шуламсын санаа агуулсныг зөвхөн тэд өөрсдөө л мэдэж байв. Зөвхөн талын чоно гэдэг хочтой мигуэль Диас гэгэч тэр хүн Кассий Колхаун хоёр итгэлтэй найз нөхөд болцгоосныг орчны хүмүүс ажиглан байнга хамт байх болсонд нь энэ жигтэй нөхөрлөл олон хүн гайхаж байлаа.

XXIV. Асотей дээр

Техасын тариалангийн эдлэнгүүд дээр нар тусмагц өдрийн ажил эрхэлдэг, хар арьст боолцуудыг ажилд дуудсан хонхо харанга, малчны урмын дуу боолын эздийг бас халуун хөнжлөөс нь босгоно.

Каса -дель-Корво хуучин эзний үед ч ийм байжээ. Америк эзний гэр бүл тэр занулынхаа өөрчлөөгүй бөгөөд үнэндээ энэ нь уламжлалыг сахих гэсэн биш, байгалийн шаардлагааро тийнхүү болжээ. үргэлж хавраараа шахуу байдаг, нарлаг Техасын сайхан тунгалаг өглөөг орон дотроо хэвтэж өнгөрүүлэх нь даанч харамсалтай. Харин нарны шатам илячинд байгаль дэлхий тэр чигээрээ нозоорхо үдийн үед амрана.

Бүх юмс нар гарахыг баяр хөөртэй угтана. Халуун орнышувууд хурц өнгийн далавчаа дэлгэн, дэлбээ нь шүүдэрт нормон цэцэг нарын туяаг хүсэн хүлээнэ. Амьд бэхэн нарыг магтан дуулна.

Өглөөний туяа шиг үзэсгэлэнт сайхан Луиза, % асотей дээр зогсч байлаа. Шөнийн шүүдэр хатаагүй чулуун хашлагын дээр гараа тавьжээ. түүний нүдний өмнө голын тохойрсон хэсгийн цэцэрлэг, цаад эрэг нь цаашилбал нэлийсэн нарынзүг ширтэнэ.

Харахгүй байхын аргагүй сайхан байгалийн үзэмжийг харж зогсоно уу гэвэл тийм биш байлаа. тэр мандаж б уй нарыг ч харсангүй.

Тэгвэл цэцэрлэг төглийн дээгүүр уянгалан жиргэх шувуудын дууг ёчагнаа ву?

үгүй ээ, тэрээр юу ч сонч, юу ч анзаараагүй байв. харц нь нэг л алмай байдалтай, бодол санаа нь хол бэлчсэн мэт.

Тунгалаг өглөө, шувуудын жиргээн, түүнийг баясгасангүй. түүний царайд уйтгар гунигийн сүүдэр илэрхий.

Тэр ганцаарахнаа, түүний гунигийг хэнч анзаарч хэн ч яасны нь асуусангүй.

-Хүнд шархдсан байж болох юм аа? үхлүүт шаххдсан байж ч магадгүй.

хэнийг тэгтлээ ингэж сэтгэл догдлон ярина вэ? Тэрүүхэн дээр нь нэг өрөөнд хэвтэж байгаа Кассий Колхауныгяриа юу? тэр нь юу л бол. түүрүүхэн нь эмч үзээд эдгэрч байна, амь насанд нь аюулгүй гэж хэлсэн билээ. хэрэв н хэн нэгэн хүнийг түүнийг ганцаараа үргэлжүүлэн ярихыг нь соссон бол өөр хүний тухай ярьж байгааг нь зовлонгүй мэдэх байх.

- Би түүнд хэнийг ч Явуулж чадахгүй нь : Би хэнд ч игэхгүй байна. тэр хаана хэвэж байгаа ... Түүнд тусламж дэмжлэг хэрэгтэй байгаа. ... Би түүнд хэнд ч мэдэгдэлгүйгээр зурвас явуулчихаж чаддаг ч болоосой. Өнөөх Зеб Стумп гуай хаашаа алга болчихдог байнаа? Гэж шивнэж байв.

Залуу креол хүүхэнд яагаад ч юм зеб юу юугүй гараад ирэх юм шиг санагдан, тал, голын

нөгөө эргийн дагуу үргэлжлэх зам руу харлаа. Энэ бол инж цайз, доод леоны тариалан хоёрын хоорондох зам бөгөөд гооос нэлээн зайдуу зурагийж зөвхөн огцом тохойрсон гакарт л нийлнэ. Бзсгүй инж цайз руу Зеб стцмдын ирж болох зүг рүү харавч энэ удаа түүний бараа байтугай өөр хүн ч үл харагдана. Нэгэнт ирнэ гэж амлаагүйээс хойш гомдох юм алга байлаа.

Луиза хэсэг болоод юунаас ч болсон юм гэнэт эргэн эсрэг тал руу харж эхэллээ.

Хэрэв тэндээс хүн олж харъя гэж бодсон бол энэ удаа хүүхэн эндүүрсэнгүй. Бөөн модны тэндээс морьтой хүн гарч ирлээ. тэр нь луизап анхандаа араб маягийн хуцвастай эргэтэй хүн шиг харагдсан боловч тэр нв сүүлдээ морин дээрээ эрэгтэй хүн шиг мордсон хүүхэн болохыг танив. Тэр морьтон хүүхэн нүүрээ нимгэн сэгсгэр ороолтоор бараг бүтээчихсэн учир царайгий нь ялган харахад хэцүү бай. гэлээ ч гэсэн түүний удаа бутарсан хөөрхөн бор царай бас өмнө зүгийн тэнгэрийн од шиг гялалзсан сайхан хар нүдийг Луиза ажиглан харжээ. Эмээл дээрээ суусан өвөрмөц маяг нь мөрөн дээрх ороолт нь ч түүнийг аятайхан хүүхэн гэдгийг хэлээд өгөхөд саап болсонгүй.

Тэр үл таних хүүхний хойноос арваад алхмын зайтай бас нэг луус унасан хүн дагаж яваа нь өмссөн хуцвас , зай барьж явааг нь бодвол зарц нь бололтой. Луиза тэр морь унасан сонин хүүхнийг сайн харж авах гэж лорнетаа нүдэндээ ойртуулангаа.

- Энэ хүүхэн хэн бэ? гэж шивнэснээ шилээ авчихаад дахин сайн ажиглан харахад -Энэ чинь хэн бэ? Мексик хүүхэн юм. тэр луус унаж яваа хүн зарц ньв байжээ... Энэ ч ямар нэг сурвалжит хатагтай бололтой Би эднийг ц өмийг нь Мцксик рүү нүүчихсэн гэж бодсон юмсан... Бараа ологч ньсагс барьж явна... тэр дотор нь юу байгаа бол? Эд яагаад цайз руу ч юмуу суурин руу ирж яваа юм бэ? Энэ хүүхнийг манайхны хажуугаар өнгөрч явахы нь энэ долоо хоногт би гурав дахь удаагаа харж бөайна. Тэр хүүхэн, нолын доод биеэр байдаг тариалангийн газрын алт нэгтээ нь суудаг байхр. Морь унахдаа яасан өвөрмөц маягтай ундаг юм бэ? Би мексик, хүүхнүүдийг морь ингэж унадаг гэж дуулсан. Хэрэв би ингэж унавал яах бол? мэдээжээр энэ нь эвтэйхэн байлгүй яахав. гэвч манайд үнийг эмэгтэй хүнд зохихгүй маяг гэцгээнэ дээ.манай шүтлэгтэй авгай нар яаж сандчих бол. Ха-ха-ха! тэд айж сүйд болно доо!... гэж шивнэв.

Гэвч төдхөн инээхээ больж нар үүлэнд халхалагдах мэт дорхнооо хуовирав. Гэвч энэ нь түрүүчийн адил гунигаас болсонгүй, гэхдээ л царай нь цонхийн сэтгэд зовсон шинжтэй. төглийн шугуй дотроос нэг гөрөөс зам дээр давхин гарч ирэв. тэгэнгүүт морь ч үргэсэ амьтны араас харайлгав. Морьтой хүүхэн нүүрийнхээ гэвлүүрийг хуу татан аваад баруун гараараа хэд дахин даллав.

-Яаж байгаа юм бол? гэж Луиза шивэгнэснээ - Өөө энэчинь бугуйл байх нь байна шүү дээ гэв.

Мексик хатагтай , үэндэснийхээ тэр зэвсгийг гаргуут эзэмждэгээ дорхон нь үзүүлж бугуйлаа ёчадмаг шилдэж гөрөөсний хүзүүнд углаад татахад гогцоо нь чангарч гөрөөс боож уналаа.

Зарц нь бушуухан давхиж очоод лууснаасаа буун харайж гөрөөсийг хутгалан зүйл дуусгаад луусныхаа нуруун дээр тэгнэн дахин мордож, хатагтайн хойноос явлаа. энэ зуур хатагтай

бугуйлаа эвхэж нүүр рүүгээ бүтээлгээ унжуулаад юу ч болоогүй юм шиг цааш явав.

Бугуйл агаарт шунгинах үед л залуу кроел бүсгүйн нүүр б арс гээд явчихжээ. Энэ н гайхсандаа бус шал бөөр нэлээд эвгүй бодлоос болж ингэжээ. хэдийгээр лорнет барьсан гарь нүүрийг нь халхлаад байсан боловч царай нь морьтныг далд ортол, нүдэнд харагдахгүй болсон хойно ч уйтгартай байгааг ажиглаж болохоор байлаа.

"Энэ чинь өнөөх хүүхэн мөн гэж үү? Насаар миний үе надаас жаахан намхан гэж тэр хэлсэн. холоос харсан боловч яг таарч байна. рио Грандад суудаг, Ленод үе үе хамаатныдаа ирдэг гэсэн. Хэн гэдэг юм бол? Би яагаад тэрний нэрийг асуугаагүй юм бол? Өнөөх хүүхэн мөн гэж үү дээ? "

XXV. Өгөгдөөгүй бэлэг

Луиза холдон явж байгаа морьтой хүмүүсийн хойноос ширтэн, харж гауун бодолдоо дарагдан зогссоор байв. Түүний гунин зогсч байгаа нь, царайны нь байдал ямар ч байсан хөгжилтэй зүйл бодоогүйг илчилнэ.

Үгүй ээ, шал өөр юм бодож байжээ. үүнээс өмнө тэр моринд гарамгай хүүхнийг нэг, хоёр бодож байсан авч яагаад наауаа ирээд байгаагийг нь бодож байсангүй. гөрөөстэй тохиолдсон явдлын нь дараа таавар нь сэжиглэлээр солигдов. Гэтэл тэр хоёр хүнийг төглийн цаагуур далд орж амжаагүй байтал яг тэндээс нь бас нэг морьтой хүү гарч ирээд тэднийх рүү ирдэг замаар эргэсэнд нь баярлав. Лорнетто өргөн хараад тэр хүн нь Зеб Стумп болохыг таниад Луизагийн царайд гэнэт баярын гэгээ тусав.

Луизагийн сэтгэл уужрав.

- Ээ гчлаа !Стумп гуай надад хэрэгтэй байсан юм! Би түүгээр зурвас дамжуулан болно. Бас тэр хүүхэн хэн болохыг надад хэлж өгч ч магадгүй. Тэдээжээр түүнтэй замд да дайралдсан байгаа Тэгэхээр сэжиг төрүүлэхгүй тэр талаар ярьж болох нь байна. Хамгийн ийм хэрэг болсоны дараа Зебтэй хүртэл болгоомжтой ярилцах хэрэгтэй. Хэрэв би түүнд аятайхан санагдсан гэдгээ мэддэг бол нэг их санаа зовоод байх хэрэггүйсэн! Гагцхүү түүний хайнга байдгийг яана тэр тусмаа надад Луиза Пойндекстерт шүү! Зүрх сэтгэлдээ шархлуулж байгаад ч болсон энэ талхидлаас ангижрах хэрэгтэй! Цаашид ингээд байж болохгүй.

Энэ үед Зеб сугмп гуай! Гэж Луиза анч өвгөний сонсохдоо дуртай байдаг уяхан дуугаар баяртай мэндлээд- Би тантай уулзсандаа яасан их баярлана вэ? Мориноосоо буугаад, миний энд ирээч, би таныг юм өөд авирахдаа сайн гэж мэднэ. Энэ шат өөд гүйхэд та огт торохгүй. та шат өөд авирсандаа харамсахгүй тийм сайхан юмыг эндээс харна шүү гэв.

- Луиза авхай таныг харах нь надад сайхан шагнал болно. үүний төлөө байшингийн дээвэр байтугаай усан онгоцны яндан өөд ч авирахад болж байна... Байзаарай, би муу хөгшин гүүгээ саравчинд оруулж орхичихоод наад өөд чинь гарья. Нүд ирмэхийн л ажил.

Тэгээлд ясанг хэдрэгээсээ буугаад түүндээ хандан

-Хөгшин минь гуниглах хэрэггүй! Толгойгоо өргөнө шүү. Плутон чамайг эрдэнэ шишээрч дайлж болох юм.

- Өө Ноён Сугмп! Гэж дөнгөж саяхан хашаа руу орж ирсэн хар дэлбэгч дуу алдаад- негр чинь одоохон наад моринд чиньв цадтал нь эрдэнэ шиш өгөмц. Харин та өөрөө ахайтан руу очигтун. Плутон гүү чинь гомдоохгүй гэв.

-Чөтгөр аваг! Чи бүр бузгай хүн юм! дараа үүгээр ирэхдээ чамд тахиа шиг үөөлхөн махтай ноцолгоно бэлэглэмц. Чамд бүр амачихья.

Ингэж хэлээдп Зеб стумп шат өөд хоёр гурав гишгүүр алгасан гишгэсээр төдөлгүй асотей дээр гарч ирэхэд залуу эзэгтэй түүнтэй дахин мэндэлсээр угтав.

Хөгшин анчин түүнийг асортейн сэлүүхэн буланд аваачихад нь Луизагийн сэтгэл ихэд догдолсныг дорхиноо ажиглан зөвхөн сайхан газкар сонирхон харах гэж энд уриагүй нь ойлгожээ.

Луиза анч өвгөний хүрэмний ханцуйнаас татан бор нүд өөд нь асуусан маягтайы хараад.

-Стумд гуай... та лав бүгдий нь иэднэ байхаа! тэрний бие нь ямар байна? Аюултай шархдаж уу? надад яриач дээ гэв

- Та мистер Колхаун гуай тухай асууж байгаа бол ...

-Үгүй ээ, үгүй би тэрний тухай бүгдий нь имэднэ.

-Гэвч мисс Луиза минь бби манай эндээс шархдсан өөр ганцхан хүн л мэдэж байна. морис мустангер шүү дээ. Та тэр хүнийг асууж байж болох юм даа?

- Тийм, тийм тэр хүн. хэдийгээр миний үеэл ахтай тэмцэлдсэн ч би тэр хүнийг хамаагүйд үзэж чадахгүй. Морис Жеральд, аминд орсон хоёр ч удаа хүлээс аварсныг та мэднэ шүү дээ? шарх нь аюултай юмуу? Хэлж өгөөч дээ.

Үүнийг тоглоом тохуу хийж цааулуулах аргагүйгээр тийм их сэтгэл догдлон асуужээ.

Стумп яаран хариу хэлсэн нв:

- Ямар ч аюулгүй.хөлийн шагайнаас дээгүүр нь сум тусчээ. энэ бол шалбарснаас аюултай биш. Кшшн гарт нь нэг сум туссанб айна. Түүнд нь ноцтой юм огт алга. Харин цус л зэгсэн алдсан. Хэд хоногийн дараа орноосоо босдонг болно. Одоо бие нь сан байна. Хэрэв морь унаад тал дундуур явбал, техасын бүх эмч нараар эмчлүүлснээс хурдан эдгэх байлаа гэж т тэр залуу ярьж байна билээ. Би ч тэгж бодож байна. гэвч түүнийэмнэж байгаа цайзын мэс засалч, одоогоор босч явахы нь зөвшөөрөөгүй байна.

- тэр одоо хаана хэвтэж байгаа юм бэ?

-зочид буудалд. Хэрүүл марган гарсан рэ загар.

- Түүнийг мэдээжээр муу л аарч багаа биз дээ? тэр зочид буудлыг чинь өөдгүй гэж би дуулсан юм байна. Өвчтэй хүнд таармаар хоол л лавөгөхгүй байгаа даа... стумдп гуай жаахан хүлээж үзээрэй. Би одоохон эргээд ирнэ. Би түүнд юухан хээхэн явуулах гэсэн юм. таныг намайг бодон хүргээд өгнө байх гэж бодож байна. тэгнэ биз дээ? Би итгэж байна.

Луиза хариу хүлээлгүй, шат руу очитж доош түргэн буулаа. Тэгээд удалгүй амттан, ундаагаар дүүргэсэн том сагс барьсаарэргэж ирээд

- Стумп гуай та түүнийг Жеральд хүргэж өгнө биз дээ. Энэ дотор Флоринда жаахан сэрүүцэх ундаа чанасан жимсээрэг юухан хээхэн хийлээ. Өвчтэй байх үед амттай юм идмээр санагддаг м. Харин гуанзнаас ямар нэг амттай юм олдж идэх ч юу л бол доо. Гагцхүү энэ юмыг хэн өгснийг түүнд битгий хэлээрэй. Бас өөр хэнд ч хэлж болохгүй шүү. таныг хэлэх ч үгүй байх

гэж бодож байна, миний сайн санаат аварга минь!

-Мисс Луиза та өвгөн Зеб Стумп итгэж болно.

Энэ амттан хэнээс ирснийг нэг ч амьтан мэдэхгүй байж болно. гэхдээ залууд юм бүгд элбэг дэлбэг бий. Бөөн амьтдыг чамттанаар цатгачихаар янз бүзрийн юм аваачижж өгдөг юм билээ.

-Өө! Түүнд хүн юм аваачиж өөгдөг байх нь ээ! хэн юм бол?

- харин түүнийг чинь д өвгөн зеб Стумп мэдэхгүй болохоор хэлж чадахгүй байна. хэнийх нь бүү мэд нэгц мексик карц л түүнд ямар нэг амттан авчирч өөгдөг гэж би зөвхөн сонссон юм. Би ч өөрөө харсан Би хэдхэн мөчийн өмнө танай ордны ойролцоо тэр хүнтэй дайралдсан. Тэр, эмээл дээрээ эр хүн шиг суусан нэг эмэгтэй хүнд бараа болж явна билээ. ихэнх нь мексик эмэгтэй тэгдэг юм. Би эрэгтэйг нь зарц нь гэж бодож байнга. Хойно нь явна билээ. тэр мексик тун маяхан морисын хүлээж авсан сагстай эгээ ижил, тийм сагс барьж явна. Бас л тэр өвчтэй хүнд өгөх гэж янз бүрийн юм авч явах шиг байна.

Цааш шалгаагүй байх хэрэггүй болжээ. хэдхэн үгээр олон юм өгүүлэгдлээ. Бүх юм зовлонтойёо тодорхой байлаа. Луиза Пойндекстерт өрсөлдөгч хүүхэн байх нь тэр. Бугуйл барьсан мексик хүүхэн бол сэтгэлтэй хүүхэн нь мөн бөгөөд Морисын сүй тавьсан бүсгүй байж магадгүйяа.

Ингэтэл асотейн хашлага дээр тавиал, креол хүүхний түшэж байсан сагс гэнэт доошоо гулсан унасан нь санамсаргүй хэрэг биү байлаа. шил лонхны хэлтэрхий хашааны чулуун хаятан дээр үйрэн хэвтэнэ. Дотор нь агуулсан юмс тал бүр тийшээ асгарав.

Хэдийгээр гарын хөдөлгөөн нь огт санамсаргүй өөрийн эрхгүй тэгж хөдлөх шиг болсон боловч цаанаа бол яг тооцсон байжээ. Луиза доош харан, өөрийнх нь зүрх, чулуун дээгүүр хагараад хэвтэж буй шил мэт бут үсэрчих шиг болохыг мэдэрлээ.

- Ээ хайран, юм! гэж луиза сэтгэлийнхээ түгшүүрийг мэдэгдэхгүйгэ хичээн хэлдээд Бүх юм өнгөрлөө. Флоринда юу гэх бол ? за яах вэ эрхэм Жеральд миний бэлгийг хэрэглэхээргүй тийм халамжинд байгаа юм байж. Түүнийг хүмүүс мартаагүйд би их баячрлаж байна. Угнь их тус болсон хүн багйа аюм. Харин Стумд гуай та хэнд ч йюу ч битгий хэлээрэй дээ. тэрчлэн түүний тухай миний юу гэж асуусныг ч битгий яриарай. тэр миний үеэл ахтай буудалцсан болохоор дэмий яриа гаргачихаж мэднэ. Эрхэм Зеб та тэгж ярихгүй гэж надад амлана биз дээ? гэв.

-хэрэвта хүсвэл амлах байтугай тангаргалая. Луиза авхай минь, нэг хүнд ч ганц ч үг хэлэхгүй. та өвгөн Зебт санаа амар найдаж болно.

- Би үүнийг мэдэж байна. За одоо эндээс явья. Нар сүрхий шарж эхэллээ. Доошоо бууж, таны дуртай мононгахилийн виски жаахан олдох нь уу үзье. Явья даа!

Тэгээд залуу креол хүүхэн “шинэ орлеаны вальс” аялсаар шат руу хөгжилтэй дүр үзүүлэн

гунхалзксаар буулаа.

Өвгөн анчин урилгыг дуртай зөвшөөрч араас нь дагав. Хэдийгээр тэр эмэгтэй хүний сайханд хэв нэг ханддаг ч дуртай ундааг нь өгнө гэдэгт хамаг бодлоо тавьсан ч зааны ясаар сийлсэн шиг мөрийг нь өөрийн эрхгүй харж явлаа.

Гэвч энэ нь удаан үргэлжилсэнгүй. Луиза бумагц анч өвгөнөө саллаа. Зеб түүнд өөрөө ч мэдэгдэлгүй мустангерын нууцыг задалчихсанаас хойш Луиза өвгөн анчинтай цуг байгаад байх сонирхол байсангүй. Түүнийг юискитэй нь хамь үлдээчихээд бүсгүй бусдаас гунигаа нуухын тулд өрөө рүүгээ яравчилан явна.

Луиза Пойндекстер хардлагын гашуун зовлонг амьдралдаа анх удаа эдэлжээ. Энэ бол тэр хүүхний ахны жинхэнэ дурлал байжээ. тэрээр морис Жеральд дурласан байжээ.

"Мексик хатагтайн Морист тавьж байгаа халамж нь жирийн үерхлийн илрэл гэж үзэж болно гэж үү. Тэд нэлээд ойр дөт харьцаатай байдаг бололтой" гэж цөхрөнгөө барсан креол бүсгүй бодож байлаа. Морисын ярьж байсан ч, өөрийн нүдээр харснаасаа ч үзсэн бугуйлтай бүсгүй бол тийм хүний дурыг чухам булаах нь с ёстой хүүхэн байлаа. Түүний бие Луизад өөгүй сайхан юм шиг санагджээ. Харин царайг нь л сайн харж чадсангүй. Бас ч гоо сайхан байсан юм билүү? Морис Жеральд шиг сэтгэлтээ сайтар барьж чаддаг хүнийг гайхуулж бахархуулмаар сайхан байсан болов уу?

Луиза тайван сууж чадсангүй. мексик хүүхнийг дахин үзэж, нүүр царайг нь ажиглаж храх юмсан гэхээс тусч ядан байв. Зеб Стумпийг явахтай нь зэрэг бидэрт мустангаа эмээллэхийг тушаагаад, голын олмоор гатлан нөгө эрэгт нь гарав. Тэгээд цайзын зүг явж байтал яг бодож байснаар нь нөгөө хатагтайтай, хатагтай ч гэж дээ өөрийн нь үеийн авхайтай дайралдав.

Энд зам нь модод сүүдэрлэгджээ. Мексик хүүхэн ороолтоо мөрөн дээгүүрээ хааш яаш унжуулаад : толгой нүцгэн явж байлаа Хэрээний дал шиг тас хар өтгөн гээг нь түүний хөөрхөн бор царайг эмжээрэлжээ.

Тэр хоёр хүүхэн уулзахдаа ёсыг бодож зөвхөн зэрвэхэнхаралцав. Гэвч жаахан холдож яваад аль аль нь өрсөлдөгчөө сэмхэн харах гэсэн хүслээ барьж чадалгүй хоёулаа эргэж харчихав.

Харваас тэр хоёр хоёулаа тийм ч их зөрөөтэй юм бодсонгүй. Зөвхөн Луиза мексик бүсгүйн тухай сонссон төдийгүй бас цаадхи нь Луизагийн тухай сонссон байжээ. Бид мексик бүсгүйн энэ уулзалтынхаа дараа юу бодсоныг ярихаа больё. Зөвхөн креол бүсгүй маань л зугааларын өмнөхөөс ч улам илүү бодлогшон буцаж харихдаа бүр хачин болчихсоныг хэлэхэл хангалттай. луиак өрсөлдөгчийнхөө дэргэдүүр гарахдаа өрсөлдөгчийнхөө хараад яасан сайхан бүсгүй вэ? Морисын зөвхөн найз нь байхад дэндүү сайхандах юм байна гэж боджээ.

Луиза байгаа юмыг байгаараар нь үнэлдэгийг хичээн өөрөө өөртэйгөө ярьж гарлаа. ондоогоор бол тэрээр мексик бүсгүйг тийм ч их магтахгүй байсан бизээ.

Тэдний ямар харьцаатай байдагт эргэлзэх юм өлгө. Морис түүнд хайртай юм байна! харин би гэдэг тэнэг амьтан ийм сэтгэлээс аз жаргал горьдож байдаг! Түүнийг марнат, энэ тууааг

зүрхнээсээ авч хаях хэрэгтэй. мартаж л хэрэгтэй. хэлэхэд амархан я хийж чаддаг болов уу? Би түүнтэй дахин уулзах ёсгүй. Ядахнаа би ингэж даанч чадах байлгүй дээ. тэр явдал болсноос хойш тэр манайхаар үзэгдэхрээ болино. Хааяа нэг тохиолдлоор дайралдаж болох л юм , тэр үед нь аль болохоор зугтаагаад л байя. Ээ, Морис Жеральд минь, юундаа чи намайг ингэж зовооно вэ? ! гэж үргэлжүүлэн бодлоо.

XXVI. Дахин асотей дээр

Үнэн санаанаасаа дурласан хүнээ мартаж нгэдэг байж боломгүй хэрэг. Хайрынхөө хариуг хүртээгүй зүрхэнд цаг хугацаа гэдэг сайн эм болж өгдөг агаад салж хагацах нь улам ч их нэмэр болох нь бий. гэвч цаг хугацаа ч салж холдох ч андаа алдахын гунигийг мартаулан, хайрыг амсаагүй зүрхийг тайвруулж чаддаггүй ажээ.

Луиза Пойндекстер өөрийгөө эзэмдэн сэтгэлтэй тэмцэнэ гэдэг амаргүй байв. хэдийгээр тэр нь дөнгөж саявтар гарч ирсэн ч гэлээ бүх саадыш даван түргэнээр газар авчээ. Энэ хайрын сэтгэлийн хичнээн гал дөльэй байсныг, эцгийн сэтгэл ханамжгүй багаа нь ч нийгэмд эзлэх байдлын адилшүй нь ч бүсгүйг огтхон ч зовоогүйгээр илэрнэ. Тэр нь нгэнт нас бие гүйцсэн учир эцгийн зөвшөөрлийг заавал авах албагүй байлаа. хоёр дахь саадын хувьд гэвэл, нэгэнт үхэн хатан дурласан хүн олны ам ямар байгааг огтхон ч тоохгүй байдагт оршино. хайр сэтгэл бол энэ мэтийн ялимгүй зүйлийг тоодоггүй юм. Луизагийн амьдралд анх удаа сэтгэлийнх нь амлаглан тайвныг эвдсэн зүйл гарч ирэх нь энэ.

Зоригийн хүчээр сэтгэлийн өвчнийг дарахад төрөлхийн сэргэлэн байдал тум болно гэж луизад анхнадаа бодогджээ. гэвч өдпөр хоног өнгөрсөөр байхад ер нь зшрх нь амарсангүй. Бүсгүй хүсэл мөрөөдлийг нь тэр чигээр нь эзэмшсэн хнээ мартаж ёчадахгүй байв.

Тэгээд заримдаа Луиза, морисыг үзэн ядах нь юмуу чухамдаа үзэн ядахыг хүсдэг байжээ. тэр үедээ Жеральдийг огт хайрлалгүй алчихаж чадах, эсвэл нүдэн дээр нь өөр хүн аллаа ч гэсэн очиж туслахгүй юм шүү гэж бодогдоно. Гэвч тэр нь агшин зуурын хилэгнэл байв.

Түүнийг хичнээн бодох тусмаа Морис түүний өстөн дайсан, хүн төрлөхтний дайсан Люцифехр өөрийн биеэр байлаач гэсэн ялгаагүй түүнд дурлахаа больж чадахгүйрээр улам илүү ухамсарчбайлаа.

Луиза Морисыг жигшин зэвүүцэж, үзэн ядаж ячадахгүй байыжээ. Түүнийг зөвхөн хайхрахгүй байх гэж л оролдов.

Өдөр бүр, бараг цаг тутам асотей дээр гарч өөрийн өрсөлдөгчөө анх олж харсан зам руу харна. Тэр ч байтугай өөрийг нь зол жаргалгүй болгосон хүнтэй уулзахгүй гэж шийдсэн мөртөө тэр хүнтэй уулзах гэсэн ганцсанаа агуулж, морь унаад зам харгүй, суурингийн гудамжаар явдаг байв.

луиза өрсөлдөгчийнхөө анх уулзсанаас хойш гурав хоногийн дараа түүнийг асотей дээрээс бас дахин харлаа. Тэр мексик хүүхэн өнөөх л морьтой хүнээ дагуулаад, яг л түрүүчийнхээ адил цайз руу явж байв. Бараа бологчоо бас л гартаа сагс дүүжилжээ. Луиза тэднийг ажиглан харангаа өвчтэй хүнийг халамжлах талаар өөрөс нь илүү байгаа мексик хүүхэнд атаархан дагжин чичирч байв.

Луиза одоо тэр хүүхнийг төдий их биш ч ыгэсэн урьдынхаасаа илүү мэдэж байлаа. Голын доод биед, Каса-дель-Корвогоос бээр зайтай байдаг газрын эзний зээ бөгөөд Рио-Грандын том орд харшийн эзний охин Исидара Коварубио де Лос Льянос авхай ажээ. залуу мексик

хүүхэн бугуйл хаяхдаа сайн, ямар ч эмнэг мустанг сургаж чаддаг, тэгэхдээ өөрийнхөө зөрүүд занг номхруулж чаддаггүй, өвөрмөц бзүсгүй хэмээн нэрд гарчээ.

Гэвч энэ тухай дуулаад Луизагийн сэтгэл амарсангүй. харин ч хардах нь удам ширүүсчээ.

Луизкад өөртн ь ийм зан таалагдаж байв. Өөрөө ч чөлөөтэй байхыг дурладаг байв. ийм зан ааш бусдад ч таалагдахр ёстой юм шиг санагдана. Тэгэхлээр Морис Жеральд яаж зүгээр өнгөрнө аж дээ.

Бас хэд хэдэн хоног өнгөрлөө гэвч й өнөөх бугуйлч хүүхэн дахин үзэгдсэнгүй.

"Түүний шарх эдгэрч цөхрөлтгүй халамжлал хэрэггүй болж дээ гэж креол хүүхэн бодонгоо лорнетоо нүдэндээ барьж алсыг ширтэн асотей дээрээ зогсч байв. нэ бол наран амандсаны дараахан өнөөх морьтой хүүхэн ихэвчилэн үзэгддэг өглөө эрт цаг билээ. Бүсгүй урьд нь өрсөлдөгчөө гарч ирдэг байсан тэр зүг харуулдав.

Луиза санамсаргүй эсрэг зүг эргэснээ харсан зүйлдээ итгэсэнгүй хөшчих шиг боллоо. морис Жеральд морь унаад уайзын зүгээс замар ирж явав. Хэдийгээр эмээл дээрээ эмзэглэн байдалтай суугаад алгуурхан хатриуулж явсан боловч эргэлзээгүй мөн байлаа. Луиза, түүний лорнетийнхаа цаанаас харангуут л зүүн гарыг нь яиг барьж боосныг ажиглав.

Залуу Креол хүүхэн түүнийг таниад асотейн хашлаганы цаагуур нуугдаж, тэсвэрлэж үл чадан гиншлээ.

Яагаад ийм уйтгартай дуу гаргадаг билээ. Шархтай гарыг нь юмуу эсвэл цонхигор царайгнь хараад тэгэв үү? Үгүй, гайхсандаа ч юмуу өрөвдсөндөө ч юмуу дуу алдсангүй. Энэ бол шаналсан зүрхний гиншилт байлаа.

Мориын шарх эдгэрч, нигүүлсэнгүй сэтгэлт хүүхний сувилал хэрэггүй болжээ. Одоо тэрүүн дээр өөрөө очдог болжээ. Луиза, цэцэглэж байгаа ширхэгтэ цэгийрмаа дор нуугдан суугаад Морисын хөдлөх бүрийг трэр бүү хэл нүүр царайгын хувирахыг лорнетоороо ажиглан харна.

Морисыг Каса-дель-корво руу нэг бус удаа харж байгаагий нь ажиглаад Луизагийн сэтгэл жаахан уужирч, бас цаашаа явж, замын хажуугийн төглийн модны сүүдэрт зогсоод, тэдний рүү удаан ширэн харахад нь улам ч сайхан санагджээ.

Морис манайх руу харахдаа минхий тухай бодсон байх гэсэн найдлага Луизадптөржээ.

Гэвч трэр нь нар хиртэх үед гэрэл нь бүүдгэрдэг шиг агшин зуурын баяр хөөр байсан учир тэр дороо уйтгар гунигаар солигдов. Морис морио давираад зам дундуур нь гарсан өтгөн шугуй руу орчихов. Тэр хаашаа явж байгаа юм бол? мэдээж исидора Коварубио де Лос-Льянос хатагтайн өөд явж байгаа биз. Гэвч Морис нэг цагч болоогүй байтал буцаж ирсэн нь тайтгарах юм байна уу даа? тэд ойрхон шиг модон дотор зөвхөн мөчрөөр халхлагдах төдий болж багаад хартай өрсөлдөгчийн бараг нүдэн дээр уулзалдаж болноо доо.

Тэгээд Морис буцаж явах замдаа бас төглийн тэнд зогсоод, Каса-дель-Корвын зүг удтал харж

ордыг ажигласан ч түүний сэтгэлийг тайтгаруулсангүй.

Эл харц элэг доог хийсэн ч юмуу эсвэл баяртай харц байв уу? Морис баярлаж болох л юм. гэхдээ юундаа ингэж хатуу зан гаргана вэ? Исидорад үнсүүлсэн уруул нь хөрж амжаагүй байхад юундаа энд зогссон юм бол?

XXVII. Би чамд хайртай

Луиза Пойндекстер дахиад л асотей дээр гарч бас л хардлагын гашуун зовлон эдлэв. Өргөн чулуун шат түүнийг шинэ шинэ сорилыг хүлээн буй нөгөө газарж нь аваачжээ. тэр хүүхэн асотей дээр ядахнаа ойрын хэд хоног гарахгүй гэж урьд өөртөө нэг бус удаа тангаргаласан билээ. гэтэл маргааш нь л нар мандаж тал нутгийн өвс ногооны шүүдэр буухас өмнө тэр тангаргаасаа няцав.

Тэр хүүхэн урьдын адид асотей дээр зогсоод голын нөгөө эргийн зам руу ширтэж байв. Өнөөх гараа сойсон морьтой хүн бас гарч ирэхэд залуу хүүхэн бас л нуугдав.

Морьтой хүн нөгөө л замаар ярьж төрлийн тэнд зогсч түрүүчийнх шигээ ордон харш руу харж, Каса-делв-Корвын зүг удтал ширтлээ.

Залуу хүүхэн зүрх итгэл горьдлого, айх эмээхээс доглон чичрэв. луиза нуугдсан газраасаа гараад ирэхэд бэлэн байсан боловч айсан сэтгэлдээ дийлэгдээд чадсангүй. морьтой хүн удалгүй далд орчихов.

Хаашаа явчихаав?

Мэдээж Исидоратой уулзахаар явлаа! Түүнд ер эргэлзэх юм алга!

Яадаг ч аргагүй тэр учры нь одоохон олох болно. дахинд хорин минут ч болоогүй байтал тэр замаараа ирвэсийн зүстэнморь унасан өөр нэг хүн гарч ирлээ. Залуу креол хүрхний хардамтагайы сэтгэл удаан эргэлзэж зовхыг тэссэнгүй. Ямар ч шнэн зүйл тэр хүүхний сэжиглэлээсээ бол эдэдсэн зовлонгоос илүү зовлонд учруулаагүй. тэгэхээр Луиза түүний бөхөж байгаа итгэлд улам ч хор болж болох үнэнийг мэдэхээр шийдлээ.

Луиза хорин минутын өмнө Морисын орж алгаболсон ширэнгэ рүү явлаа. хуйас моддын сүүдэр зам дээр тусч чичирийлнэ. Луиза замын хажуугийн өндөр ургасан , зөөлөн ногоон дээгүүр огт чимээгүй явж байв. тэр хүүхэн мориныхоо туурайнд чулуу дайралдаж дуу чимээ гаргачих бий гэж айж явжээ. хуайс модны үслэг мөчир бүрхийх нь өдтэй зууралдана. Бүсгүй өөрийг нь ажиглачихаж нугдайх мөртлөө урьхаа гайгүй сайн ажиглаж явав.

Луиза ойр хавийн юмс ив илэн хараггдах толгодын хяр дээр гарлаа. Өндөр моддын дунд байгаа харваас баян чинээлэг айлын байшин нь исидорын авга Сильвио Мартинесын ордон мөн гэж таньжээ. Доод хөндийд өөр байшин харагдах боловч гагцхүү эл ордон, түүнийг чиглэсэн зам харгуй руу креол хүүхэн асуух мэт ширтэн харна.

Гэвч харшид ч, түүний ойр орчинд хүн лд үзэгдэнэ. Замаар ч хүн амьтан алга. нугад хэдэн морь идээшлэх авч эмээлгүй ажээ.

"хатагтай, морисыг угтаж очоо бол уу, эсхүл Морис тэднийд орсон байлгүй дээ? хэрэв модон дотор бол энэ тухай ноён Силвио мэдэж байгаа бол уу? хэрэв Морис гэрт нь зочилсон бол хүүхний авга үүнийг юу гэж үзэх бол? зр нь тэр хүн гэртээ өөрөө байгаа бол уу?"

Нэгэн морь тургиж, туурайны нь тах чулуу мөргөх чимээгээр Луизагийн бодол тасалдав. Луиза доошоо харахад морисөөдөөс нь халз чиглээд, толгодпын хэц өөд өгсөн айсуу. Хэрэв алсыг тэгтлээ ширтээгүй бол Луиза түрүүний харж болох нь байжээ. Бас л урьдах шигээ ганцаараа бөгөөд дөнгөж саяхан хэн нэ хүнээс, тэгэхдээ бүр сэтгэлтэй хүнээсээ салаад иржээ гэж үзэх ямар ч үндэс алга бөайлаа.

Нуугдья гэхэд нэгэнт хожимдсон байв. Бидэрт мустанг хуучин танилдаа хариу янцгаалаа. Бүсгүй мустангерыг байрандаа хүлээхээс өөр арга байсангүй.

-Сайн байна уу? Пойндекстер авхай. Та ганцаараа яваа юмуу? Гэж ойртононгоо хэлэв. Талд эмэгтэй нь эхэлж дуугардаггүй ёстой ажээ.

-Ганцаараа яваа. Та юунд нь гайхаав?

-Ширэнгэ ч нэг их зугаалаад баймаар газар биш л дээ. Нээрээ та ганцаараа явах дуртай гэж надад хэлсэн шүү дээ.

-Эрхэм Жеральд та ч гэсэн бас ганцаараа зугаалах дуртай шиг билээ. гэхдээ ганцаардаж байгаа нь юу л бол... Эсхүл би андуурч байна уу?

- тиймээ би хүмүүсийн дунд байхгүйн тулд ганцаараа явах дуртай. Гэвч эзэн нь зочид буудал гэж нэрлэсэн нэг цайны газар зовж суугаа минь харамсалтай. Тэндхийн маш их шуугиан надад бүү хэл, эрүүл саруулд хүнд ч хэцүү. Ийм болохоор чимээ аниргүй газар мориор салхинд гарах таатай байв. Хуайсны сэрүүн сүүдэр зөөлөн үлээх салхи үхсэн хүнийг ч босгоод ирмээр шүү.Танд ингэж санагдахгүй байна уу?

-та л илүү сайн мэднэ дээ. та дандаа үүгээр мориор зугаацан явдаг шүү дээ...

- дандаа гэн ээ? Эмээл дээр суухтайгаа болсноос хойш дөнгөж хоёр дахь удаагаа энд ирж байна... Уучлаарай Пойндекстер авхай ... намайг үүгээр явсан гэж та хаанаас мэдээ вэ?

- Өө ,би мэдэхгүй яах вэ дээ гэж нүүр улайснаа, хувцхай цайж байгаа луиза хэлээд- Би өдрийн ихэнхийг асотей дээр өнгөрөөж сурчихсан юм. Тэндээс бүх юм сайхан харагдана. цлангуа өгдөөний цагаар сэрүүн салхи сэвэлзэх, шувуудын донгодохыг чагнах тун сайхан.. тэндээс энэ зам сайн харагддаг юм. тэгээд таныг замаар явж өнгөрийг өөрөөр хэлбэл хуайсны сүүдэр дор ортол чинь хардаг юм гэж Луиза түгдрэн хэлэв.

-Тэгэхээр та намайг харсан байх нь ээ? хэмээн эвгүйрхэн зовсон Морис хэлэв. Түүний эвгүйрхэн нь Луизагийн хэлсэн сүүлчийн өгүүлбэрээс болсон бус, тэр өгүүлбэрийн утгыг ойлгосно ч үгүй. харин төглийн цаанаас харш руу ширтээн харж байснаа санажээ.

- Тиймээ харсан. Манай дэргэдүүр зам ойхрон гардаг шүү дээ. Би бас тэр замаар морь нь таныхтай адил содон биш ч угэсэн, морьтой явж байсан хатагтайг харсан. Хөөрхий нэг бяцхан гөрөөсийг сурамгай бугуйлдаж байхы нь хүртэл бахархан харсан. Эртээр таны авьяасы нь надад магтаад б айсан өнөөх залуу хүүхэн лав мөн байх гэ бодсон шүү.

- Исидора юу ?

-Исидора!

-Өө тийм! тэр чинь энд авгындааайлчилж байсан юм.

-тэгээд тэр хүүхэн эрхэм Морис Жеральд таныг их халамжилж байсан биз?

- Тиймээ, үнэхээр сахан сэтгэлтэй хүүхэн байгаа юм. Харин түүнд талархал илэрхийлэх завшаан хараахан олдоогүй л явна. Хэдийгээр надад найрсаг байдагч гэлээ тэр чинь биднийг , гадаадынхныг үзэж чаддаггүй болохоор эрхэм Обердоферын босгийг алхахыг хэзээ ч хүэсэхгүйхүн.

-Нээрэн үү? Тэгээд л хуайсны ёүүдэрт уулзахыг илүүд үздэг юм биз дээ?

-Би ер нь түүнтэй уулзалгүй удлаа. тэр хүүхэн Рио-Гранд руу гэртээ хартьчихсан учир ойрын хэдэн сард л лав уулзахгүй байхаа.

-Эрхэм Жеральд та үнэн хэлж байна уу? та түүнтэй тийм удаан уулзаагүй гэж үү дээ? ... Авгынхаасаа яувчихсан юмуу?

- Тиймээ, тэр явчихсан гэж морис гайхан хэлээд Би т??нтэй мэдээж уулзаагүй ч гэсэн зочлон иирснийг нь мэдсэн юм. Учир нь намайг хэвтэж б айхад тэр явуулсан юмнууд нв өвчтэй байхад минь тун хэрэг болсон. Обещрдоферын зочид буудлын гал тогооны газар нэг их магтахаар газар биш , эзэн нь бас надад тааруухан болохоор юм юмаар гачигдаж л байаа. Исидора авхай дээр үед миний үзүүлсэн өчүүхэн тусын хариуд өгөөмөр сайхан ач тус хүргэснийг хэлэх хэрэгтэй юм. -Та түүнд тус хүргэсэн гэнээ? Эрхэм Жеральд ямар тус хүргэснийг тагь асууж болох уу?

- Ээш бололгүй чух вэ? санамсаргүй явдал болсон юм. Исидораавхайг нгэн удаа индиачуудын зэрлэг муур болсон түүний өрөөсөн дугуй семинолуудын гараас салгаж авах завшаан надад тохиолдсон юм. Түүнийг Рио-Грандаас Леон руу ноён Сильвио авгынх руугаа байшин нь тэр харагдаж байна, явж байх зам нь тэд дайрчээ. Өөдгүй амьтад согтуу байсан юм. Амь насанд н хүрдэггүй юмаа гэхэд айхтар аюултай юм болох юм. хэрэв би тэр үед очоогүй бол тэдний гараас мултрахад хэцүүб айжээ.

- Та түүнийгээ өчүүхэн тус гэж багйаа юмуу. Эрхэм Жеральд та тун даруу хүн юм.Хэрэв би тийм байдалд орчихоод ямар нэг хүн миний төлөө ингэсэн бол...

-Та юугаар шагнах байсан бол? гэж Морис илтэд хариулав.

-Би түүнд дурлах байсан гэж Луиза түргэн хариулав.

- хэрэв тийм бол, би таныг индиан нарын гарт орсон байхы чинь үзэхийн төлөө амь насаа хагасыг зориулаад, бас үлдсэн хагасыг нь нь тэндээс таныг аврахад зориулах байсан

-Нээрэн үү, Морис Жеральдаа? Надтайбитгий тогло, Би чинь хүүхэд биш шүү. Би үнэнийг

мэдэхийг хүсч байна. Та надтай үнэн санаанаасаа ярьж байна уу?

-Тиймээ, Энэ бол үнэн, танд тангаргалая

Луиза Пойндекстер дөрөөн дээрээ босоод мустангерын мөрөн дээр гараа тавин нүүрээ ойртууллаа.

Түүний үнсэлтийн хариуд нь

-Би чамд хайртай хэмээн итгэлтэйгээр шивнэв.

XXVIII. Булаагдсан зугаа

Англи-саксоны цагаачлагчид Техаст хүрч ирснээс хойш тэр ч бүү хэл зуун жиолийн өмнө Конхквистадорийн удам суурьшиж эхэлсэн цагаас эхлээд индиан нартай харьцах харьцааны асуудал техасын оршин суунчдын хамгийн чухам зүйл болжээ.

Улс орны хууль ёсны эзэд нь индиан байсан ч гэлээ, колончлогчидтой дайны байдалтай ч юмуу, эсвэл түр эвлэрсэн алин боловчялгаагүй тэдний тухай ярилцан шуугилддаг байлаа. Дайны байдалтай байвал тулгарч байгаа аюулын тухай, түр эвлэрсэн байвал улаан арьстны удирдпагчид томагавкаа хэр зэрэг удаан булах бол гэдгийг ярилцана.

Энэ асуудлыг өглөө өдрийн турш оройн цайн дээо ер цаг ямагт газар сайгүй ярилцана. “Баавгай”, “Зэрлэг гахай”, “шилүүст” гэсэн үг тариалангийн эзний орд харшид анчны урцад я “индиан” гэдэг үгийг бодвол цөөн, тэгсэн мөртлөө гайгүй айсан маягтай хэлдэрш болжээ. индиан нараар хүүхэд айлгаж, тэр нь зөвхөн хүүхдийн нойрыг сэргээх төдийгүй, эцэг эхийн нь нойрыг хулжаажээ

Каса-дель-Корвыг цайз хэрэм шиг болгосон өндөр хилийн бүс ч суурингуудыг хамарсан сайхь айдсаас энгижруулж чадсангүй

Энэ үеийг хүртэл Пойндекстерын гэр бүлийнхэн индианчуудын тухай цуу ярйиагаар дамжсан төсөөлөлтэй байв. гэвч өдөр хоног өнгөрөх тусам улаан арьстнуудын уулгалсантухай улам олон зүйл мэдэж авч байлаа.

Тэд эл аюулыг жирийн нэг санаанаааа зохиосон зүйл биш гэдгийг үнэмүиж эхэлсэн бөгөөд хэн нэг нь эргэлзсэн хэвээр байсан бол зугаалга болсноос хойш хоёр долоо хоногийн дараа цайзын захирагчаас ирсэн мэдээ тэр аюулын үнэн бодитойг нотоллоо. Өглөө эрт, Пойндекстерын цайгаа ууж байтал цайзаас нэг морьтой элч ирж, Пойндекстцр Ямар нэг дугтуйтай бичиг өглөө. Луиза, Генри Кассий Колхаун цөмөөрөө ширээнд сууж байв.

-Гайхалтай мэдээ байна даа! гэж Пойндекстер цаасан дээгүүр нүдээ хурдан гүйлфгэж хэлээд-хэрэв үнэн бол тун өөдгүй мэдээ байна. үүнийг хошууч өөрөө үнэмшиж байгаа болохоор эргэлзэх хэрэггүй гэв.

-Ааваа, өөдгүй мэдээ гэнээ? гэж охин нь ув улайж асуув. “Хошууч юу бчисэн юм бол. Би түүнтэй өчигдөр төгөл дотор уулзсан. Намайг... түүнтэй хамт байхыг харсан. Тэр тухай бол уу? Бурхан минь , аав мэдчихвэл...!” гэж дотроо бодов.

“Команч омгийнхон дайнд б элджээ” гэж хошууч бичсэн байна гэж Пойндекстер хэллээ.

- Тэгээд л тэрүү гэж тэр мэдээн дотор ямар ч аймаар юм байхгүй байгаа юм шиг Луиза сэтгэл тайывшран асуугаад. Та биднийг айлгачихлаа. Ямар нэг айшигтай юмны тухайы мэдээлсэн юм байх гэж бодлоо гхэд нь

-Өөр айшигтай юм гэнээ? Чи юугаа донгосож байна , охин минь. Техаст дайн зэхсэн команчаас илүү аймшигтай вь байхгүй. Энэ л хамгийн их аюул даа гэв.

Луиза мултарч гаргахалд амаргүй өөр аюулын тухай бодон аавынхаа хэлсэн зөвшөөрөхгүй байж болох д юм. Зэрдэг гүүний сүрэг юм уу, цурам болсон тал дундуур гарсан бугуйлын мөрийг ч сансан байж магадгүй. юу ч хариулсангүй.

-Индиан нар манайхантай байлдах гэж байна гэж хршууч игэж байгаа ухэрэг үү? Юу гэж бичсэн байна, ахаа? Гэж Колхаун асуулаа.

- Хэд хоногийн өмнө гарсан эл цуурхалыг онц хайхраагүй гэж бичжээ. харин одоо бүргд батлагдсан байна. Семинол нарын толгойголч зэрлэг Муур гэгч , омгийнхноосоо хэлдэн хүн дагуулж өчигдөр шөнө цайзад иржээ. Команчууд Техас даяар өөрсдийгөө гацаанд будагтай эрээн мод зооцгоож, бүтэн сарын турш дайны бүжиг хийж, зарим баг нь баг нь хэдийн тулалдаанд мордсон бөгөөд Леон голын сав газар хэзээ болхээгүе ирж болох юм гэж тэдгээр хүмүүс мэдээлжээ.

- Тэр зэрлэг Муур гэдэг чинь өөрөө өөдтэй амьтан юмуу? Гэж мустангерын яриаг санасан луиза асуугаад- тэр урвагчид итгэж болно гэж үү дээ? Аль ч талаар нь бодсон тэр чинь өөрийнхөндөө дайсагнадаг шигээ цагаан арьтныг үзэж чаддаггүй юм гэлээ.

- Охин минь, чиний хэлдэгзөв. хошууч ч бас жичдээ түүний зан чанарыг яг тэгж тодорхойлосон байна. тэгээд өөрт нь ашигтай санагдвал команч нарын талд урваад очи ж мэдэх тэр хоёр нүүртнээс болгоомжилж байхыг зөвлөсөн байна гэж эзэн цаасаа хажуу тийш тавьж, аягатай кафенаасаа балгангуут хэлээд - за яахав , бид энд команч бай, семинол ч бай, ямар ч улаан арьтсныг үзэхгүй гэж итгэе. Команчууд дайтаар мордлоо гэхэд Каса-дель-Корвын ханы өмнө тулгараад , манай орд харшийг үймүүлж зүрхлэхгүй гэж бид найдаж болно гэв.

Энэ үед тэдний өглөөнийхөө цайг уугаад сууцгааж байсан хоолны өрөөний үүдээр хөтөч негрийн царай цухалзаад яриа өөр юм руу шилжлээ.

-Плутон, чи юу гэж явна? Гэж эзэн асуув.

- Вудли гуай надад юу ч эрэггүй. зүгээр л шагайсан юм. луиза авхайд бидэрт морий нь эмээлчихээд бана, цайгаа түргэн уугаач гэдгийг л хэлэхр гэсэн юм. Бидэрт мустанг хашаан дотор , чулуун шалан дээр үзогсохыг таалахгүй, тал газрын зүлэг ногоо руу тэмүүлээд байна.

-Чи зугаацахаар явах нь уу, Луиза? Гэж эзэн илэрхий дургүйцсэн байдалтай асуув.

- Тиймээ ааваа, Би жаахан даьхих гэсэн юм.

-Чи явж хэрэггүй !

-Үгүй ер өө!

Би чамайг ганцаарангий чинь явуулах дургүй байна. Тохриомжгүй хэрэг. Намайг ойлгооч.

- Яагаад тэгж бодоо вэ, ааваа? Би дандаа ганцаараа явдаг шүү.

-Тиймээ ганцаараа олон удаа явсан чинь харамсалтай байна.

Пойндекстерын сүүлийн үг чухам юу гэх гэсний нь Луиза нарийн ойлгоогүй ч царай нь үл мэдэг улайв.

Шэвч Луиза мэдэж авья гэж оролдсонгүй. Харин чэнэ яриаг орхихыг хүсэн.

- Ааваа, хэрэв таныг дургүйцэж байгаа бол би дахиж явахгүй Эрчүүл та нар ажил хэргээ яваад намайг энэ байшинд түгжин суулгах гэж шийдээ юу? техаст би ийм маягаар л амьдрах юм биз дээ?

- Луиза чи намайг ойлгосонгүй. Ер нь би чамайг огт гаргахгүй гэсэн юм биү, дураараа л зугаац. Харин хүн дагуулц явж бай. Генри юмуу, эсхүл Колхаунтай яв. Чамайг зөвхөн ганцаараа явахыг л хорьж байна. ганцаарангий чинь явуулахгүй байх шалтгаан байна.

-Шалтгаан байна гэнээ? Ямар ?

Луиза өөрийн эрхгүй ингэж асуучихав. Тэгээд сүүлдээ бие барьж чадсангүйдээ харамсаж, сэтгэл түгшин хариу хэлэв. Тэгээд хариуг нь сонсоод жаахан уужирчээ.

- Чи ямар шалтгааны улмаас мэдэх гэсэн юм бэ? Юуны өмнө хошуучийн энэ захидал байна. техас бол бүсгүй хүн өөрийг нь доромжилж, дээрэмдэнэ гэж айхгүйгээр дуртай зүгээ тайван явж болдог Луизагын биш гэдгийг битгий мартаарай. энэ Техаст алхам бүр аюултай. Адаглаад л индианчууд ...

- Индианчуудаас айх юмгүй. Би ордноос гадагш таван бээрээс илүү хол явах ч үгүй.

-таван бээр гэнээ? гэж Колхаун егөөтэй хэлээд Энэ чинь тавин бээр явна угэсэн үүг. Чи гэрийнхээ босгоноос зуу алхахдаа л зуун бээр байгаа юм шиг индианчуудтай амархаан дайралдчихаж болно. Тэд дайнд мордсон байхад газар сайгүй цаг ямагт дайралдана. Вудли ахын зөв гэж бодож байна. ганцаараа явна гэдэг тун ч бодлоггүй хэрэг.

Өө, чи тэгж бодож байна уу? гэж креол хүүхэн, үеэл ах руугөө жигшэн маягтай харж хэлээд хэрэв би команчуудтай үнэхээр дайралдчихдаг юм гэхэд ноён та надад ямар тус болох юм бэ, хэл л дээ гайгүй? хэдийгээр би тэдэнтэй дайралдана гэдэгт итгэхгүй байгаа ч гэсмэн хэлчих... тэр будаж шунхадсан зэрлэг омгийнхон дун бид хоёулаа орчихсон байбал мөн их сонин харагдана аа даа! ха,ха! Чи л аюулд учрахаас би учрахгүй. Би чамайг дайсны дунд орчихоод аюу гэдэг чинь энэ дээ! лунагаа унаад явж байхад намайг хөөгөөд гүйцэх тийм морьтой хүнийг зэрлэгүүдийг оролцуулаад ь Техасаас олохгүй! Чи арай чадахгүй байхаа Каш минь!

- Дуугүй бай Луиза! Гэж Пойндекстер зандраад Чиний ингэж чалчихыг би таалахгүй байна. Кассий чи наадхиа битгий анзаар. Энэ фнутагт чинь индианчуудаас гадна элдэв муусайн юм зөндпөөн. тэднээс ч бас айх хэрэгтэй. Би чамайг урьдынхтайгаа чинь адил тэгж хол явахыг хориглолоо гэдгийг санаарай гэв.

- За, ааваа таныхаар болдог гэж Луизасуудлаасаа босонгоо дуулгавартайяа хэлээд- Би танд захирагдах ёстой. Харин хөдлөхгүй суугаад байвал эрүүлд мэндэд минь хортой гэж мэдээрэй гэж хэлээд үүднийхээ тэнд инээмсэглэсээр зогсч байгаа негр рүү хандаж-Плутон чи очоод лунаг тавьчих, дуртай тийшээгээ явчихаг. Хэрэв тэрүүнд таалагдвал өөрийнхөө нутаг руу давхиг гэв.

Ингэж хэлээд бүсгүй тасалгаанаас толгйо дээгүүр гарч, ширээнд суугаа хоёр хэлсэн үгнийхээ нь учрыг бодох зав гарган одлоо.

Гэвч энэ түүний сүүлчийн үг биш байлаа. гудмаар өрөө рүүгээ явангаа ямар ч тодорхой хариу өгч боломгүй хэд хэдэн асуултыг шивэгнэн явав.

-Аав юу мэдсэн байж блдлх вэ? зөвхөн сэжиглэж байга нь энэ үү? Түүнд хэн хэлсэн байх вэ? Бид хоёрынг уулзсаныг аав мэдээ бол уу?

XXIX. Талын чоно үүрэндээ

Колхаун бараг Луиза шиг гэнэт боссон боловч түүнээс ялгаатай нь өрөөндөө оролгүй байшингаас гарлаа. Үтэр шархандаа шаналсаар байгаа боловч бие нь овоо сайжирсан учир морины саравч, хашаанд хүрдэг болжээ.

Гэвч энэ удаа нэлээд хол явчихжээ. түүрүүчийн яриа юмуу, эсвэл өнөөх мэдээнээс болсон юмуу вутай ч гэсэн бие сулаа хайхралгүй Инж цайз руу таягаа тулаад зүглэлээ.

Колхаун догонцон байж ордон цайз хоёрын дунд байдаг гэндмал нүцгэн газрыг өнгөрөөд өндөр өндөр моддын сүүдэр дор ургасан намхан хуайсан шугуйд хүрэв. Зөвхөн зүүн өмнөд техасынхан байдаг бургасаар сүлжиж шавардсан нэг урц хамгийн балар ногоон сүлжиж шавардсан нэг урц хамгийн балар ногоон шугуй дотор байдаг ажээ. Энэ бол мустангер мигуэль Диаз гэдэг мексик хүний урц юм. тэр урц “талын чоно” гэсэн нэрэндээ зохисон харгис, хагас зэрлэг эзэндээ яг дүйжээ.

Мигуэль Диаз буюу Талын Чоно гэгчийг олиггүй нэртэй үүрэндээ байхад нв тэр бүр дайралдана гэдэг амаргүй хэрэг. Энэ үүр бол түүний хоноглодог түр зуурын байр юм. тэр хааяа ан авд олз омогтой явсныхаа дараа бүдүүлэг зугаа цэнгэл эргүүлж суурины хавиар байзнадаг бөгөөд бусад цагаа тал нутгаар тэнэж өнгөрүүлдэг ажээ.

Колхауны аз болж Талын Чоно гэртээ согтуурхан байж байв. Согтуу хөлчүү б айх нь түүний ердийн үзэгдэл. Үнэндээ мексик эр сайтар унтаж авчан учир согтуу нь жаахан гарч ухаантайгаа байлаа.

Талын Чоно зочин орж ирэхийг хараад.

-Өө, ноёнтон ! Ямар хувь заяагаараа хүрээл ирчихэв? Таныг энд ирнэ гэж огт сансангүй шүү! тэр сандлыг аваад суу. сандал ч гэж дээ? ха-ха-ха! гэв.

Сандал гэж нэрлэсэн тэр юм руу хараад инээсэн нь энэ ажээ. тэр нь сандлын үүрэг гүйцэтгэдэг ерийн мустангерийн гавал байв. Энэ ядуу урцын тавил төхөөрөмж гэвэл: ширхэгт цэгийрмаагийн булцруугаар эв ургүй хийсэн ширээ, гэрийн эзний ор болгон хэрэглэхдэг бөгөөд зэгч төдийхөн ажээ. хол яьсандаа ядарсан Колхаун урцын эзний урцын эзний урилгыг хүлээн авч мустангерын гадал дээр суулаа. тэгээд цаг гарздахгүй тул шуудл зорьсон хэргээ ярьж эхэллээ.

-Эрхэм диасээ, миний энд ирсэн хэрэг бол... гэтэл,

- Эрхэм америк гэж халмаг анчин дуу алдаад Илүү яриагаар яах вэ? Карамба юу гэж ирсний чинь би сайн мэдэж байна. Өнөөх ирланд чөтгөрийг надаар ниргүүлэхгээл билүү гэв.

-Тэгээд!

- Тэгээд таван зуун доллар өгвөл чинь ахныгээ таарахад л нидэрчихнэ. Гэж танд ал хэзээний амласан шүү дээ. мигуэль Диас хэлсэн үгэндээ заавал хүртдэг юм. гэвч аятайхан,

эгзэг нь таарч өгөхгүй байна. Хожимдоогүй л дээ. Чөтгөр аваг! Хү алахад чинь бас дүй хэрэгтэй юм шүү. Энэ эзгүй хээр тал нутагт хүртэл ул мөрийг нь олчихдог вч. Ул мөрүлдээгээд мэдэгдвчихвэл надад тоглооёс биш юм болно. та намайг мексик хүн гэдгийг мараад байна аа даа. хэрэв би тантай адил герман байсансан бол түүнийг няхчихээд амархан. Хараалд хүрмэр! Гэтэл мексикүүдийн хувьд бол өөр хууль бий. хэрэв бидний хэн нэг нь хүний зүрхэнд хутгаа зоочихвол хүн алсанд тооцно. Тэгсний дараа америкёууд та нар намайг хүн аллаа гэж арван хоёр “шудрага” шүүгчтэй шүүхээр шүүлгэж “дүүжилж алсугай” гэсэн тогтоол гаргана. Карамба! Энэ надад тохирохгүй. Би тэр ирландыг , тантай адил үзэн яддаг, гэвч дүүжлүүрийн гогцоонд хүзүүгээ углуулахыг хүсэхгүй байна. Би цаг нь ирээд боломжтой учрал гарахыг хүлээх ёстой :. Чөтбгөр аваг, цагш боломж гараг!

-Одоо л ёстой хөдөлдөг цаг ирсэн дээ гэж Колхаун мексик рүү тонгойж хэлээд - индиан нартай харгалдаж эхэлмэгц л түүнийг цааш харуулчихад амархан гэж та хэлсэн шүү дээ гэж Колхаун яаран хэлэв.

- Тиймээ, би тэгж хэлсэн. Тэгэлд тийм юм болдог юм бол ч..

-Та чинь шинэ сонин сонсоогүй байгаа хэрэг үү?

-Ямар сонин?

-Команчууд дайтаар мордсон шүү дээ!

- Чөтгөр аваг, гэж хэлээд талын Чоно зэгсэн хэвүтэр дээрээс олзны үнэр авсан чбоно мэт шаламгай босон харайж -Дар эх минь ! нээрээ үнэн гэж үү, эрхмээ ? гэв.

-Бүр цайзын даргаас өөрөөс нь лавтай мэдээ авсан.

-тэгвэл ... гэж мескик хүн бодол болсноо- тэгвэл ноён Морис үхэж болно. Түүнийг команчууд алчихаж болно шүү дээ. ха-ха-ха! гэв.

-та үүнд итгэж байна уу?

-Түүний гавлыг нээсн й төлөө таван зуугийн оронд мянган доллар өгвөл бүр ч яриа байхгүй болно.

- Тэр ийм үнэд хүрнэ.

-Ямар үнэд?

-Мянган долларт

-Та амлаж байна уу?

- Ноён ахмад минь, тэгвэл команчууд түүний хуйхыг хуулна. та Каса- дельКорвотоо очоод санаа амар сууж бай. нэг л эгзэг нь таарвал дайсан чинь үсгүй хусагдана гэж мэд. Та миний хэлж байгааг ойлгож байна уу?

- тиймээ, ойголж байна.

-тэгэхээр одоо мянган доллараа бэлтгээрэй.

-таныг хэзээ авах бол гэж хүлээжбайна.

-Карамба! Би тэрний чинь авна даа!... Баяртай, баяртай,

- Гэгээн дар эх минь, гэж мескик хүн Колхауныг далд ормогц хэлээд- за яамай! Тэртэй тэргүй алах гэж байсан хүнээ няхчихаад мянган доллар авна даа! Команчууд дайтаар мордох гэж байдаг! Карамба!энэ үнэн гэж үү? Хэрэв тийм бол би ч гэсэн энэбагт наадамд зориулсан хувцас бэлтгэх хэрэгтэй. индианчуудтай эвлэрсэнээс хойш гурван жил хэрэглээгүй хэвтэж байгаа хуцвас юм даг. Пайнд зэхсэн индианчууд мандтугай! Миний наадам амжилтаар дуусах болтугай!

XXX. Агаарын шуудан

Луиза Пойндекстер эрэтгэй хүний гэж тооцогддог спортын янз бүрийн төрлийг сонирходгийн учир мэдээж нум сумыг орхисонгүй. Тэр хүүхэн нум сумаар гайхамшигтай сайн харвана.

Анх индианы юмаа омгоос суралцсан агаад эрт дээр цагт хүчирхгээрээ гайхагдаж асан эл омгийн сүүлчийн хэдэн хүнийг Миссип мөрний сав, Атчафалын булан Пойнт Купегийн ойролцоо газраар одоо ч гэсэн үзэж болно.

Тэгээд Техаст ирэхлээ Луизанаас нум сумаа авчирсан боловч хөвчилсөн ч үгүй, хэвтэж байгаа жээ. Нум сумаараа дасгал хийхц аг ч гарсангүй. Жүржийн модоор хийсэн сайхан нум, өд хатгасан сум хочр нь агуулахад дэмий хэвтэж б айдаг болов.

Гэвч тэр хоёрыг санах цаг иржээ. энэ бол Луизаг ганцаарангий нь явуулахгүй гэж аав нь зарлиг буулгасан өглөөний цайнаас хойшхи хэрэг юм. Тэр хүүхэн эцгийнхээ хэлсэн үгийг үг дуугүй дагаж ганцаараа явахаа больсноор барахгүй мориор зугаалахаас хүртэл татгалзжээ.

Бидэрт мустанг морины саравчинд хөштөлөө зогссон эмвэл бэлчээрийн хашаан дундуур давхин өөрийг нь чөлөөтэй биш гэдгийг мэдрүүлдэг ганц зүйл болсон эмээлийг яагаад нуруунд нь тохохгүй байна гэж гайхах мэт.

Луиза хайртай морио мартсангүй. Түүнийг унахаа байсан ч гэсэн байнбайн эргэж, хоол тэжээлийг нь сайн байлгаж байгаа эсэхийг шалгаж байв. Түүнийг хамгийн сайн тариа-өвсөөр хооллон, Леон голын цэнгэг усаар ундаалдаг. Дплутон гараа гарган арчилна. Сам сойзоор ундаалдаг хар царайнаас дутахгүйгээр гялалзтал нь сойздоно.

Луиза морь унахаа байснаас хойш нум сумаар оролдож хамаг цагаа энэ спортод зориулдаг болжээ.

Дасгал хийдэг газар нь ширэнгэтэй залгаа цэцэрлэг болж байлаа. гурван талаас нь шол тах шиг хааж, үлдсэн нэг талы нь шилгээний хана хаажээ. Цэцэрлэг их дээр үеийнх болохыг тэнд ургасан аварга мод төдийгүй түүнийг чимэглэн байгаа хагарчан цав гарсан баримлууд гэрчилнэ. Тэдгээр нь испанийн уран гартны урласан эрт дээр цагийн баатруудын баримал байлаа. Энэ ацугаа Кондэ, Кампеадор Америкийг нээсэн суут далайя, хоёр нэрт конквистадор Кортес, Писсаро болон гоо сайхан, сэтгэлт хүндээ эргэлт буцалтгүй үнэнчээрээ алдаршсан индиан бүсгүй Малинче нарын баримлыг үзэж болно.

Хэдийгээр Луиза, маличнийн баримлын өмнө шоо сайхын шагшран зогсох нь олонтаа боловч эдгээр чулуун баримлын дунд нум сум харвах дасгалаа хйдэггү ажээ. залуу инпиан хүүхнийг испанийн цэргийн жанжинд дурлалаа гэж Луиза сэтгэлийнхээ угт т малинчийг буруушаах үндэсмгүй гэдгээ мэдэрдэг байв. Өөрөө орчлонгийн бүх юмсыг умартсан, хэдийвээр түүний үзэж буйгаар алдар нэрээр хэнээс ч дутамгүй авч, Кортестай адидхан цууд гараагүй хүнд зүрх сэтгэлээ өгячихсөн хүн чинь аргагүй юм.

Луика баримлуудын дунд ийм сумаар дасгад хийж байсангүй. тэр нь глоын нугачааг даган

эрэг, цэцэрлэг хоёрын пунд хагас дугуй төрөл болон ургсан том том моддын сүүдэр дор ороод явчихдаг байлаа.

Энд нь байгаль өөрөө хэдэн зууны өмнө тарьсан хуш, ялма, шид мод ургасан байх агаад цэцэрлэгт түүнийг тэр чигээр нь үлдээжээ.

Креол бүсгүй сайхь, аварга моддын ногоон хүнхэр дор суух юмуу, хажуугаар нь дөлгөөхөн урсгах голын эргийг даган явах дуртай байв.

Энд Луиза гав ганцаараа байж болох бөгөөд сүүлийн үед улам илүү бөглүү газар эрдэг болжээ. Эцэг нь хамгийн ширүүн зан авиртай байхдаа хүртэл охиноо тэгж гэм зэмгүй зугаалахыг хориглж чадахгүй байлаа. Каса-дель- Корвын өндөр хана хэрэм, өргөн гүнзгий Леон гол хоёр Луизагийн найдьартайы халхавч болно гэж бодоод Пойндекстер сэтгэл тайван байв. Луизаг тэгж аглаг буйд газар ганцаараа зугаалахыг хориглох байтугай баярладаг байлаа. Өнөөх шалтгаангүй бус байсан сэжиг таавар нь ч тэр дорхиноо замхарчээ.

Эцсийн эцэст энэ нь жирийн нэг ховяриа байсан байж болох юм. Эзэн ч өөрөө хов живийн золиос болсон байхад үгүй гэх газаргүй. түүний охин морис мустангертай уулзсан нь жирийн нэг тохиолдол байлгүй. тэд төгөл дотор нь санамсаргүй дайралдахыг хэн байг гэх вэ! тэгээл Луиза хоёр дахиж аминлаа орсон хүний хажуугаар зүгээр явж өнгөрвөл ямар олиг байх билээ. ингээд л жирийн нэг талархалаа дахин илэрхийлэхээс өөр ювмгүй биз.

Охин нь морь унаж зугаалахаасаа тийм амархан татгалзсан нь энэ бодлыг нь баталжээ. Юманд тийм ч амархан бууж өгдөггүйг нь бодоход морь унаж явах нь түүнд тийм ч их эрхэмлэх зүйл биү байсныг хэлээд өгчээ.

Охиныхоо зөрүүд занг өөрөөр ойлгох амархан байсан хайрт эцэг ингэж тунгаан боджээ. хэрэв тэд өөр оронд ч юмуу өөр хүрээд хамаарагддаг байсан бол охиноосоо шууд асуугаад , шуудхан хариул гэж шаардах байсан байж магадгүй. Гэвч Миссип ийм юм байхгүй. Тэнд арван тав ч хүрээгүй хүү ч юмуу охин зэвүү нь хүрч, худлаа хардсан байцаалт гэж үзэхбайлаа.

Вудли Пойндекстер охиныхоо дуулгавартайд арай ядан найддаг байв. Сүүлийн жилүүдэд охин нь улам ч үзэсгэлэнтэй болж элдэв магтаал сайшаалыг хүлээдэш болжээ. Энэ нь ихэнхдээ хүнийг эвддэг шүү дээ. хэдийгээр эцэг нь хууль ёсоор түүний толгойг мэдэх эрхтэй ч энэ эрхт нь нэрнээс цаашгүй гэдгийг сайн ойлгодог. Ийм учраас охиныхоо дуулгавартай байгаад сэтгэл хангалуун байж талаар хий дэмий даьхихын орондп цэцэрлэгт зугаалан гай нь дайрахад хажуугаар нь өнгөрөх шувуудыг харван зугаагаа гаргаж байгаа нь баярлаж байлаа.

Тавь хүрсэн хүн байж та яагаад ингэж гэнэхнээр бодно вэ? Та өөрийнхөө залуу насыг , яаж хүсч мөрөөддөг байснаа, амьдралд тань хамгийн ариун хайр сэтгэл байсан байж мэдэх тэр юмаа нууж , хэнэггүй царайлан явснаа мартчихлаа гэж үү дээ!

Гэвч үзэсгэлэнт Луизагийн эцэг санаж дурсах юм байсан ч гэсэн юуг ч

санахгүй юм шиг байв. Өөрийг нь бүхнийг мартчихжээ. тэгээгүйсэн бол охиныхоо араас нууцаар цэцэрлэгт даган очиж голын эрэгээр хүрээлэгдсэн төгөлд чухам юу хийж байгааг нь

харах байлаа. тэгсэн бол луиза охин нь гаднах дээрээ харагддаг шигээ тийм ширүүн, догшин биш гэдгийг мэдэх байв. тэрээр хажуухнаар нтв итгэмтгийгээр эргэлдэх шувууд руу нум сумаа шагайсангүй. Зэвэнд нь хэсэгхэн цаас уясан сумаараа шувуу харвах гэж тэр хөвчөө татсангүй , харин эргийн нөгөө талын төгөл рүү сумаа тавина.

Үүнээс ч сонин юмын бас харж болох байв. хэсэгш хугацаа өнгөрсний дараа нөгөө сум нь илгээсэн газарт дургуйцсэн мэт эргэн бүсгүй руу буцаж ирнэ. Тэгэхдээ зэвэнд нөгөө хэсэгхэн цаас ч юмуу эсвэл түүнтэй адилхан хэсэгхэн цаастай ирнэ.

Гаднаас нь харсан хүнд бол энэ нь хачин жигтэйгээр барахгүй бүр ид шидийн юм шиг санагдаж болох байлаа.Гэвч гадны хүн үгүй учир, гайхаад байх юм юу ч байсангүй. ганц сумыг ээлжлэн нэг нэгэндээ харван тоглож байгаа хоёрхон хүнд л бүх юм ойлгомжтой байв.

Хайр сэтгэл саад хоригийг шоолон элэглэж байгаа нь энэ. Уулзаж учрах боломжоо алдсан Морис, Луиза хоёр эл агаарын шууданг бодож олжээ.

XXXI. Амжилттай гатлав

Агаарын шуудангаар удаан харилцсангүй. Ер нь дурлалцсан хоёр хүн сум нисаэх зайд байж, и зурвас төдийхнөөр ханаж болно гэж үү дээ! Дурлалцсан зүрх хамт байж шатан цохилж байх ёстой билээ.

Морис Жеральд Луиза хоёр хагацахыг цааүид тэсвэрлэж чадсангүй. эцэст нь тэд нарын найдваргүй гэрлийн лор чимээ аниргүй цөнийн цагаар уулздаг болжээ. зөвхөн одод л тэдний зууцыг дуугай гаэрч болжээ. Цэцэрлэгийн хажжуугийн цэуэрлэгт хоёр удаа учран, оддын жирвэлзэн туяаны дор хоёр ч удаа дурлалын тангаргаа өргөлцөөд , гурав дахь болзоогоо хийсэн байжээ.

Харин охиноороо ихэд их бах болгодог эцэг нь охин нь өөрийг нь тийм сүрхий хуурч байгааг ажиг авсангүй. газар дээрх ганц охин нь гоо үзэсгэлэнтэй ыардам сэхүү, билэг авьяастай , хэнээс ч дутамгүй хадамд гарч чадах байсан охин нь жирийн нэг морины ангуучинд дурлаж байдаг! Хэрэв ингэж зүүдэнд нь үзэгдэх юм бол галав юүлэхийг зарласан бүрээн дуу сонссон мэт, зөөлөн орноосоо босон харайж байсан бизээ. гэв тэр одоохондоо ямар ч сэжиггүй байв. Энэ бол дэндүү байж боломгүй муухай юм болж таарах байлаа. Хэрэв ийм санаа толгойд нь ордог юм бол утгагүй , дэмий юм шиг санагдах болно.

Охин нь түүний хориглосныг үг дуугүй дагаж үгэнд нь орсонд ихэд сэтгэл ханамжтай байв. үнэндээ охин нь түүний хүссэнийг яв цав биелүүлж талд зугаалахыг бүрмөсөн татгалзахгүй, дүүтэйгээ юмуу, эсвэл үеэл ахтайгаа мориор явдагсан бол улам ч баярлах байжээ.

Охин нь одоо болтол үүнийг зөвшөөрөөгүй агаад эцэг нь нэг их тулгасангүй. Эцэг нь охиныхоо зөрүүдлснийг дуртай дагажээ. ер нь луиза гэртээ байна гэдэг, шинээр ямар ч хов уив гарахгүй гэсэн үг. Охиныхоо тэгж үгэнд оромтгой байгаад тхэд уярахн хэрэг ч үгүй хориглоов уу даа гэж халагдахад бараг хүрчээ. тэгээд тайвширсандаа болоод хориглохоо больдог ч юм билүү гэж бодож байв.

Сартай шөнө байлаа. зөвхөн өмнө зүгийн шөнө л ийм байдаг. Эрдэнийн индранил чулуу шиг өнгөтэй шөнийн огторгуйд тэргэ мөнгөн сар хөвөлзөн, аврага том уулс цэлмэг агаарт гар сунгахад хүрчихэм гэлтэй тодхон дүнхийнэ. Салхи намжин халуун орны моддын навчис хөдөлгөөнгүй болжэ ан амьтан, хорхой шувууны найрал дууг чагнах мэт чимээгүй ажээ.

Энэ бол байгалийн нуцлаг хүчээр зүрхийг тань эзэмшсэн ганц хайрттайгаа хоёулахнаа зугаалмаар санагддаг гоолиг цагаан гараа хүзүүгээр тэврэн, сарны нууцлаг гэрэлд бүхнээс энхрий сэтгэл догдлуулсан харцаар энхрий нүд өөр лүү тань ширтээстэй... гэж мөрөөсөн байдаг тийм нэгэн орой байлаа.

Явагн цэргийн бөмбөр, морин цэргийн бүрээ, Инж цайзын гарнизон унтсаныг хэдийнээ мэдэгдсэн үе байлаа.

товчоор хэлбэл Обердофцрын буудлын хаалгаар нэг хорьтон хүн гарч ирэхэд аоль хэдийнээ

шөнө дунд болж байсан бөгөөд леон голын хажуугаар гарсан үямаар орж сууринг ардаа орхив. Дээр хэлсэнчлэ, эл замаар Каса”дель- Корвогийн хажуугаар голын нөгөөэргээр өнгөрч, мөн тал дахь өнячин төглийг огтлон гарчээ.

оршин суугчид нь ойн аралхан гэж нэрлэдэг энэ бөөн молд дөнгөж саяхан суурингаас гарсан морьтны явж байгаа зам даар байв.

Төгөлд хүрч очоод морьтон моринооёо үсрэн бууж, морио модноос уялаа. тэгээд адууны хялгасаар томж хийсэн урт аргамж ганзагнаасаа тайлж аваад цагариглуулан эвхэж, бугуйндаа углачихаад голын зүш сэмхэн явлаа.

Тэр хүн моддын харанхауй сүүдэр дороос гарахынхаа өмнө тэнгэр өөд, гэрлээ тодхон цацруулсан буй сарны зүг анхааралтай ширтэн харлаа. Харцанд нь нэг л түшгсэн шинж илэрхий. “Энэ саран гуа далд орохы нь хүлээж энд байхф хэрэг алга. Өглөө болтол энд мэлтийн байхаар шийдсэн бололтой” гэж тэр хүн санаа зовон үглэв.

Тэгээд тэндээс голын эрэг хүрэх ил задгай газрыг нүдээрээ хэмжиж үзэв. Каса-дель-Корво үйлтгээн голын цаад эрэгт бүртийн байна.

- Хэрэв тэнд хэн нэг хүн унтаагүй байвал яана? ийм орой болсон арай ч үгүй биз дээ мэдээжээр хэн нэгэн хүн хар муу санасан бол... Тиймээ! Тэнд тийм хар санаатай хүн бий! Хэрэв тэр хүн сэрүүн байгаа ыбол намайг заавал харна. Энэ мааньв ганцхан надад хамаатай бол огтхон ч айх юм алга. сар орохыг хүлээвэл хэдэн цаг болно. тэнгэрт өас бүртийх ч үүлгүй байдаг. Луизаг хүлээгээд байж чадахгүй нв Юу ч болдог байлаа гэсэн өөро арга алга.

Өнөөх хүн ингэж хэлээд голын тийш, задгай газраар болгоомжтой хурдан алхалж, тэр дорхиноо Леон голын өндөрт эрэгт хүрч очлоо. тэгээд өөрт нь хэзээний танил бололтой мухиралдсан зөргөөр бууж голын захал бүр тулж очлоо. Яг тэр харалдаа, нөгөө эрэгт асар том улиангарын сүүдэр дохр нэг бяцхан завь усан дээр хөвөлзсөн байв. тэр хүн голын нөгөө эргийн төгөлд хүн байгаа юм бүү биз гэсэн маягтай хэсэг зуур анхааралтай ажиглан харлаа.

Шугуйд хэн ч байхгүй гэдэгт итгэмэгц бугуйлаа авч хэд даллаадголын усан дээгүүр маш чадварлага шидэв.

Бугуйлын гогцоот үзүүр завины хошуун дээр буулаа. тэгээд бугуйлаа атаж завийг чирч авчираад түүн дээр үсрэн гармагц ёроолд нь байсан сэлүүрээр сэлүүрдэн түрүүчийн байсан газар нь очлоо.

Эрэг дээрээ гармагц кавийг усанд авахуулчихгүйн тулд эргийн элсэн дээр татаж гаргав. Тэгээд Кас-дель-Корвогийн шөнийн зочин, улиангарын сүүдэрт орлоо. тэрээр ямар нэг болзсон дохио ч юмуу, эсвэл урьд нь уулзахаар ярьж тохиролцсон хүнээ ирэхийг хүлээж байгаа ыололтой. Хэн нэгэн хүн түүнийг яг энэ үед харсан бол шилгээнийг цөлмөхөөр ирсэн хулгайч гэж бүрнээ бодож болохоор байлаа. гэвч түүний аяарханаар шивэгнэж байгааг сонсох аваас худлаа хардсанаа бас ойлгох байлаа. Үнэндээ ч тэрээр шилгээний хананы цаана буй эрдэнийг мөрөөдөж байв. гэхдээ тэр нь мөнгө зоос, үнэт эдлэл, өв хөрөнгийн аль ч биш, харин гэрийн эзэгтэй байжээ. морио төгөлд арагмжчихаад, голыг тийм амжилттайгаар

гатагсан энэ хүн маань Морис- мустангер байсныг тайлбарлах хэрэг юун билээ.

XXXII. Гэрэл сүүдэр хоёр

Морис улиангарын сүүдэр дор удаан хүлээмэнгүй. түүнийг завин дотор үсрэн суух тэр агшинд шилгээний цэцэрлэг рүү харсан нэгэн уонх нээгдэн хэн нэгэн хүн түүгээр гарах гэснээ түдгэлзэв бололтой ажиглан зогсох мэт болов.

Нээлттэй цонхны жаазнаас барьсан үнэт бөгжтэй жижигхэн цагаан гарыг сарны гэрэлд харж болох байв.

Хэдэн минутын дараа бүсгүй хүний гоолигхон дшрс цэцэрлэг рүү орсон шатаарбууж явлаа.

Энэ бол луиза Пойндекмтер байв.

Бүсгэй хэдэн хором зогсож чимээ чагнав. Сэлүүр дуугарч байна уу даа? Эсвэл тэгж санагдав уу? Жирхэрэйнүүд агаарт эцэж цуцуахгүй дэвхрэлдэн жиргэж байхад андуурсан ч байж болно. Болзоот цаг болсон тул бүсгүй илүү хүлэж тэвчсэнгүй.

Луиза чулуун шатаар сэмэxn бууж, цэцэрлэг ороод, бут сөөгөнд дундуур чимээ гаргалгүй өнгөрч гантиг чулуунг хөшөөний хажуугаар гаран улиангарын дэргэд хүрч очив. Энд түүнийг Мустангер угтаж энхрийлэн тэвэрлээ. Жаргалтай хором амархан өнгөрх бөгөөд нэг мэдэхэд л хагацах болчихсон байдаг билээ

-Хайрт минь, бас маргааг шөнө хоёулаа уулзана биз?

-Хэрэв би чаддаг л юм бол маргаач нөгөөдөрч үр нь өдөр бүр уулзалгүй чахав хайрт минь!

- Яагаад уулзаж чадахгүй байх билээ. Чи яагаад уулзъя гэж хэлж болдоггүй юм бэ?

- Би маргааш үүгээр Аламо руу явах хэрэгтэй боллоо.

-Өө, тийм үү? Заавал явах хэрэгтэй юмуу?

Эсэ асуулт өөрийн эрхгүй, зэмлэл шиг сонсогдлоо. тэр хүүхэн Аламод байдаг бөглүү овоохойны тухай санах бүрт ямар нэг тааламжгүй сэтгэгдэл төрдөг байжээ. Яагаад гэдгийг луиза өөрөөч мэддэггүй байв.

- Би тийшээ явах чухалхэрэгтэй.

-Чухам хээрэгтэй гэнээ? тэнд ямар нэг хн чамайгш хүлээж байгаа юм уу?

- Тэнд миний зарц Фелимээс минь өөр хэн ч байхгүй. Түүнд ямар нэг юм учраагүй тайван байж байгаа гэж бодож байна. Би түүнийг индиан нарын тухай яриа гарахаас арваад хоногийн өмнө тийш нь явуулчихсан юм.

-Зөвхөн Фелимээсөөр хэн ч байхгүй нэнээ? Чи үнэн хэлж байна уу Морисоо? Хонгор минь

намайгаа л битгий маллаарай даа

Түүнээс өөр хүн байхгүй гэж хэлсэн биз дээ?

-Луиза чи энэ тухай яагаад асуугаад байна?

-Яагаад гэдгээ би чамд хэлж чадахгүй байна.

Хэрэв миний толгойд хааяа орж ирдэг юмаа чамд хэлчихвэлби ичиж үхнэ.

-Юу бодож байгаагаа надаас айлгүй цөмий нь хэл. Би чамаас юу ч нууж ё чадахгүй шүү дээ. За хэл л дээ хонгор минь!

-Морис чи хэлүүлэх дуртай байна уу?

- Мэдээж хэлүүлмээр байна. Чиний рэгэлзэж байгаа юм бүхнийг тайлж өгөхөд бэлэн байна. хэрэв чиний тухай иусгүй яриа гарна. тэгэхлээр би Аламо руу явах хэрэгтэй гэж бодож байнга.

-Тэндээ тэгээд суух гэж үү?

-Ердөө ганц, хоёрхон хононо. Тэнд очиж юм хүмээ эмхлүүлэн авч, тал нутгийн амьдралтай сүүлчийн ёслолыг хийх гэсэн юм.

- Өө тийм үү?

-Чи гайхаж байх шив дээ.

-Үгүй ээ! зүгээр л эргэлзэж байна. Би зүгээр л чиний хэлж байгааг ойлгохгүй байна. Ер нь хэзээ ч чамайг ойлгох аз тохиолдохгүй байхаа даа.

-Ойлгож ядаад байх юу байхав. Би нэг чухал юм шийдээд байна. үүнийг дуулаад чи намайг уучилна байх гшэж бодож байна.

-Морисоо, юу уучлах гэж ? Юу тэр вэ?

-Чамд нууцаа хэлүүлэхгүйгээр миний уучилна биз. Би чиний боддогтой адил... тийм хүн биш шүү дээ.

- Чи миний нүдэнд харагддаг шигээ хүнд тусархуу, зориг зүрхтэй, сайхан хүн шүү дээ. Ээ Морис минь! Чамд яаж дурлаж, яаж хайрлаж үздэггүй чий чи мэддэг ч болоосой доо!

-Хонгор минь , би ч гэсэн чамд түүнээс чинь илүү хайртай. гэвч зол жаргалынхаа төлөө бид хагацах хэрэгтэй боллоо.

Хагацах гэнээ?

-Тиймээ хайрт минь, түр зуур хагацах хэрэгтэй боллоо.

-Хэдий болтол ?

-Атлантын далайг хөлөг онгоц хэдий хугацаанд гатлаад буцаж ирдэг бол төдий хугацаагаар л хагацах ёстой болоод байна.

-Яасан удаан юм бэ? Яагаад тэр вэ!

- Би төрсөн нутаг, чиний сайн мэдэж байгаагаар эндхийхэн үзэж чаддаггүй. Ирланд руугаа явах хэрэгтэй. хорьхон цагийн өмнө тэндээс чухал мэдээ авлаа. Би эргэж ирээд охины нь зүрх этгэлийг татсан хөөрхий ядуу мустангер... хэн болохыг аавд чинь татаж байна гэдэг үнэн үү, Луиза?

- Чи өөрөө сайн мэднэ шүү дээ. Миний хамаг зүрх сэтгэл эргэж буцалтгүйгээр чинийх болсон шүү дээ. Морис минь, намайг бүү шоолоорой, би насан туршдаа чиний боол байх болно.

- Дахин тэврэлдэж үймэлэхээ , уирхээхэй уар, цар хийхээ зогссон өндөр улиангарын орчинд чив чимээгүй болж тэмээн хараацай дээр гэгч халин нисч эхэлжээ.

-Гэвч дурлалт хоёр юу ч анзаарсангүй : тэрхоёр хүн ч юмуу бүр чөтгөр ч байж магадгүй нэг сүүрийг ажигласангүй

Хөшөөний ард нэг нуугдаж бутан дотор нэг нуугдаж, бутад дотор нь нэг хярсар тэр бараан сүүдэрт эцэст нь тэднээс арваад алхмын зайтай модны ард нуугдлаа. Ойр хавьд нь чив чимээгүй аз жаргалд умбасан тэд нар энэ анир чимээгүй байдал тэдний яриаг дуудуулж , өөдгүй сарны туяа хөдөлгөөн бүрий нь илчилж байгааг сэжиглэсэнгүй.

Модны ард нуугдан сүүдэгнэн тэдний үг бүрийг, хайр дурлалаа илчилсэн сүрс алддалтыг нь алдалгүй сонсон, марны мөнгөн туяанд хөдөлгөөн бүрийг нв алдалгүй харж байлаа.

Энэ өөдгүй тандуул хэн байсныг хэлэх хэрэг байна уу? мэдээж Кассий Колхаун нэр гарна. үнэндээ тэ биеэрээ байлаа.

XXXIII. Сэтгэл шаналгасан нээлт

Луиза пойндекстерын үеэл ах ийм шөнө буюу чухамдаа ийм өглөө эрт яагаад сэрүүн байв аа? энэ уулзалтынхаа тухай урьдаас мэдэж байв уу, эсвэл түнийг орноос нь босгож цэцэрлэгт бүх юм зүй ёсоор бана уу гэдгийг шалгахад сэжиг зүгээр л нэг төрөв үү?

Өөрөөр хэлбэр дурлалт хосыг санамсаргүй харав уу, эсвэл урьдаас хэлэх хэрэггүй бөгөөд цэвэр сайхан Юуны өмнө үнэнийг хэлэх хэрэггүй бөгөөд цэтэр санамсаргүй тохиолдолд, чухамдаа гэвэл санамсаргүй явдал гэрэлтэй нийлээд чөлөөнд гарсан ахмадын сэтгэлийг одоо тамын гал мэт төөнөх тэр нууцыг мэдэж авахад тусалжээ. Колхаун шөнө дундын үед яагаад тжэгснээ өөрөө мэдэхгүй, шилгээний дээвэр дээр гараад сайхан үнэрт оромол навчин тамхи татаж, сэтгэл тайван зогсч байв. Түүний сэтгэлийг тэгтлээзовоосон юм байхгүй бололтой. мустангерын учруулсан шарх нь эдгэрсэн болов үнэндээ буудалцаанд дийлдсэндээ санахаас улам бүр шаналан зовж тэр гашуун зовлон нь удахгүй өшөөгөө авна гэж бодохоор бага зэрэг дарагдах шиг болно.

Луизаг морь унаж алс хол зугаалж явахаа больсонд Колхаун аав шиг нь их сэтгэл өег байсан бөгөөд чухамдаа гэвэл түүний зөвөлгөөнөөр Пойндекстер охиноо ганцаар мориор зугалахыг хоригложээ. Луизаг нум сумаар зугаацах болсны цаад учрыг бас л аав шиг ньхарагдаж сэжиглэдэггүй, түүнийг гэм зэмгүй тоглоом зугаа гэж үздэг байлаа. тэрч байтугай Луизагийн өөрт нь хайхрамжгүй байдаг нь зөвхөн түүний элдэв маягаа л болж байна уу гэж өөрийгөө тайтгаруулан найддаг ч байжээ. Луиза сүүлийн үед тэр бүр ширүүн дориун хандахаа байсан учир Колхаун өнөөх хардлага юу ч бол гэж бодоход бараг хүрчээ. Түүнд одоо болтол Луиза залуу ирландад татагдаад байна гэдэг байталгаа байсангүй. тэгээд сүүлийн үед дахин сэжиглэхээр зүйл юу ч гараагүй учир, хий дэмий ч сандарчээ хэмээн бодох болжээ.

Ийм юм бодсондоо уужирсан Колхаун асотей дээр гарч ороомол навчин тамхи хайнгадуухан асааж аваад, харваас зүгээр л нэг наауаа гарёч ирсэн нь илэрхий тайван шиг тамхиа татаж байлаа. Тэр нь бөгчим өрөөнөөсөө зүгээр л нэг цэнгэг агаар цээж дүүрэн амьсгалахаар ч юмуу эсувэл өөрт нь даанч байдаггүй ч гэлээ тэргэл сарыг сонирхон хүсэлдээ хөнтлөгдөн гарч ирсэн ч байж болох юм.

Юу ч гэсэн тмхиа зуугаад амостейн хашлагыг налан гор руу харж зогсов.

Дөнгөж сая төглөөс гарсан бололтой нэг морьтон голын нөгөө эрэгт хараад нэг их юм бодсонгүй. Энэ замын тэр сайн мэднэ. Шөнийн сэрүүнд л газар ахиах гэсэн хүн гэж боджээ. ер нь ийм гшөнө ямар ч ядарсан хүнийг замд гарах нь дамжихгүй. Энэ бол суурингийн бааранд баахан суучихаад буцаж яваа хөрш тариалангийн эзэн ч байж болох юм.

Өдөр бол таних байсан байж магадгүй. харин сарны гэрэлд танигдсангүй. Колхаун түүнийг хайнга харангаа шал өөр юм бодож, усан дээгүүр хөвөх зомгол нь цавчдас харсан шиг зогсч байв.

Тэгтэл нөгөө хүн нь төгөлдойртож ирснээ түүн рүү ячиглэн ирсэн нь жигтэй санагджээ.

Сайхь хүнийг мориноосоо бууж голын тохой руу явахад нь ьааж байсан тамхиа хаянгуут.

- Энэ чинь юу болж байна ? Чөтгөр аваг! Яарч байхы нь бүр! Бүр тоххой руу ороод ирлээ. Эрэг рүү буухы нь харваас энэ газрыг сайн мэдждэш бололтой. Арай цэцэрцлэгрүү орох гэж байгаа юм биш байгаадаа? Яаж орох юм бол ? сэлээд ирэх нь үү? Ер нь тоглоом ч үгүй юм болох нь байна. Арай хулгайяч биш байгаа даа? гэж колхаун үглэж зогсоно.

Энэ бол түүний толгойд орж ирсэн ахны таавар бөгөөд гэвч энэ таамаглалаа үндэсгүй болохыг тэр дорхиноо мэджээ.

Үнэндээ испани америкийн орнуудад хулгайч бүү хэл гуйлагчин ч мориор явдаг нь. гэхдээ л шөнө дунд жимс, ногоо хулгайлах гэж мориор явах нь юу л бол

“Гэвч түүнд юу хэрэгтэй байна аа?”

Морис морио төгөлд орхичоод өөрөө гол руу болгоомжтой явганаар гэтэж ирсэн нт мөн сарны гэрэлд юм бүхнийг сайтар ажиглаж байгаа байдал нь тэр хүнийг ямар ч байсан сайн л юм хийх гэж ирээгүйг, нэг л сэжигтэй гэдгийг хэлээд өгчээ.

Юу хийх гэсэн байж болох вэ?

Тэр хүнийг эрэг рүү доош буугаад явчихад нь Колхаун асотей дээрээс дахин харжэ чадсангүй. Цаад эргийг эмжсэн ширэнгэ түүнийг халхалжээ.

"Ямар зорилгоор энэхүн түүгээр эргэлдэнэ ьэ?" Чөлөөнд гарсан ахмад энэ асуултыг өөртөө дахин дахин тавьж улам улам сэтгэл нь зовнин байтал, гэнэт хэн нэгэн хүн ус руу шумбах мэт цүл дал хийсэн чимээ хэдий чанга биш авч тод сонсогдохоор гарлаа.

- Сэлүүр дуугарч байна.. тэр завийг татан голын цаана аваачаад шууд цэцэрлэг рүү сэлүүрдэж байна ! Үгүй ер түүнд юу хэрэгтэй юм бэ? гэж амандаа дуугарав.

Колхаун дээвэр дээр хий дэмий тархи, толгойгий зовоохооны оронд сэм доошоо бууж, эрэгтэйчүүдийн сэрээгээд цөмөөрөө тэр хүнийг авлая гэж шийджээ.

Тэгээд хашлагаас гараа авч явах гэтэл бас нэг чимээ сонсдож , дахин

цэуэрлэг рүү харахад хүрэв. Энэ чимжээ сэлүүрийн дуу биш байснаас гадна , голын тэндээс гарсангүй ямар нэг хаалга ч юмуу цонх онгойх мэт чимээ Колхауныг зогсч байгаа газрын яг дороос нь гарчээ.

Колхаун тэр чимээ чухам вуных болохыг мэдэх санаатай хашлага дээгүүр тэгнэн доошоо хараад царай нь түүнийг гэрэлтүүлж буй сар шиг хувхай цайн, зүрх нь бөөзлаад явчихав.

Үеэл дүү Луизынх нь цонх онгорхой байв. луика өөрөө цэцэрлэг рүү очдог шатан дээр буух гэж байгаа бололтой зогсож байь. Өргөн халхгар хуниастай цагаан плааж өмсөн, толгойдоо нимгэн алчуур уясан нь түүнийг сар мөнгөлөг гэрлээрээ гийгүүлсэн шөнийн лусын дагина уу даа гэмээр харагдуулна.

Луиза байрнаасаа гарч ирсэн нь завтай хүний ойртож яваатай ямар нэг холбоотойг Колхаун тэр дороо ойлголоо.

Тэр гол гаталж яваа хүн нь хэн бэ? морис мустангераас өөр хэн ч биш! Нууц уулзалт Үүнд ямар ч гэсэн эргэлзээ алга. Цагаан плааж ячимээ гаргалгүй цэцэрлэг рүү орж эргийн моддын ёүүдэрт алга болов. Цочиж гайхсан Колхаун тэнгэрт ниргүүлсэн мэт хөдөлж ч чадахгүй зогсов. Тэгээд цагаан хувцастай бүсгүй алга болж цэцэрлэг дотор хүний аяархан ярих сонсодсон хойно Колхаун сэхээ авч, хөдлөх хэрэгтэй юм байна гэж шийдлээ.

Тэр хэнийг ч сэрээхээр явсангүй. Ямар ч байсан одоохонхэрэггүй гэж үзжээ. Эхлээд үеэл дүүгийнхээ шившигт явдлын гэрч болох хэрэгтэй. дараа нь ... дараа нь гайгүй учир нь олдono гэж бодов.

Яг энэ агшинл тодорхой төлөвлөгөө бодохтой манатай, хорсон тачаадсандаа ухаан жолоогүй чичирсэн амьтан, асотей дээрээс буугаад цэцэрлэг рүү оров.

Гэнэт хамаг бие н сулран чулуун шатаар буухдаа хөл ньнугарчих гээд байь. Цэцэрлэгийн замаар явж байхад нь модны ард нуугдан өр зүрхий нь өш авах мэт болсон явдлыг ажиглаж байхад ч хөл нт салганан чичирсээр байлаа.

Тэдний тангараг, янаг дурлалын үг, маргааш өглөө явна угэсэн Морисын үг , удалгүй буцаж ирнэ гэсэн амлалты нь мөн ирээдүйн тухай хагас хугас хэлсэн мөрөөдлий нь цөмийг сонсчээ. Бас луиза мустанг?рыг явуулахгүй байх гэж оролдон, эцэст нь морис явахаас өөр аргагүй гэдгээ итгүүлснийг ч байж ядан сонсчээ.

Тэднийг энхрийхнээр тэврэлдэхийнх нь гэрч болсондоо цухалдан хөлөө дэвслэхэд нь жирхээрэй цочсондоо дуугаа хураав.

Яагаад тэр энэ хоромд урагш ухасхийн өөрийг нь тамлан буй сайхь уулзалтыг төгсгөл болгож өрсөлдөгчдөө хутга шаан өөрийнхөө хөл дор, дурласан хнийх нь хөл дор амьгүй болсон биеийг нь хэвгүүлсэнгүй вэ? Яагаад эхлээд л ингэсэнгүй вэ? Түүнд өөр ямар нэг гэрч баримт хэрэгтэй байв уу? эсвэл сарны гэрээлд мустангерын бүсэнд гялалзах зургаа үэсрэдг кольт бууг харснаасаа болоод зүрхлэсэнгүй юу?

Хэдийгээр өшөө авах хүсэл нь оргиловч ямар нэг юм түүнийг үсрэн айдархынг нь хориглосон барахгүй өөрт нь ихэд зовлонтой яг тэр тэвэрэлдэх хоромд тэднийг орхин явахад хүргэн, дурлалт хосыг зөнгөөр нь орхин гэрийн зүг харайлгав.

XXIV. 'Сайн эрийн' санаа

Кассий Колхаун хаачив аа? тасалгаа руугаа буцаагүй нь лав. тийм гашуун зовлонд унасан хүн унтаж чадна гэж үү?

Тэр үеэл Генри Пойндекстерын тасалгаа руу явжээ. тэгэхдээ лаа гэрэл авах гэж цаг гарздахгүй шууд тийшээ муруй тахир гудмаар алхлаа. Ер нь лааны хэрэг байсангүй. Цонхны хаалтаа хаагаагүй учир цонхоор тусах сарны гэрэл таслагааг сайтар гэрэлтүүлнэ.

Тасалгааны доторх нүүр гарын угаалгуур, жижигхэн ширээ, хоёр сандал, ялаа шумуулаасхамгаалж шаа татсан ор дэвсгэр ор зэрэг авсаархан авил хэрэгсэл нь ялгарсан танигдахаар байв. Заалуу ххүн цэвэр ариун санаатай хүмүүст л байдаг тэрхүү амар тайван нойрондоо дугжирч байла. Дэрэлсэн дээр нь өтгөн бужгар үс нь задран таржээ. Колхаун орны бүрхэвчийн сөхөхөд сарны гэрэл санаа амар унтаж байгаа залуу эрийн эрхшүүд царайггэрэлтүүлэв.

-Сэрээрэй Генри, сэрээрэй! гэж Колхаун унтаж байгаа хүүгийн дал мөрнөөс хүчтэй угзран хэлэв.

- Юу вэ? Энэ чинь Каш чи юу? Юу болоо вэ? Индианчууд ирсэн юм биш! Босож, гэр бүлийнхээ дотор гарч байгаа шившигтэй, гутамшигт явйдлыг хараач, Бушуулахгүй бол Пойндекстерын Техасын хамаг амьтан элэг доог болж гүйцэх ньбайна шүү!

Үнэндээ ингэж хэлж битгий мунгина. Ер нь өмдөө өмсөөд л боллоо. Бусад нь яахав чөтгөр аваг! Бушуул гэм! Хэмээн Колхаун цухалдан хэлэв. Генри хрөвөн даавуун бааз хувцасаа хормын дотор углаж, Колхауны хойноос цэцэрлэг сэрээсний учрыг олоогүй хэвээр л явав.

Колхауныг гараар зогсох дохио өгөхөд

-Кассий Колхаун юу вэ? Юу болоод байна вэ? Надад хэлээе гэж Генри асуув

-Чи өөрөө хар л даа.—Наашаа ир. Завь тавьдаг гакар өөдөө, энэ хоёр моодны завсраар хараач. Чи энд юу байгааг харж байна уу?

-Нэг цагаан хуцвастай хүн байна. Эмэгтэй хүн палааж бололтой... Энэ эмэгтэй хүн үү?

- Тиймээ, эмэгтэй хүн байгаа юм. Чи түүнийг хэн гэж санаж байна.

-Мэдэх юм алга. Хэн байж таарах вэ?

-Дэргэд нь бас нэг хар хувцсатай хүнй бараа харагдаж байна.

-Аа, тэр нь эрэгтэй хүн шиг байна... Тийм юмаа?

-За чи түүнийг хэн гэж бодож байна ?

-Кассий минь би яаж мэдэх вэ дээ? Харин чи таньж бөайна уу?

-Би таньж байнаа. Тэр эрэгтэй нь Морис мустангерын байгаа юм.

-Тэр эмэгэний нь хэн бэ?

-Чиний эгч Луиза, Морис тэврүүлээд зогсч байгаа нь тэр.

Залуу хүн ячг зүрхэндээ шархдсан юм шиг гуйвалзсанаа урагш ухасхийгээд нь:

- Байз! Гэж колхаужн түүнийг барьж аваад - Чамд зэвсэш байхгүй , харин Морист буу бий. Май энэ хойрыг ав гэж хэлээд гар буу, хутга хоёроо өгя- Би өөрөө буудчих байсан юм. Гэвч эгчээ өмөөрөх дүүгийн хувьд чи буудчих байсан юм. Гэвч эгчээ өмөөрөх дүүгийн хувьд чи буудсан нь дээр гэж бролсон. Яв, Генри ! харин Луизагш буудчихав даа, мэдээтэй байгаарай! Сэмхэн дөхөөд оч. Тэгээд салангуув нь цаадахдаа хар гэдсээ нь буудчих. Хэрэв зургаан суманд алагдахгүй бол хутгалчих! Би ойрхон зогсч байгаа чам руу очиж элбэлцэмц. Урагшаа! Цаад өөдгшүй амьтнаа гэтэж очоод зүйл дуусгачих! Гэв.

Генри Пойндекстер ингэж ятгахын яч хэрэггүй байжээ. Бүхнийг умартан, урагш тэмүүлэн хэдхэн хормын дараа дэргэд нь оччихов. Тэгээд мустангерын өмнө ухасхийн хүрээв.

-Адгийн муу хог ! Эгчий минь тэврэхээ боль.. Алив Луиза хойгоо бол, наадхий чинь алаадахья ! Зайл Луиза, би чамайг зайл гэж байна шүү!

гэж Генри хашгирав. Хэрэв Луиза үгэнд нь орёон бол морис Жеральд агшин зуур амь алдах байна. Генрийн эрэг гар далайж л чадвал амьд үлдэж чдах байжээ. Буугаа сайн эзэмшдэгээ хрэг юу билээ, амжижи буудаж чадах нь байлаа.

Морис амиа хамгаалах гэу буруугаа гэрнээс нь суглахын оронд харин Лузаг ташир буудуулахаас айж, түүнийг биеэсээ ходуулахын оролдов. Гэвч тэру нь улам чанга наалдахаад салахгүй байна.

Генри Мориыг буудвал Луизаг ташир буудаж амь насанд нь аюул учруулахыг ойлгшоод гохоо дарсангүй. Энэ удаашрал нь тэр гурвыг аварлаа. Луиза байдойыг түргэн зуур ойлгон мустангерын орхиод дүүгийнхээ гарааё шүүгч зөвхөн дүүгээ хориглон зогсоох хэрэгтэй байжээ.

- Гүйгээрэй, гүйгээрэй! Гэж Морис руу хашгираад улаан залзуу уурласан дүүгээ саатуулахыг оролдож - Генри эндүүрч байна. Би хамаг учрын хэлж өгнө. Бушуулаарай Морисоо, бушуухан амь гарч үз! гэв.

Луизагийн найрсаг үгэн ороод явахад бэлэг байсан ирланд залуу эр,

-Гэвч Генри Пойндекстер, та намайг өөдгүй бэлэн байсан ирланд залуу эр,

- Генри Пойндекстер , та намаг өөдгүй хн гэж ташаа боож байна. Дүү чинь намайг эцэг, үеэл ахаасаа илүү зөв ойлгосон гэдгийг үзүүлээд өгөх хугацаа надад өгөөтөх. Зургаан сарын

дараа би эгчийн чинь хайр, хүндэтгэлийн хүлээхээр хүн биш гэвэгт та нар итгэжээл намайг анхны уулзалтаар л зам дээр чинь тааралсдан чоно шиг алчихаарай. Харин одоо баяртай гэв.

Генри , өөрийнхөө нь булчинтай мэт санагадх эгчинтхээ гараас мултрах гэж оролдох нь алгуур намжин, голын зшүгээс Каса-дель-Кривогийн амгалан байдлыг алдадгуулсан хүн хчр дахь эх орон нь болсон тал руу одсоныг илтгэсэн ус цалгих чимээ гарахад гараа дош буулгав.

- Дүү минь, чи түүнийг андуурч байна. Чи түүнийг глмдоолоо шүү дээ гэж Морисыг далд оронгуут Луиза хэлээд- Ээц, Генри минь, түүнийг гайхамшигтай сайн хүн гэдгийг нь мэддэг ч болоосой! Тэр надад нэг ч хар муу санаж, намайг огт гомдоож байсангүй. Дөнгөж сая надад хов жив арилган намайг аз жаргалтай болгохын тул юу хийхийг напад ярьж байсан аз жаргалтай болгохын тул юу хийхээ надад ярьж байсан юм. Дүү минь надад итгэ. Тэр чинь зөв боловсон хүн! Гэвч би түүнийг хэнч байлаа гэсэн, харц энгийн хүн байлаа ч гэсэн дурлахгүй байж чадахгүй ! гэв.

- Луиза чи, надад үнэний нь хэл. Чи ч өөрөө өөртэйгөө ярьж байгаа юм шиг л надтай ярь. Би чиний хэлснээс илүүгээр энд болсон юмыг хараад л тэр хүнд дурласан чинь ойлголоо. Чи надал үнэний ньхэлээч Чиний итгэлдхайрыг хортойгоор ашиглаж байгааюм биш биз?

-Үгүй Үгүй! Чамд тангаргалая. Тэр ариун шудрага хүн. Генри чи юунд тэр хүнийг дэмий доромжилчихов оо?

- Би доромжилсон гэж үү?

-Тиймээ. Шудрага биш, бүдүүлэг зан гаргасан.

-Би түүнийг өмнө буруугаа хүлээхэд бэлэн байна.

-Би түүний өмнө буруугаа хүлээхэд бэлэн байна.

Хойноос ньочоод буруугаа хүлээхэд бэлэнб айна.

Хойноос н очоод биеэ барьж сүржин хөдөлсөндөө уучлал гуйна. Эгч минь, чи л үнэнэийг хэлж байгаа бол түүний хойноос очиж уучлал гуйх ёстой. тэр чинь анхнаасаа л надад таалагдсан гэдгийг ёи мэдэж байгаа. Харин одоо би чамайг хүргэж өгтє. Хариад унтаж бай. Би түүний өмнө буруугаахүлээхээс нааш амар заяа үзэхгүй!

Гэрлүүгээ буцахдаа Генри эгээ сугада хийсэн хэрэгтээ гэмшиж уур нь оргүй алга болжээ. Бушууахн мустангерын араас очиж цухалдсанаа болоод ямар ч үндэсгүй гомдоосондпоо уучлалт гуйя гэж бодохоос яаран байю.

Эгч дүү хоёрыг байшин руу явахад бжтан дотроо нцуугдаж байсан гурад дахь хүн г.арч ирэн араас нь чулуун шатаар өгсөв. Энэ бол Кассий Колхаун байв.

Тэр хүн бас л мустангерын араас яваья гэж бодож байжээ.

XXXV. Найрсаг бус эзэн

“Өөдгүйхулчгар амьтан ! хар тэнэг! Би ч гэсэн ийм юманд найдаж мангуурч байдаг тэнэг хүн юм. Луйза нохойн гөлгийг ятгаж чадна, тэгээд цаад муу золигийг нь зайлчихаж мэнэ гэдгийг би урьдаас бодох нь яав даа. Би өөрөө түүнийг моднб араас огт мэдэгдэлгүй нухчихаж чадах байсан юм. Тэглээ гээд хохирох юу байхав, нэрэнд минь чхүртэл муу юм болохгүй. тэгсэн бол Вудли ах надад баяр хүргэхээс ч өөр яах ч үгүй. Цөм миний хийсэн хэргийг зөв гээгээнэ. Нэртэй айлан зүстэй охин. Мини үеэл дүү нэг муу морины наймаачин, и тэнэмэл юманд хууртагдажээ л гэнэ биз! хэн намайыг буруушаах юм! Чөтгөр аваг, сайхан боломж! Тэгээдби тийм юмыг алчихаж байаг. Харин одоо дахиад хэзээ тийм эгзэг таарах нь вэ гэдгийг мэдэх юм алга!

Луиза Генри хоёрын хойноос шилтгээн руу буцаж явахдаа колхаун ийм юм боджээ.

Колхаун хашааны хаалгаар оронгуут өөртөө хэлсэн нь:

- Энэ амны салиа арилаагүй тэнэг чинь үнэхээр ярьсан юм биш байгаа даа? Эгчийнхньтолгойг эргүүлэгч тэр этгээдээс знэхээр уучлал гуйх гэж багаа юм бол уу? Энэ ч ёстой инээдмэтэй юм болно доо. Мориний саравчин дахь чимээнээр бол мордох гэж байгаа даг аа... Тийм байна морио эмээллээд уналаа.

Жүчээний хаалга Мескикийн суурингуудынх шиш чулуу дэвссэн хашаа руу харжээ. тэр хаалга гүйэд хаагдамгүй байв. Колхауныг очоод шагайтал, дотрос н нэг хүн түлхэж хаагийг цэлийтэл нээв.

Мөрөнөөс нь сул унжсан халхгар том цувтай, дэлбэгэр өргөн хүрээтэй малгай өмссөнг хүн саравчинд босгон дээр гарч ирлээ. Тэр хүн эмээлтэй морь хөтөлжээ.

Генри хилэн хар морио хөтлөөд гарч ирэхийг нь Колхаун тагьжээ. тэгээд тэр залуууг ойртож ирэхэд нь.

- Хартэнэг!Түүнийг тавьчихдаг чинь ! Буу хутга хоёрыг минь өгөөд орхи. Чиний цагаан гарт таарахгүй тоглоом. Чи яагаад миний хэлснээр хийсэнгүй вэ? Яахаараа тэгж тэнэглэдэг байна аа? гэж уур хилэн нь бадран бувтанав.

-Тиймээ үнэхээр, би тэнэг юм хийлээ. Би үүнийг мэдэж байна. Би тэр тохиотой томоотой хүнийг дэмий муухай гомдочихлоогэж залуу эзэг тайван өчив.

-“Тохитой томоотой хүнийг гомдоочихлоо гэнэ шүү!” Ха-ха,ха! Чи чинь мэдэрлээ алдаж солиорчээ!

- Хэрэв би чиний үгэнд орсон бол знэхээрийн солиотой хүн боох байлаа. Аз болоход тийм юм хийсэнгүй. Гэлээ гэхэд л тэнэг гэж хэлэгдэж бүрэн болохоор дэмий юм хийчихлээ. гэвч тэр на айг уурын мунхагаар тийм юм хийснийг ойлгон уучлах байх гэж найдаж байна. Ямар ч байлаа гэсэн би одохон цаг алдахгүй явья

- Чи хаашаа явах нь вэ?

-Би Морис мустангерын хойноос очиж түүний өмнө өөрийн үйлдсэн журамгүй хэргийн төлөө уучлал гуйяа

- "Журамгүй хэрэггэнэ шүү!" ха-ха-ха! Чи зещр нь тоглож бана уу?

-Үгүй ээ. Би яинь үнэн үгээ хэлж байна. хамт яьъя л даа чи яахыг минь хар.

-Тэгвэлл чамайг ёстой галзуу хүн вь гэж бас нэг хэлчихэе. Тэгээд бас зөвхөн галзуугаар барахшй эргүү тэнэг хүн юм !

- Би ярьж ярьчихсан ч гэсэн, чиний энэ занг уучилъя л даа. Гэхдээ колхаун чи эелдэг хүн биш юм. Хэзээ нэгэн цагт чи миний жишээгээр өөрийн муухай аашилсандаа уучлалт гуйж болох л юм гэчихээд залуу, морио давирч ухасхийн давхив.

Тэр Генри Пойндекстерын араас нэг хочр бээрийн зайтай гүйцэж очих гэж бодоогүй нь илт явж байв.

Генрийн морины тахны цуурай аль хэдийн дуулдахаа больж Колхаун я яаралгүй шогшуулж явлаа.

Колхаун гол өгсөн явж цайз руу зэргэлдээх төгөл рүү анхааралтай ажиглаж хараад гол руу эргэсэн хажуугийн зөрөг рүү ошцом эргэж явлаа.

Оодоохондоо бүх юм баларчихаагүй л байна. Харин түрүүчийнхээс илүү их үнэтэй юм. Мянган доллар зарцуулах болох нь. За яах гэх вэ? Гол нт амьдралыг минь баллаж байгаа энэ му ирландаас л салах хэрэгтэй байна. хэрэв худал хэлээгүй бол өглөө эрт овоохой руугаа явна гэж байсан Хэдийд явах бол мэдэх юмсан ? Үүрээрбосно гэдэг чинь тал нутгийнханд орой л юм шиг санагдана. За яах вэ. Бидэнд цаг мундахгүй ! Талын Соно Морисын уртгаж амжина. Энэ зам эртүүдийн билд нарын явсан зам байх. Аламод байдаг урцныхаа тухай ярж байсан. Бидний эрэг дээр нь хооллосон голыг тэгж нэрлэдэг гэсэн. Овоохой нь эндээс холүй бөйх ёстой. Эль-Койрот чухам хааны нь мэдэх ёстой. Ямар ч байлаа гэсэн яаж тэнд хүрэхийгээ л лав мэдэж таарна.

Энэ нь д бидэнд хангалттай. Ер нь овоохой нь бидэнд ямар хэрэг байна. Эзэн нь хүрч чадахгүй л болчихлоо биз. замдаа индианчуудад дайралдаж болно шүү дээ. Ер нь дайралдах юм чинь

Энэ үеэр чөлөөнд гарсан ахмад нэг урцанд хүрч ир нь саяны бодож явсан овоохой бус, мексик мустангерын оромж балаа. Түүний гол зорилго нь ч энд ирэх явдал байжээ. Эмээллэсээр срэн бууж морио модны мөчрөөс уячихаад үүд рүү нь ойрьлоо.

Овоохойны үүд онгорхой , дотор нь унтаж байгаа хүний хурхирах сонсдов. Гэхдээ энэ нь тайван нам унтаж байга хүнийг хурхиралт биш ажээ.

Энэ тасалдангит хурхиралт нэ үе чимээ тасарч, нэг үе гайхан хахираа шиг дуугаран сайн

анхааралтай чагнавал хараал, ерөөл хэлээд байх шиг байв. Овоохойн эзэн зэгсэн согтжээ. гэдэг нь илт байна.

-Тамд очмоор! Чөтгөр алгад! Гэснээ бурхдыг дуудаж-Иусус минь! Гэгээн Мария! Эх сахиус минь! гэж үглэнэ.

Колхаун овоохойны босгон дээр үөгөч чагнаж эхлэв.

- Өөдгүй новш нууд! Христосын нэрийг барьж тангарагалахд сайхан мэдээ байна! Индианчууд... Косанчууд байлдаанд зэхчихэж. Команчийг бурхан тэтгэг! гэх нь сонсдов.

-Энэ мал чинь балартлаа согтчихож шүү! гэж Колхаун чанга хэллээ.

- Өө ноёнтон ! гэж хүний дуу гарахалд хагас дутуу сэрсэн урцын эзэн хэлээд- Хэн байтугай нь байнаа, энэ чинь? Үгүй тэр хүн биш байна? таныг харсандаа миний бие, тэнүүлчдийн Талын Чоно гэж нэрлэдэг Мигуэль Диас би баяртай байна. Ха_ха_ха !Чоно шүү! Ингэхэд таныбг хэн гэдэг вэ? Эрхэм таны нэр хэн билээ? Чөигөр аваг!Та чинв хэн гэгч вэ? гэв.

Талын Чоно зэгэн хэвтэр дээрээ өндийн хэсэг зуур дахин суугаад хөлчүүрхэн унтасан нойрноос нь сэрээсэн гэнэтийн зочноо нойрмог нүдээр харна. Гэвч улсангүй нэг будэг юм хэлөйхээд орон дээрээ дахин тэрийэ хэвглээ. төдөлгүй чангаар хурхирах нь хэнчбайгааг мэдэх юмгүй болсныг илгэнэ.

- За ингээд л бас нэг бололцоо алдаг дах нь тэр! гэж колхөаун гарахаар эргэхдээ ууртай хэлээд- Эрүүл тэнэг, согтуу мал, мөн таасран туслагчаа олов оо! Хараал хүрмэрүүд! Шөнөжингөө үйлс бүтмэнгүй. Энэ гахайг смэртэл наад зах нь гурван цаг болно. Бүтэн гурван цаг шүү! тэгэхээр дэндүү оройтно, дэндүү оройтно... гэж хэлээд Колхаун хайш явахаа шийдээгүй юм шиг мориынхоо цулбуураас барилаа.

-Энд байхын хэрэг огт алга. Үүнийг ухаан ортол гэгээ гарчихна. Би тиймэрхүү амжилттай буцаж хариад тэнд хүлээх үү, эсвэл ...

Тэр бодсоноо дуулдахаар гүйцээж хэлсэнгүй. харин юу ч бодсон байлаа гэсэн тээнгэлзээд нь арилжээ. Колхаун морио тайлж аваад харайн мордож, түүнийг талын Чоно урцанд хөтөлж авчирсан замаасаа эсрэг зүг рүү явлаа.

XXXVI. Гурвуул нэг замд

Зөөлөн өвсөөр хучигдсан тал нутаг дундуур аялна гэдэг нарт ертөнцөд хүн болж төрөөд үздэг сайхан юмуудын нэг мөн гэдгийг хэн ч үйгүйсгэж чадахгүй.

Хэрэв унасан морь чинь сайн байгаад, эмээлийнхээ араар дүүрэн хоол хүнстэй богц ганзаганаасаа , бүүргэндээ дүүрэниуух юмтай дашмаш өлгөчихсөн, дүүрэн тамхитай хайрцаг богцонд чинь явах юм бол ийм аялал өөрийг чинь уйдаахгүй гэдэгт итгэж болно.

Тэгээд дөрөө нийлүүлэн давхиж, нөхөр тань байгаль дэлхий сүр жавхланг, үзэсгэлэнт сайхныг тантай адил шагшин гайхаж явах юм бол ч энэ хүнд аялалыг олон он жилээр мартуулахааргүй болно.

Тэр тусмаа зүрө сэтгэлээ өгсөн хрүнд чинь цуг явах юм бол ч Баруун Техасын бөглүү тал хөндий жуулчдаар дүүрэн байсан биз дээ? Өргөн уудам зэрлэг тал нутаг тоо томшгүй зөргөөр дшшрч, харц дээгүүр гангачуул хаана л бол хана зөрөлдөх байсан бизээ. гэвч байгаа юм байгаагаараал байх нь чухал шүү дээ. За тэгээд та тал хөндий рүү явахдаа суурингаас зайтаахан гараад тав, зургаан морины мөр гарсан их замаас хажуу тийш эргэхэд л бүх юм болод явчихна. Тэгээдл хэдэн цаг, долоо хоног, сар амагадгүй бүтэн жилээр ч явсан нэг ч хүнтэй дайралдчихсангүй байж мэднэ.

Гагцхүү Техасын асар уудам тал хөндий дундуур аялсан хүн лөөрөө тэр нутгийн үзүүр хязгааргүй цэлгэр их талыг үнэлэн үзэж чадна. _

Гадаад их далай яч хүртэл тийм эн захгүй өргөн уудам санагдахгүй. та далай дунуур явж байхдаа ургша явж байгаагаа мэдэхгүй. Хөх цэнгэр далай өргөн мандал, түүнээс арай тод хөх өнгөтэй хүнхэр- тэнгэро таны эргэн тойрон үргэлж харагдаад дээр чинь өөр юм эс үзэгдэх бөгөөд асар том дугаргын төв дунд зүгээр л зогсоо байгаа юм шиг санагдаж эхэлнэ. Тэгээд та хязгааргүй их усан далайн сүр барааг нь ойлгож мэдэхийн аргагүй болно.

Харин тал нутаг бол өөр хэрэг. Хэсэгхэн ой, толгод , мод үугуй нь үавга мэд одр дороо солигдож, хязгааргүй ардвин тал нутгийг туулж явааг чинв танд хэлээд өгнө.

Тал нутаг, ялангуяа баруун өмнөд Техасын тал нутагт жуулчлагч хүн тэр нутгийн онгон сайхан үзэсгэлэнг ганцаараа сонирхон нь ховор бөгөөд энд хүмүүс хоёроороо гурваараа, ихэвчлэн арав хориороо явцгаана.

Гэлээ ч гэсэн заримдаа ганцаарахнаа яваа морьтонтой дайралдах болно. Жишээ нь Каса-дель Корвын тэнд будлиан гарсан тэр үөнө гурван морьтой хнүн цувран гарч, Леон голын баруун өмнө үргэлжлэх тал руу явцгаасан билээ.

Мексик мустангерын урцаас Колхауныг яг гараад явж байх үед тэдний түрүүч нь суурингаас гаран Нуэсес гол буюу түүний түрүч нь суурингаас гаран Нуэсес гол буюу түүнийг нэг цутгаланг чиглэн явж байв.

Техаст хот буюу тариалангийн газрын орчим байдаг хүмүүсээс өөр хэн ч явган явдаггүй

болохоор тэр хүнийг морьтой явга гэж хэлбэл илүү үг болох биз ээ.

Тэр хүн сайхан морь унажээ. Унасан морь нь хөнөн, сэвхэлзтэл толгой хаялан алхуулах нь мольн замыг алжаалгүй туулж чадахы нь харуулна. Холын аянд гарсан эсэхийг нь хэлэх арга алга. Тэр хүн Техасынхнаас хэн ч гэсэн арав хорин бээр газар аялахдаа явахдаа өмсдөг тийм л нэг энгийн хувцас өмсжээ. Ямар ч гэсэн гэр лүүгээ явж байгаа бололтой. Түүнээс ийм орой гэрээс гарна гэдэнг юу л бол. Мөрөн дээгүүрээ хааш яаш тохсон серапэ нь шөнийн чийгнээс хамгаалах гэж тэгээ юу гэлтэй. Гэвч энэ шөнийн агаар хув хуурай байсан тул тэр хүн ойр хавьд нь суурин дайралдахгүй тийм алс холыг үнэхээр зорьж ч байж магадгүй юм.

Тэгэхдээ бас зорьсон газартаа хэдийд ч хүрсэн хамаагүй юм шиг огтя аралгүй явж байв. Өөрийгөө тойрон багйаа гадаад орчонг огтхон ч хайхрахгүй явж байгаагий нь үзвэл бодолдоо дарагдсан байж болох юм. Жолоо нь морины хүзүүн дээгүүр сул тохоостой морь зоргоороо явж байв. Харин танил замаараа яваа юм шиг зогсолтгүй итгэлтэй алхална.

Тэр амгалан жуулсин сарны гэрэлд дөнгөж гийгүүлэгдсэн алсын манан дундуур далд ортлоо ийнхүү явлаа.

Бараг түрүүчийн хүний далд орох үед өнөөх замаар хочр дахь морьтой хүн суурингийн захаар гарч ирлээ.

Өмссөн хувцсаар нь үзвэл тэр хүн бас л алсыг зорьж яваа бололтой. Хүлхэгэр хуниастай өргөн хар цув өмссөн нь морины хондлойг нь бүрхжээ. Морио үргэлж давирч гуйдан ал нэг газар руу илт яаран яваагаараа итгүүчийн хүнээс ялгаатай.

хэн нэг хүний хойноос гүйцэж ояих гэж бодёон бололтойн тэр хүн, түрүүчийн өнгөрсөн морьтой хүнийг гүйцэх гэсэн ч байж магадгүй ... хөдөлж барих нь тийм гэдгийг илтгэнэ. Байн байн урагшаа ыбөхийж алсын эрмэлзэх мэт. Төдөлгүй хочр дах морьтой хүн түрүүчийн хүний бараа тасарса яг тэр газар очоод бас далд оров.

Хэрэв түүний тохиолдол гэж хэлж болох бол, хачин тохиолдолоор хоёр дахь морьтой хүнийгдөнгөж далд оронгууь жижиг суурингийн захаас гурван д ахь морьтой хүн гарч ирэн, түрүүчийн хоёр хүний явсан зүгийг яг чиглэн явлаа.

Гурав дахь хүн, түрүүчийн өнөөх хоёр хүний алил хувцасласан нь бас л алсыг зорьсон мэт. Бие хараагий нь битүү бүрхсэн улаасм цув өмсжээ. Ганзагласан буу нь цувны өргөн ноодороос цухуйж байв.

Тэр хүн хамгийн түрүүчийн морьтон хүн шиг огт яаралгүй холыг зорьсон хүн гэхэд даанч аажуухан явна. Тэгсэн мөртөө сэтгэл нь тавгүй багаагаараа өмнө нь явж байгаа хоёр хүний байдал их ялгаатай ажэ. Бараан цувгай хүн энэ хэн нэгний хойноос нэхэн хөөж яваагүй байгаа гэж чимээ чагнах мэт эргэнэргэн харж явна.

Заримдаа дөрөөн дээрээ б өндийж,и заримдаа мориныхоо амыг эргүүлж явж өнгөрсөн амынхаа дагуу үргэлж анхааралтайгаар ажиглан харж чимээ чагнаж өөрийг нь хэн нэгэн хүн ... гүйцэж ирэхийг хүлээх мэт

Тэгээд гуравдахь морьтой хүн хэнийг ч хөөж гүйцэлтгүй, өөрөө ч хүнд гүйцэгдэлгүй бас л дорхино далд орчихлв.

Хоор хоорондоо бараг адилхан зайтай явсан тэр гурван хүн бие биеэ харалгүй тал нутаг дундуур урагшлан явцгаана. Өндөр модны орой дээрээс ажиглаж байсан шар шувуу буюу тэнгэрт шөнийн эрвээхэй агнаж явсан ямаалзайгаас бусад амьтан тэр гурван хүнийг, эсвэл хоёрыг нь зэрэг харж чадахгүй байсан билээ.

Нэг цагийн дараа буюу Инж цайзаас арван бээр холдсоныг хойш тэр гурван хүний байдлаас эрс өөр болов.

Түрүүчийн морьтой хүн нүд алдам үргэлжлэх шугуй дундпуур зурайсан урт цамцаалд дөнгөж хүрч очлоо. Тэр цамцаалыг далайн өргөн хоолойтой зүйрлэж болно. Хар ногоон модоор хүрээлэгдсэн усны манал шиг харагдана.

Цамцаалын тэн хагас нь усны манадл шиг и харагджээ. Цаашхи хэсэг нт модны харанхуй сүүдэр дундуур огцом тохойрон орсон байв.

Гурван морьто хүнний түрүүчийн цамцаалдаад орохын өмнө мориныхоо амыг татаж, юу ажиглаж , нэг хоёр хором хэртэй зогсов. Тэгэхдээ эргэж харалгүй шууд уругшаа харж байвТэр удаан ингэж зогссонгүй. Энэ замаараа цааш явахад саад болох юм өмнө нь огт байсангүй морио давирч, урагш явлаа.

Яг энэ үеэр хагас бээрийн зайд ойртож ирсэн хоёр дахь морьтой хүн түүнийг олж харлаа.

Түүнийг харчихаад бараан цувтай хүн дуу алдав Арваад бээр хойноос нь нэхэж явсан хүнээ гүйцсэнлээ баярлав бололтой. морио дабирсаар цамцаал руу орлоо.Гэтэл түрүүчийн хүн цамцаалын эрэгцэх дэх хар сүүдэр дунд нь аль хэдийн алга болжээ.

Хоёр дахь морьтой хүн шууд түүний хойноос явлаа. Гурав дахь нь морьтой хүнийг энд иртэд зэгсэн даан хугацаа өнгөрөв.

Тэгээд түрүүчийн хоёр хүн шиг цамцаал руу орохгүй, хажуу тийш эргэж шугуй дотор ороод тэнд морио уяж, шугуйг гатлан цамцаал дээр сэмээрхэн гарч ирлээ.

Гуравдахь нь хүн ард нь ямар нэг юм болж байгаа мэт бас л түрүүчийнхээ адил эргэж харан, өмнөхөөсөө илүү хойтохийгоо сонирхон харж байв. тэгээд цамцаалын сүүдэр хэсэгт очоод, түрүүчийн хоёр хүн шиг бас алга болчихлоо.

Мориэн туурайн төвөргөөнд хоёр удаа, явган хүний хөлийнчимээнд нэг удаа тасалдан шөнийн дуучдын үл цуцагч найрал дуу, халуун орны гугуй модны шөнийн агаарт үргэлжлэн цууриатсаар нэг цаг хэртэй болов.

Гэтэл эл ойн дуун дахин тасалдах нь тэр. гэхдээ энэ удаа бүрмэсэг удаанаар тасалдана. Тэдний дууг морин туурай ч ююмуу, хүний хөлийн чимээ тасалдуулсангүй. Энэ нь бууны тас хийсэндүү байлаа.

Энэ чимээгээр талын чонын улилт, шилүүсийн дуу, тэр ч байтугай цоохор барын хүрхэр нь хүртэл зогсч, цөм чимээ аниргүй болов.

Гэвч шархдсан хүний ёолох, буудуулсан амьтны чалрлах луу гарсангүй. Цоохор бар харихан хүрхрэлтээрээ ойн амьтнбг дахин айлгаж эхлэв.

Араатан жигүүртэн, хорхой шавьж цөм найз ч бай, түүний хүрхрэлтийг үл ажиглаж чих дүлийрэм концертоо дахин үргэлжлүүллээ. Төдөлгүй төгөлд дахин чимээ шуугиан ихэсч хажуудаа зогсч буй хүнтэйгээ хүртэл хашгирч яоилцахаас өөр аргагүйд хүрэв.

XXXVII. Битүүлгээр алга болов

Каса -Дель-Корвын хонх хүн амьныг өглөөний зуушид урин нэг удаа цохино. Өмнөх нт тариалангийн талбайд ажиллаж байсан боолчуудыг дуудан урам үлдээсэн ажээ.

Ордны ойролцоо ажил хийж байсан боолчууд урцны хажуугийн зүлэг ного, дүнзэн дээр сууцгаан хоолож эхэллээ.

Эзний тэр бүлийнхэн хоолны газар ороод ширээ тойрон сууцгаахад бэлэн бай. Гэтэл цөм бүрдээгүй шиг санагдаж, нэг хүн дутуу байв.

Генри алга байлаа.

Түүний алга байгааг анхандаа огт гайхаагүй бөгөөд ингэсгээд хоолны газар орж ирнэ гэж бодоцгоожээ. Гэтэл хэдэн минутын өнгөрлөө. Генри орж ирээгүй л байлаа. Эзэн,хүүгээ хоолонд хожимдож ордоггүй юмсан гэж гайхсан шинжтэй хэлэв. Баруун өмнөд Америкт өглөөний зоог зооглохдоо тогтоосон цагт гэр бүлэрээ цөм цуглардаг ёстой. Энэ нь хоолных нь өвөрмөц байдалтай холбоотой юм. “Виргиний боорцог”, өрмөнцөр, сагадайн сам боорцог цөмөөрөө л тогтоосон гаргасны дараахан л амттай байдаг билээ. Хоол идэх энэ үе, халуун ширэмжийн хажууд шаргадаж тогоочид там санагддаг үе байлаа.

Унтах дуртай залуу амьтан бол, хүйтэн сам боорцог ч юмуу эсвэл өрмөнцөргүй хоцорно. Иймээс өмнөдийхнөнд ийм залруу хн ховор байлдаг. Энэ учраас Генри Пойндекстерын байхгүй байгаад гайхдаг нь долоон зөв.

-Тэр хүү хаашаа алга болчихвоо? Гэж эцэг нь дөрөв дэх удаагаа асуулаа

Колхаун ч гэсэн, Луиза ч гэсэн огт хариу хэлсэнгүй. Луизад өөрөө ийн харайж зогсов. Түүний харц, дууны өнгөнд нэг ч хачин байдал цухалзах авч үүнийг нь хажуугаас нь нүүр лүү нь сайтар ажигласан хүн лгадарлах байлаа.

Дүү нь хоолоондоо ирээгүйд ингэх нь юу л бол. Ийм дэмий юманд зовох хэн байхав, гэхдэнэ л Луиза учиргүй сэтгэл догдолсон байлаа.

Юундаа ингэв? Хэн ч түүнээс асуусангүй. Эцэг нь ч түүний харцыг ажигласангүй. Тайван царай гарган ямар нэг эвгүй бодлоо нуух гэж оролдож байгаа үеэл ах нь бүр ч ажиг сэжиг авсангүй. хоолны өрөөнд орж ирснээсээ хойш Колхаун нэг ч үг дуугарсангүй барахгүй нөгөө их Луизаг ширтээд байдаг хүн маань нэг ч удаа түүн рүү харсангүй.

Тэр, ширээний ард сүрхий цухалдан сууж бас зарц нарыг орж ирэхэд нэг хоёр ч удаа даьхийжээ.

Колхаун ямар нэг юманд сэтгэл их зовсон нь илэрхий байв.

-Генри энд байхгүй нь маг гайхалтай гэж эзэн бараг арав дахь удаагаа шахуу давтаж хэлээд-Унтаж байгаа юм биш байгаа даа? Үгүй, Генри хэзээ ч ийм орой босдоггүйсэн. хэрэв ийш

тийшээ явчихлаа гэхэд урмын дуу сонсох л ёстой доо. тасалгаандаа байгаа юм биш биз? ...
Хүүш Плутон ! гэв.

-Вудли гуай, би энд бана! Та намайг дуудаа юу?

Плутон хөтчийн зэрэгцээгээр бас хоолны газар үйлчлэгч зарцын үүрэг давхар гүйцэтгэдэг байжээ.

-Чи, Генрийн унтлагын тасалгаанд очоод тэнд байвал биднийг өглөөний зуушаа зооглож джуушлаа гэж хэл

-Вудли гуай, Генри тэнд байхгүй бана лээ.

-Чи тасалгаанд нь орсон гэж үү?

-Тиймээ... Үгүй би түүнийг байхгүй гэж хэлэх гэсэн юм. Би тасалгаанд нь ороогүй. Морьдын тэжээл тавьж өгөх гэж саравчинд очиход түүний морь байгаагүй. Өглөөнөөс хойш алга байна. Генри гуайы алга байхыг бодоход лав л биднийг унтаж байхад яваад өгсөн өлөлтэй.

-Чи үнэн хэлж байна уу? гэж зарцын хэлсэн үгэнд сэтгэл нь уймарсан эцэгнь сүртэй асуув.

-Нээрээ шүү, Вудли гуай. Тэр саравчин дотор зөвхөн Колхаун ноёны морь л ганцаараа байна билээ. Бидэрт мустанг хашаан дотор байсан. Гэтэл Генри гуайн морь л ганцаараа байна билээ. Бидэрт мустанг хашаан дотор байсан. Гэтэл Генри гуайн морь алга.

-Энэ чинь Генри тасалгаандаа алга гэсэн үг биш. Одоохонбушуухан очиж үзээд ир.

-Ноёнтон минь би одоохон очоод ирье. Харин та Плутогийн үнэн хэлснийг үзэн дээ. Залуу ноён тэнд байхгүй : Морь нь хаана байна, тэнд Генри гуай байгааг би мэдэж байна.

-Би юу ойлгохгүй байна.. гэж Плутоныг тасалгаанаас гарахад эзэн хэлэд- Генри шөнө л гэрээсээ шарч дээ. Хаашааявсан юм бол доо? Би түүнийг тийм шөнө орой болсон хойно ямар нэг айлд очихоор явгна гэж санахгүй байна. Негрийн хэлснээр бол шөнөжингөө байхгүй байсан. Цайзад л залуустай байсан байж таарах нь дээ. Арай бааранд... гэтэл.

-Өө, ханаас даа , тийшээ явахгүй гэж эзнээсээ багагүй сэтгэл нь зовсон мэт Колхаун хэлэв. Гэлээ ч ямар нэг санаа авчихаар юм, цэцэрлэг болсон өнөөх явдлын тухай нэгч үг дурссангүй.

"Кассий тэр явдлын тухай юу ч мэдэхгүй. тэгэхээр бүх юм Генри бид хоёрын нууц бож үлдэнэ. Би хэзээ ч Генрийг үгэндээ оруулж чадна... Харин тэр одоо хүртэл яагаад алга байна? Би шөнөжин хүлээж суулаа. тэр лав, Морисын хойноос очоод хоёулаа эвлэрсэн байх ёстой. Уулзах газар нь баарч гэсэн ингэсэн л байж таарна. Генри биеэ боддог даруу л даа, гэхдээ ийм юм болж байхад заншсанаасаа өөрчилж болох юм. Ингэтлээ гээд түүнийг зэмлээд байх юм алга, тийм хүн байхад ямар ч муу юм тохиоолдохгүй гэж Луиза бодож суув.

Хэрэв Плутон орж ирээгүй бол Луиза цааш юу бодох байсаныг бүү мэд. Энэ үед Плутон их

уруу царайтай орж ирэв. нэг чухал юм хэлэх гээд л халгалж ядаад байгаа бололтой.

-За яав? Тэнд байна уу? гэж эзэн зарцын илтгэхийг хүлээлгүй хашгирав.

-Алгаа, Вудли гуай гэж тэр негр их сэтгэл зовсон дуугаар хэлээд- Ноён Генри тэнд байхгүй... Харин ... гэснээ түшдэрэн -Плуту хэлэхэд хэцүү байна... түүний морь тэнд байж байна.

-Морь нь тэнд байна гэнээ? тасалгаанд нь байгаа юм биш биз дээ?

-Үгүй ээ , ноёнтон минь. тэгэхдээ саравчиндаа ч биш хаалганы тэнд зогсч байна.

-Морь нь хаашаны тэнд байна гэнээ? Чи тэгээд юунд урвайсан юм бэ?

-Вудли гуай минь тэгээд тэгээд... Генри гуайн морь нь ... нөгөө хилэн хар ...

-Тэгээд яасан юсм бэ?, хэлийг хог минь яриач! “Юу тэгээд нөгөө гэж ” Морины нь толгой бүтэн байна уу? Эсхүл сүүл нь байхгүй байна уу?

-Ээ ноёнтон минь таны негр чинь ийм юмнаас айхгүй шүү!

Яах вэ тэр морь толгой сүүлээ гэсэн л байг, харин эзнээ гэсэнд нь Плуту айж байна.

-Юу гэнээ? Генрийг морь нь хячихаж гэжн үү? Тэр дэмий , Плуту! Манай хүү шиг тийм унаанд сайн хүн мориноос ойчих ёсгүй. тийм баж болохгй!

Плутогийн эг маг хийсэн яриа ялангуяа дуу хоолой, хөдөлгөөн нь ганц эзэн ч биш охиныг нь үеэл ахыг нь цөмийг сандарган, ухасхийн босоцгоож хаалга руу гарцгаалаа.

Тэдний харсан юм нь хамгийн муу муухай зүйлийгбодогдуулахаар ажээ.

Нэг нгр боол эмээлтэй морь барин зогсч байв. Морь ямар нэг аюулаас дөнгөж мултарсан мэт туурайгаар газар цавчилж тургина Өөрийн нь зүснээс ч хар өнгөтэй, шүүдрээс ч бараан ямар нэг шүүсэнд нэл шүршигдэн будагджээ. Их бие, хөл, эмэл, хамаг юм нь бүлэгнэсэн бараан цусан толбо болжээ.

Энэ морь хаанасирээ юм бол?

Талаас иржээ. Жолоо цулбуураа хөлдөө ороолдуулаад , шилтгээний зүш чиглэн явж байхад н түүнийг негр барьжээ.

Энэ хэний морь вэ? гэж хэнч асуусангүй. тэнд байсан хүмүүс цөм үүнийг Гцнри Пойндекстерын морь гэж таньжээ.

Энэ морь юуны цусанд будагдсаныг хэн ч асуусангүй. тэр цусан толбыг айж сандарсан нүдээр харж байсан эзэн, Луиза , Колхаун гурав гурвуулаа ганц хүнийг буюу нэг нь хүүгээ , нөгөө нь дүүгээ , гурав дахь нь үеэлээ бодож балаа. Тэр морийг Генри Пойндекстер цусны толбоор будагджээ гэдэгт тэд эргэлзсэнгүй.

XXXVIII. Эрэлд мордов

Барин тавин аймшигт баримттай учран гуньснаасаа болоод ухаан алдсан эцэг нь цус босон эмээлтэй морин дээр харайн мордож шууд цайз руу давхилаа. Колхаун ч араас нь давхив.

Болсон явдлын тухай мэдээ тэр дорихноо ойр хавиар тарлаа. тэр мэдээг морьтой хүмүүс голын дээд доод талдаар муурингийн хамгийн холын тариалангийн газруудаар тараажээ.

Индианчууд дайнд мордож, хуйх аөвчих ажилдаа орж Генри Пойндекстерыг анхныхаа золиос болгожээ.

Генри Пойндекстер бол номхон томоотой залуу билээ!

Техас даяар түүнд дайсагнах хүн нэгч байгаагүй юм. Индиан нараас өөр хэн тэр гэмгүй хүний цусыг урсгах билээ?

Инж цайзын талбайд цугласрсан морьтой хүмүүсийн хэн нь ч энэ гэмт хэрг йг команч нар өдүүлсэн гэдэгт эргэлзсэнгүй. Чухам яаж, хэзээ, хаана алаа вэ? гэсэн асуудал байв.

Цусны толбо ахны асуудалд хариу өглөө. Түүнийг буудсан юмуу эсвэл жадаар сүлбэн алжээ. Цусан тобло морины баруун хаагаар бүр нялгадсан юм шиг тодрон морины нуруу, эмээлийн бүүрэг дээгүүр ч үзэгдэнэ. Морины эзэн газарт унахдаа ийнхүү нялгадсан бололтой. Тэнд байсан хүмүүсийн зарим нь хидийнамыдралын турлагаар үндэслэн уг хэрэг гарсан цагийг хүртэл зэгсэн итгэлтэй тогтоож байлаа.

Тэдний таамаглалаар бол цус гарснаас хойш арван цагаас илүү удаагүй байжэ.

Одоо үд болж байгаа учир тэр хүнийг шөнийн хоёр цагт алсан байж таарлаа. Гэмт хэрэг нэгэнт гарсан нь илэрхий энэ үед гурав дахь асуудал л хамгийн гол нь болж тарав.

Гэмт хэрэг хаана гарааа вэ? Хүүрийг хаагуур эрэх вэ? Эцэстнь алуурчийг хаагуур эрэх вэ?

Чухам энэ асуудлыг Инж цайзад яаралтай зарлан харлуулсан инж цайзад яаралтай зарлан хуралдуулсанаар орон нутгийн болоод цэргийн хүмүүсийн зөвлөгөөн дээр хэлэлцэв. Зөвлөлгөөнийг цайзы дарга удирджээ. Уй гашуудалд цөхөрсөн эзэн үг дуугүй зогс байв.

Гэмт хэрэг гарсан газар болоод хэрэгтэн этгэдэийг хаагуур эрэх вн? Команчууд баруун зүгт амьдардаг гэдгийг бүгд мэднэ. Гэвч тэд хэдэн зуун бээрийн газар нүүдэллэн явдаг тухай чухам тэнд гэж тодорхойлох аргагүй юм.

Үүнээс гадна индиан нар одоо дайнд мордсон учир Леон шиг өнчин суурийг дорно зүгээс дайрч мэдэх байлаа. Энэ нь туршлагатай хашир дайчинд болох команчуудбн хувьд жирийн нэг заль байлаа.

Тал нутгийн ч , далайчдын ч замыг заагч лууун дээр адилхан гучин хоёр хуваарь байдаг. Иймд энэхүү зөвхөн ганц л зөв зүгийн заах гуин хоёр зүгээс команчийн дайнч багийн байгаа

зүгийг шилж авна гэдэг эрлийхэнд ярвигатай байх нь мэдээж. Таамгаар эрнэ гэвэл тэнэг хэрэг болно. тэгээд нөгөө гучин хоёр чиглэлээс чухам алийг нь шилэх вэ?

Хүмүүсийг цөөн цөөн бүлэг болгон хуваарилаж тал бүр тийш нь эрэлд гаргая гэсэн саналыг зөвшөөрөөгүй бөгөөд тэр энэ саналыг хошууч хэрэгсэхгүй болгожээ.

Индиачууд мянгаар тоологдож ч болох байсан бөгөөд тэдний өөдөөс дөнгөж зуун хүнтэй багийг явуулж чадах айв. Бэлэнб айгаа таван морин цэрэг дээр бас төдий тооны хүмүүсийг жирийн иргэ дундаас гаргаж авч чадах байлаа. тэгэхдээ цөмөөрөө цуг байх шаардлагатай бөгөөд хэсэг бүлэг болбол дайсны хоол амархан болж мэдэх байв. Дээрх учир байдлыг үндэстэн гэж үзэцгээжээ. Хошууч дэмжиж, , олонхийн сайшаасан эл саналд уй гашуудалдаа автсан өвгөн, түүнээс ч йдутахгүй шаналж буй зээ хоёр хүртэл нэгджээ.

Тэгээд эрэлд ганцхан хүчэй багийг гаргахаар шийдэв. Гэвч аль зүгт явуулах юм бэ гэдэг дээр маргалдсаар байлаа.

Ухаалаг ахмад Слоумен, алагдсан гэж тооцогдож байгаа хүн маань хамгийн сүүлд ал зүг рүү явсныг сураглаж олье гэдэг санал гаргав.

Тэгээд хамгийн түрүүн эцэг , үеэл ах хоёроос нь асуулаа. Эүүн, хүүтэйгээ сүүлчийн цудаа оройн хоолдээр уулзсан , бөгөөд дааа нь түүнийг унтахаар явсан гэж бодож байлаа.

Колхауныгш хариулт нэг л булзааруулсан шинжтэй байв. тэр нь үеэл дүүтэйгээ хоолны дараа ярилцсан бөгөөд ярианы дараа дүү нь өрөө рүүгээ явсан байж таарлаа. Үнэхээр болж өнгөрсөн явдлыш Колхаун яагаад нуудаг билээ. Цэцэрлэгт болсон болзооь уулзадтыг гэрлчэх хүн мөртлөөяагаад тэр тухай дурсахуй байна вэ?

Тэр явдалд өөрийнхөө оролцсон үүргийг ярьж эвгүй байдалд орохоосоо айгаад ингэлээ гэж үү?

Ямар ч байлаа гэсэн тэр нь үнэнийг нуугаад өнгөрсөн агаад түүний хариулт тэнд байгаа хүмүүст нэг л эргэлзээтэй юм шиг санагджээ.

Хэрэв тэдэнд ямар нэг сэжиг ч юмуу эсвэл сайтар эрэгцүүлэн бодох уаг байсансан бол худлаа хэллээ гэдэг нь улам ч илт болох байсныг хэлэх юун. Гэтэл огт санамсаргүй байтал хэрэг явдал огт өөрөөр эргэлээ.

Гуанзны эзэн Обердофер урилга хүлээлгүйгээр өөрөө энэ яаралтай зөвлөгөөнд иржээ. тэр, олны дундуур гараад Генри Пойндекстерын сүүлчийн удаа хэдийд харсан тэр хүн аль зүйт явсан тухай асуултыг хариулахад тус болохоор чухад мэдээ хэлэхийг хсч буйгаа хэлэв.

Тэр герман муруй хазгай англи хэлээр дараахь зүйлсийн ярив. Ахмад Колхаунтай буудалцсаны дараагаас эхлэн буудалд нь амьдрах болсон Морис мустангер энэ шөнө яваад өгдөг байсантайгаа адил энэ шөнө явчихаад маш орой болсон хойно эргэж иржээ. Тэгэхэд бааранд нь залуучууд наргицгааж байсан учир буудлын эзэн унтаагүй байжээ. Морис аль хэдийнээс эхлэн бодуулаагүй байсан тооцоогоо бодуулахаар гуйгаад хамаг өр ширээ нэгмөсөн

төлчихөөд нь буудлын эзэн гайхжээ.

Энэ мөнгийг хаанаас олсны нь хэн ч мэдэхгүй бөгөөд вунд тэгтлээ явахыг яарсан нь бас тодорхойгүй гэнэ. Обердоферын ганц мэдэж байгаа юм нь Морис Жеральд буудлаас зэр зэвсгээ авч Явжээ. Тэгэхээр нь түүнийг морь барихаар явлаа гэж бодсон байна.

Гэвч энэ бүгд нь болсон явдалд ямар хамаа байх билээ. Хэдийгээр гэрчийн этгээд чухал баримт ярих үед буюу ярианы сүүл хэрд тайлбарласан ч гэсэн их хамаатай байсан ажээ. Морисыг явснаас хойш хорин минутын дараа Генри Пойндекстер буудлын хаалга цохижээ. тэр хүн Морис Жеральдтай уулзах гэсэн байжээ. Морисыг явчихсан гэж хэлэхэд хэзээ аль зүгт явсны нь асууж залуу Пойндекстер зохих мэдээ сонсоод буудлын эзэн заасан зүг мустангерын хөөж гүйцэх гэсэн мэт нэн даруй давхин оджээ.

Обердоферын хэлж чадах мэдэх юм ньингээд гүйцэв.

Хэдийгээр эл мэдээнд зарим нэг тодорхойгүй зүйл байгаа ч гэсэн ямар ч байсан эрэлд хэрэг болохоор баримт гарч ирэв. Хэрэв тэр алга болсон хүн Морис мустангерта хамт явсан буюу хойноос нь явж байсан бол түүнийг Морисын явбал зохих зам мөрний дагуу эрэг хэрэгтэй.

Морис Жеральдынх хаана байгааг хэнмэдэх вэ гэдэг асуудал гарч ирлээ. Үүнийг хэн ч тодорхой мэдэхгүй байв. Аламогийн цутгалан Нуэсес голбын хавьцаа хаа нэг газкар байх ёстой гэж зарим хнн үзэж байв.

Тэгээл алга болсон Генрийн ул мөр эсвэл түүний хүүрийг олохоор Аламогийн тийш явахаар шийдэж. Тэндээс Морис мустангерын хүүрч олдож болох юм. тэгсэн цагт зэрлэгээр алуулсан нэг биш хоёр хүний өшөөг авах хэрэгтэй болохыг хэлэх юун.

XXXIX. Тунасан цус

Хэдийгээр аль нэгэн төөрсөн хүн эрэхээр гардаг жирийн нэг багийг бодвол хүний тоогоор олон ч ыгэлээ, эл баг маш болгоомжто явж байлаа. Индиан нар далайгаар мордсон болохоор болгоомжлохоор ч аргагүй байжээ. Ул мөр олж, түүний учрыг тайлбарлуулахаар туршлагайт мөрч, тагнуулч нарбг түрүүлэн явуулжээ.

Леон голоос баруун тийш бараг арван бээр үргэлжилсэн тал нутгаас ямар ч ул мөр олдсонгүй. ГАЗар нь хуурай, хатуу учир давхиж яваа морины л туурайн мөр үлдэж болох байв. гэвч тийм мөр дайралдсангүй.

Баруун хойд болоод зүүн өмнөд зүйг тийш алс хол үргэлжилсэн шугуй, цайзаас арван бээрийн зайтай газраар тал хөндийг огтлон гарчээ. Чөдөр ургамал модонд нь битүү агссан эл шугуй нь хүн, мал бараг нэвтрэх аргагүй үнэхээрийн битүү ширэнгэ ажээ.

Цайзаас чанх өмнө энэ шугуй дундуур огтлон гарсан цавчлан зам нь Нуэсес голын эх өөд явахад нэлээд дөт зам ажээ. Цавчаал замын хоёр талаар эрэмбэ цэгцтэй зэрэгцэн ургасан модод нь зориуд гудамжлан таьсан юм шиг анагдана. Энэ бол шинэ Нуэо Леон , Коауила, Тамаулипасуу зоманчууд довглон байлдах үедээ гаргасан хуучин дайны зөрөг замбайж болох юм.

Мөрч нар энэ замыг Аламо руу чиглэн явсныг мэдээд учир эрлийнхнийг тэр үамаар явуулжээ.

Удалгүй морьтонгууд трэдний түрүүн явгаар явж байсан мөчр нарын нэг нь өөрсдийг нь хүлээн ойн захад үогсч байхыг харлаа.

-Юу болов? Мөр байна уу? гэж бусдыгаа гүйцэн түрүүлж ирсэн хошууч асуув.

-Тиймээ, мөр зөндөөн байна хошуучаа Энэ рүү хараач! тэр зөөлө газар руу хар.

-Морьдын мөр байна.

-Хоёр морины мөр гэж мөрч, хошуучийн хэлснийг хүндэтгэнгүйгээр засан хэлжээ.

-Тийм байна , хоёр юм.

-Цаашаа дөрвөн морины мөр байгаа вм шиг боловч цөм тэр л хоёр морины мөар юм. тэд эхлээд энэ замаар өгсөж дара нь буцаж иржээ.

-Сайн байна, Спенглер. Энэ талаар чи юу гэж бодож байна.

-Би цавчаал замаар дээшээ хол яваагүйы болохоор тааварлахгүй юм бас олон байна гэж цайзын тагнуулячаар алба хаадаг Спенглер хэлээд- Гэвч хүн алсан хэрэг яриагүй энд гарсаннь тодорхой байна гэв.

-Чамд нотлох ямар баримт байгаа юм бэ ? Хүүрий нь олоо юу ?

-Үгүй ээ...

-Тэгээд чи юу олоо вэ?

-Цус. Азрангийн (бизон) гүрээг ханачихсан юм шиг цусан шалбааг оллоо. Өөрөө очоод үз гэсэнээ- харин мөрний учрыг цаашид нарын ольё гэвэл бусдыг, ялангуяа тэр өмнө нь яваа улсыг нэг их ойртуулах хэрэггүй гэв. Энэ хэлж байгаа юм нь хөгшин эзэн, зээ хоёрт хамаатай нь илэрхий. Учир нь мөрөн тэдэн рүү зэрвэсхэн хараад авлаа.

-За тэгье, Санаа зовох хэрэггүй, Спенглер. Чамд хэн ч саад болохгүй гэж хошууч хэлээд эрлийнхэнд хандаж- Эхрмүүдээ! Би та бүхнийг хэдэн минув байрандаа зогсч байхыг гуйя. Спенглер мөрний учрыг сайтар оох хэрэгтэй учир наашаа явж болохгшуй. ганц намайг л дагаж яв галаа.

Хошууч өөрт нь шууд захирагддаггүй хүмүүстэй ярилцаж байгаа учир тушаал эелдэгээр хүссэн маягтай хэлжээ. Гэвч бүгд эл тушаалыг үг дуугүй дагаж зогссон газраасаа хөдөлсөнгүй. харин хошууч л тагнуулчийн араас явав.

Спенглер тавин алхам яваад зогсч газар руу заагаад

-Үүнийг харж байна уу хошууч аа? гэв.

-Хараа муутай хүн ч хармаар юм байна. таны хэлдэгээр ёстой азран нударсан газар гэж бодмоор цусан шалбааг байна. хэрэв энэ маань хүний цус бол тэр хүн хэдийнээ амьсгал хураасан гэхэд эргэлзэх юм алга гэж хошууч хариу өчив.

-Энэ цусыг бүлэгнэхээс өмнө үхсэн байх ётой гэж мөрч хэлжээ.

-Спенглер та үүнийг хэний цус гэж бодож байна?

-Энэ бол одоо бидний эрж хайж яваа, өвгөн эзний хүүгийн цус. Энэ учраас би Пойндекстер гуайг энд ирүүлэхийг хүсээгүй юм.

-Үнэн юмыг түүнээс нуухын хэрэггүй гэж надад санагдаж байна. Тэртэй тэргүй цагаа болохор тэр хн мэднэ.

-Тэр зүйтэй. Гэвч ямар ч байлаа гэсэн эхлээд залууг яаж алав гэдгийг учрыг тайлбарлах хэрэгтэй. Гэтэл тэр учрыг би яагаад ч олохгүй байна.

-Учрыг олохгүйы байна гэж үү? Мэдээж тэр хүн индианчуудын алуулж. Команч нар түүнийг алсан юм биш үү?

-Тэд нар л лав биш гэж мөрч итгэлтэй хэлэв.

-Спенглерта яагаад тэгж яриад байна?

-Хэрэв энд индианчууд байсан бол хоёр биш дөчин морины мөр үлдэх байсан юм.

-Энэ ч яриагүй үнэн. Ер нв зкоманч нар ганц ганцаараа явж гэхэд их эргэлзээтэй байна.

-Ямарч команч, ер нь ямар ч индиан энэ хэрэгт оролцоогүй. Цавчаал зам дээхр хоёрхон морины мөр байна. тахтай морины мөр байгааг та харж багйаа биз дээ. Команчууд хулгайн л биш бол тухтай морь унадаггүй. Тэр хоёр морийг улаан арьстай биш, цагаан арьстан унаж явжээ. нэг нь мустангийн мөр, нөгөө нь н америк морины мөр байна. Баруун тийшээ явахдаа мустанг түрүүлж явсныг мөр нь зарим газар дарагдсанаар мэдэж болох юм. Буцахдаа америк морь түрүүлж , мустанг хойноос нь явж байжээ. гэвч хоёр морьтой хүний нэг нь нөгөөгийнхөө хойноос аль хэр зайтай явсныг хэлэхэд одоохондоо бэрх байна. Харин тэр хоёрын буцсан газар хүрч очвол учры нь олоход амар болно. Тэр газар холгүй байх ёстой.

-За тэгвэл тийшээ явъя. Би эрлийнхнийг тэндээ хоцор гэж хэлье гэж хошууч хэлээд, хүмүүст хоцрох тушаал өгч , өөрөө мөрчийг дагаж явлаа.

Тэр мөрч дахиад бараг аван зуун алхам газар үргэлжилжээ. Ахмад модны ёүүдэр доорхи зөөлөн газар дээр үлдсэн мөрийг ялгаж байв. Баруун тийшээ явахдаа мустанг түрүүлж , буцахдаа америк морь түрүүлж явж гэсэн таамаглал нотлогдлоо гэж мөрч хэлэв.

Энэ газраас цааш мөр гараагүй бөгөөд хоёр морь эндээс буцаж явжээ. Буцаж явахаасаа өмнө морьд бүдүүн улиангарын доор хэсэгш зогссон байв. хэсэг газар морины таханд тахлагдсанд нь үүнийг тодорхой хэлээд өгнө.

Мөрч мориноосоо бууж, энэ хэсэш газрыг анхааралтай судалж үзлээ.

-Тэд энд нилээд удаан хамт байж гэж мөрч хэдэг минутын дараа газар руу ажигласан хэвээр хэлээд- Хоёулаа мориноосоо буулгүй тайвнаар ярьугааж байсан нв бас илэрххй байна. Энэ бүхэн уг хэргийг будлиантуулу байна даа. Уг нь тэд муудалцсан байх ёстой юмаа... гэв.

-Спенгер чи хэрэв үнэн хэлж байгаа бол ёстой ид шидтэй хүн юм даа. Энэ бүхнийг чи яаж мэдэв, хэлж өгөч?

-Мөрөөр нь мэдэж байна. мөрөөр нь шүү хогууч аа. Энэ бол их амархан , мөрнүүд нь бие биенээ дарсан байх юм. Энэбол морь нэг зэрэг хамт энд байсан бөгөөд зогсч ядан дороо газар цавчилж байжээ. Хоёр хүн бүтэн ороомол навчин тамхи дуустал татсаны нь үзвэл тэд энд нэлээд удаан зогсчээ. тамхины улдагдал нь энэ байна. Дуустал татсан янжуурын үлдэгдлийг та хараач. Бүтэн гаанё, нэрчихээр вм үлдсэнгүй гээд бөхийж тамхины үлдэгдэл авч хошуучидөглөө.

-Үүгээр үэхэд тэр хоёр хүн бие биедээ дайсагнасан санаагүй л улс байж. Хэрэв минутын дараа бие биенийхээ багалзуурт асахаар санасан улс бол хэмт тамхиа татна гэж байхгүй. Тамхиа татаж гүйцсэн хойно л хэрүүл гарсан байж таарна. ийм юм болсон гэдэгт би эргэлзэхгүй байна. тэр хоср хүний альнэг нь нөгөөгөө нухчихжээ гэдэг таны энд байгаагай адил үнэн хэрэг. Чухам хэн нь үхэв гэдгийг таах нь тийм ч хэцүү биш байна. хөөрхий өвгөн Пойндекстер , хүүгээ амьлд байхы нь хэзээ ч үзэхгүй болжээ! Гэв.

-Энэ бүхэн цөм нэгл битүүлэг юм гэж хошууч хэллээ.

-Тийм шүү , чөтгөр аваг!

-Харин хүүр нь хаана байна?

-За тэрнийг чинь л тархиа гашилтал бодож байна. хэрэв түүнийг индианууд алёан бол хүүр нь алга болоход би төдий л гайхахгүй байна. тэд түүний хүүрийг аваад явсан баж болно гэвч энд индианчууд байсан гэхийн ямар ч тэмдэг алдга. Тэр хоёр хүний нэг нь нөгөөгөө нударсан гэдэгт та итгэ. Харин хуурий нь яачихав гэдгийг лб и ойлгохгүй байна.

-Туйлын хачин юм! Туйлын бэрх таавар юм! гэж хошууч дуу алдав.

-Бид энэ нууцыг тааж ч бас болох л юм. Тэгэхдээ хэрэг үйлдсэн газраас морьд хаашаа явсан тэр мөрийг олох хэрэгтэй байна. Ямар нэг юм мэдээд авч болох юм. Энд бидэнд өөр хийгээд байх юм алга. Буцъя, хошууч аа. Түүнд хэлэх хэрэгтэй юу?

-Пойндекстер гуайд уу?

-Тийм ээ?

-Чи түүнийг хүүг үнэхээр алагдсан гэдэгт итгэж багаа юмуу?

-Өө хаанаас даа! Би түүнийг баталж чадсангүй. Би зөвхөн уг гэмт хэргийн гэрч болох хоёр морины нэгий нь залуу Пойндекстер үнэхээр тэр мөрийг унаж явсан бол түүнийг амьдаар нь үзэх найдвар бага байгаад би айж байна.

хоёр дахь хүн нь хойноос нь явсан нь их сэжигтэй байна.

-Түүнийг алсан хүн хэн болох тухай Спенглер чамд ямар нэг сэжиг төрсөн юм байна уу?

-Юу ч алга. хэрэв өвгөн обещроферын үгийг сонсоогүйсэн бол Морис мустангерын тухай би огт бодохгүй байх байсан. Хэдийгээр тахалсан мутсангийн мөр багаа ч гэсэн Морисын морины мөр гэж би баталу чадахгүй. Арай чдээ... тэр ирланд залуу бол хүнийг сэмхэн нударчихдаг этгээдүүдийн нэг биш.

-Чиний хэлдгийг би өв гэжбодож байна.

-Тэгэхээр зөлөө пойндекстер алагдаж Морис Жеральд түүнийг алдаг юмаа гэхэд тэр хоёрын хооронд шудрага тэмцэд гарч, эзний хүү ялагджээ. Би ингэж бодож байна. харин тийм их цус гарсан, хүүр нь алга болсныг учрыг би ойлгохгүй байна. мөрөөр нв цааш явах хэрэгтэй. Ямар нэг таамгийн үзүүрт хүргэж магадгүй ... Бодожбайгаагаа өвгөнд хэлбэл яана?

-Үгүй ээ, хэлж болохгүй шүү. Тэр чинь аль хэийын зөндөө юм мэдэж авсан. тэр энэ аймшигт явдлыг үнэн учрыг яваандаа алгуур дууж мэдвэл дээр байх. үзсэн харсан юмаа түүнд битгий яриаарай. Чи нөгөө цус тунасан гаүзар луу очоод эргэсэн мөрий нь хай, эрлийнхнийг хэн ч юуч ажиглахгүйгээр хойноос нь дагууоахыгбродъя.

-За тэг хошуучаа. Буцсан мөр хаанаа аваачихыг би таамаглаж байх шиг байна. надад арван

минутын хугацаа өг. тэгвэл намайг дохио өгөхөөр над руу очоорой гэж мөрч хэлээд өнөөх цус байсан газар руу буцаж явлаа. тэнд очоод мөргүүдийг дахин анхааралтай үзээд хажуугийн цавчаал руу эргэж орлоо.

мөрч болзсон цагтаа чанга исгэрч дохио өгөв. Түүний исгэрэлтийн чимээ бүтэн б ээрийн тэртээ, цусан шалбааг байсан газраас өөр зүгт сонсдов.

Хошууч эрлийнхэнд хөдлөх тушаал өгөөд өөрөө өвгөн Пойндекстерын болоод бас нутгийн хэдэн баян хүний хамт зэрэгцэн явлаа. Харин эрлийнхэн удирдагч мөрчийн аймаар битүүлэг нээлтийг хэнд ч хэлсэнгүй.

XL. Тэмдэгтэй сум

Эрлийнхнийг ба тагнуулуудын гүйцэж очихоос өмнө нэг жижиг явдал болов. Хошууч хүмүүсээ цавчаал замаар оруулалгүйы шууд ой дугдуур авч явлаа. Хошууч энэ замыг сонгон авахдаа мөрчийн үзэж буйгаар хүүгийнх нь цус болсон цусан шалбаагийг өвгөнд үзүүлж , сэтгэлий нь шимшоүүлэхгүйг боджээ. Аймшигт газар хажуу талд хоцорч, мөрч хошууч хоёрын өөр хэн ч тэр тухай мэдсэнгүй, урагшилсаар байлаа.

Эрлийнхэн хоёр морьтой хүн арай гэж багтмаар тийм нарийхан зөрөг үамаар орлоо. ойн цагаалжид зам өргөсөн ирснээ, шугуй руу орохдоо дахин нарийсжээ.

Эрлийнхэн зам дээр дайралдах нэгэн ойн цоорхойп гэнэт нэгэн цоохор бар шугуй дотрос үсрэн гарч иржээ. Тийм сайхан цоохор бар халуун орны шугуйд ч ховорхон байдаг. Байгаль түүний шар арьстан сонин гайхалтай чимэглэжээ. Ойн чөлөөнд уяхан харайлтаар үсрэн гарч ирсэн энэ хүч чадалтай, хөнгөн шалмаг аварга цоохор муур хичнээн өөр зорилоготой, өөр юманд ахаарлаа чиглүүлсэнг нь эрлийнхний ажхаарлыг татахгүй хоёр удаа буудлаа.

Зассий Кохаун , түүнэй зэрэгцэн явсан залуу эзэн хоёр буудсан юмсанжээ.

Цоохор бар үэхтхийн унав. Су ууцны нь хуга буудсан бололтой. тэр хоёр хүний аль нь тийм сайн буудав? Колхаун залуу эзэн хоёр хэнхэн нь өөрийгөө тэр амьтныг буудаж алсан гэж боджээ. Хоёул зэрэг буудсан ч гэлээ нэг л сум оножээ. Колхаун мориноосоо бууж:

-Би та нарт үзүүлээд өгье гэж хэлээд бүснээсээ хцтга сугалж, хүмүүст хандаж- хэрэв миний сум оносон бол дээрээ “К.К” гэсэн миний овош, нэрийн эхний усэг, хагас сара тэмдэгтэй байгаа. Би сумаа захиалж хийлгэдэг болохоор алсан ангаа хэзээд таньдаг юм гэв.

Колхаун гаргаж авсан сумаа бардмаар дээш өргөу түүний хлэснэ нь үнэн болохыг амархан тааж болохоор байлаа. Хэрэгт дуртай хүмүүс сумыг сонирхон Колхауныг овог нэрийн толгойн үсэг үэнээр байгааг үзэж маргааш залуу эзэнд ашиггүйшээр дуусав.

Тэгээд эрэлчид, тэр дорхноо мөрчийн хүлээж байсан газар очиж, түүнийг даган цааш хөдлөв.

Энд хоёр тахтай морины мөр үл харагдана. Ганц морины мөр байвч зарим нь газраа мөрчөөс өөр хүнд ажиглагдамгүй ажээ.

Энэ мөр шугуй дундуур орж үе үе үе ойн чөлөөнд ил гаран, сүүлдээ, дугуйрч, баруун талд нэлээд холуур цавчаал за лээр гүйцэж явав.

Чу ямар морины мөр болохыг Спегшлер мэдэж байв. Энэ бол улиангарын дор зогссон эзэн нь ороомол навчин тамхи татаж байх хооронд цус бялдсан газар туурайнхай гүнзгий мөрийг үлдээсэн мустангийн мөр гэдгийг таньжээ.

мөрч ганцаараа байсан тэрхэн зуураа бас америк морины мөрөөр явжээ. Энэ мөр эрлийнхний ирсмэн замын дагуу тал нутаг тийш буцаад, дараа нь леон голын тэндэх суурин руу явснаас зайлаагүй байв.

Гэвч мустангийн мөр цусь явдлын нууцыг дэлгэхээр барахгүй, бас хүн алсан дээрэмчний ичээнд хүргэж өгнө гэж амлаж байх шиг санагдажээ. Гэвч энэ мөр нь бие биеийнхээ мөрийг гишгилсэн хоёр морины мөрөөс дутуугүй мөрчийг тэвдүүлнэ.

Хүн унаж явах үед морь явдаг шиг ердийн байдлаар чигээрээ яваагүй байв. мөр нь нэг үе тахиралдан , нэг үе жаахан эргэцэж , заримдаа шүлуун, тэгснээ бас дугуйрч мустанг нэг бол дээрэ хүнгүй , эсхүл унаж яваа хүн нь морин дээрээ унтчихсан вмуу даа гэж бодмоор байв.

Хүний аминд хүрчихээд хурдахн шиг алга болоод өгөхийг яарч багйаа гэмт хэрэгтний унасан морь ийм мөр үлдээнэ гэж байж болох уу?

Спегшлер инэгж бодсонгүй. Ерөнхийдөө ву болохоо ч мэдсэнгүй. Бүр толгой нь эргэж гүйцэн, мөрний тухай хошуучийн асуухадучры нь ойлгохгүй , багаагаа илээр хэлжээ.

тэгж байтал улдсан ч үгүй мөрчөөр барахгүй бусад бүхр хүний нүдний өмнө , нууцыг илрүүлэх нь бүү хэл, харин ч бүр тайлагдашгүй болгосон зүйо харагдах нь тэр.

Түүгээр ч зогсохгүй таавар байсан зүйл маань бүхнийг айлган айдас болон хуирчээ. Ямар ч үндэмгүйгээр ингэж айлгах гэж хэнч хэлж чадамгүй юм болжээ. хэрэв таш эмээл дээрээ хэнэггүйхэн суугаад дөрөөгөө лав жийэ, цулбуураа барьсан ,хальт харахад бусдын л адил морьтой байна гэж хармаар морьтой хүнийг харан улам лавшруулан ажигласан чинь нэг лер бусын и санагдан ахиулан хартал чинь толгойгүй юм гэж бодогдвол та айхгүй байх юм гэж үүдээ!

Яг л ийм юм эрлийнхний нүдэнд тусаж. тэд ёроолгүй харлах ангалын ирмэгт гэнэт тулгарсан юм шиг мориныхоо амыг зэрэг татан зогосв.

Наран хариугүй жагах шахаж, галан бөмбөлөг бараг өвсний үзүүрт зэрэгцэхээр доошилж учир эрлийнхний нүдийг гялбуулаад юм харах аргагүй болгож байв. гэлээ ч гэсэн нүдний өмнө илгарч ирсэн хачин жигтэй юм бол морь унасан толгойгүй хүн байхыг бүгд тодорхой харцгаалаа.

Хэрэв эрлийнхний нэг нь буслалаа морь унасан толгойгүй хүн харлаа гэж хэлсэн бол түүнийг шоолж, галзуу солиотой гэгцгээх байсан билээ. Бүр хоёр хүн хэллээ ч гэсэн солиотой гэх байв.

Гэвч цөмөөрөө зэрэг харсан болохоор эргэлзэхийн аргагүй бөгөөд харин хэн нэг нь үүнийг хараагүй гэвэл тэр хүнийг галзуу солиотоод тооцох байв. гэвч хэн нь ч үүнд эргэлзсэнгүй. Бүгд л нэг зүгт морь унасан толгойгүй хүн ч юмуу эсвэл чадамгайгаагр хийсэн чихмэлийн зшүг амьсгаа даран харцгаав.

Энэ асуулт бүгдийн толгойд үзэрэг оров. Тэгээд хэн ч хариу олоогүй учир цөмөөрөө таг чиг байцгаана. Цэрэг, харгуй цөм дуугаа хураан, хэний ч хариулж үл чадах тайлбарыг хүлээн зогсоно.

Гайхаж айсан дуу сонсогдож бус хэн ч таамаглал, тайлбар болчихоор үг дуугарсангүй. пХий

юм, бодит алин боловч морь унасан толгоойгү хүн тэднийг харах үед, цавчаал замын нөгөө үзүүрээс ирж явав. Хэрэв тэд чигээрээ яваад байвал, мэдээж хүлээх зүрх нь хүрэх юм бол тэдний чанх өмнөөс ирэх байлаа.

Гэвч тэднийг зогсохтой бараг зэрэг шахуу зогсон, мөн ч өөрсөдтэй нь адилхан үл итгэсэн байлдаар харж байх шиг санагдав. Чив чимээгүй болж өвөөн дээр тамхины их хаях хүртэл сонсдож байв.

Тэрхэн үед хамгийн зоригтой нэг нь сайхь аймаар морьтон руу харсан хэвээр байсан бөгөөд ихэнх нь айснаасаа дагжин харахтай, манатай болцгоосон байлаа. Тэр зориглож хэрсэн хэд нь орж багаа нарны туяанд гялбалзах эл битүүлэг дүрс чухам юу болохыг ойлгохын хичээнб айв. тэд зөвхөн дээрээ хүнтэй том биеьэй морины дүрс харж байв. хүний би? цувархуу юмаар ороосон учир сайн ялгаж харахад төвөгтэй байв.

Тэр хүн толгойгүйгээс л хойш энэ нь ямар хамаа байх өилээ дээ? морь унасан толгойгүй хүн эмээл дээрээ дэгжин нь аргагүй харагдана. Өсгийд нь давируул гялалзан, нэг гараараа цулбуураа барин, нөгөөгөө унжуулжээ.

Энэ чухам ву вэ? хий үзэгдэл үү? Амьд хүн ийм байж болох уу?

Үүнийг харж байгаа хүмүүс бол сүг , сүнс ад чөтгөр бадаг гэдэгт итгэдэггүй хүмүүс байлаа. тэдний олонхи нь хорвоо ертөнцийн хамгийн ал холын өнцөг буланд баж үзсэн, байгалийн хамгийн санамсаргүй гэнэтийн аймшиг үзэгдэлүүдтэйтулгарч, тэмцэлдэж явсан хүмүүс ажээ.Тийм хүмүүс ад чөтгөр байдаг гэдэгт итгэдэггүйюм!

Гэвч ийм хачин ер бусын үзэгдлийг харчихаад хамгийн ухаалаг, ззүрх зоригтой нь хүртэл түүний бодитой эсэхэд эргэлзэн “Энэ хий юм л байж таарлаа? Мэдээжээр яаж ийм хүн байж болох вэ!” гэж дотроо бодож зогсов.

Үүний нь батлах мэт өмнө нь байгаа нөгөө морь унасан хүн нь ид шидийн юм шиг харагдана. Жирийн хүн, мориноос хоёр лахин том харагдах нь санааных байж болох юм. Учир н халуу төөнөсөн тал дуугүүр долгилох агаар дунпуур тэнгэрийн хаяанаас шахуу нэвглэн тусч байгаа нарны хугарсан гэрлээс ийнгэж харагдсан байж ч болох юм.

Гэвч юун элдвээр тунгаан бодохтой манатай, тэр бүү хэл нүдэн сөрөг нарны гэрлийг саравчлан байж харлаа ч гэсэн сайтар харчихаар цаг зав байсангүй.

Түүний хувцасны өнгө, морины зүсийг ялгаж болохгүй байв. тэнгэрийн алтлаг дэвсгэр дээр хар бараан дшрс л харагдана. Аль талаараа тэдэн рү эргэлээ ч гэсэн нөгөө л хачин, яахын аргагүйы морь унасан толгойгүй хүн харагдана.

Энэ чухам ву вэ? Хий үзэгдэл үү? Амьд хүн үү? Амьд хүн ийм байж болох уу?

-Энэ чинь морь унасан чөтгөр байна! Ёстой чөтгөр юм! гэж ер ямар чюманд сандарч тэвддэггүй нэг хашир хилчин гэнэт дуу алдлаа.

Тэгээд муухайгаар инээд алдан, хараал тавьсана нь тэнд байсан хүмүүсийн хамгийн хулчгарын нуруунд хүйт даалган, морь унасан толгойгүй хүнд хүртэл нөлөөлөх шиг болов.

Өнөө хачин хүн мориныхоо амыг гэнэт эргүүлэн, морь нь үүрсэн янцгааснаа давхин одлоо.

Эл морь унасан толгойгүй хүн шууднарны зүг давхин, удалгүй гялбалзаан туяарах бөмбөлөг рүү орчихов уу гэлтэй бараа нь тасрав.

XLI. Дөрвөн морьтон

Тэр нэг учир явдалтай өглөө Инж цайзаас зөвхөн хошуучаар удирдуулсан нэг бүлэг хүн мордсон төдийгүй тэднээс хамаагүй эрт бараг үүр шөнийн дөрвөн хүн мордож, мөн л Нуэсес голыг чиглэн явцгаажээ.

Тэр дөрвөн хүн Генри Пойндекстерын эрэхээр гарсан нь юу л бол. Тэр үед Генри алагдсан гэж хэнч мэдээгүйы бөгөөд тэр ч байтугай түүнийг алга болсныг ч дуулаагүй байжээ. Унасан эзэнгүй морь муу ёрын мэдээг хараахан авчраагүй үе байв. Гэмгүй хүний цус урссаныг мэдээгүй суурингуудыхан бөх нойронд дарагдан байлаа

Хэдийгээр хоёр баг нэг газраас гаран нэгэн зүгт явж байаач гэсэн , хүмүүсийнх нь хооронд адилтгамаар юм байсангүй. Өглөө үүрээр мордсон хүмүүс нь испани ацтекийн цус холилдсон, өөрөөр хэлбэл мексикүүд байлаа.

Тэднийг мексик хүн гэж танихад нэг их мэдлэг, ажигч байдал хэрэггүй харахад л танигдаж байлаа. тэдний морь унаж ячваа байдал , өндөр эмэлээс нь болж улам ч сайн иэдэгдэх үөрмөсөн гуя, мөрөн дээгүүр дохсон серапэний нь хурцу өнгө, хилэн өмд, гутлынх нь өргөн давирлууд , толгой дээрх дэлбэгэр хар сомбреро малгай энэ бүхэн нь тэднийг мексик хүн буюу мексик зан заннулыг өөрийн болгосон хүмүүс гэдгийг илтгэнэ.

Гэвч тэр дөрөв яриагүй мексик хүүүс байв. хүрэн бор арьс , богинохон тайтгаруулсан хар үс, ширвээ хар сахал, гонзгойвгор царай- энэ бүхэн нь эртний Монтесумын газар нутагт одоо оршин сууж байгаа испани ацтек хүмүүсийн шинж байдлыг илэрхийлнэ..

Тэр дөрөвний нэг нь бусдаасаа илүү хүдэр яийрэг эр байв. тэр хүн хамгийн сайхан морь унаж, баян тансаг хувцас өмсөн, дөмөг хийцтэй зэвсэг агссан зэрэг бүс байдлаараа бусдынхаа ахлагч юм гэдэг нь илэрхий байв.

Болгинохон засуулсан томго сахал нь залуу харагдуулавч, тэр хүн дөч орчим настай ажээ. Хэрэв хэрцгий, танхай зан авирыг илэрхийлсэн барзайсан царай, хүйтэн зэвүүг харцгүй бол түүнийг сайхан эр гэж хэлж боолмоор

Яралзсан цагаан шүд гарган инээх нь хүртэл энэ бодлыг мартагнуулж чадахгүй агаад түүнд нь ямар нэг муу ёрын юм байх ажээ.

Түүний царай зүснээс болж нөхөд нь түүнийг Техасын талд алдартай араатны нэрээр нэрлэсэн бус ажээ. Зан авираасаа болоод л Эль-Койото буюу талын Чоно хэмээх нэг их хүсмээргүй хочтой болжээ.

Талын Чоно ийм үүүр цүүрээр нөхдөө дагуулаад тэгээд бас харваас цоо эрүүл саруул явж байдаг нь юу билээ? Хэлхэн цагийн өмнө урцандаа шал согтуу , хүн хүлээж авах нь бүү хэл, хүний хэлснийг ч ойлгохгүй байсанбиш шүү.

Ингэж гэв гэнэт хачин жигтйэ хувирчийхсан тайлбарлахалд хэцүү биш ээ. Колкаун тэднийхээс гарсан үеэс эхлээд... Талын Чоно болон гурван өнөхрртэй нь бидний уулзсан үе

хүртэл болсон явдлыг яриихад л хангаллтай. Колхауны явахдаа хаагаагүй орхисон урцны хаалга өглөө болтол онгорхой чигээрээ байжээ.

Талын Чоно үүрээр даарч жиндэн сэржээ. ийнхүүдпаарсан нь түүний архийг жаахан гаргажээ. тэгээд орноосоо сугаран босч, урц дотуураа гуйвлан явж хүйтэн жавар оруулсан хаалгаа хараан зүхэв.

Түүнийг хаалга хаах нь гэж бодмоор. Гэвч хаасангүй Хуучирсан хананых нь ан цавыг эс тооцвол хаалга нь гэрэл оруулах ганц нүх сүв байлаа. Боссон зорилгоо биелүүлэхэд нь гэрэл хэрэгтэйбайв.

Онгорхой хаалгаар тусах үүрийн цагаан гэгээ урцыг маш бүдэг гийгүүлнэ. Талын Чоно эргэн тойрноо бүдчин тэмтэрч, хайж яваа юмаа олтлоо хараал урсагсаар байв. дундуураа суран бүслүүртэй ,хоёр нүх гаргасан хулуун дамшиг нь ус зөөдөг сав боловч ихэвчлэнг архи хийдэг ажээ. Дажмагийн бөглөөг авмагц ханхийх үнэр нь саявтар архитайы байсныг илтгэнэ. Гэвч эзэн хүний элдвээр хараал тавихыг сонсвоос одоо болтол хоосон байгаа нь илт.

-Цусаар олгойд! Гэж Талын Чоно үнэхээр юу ч байхгүйг шалгах мэт дажмага сэгсрэн цөхөрсөн ууртай дуугаар хашгираад - Дусал ч юм алга шүү! хэл ч норгох юм алга. Ам хатсаныг яана. Хоолой минь улаан цог залгачихсан юм шиг хатуу оргиж байна. Чөтгөр аваг! Тэсэхийн арга алга. Яах билээ? Гэгээ гарчихлаа. суурин руу явах хэрэгтэй. Эрхэм Доффер үүрийн шувуухай барих гэж арын хаалгаа нээчихсэн дээ. хэрэв тэгсэн бол талын Чоно айлчин нь болж болноо доо! гэв.

Талын Чоно дашмагаа хүзүүндээ зүүгээд, алхмын зайтай голын цаад эрэгт учир тэрээр нүдээ боолгоод ч оччихоор үамаа сайн мэддэг ажээ. хорин минутын дараа гэхэ “Үдлэх газар” гуанз руу гуйвалзан хүрэв.

Аз болж Обердофер мухлагтаа байж байлаа. тэр, унтаж босоод хоолойгоо норгох гэж хуарангаас сэмхэн гарч ирсэн өглөөний зочин хэдэн цэрэгт ыаарандаа үйлчилж байв.

-Бурхан минь, Диас гуай шив дээ! гэж буудлын эзэн зээл ууж байсан, зургаан зочноо хайхралгүй бөөлнээр төлдөг нь болж ганц хүний тулд нөгөөдүүлээ орхчихоод -Та бас ийм эрт босдог юм аа? таны юу хүсч явааг ч мэдэж байна. дашмагаа нөгөө мексик архиар, аг... аг... юу гэдэг билээ дээ, нөгөө архиараа дүүргэх гэж явна уу?

-Агвардиенте гэдэг юм. та таачихлаа, эрхмээ.Энэ чинь яг л миний хүссэн юм даа.

-Нэг доллар. ганцхан долларын үнэтэй.

-Чөтгөр аваг! Би үний нь мэдэхээр олон авсан. Май мөнгө сав хоёр энэ байна. Бушуухан дүүргээл өгч үз.

-Диас гуай яарч байна уу ? Би таныг хүлээлнэхгүй. та зэрдэг адуу барихаар мордохгэж байна уу? Танаас урьгаад өнөөх ирланд очихсон байх гэж айж байна. тэр, манай буудлаас шөнө дундаас хойш явсан шүү. Морис Жеральд ч хаяин хүн дээ! хэн ч хэзээ ч түүнимий яах гэж

байгааг ер мэддэггүй юм. Гэхдээ би л түүнийг муу хэлж чадахгүй. Миний сайн зочин байсан юм. хамар өр ширээ баян хүн шиг төлчихсөн. Цаана нь зөндөөн юм үлдсэний нь яана. Өвөр түрий нь доллараар дүүрэн байна лээ!

Мексик хүн Обердоферын ирланд эр “мустангерийн тар руу” явсан гэсэн яриаг ихэд сонирхожээ. тэгж сонирхож байгааг хэлээд аяархан дуу алдахаар илэрхийлэн байснаа сүүлдээ тэсгэлгүй бүх хөдөлгөөнөөрөө байж ядан гаргаж байна.

Гэвч энэ байдлаа мэдэгдэхгүйг хичээнэ. Обердоферын асууж лавлахын оронлд хааш яаш байдлаар хариу хэлж.

-Эрхэм минь, энэ надад хамаагүй. Тал нутагт мцустанг зөндөөн бий. Анчин бүрт хүрэлцэнэ. За эрхэм минь, миний агвардиентийг бушуухан өгнө үү гэв.

Хов үг яриулаагүйд нь гомдсон герман кашмагт нь бушуухан архи хийж эхлэв. Тэгээд цаашярих гэж оролдогүй, дашмагтай архий нть мексик хүнд өгч, доллараа аваад мөнгөтэй хайрцаг руу чулуудсанаа, зээлээр ууж байгаа учир овоо яриа хөөрөөтэй болсон цэргүүд рүү очив.

Диас ам нь цангаж байсан боловч дашмагынхаа бөглөөг авсангүй бүр түүнийг мартчихсан юм шиг гарч одов. Архи уух гэсэн их дур хүслээсээ илүүгээр ямарнэг юманд ссэтгэл нь хөдөлсөн ажээ.

Тэр гэр лүгээ шууд явалгүй суурингийн захалд байдаг өөртэй нь адил хөнгөн олзонд дуртай гурюан эрийн урцаар орчихоод дараа нь овоохой руугаа явжээ. Буцаж явахдаа талтай морины мөр байхбг ажиглаж, урцынх нь хажууханд моднооё уясныг мэдэв.

-Карамба! Америк ахмад шөнө энд иржээ. Чөтгөр аваг! Би нэг бүрэг бараг юм санаж байна, зүүдэн дунд харагадх шиг болсон. Яах гэж энд ирснийх нь би тааварлаж бөайна. Тэр морисын явах гэж байгааг мэджээ. Намайг унтсаар байгаа гэж бодоод бас дахиад л ирнэ дээ, ха-Ха! тэргүйгээр хамаг хэрэг бүтнэ. Түүний хойшдын заавао надад хэрэггүй. мянган долоар! Мөн ч аз шүү! мөнгөө авангуут л Рио-Гранд руу явна. Тэгээд исидоратой эвлэрэхийг оролддог хэрэг.

Ийн ганцаараа яриад Талын Чоно овоохойдоо орон хэвэн хэрчим шарсан мах санд мэнд үмхэж, хойноос нь агвардиенте сэнгэнтэл залгиж дарууллаа. тэгээд идшилж байсан морио барьж эмээллэн, хөлдөө том давхируул хиж , жижиг карабын буу ганзаглаад, гар буугаа гэрэнд н хийж, бүсэндээ хутгаахавчуулж, мориндоо харайн мордоод давхиж одлоо.

Талын Чоно тал руу гарахынхаа өмнө суурингийн зах руу очиж, түүнийг дагалдан , нэгэн нууцлаг хэрэгт тус болохоор урьдчилан тохиролцсон гурван нөхөртэй нийлэв.

Тэр гурав нь түүний төлөвлөгөөг мэдэж байгаа бололтой. юутай ч гэсэн тэд Аламод очиж хэрэг үйлдэхээ мэдэж байжээ.замд гарсны дараахан Диас хажууу тийш эргэж явахад буруу замаар орчихлоо гэж нөхөд хашгирлаа.

-Би Аламог сайн мэднэ тэнд олон удаа очиж ав хийж байсан юм. тэр газар эндээс баруун урагшаа бий. тийшээ явах хамгийн дөт үам бол тэр цавчаал замыг дайрч гардаг юм. Эрхэм Мигуэль та дэндүү буруугаар эргэчихлээ гэж нэг мустангер хэлэв.

-Тийм бий гэж Диас тоомжиргүй дуугараад - Эрхэм Висенте Барахо та америк хн байж таарах нь ээ. Бидний морьд тахтай гэдгийг та мартаж байна. инланууд инж цайзаас шууд Аламо руу явахгүй... Та миний үгийг ойлгож байна уу? гэв.

-Таны зөв! Уучлаарай дон Мигуэл. Чөтгөр ав! Би энэ тухай бодсонгүй гэж Барахо хэллээ.

Тэгээд дахин олон таван юм ярилгүй, гурван нөхөр нь үг дуугүй түүний хойноос явлаа. Барахогийн хэлсэн цавчаал замаас хэдэн бээр газар явглаа бараг дуугарсангүй.

Ойн дунд ормогц дөрвүүл мориноос бууж мориноос уяцгаагаад ажилдаа орлоо. тэр нь хөдөөгийн театр зэрлэчүүдийн амьдралыг харуулсан жүжгийн өмнө хөшигний ард бэлддэг шиг л юм байв.

ХЛЦ. Нөмрөг тас эргэлдэж байна

Тал нутгийн дээгүүр хар атсын сүрэг эргэлдэн нисэх нь өмнөд

техасын ердийн үзэгдээл бөгөөд үүгээр явсан хүн хэн боловч ийм үзэгдлийг үзсэн нь мэдээж.

Хэдэн зуугаараа сэрэглэсэн тас нэг үе том цагариг болон нэг үе мушгиран эргэж, заримдаа өвс ногоо буюу модны оройд хүрэх шахуу доошилж, заримдаа далавчаа хөдөлгөлгүй дэлгэн гэнэт дээү хөөрнө. Тэдний бараан хоншоорт дшрс тэнгэрт тодхон харагдана.

Энэ үзэгдлийн анх харсан хүн тэр шувуудыг сайн ажиглах гэж өөрийн эрхгүй морины амыг татаж зогсдог. Тэрчлэн тасын сүргийг үзэж хансан хүн ч гэсэн тэр шувуудыг юунд хуран цугларсан юм бол гэж бодохгүй өнгөрдөггүй.

Энэхүү ёсрын шувууд хар аяндаа тэгж эргэлддэггүй :. Аяны хүн харсан ч бай, хараагүй ч бай, махчин гувууд дээгүүр нь эргэлзэж байга яг тэр газар үхсэн амьтан ч юмуу, эсвэл хүүр ч юмуу , амь тавьж байгаа хүн ч хэвтэж байгааг мэддэг юм.

Гурван морьтой хүн тал хөндийг гаталсан тэр нэгэн гунигт шөнийн дараахь өглөө тэдний орсон шугуйн дээгүүр тасын сэрэг хэрхэн эргэлдэж байгааг хэрж болох байв. энэ нь нөгөө цавчлаад зас тохойрсон тэр газрар байлаа. Энд үүрээр ганц ч шувуу үзэгдэхгүй байжээ. Гэтэл нар мансданы дараа цаг болоход далавчаа ал ь байдгаараа нь дэлгэсэн хэдэн зуун нөмрөг тас бужигнан нисч, тэдний хар сүүдэр тодхон ногооной шугуйн дпээр тусч байв.

Цавчлаад ирсэн Техаст хүн бол эл ёрын сүзргийг хараад энд нэг л үхэл болж дээ гэгийг шууд гадарлах байв.

Жаахан цааш явбал үүнийг нь баталсан зүйл болох морин туурайнд гишгэгдсэн цусан шалбаагийг харах байлаа.

Гэвч махчин шувуул яг тунасан цусан дээр эргэлдсэнгүй. Тэндээс нэлээд зайтай модон дотор л тэдний сонирхолыг татасан олз байгаа ыбололтой тойрон эргэлдэнэ.

Ийм эрт үүний үнэн худал шалгачихаар нэг ч техас, нэг ч өөр хүн байсангй. Тэглээ ч энэ бол үнэн зүйл байлаа. Цусан шалбаагнаас дөрвөн бээрийн зайтхай ой дотор, нэ хүн хэвтэж байна. Үхсэн хүн юм болов уу?

Халыт харахад шүхсэн юм шиг харагдана. Хар тасууд ч мөн тэгж бодсон нь илт. хөдлөхгүй, хэвтэж байгаа байдал нь үүнийг гэрчилнэ.

Толгойгоо гэдийлгэн, дээшээ харчихсан нарнаас нүүрээ сүүдэрлэх ч үгүй хэвтэж байв. хөл гараа захирч чадахаа больчихсон юм шиг чулуутай газар тэрийн хэвтэх ажээ.

Хажууханд нь байгаа том царс мод түүнийг сүүдэрлэсэнгүй. Түүний духыг дөнгөж халхал

далбагар цагаан малгайнаас нь болж улам ч цонхигор харагдах нүүрий нь дөнгөж тусаад байгаа нарны туяа гэрэлтүүлнэ.

Энэ үхсэн хүн үү? Эсвэл үхэж байна уу?

Таснуудыгн айшилжэ аяглаж байгаагаар бол түүнийг үхсэн гэж бодож болмоор. гэвч энэ удаа шувуудын зөн ташаарчээ.

Нарны туча хагас аньсан зовхин дээр нь тэсч сэрээснээс юмуу, аль эсхүл амарсандаа дахин хүч орохдоо ч юмуу, гайхан харлаа. Таснууд тохой дээрээ гэгч хөөрөн, нэг хэсэгтээ доошилсонгүй.

-Би чинь үхээ юу, эсвэл амьд байна уу? Үнэн явдал уу эсвэл зүүдэлж байна уу? Энэ юу болж байна вэ? Би хаана байгаа юм бэ? гэж тэр залуу шивэгнэлээ.

Нарны гэрэл нүдий нь гялбуулаад, гараараа саравчлахгүй бол юм харахын аргагүй байжээ. саравчлан харахад нь юм бхэн манан буданг дотор байгаа юм шиг харагдав.

Удалгүй тохой дээрээ гэгч хөөрөн, нэг хэсэгтээ доошилсонгүй.

-Би чинь үхээ юу? эсвэл амьд байна уу? Үнэн явдал уу? эсвэл зүүдэлж байна уу? Энэ юу болж байна. Би хаана байгаа юм бэ? гэж тэр залуу шивэгнэлээ.

нарны гэрэл нүдий нь гялбуулаад, гараараа саравчлахгүй бол юм харахын аргагүй байжээ. смаравчлан харахад нь юм бүхэн манан буан дотор байгаа юм шиг харагдав.

Миний дээр эргэн тойрон мод... дор минь чулуу ... тэгээд бүх яс өвдөх нь аргагүй юм. Ойн төгөл... бодсондоо хэлээд- Би толгойгоороо мод мөргөсөнгүй. Эмээлээс минь унагсан мод энэ байна. Зүүн хөл өвдөөд байх чинь.

Өө тийм, моднод шүядуулчихсан л даа, одоо л саналаа. Чөтгөр ав, хугарчихсан юм шиг байна гэв.

Залуу босох гээд чадсангүй. Булгарсан ч юмуу, няцарсандаа болоод өвдгөөрөө хавдчихаад гишгэж болсонгүй.

-Нөгөө хөө хар морь минь хаа байна? Яваад өгч дээ. Одоо тэр хэдийн

Каса -Дель-Корвосаравчинд байж байна. Ер нь тэгээд ямар ялгаа байх вэ дээ Хажууд минь зогсч байлаа ч гэсэн би мордож чадахгүй юм чинь... гэснээ -- харин нөгөө дөх? Ээ, бурхан минь, юу ч гээс нүдэнд харагдсан юм бол? Морь үргэсэн нь гайхалтай биш... Би яадаг билээ? хөл хугарсан байж таарна. Хүний дэм авахгүйгээр би байрнаасаа хөдөлж чадахгүй. Энд ямар нэг хүн хүрээд ирнэ гэж горьдохын гарз. Энд ямар нэг хүн хүрээлд ирнэ гэж гоьвдохын гарз. Ямар ч байлаа гэсэн эн ерын шувуунуудын олз болохоос нааш ирэхгшүй дээ. Ямар бузар амьтан вэ намайг бүр идчих гэж байгаа юм шиг хошуугаа сунгаснб нь хараач!...

Би энд удаан хэвтээ юм болов уу? нар нэг их дээр хөөрөөгүй л байна. Лав л цаг хяраатай

ухаангүй хэвтээ биз? Чөтгөр ав, бүтэх юм алга... Өвдөж байгаагаар нь үзвэл, хөл ч яриангүй хугарч дээ. гэтэл энд мэс засалч байхгүй. техасын шугуй доторхи чулуун хэвтэр ... эргэн тойрон олон бээр үргэлжилсэн их шугуй бий. Эндээс өөрөө явна гэж огт бодолтгүй. тэгээд бас энд хэн ч итэхгүй. газарт чоно, тэнгэр т тас... тэгээд бас жолоо цулбуур байдаггүй шүү.. гэж харамсав.

Залуу эрийн царай гунигтай болов. Өөрийнхөө аюултай байдлыг ухамсар тусам улам улам гунигтай болж байдаг.

Дахин босох гэж оролдоод арай чүү гэж бослоо. Гэтэл зөвхөн нэг хөл нь хөдөлж, нөгөөх нь гишгиж болохгүй байв. дахиад л хэвтэхээс өөр арга байсангүй. Энгээд хоёр цаг хяраатай хөдлөлгүй хэвтлээ. Тусламж эрсэн түүний дуу ойд үе үе цууриатна. Тэгж хашгирахы нь хэн ч дуулахгүй байна гэдэгт итгэтлээ хашгирсаар дараа нь дуугүй болов.

Хашгирсаар байтао хоолой эь хатаад ам нь жигтэйхэн цангажээ. ийм байдалтай хүн заавал цангаж таарах нь мэдээж. Мэдээ мэдрэл алдаж, хөлийнхөө өчнийг ч мэдэхгүй болтлоо цангажээ.

-Хэрэв энд л байх юм бол харангадааж үхнэ. Хамаг хүчээ шавхаж усанд хүрэххэрэгтэй. Эндээс холгүй горхи байх ёстойсон. Мөлхөж яваад ч болсон, дөрвөн хөллөж байгаа д очиих юмсан. Тэгэхээр ганц өвдөг дээрээ л тулах хэрэг гарах нь ээ дээ... Ямар ч байсан оролдоод л үзье гээд шивнэснээ

-Энд хичнээн удвал төчнөөн муу юм болно. нар шарж эхэллээ. Толгой дүүртэл төөнөж байна. Ухаан алдаж ч болно. тэгвэл чоно, тас... гэж ганцаараа ярин хэвтлээ.

ийм аймшигтай юм бодсондоо татвасхийн дуугаа хураав.

Жаахан байснааснаа дахин

-Замы нь мэддэгсэн болоосой! Тэр горхийг сайн санаж байна. Эндээс баруун өмнө цэрдэн тал руу урсч байх ёстой. Тэр зүг мөлхөхийг оролдьё. Аз байвал одоо нараар чигээ баримжаалж бололх юм. хэрэвусанд л амжаад хүрчихвэл бүх юм аятайхан өнгөрч болно. тэнхээ л хүрээсэй билээ! гэж дуугарав.

Ингэж хэлэнгүүт мөлхөж эхэллээ. Шархтай хөлөө чирэн , чулуурхаг хөрсөн дээгүүр нуруу нь бэртсэн аврага том гүрвэл мэт урагшлалаа.

Мөлхсөөр , урагшилсаар л ... Энэ нь хэдийгээр зүдүүртэй ч , цааш улам зовлонтой юм болно гэж бодохооё өөрийн эрхгүй зүтгэсээо байв. хэрэв ус л олохгүй бол, цангаж үхнэ гэдгээ сайн мэдэж байлаа. Энэ нв түүнийг урагш нь түлхэж байв.

Байсгаад л зогссон, амарч хүчээ сэлбэнэ. Нэг хөл н хугархай. тэгээд дөрвөн хөллөн мөлхөнө гэдэг хэцүү байх нь мэдээж,

Өвдөж эмзэглэхээсээ болж хүчээ сэлбэнэ. Нэг хөл нв хугархай. тэгээд дөрвөн хөллөн мөлхөнө

гэдэг хэцүү байх нь мэдээж.

Өвдөж эмзэглэхээсээ болж удаан урагшлуулна. Зөв зшг рүү нь явж чадаа болов уу? гэж бодохоос улам ч зовуурьтай. зөвхөн үхлээс айх аюул түүнийг замаа үргэлжүүлэх хүргэнэ.

Шархтан нэлээд хол газрыг ийнхүү мөлхсөнөө гэнэт санаанд нь өөр аргаар урагшлуулж болох юм гэсэн бодол оров.

“хэрэв таягтай бол би босч чалдна... Бурхны аврал,хутга минь гээгдсэнгүй!... Энэ залуухан царс л яг таарах юм байна.”

Бүснээсээангийн хутгша сугалаад зулаган модыг тайрч, таяг маягийг юм хийгээд ацанд нь сугаараа тулж болохтой болголоо.

Залуу эр суга таягаа тулан босоод цааш явав.

Үшгээ алдах нь хамгийн аюултайг мэдэх учир түрүүчийнхээ адил баруун өмчийг чиглэн хазагнана. Энэ нь тийм я амархан юм биш байв. түүний ганц луужин болсон нар дээр хөөрчээ. Жилийн энэ улиралд Өмнөд Техасын өргөрөгт үд дундын нар чанх дээр шахуу байдаг билээ. Бас битүү ургасан бут сөөгийг тойрон, завсар заальхайгаар нь явах хэрэгтэй учир зүггүй нь будиантуулж нь явах хэрэгтэй учир зшгий нь будлиантуулж байв. зарим үед газрын газдаргуугаар зүгээ барина. Учир нь горхи судаг даган урсдагийг мэдэх ажээ.

нэг жаахан урагшилсанаа зогсон амсхийхээсээр бээр хяраатай зам туулаад, ан амьтан цувдаг бололтой зөрөгт тулж очлоо. Балархай шахуу ч гэсэн харваас ямар нэг булаг юмуу, усанд хүрдэг бололтой шулуухан явсан байв.

Усанд л хүрч байвал ямар нь хамаагүй учир, нөгөө нар, гадаргуугаас чигээ барихаа орхичихоод амьтны зөргөөр урагшлав.

Таяг тулж явах нь дэндүү зүдэргээтэй учир байсгээд л анхныхаа аргад шилжин дөрьн хөллөн мөлхөж явлаа.

Гэвч удалгүй баярласан сэтгэл нь цөхөрлөөр солигдов. Зөрөг нь тал талаасаа шугуйгаар хүрээлэгдсэн ойн цоорхойд ирээд аога болжээ.

Залуу эр амьтны ус уудаг газар нь энд биш, зөргийн нөгөө үзүүрт гэдгийг ойлголоо.

Энэ ньхичнээн хүнл цохилт болсон ч байж явахаас өөр арга байсангүй. Ойн цоорхойд үлдэнэ гэдэг амиа хорлохтой адил байв:.

Тэгээд зөргөөрөө буцан гэлдэрч, анх орж явсан газраа өнгөрөв. Цангахын зовлон түүнийг урагш нь түлхэх, эцсийнхээ хүчийг шавхавч улам улмаар тамир нь барагдаж байлаа.

Түүний дундуур нь зүтгэн гарч буй модны гарч буй модны ихэнх нь аршийн нудрага зуун наст холилдон хуайс учир үдийн нарыг халхалж чадахгүй бөгөөд сиймхий навчин дундуур тусах нарны гэрэд төөнөн шарна.

Хамаг хөлс нь цувж, ам нь цангаж сүүлдээ тасашгүй болж ирэв.

Мескито хэмээх өргөст ургамлын шүүслэг жимс байн байн нүдэнд нь тусна. Гара сунгаад л гүйцээ. гэвч энэ нь дэндүү нялуун учир цангаа гаргахгүй гэдгийг залуу эр мэдэж байлаа. Зуун анст, аршийн нударганы гашуунм шүүс ч бас тус өолохгүй.

Ядралын туйлд хүрч, бэртсэн хөл нь бүр хөлдлөхөө байв. Ихэд хавдан., гишгэн тоолонд нь гол тасратал өвөнө. горхи бөбайлаа ч гэсэн тэнд хүрэх тэнхээ байна гэж үү дээ? хэрэв чадахгүй бөөл , үхэл нь ирлээ гэсэн үг. Ганцхан үлдсэн юм нь шугуйн дунд яг энд хэвтээд үхэх л байлаа.

үхэхээ хүрэхээр бас ч тийм амархан биш. Юмны мөргөсөн толгой, бэртсэн хөл нь тэсэхийн аргагүй өвдөж байгаа ч гэсэн энэ үхлийн шархбиш гэдгийг мэдэж байв. Түүнийг хамгийн их аюултай зовлонтой зхэл хүлээж байгаа бөгөөд тэр нь цангаж тарчлан үхэх байлаа.

энэ бодол эцсийн хүч гаргахад хүргэв. Хэдийгээр маш их зүдэрсэн удаанаар урагшлавч, үхэн хатан тэмүүлсээр л байлаа.

Харин хар тасууд түүний дээгүүр ойртох ч үгүй холдох чүгүй эргэлдэнэ. Бээр илүү газар нь нь ч хоцролгүй даган, харин ч олон болсон байв. Олзны үнэнээр өөр шувууд ч нийлжээ. Хэдийгээр золиосонд гарсан эр одоохондоо хөдөлж байвч, мөдхөн дуусна гэдгийг зөнгөөрөө мэдэх ажээ.

Шувуудын хар сүүдэр байн байн үархтны гэлдэрч буй сөрөг дээр тусна.

Эргэн тойрон нам гүм Олзонд шунасан таснууд ч дуу гаргалгүй эргэлдэнэ. Төөнөн байгаа наран, тэлхий, царцаануудыг нозооруулж, мөнгөлөг гүрьэл чулуун дор нойрсоно.

Хувцас нь өргөст ургамалд тээглэн шархийтэл ургадах чимээ, тэр хүний тусламж эрж, дэмий хашгирах дуу л энэ ойн чимээ аниргүй байдлийг эвдэнэ.

Аршийн нудрага болон зуун насын өргөс түүний гар нүүрийг уран цус хөлс нь хоёр нь нийлэн урсана.

Тамир тэнхээ нь бүрэн алдарсан шархтай хүн цөхрөнгөө бардагаа барчихаад амь аврагдах аргагүй нь гэж бодоод түрүүлгээ харж газар унав.

Гэтэл энэ нь түүнийг аварчээ. газарт ойчиходд чихээрээ дэрлэн хэвтсэн учир арайхын ялгагдах сулхан шоржигнох чимээ сонсжээ. хэдийгээр энэ чимээ хачин сулхан байсан ч түүний тэсч ядан хүлээж бөайсан тэр чимээ усны шоржигнон урсах дуу гэдгийг таньжээ.

Баярласандаа дуу алдан таягаа тулж босоод, шин хүч чадал орж цааш явлаа. Өвчтэй хөл нь хүртэл сайн гишгэж ббайх шиг санагджээ. Амьд явахын хүсэл зоригь үхлээс айх сул кантай тэмцэлдэж байлаа.

Амьд явахын хүслэг дйиллээ. Арван минутын дараа болор уст горхины дэргэд, зүлэг ногоон дээр тарайж хэвтээд, энэ жирийн нэг цангаа түүнийг яаж тиймм аюултай гамшиг зовлонд

учруулсаыг ойлгож ядан байв.

XLIII. Мустангерийн овоохойд

Мустангерын овоохой руу шагайж харцгаая. Түүнгий үнэнч зарц нь овоохой дунд мухар сандал дээр сууж байна. Нохой нь голомтынхоо өмнө халуун үнсэнд хоншоороо шаан хэвтжээ.

Хүн нохой хоёр нөгөө л бахь байдгаараа байлаа. Гэвч урцанд өөрчлөгдсөн юм байв.

Мустангерийн арьсан хаалга нв Өнөөх мустахнгийн арьсан хивс, бүдүүлэг ширээ , ор, хоёр, мухар сандалд, Фелимийн унтдаг адсага хуучнаараа л байна.

Гэвч хананд өлгөсөн буу, мөнгөн цом , анчны урам алга байлаа. Эмээл, хазаар цулбуур , серапэ бас алга. Номнууд , бэх, цээс нэг тийш алга болжээ.

Урцы нь индианчууд тоночихоо юу даа гэж бодмоор Гэвч үгүй гэдэг нь илт. Хэрэв тийм юм болсон бол Фелим сандал дээгээ ийм амгалан дүртэй суугаа л үгүй, толгойд нь даахирсан шар шсэнд үлдээ ч үгүй байх байсан биз.

Хэдийгээр хананд өлгөөтэй зүйлийг хураасан боловч тэр нь урцан дотроо зөвхөн байраа өөрчлөн өөр газарт л байгаа нь тэр. Шалан дээр сураар багласан хэдэн боодолтой юм хөглөрсөн дунд нь нь ширэн авдар харагдаж бай. Харваас нүүдэлд бэлдэн юмаа янзалжээ

Хэдийгээр бүх юмаа ийнхүү янзалсан ч архитай лонх нь булан дахь байрандаа хуучин хэвээрээ байж байна. Фелим овоохой доторхи юм бүхнээс илүү тэр лонхыг байн байн хэр жсууна. Тэр хаашаа ч харсан удган модоор ёулжин хийсэн сагс дотрхи хорхой хүргэсэн сав руу нүд рүү нь үргэлж тусна.

-Ээ нандин эрдэнэ минь, чи энд байгаад л байна уу? гэж Фелим лонх руу лав хорь лдахин харан хэлээд

-Чиний сайхан ходоодон дотор хоёр кварт илүү юм байдаг. Тэглээ гээд чамд ямар ашиг байна?т Харин аравны нэг хувы нь миний ходоодонд орчихвол хоол шингэхэд муугүй л болох вий? тийм биз дээ. Тара? Хөгшин нохой минь сонсоод өндийж, өөн нь юу хүссэнийг асуух мэт эргэн тойрон харлаа.

Тэгээд зарц өөрөө өөртэйгөө ярьж буйг ойлгоод дахин хэвтээд өгөв.

-Найз минь хариулахгүй байж ч болно. Би түүнийг чинь мэдээж л байна. Ганц аяга явуулчихвал ямар сайхан байхсан бол? харин эзнийг тэгж хэлснээс хойш би дуслыг ч ууж зүрхлэхгүй. Би өнөөдөр энэ юмнуудыг эмхлүүлж , баглаж ядарч гүйцлээ. наалддаг гоёу балгачихсан юм шиг хэл минь хатаж тагнайдаа наалдчихлаа. лонхонд хүрэхгүй гэж Морис гуай ам өчиггүй минь авсан нв ямар хэцүү хэрэг вэ? Энэ архи тэгээд хэнд хэрэгтэй юм бэ? Сууринаас буцаж ирээд энд ганцхан орой хоёр кварталыг уучихгүй шүү дээ! хэрэв түүнтэй нүгэлт Стумп өвгөн цуг ирэхгүй бол ... Тэр архичинг чөтгөр авасай билээ.

Шунаг уухы нь яана! Бурханы аварлаар ганц санаа амарсан юм нь Баллибаллахдаа л буцна

гэдэг байна. тэгвэл ч ёстой энэ америк сувсны оронд жинэхэн ирланд вискигээ ууна даа. Зөвхөн ингэж бодоход д сэтгэл ханаад ухаан алдмаар болох юм! Мөн сайхнаа! Ура! Ура!

Сайхан мөрөөдөлдөө автсан ирланд эр эсгий бүрхээ тааз руу шидэн хэдэн удаа “ура” хашгирав. Тэгээд жаахан тайвшрав бололтой Баллибалахад түүнийг хүлээж байгаа баясгалант явдлыг сэтгэлээрээ үзэх мэт хэсэг зуур чимээгүй суув.

Гэвч төдийгүй суув.

Гэвч төдлгүй мөрөөдөл нь бахтй байдгаараа урц руу эргэн өнөөх хорхой хргэгч олнх байгаа булан руу эргэж, ирланд хүний нүд тэр зүг шилэнгэтэн тэмүүллээ.

-Нандин эрдэнэ минь! гэж Фелим лонх руу хандаж хэлээд, Чи ч дэндүү сайхан юм даа. Би часайг ганц үнсээд авбал, чи намайг хэлчихгүй бөиз? Ганцхан үнсэнэ шүү? Үнэсэхэд муу юм юу байгаа юм бэ? Боодол баглаатай ноцолдсоны минь бодохлоороо эзэн мэдлээ ч гэсэн юм хэлэхгүй н Би хичнээн тоос шороо залгив даа! За тэгээд, сүүлд нв бид явж байгаа ыолохоор намайг хэлсэн амангдаа хүрч байна уу? гэдгийг тооцох зав гарахгүй. Замд гарахдаа хоолой норгохгүй бол цаашид хожимдож байна. санаанд янз бүрийн юм ороод байхаар нь жаахан баолгачихсан юм гэж түнд хэлнэ мэдээж вм хэлэхгүй дээ. Би дөнгөж жаахан үнэрлэнэ тэгээд юу л болбол болог, ... Хэвт тара, би хаашаа ч явахгүй гэв.

Фелимийг үүд рүү явахыг хараад нохой нь өндийв. Тара, Фелимийн санааг ойлгосонгүй. Фелим эзнээ ирж санаж бодсон юманд нв саад тотгор болчих вий гэж харахаар гарчээ. юу ч харагдахгүй болохоор нь бушуухан буланд очиж, лонхны бөглөөг мултлаад, уруулдаа хүргэж “балга” байтугайг уув! Тэгээд лонхоо байранд нь тавиад эргэж сандал дээр суулаа.

Тийнхүү зэгсэн удаан сууснаа, тара, лонх хоёрт хандан, бас л өөртэйгээ ярьж гарлаа.

-Эзэн ирэхгүй яагаад ингэж их удаж байгааг ойлгохгүй байна. тэр өглөөний найман цаг ирнэ гэж хэлсэн. Гэтэл Техасын нар л буруу яваа юм ыбиш бол одоо оройн зургаан цаг болж байна. лав түүнд ямар нэг саад тохиолдож дээ ... Тара, чи юу гэж бодож байна?

Энэ үед тарын хамарт үнс орчихсон тл түүний хэлсэн үгийг батлах мэт утггив.

-Гэгээн Патрик! Ямар нэг юм тохиолдоогүй байгаа даа? тэгэл бид хоёр яана даа? , Тара? Ээ, муу хөгшиж нохой минь дээ! тэгвэл бид Баллибалахад мөд очихгүй шүү. Эзний хэрэгтэй хэрэггүй юмыг л худалдах болдог байгаа даа? Цэвэр мөнгөн цом л ганцаараа бидний замын хөлсийг даачихна. Чөтгөр аваг! Би чинь тийм гоё савнаас хэзээ с уугаагүй юм байна! Уухад бүр ч сайхан байх. Амсаад үзье, яг л одоо уудаг цаг гэснээ авдарснаасаа цом гарган, лонхтойгоо хийгээд ганц хөнтрөөдп архины чанга сулыг үзэж байгаа юм шиг уруулаа долоосноо, нэг гартаа үзэж нөгөөдөхөө цом барьсан хэвээр- Ер нь лонхноос нь уусан амттай шүү дээ. Алинаас нь уухад амттайг мэдэхийн тул хоёр савнаа хоёулангаас нь зэрэг ууж үзэх хэрэгтэй юм байна гэв.

Тэгээд лонхтойгоос хэд сайн балгаснаа байранд нь тавиад юм мэддэг хүн шиг тамшаалав.

Янз нь дахиад д андуурчихаж гэж толгой сэгсрэн, Үгүй юм байна. мөнгөн саван дахь нь амттай юм. Эсвэл зүгээр л тэгж санагдав уу? Шалгаж үзэх хэрэгэй. Цомоор жаахан ууж болох ньв Би чинь хоёр удаа лонхноос уусан мөртлөө зөвхөн ганц удаал мөнгөн савнаас уусан байна ошүү дээ. Үнэн үудрагыг эрхэмлэнэ гээг хорвоогийн жам. Үнэн шудрагыг эрхэмлэнэ гэдэг хорвоогийнжам. Би энэ хөөрхөн хундагыг тэр удаад ёулжин сагтай лонхноос доорд үзэж яаж болох вэ. Ингэж ч болохгүй ээ, чөтгөр ав! гэж лонх цом хоёрбг нэг нэг гартаа барьсаар хэлэв.

Ингээд л мөнгөн цомонд дахин нөгөө лонхтойгоо хийж, Фелимийн ходод руу нэлээн м орох нь тэр. Эцсийн эцэст мөнгөн цомонд , лонх хоёрын алиныг илүүд үзэж байгаа нь мэдэгдэлгүй хоцров. Вискийг дөрөв дэх удаагаа амсаад ирланд эр цаг байна гэж бодов бололтой ажилаа орхив. Тэгээд гэнэт сандал дээрээ бодол орж иржээ.

Фелим босч хаалга өөд явангаа,

-Тара явья хөө! хөгшин нохой минь хоёулаэ эрэг рүү гарч эзнээ ирж яваа үгүйг харья. Бид хоёр өөрийн нь төлөө сана зовж байгааг Морис гуай харвал баярлана шүү дээ гэж Фелим хэллээ.

Тэд голын хөндийн шугуй дунпуур гараад хажуу өөд өгсөж тэр дорхиноо ташуурын ором дээр талын захад гарав.

Тэдний өмнө тал хөндий цэлийнэ. Орж байгаа нар ар нуруунаас нь ээнэ. Тэв тэгшхэн талын аль нэгтээ ганц нэгхэн цэгийрмаа юмуу аршийн нудрага ёрдойно. Өөр алсын бараа халхлах юм уу ч байсангүй Тэр бүү хэл давхиж яваа чоныг ч амархан харж болмоор ажээ.

Тэртээ тэнгэрийн хаяанд шугуй бараантан зурайна. Фелим эзнийхээ ирэх зүг чимээгүй харж зогсоно. Гэвч тийм ч удаан хүлээхэд хүрсэнгүй. тэртээх моддын цаанаас нэг морьтой хүн гарч ирлээ. Тэр хүн Аламо руу чиглдэн айсуй явна. Морьтой хүн бээр гаруй газрын тэртээ явсан боловч үнэн зарц эзнээ дорхиноо танив. Морисын замд гарахдаа өөрөөсөө салгадаггүй Навахо овгийнхны нэхсэн тод эрээн өнгийн сеапийг нь таньсан байв. Серапийг нь улаан, цагаан , хөх өнгөөр судлууд нь тодхон ялгаран харагдана.

Ийм бүгчим орой эзэн яагаад серапээ нөмөрч явдаг билээ гэж Фелим гайхжээ. Түүнийг эхлээд ганзагалчихсан бол дээр байхсан.

-Тара минь ээ! хачин юм байх юм ! Одоо чулуун дээр мах үарчихаж болмоор ийм халуун байхад эзэн түүнийг огт анзаарахгүй юм шиг явж байна. Обердоферын цайны газрын хэвтшинд байж байгаад салхинд цохиулчихаа юм болов уу? гахай ч гэсэн тэнд байх гэж дурлахгүйсэн байхаа. манай муу урц тэдний дэргэд ёстой диваажингийн орон гэсэн үг.

Фелим, морьтой хүнийг хэсэг зуур чимээгүй ажиглан харлаа. Тэр нь бүр хагас бээр ойртож ирэв.

-Дар эх минь! Энэ чинь юу болоо вэ? Серапээ нөмөрчихсөн... Үгүй ээ, тара минь лав тоглоом хийж яваа байх. Чи бид хоёрын гайхаш барах гэж л дээ. Бид хоёрыг даажигнамаар санагдаж дээ... гэгээн минь! Яасан жигтэй юм бэ? Толгой нь алга байх шиг байх юм. Үнэндээ алга!

Энэ чинь юу гэсэн хэрэг вэ? Дар эх минь! Хэрэв эзэн маанв гэдгийг мэдээгүй бол үхгэлээ айх нь байна шүү! Ер нь энэ чинь манай эзэн мөн үү? Манай эзэн арай өндөр лөө. Толгой нь яав? Гэгээн Патрик өршөө, толгой нь өндөр дөө. Толгой нь яав? Гэгээн Патрица минь өршөө, толгой нь хаана байна? Серапэ дор нь байна гэж үү? Үгүй л юм шиг ... Энэ чинь юу гэгч болж байнаа , тара?

Фелимийн дуунд айсан шинж илэрхий. Баснүүр царай нь хувирна. Фелимийн өмнө зогсч байгаа нохой нь бас тогтож ядна. Яльгүй оцойгоод ухасхийхэд бэлэн харагдана. Зуун тавиадл алхам ойртож ирсэн эзнээ айж гялалзан дүрлэгэр нүдээр ширтэн харна.

Фелимийг сунжруу үгээ төгсгөөд сүүлчийн асуултыг тавихад тараа хариулах мэт өрөвдөмөөр гангинан гаслав.

Тэгээд нохой нэг л бишү юм болж байгааш знэр авсан мэт байрнаасаа ухасхийн, Фелим болон өөрийг нь тэгтлээ дүйнгэтүүлсэн хачин дүрс рүү давхив. Тосч давхингаа чангаар гаслан гиншиж эзнээ гэртээ ргэж ирэхэд нь баярлан угтгад , сайхан хүнгэнэн хуцдаг нь огт адилгүй байв. Гасалсан хэвээр морьтон руу ойртлоо. Эзнийхээ морийг мөн гэж Фелимийг аль хэдийн таньсан хээр морь гэнэт эргээд тал нутаг руу буцаж давхилаа.

Морийг огцом эргэхэд нүд салгалгүй харж байсан Фелим аймаар муухай юм хараад хамаг бте нь зарсхийж нуруу руу нь хүйт оргижээ.

Фелим өнөөх морьтой хүний толгойг харчихжээ. Хүний толгой мөрөн дээрээ байдаг байхад тэр хүн толгой эмээлийн урд бүүрэгний тэнд гарт нь байжээ. Морийг хажуугаар нь эргэхэд н цус нөж болсон хагас нв цогцсонд халхлагдсан аймаар муухай царай Фелимд харагджээ. магадгүй тэгж харагдлаа гэж санагдсан ч байж болох юм.

Фелим өөр юу ч харсангүй. Тэр нэг агшин зуур тал хөндийн зүг эргэж, дахиад нэг агшны дараа ташуу руу чөргөр нарийн шилбэнийхээ тэнхээ мэдэн гүйж явлаа.

XLIV. Дөрвөн команч

Фелим эргэж харалгүй ухаан, жолоогүй гүйж байв. Оройны нь хонгор шаргал үс босчих шиг болж, золтой л бүрхээ унагаачихсангүй. Овоохойдоо гүйж ороод мустангийн арьсан хаалгаа хааж, шал дээр хэвтэж байсан хэдэн боодолтой юмаар дотроос нь бэлхэн дарав.

Тэгсэн мөртөө өөрийгөө аюулгүй болоо гэж бодсонгүй. хий юмнаас үүд хаалгаа цуургаалсан ч гэлээ хамгаалж чадна гэж үү.

Үнэндээ түүний үзсэн юм нь буг чөтгөр л байж таарна. Хорвоо ертөнцөд , тийм гайхалтай юм харсан хүн байна гэж үү. Өөрийнхөө толгойг барьчихаад морь унаж ябаа хүнийг хэзэ жнэгэн цагт ямар нэг хүн үзсэн гэж үү? Тэр бүү хэл тийм юмыг сонссон хүн байна уу? Мэдээжээр байхгүй, ямар ч байлаа угэсэн Фелим л сонсч явсангүй.

Айснаасаа ухаан тавьсан зарц овоохой дундуур хойш урагш бачимданг гүйж , нэг сууж , нэг босож , үүд хаалга руугаа мяраана. Гэвч түүнийг онгойлгох байтугай завсар заальхайгаар нь харж ч зүрхлэхгүй байв.

Фелим үе үе толгойтой үсээ зулгааж хоёр шанаагаа салгана базалж нүдээ зүүдэлэн биү, үнэхээр тэр аймаар зэвүүн юмыг үзсэнээ нотлохыг оролдох мэт сандчина.

Нэг юмл юм түүнийг жаахан тайвшруулж байсан энэ ташуу руу бууж явахдаа нэг эргэн харахад нь морь унсан толгойгүй хүн Аламоос холдон ойын зүг хагируулж яваа хэрэгджээ.

Хэрэв үүнийг хараагүй бөөл ирланд эр улам ч бажга алдахбайлаа. Үг хэлэх нь тэнхээгүй бол үе үе учиргүй гаслана.

Жаахан байзнаад тайвшраагүй боловч бодож цэгцтэйхэн , дахиад ярьж чадахаар болов Энэ удаа зөвхөн өөртэйгөө л ярилаа. Тара гэртээ байгаагүй учир ярианд оролцож чадсангүй.

Фелим овоохойны гаднаас ямар нэг амьтан сносчих вий гэж болгоомжилсон юм шиг бүр шивэгнэн ярж байв.

-Ээбухран минь! Байж боломгүй юм! тэгэр манай эзэн биш ! гэгээн Патрик минь намайг авраач! Тэгээд энэ чинь хэн байдаг билээ? түүний хамаг юм нь мөн байсан. Түүний морь, судалтай серапэ , цоохор барын арьсан гутал, бас толгой нь... хэрэв царай нь нь л биш байдаг юм бол молрис гуай мөн байх ёгүй. Бишээ! Биш! Энэ бол зүүд. Би лав ундтаад тийм юм зүүдэлсэн. Эсхүл энэ бзхэн вискинээс болсон юм болов уу? Гэхдээ тэгж амиа алдатлаа согтоогүй л юмсан. Хоёр удаа лонхноос , хоёр удаа хундагнаас балгаад л гүйцсэн. ийм юманд юундаа согтох вэ? Бурхан минь тэгээд согтуу байсан гэхэд яахаараа одоо эрүүл болдог билээ? нөгөө юмыг харснаас хойш хагас цаг ч болоогүй байна. Гэтэл шүүгч шиг эв эрүүл болчихсон байдаг. Ингэхэд одоо энэ нэг жаахан юм балгачихаад муу нь юу байх билээ? тэгэхгүй бол би шөнөжин нойргүй юм бодоод хонох болно. Энэ хий юм чинь юу вэ? хэрэв энэ үзсэн юм эзэн маань биш бол, тэр хаана байгаа бол? гэгээн минь! Ад чөтгөр, алыбин тйирэнд бүслэгдэжөнчиэн ганцаараа хоцорсон хөөрхий муу намайгаа хамгаалаач!

Тэр ирланд хүн катологийн ариун хутагтад ингэж залбирсаныхаа дараа элэнц хуланцын үеэс Вакх гэж нэрссэн, грекимйн үлгэр домогт гардаг архи дарсны бурханд махцш их бишрэн залбирав.

Сүүлийн бурхан нь залбаирылг сонсжээ. Фелим моногахелийн архитай лонхны лдүрээр хувилсан энэ буруу номт бурхны шүтээнд сөгдөн залбирсанаас хойш нэг цаг болоход хамаг зовлонгоосоо ангижирчээ. тэр, өөрийгөө үхтэл н айлгасан өнөөх зэвүүн муухай юмны тухай санах ч байтугай өөрийнхөө байгаа байхгүйг мэдэлгүй овоохой дотроо гулдайн хэвтэв.

Шөнө боллоо. Морис мцстангерийн овоохойд чимээ аниргүй нам гүм ажээ.Нэг шөнө газар дэлхий дээр бууж ирлээ гэдгийг мэдэгдэх цагны чагчаг хийх ч сонсогдохгүй байв.

Зөвхөн овоохойн гадна талд л чимээ гарна.гвэ ч тэр нь дасал болсон дуу чимээ- ой модны шөнийн дуу, гол горхи хоржигнон , навч нахиа сэрчигнэн, жирхэрхэйний цар хийх , хааяа ямар нэг араатны дуу гарна...

Шөнө дунд болсон ч сарны гэрээл бүх юм өглөөшиг одохн , мөнгөн цагаан туяа нь газар дэлхийг гийгүүлж, хамгшийн балар шугуйг нэвглэн, моддын хар сүүдэр дунпуур цагаан судал татуулна.

Хэдэн морьтон гэрлээс сүүдрийг эрхэмлэн явж байв. тэд дөрвүүлэхнээ боловч тэднийг харахад айдас хүрмээр. Ув улаан нүцгэн бие, хацар дээрх шивээс, толгой дээр нь гозолзож байга галт отго, гартаа барьсан зэвсгийн гялазах энэ бүхэн нь аюултай, зэрлэг хүнийг санагдуулна.

Эд хаанаас гараад ирэв ээ?

Тэд Команчуудын байлдааны хувца өмсжээ. Үүнийг тэдний өмнө зүс, бүргэдийн өдтгй малгай, нүцгэн гар, цээж, бугын илгэн өмд зэрэг нь өгүүлнэ. Дээрэм хийж, уулгахаар ирсэн индианууд гэдэг нь илт байна. Команчууд гэдэгж нь эргэлзээгүй бөгөөд баруун талаас л ирсэн байх ёстой байв.

Тэд хаашаа явж байна вэ?

ухаан мэдээгүй хэвтэж байгаа өнөөх овоохой руу чиглэн явж байлаа. Морис Жеральдын урц нь тэдний дотолгоо хийх гэж сонгож авсан гаар нь байжээ. птэдний муу санаа өвөрдөтж ирсэнд эргэлзэж болох уу даа! Зүгээр л нэг зэр зэмсгээ асгчихаад, ингэж болгоомжилж явах гэж үү?

Тэд овоохойныб ойролцоо очиж буугаад , морьдоо модноос уяж, цааш явган явлаа.

Тэд унасан навчис дээгүүр огт чимээ гаргалгүй гишгэж чагнана. Толгойгологч нь үг дуугаралгүй, дохиогоор командлана. Хаанаас нь ч харсан тэд, урц дотор байгаа хүмүүст мэдэгдэлгүйг ойртох гэсэн нь илт. Сансан санаандаа хүрэх шиг болов. тэднийг урцын хананд

тулж очтол хэн ч харж мэдсэнгүй бололтой.

Овоохой дотор огт чимээ аниргүй э Тэндээс нэгч чимээ, тэр бүү хэл, хүрэлзэгний дуугарах нь ч үл сонсогдоно.

Уг нь овоохойд амьдрагчпийн нэг н гэртээ байж байжв. Гэвч хүн гэдэг амьтан ярьж, хухирах бүү хэл чангахан ч амьсгалж чадахгүй болтлоо уудаг ажээ. Фелим ягийм байдалтай байв.

Дөрвөн команч хаалганы нь дэргэд мярайж очоод болгоомжтой оролдов. Хаалга нь хаалттай боловч завсар зайльхайгаар нв чагнаж болох байв. Тэр дөрөв дөрвөн зэрэг чихээ нааж, амьсгаа даран завсараар нь чагнав. Хүний хурхирах, тэр ч байтугай амьсгалах, ер нв ямар ч анир чимээ алга байлаа.

-Магадгүй... Тэр амжижирээгүй байж ч болох юм. гэвч аль хэдийн ирсэн баймаар юм даа. дахиад өөр тийшээ яваад өгсөн юм болов уу? Урцын ард морины нь саравч байх ёстой. хэрэв мустангер гэртээ байгаа бол хээр мустанг нь саравчиндаа байх ёстой. Найзуудаа эндээ хүлээж байгаагаарай би очиж үзээд ирье гэж толгойлогч нь хамт яваа нэгэндээ цэвэр испаниар хэлэв.

Морины баазхан жүчээг үзэхэд хэдхэн хорос орох ажээ. тэнд хоосон байв.

Мөн өдий хэрийн хцугацаанд тийшээ очсон, зөргийг харячихаар байлаа. Түүн дээр шинэхэн мөр алга байв. Үүнийг нягталсан толгойлогч буцаж ирэхэд нөхөд нь овоохойны үүдэнд зогссоор байв.

-Цусаар урс! Тэр энд алга өнөөдөр энд байсангүй гэж толгойлогч нэлээд чанга хэлэв.

-Овоохойд орж үзэж магадлах юмсан. Ирланд хүн тал нутагт орон байраа яаж тохинуулдгийг үзэхэд юу нь муу байх вэ? гэж дайчдын нэг нт испани хэлээр цэвэрхэн хэлэв.

-Аль вэ орцгооё. Амбаар руу нь шагайж харъя. Би бүр түүхий мах зулгаамаар их өлсөж байна гэж гурав дахь нв мөн Сервантесийн хэлээр өгүүлэв.

-Чөтгөр аваг! Эднийд архины зоорь бий гэж дуулсан юм байна.Хэрэв тийм бол.. гэж дөрөв дэхь нь мөн л чихэнд сонсогдолонтой өнөөх хэлээр хэлэв.

Толгойлогч нь сүүлчийн хүний үгийг бүтэн хэлүүлсэнгүй. Ахроины зоохины ухай дурссан үг түүнийг илбэдсэн юм шиг хөдөлгөөнд оруулав. Сайхь эр хаалганыг хөлөөрөө түлхсэн боловч нээгдсэнгүй.

-Карамба! Дотроосоо түгжээтэй байна. Арслан бахс, баавгай, зэрлэг үхэр, бас индианчууд эзгүй үедээ оруулах дургүй юм байж л дээ. ха-Ха-Ха! Хаалга руу дахиад нэ чанга өшиглөлөө. Гэвч хаалга ер онгойсонгүй.

-Нэлээд хүнд юмаар дарчихаж, Түлхээд онгойхгүй нь. Одоо учры нь мэдье гээд бүснээсээ хутга сугалав. Хөнгөн жаазанд тэлж татсан мустангийн арьсанд том онгорхой нүх гарлаа.

Индиан тэр нүхээр гараа шургуулж, даруулсан юмыг тэмтчив.

Баглаа хүлээтэй юмнууд тэр даруй байрнаасаа хөдөлж хаалга цэлийтэл нээгдлээ.

Зэрлэгүүд орцгоов. Онгорхой хаалгаар сарны гэрэв тусч овоохой доторхийг гийгүүлэв овоохойны гол дунд шалан дээр нэгэн хүн тэрийн хэвтэж байлаа.

-Чөтгөр аваг!

-Энэ унтаж байхшив дээ?

-Энэ лав үхчихсэн байх, хэрэв амьд юм бол биднийг сонсмоор юм.

-Үгүй энэ чинь зөвхөн үхтэлээ согтсон хүн юм гэж толгойлогч нь шал дээрх хүн рүү тонгойнгоо хэлээд

-Энэ чинь мустангерийн зарц байна. Би энүүнийг танина. Үүний байж байгаагаар үзвэл эзэн нь гэртээ байхгүй байгаа юм байна. Арай энэ мал чинь зоорин дахиа цөмий нь гударчихаад санаа амар хэвтэж байгаа юм биш байгаа даа? Өө, лонх, байна. Сарнай цэцэг шиг сайхан үнэртэй юм. Гваделупын эх дагина минь, бидний хувь үлдэж шүү гэлээ.

хэдэн хормын дараа үлсдэн виски ч шавхруугүй дуусав. Хүн бүр нэг нэг хүртэж харин толгойлогчид илүү оногджээ. Сайхь эр ч тэнцүү биш хувааж байгааг эсэргүүцсэнгүй.

Цаашаа юу болох бол?

Эрт орой түүнтэй уулзах гэж яриагүй хүсжээ. Тэгээгүй бол тэд ийм шөнө орой болсон хойно энд угаа хийж ирэх билээ. Ялангуяа толгойлогч нь уулзахын туйлгүй хүснэ.

Тэр дөрвөн индиан хүн морис мустангертай уулзах ямар хэрэгтэй юм бол?

байсангүй .

Тэд Морисыг алах гэж ирсэн ажээ!

Энэ нь толгойлогчийн ганц зорилго байв. Бусад н зүгээр л хам оролцогчид юм.

Тоглоо м ч үгүй, айхтар хэрэг. Алсны шанд мянган доллар аваал, бас өшөөгөө хангана. Гурван туслагч нь зуу, зуун доллар авна. Хэн команчийн багаар биеэ халхласан нь уншигчидад аль хэдийн тодорхой болсон биз мань команчууд бол мексик хүмүүс, тэдний толгойлогч нь мустангер Мигуэл Диас байлаа.

-Отох хэрэгтэй байна. Одоо тэр тун удахгүй ирнэ. Барахо ганга өөд очоод түүнийг тал дундуур гарч иэрхийг нь харож бай. Бусдад нь надтай хамт үлд. Тэр Леон шолын зүгээс ирэнэ Бид түүнийг ташлуурыг тэндэх заан модны зүгэээ ирнэ. Бид түүнийг ташлуурын тэндэх заан модны дор хүлээж болох юм. Энэ бол хамгийн аятай газар.

-Бид үүнийг зүйл дуусгачихаад дээргүй юу? гэж цусанд шунагч Барахо Фелимийг зааж хэлэв. Аз болоход хөгшин зарц урцанд юу болж буйг мэдэрсэнгүй.

-Үхсэн хүн үг хэлдэггүй гэж нөгөө нэг нь дэмжлээ.

Үгүй шүү, үхсэн хүн чинь илчилчихдэг юм! гэж Диас хэлснээ -Ингээд согтуу хэвтэж байх нь дээр. Энэ гайхлыг зүгээр орхи. Би зөвхөн эзний нь алах хэлэлцээтэй. за, Барахо хөдөлж үз. Түргэл түргэл !Ганга руу яваарай.

Морис хэдийд ч гарахад ирж мэднэ. Самбаатай ажиллах хэрэгтэй Хожим бидэнд ийм далим хэзээ ч тохиолдохгүй байж мэднэ. Ганга өөд авираад гарчих. Ийм гэгээтэй байхад та түүнийг холоос харна. Харангуут л бушуухан наашаа гүйж ирэ. Биднийг заан модны дэргэд хүрч амжихаар түргэн ажилларааай гэв.

Барахо тушаал биелүүлэхээс хойрогшиж байв. Уртыд нь шөнө аз нь харьж талын Чонотой хөзөрдөөд сүрхий хожигджээ. тийм учраас хариугаа авах гэж боджээ.

-Эрхэм Висенти бушуулж үзээрэй! Гэж түүний овоохойгоос гарах дургүй байгааг нь Диас мэдэж тушаал өгөөд хэрэв бид амжилт олохгүй бол та хөзөрт хожихоосоо илүүг алдана шүү. тэр, нэгц агт дотор гарч ирэхгүй бол хэн нэг нь чамаас халаа авна. Явж үз! гэв.

Барахо үгэнд нь оров. Тэр урцнаас гарч гангыг чиглэн явлаа. Бусад нь урцанд тухалж лаа асаалаа.

Тэдний өмнөх ширээн дээр оройн хоол биш, харин тэнэмэл мексикийн салшгүй дагул болсон исбпани хөзөр тавилаа. Хатан боолоо гаргаж тавиал , тоглоомоо эхлэв. Мөрийтэй тоглоход цаг мэдэгдпэхгүй өнгөрдөг ажээ. нэг цаг боллоо...

Талын Чоно банү барьж байв. “Хатан тавилаа”, “Боолын хожлоо” гэсэн дуу мустангийн арьсаар бүрсэн урцан хананы цаанаас цууриатна. Мянган доллар ширээн дээгүүр хангинана. Хөзөр аяархан шажигнана.

Тэгтэл чанга орлиох дуу гарч тоглоом гэнэт тасалдав. Фелим сэрж хачин амьтдыг харсандаа орилсон нв энэ байжээ.

Хөзөр ширээн дээрээс үсрэн цналж, гэнэт хүтгааа сугалан авцгаалаа. Фелимийн амь дээсэн дөрөөн пээр тулж ирэв.

Гэнэтийн тохиолдолд түүн йг аврав. Байдгаараа амьсгаадан Барахо үүдээр орж ирэв. Үнэндээ тайлбарлаад ч байх хэрэггүй бөгөөд зөвхөн л

-Өнөөх чинь айсуй, ганганд бүр ойртоод ирлээ... Бушуулаарай нөхдөө, бушуулаарай! Гэж арайханшивнэсэн нь хангалттай байв.

Ирланд эр аврагдах тэр. Фелимийг алах гэ бодсон байлаа ч гэсэн зав байсангүй. Арай илүүхэн ашиг унах хэрэг хүлээж байв.

Хэдхэн хормын дараа зүсээ хувиргасан дөрөв мустангерын бууж ирэх ёстой ганганы ёроолд хүрчихсэн байв. Тэд заан модны дор отоо хийгээд золионхоо хүний ойртож ирэхийг хүлээлээ.

Удалгүй мройн төвөргөөн сонсогдож тах хангинав. Тэр чимээ жигд биш дуугарч, , морь нь бартаатай газраар давхиж байх шиг байв.

Тэр морьтой хүн ташуу руу бууж яваа бололтой. гэвч харагдахгүй байлаа. Тагуу газар нь моддын сүүдэр дайрсан голын эрэгтэй адил харанхауид дарагдсан бөгөөд нөгөө хэдийн нуугдсан газрын моддын сүүдэр дайрсан голын эрэгтэй адил харанхуйд дарагдсан бөгөөд нөгөө хэдийн нуугдсан газрын хажуугаар нь сарны гэрэл туссан байв. гэвч зөрөг нь түүгээр биү заан модны сүүдэр доогуур гарчээ. Морьтон тийшээ ирэх ёстой байв.

-Түүнийг битгий алаарай! Гэж Мигуэль Диас захирсан дуугаар, шивэгнэн хэлээд- Тэр нэг хоёр цаг амьд байх нв надад хэрэгтэй байна. тэгэх шалтгаан байгаа юм. Түүнийг морьтой эь хамт бариад ав. Айх юм байхгүй, гэнэт дайрахад учиртай. Хэрэв эсэргүүцэх ална. Эхлээд би буудна шүү! гэлээ.

Хуйвалдагчид толгойлогчийнхоо үгэнд орохоо амлав. Төдөлгүй амласнаа үзүүлэх цаг ч ирдээ. Хүлээж байсан хүн нь налуу руу буугаад модны ёүүдэрт ойртож ирэв.

-Зэвсгээ хая! Мориноосоо буу! гэж хэлээд Талын Чоно ойртон ирж яваа морьтой хүний урдаас ухасхийлээ. талын Чоно морины хазаараас шүүрэн авч, наад гурав нь хүн рүү нь ухасхийв.

Тэр хүн ямар ч эсэргүүцэл тавьсангүй. Буу зэвсгээр ч өөрийгөө хамгаалсангүй , хэл үшээр ч эсэргүүцсэнгүй. тэдний өмнө эмээл дээрээ тухтай суусан хүн байхыг нүдээрээ үзэж, бие цогцсынь гараараа тэмтэрч үзлээ. гэвч тэр нь нэг л мэдээ мэдрэлгүй юм шиг санагджээ. гагцхүү морь нь эсэргүүцэв. Морь хойд хоёр хөл дээрээ цоройн, гэдрэг ухарч , өөр рүү нв дайран орсон дайснийг чирч гулдан сарны гэрэл туссан зурвас газарт хүрэв.

Ээ, өршөөлт тэнгэр минь! Энэ чинь юу гээч вэ?

Мексикчүүд цөм айсан зэвүүн дуугаар нэгэн зэрэг хашгиран гэдрэг ухасхийн морьдоо уясан өнөөх үугуй руу хөлийн хурд мэдэн гүйж очоод, мориндоо санд мэнд үсрэн мордоод ухаан жолоогүй зугадлаа.

Тэд, нэлээн зүрх зоригтой хүмүүсийг хүртэл айлган жихүүцсэн өнөөх морь унасан толгойгүй хүнийг үзжээ.

XLV. Тасарсан мөр

Энэ хий үзэгдэл байв уу? Хүн байж яагаад ч таарахгшгүй юм биш үү?

Ийм асуултыг Эль Койот түүний айснаас сүнс нь зайлсан нөроөд тавьж байлаа. үүнийг бас, байн байн лонхтойгоос хөнтөрсөөр толгой нь мансууран түр зуур айдсаа мартсан Фелим ч өөрөөсөө асууж байлаа.

Энэ тухай, бас, хошуучтэй цуг явж байысан, морь унасан толгойгүй хүнийг харсан зуугаад хүн бодож л байв. Энэ өдрийн үзэгдээ тэдний өмнө нэлээн эрт, зүүн зүгт таван бээр хяраатай газар хүрч иржээ.

Энэ ерийн үзэгдэл тэдний өмнө нэлээн эрт, зүүн зүгт таван бээр хяраатай газар гарч иржээ.

Баруун зүгээс гарч ирсэн учир нар тэдий нүдийг гялбуулан, тэр хүнийг зөвхөн дүрснээс өөр юу ч олж харсангүй. Түүнийг Морис мустангертай адилхан юм юу ч олж харсангүй.

Фелим , шингэх нарны зүг нуруугаараа харан зогсч байгаад морь унасан толгойгүй хүнийг харжээ. Яг эзнээ байна гэж итгээгүй ч эзнийхээ адилхан юмыг олж ажиглажээ.

Морисыг тандаш дөрвөн мексик ч бас сарны гэрэлд сайхь хачин морьтонг хараа Фелим шиг бодсон байна. тэгээд Фелим болон өнөөх дөрвөн мексик хүн сморь унасан толгойгүй хүнийг харчихаад үнэхэлцэгээ хагартал айжээ.

Хошуучын удирдсан эрлийнхэн тэр оньсогыг таавар шоглож хэлснийг эс тооцвол хэн ч тайлбар хэлсэнгүй.

-Энэ чинь юу гэгч вэ? Ноёдоо, та нар үүнийг юу гэж санаж байна ? Би бүр мэл гайхчихлаа гэж хошууч бусдаасаа асуулаа.

-Индианчуудын арга заль уу? Биднийг мэхэлж занганд оруулах гэж байна уу? гэж нэг хүн хэлэв.

-Өөдгүй илбэ гэж хэлэх байна. Намайг яалаа ч гэсэн ийм илбээр хуурч чадахгүй гэж өөр нэг хүн хэллээ

-Индианчууд үүнд хамаагүй гэж би бодож байна. Спенглер чи энэ

талаар юу гэж бодож байна ? гэж хошууч асуулаа. Спенглер хариуд нь зөвхөн толгой сэгсэрэв.

-Өөр хувцас өсгөчихсөн индиан хүн биш биү? гэж хошууч түүнээс дахин асуулаа.

-Хошуучаа, би танаас илүү мэдэхгүй байна. Тиймэрхүү л нэг юм бололтой. нэг бол хүн, нэг бол чихмэл, энэ хоёрыг л нэг гэж мөрч хариу өгч

-Нээрээ мануухай гэж хэд хэдэн хүн хэлэв.

-Хүн биш мануухай шулмас байлаа ч гэсэн мөр л үлдээдэг юм бол тэр мөр нь хаашаа ч явсан бид яагаад мэдэж болохгүй байх вэ гэж анх саналаа хэлж байсан хүн хэлэв.

-Бид одоохон үүний учрыг оломц, Бидний мөшгиж яваа мөр тэр тал руу явсан байна. Хошуучаа явж болох уу? гэж Спенглер хэлэв.

-Тэгэлгүй яах вэ ийм дэмий юм зорилгоо биелүүлэхэд маань бидэнд саад болохгүй урагшаа!

Зарим нэг нь яая даа гэсэн байдалтай эргэлзэн, цөмөөрөө урагшаа хөдөллөө. Эрлийнхнийг дотор өөрөө мэдэгдсэнбол бушуухан буцахыг бодсон хүмүүс ч байв. тэдний дотор Колхаун орно. Морь унасан толгойгүй хүнийг хараад айснаасаа хашчих шиг болон нүд нь гөлийн хөдлөхгүй болж эрүү нь унжин , уруул нь зэвхийрч хүч гарган чичирэхээ дарж байжээ.

Хэрэв хүмүүс айж самгардаагүй байсан бол түүний тэр хачин байдал үнэндээ хажуугийн нь хүмүүсийн хараанаас мултрахгүй мбайх байлаа. Тэд цөм тэр битүүлэг үзэгдлийг далд ортол , илбэдүүлсэн юм шиг тэр зүгт харцгааж байжээ. Эрлийнхнийг урагш хөдлөхөд нь Колхаун арын эгнээнд орж бусад нь түүнийг анзаарсангүй.

Морь унасан толгоогүй хүн зогсч байсан газар нь эрлийнхний яг зам дээр гэж Спенглер зөв хэлжээ.

Гэтэл тэр толгойгүй хүнхий үзэгдэл болохоо нотлох гэсэн мэт ямар яг ул мөр үлдээгээгүй байв.

Гэвч үүний учрыг амархан олж болох байлаа. Морины эргэсэн газраас цааш хэд хэдэн бээр газрын хөрс цагаан хайргаар битүү хучигджээ. Анчид энэ хавийг “шохойн тал” гэж нэрлэддэг байв.

Зарим газраа чулуу нь тахаар зурагдан ховхорсон бололтой ажээ. Гэвчтүүнийг туршлагатай мөрч ялгаж храхаар байв.

Эрүүлийнхний дагаж явсан тахтай мустьянгийн мөр алдагджээ. ойрмогхон үүгээр өнгөрсөн зэрлэш адуун туурайд газар онгилогдон, ганц морины мөрийг тэр дунпаас олно гэдэг боломжгүй хүний явсан зүг цааш яаж болох байлаа. нар, дараа нь үдшийн оддын гэрлээр замаа олж болох байв. гэвч тахтай мустанг унасанхүнийг тэдний анхаарлыг татах учир орж байгаа нарны гэрлийн үлдсэн хагас цагийг мөр эрсээр байгаад өнгөрөөв. мөр нь шохойт талд хүрээд алдагджээ.

Нар жаргах үеэр Спенгер цааш яваад ямар ч ашиггүйг хэллээ. Гагцхүү мод руу буцаж, ойн цоорхойд хуарагнан буудуулах л үлджээ. Үүрээр дахин рэгэлд гарахаар шийдэв.

Гэтэл тэгж амжсангүй. санамсаргүй тохиолдол тэдэнд саад болов.

Эрлийнхнийг буудаллаж амжаагүй байтал элч ирж, хошуучид яаралтай бичиг өглөө. Тэр нь Сан-Аниониоде Бехарын штабаас торйгийн командлагчийн явуулсан бичиг байв. Цайзад явуулсан байсан бөгөөд тэнждээс нааш нь авчирчээ. Хошууч морьдоо эмээллэх тугаад өгч

ядарсан морьдын хөлс нь хатаж амжаагүй байтал, цэргүүд мориндоо мордов.

Тэр бичигт Леон голоос зүүн тийш тавин бээрийн зайтай сан- Антониогийн хавиар команч нар үзэгдсэн тухай мэдээлжээ.

Одоо тэдний тухай яриа жирийн нэг цуу үг биш болж галдан шатааж, аминд хүрэн уулгаласан байв. хошууч цаг алдалгүй цэргээ цуглуулж, Сан-Антонио руу явуул гэсэн тушаал авчээ. Ийм учраас морин цэргүүд явах болсон байлаа.

Үнэндээ цэргийн биш хүмүүс аоцроод эрлээүргэлжүүжл болох байсан боловч эвтэй найрсаг байдал , тэр бүү хэл эх эцэг, ах ддүүгийн хайр халамж ч зайлшгүй зүйлийн өмөн нугарав. Тэд зөвхөн бүү зэвсгээ аваад гарсан учир өлсөх аюул тэднийг гэр рүү нь өөрийн эрхгүй хөөж байлаа.

Хэн ч эрлийг үргэлжлүүлэхээс татгалзья гэж бодсонгүй. Тэд унаагаа сонин, хоол хүнсэнд базааж аваад, бүгдээрээ нэгэн дуугаар “хөөрхий залуу эрийг олон олтлоо” эрлээ үргэлжүүлэх хэрэгтэй байлаа.

Спенгер тэргүүнтэй цөөн хүн мөрчийн ыодлоор тэднийг Леон гол руу буцаан аваачих ёстой америк морины мөрөөр мөшгөхөөр үлдлээ. Бусад нь морин цэргүүдтэй хамт цайз руу буцаж болов.

Спенглерийн олж мэдсэн гунигт нээлтүүдийн тухай Пойндекстер болоод түүний нөхдөд салахынхаа өмнө хэлж өгөх нь өөрийн үүрэг гэж хошууч үзжээ. Өөрөө уашид эрэлд орооцолдож чадахгүй болсон учир, түүнийг үргэлжүүлэх ёстой хүмүүс энэ чухал явдлыг мэдэж авах хэрэгтэй гэж шийдлээ.

Хошууч өөрөө муугүй байдаг ирланд залуугийн эсрэг сэжиг төрүүлэх нь хичнээн эвгүй ч гэлэ, үүрэг нь юунаас ч илүү байлаа.

Хэдийгээр Морис мустангерын гэм бурутайд итгээгүй ч түүний буруутгах ноцтой баримт нотолгоо байгааг зөвшөөрөхгүй байж чадсангүй. Харин эзэн болон түүний нөхөл мустангерын гэм буруутан огтхон ч эргэлзсэнгүй. индианчууд энд ямар ч хамаагүй гэдэг нь илэрхий өолсон одоо үед, Морис мустангерын хүн алсан этгээд хэмээн нэгэн дуугаар зарлгажээ.

Хүн амины хэрэг гасранд хэн ч эргэлзсэнгүй.

Тэр эмгэнэлт явдлын эхлэлийг Обердоферын өгүүлэл илрүүлсэн бөгөөд харин эмээл хазаар нь бцус болсон Генри Пойндекстерийн морьуг хэргийн төгсгөлийг гэрчилж байв. тэр цуст хэргийн эх, төгсгөл хоёрын хоорондох үйл явдлыг хагасы нь Спенгелерийн олж мэдсэнийг үндэслэн, хагас нь зүгээр л таавар төдийгөөр зовлонгүйгээр бий болгожээ.

Харин мустангерын ийм гэмт хэрэг рүү ву түлхээ вэ гэсэн асуудлыг хэн ч нухацтай бодсонгүй. Колхаун Морис хоёрын муудалцсаныг л бүх хүн хангалттай шалтгаан гэж үзэж байлаа. Морис, Колхаунд дайсагнахдаа л Пойндекстерын бүх гэр бүлийг үзэн ядсан байна гэж

бодоцгоожээ.

Ийм бодолтойгоор эрэлд оролцогчид салцгаав.

Маргааш өглөө нь дахин цуглаж эрлээ үргэлжүүлэхээр болжээ. хоёр морины мөрийг эцэст нь хүртэл хөөж алга болсон хоёр хүний амьд үхсэн алин боловч олж авахаар шийджээ.

Энэ бол зүйл үл нийцэх зүйл боловч, хүмүүст гэмт хэрэгтнийг эрж явахдаа зүй зохистой бодно гэдэг маш ховор зүйлийн нэг ажээ. Тэд зөвхөн шийтгэх тухай л бодно.

Спенглерийн толгойлсон хэсэг хүн, хошуучийн сонгож авсан ойн цоорхойд байрлав. Тэд аравдхан хүн байлаа. түүнээс их хүчний хэрэггүй байв. Тэр хавьд команчуудын аюул занал байсангүй. Өөр аюул л байхгүй юм шиг байлаа. Тэдэнд даалгасныг хоёр гуравхан хүн л гүйцэтгэж чадах байв

Зарим нэг нь хэрэгтээ дуралсандаа, нөгөө зарим нь хань бараа болья гэсэндээ үлджээ. Ихэнх эл газрын эздийн хүүхдүүд бөгөөд албан ёсны Колхаун ахлагч нь боловчмөрч Спенглер эрлийг удирдах нь мэдээж

Хэдүүл үлдээд унтахаар хэвтсэнгүй, дүрэлзэн ноцох түүдэг тойрон сууцгаана. Идэж уух юм элбэг дэлбэгийг хэлэх юун. Цайз руу буцсан морин цэргүүд тэдэнд хоол унд, архитай дажмагаа үлдээжээ.

Галын дөл хөгжилтэй дүрэлзэж хүмүүсийн сэтгэл бас л уймарсан хэвээр. Хорвоо дээрх жаргалын дээд нь байж мэдэх тэр сайхан цэнгэлийг эдлэхэд нь саад болсон сэтгэлийн түгшүүр хүн болгонд байлаа.

Түүний дэргэд гал голомтоо амарлинггүй баяр гэдэг юу юм бэ? Нүд алдам талын дунд би ч бас гэрээ санадаг үе байдаг л байлаа. Гэвч одоо өнгөрснөө эргэн харж, аль алиныг нь алагчлалгүй харьцуулж үзэхэд “Надад түүдэг гал, анчин нөхдийг минь эргүүлэхэд аль, алийг нь алагчлалийг харьцуулж үзэхэд “Надад түүдэг гал, анчин нөхдийг минь эргүүлээд аль, дүрэлзсэн галын эдргэд тэдэнтэй минь дахин суулгаадах, би танд хариуд нь бүх хураасан хөрөнгө, мөнгө ямар ч хэрэггүй алдар нэрээ өгье. Би энэ бүхнийг, тэднийг байлгахын тул шаардагдах халамж, хөдөлмөрийнхөөхамт өгөхдөө баяртайы байна гэж дуу алдахгүй байыж чадахгүй.

Эдгээр залуучын баргар царайлсны учрыг амархан тайлбарлаж болно. Морь унасан толгойгүй хүнээс болж айсан айдас нь арилаагүй тайтгарч чадаагүйгээс болжээ.

Тэд болсон явдлын учрыг тайлах гэж тархиа эргэтэл бодон заримдаа бүр тэрхүү битүүлэг хий үзэгдлийг доог хийх боловч, яагаад ч сэтгэлийг нь зовоосон тэр зүйлээс салж чадахгүй, ямар ч таавар санааг мараахгүй байлаа. Спеглер Колхаун хоёрч мөн л ийм байдалтай байв.

Колхаун хүн бүхнээс илүү баргар царайтай харагдана.

Тэр задгай галаас, хол , модны ёроолд суун, морин цэргүүдийг явснаас хойш ганц ч үг дуугарсангүй. харваас галд ээн байгаа хүмүүстэй нийлмээргүй санагдсан нь илт. Сониуч харцнаас хол байя гэсэн юм шиг ганцаарахнаа галаас хол суужээ. нүд нь урьдын адил гөлөлзөн, царайд нь айж эмээсэн тэмдэг хэвээр байна.

-Хөөе Колхаун! гэж нэлээ ууж халчихсан нэг залуу хашгираад -Ах минь нааш ирж, бидэнтэй хамт түүдгийн дэргэд сууж хундага юм уугаач. Бид таны уйтгар гунигтай байгааг ойлгож байна. Тэгээд ч алуурчнаас өшөөгөө авахад чинь танай гэр бүлийнхэнд чадах чинээгээрээ туслана. Харин цаг ямагт царайгаа барайлгаад суухын хэрэггүй. Харин цаг ямагт царайгаа барайлгаад суухын хэрэггүй! нааш ирж, бидэнтэй хамт виски тогтоогооч. тэгвэл танд их ашигтай, нээрэн шүү! гэв.

Колхаунд зожигросных учрыг тайлбарласан шалтгаан нь таалагдсан ч юмуу эсвэл үнэхээр бусадтайгаа нийлмээр санагдсандаа ч юмуу, урилгыг хүлээн аьч, залуучуудын дундтүүдэг галынг захад очиж суув. Суухынхаа өмнө өөрт нь сарвайсан дажмагтайгаас нэг сайн хөнтөрөөд авав.

Энэ үеэс эхлэн илбэдүүлсэн юм шиг шал өөр болов. Уйтгар гуниг нь ор мөргүй арилж, хачин хөгжилтэй болох нь бүх орчны хүмүүсийн агйхлыг төрүүллээ. Дөнгөж өглөөхөн үеэл дүүгээ агуулсан хүн ийм байдалтай байна гэдэг байжболомгүй санагдана.

Тэр түүдэг галын эдргэд зочин болж ирээд, төдхөн эзний үүрэг гүйцэтгэж гарав. Бүх дашмагийг суларсан дараа, дахиад дуусаж, дундаршгүй юмуу гэлтэй нөөцөөсөө дарс гаргаж ирэв. Богцноосоо хошуучтай хамт явсан нөхдийн үлдээсэн дарсыг дашмаг дашмагаар нь гаргаж ирнэ.

Түүдгийн дэргэдэх техасын наргианя эрчүүд удирдагчийнхаа жишээгээр сэтгэл нь хөөрөн өгсөнидээнээс нь татгалзсангүй. Дэмий балай юм ярьж, дуулж, цовхчин хөхөрцөгөөнө. Дараа нь ядарсандаа , найрт дийлдэн зүлгэн дээгүүр тэрийн хэвтээл нам унтацгаалаа. Тэдний зарим нь амьдралдаа анх цдаа ингэтлээ согтож үзсэн ч байж магадгүй.

Колхаун хамгийн сүүлд хэвтэв. Нрагиа дөнгөу дууссан согтсон улс хухирцгааж цөм унтлаа гэдэг нь илэрхий болмогц ахмад босон тэдэн дундуур сэмхэн гэтэж эхлэв.

Ийнхүү болгоомжлол явсаар, хуарангийн захад модноос учсан морин дээрэ очлоо. Цулбуурыг нь тайлаад сэмхэн мордоод чимээ гаргалгүй явав. Байдлыг харваас өчүүхэн төдий ч согтоогүй Харин цоо эрүүл , урьд нь ттөлөвлсөнийхөө дагуу бүгдийг хийж байлаа.

Ямар төлөвлөгөө байх вэ? Амь үрэгдсэн үеэл дүүгээ хайртай болоод эрэхээр явж байгаа юм боловуу? Эсхүл ганцаараа явж, гоц ззүтгэл чармайлт үзүүлэх гээ юү?

Түүний өөртэйгөөярих ярианаас үзвэл тиймэрхүү санаатай байгаа юу гэж бодож болмоорб айв.

-Бурханы ачаар сартай, үүр цайтал бүтэн зургаан цагийн зай байна. Энэ банди нарыг дугжирч байха хооронгд эргэн тойрон хоёр бээрийн доторхи ой шугуй өнцөг булан бшхнийг

нэгжиж үзэхэд хүрэлцээтэй цаг байна. хүүр тэнд байдаг л юм бол би олжтаарна. үгүй ээ, энэ ер ямар учиртай юм бэ? хэрэв би ганцаараа үзсэн бол өөрийгөө солиорч гэж бодохсон. Гэтэл цөмөөрөө харсан шүү дээ? Тэнгэр минь ! Энэ ер нь юу байх нь вэ? гэв.

Түүнийгээ үгээ хэлж амжаагүй байтал гэнэт гайхаж айсан дуу амнаас нь өөрийн эрхгүйгарлаа. Тэр гэнэтийн аюулд тулгасан мэт мориныхоо амыг огцом татан зог тусав.

Колхаун аль хэдийн бидний мэдэх цавчаалын хажуу талын нарийн зөргөөр явж байлаа. Тэгээд цавчаал руу явж байхыг гэнэт харжээ. Тэр морьтой хүн цавчаал үзамаар өөр шиг нь аажим эргэх гэж явтал нь ой дундуур нэг морьтой хүн явж байхыг гэнэт харжээ.

Тэр морьтойхүн цавчаал замаар өөр шиг нь аажит алхуулах биш бүр цогиулж явав.

Колхаун ойртож ирэхээс нь өмнөхөн түүнийг өнөөх морь унасан толгойгүй хэ мөн гэж мэджээ.

Андуурахын арга байсангүй. Сарны мөнгөн туяа тэр хүний мөрийг гийгүүлэх боловч мөрөн дээр толгой нь алга. Энэ бол сарны гэрлээр бий болсон хий үзэгдэл биш байв. Колхаун тунгалаг нарны гялаа гэрэлд үзсэн өнөөх л дүрсээ дахин харжээ.

Тэгэхдээ Колхаун одоо улам ч илүү юмыг, толгойгий нь олж харлаа. Толгой нь байдаг газраа биш, гуяных нь тэнд дүүжлээстэй бай. Өрөөсөн тал нь богцонд халхлагдаж, цус нөж болсон аймаар зэвүүн толгой харагдана. Түүний унасан морт, нөмөрсөн судалтай серапэ цоохор барын арьсан гутал, энэ бүхэн нь Морис мустангерын гэж колхаун таьжээ.

Колхаунд бүгдийг сайн харж авахад хүрэлцэхээр цаг байв. тэр айж жихүйцээд хөдөлж ч чадахгүй хажуу талын зөрөг дээр зогсов. Унасан морь нь ч эзнийхээ адил байгаа бололтой. Хамаг бие нь чичирэн морь унасан толгойгүй хүн өмнө нь зогсч, хээр морь янцгаан хойд хоёр хөл дээрээ цоройход ч хөдөлсөнгүй. Жигтэй хүнд унуулж яваа морь үүрсэн хойноосоо салахгүй дагаж яваа нохойн хуцахад хариу болгоо үүрсэн янцгааснаа эргээд давхиж одсон хойно л Колхауны сэтгэл уужирч дахин үг хэлэх чадалтай болжээ.

-Тэнгэр минь! Энэ чиньв юу гэгч вэ? Энэ чинь хүн үү? Эсвэл чөтгөр шуламас уу? надаар даажигнаад байна уу? Эсхүд өнөөдөржин аймаар муухай хар дар зүүдэлэв үү? Эсхүл би солиороо юу? Солиорчээ, солиорч ! гэж Колхаун чичирхийлсэн дуугаар хашгирлаа.

Ийм эв хавгүй юм хэлэд мориныхоо амыг шийдмэг эргүүлж урьд төлөвлөн бодсон зорилгоосоо няцсан бололтой шалавхан буцаж хуаран хүртлээ зогссонгүй давхив. Тэгээд задгай галын дэргэд гэтэж очоод унтаж байгаа залуусын дундуур орж хэвтэв. Гэвч унтаж чадсангүй. Ганц ч унтаж чадсангүй. Ганц ч минут нүд аньсангүй. Хомх өвчин туссан юм шиг дагжин чичирч, үүр цайхыг тэсгэлгүй хүлээв. Өглөөний бүдэгхэн гэгээ, түүний үхээнц цайвар царай, солиотой юм шиг гөлөлзсөн нүдний нь айж жихүүрэхсэн харцанд тусч байлаа.

XLVI. Үнэнээ нууцаар хүлээсэн нь

Дөнгөж үүр гэгээрэхэд Каса-Дель-Корво шилтгээний эргэн тойрон их хөлийн хөдөлгөөн эхлэв. Хашаанд зэвсэглэсэн хүмүүс сүлжилдэнэ. Зарим нь ангийн урт буу, хоёр амтай буу агсаж, зарим нь том жижиг гар буу, нөгөө зарим нь балиус хутга, хангинуур сүхээр зэвсэглэжээ. Тэдний өмссөн хувцас хунар яч гэсэнянз бүрийн. Тэр улаан хилэн цамц, индиан нарын хийсэн суйн буюу кентуккс үстэй даавуугаар хийсэн хүрэм гараар нэхсэн ноосон өмд, эсгий бүрх, савхин малгай, давхар арьсан гутал, бугын илгэн гутал зэрэг зүсэн зүйлийн хувцас өмсөцгөөжээ. Техасын хилийн сууринд зэр зэвсэг агсан, эр чадалтай хүмүүсийн тийм эрээн цоохор цуглаан болох ньхамгийн жирийн үзэгдэл юм.

Тэдний эрээн мяраан хуцвас, буу зэвсгээр нь ямар зорилгоор ирснийг хэдэхийг аргагүй чгэсэн хүмүүс зэр зэвсгээ агсан, эрээн мяраанаар хувцаслаж ирдэг нь гэм биш зан ажээ. гэвч бид тэдний яах гэж цугласныг мэдэж байгаа билээ

Тэдний ихэнх нь эрэлд оролцож байсан хүмүүс бөгөөд тэдэн дээр холын тариалангийн хүмүүс, эрэл эхлэхэд гэртээ байгаагүй анчид шинээр нийлжээ.

Энэ өглөө Каса-Дель-Корвгийн хашаанд цугларсан хүмүүс, өчигдөрийн эрэлд цэргүүд оролцсон ч гэсэн хүнээр олон байдаа.

Цугларсан дотор цэргийнхэн байгаагүй ч гэсэн сайн дурынхан гэж нэрлэдэг “журам сахиулагчид” байв.

Тэр журам сахиулагчид байгуулагддаг бөгөөд журам сахиулан гэмт хэрэгтэй тэмцэхэд оролцон, заримдаа зандалчны үүрэг гүйцэтгэнэ. Генри Пойндекстены амь үргэдсэн тухай цөм ам амандаа ярилцан Морис мустангерын нэр байсгаал д сонсогдож байв.

Морь унасан толгойгүй хүн

тал нутагт үзэгдсэн явдал хөл,т үймээн, яриа хөөрөө үүсгэжээ. Урьд нь түүнийг харсан нэг нь хараагүй түүний тухай ярина. Зарим нэг нь энэ яриаг тоглоомоор ярьж байна гээд итгэхгүй байв. Гэвч тэд төдхөн түүнийг харсан хүмүүсийн баримт ннотолгоонд бууж өгөн, морь унасан толгойгүй хүн байна гэж бгүд хүлээжээ.

Мэдээж энэ гайхалтай үзэгдлийг тайлах гэж оролдсон янз бүрийн санаа гарч ирлээ. тэндээс зөвхөн ганц нь их бага я гэлээ үнэнд ойртож болмоор ажээ. Энэ нь нөгө хилийн оршин суугчдийн морь нь жинхэнэ, хүн нь чихэл гэсэн санаа байлаа.

Юуны тулд, хэн үүнийг хийлгээ вэ гэдгийг хэнч тайлбарля гэж оролдсонгүй. Энэ хүмүүсийнцуглуулахад хүрсэн ажилд ямар ч онцгой бэлтгэл шаарлаггүй , бүгд хэдийн бэлэг олсон байв.

Морьд нь шилтгээний өмнө, зарим нэгийг нь зарц нар барьчихсан, ихэнх нь дайралдсан юмнаасаа уясан байлаа.

Хүмүүс юуны учир цугласанаа мэдэж байгаа учир эрлийг удирдах ёсоор Вудли Пойнедекстерын хөдлөх тушаал өгөхийг хүлээж байв.

Эзэн Аламо руу явахзамг зааж, эрлийнхнийг Морис мустангерын овоохойд дагуулж аваачих хүн олдож магад гэж хүлээн саатаж байжээ. Тийм хүн цугларсан дотор байсангүй. Газрын эзэн, худалдаачин, шүүгч аняин, морины данзчин, нар мухлагийн эзэн, боолчуудын хэн нь ч гэсэн Адамагийн хөндийг муу мэддэг байв.

Газарчийн үүргийг гүйцэтгэх чадах хүн сууринд ганцхан байсан нь өвгөн Зеб Стумп ажээ. Гэвч Зеб Стумпийг хаанаас ч олж чадахгүй. Гэвч Вудли Пойнедекстер үүнийг мэдсэнгүй.

Мэдээгүй нь сайн болжээ. хэрэв эрхэмсэг эзэн, охиноо Аламо дахь зэлүүд овоохой руу явахад газарчилжчадах ювм гэдгийг хором зуур ч болов сэжиглэхэл хнүрвэл тэр алуулсан хүүгийнхээ төлөө гцунихаасаа илүү, ухаангүй вч хийж буй охиноо бодохоос гутаажүхэх байлаа.

Зеб Стумп ийн эрэлд явв явсан сүүлчийн хүн шилтгээнд ганцаараа эргэж ирлээ. Цаашид хүлээх аргагүй болов. хүмүүсийн дунд шөнө авахын хүсэл их байна. Тэгээд газарчингүй хөдөлөхөөр шийджээ.

Эрлийнхнийг Каса-Дель-Корвоос дөнгөж хөдөлмөгц аль аль нь Аламо руу явах замыг сайн мэддэг хоёр хүн шилтгээнд уулзлаа.

Ингэж уулзсан нь урьдаас тохиролцсон биш ажээ. зеб Стумп ангаас буцаж ирмэгцээ түүний байдагтай. буунд өтөөн олз омогноосоо эзний гал тогоочын газар аваачиж өгөх гэж явжээ.

Үнэндээ Зеб Стумпийн тул Луиза Пойнедекстер гэртээ байжээ. тэр ч байтугай Зебтэй уулзахыг тэсгэлгүй их хүлээж суужээ. Анч өвгөнтэй уулзах гэж хүссэндээ, урьд өдөр өглөөнөөс аваад үдэш хүртэл өдөржин голын цаадах замаас нүд салгалгүй ширтэж өнөгрөөлөө.

Эрэлд мордсон шуугиантай олны дөнгөж далд ормогц тэр хүүхэн, асотей дээр дахин гараад хөгшин гүүгээ унасан анч өвгөн барааг харжээ. Өвгөний морь анчин их олз дээжинд дарагдаад алгуурхахн явж байв. Зеб Стумп шилгээний зүг гарцаагүй ирж яваа харагдав.

луиза өвгөний ханхар том дүрийг хараад маш их баяр хөөр болов. Энэ хүн бол итгэлтэй нөхөр энэ хүнд итгэж, хамгийн нандин нууцаа хэлж болно. гэж Луиза мэдэж байлаа. Өдөржин сэтгэлийн зовоосон, өвгөнд л итгэж нээж болох нууц түүнд байлаа.

Зеб Стумп хашаанд орж ирэхээс өмнө залуу хүүхэн сэхээвч рүүгээ буугаад түүнийг хүлээв.

Анч өвгөн шилтгээнийхнийг зовлонд учруулсан золгүй явдлын тухай юу ч мэдээгүй болохоор бодож сансан юмгүй, хөгжилтэй сэргэлнээр ордон руу санаа амар явж байлаа.

Шилтгээний хаалга оньслоотой байхыгхараад Зеб Стумпийн царайд гайхсан шинж тодров. Жирийн цагт Пойнедекстерын шилтгээн ийм байдаггүй байжээ.

Даамад хаалган дээр түүнийг тосч авсан негринь гунигтайы царайЗеб Стумпийн царайд гайхсан шинж тодров. Жирийн цагт Пойндекстерийн шилтгээн ийм байдаггүй байжээ.

Дааман хаалган дээр түүнийг тосч авсан негринь гунигтай царай Зеб Стумпийг улам ч гайхуулав.

-Юу болчихоо вэ? Pluto найзаа аа? Яг л сүүлээ таслуулсан элбэнх шиг харагдах чинь. гэгээн цагаан өдөр, гэнэт үүд хаалгаа түгжээп яаж байгаа юм бэ? Ямар нэг юм болоогүй биз дээ, энэ чинь?

-Ээ эрхэм минь юм болохоор барах уу! Ёстой золгүй явдал тохиолдсон! Их золгүй юм босон, ярихад ч хэцүү байна.

-Золгүй явдал ий! Ямар золгүй явдал боло вэ? бушуухан яриач дээ! Чиний царай зүсэн дпээр бичээстнй байгаагс илүү аюултай юм байдаг юмуу! Лиуеа авхайд Ямар нэг юм тохиолдоогүй биз дээ? луиза авхай... гэж Стумпийг хэлтэл негр үгий нь тасалж

-Үгүй, үгүй, Луиза авхайд юу ч тохиолдоогүй. харин нэг тиймэрхүү... Залуу авхай гэртээ бий. Стумп гуай, та ор л доо. Авхайтан өөрөө танд золгүй явдлыг ярьж өгнө.

-Эзэн чинь хаана байна? Гэртээ байна уу?

-Үгүй ээ, байхгүй. Одоо байхгүй, эзэн гэрээсээ тэртээ хол байгаа. Мөчийн өмнө явсан. Одоо гэртээ байхгүй. Зэрлэг адуу байдаг тал нутаг руу яваад өгсөн. Одоогоос сарын өмнө ан ав хийсэн гзар руугаа явсан. Та тэр газрыг мэднэ дээ.

-Зэрлэг адуу байдаг та л руу гэнээ? Тиймээ яах гэж явсан юм бэ? Түүнтэй хамт хэн явсан бэ?

-Түүнтэй хамт Колхаун гуай, за тэгээд бас өөр олон цагаан хүмүүс явсан. Тэд их олуулаа.

-Залуу Генри бас л тэдэнтэй хамт яваад өгсөн биз дээ?

-Ээш, Стумп минь, бидний гуньж зовж байгаа юм яг л энэ дээ. Генрт гуай бас яваад өгсөн. тэгэхдэ буцаж ирээгүй. Морь нь нил цус нөж болчихсон буцаж ирсэн. Генрт гуайг үхсэн гэж улс амьтан ярилцах юм - Үхсэн гэнээ? Негр, чи хөө тоглоом хийгээд байна уу? Аль эсвэл үнэн ярьж байна уу?

-Өө! Чин үнэн шүү, Стумп гуай. Энэ тухай ярихад надад хэцүү байна. тэд цөм ихүүрий нь эрэхээр явсан.

-Май үүнийг гал зуухандаа аваач. Цацагт хяруул сойрын мах байгаа. луиза ахай хаана байна?

-Стумп гуай, би энд байна , ороод ир гэж анч өвгөнд сайн танил шингэн дуу гарлаа. Гэвч тэр дуу энэ удаа гунигтай сонсогдон учирч Зеб Стумп арай гэж таньжээ.

Plutoгийн танд ярьсан цөм үнэн. Дүү минь алга болчихлоо. Уржигдпар оройноос хойш түүнийг хэн ч харсангүй. Морь нь эмээл дээрээ цусны толботой ирсэн. Ээш, Зеб минь энэ

тухай бодоход ч аймшигтай юм! гэж Луиза өгүүлэв.

-Тэгэлгүй яах вэ? Тэр хүн хаа нэг тийшээ яваа морь нт эргэж иржээ ... Луиза авхай минь, би танг нэмж зовоохыг хүсэхгүй. гэвч эрэл үргэлжилж байгаа болхоор, би тус хүрргэж магадгүй. тэгэхлээр тодорхой мэдэж авах хэрэгтэй юм.

Луиза мэдсэн бүхнээ Зебт ярьж өглөө. гагцхүү цэцэрлэгт болсоон өнөөх явдал болоод түүний өмнөх хэргийг хэлсэнгүй. Гэвч Морисын хойноос лавтай явсныг бататган Обердоферын ярианаас иш татжээ. Түүний хоолойд хязгааргүй уй гашуудлын өнгө илрэн байснаа дүүгий нь алсан хүнийг Морисыг гэж цаадуул нь үзэж байгааг хэлэхдээ зэвүүцсэн, дургүйцсэн өнгө л илрэв.

-Энэ худал! гэж анч өвгөн түүний эгдүүцлийгш хуваалцан хашгираад- Гүтгэж байна! Зөвхөн бузар малууд л ийм юм бодож чадна! Өөр хэн ингэж хэлэх вэ Морис тийм хэрэг хийх хүн биш. Түүний ямар хэрэгтэй юм? Тэр яалаа гэж ийм юм хийх вэ? хэрэв тэр хоёр муудалцсан балаа ч гэсэн ийм юм болохгүй! Би мустангерыг толгойгоороо даана. Дүүг чинь надад нэг бус удаа магтаж яриж байсан вч. харин үнэндээ Морис, үеэл ах, Колхөауныг чинь үздэггүй хүн. Түүнд дуртай хүн гэж байдаг юмуу, мэдэж авах юмсан. Намаг ингэж хэлсэнд уучлаарай. Хэрэв Морис, танай дүү хоёрын хооронд хэрүүл магаан гарсан бол тэр нь...

-Үгүй, үгүй гэж креол хүүхэн гасландаа болон өөрийгөө илчлэн хашгираад - Бүх м зүй зохисоороо болсон юм. Генрт буруу гэдгээ ойлгоод уучлалт гуйна гэж хэлж байсан юм. харин Морис...

Зебийн гайхсан царай түүнийг дуугүй болгов. Бүсгүй гараараа нүүрээ дарж, цурхиран уйлав.

-Өө! Тэр хоёрын хооронд ямар ч байсан нэг юм ыболжээ дээ... Луиза авхай та, өөрийнхөө дүү, тэр хоёрынг муудалцсан. Тэгээд...

-Эрхэм минь, Зеб минь, гэж тэр хүүхэн нүүрнээсээ гараа аван аврага том биет анчин шууд харж хэлээд- та миний нууцыг хадгалана гэж надад ам өг! Та танил найзын хувьд, шудрага, томоотой хүний хувьд надад амла. Та амлана биз? тийм үү? Гэв.

Анч өвгөн амлалынхаа оронд лужир гараа өргөж, амлахын тэмдэг болгож цээжээ зүрхэн тус газраа дэлслээ.

Зеб Стумп таван минутынг дараа хүүхнүүд эрэгтэй хүнд хэлэх нь ховор, хэллээ ч зөвхөн хамгийн их итгэсэн хүндээ л хэлдэг тэр нууцыг мэдэж авлаа.

Зеб , ингэж үнэнээ хэлэнд нь санаснаа, бага гайхжээ. Зөвхөн аман дотроо “Би ч, ялангуяа тэр талаар давхисны дараа, нэг юм болно гэж бодоод байсан юмаа” гэв.

-Луиза авхай минь, энд чинь ичиж зовоод байх юм юу байна гэж би танд хэлж байна. Эмэгтэйчүүд бол эмэгтэйчүүд хэвээр ээ л байна. Танутагт ч гэсэн, алтан дэлхийн аль ч өнцөг буланд адилхан. Хэрэв та мустангерын зүрх сэтгэлээ өглөө гэхэд та буруу хүнээ сонгожээ гэсэн хэрэг биш. ирланд хүн ч гэсэн жир нэг хүн биш шүү гэдэгт итгээрэй. Таны

надад ихэлсэнг бусад юмны тухайд гэвэл , тийм хэрэг болсон ч гэсэн мустангер л лав тэр хэргийг хийгээгүй гэж хэлснийг минь нотолж байна. Ер нь хэрэг болсон гэх ямар баримт нотолгоо байгаа юм бэ? Зөвхөн морь нь эмээл дээрээ цустай эргэж ирсэн юм биз дээ?

-Өө бас өөрийн баримт нотолгоо олджээ. Өчигдөр эрхсэн юм. Мөрөөр нь зөндөө явж баж ямар нэг юм мэдэцгээжээ. тэгээд тэрийгээ хэлээгүй , Аав надад хэлэхийг хүсэхгүй байх шиг байна. билээ. Бусдаас нь асуухаасаа би айсан юм. Тэд өнөөдөр таныг ирэхээс өмнөхөн бас яваад өгцгөөлөө.

-Морис яасан бэ? Тэр өөрийгөө цагаатгахаар ву яртж байна.?

-Өө би таныг мэднэ гэж бодсон юм! Тэр бас олдохгүй байна шүү. Бурхан минь! Дүүгий минь алсан хүний гарт үхсэн ч байж магадгүй.

-Тэднийг мөрөөр явсан гэж хэлэв үү? Мэдээжээр мустангерын мөрөөр яваа биз? Хэрэв тэр хүн амьд л юм бол Аламод байгаа. Тэд яагаад тийшээ яваагүй юм бэ? Аа мэдлээ! Тэдний хэн нь ч гэсэн Спенглер зулзага юм бэ? Аа мэдлээ? Тэдний хэн ч гэсэн Морисын байдаг газрыг лавтай мэдэхгүй. Тэднийг Спенглер зулзага дагуулж яваа юм бол мэдээжээр шохойт талд хүрээд л мөрөө алдана. Тэд бас л тийшээ яваад өгөө биз дээ?

-Тиймээ, тэдний хэн нэг нь үүнийг сануулжбайхыг дуулсан

-Хэрэв тэд мустангерыг хайхаар явсан бол би ч гэсэн хөдөлье. Тэднээс өмнө Морисыш оно гэдгээ андгайлья.

Тэгээд л би тантай уулзахыг хүссэн юм. Аавтай хамт янз бүрийн хүн явсан. Хөдлөхдөө хачин их хараа зүхэл тавьцгаан нь сонсогдлоо. Өчиггүй шүүх юм яриад байна билээ. Ямар ч өршөөлгүйгээр өшөө авнагэж зарим нь тангараг өргөх байсан. Тэнгэр минь! хэрэв тэд Морисыг олох юм бол , тэр гэм хийгээгүй! гэдгээ итгүүлж чадахгүй бол яана!... Бас тэгээд Кассий Колхаун шиг тийм хүн дотор нь яваа, хорсол занал нь ба Дарсан хүмүүс Морисыг яахыг та бодооч?! Эрхэм Зеб минь, миний төлөө, найз нөхөрлөлийн төлөөтэр таны анд шүү дээ. Аламо руу явж үз, бушуухан яв! Тэднээс заавал түрүүлж Морист урьдчилан мэдэгдэх нь чухал. Таны морь хөнгөн хөлтэй биш шүү дээ. Миний морийг ав. Манай саравчинд байгаа морьдоос дуртайгаа ав! Бушуулаарай...

-Зүйтэй гэж анч өвгөн, түүний үгийг тасалж хэлээд явахыг завдаж - Үнэндээ энэ хэрэг мустангерт муугаар төгсч болно. Би түүнд туслахын тул чадах бүхнээ хийнэ. Луиза авхай битгий санаа зов. Цаг байна, тэднийг талд мунгинаж явахад нь амжуулна. Би муу хөгшин гүүгээрээ дажгүй түрүүлж амжина. Танб бидэрт мустангад мордох зүрх алга. Бас тэгээд Плутон л эмээлий нь авчихаагүй бол миний морь эмээлтэй байгаа... Битгий гуньж гутар. Дүүд чинь ямар нэг муу юм тохиолдоогүй ч байж болно. Харин Морис бол ариун шударга залуу. Энэ нь надад тодорхой байна. туйлын тодорхой байна гээд мэхийн ёслоод гарч одов. Луиза хайр хүнээ аврах талаар догдолсон сэтгэлээ тайтгаруулахаар өрөөндөө явж орлоо.

XLVII. Олзлогдсон захидал

Гэнэт жигтэйхэн их айж сандарсан Талын Чоно болоод түүний нөхөд морьд руугаа гүйж очоод санд мэдн мордоцгоов.

Тэд Морсын овоохойд буцаж очихыг ч бодсонгүй. Харин ч энэ зэлүүд овоохойгоос, нүдний нь өмнө тийм хачин байдалтай харагдсан эзнээс нь аль болох холдохын түүс болжээ.

Өнөөх хүн бол ‘ Эрхэм Морис’ мөн гэдэгт хэн ч эргэлзсэнгүй, Дөрвүүлээ, тэдэн дотроос Диас хамгийн илүү таньдаг ч гэлээ, цөм л морь унасан толгойгүй хүн бол Морисоос өөр хэн ч биш гэдэгт итгэж байжээ.

Тэд унасан морь, цоохор барын арьсаар хийсэн гутал, жирийн мексик серапэгээс хурц тод өнгөөрөө ялгардаг навахо омгийн индиан нарын хийсэн серапэгий нь таьжээ. Эцэст нь толгойг нь ч харсан байна.

Тэд царайг нь сайн харж амжсангүй. Харин толгой дээр нь Морисын үргэжл өмсөж явдаг гилчгэр хар өнгөтэй дэлбэгэр бүрх байжээ. Малгайнь сарны зурвас туяанд гялалзан харагджээ.

Тэд бас нэг том нохой харжээ. Түүнийг Морисын нохой гэж Диас дотроо таньжээ. Тэр нохой, тэдний хойноос галзуу мэт архиран дайрчээ. Үнэндээ тэд гэртээ тэргүй тэнхээ мэдэн зугадсан болохоор нохойны тэгж архиран дайрсан нь илүү байв.

Дөрвөн морьтон ойн ширэнгэ дундуур ум хумгүйдавхицгаав. Тэд хүн алах гэж төлөвлөж байсан газраа тойрон хэц дээгүүр давж тал хөндийд орлоо.

Тэнд ч зогссонгүй давхисаар команч болж зүсээ хувиргаж авсан өнөөх ойн ширэнгэдээ орлоо.

Тэд зүсээ буцаан хувилгаж, хуучин биедээ орохдоо яарч сандран төдий их анхаарл тавьсангүй. Өөрсдийн авч явсан том дашмагтай усаар биеийнхээ будан шунхыгсанд мэнд угаагаад, модны хонгилоос мексик хувцсаа авч , яаран өмсөнгүүт мориндоо харайн мордож Леон голын зүн давхицгаалаа.

Тэд буцах замдаа зөвхөн морь унасан толгойгүй хүний тухай ярьцгаав. Хосгүй их айж тэвдсэн мексик мустангер нар тэр ер бусын үзэгдлийг тайлбарлаж чадсангүй. тэгээд гүнээ гайхаж эргэлзсэн хэвээрээ суурины захад очиж бие биедээ салах ёс гүйцэтгээд, өөр өөрсдийн урц руу явцгаалаа.

-Чөтгөр ав! гэж Талын Чоно урцныхаа босгыг алхангуут хэлээд зэгсэн орон дээрээ ойчоод - Ийм Юм үзсэний дараа нойр хүрнэ гэж үү. Гэгээн минь! Мөн ч хачин үзэгдэл байна шүү хамаг цус минь царцчихлаа. Бүлээцүүлж ухаан оруулах юм ч алга. Дашмаг хоосон. Буудлын газар хаалттай. Хамаг амьтан унтаад өгсөн_ Дар эх минь, тэр ер юу юм бэ? Буг чөтгөр юм уу? Бишээ! Би өөрөө түүний биеийг барьвж үзсэн. Вансенте ч нөгөө талаас нь барьсан шүү дээ... Хоёул хоёулаа андуурна гэж яаж байх вэ? Хэрэв жирийн нэг чихмэл бол хэнд, ямар хэрэгтэй

юм бэ? Бид хэдээс өөр хэн тэгж хээр талд багт наадам гарагж байх билээ дээ? Чөтгөр аваг! Яасан гайхалтай наадам бэ!... Үгүй байз, надаас урьдчихаагүй байгаа даа? Надаас өөр ямар нэг хүн мянган доллар хүртчихсэн юм биш биз? Өнөөх ирланд толгойгоо авахуулж, гартаа барьчихаад явж байсан юм болов уу? Үгүй, тийм хүн үнэмших аргагүй гайхалтай муухай худал юм байж болохгүй! Тэгвэл юу вэ?... Аа мэдлээ! Тэд биднийг овоохойд очихыг хэн нэгнээс мэдсэн юмуу, эсвэл очно гэж хардаж, сэжиглэсэн байж болно. тэгээд биднийг айлгах гэж тийм инээдэмтэй үзэгдэл гаргасан байна. Бүгдийг ичгэвтэртэй зугадаж байхыг тэр лав өөрөө харсан даа, цусыг даа!... Гэвч хэн биднийг хэлсэн байж таарах вэ? Хэн ч тэгэхгүй. Үнэндээ миний санааг хэн ч мэдээгүй. Тэгэхээр тэр яаж тийм, хүний санаанд ормооргүй шуламсын арга гаргаж чадах вэ! Өө тийм, би бас нэг юм мартчихаж! Бид гэгээн цагаан өдрөөр тал дундуур явснаа мартчихжээ. Биднийг харчихаад санаагий маань тааварласан байж болно. Тэгсэн л байх ёстой. Тэгээд биднийг модон дотор хувцсаа сольж байхад тийм юм хийж л дээ. Өөрөөр байж болохгүй... Тэнэг амьтад! Мануухайнаас айж шүү!... Чөтгөг ав! Тэгж ярихгүй ээ, хөө. Би маргаан дахиад Аламо руу явна. Нэг жилийн хугацаа хэрэгтэй боллоо ч гэсэн тэр мянган доллрагы олж авна даа! Ер нь хэргийн учир мөнгөндөө ч байгаа юм биш. Исидорыг алдсан маань л хангалттай. Исидорыг түүнд алдаагүй ч байж болох юм. Гагцхүү тэгж бодоход л тэвчиж болшгүй юм. Хэрэв тэр хүүхэн Морист дурлаж, түрүүчийн явдлаас хойш түүнтэй уулзан учирсан гэдгий нь мэдвэлдээ, чамайг... Ээ, бурхман минь! Би солиорч байна! Тэгээд солиорохынхоо эрхэнд зөвхөн тэр үзэн яддаг хүнээ алаад зогсохгүй, бас дурласан хүүхнээ ална даа! Ээц, Исидора авхай минь! Гайхамшигт гоо сайхны бурхан, гайт хар санааны шулам юм! Би чамайг нэг бол тэврэн ална_, эсвэл хутглаж ална даа! Аль нэг нь лбайж таарна. Чи алийг нь сонгож авахаа өөрөө мэд

Ийм занал, нөгөө хачин зүйлийг өөрийнхөөр тайлбарласан нь уймарсан сэтгэлийг нь жаахан тайвшруулж санаа нь амраад тэр дорхиноо унтчихав.

Үүдээр нь шагайн туссан өглөөний гэгээтэй хамт зочин босго алхан ороход Талын Чоно нойроос сэрэв.

-Хосе! Чи хүрээд ирэв үү? Гэж тэр илтэд баярлан гайхсан дуугаар хашхирав.

-Тийм ээ би ирлээ.

-Хосе, найз минь чамтай уулзсандаа баярлаж байна. Исидора авхай бас ирсэн үү? Би түүнийг Леонд ирсэн үү гэж асууж байгаа юм шүү.

-Тийм ээ ирсэн.

-Тийм түргэн эргэж ирээ юу? Эндээс яваад хоёр долоо хоносонгүй шив дээ? Би сууринд очоогүй. гэвч энэ тухай сонссон. Би чамаас мэдээ хүлээж байлаа. Чи яагаад надад огт юм бичсэнгүй вэ?

-Эрхэм Мигуэль минь надад найдвартай хүн байхгүйгээс л ийм боллоо. Өөр хүнд итгэж хэлүүлмээргүй ямар нэг мэдээ танд өгөх хэрэгтэй байсан юм. Харамсалтай нь, миний хэлэх юманд та баярлахгүй л дээ. Гэхдээ миний амь таны гарт шүү дээ. Би танд хэлсэн юмаа цөмийг хэлж өгч байна гэж амласан шүү дээ.

Талын Чоно хатгуулсан юм шиг өндөсхийж,

-Тэр хоёрын хоёулангий нь тухай юм байх нь ээ! Би чиний царайг хараад мэдэж байна. эзэн хатан чинь түүнтэй уулзаа юу?

-Үгүй ноён минь. Миний л мэдэж байгаагаар бол нэг уулзсанаасаа хойш дахиж уулзаагүй.

-Тэгээд юу гэж? гэж Диас нэлээд сэтгэл тайвшран асуугаад -Тэр хүүхэн нөгөө дэхийг зочид буудалд сууж байх хооронд энд байгаа биз дээ? Тэр хоёрын хооронд ямар нэг холбоо байсан уу?

-Тийм ээ, ноён Мигуэль минь байсан. Исидора авхай түүнд өгүүлсэн амттантай сагсыг би гурван ч удаа хүргэж өгсөн. Сүүлчийнхэд нь захидал хавсаргасан байлаа.

-Захидал гэнэ ээ! Чи түүнийгуншиж, утгы нь мэдэж авсан уу?

-Таны ач, таны сайн сэтгэлийн ачаар муу зарц чинь уншиж чадсан. Тэр ч байтугай хуулж авсан.

-Хуулбар нь чамд байна уу?

-Байна! Ноён Мигуэль та намайг сургуульд дэмий ч явуулаагүйгээ харж байгаа биз дээ? Исидора авхайн захидал энэ байна.

Диас зурвасыг тэсгэлгүй шүүрэнавч, шуналтайгаар уншиж эхэллээ. Тэр зурвас Диасын санааг амраах шиг боллоо.

-Карамба! Гэж захидлыг хайш яаш хумхиж хэлээд, - Хосе найз минь энэ захидалд онц юм юу ч алга. Энд зөвхөн тэр хүүхнийхээ ач тус хүргэсэнд талархал илэрхийлсэн байна. хэрэв ингээд л бүх юм гүйцвэл...

-Үгүй ээ, гүйцээгүй. Үүний төлөө л би танайд ирсэн юм. надад сууринд хүргэх бичиг байна. Унш л даа.

-Өө! Өөр захидал уу?

-Тийм ээ, эрхэм минь. Энэ бол миний шаазгайн мөр шиг сарвагар бичиг биш, ёстой захидал байгаа юм.

Диас чичирсэн гараар бичгийг авч задлаад уншиж гарсан нь:

Эрхэмсэг Морис Жеральдад. Эрхэм найз минь, би бас Сильво авгYNдаа айлчилж ирээд байна. Би таны тухай сураг чимээ сонсохгүйгээр санаа амар сууж чадахгүй нь. Тэгж сураг чимээгүй байгаад чинь зовж байна. Өвчилснөөсөө хойш бие чинь сайжирсан уу? Ээ, сайжирсан л байгаасай нь билээ! Сайхан нүдий чинь харж, таныг цоо эрүүл болсныг чинь нүдээрээ харахыг яасан их хүснэ вэ! Надад ийм баяр байсгалан олгохыг танаас гуйя. Би хагас цагийн дараа авгYNхаа гэрийн цаадах толгой дээр гарна.

Наашаа ирээрэй. Би хүлээж байя!

“Исидора Ковариубио де Лос-Ланос”

-Өөдгүй новш! Хайр сэтгэлийн болзоо байх нь! Гэж Диас зэвүүнээр дуу алдаад - Өөрөөр нэрлэх ч аргаалга. тэр хүүхэн өөрөө болзоо тавьж байдаг. Үгүй ер өө! Түүний урилгыг хүлээж авах болно. гэхдээ тэр найр тавиад байгаа хүн нь биш. Тэнд минут ч хожимдолгүй очих юм шүү. Тэгээд яаж өшөө авдгаа үзүүлэмц.... Хосе, сонсож бай! Энэ зурвас чинь хэнд ч хэрэг болохгүй. Хаягласан хүн нь аль хэдийнэсууринд ч , ойр хавьд ч байхгүй болсон. Хаана байгааг нь бурхан л мэдэх байх. Нэг нууцлаг юм болоод байгаа юм. Тэгэхдээ зүгээр. Зочид буудал руу очоод ямар ч байсан сурагла л даа. Чи эзэгтэйхээ даалгаврыг биелүүлэх ёстой. Захиагаа надад орхичих. Чамайг буцаад ирэхэд чинь өгөмц, тэгээд эзэгтэйдээ эргүүлээд өгчихнө биз. Майэнэ долларыг ав, бааранд юм авч уугаарай. Ноён Доофер ч сайн архитай шүү. Баяртай! Гэв.

Хосе тайлбар ч шаардсангүй, доллары нь аваад чимээгүйхэн шиг оромжоос гарав.

Түүнийг далд орж амжаагүй явахад нь Диас ч мөн овоохойноосоо гарч ирлээ. Морио хам хум эмээллэж мордонгуугаа Хосгийн явсны эсрэг зүг рүү явлаа.

XLVIII. Исидора

Тал нутгийн хязгаарт дөнгөж нар тусав. Улаан шаргал алтан бамбай шиг төгрөг шар нарны туяа өндөр ургасан өвс ногоон дээгүүр гүйж, онгонтал дунд энд тэнд тархан ургасан булар шугуй дотор алтан туяа нь нэвтэрнэ. Шүүдрийн том том дусал хуайс модны сэрмэгэр навчсыг даран бөнжийж, газар ру бөхийлгөнө. Моднууд шөнийн харанхуйгаас гагацаж, ядан, чийгтэй, сэрүүн амьсгалаас салах цагаа хүлээн, өдрийн аагим халуунтай уулзахаасаа айж байгаа мэт санагдана. Шувууд мандах наранд баяр хүргэн мэндэлж байгаа юм шиг модны нахиа мөчир дээгүүр хөгжилтэй жиргэлдэнэ. Харин Техасын тал нутгаас өөр ямар нэг газар тийм эрт сэрсэн хүнтэй дайралдаж яахан болох билээ. Энэ нутагт наран мандах үе бол өдрийн хамгийн аятайхан цаг бөгөөд хөнжилдөө ч юмуу, өрөөндөө энэ үеийг өнгөрөөх хүн ховор.

Инж цайзаас гурван бээрийн доошоо, Леон голын эрэг дээр өглөөний нойроо зөнд нь орхиж шугуйд зугаалахаар шийдсэн бололтой нэг морьтой хүн гарч ирэв. Амы нь татахад дургүйцэж буй бололтой аргамаг хөлөг унажээ. Европт бол эмэгтэй хүнд зохисгүй гэж үзэдгэ морин дээр суусан маяг, өмссөн хуцвас, мөрөн дээрх серапе, дэлбэгэр бүрх энэ бүхэн нь түүнийг эрэгтэй хүн юм гэж бодогдуулж магадгүй. Гэвч энэ бол баруун өмсөнд Техаст болж байгаа хэрэг учир тэднхийн хүүхнүүд бас л эрэгтэй хүн шиг морь унаж яваг бөгөөд түүндээ таарсан хувцас өмсдөгийг мартаж болохгүй.

Сайтар ажиглан харвал энэ өглөө эрт морь унаад явж байгаа хүн маань эрэгтэй хүн биш үнэхээр эмэгтэй хүн болохыг итгэх болно. Жолоо барьсанбулбарай гар, дөрөө жийсэн жижигхэн хөл, эмэгтэй хүний гоолиг зэгчгэр бие, бас дэлбэгэр малгайны хүрээн доогуурх цухуйх эргүүлэн дарсан гялалзсан гэдгий нь харахад л бидний өмнө эмэгтэй хүн явж байгаа нь эргэлзээгүй болно.

Одоо таны өмнө, зарим талаар эмэгтэй хэнд баймгүй зантай ч гэлээ, аргагүй л бүсгүй хүн байна гэдэгт эргэлзэхийн аргагүй болно.

Энэ бол Исидора Коварубио де Лос-Ланос авхай байлаа.

Исидорагийн нас нэгэнт хорь гарсан учир мексикийн ойлголтоор охин гэж нэрлэж болохгүй болжээ. Тэр хилэн хар үстэй, гоц сайхан хүүхэн юм. гэвч түүний гоо сайхан нь эм барсынхтай адилхан бөгөөд түүнд энхрийлэн дурлахаасаа илүү сүрдмээр санагдана.

Түүний харцанд эрч шулуун зориг, хатуужил, эмэгтэй хүнд баймраагүй овун цхаан илэрч байв. Царайд нь аймхай доройн шинж огт үгүй. Хөрслөг бор царайд нь идэр залуугийн жавхааг илтгэсэн улаан туяа татаж, үхлийн аюул тохиолдсон ч хувирахгүй ажээ.

Тэр үбсгүй Леон голын модорхог эргээр ганцааооа явж байв. Гэр нь ойрохон харагдавч хүүхэн гэрээсээ холдон явна. Энэ бол түүний алга Сильвио Мартинесын шилтгээн ажээ.

Залуу мексик хүүхэн эмээл дээрээ итгэйтэй, чөлөөтэй суужээ. Унасан морины нь омголныг хэлэх үү, хойд хөл дээрээ цоройн алдан тэмүүлнэ. Гэвч та тэр хүүхний төлөө огт санаа зоволтгүй. Унаанд их сайн бүсгүй.

Авсаархан хөнгөн бугуйл нямбай эвхэж, эмээлийнхээ бүүргэндуглажээ. Их цаг гарган нямбайлан эвхсэн аргаад үүнээ бүсгүй чадмаг эзэмшдэг байх ёстой. Үнэндээ ямар ч мэргэжлийн мустангерээс дутахгүй шиддэг ажээ. Исидора үүгээрээ бахархдаг, зугаагаа гаргадаг зүйлийнх нь нэг байв.

Тэр хүүхэн голын эргийн дагуу их замаар явалгүй, харин авгынхаа шилтгээний хажуугаар гарсан, их замтай голын эгц эргийн толгод дээрнийлдэг хажуугийн нарийн зөргөөр явлаа.

Зөрөг эцг дээшээ гарсан учир сорь нь амьсгаадаж эхлэв. Исидора их зам нийлсэн толгой дээр гараад мориныхоо жолоог татав. Тэгэхдээ морио амраах гэсэн биш, зорьсон газраа хүрээд ирж байгаа нь энэ байжээ.

Замын ойролцоо өвс ногоогоор бүрхэгдсэн өчүүхэн тал нутаг шиг ойн чөлөө байна. ойтой огт адилгүй өргөт ширэнгэ тэр чөлөөний тал бүрээс хүрээлжээ. Үл мэдэг гурван харийн зөрөг зам, бут сөөг дундуур дайран, өөр өөр зүг рүү тэр чөлөөнөөс гарчээ.

Исидора ойн чөлөөнд ирж мориныхоо амыг татан морио тайвшруулан хүзүү рүү нь алгадав. Морь нь өөд газар өгсөөд нэлээд ядарч, урагш тэмүүлэхээ байсан болохоор тэгэх хэрэггүй шахам байжээ.

-Би тогтоосон цагаасаа эрт хүрээд ирлээ! Гэж залуу хүүхэн серапе дороосоо алтан цагаа харж хэлээд, - Ер нь тэр ирэхгүй байж бас магадгүйяа! Бие нь л сайжирсан байгаасай билээ! ... Би чичрээд байх чинь юу болж байна? Эсвэл морь маань амьсгаадаа юу? өө, үгүй, юм байна. Би өөрөө чичрээд байна. Миний сэтгэл хэзээ ч ингэж догдолж байгаагүйсэн. Эсвэл айсных уу? Тийм ээ яг тийм. Хайртай хүнээсээ, дурласан ганц хүнээсээ айж байгаа нь хачин юм! Эрхэм Мигуэльтэй харьцдаг миний харьцааг дурлал гэж хэлж болохгүй нь мэдээж. Энэ бол өөрийгөө хуурсан хэрэг. Түүнээс ангижирсан нь ямар сайн болов. Аз болоход би түүний аймхай хулчгарыг мэдэж авсна юм. Энэ маань миний хий мөрөөдлийн баатрыг ширээнээс нь унагажээ. Үүнд би их баяхтай байна! Би одоо Мигуэлийг... тэр өөдгүйг нь бодохоос үзэн ядаж байна. Бурхан минь, дээрэмчин болсон гэдэг нь үнэн болов уу! Гэвч би түүнтэй энэ зэлүүд газар уулзсан ч гэсэн айхгүй. Би хэрцгий муухайг нь мэдээд жигшин занаж байгаа хүнээсээ ч айхгүй байтлаа хамгийн сайхан, хамгийн ариун шударга гэж тооцоод дурласан хүнээсээ айна гэдэг мөн ч хачин юмаа! Ойлгомжгүй юм! Ухаарахын арга алга! Тэглээ ч гэсэн үүнд ойлгомжгүй хачирхах юм огт байхгүй. Би аюулын өмнө айн чичирсэн юм биш. Зөвхөн надад, дурлахгүй болов уу гэж айж байна. Миний чичирч байгаагийн учир энэ юм. Ийм учраас ч Морис Жеральд индианчуудын гараас намайг салгаж авсан тэр өдрөөс эхлээд шөнө ч тайван унтаж чадахаа байлаа. Би түүнд өөрийн бодож явдгийг хэзээ ч хэлээгүй. Тэгээд ч миний хэлэх үгийг яаж хүлээж авахыг нь мэдэхгүй байна. Гэвч тэр ямар ч байсан цөмийг мэдэх ёстой. Би энэ учир нь үл ойлгогдох зовлонг цаашид тэвчиж чалахгүй нь. Хэрэв хүсэл мөрөөдөл минь намайг хууран мэхэлсэн бол би цөхрөнгөө бараад ч зогсохгүй үхвэл дээр гэж бодож байна.... Байз! Морин төвөргөөн сонсдож байна! Тэр маань ирж явна уу? Тийм ээ! Хурч тод өнгөтэй манай үндэсний хувцас модны завсраар харагдаж байна. Морис Жеральд энэ хувцсыг өмсөх дуртай байдаг юм. Хувцас нь түүнд тэгж зохисонд гайхах юмгүй. Гэгээн Дар эх минь! БиСерапе нөмөрч, дэлбэргэр бүрх өмссөн байгаа шүү дээ. Тэр, намайг эрэгтэй хүн гэж бодох байх! Энэ муу багийг авч хаяя! Би бол эмэгтэй хүн, тэр эмэгтэй хүн байхыг олж харах ёстой!...

Исидора серапе малгай хоёроо хоромхон зуур хуу татан авлаа. Тайзан дээрх жүжигчин ч ингэж хурдан амжуулахгүй байсан биз. Одооногоон ургамлын зэвсгэр дээр эмэгтэй хүний булбарай дүр, үзэсгэлэнт сайхан тэргүүн нь Италийн уран барималч Кановын алдартай сийлбэр шиг дурайв.

Тэр бүсгүй дөрөөн дээрээ яльгүй өндийж, бүх биеэрээ урагш бөхийн хүлээж учрахын дүрээр хувирав.

Исидора айж байна гэж хэлж байсан мөртөө одоо огтхон ч айсан шинжгүй байв. Түүний царай зүс хувирч, уруул ам нь чичиргэнэхгүй ажээ.

Харин ч нүдний нь харц урагш тэмүүлж, бахтай дурлалын уриа дуудлага% эр бор харцагаа хүлээсэн охин харцагын уриа дуудлага гэмээр байв.

Гэтэл гэнэт түүний байдал шал өөр болоод явчихав. Айсуй яваа морьтонг танвьжээ. Алтан хиаз л түүнийг төөрөлдүүлжээ. Мексик хувцас өмссөн тэр морьтой хүн Морис Жеральд биш, харин Мигуэль Диас байлаа.

Сэтгэл нь хөдөлж, хөхүүн хөгжилтэй байсан Исидорагийн урам хугарав. Арга нь барагдсан хүүхэн эмээл дээрээ суун тусч, цөхрөн хашгирах мэтсүүрс алдав.

Талын Чоно эхлэн дуугарч

-Өө, энэ чинь хатагтай та байсан юмуу! Таныг ийм зэлүүд газар, эл өргөт бутны дундах сарнай шиг байж байх юм гэж хэн бодох вэ дээ! гэв.

-Энэ бол эрхэм Минуэль танд ямар ч хүртээлгүй юм биш үү?

-Хачин асуулт байна авхай минь. Энэ бол надад хүртээлтэй байлгүй яах вэ. Та үүнийг өөрөө сайн мэднэ. Би танд ухаангүй дурладгийг та сайн мэднэ. Би таны боол гэдгээ хэлэх үед тэнэг амьтан байж. Чухам энэ л таны сэтгэлийг тийм амархан хөргөчихсөн байжээ.

-Эрхэм та эндүүрч байна. Би танд хайртай дуртай гэж хэзээч хэлээгүй. Хэрэв мориндэрэмгий чинь надад таалагддаг гэж би хэлсэн бол, тэгж хэлснийг минь өөрөөр тайлбарлах эрх танд байхгүй. Би таныг шохоорхоогүй, зөвхөн морь унадаг чадварыг чинь шохоорхсон юм. Түүнээс гадна энэ бол гурван жилийн өмнөх хэрэг. Тэгэхэд би жаахан охин байсан. Тийм тэнэг байдаг насанд имйэрхүү юм гүн сэтгэгдэл төрүүлж, хүнийг сэтгэл дүрхээр нь биш, гадаад өнгөөр нь үнэлдэг юм. Харин би одоо том болж олон юманд өөрөөр ханддаг болсон нь зүй ёсны хэрэг.

-Чөтгөр ав, тэгвэл та яагаад намайг худлаа горьдоож байсан юм бэ? Би цоо эмнэг шар сургаж, аавын чинв адуун сүрэг доторхи хамгийн догшин морийг номхруулсан, тэр нэг мал имнэсэн өдрийг санаж байна уу? Түүнд нэг ч малчин ойртож зүрхэлдэггүй байсан шүү дээ. Тэр өдөр та намайг хараад инээмсэглэсэн. Тэгэхэд нүдэнд чинь дурлалын тэмдэг үзэгдэж байсан юм. Исидора авхай та үүнийг битгий мэлзээрэй! Би хүмүүсийг зэгсэн сайн мэддэг болхоор таны юу бодож, юу сэтгэж байсныг царайгаар чинь мэдсэн юм. Гэвч одоо та шал өөр болжээ.

Яагаад тэр вэ? Яагаад гэвэл би таны хуурамч илбийн эрхэнд орсон буюу өөрөөр хэлбэл үүнийгээ зөвшөөрчихсөн юм. Харин та эмэгтэй хүнд байдаг ёсоор түүнийгээ мэдээд яллагдагчаа сонирхох сонирхлоо алдсан юм. Энэ тийм шүү авхай минь, та битгий мэлзээрэй!

-Үгүй, тийм биш ноён Мигуэль Диас. Биүгээрээ ч гэсэн, харцаараа ч гэсэн, хэзээ чтанд дурласны тэмдэг үзүүлээгүй. _ Та бол зүгээр л нэг моринд эрэмгий шударга эр хүн гэж надад санагддаг байснаас өөр юмгүй. Ямар ч байлаа гэсэн тэр үед л тэгж санагдсан юм. Харин та одоо ямар хүн болчихоод байна даа. Таны тухай энд, зөвхөн энд чбиш, бас Рио-Грандад юу гэж ярилцдагийг та мэдэж байна уу?

-Би худал гүтгэлгэнд хариу өгөх хэрэггүй гэж бодож байна. Тэртэй тэргүй энэ бол урвагч анд нар эсвэл хортон санаат дайснуудын зохиосон гүтгэлэг юм. Би учры нь дуулах гэж энд ирснээс би, тайлбар хэлэх гэж ирээгүй.

-Хэнээс?

-Танаас, үзэсгэлэнт Исидора авхай.

-Эрхэм Мигуэль Диас та өөртөө дэндүү итгэсэн хүн юм. Эрхэм та хэнтэй ярилцаж байгаагаа битгий мартаарай. Би бол...

-... Та бол Тамаулипасын хамгийн эрхэмсэг омогтой эздийн нэгний нь охин, мөн Техаст багагүй хүндтэй баян хүний зээ юм. Би энэ бүхнийг бодсон. Тэр ч байутгай би өөрөөхээ нэг цагт ордны эзэн байгаад одоо зөвхөн зэрлэг морь авлагч төдий болчихоод байгаагаа ч санаж байна. Карамба! Энэ яах вэ! Та бол зөвхөн ядуу гэдгээс нь болоод хүнийг зэвүүцэх тийм бүсгүй биш. Ядуу мустангер хүн ч гэлээ танд олон зуун адуутай баян тарган хүний адил таны ивээлийг горьдож чадах нь илэрхий. Тэгээд ч таны өгөөмөр сайхан санааны баримт нотолгоо надад байна.

-Ямар нотолгоо вэ? гэж бүсгүй анх удаа сэтгэл нь зовсноо илтгэн асуугаад - Таны тэр эелдэгхнээр минийх болгоод байгаа нотолгоо чинь хаана байна? гэв.

-Энэ сайхан захидал дотор байна. Исидора Коварубио де Лос-Льяносын гарын үсэгтэй захидал энд миний гарт байна. Энэ захидал над шиг л тийм нэг ядуу мустангерт очих байжээ. Энэ захидлыг заавал танд өгөхийн хэрэг байна уу даа. Та тэндээсээ хараад танина биз дээ?

Бүсгүй захидлыг таньсан нь Диас руу ууртай харсан харцаар нь мэдэгдэв.

-Энэ захидал яагаад таны гарт орчихоо вэ? гэж Исидора дургүйцсэнээ нуухыг оролдолгүй асуув.

-Тэр нь чухал биш. Миний гарт л орсон юм. Үүнийг би аль хэдийн олж авсан. Тэгэхдээ намайг сонирхохоо байсны чинь мэдэхийн тул биш, энэ бол надад тодорхой байгаа юм. Харин өөр хүнийг сонирхох болсны чинь нотолгоог олж авах гэсэн юм. Энэ захидлаас харахад та түүнд дурласан нь илт байна. Түүний сайхан нүдийг харах гэж хүсэн мөрөөдөж байдгийг чинь энэ захидал хэлж өгч байна. Харин та түүнтэй хэзээ ч уулзахгүй болсноо

мэдээрэй!

-Эрхэм Мигуэль Диас, энэ чинь юу гэсэн үг вэ? гэж бүсгүй асуув.

Хоолой нь хариу сонсохоос айсан юм шиг чичигнэнэ. Үүнд гайхах юм алга. Талын Чонын царай айдас хүрмээр харагдаж байжээ.

Диас бүсгүйн айсныг ажиглаад хариу хэлсэн нь:

-Таны айдаг чинь долоон зөв. хэр би Исидора авхайн таныг алдчихсан бол таныг өөр хэнд ч өгөхгүй гэж шийдсэн.

-Ойлгохгүй байна, энэ чинь...

-Таныг өөр хэн ч өөрийнхөө болгохгүй. Мэдээж Морис мустангер бүр ч ярихгүй гэдгийг би танд хэлсэн.

-Өө тийм бий!

-Тийм ээ! Яг тийм. Та үүнээсхойш хэзээ ч түүнтэй уулзахгүй гэж амла, эс тэгвээс та эндээс мэнд явахгүй шүү!

-Ноён Мигуэль та тоглож байна уу?

-Үгүй ээ, Исидора авхай, би чин үнэнээсээ ярьж байна.

Энэ үгийн үнэн болох нь эргэлзээгүй байв. Талын Чоно хэдийгээр аймхай хулчгар боловч, харц нь түүний нэгэнт шийдсэн хүйтэн хэрцгий байдлыг илэрхийлж байгаагаас гадна, хутганыхаа ишийг хэдийнээ атгачихсан байлаа.

Исидора хэдийгээ зоригтой ч гэсэн балмагдаж эхлэв. Мултран гарахад амрагүй аюул заналхийлж байгааг ойлгов. Энэ уулзалтын эхнээс эхлэн бүсгүй түгшиж байсан боловч Морис ирээд эвгүй яриаг таслан шал өөр юм руу чиглүүлнэ гэж итгэж байжээ.

Залуу мексик хүүхэн Талын Чонотой анх ярилцаж байхдаа моин туурайн чимээ чих тавин чагнаж, ширэнгийн нөгөө зах руу, тэр чимээ гарах ёстой зүг рүү байн байг харж байжээ.

Одоо тэр найдвар нь тасарчээ. нэгэнт явуулсан захидал нь мексик эрийн гарт байгаа болохоор хаягласан хүндээ очоогүй гэсэн үг. Тусламж горьдохын хэрэггүй болсон учир яаж ийгээд зугадахыг бодов. Гэвч тэгж зугатах нь хэцүү бөнөөд амь насанд нь аюултай байв. Мориныхоо амьг эргүүлээд давхиж болох боловч Талын Чонын гар хутга, буундаа ойрхон байсан учир араасаа сум зооглочихож мэдэх байлаа.

Исидора хамаг аюулыг бүрнээ цэгнэж үзэв. Түүнээс өөр ямар ч хүүхэн байсан самгардах байсан боловч Исидора тэр заналхийлэл өөрт нь ямар нэг сэтгэгдэл төрүүлснийг ч ил гаргасангүй.

-Дэмий юм! гэж их итгээгүй шинжтэй дуу алдаад - Та надаар тоглож байна. намайг айлгах гэж л дээ. Ха-Ха-Ха! Би яалаа гэж танаас айх юм бэ? Би морь унахдаа танаас доргүй. Бас бугуйлаа тантай адилхан сурмаг хол шиддэг. Бугуйлаа яаж чадмаг шидэхийминь хар л даа! гэж инээмсэглэн хэлээд эмээлийнхээ бүүрэгнээс буйглаа тайлан авч эрдэм чадлаа үзүүлэх гэж байгаа юм шиг толгой дээгүүрээ эргүүлээ.

Гэвч санаа нь шал өөр байсныг Диас тааж мэдсэнгүй. Бүсгүйн аяг занг гайхсан мань эр хөдөлж аашлахы нь дуугүй харж байлаа.

Зөвхөн бугуйлын сур тохойгий нь ороож авахад л мексик эр бүгдийг ойлгосон боловч нэгэнт хожимджээ. Дараагийн агшинд гар нь хавиргандаа наалдаж янгинатал хүлэгдэн, хутгандаа ч буундаа ч хүрэх аргагүй болжээ.

Талын Чоно бугуйлаас барьж амжихаас өмнө эмээлээс нь угз татан унагаж, ухаангүй амьтан газар гулдайв.

-За эрхэм Мигуэль Диас та дахин намайг сүрдүүлэх хэрэггүй шүү! гэж Исидора мориныхоо амыг эргүүлж хэлээд - Сулрах гэж битгий оролд. Зөвхөн хуруугаа л хөдөлгөвөл чинь би одоохон урагш давхина шүү! Муухай золигийг дээ чамайг! Чи аймхай хулчгар мөртөө намайг алах гэж боджээ. Үүнийг би чиний нүдний харцаар мэдсэн юм. Тэгэдг хөг чинь өнгөрч. Харин... гэснээ хариу дуугарахгүй болохор нь чимээгүй болоод бугуйлаа улам чангалан унасан хүнийг нүд салгалгүй харав.

Бугуйлд хүлэгдсэн Талын Чоно газарт хөдлөлгүй хэвтэнэ. Тэр мориноос унахдаа ухаан алджээ. Үхсэн ч юмуу гэмээр санагдана.

-Дар эх минь! Би алчихаагүй байгаа даа? гэж Исидора морио жаахан ухраасан боловч бүр эргэлгүй ухас хийхэд бэлэнболгож - Би хэдий ингэх бүрэн эрхтэй ч үүнийг хүсээгүй юмсан. Энэ өөрөө намайг алах гэж эрс шийдсэн хүн шүү дээ... Энэ үхчлээ юү? Эсвэл намайг ойртуулах гэж баашилж байна уу? Яах вэ, үүнийг өөр улс шийдэг. Одоо би гэр рүүгээ зоригтой явж болно. Энэ намайг хөөж чадахгүй. Зарц нар хүлгий нь тайлах юм байгаа биз. Ноён Мигуэль, Диас гуай баяртай! Гэж хэлээд бугуйлаа яг эмээлийн бүүрэгний тус газраас тас огтлов. Тэгээд газарт тэрийн хэвтэж байгаа золиныхоо хүнийг тэр чигээр нь орхиж ийм юм хийсэндээ гутарсан ч янзгүй гэр өөдөө давхилаа.

XLIX. Бугуйлыг сулав

Айж сандарсан бүргэд муухай дуу гарган, хөгшин улиангарын мөчир дээрээс сүрхийн тэнгэр өөд цойллоо.

Аварга далавчаа ганц дэвэхэд хэлийнээ агаарт халин, ойн цоорхой, ойр хавийн шугуйг гярхай ажиглаж эхлэв. Ойн цооххойд амь алдсан бололтой нэгэн хүн газарт гулдайн хэвтэж, хажууд нь морь нь чангаар унгалдан давхина. Шугуйд хоёр морьтой эмэгтэй харагдав. Толгой нүцгэн үс нь салхинд хийссэн, эмээл дээрээ эр хүн шиг суусан нэг нь ойн цоорхойгоос давхин гарав. Цоохор морьтой, эмээл дээрээ авхай маягаар хажуулдаж суусан нөгөө дэх нь ойн цоорхойг чиглэн явна. Нимгэн платые өмсөн, бүрх духдуулжээ. Аажуухан хатируулах агаад царайд нь сэтгэл зовсон шинжтэй ажээ.

Бүргэдийн өндрөөс харсан зүйл нь энэ.

Хоёр морьтонг хоёуланг нь бид танина. Ойн цоорхойгоос давхиж яваа нь Исидора Коварубио де Лос-Льянос, цоохой руу чиглэж яваа нь Луиза Пойндекстер байлаа.

Нэг нь яагаад ойн цоорхойг орхих болсныг бид хэдийнээ мэднэ. Харин нөгөө дэх нь тийшээ явж байгааг л тайлбарлах үлджээ.

Залуу креол хүүхэн Зеб Стумптэй ярилцсаныхаа дараа тасалгаандаа очиж эх дагинын баримлын өмнө сөхрөн суугаад залбирч гарлаа. Тэр бүсгүй бүх креол хүний адил католик шашинд шүтэж, бурхны авралд гүнээ итгэдэг байжээ. Залуу креол бүсгүйн залбирал нь хачин жигтэй, гунигтай байлаа. Бүсгүй өөрийнхөө дүүг алсан гэж хэлэгдэж байгаа хүний төлөө залбирч байлаа.

Тэр аймшигтай гэмт хэргийн буруутан нь Морис Жеральд биш гэдэгт Луиза агшин зуур ч эргэлзсэнгүй. Энэ бол байж болшгүй юм. Хэрэв түүнд жаахан ч гэсэн сэжиг төрвөл зүрх нь ийм юмыг давахгүй байлаа.

Бүсгүй Морисыг өршөөгөөч гэж эх дагинаас гуйсангүй. Түүнийг өөрийнхөө андууд болох дайснуудаас хамгаалаач гэж залбирч байв.

Залуу креол бүсгүй цурхиран уйлахад залбирлын үгс нь тасалдана. Тэр хүүхэн дүүгээ эгчийн ёсоор их л энхрийлэн хайрладаг байжээ. Луиза гашуудал зовлонд гүнээ нэрвэгдсэн боловч тэр зовлон нь ураг төрлийн барилдлагаас илүү хүчтэй өөр нэг сэтгэлийг нь дарж чадсангүй. Тэр дүүгийнхээ төлөө гашуудсаар, хайрт хүнээ аврахын төлөө залбирч байв.

Тэгээд босохдоо, түүний янагийн үгийг сэтгэлтэй хүнд нь дамжуулахад нэг бус удаа тус болсон нум руу санамсаргүй харчихав.

“Ээц, би Морист энэ аюулын тухай урьдчилан мэдэгдэхийн тул нэг сут илгээж болдог ч болоосой!”

Ингэж бодсон нь, тэдний нууцаар учирсны ул мөр үлдээгүй байгаа? Гэдэг өөр нэг юмбодоход хүргэв.

Морис тэр нэг шөнө болзож уулзсаныхаа дараа завиар ус гатлахын оронд өөрөө сэлж гарсныг Луиза саналаа. Бугуйл нь завь дотор заавал үлдсэн байх ёстой.

Гашуудал зовлонд учирсан луиза урьд нь энэ тухай бодсонгүй. Хэрэв бугуйл олдвол, өөрийнх нь бодож байгаагаар зөвхөн тэр хоёр болгон, нэгэнт дуугарахаасаа өнгөрсөндүү нь мэдэж байгаа шөнийн уулзалтыг нь ч илчилчихэж болох байлаа.

Наран нэлээд дээр хөөрч шилэн хаалгаар тодхон тусна.

Луиза цэцэрлэг рүү бууж, завь тийш очихоор хаалгыг нээв.

Гэтэл жигүүрийн асарт оронгоо дэр нь хүн ярилцаж байгааг сонсоод зогсов. Эзнээ байхгүйд асотей зээр гарч цэвэр агаар амьсгалах гэсэн түүний зарц Флоринда, хөтөч хоёр ярилцаж байсан нь тэр байжээ. Тэдний яриаг дор нь байгаа хүн тов тодхон сонсч болохоор байв. Гэвч Луиза төдий л сонирхсонгүй. Гагцхүү өөрт нь эрхэм хүндтэй хүний нэр сонсогдоход чих тавин чагнав.

-Тэд нөгөө Жеральдын тухай ярилцаад байгаа юм. Түүний нэрийг Морис Жеральд гэдэг юм. Тэд, түүнийг ирланд хүн гэгцгээдэг. Тэр нь үнэн бол Шинэ Орлеонд миний үзсэн ирландуудтай огт адилгүй хүн билээ. Тэр ёстой ёсорхог хүмүүжилтэй эзэн баймаар хүн дээ. Тийм л баймаар хүн шүү дээ!

-Тэр чинь Генри гуайг алсан гэж чи бодохгүй байна уу? Плутон?

-Мөн бодох юмаа олов оо! Тэр хүн Генри гуайг алсан гэнэ шүү! Нэртэйгээр нь намайг Генри гуайг алсан гээд хэлчих л дээ. Тийм л худлаа юм шүү дээ... Хүүш, хараач, Флоринда! Сайн хүн санаагаарааи гэгчээр өөрөө ирж явна. Аль вэ тийшээ хараачээ.

-Хаашаа?

-Тэр, голын цаад талд. Морь унасан эрэгтэй хүнийг харж байна уу? Тэр бол хар талд бидэнтэй уулзсан өнөөх Морис Жеральд байна... Луавхайд өнөөх бидэрт мустанг бэлэглэсэн хүн. Тэдний өнөөх эргээд олохгүй байгаа хүн чинь шүү дээ! Тэд эрэх газраа олсонгүй. Өнөөдөр л лав талаас түүнийг олохгүй нь!

-Чи үүнд баярлахгүй байна уу, Плутон? Би трэр хүнийг буруугүй гэж итгэдэг юм! Тэр мөн ч зоригтой сайн ноён шүү! Хэзээ ч тийм юм хийхээр хүн биш...

Луиза цааш сонссонгүй. Тэр гэртээ буцаж ороод асотей өөд алгуур өгсөв. шатаар явж байхад зүрх нь хүчтэй цохилон, хөлийн чимээг нь дарчих шиг санагдана. Сэтгэлийнхээ хөдөлгөөнийг зарц нараасаа арайхийн нууж байлаа.

-Та нар юунд ингэж чанга чанга ярида байгаа юм бэ? юугаа тэнд харчихаа вэ? гэж Луиза ширүүн дүр үзүүлэн асуулаа.

-Өө, Луиза, авхай та тийшээ хараач! залуу эр...

-Ямар залуу эр?

-Өнөөх эрүүлээд байгаа, өнөө...

-Би юу ч харахгүй байна.

-Дөнгөж сая модны цаагуур орчихлоо. Тийшээ хараач, тийшээ! Гялалзсан хар бүрх, хилэн хүрэм, гялтганасан мөнгөн иовчий нь харж байна уу, Энэ бол тэр хүн. Өнөөх залуу эр биеэрээ байна.

-Чи эндүүрч байна Плутон. Энд ийм хувцас өмсдөг хүн олон бий. Ялангуяа одоо бараг харагдахгүй шахам байхад нь тэр хүнийг танихад дэндүү хол байна. За хэнч байсан яах вэ... Флориндаа, доошоо гүйгээд миний малгай, бошинз хоёрыг аваад ир. Плутон, чи миний лунаг бушуухан эмээллэ. Наран дэндүү дээр хөөрчихнө гэж би айж байна. За бушуу, бушуу.

Зарц нарыг шатаар доошоо далд ормогц луиза асотейн хашлага руу очлоо. Сэтгэл хөдөлсөндөө амьсгаа нь давхцана. Одоо, толгойн дээр шугуй дотор хэн байгааг сайн харж авахад нь түүнд хэн ч саад болсонгүй.

Гэвч хожимджээ. Морьтой хүн алга болчихсон байв.

“Их төстэй боловч биш шиг байна. Хэрэв тэр хүн Морис Жеральд мөн бол яах гэж тийшээ явах билээ?”

Тэгтэл зүрх нь базлах шиг болов. Нэгэн удаа энэ асуултыг өөртөө тавьж байсан нь санаанд оров.

Тэгээд асотей дээрээс буув. Арван минутын дараа Луизааль хэдийн голын цаад талд гарчихаад өнөөх морьтой хүний далд орсон шугуй дотор явж байлаа.

Луиза урагшаа анхааралтай харж түргэн явж байв. Огцом эргэ дээр гараад гэнэт мориныхоо амьг татлаа. Хэн нэгэн хүн ярьж байх шиг сонсогджээ...

Луиза чимээ чагналаа. Холоос дөнгөж дуулдах төдий сонстож байгаа тэр чимээг ялгантаньж болохоор байлаа. Эрэгтэй эмэгтэй хоёр хүний дуу сонсогдоно. Ямар эрэгтэй эмэгтэй хочр хүн байдаг билээ? Түүний зүрх бас дахин шимшрэн чичрэв.

Тэгээд ойртсоноо бас зогсч дахин чагнав.

Испаниар ярьж гааж байв. Энэ нь түүнийг тайвшруулсангүй. Исидоратой бол Морис Жеральд испаниар ярьж таарна.

Креол хүүхэн импани хэлийг хүний яринаыутга санааг ойлгохоор мэддэг байжээ. Гэвч тэр хүүхэн дэндүү хол байсан учир үг нь ойлгогдохгүй байв. Ярианы өнгө нь ширүүн, хочулаа их сэтгэл хөдлөн уурласан юм шиг санагдана.

Энэ нь Луизад бараг л аятайхан санагдсангүй.

Луиза улам дөхөж, нэг зогсон, нэг ахисаар ойртохоод эрэгтэй хүний дуу сонсогдохоо больчихов. Эмэгтэй хүнийзанан сүрдүүлэх дуу гоц тод гарав.

Дараа нь чимээгүй болсоно, морины туурайн чимээ гарч бас дахин чмээ аниргүй болох нь тэр. Тэгээд эмэгтэй хүний дуу занаж сүрдүүлсэн байдалтай чанга чанга дуулдсанаа, дараа нь намдан, өөрөө өөртэйгөө ярьж байна уу гэлтэй болсноо морь давхих шиг санагдаад, дахин чив чимээгүй боллоо. Ингээд л гүйцэх нь тэр. Ууртай дуунаас үргэсэн бүргэд сүр сар хийн муухай дуугарахаас өөр чимээ гарсангүй.

Хүмүүсийн ярилцах дуу луизагийн сайн мэддэг ойн чөлөөнөөс сонсогджээ. Эна газартай түүний эрдэм сайхан дурдатгал нь холбоотой билээ. Бүсгүй бүр ойрхон дөхөж очоод зогслоо. Түүнээс цааш явж гашуун үнэнийг мэдэхээсээ айжээ.

Эцэст нь шийдэв бололтой ойн чөлөөнд гарч ирлээ.

Эмээлтэй морь хойш урагшаа давхина. Гар нь бгуйлд хүлээтэй нэг хүн газарт хэвтжээ. Хажууд нь дэлбэгэр бүрх серапэ хэвтэх боловч тэр хүнийх биш бололтой. Энэ ду болсон байж таарах вэ?

Тэр эрэгтэй хүн мексикүүдийн өмсдөг сайхан хувцастай ажээ. Морин дээр нь мексик хийцтэй гоё нөмрөг харагдаж байв.

Луизагийн сэтгэл баяр баясгалангаар дүүрэв. Энэ хүн үхсэн юмуу, амьд аль нь ч гэлээ асот?й дээрээс харагдсан тэр хүн яриагүй мөн болохоос Морис Жеральд биш байлаа. Луиза сүүлийн мөчийг хүртэл бүх зүрхээрээтүүнийг биш гэж итгэж байсан бөгөөд санасан нь ийнхүү бүтжээ.

Луиза ойртон очиж газарт дээш харан тэрийн хэвтэж байгаа хүний нүүрийг ажиглан харлаа. Хаа нэг газар харсан хүн шиг санагдав.

Энэ нь мексик хүн гэдэг нь илт байв. Зөвхөн хувцас ч биш, нүүр царай нь америк испани цусны хүн гэдгийг гэрчилнэ.

Сайхан эр шиг харагдав.

Гэвч тэр сайхан царай Луизаг мориноосоо буун харайж, хэвтэж байгаа хүний дээрээс элгэмсгээр өнгийн харахад хүргэсэнгүй. Энд олж уулзахаасаа айж байсан хүн нь биш байсанд баярлахдаа түүнд туслхаар ухасхийлээ.

-Үхээгүй юм шиг байна, амьсгалж байна гэж шивэгнэв.

Бугуйлын сур хоолойг нь боожээ. Луизахормын дотор бугуйлын гогцоог задлав.

"Одоо энэ хүн чөлөөтэй амьсгалж болно. Харин энд юу болсон юм бол? Морин дээр байхад нь бугуйлдаж аваад, гуд татчихсан юм болов уу? Тэгж л таарчээ дээ. Гэвч хэн тэгээ вэ?"

Андуурахын аргагүй эмэгтэй хүний дуу гараад байсан даа...

Тэгээд бас түүнийх байж таарах бүрх, серапэ хоёр энд байдаг. Энд бас өөр нэг эрэгтэй хүн байж байгаад тэр хүүхэнтэй хамт яваад өгөө юу? Тэгвэл ганц морины туурайн чимээ гардаг нь... Өө, ухаан орж байна! Бурхны аврал! Одоо бүгдийг нь мэдэж авъя.

-Эрхмийн бие дээрдэж байна уу?

-Авхай та хэн бэ? Тэр хүүхэн хаана байна? гэж Мигуэль Диас толгойгоо өндийлгөн, эргэн тойрон сэтгэл түгшүүртэй харж асуув.

-Та хэнийг хэлж байна? Би энд танаас өөр хэнийг ч харсангүй.

-Карамба! Яасан хачин юм бэ! Та бор морьтой хүүхэнтэй дайралдсангүй гэж үү дээ?

-Би наашаа ирж явахдаа эмэгтэй хүний дуу гарахыг л сонссон.

-Үнэний нь хэлэхэдтур шуламсын дуу чинь Исидаора Коварубио де Лос- Льяносын дуу байсан юм. Амилсан шулам!

-Тэр хүүхэн таныг ингэчихлээ гэж үү?

-Тэр муу золигийг дээ! Чамайг даа! Тэр хүүхэн хаана байна? Авхай та хэлээд өгөөч.

-Би мэдэхгүй. Морины нь төвөргөөнийг сонсвол толгойн хажуу руу уруудах шиг болсон. Лав тэгсэн байж таарна. Учир нь би нөгөө талаас нь ирлээ.

-Өө! Уруудсан бол ч тэр хүүхэн гэр рүүгээ явж л дээ... Авхай та тун сайн хүн юм. Намайг энэ хүлээснээс гаргасанд тань би их баярлалаа. Мэдээж та л тэгээ биз дээ? Та нинжин сэтгэлийнхээ үүднээс мориндоо мордоход минь тусална уу? Зөвхөн түшээд л мордуулчихвал болно. Ямар ч гэсэн би энд удаан байж болохгүй. Миний дайснууд эндээс холгүй байна... Карлито нааш ир! гэж тэр хүн мориндоо хэлэн ямар нэг онцгой исгэрэлтээр исгэрээд

-Наашаа ойртоод ир, энэ хонгор бүсгүйгээс битгий ай. Энэ бол чи бид хоёроор хортой муухай тоглоом хийсэн хүүхэн биш. За морь минь, нааш ир, битгий ай! Гэв.

Морь нь исгэрэх чимээнээр эзнийхээ дэргэд давхиж ирэхэд хазаараас нь барьж авав.

-Мориндоо мордоходминь таны өчүүхэн туслалцаа хэрэгтэй байна. Мордоод л авбал надад хойноос хөөнө гэж айх юм байхгүй болно.

-Та хойноосоо мөрдөн гэж бодож байна уу?

-Яаж мэдэх вэ? надад дайсан бий гэдгийг түрүүн хэлсэн. Гэвч тэр гайгүй... Бие минь их суларчээ. Та надад туслахаас татгалзахгүй биз?

-Яалаа гэж дээ. Би танд чадлынхаа хэрээр ямар ч тусламж үзүүлэхэд дуртай байна.

-Эрхэм авхай танд маш их баярлалаа!

Залуу креол хүүхэн тэр мексик хүнийг арай гэж эмээл дээр нь мордуулав. Эмээл дээрээ гуйвалсан боловч тогтож чадав. Тэгээд жолоогоо аваад

-Авхай минь баяртай. Таны хэн болохыг би мэдэхгүй. Харин таныг мексик хүн бишгэдгийг харж байна. Америк хүүхэн гэж бодож бахйна... Гэвч энэ хамаагүй хэрэг. Та сайхан зүс царай шигээ өгөөмөр сэтгэлтэй хүн юм. хэзээ нэг цагт хэрэгтэй үе тохиолдвол Мигуэль Диас энэ ачий чинь хариулна гэжээ.

Ингэж хэлээд Аль Койот жолоогоо хөдөлгөж, арай ядан тэнцсээр гэлдрүүлэн явлаа.

Гэвч тэр дорхиноо бараа нь тасарч, ойн чөлөнөөс гармагц шугуйд далд оров.

Тэр гурван замын алинаар нь ч явсангүй, нэгэн балрахай нарийн зөргөөр орж явлаа.

Залуу креол хүүхэнд энэ бүхэн нь муухайгаас илүү хачин жигтэй зүүд мэт санагджээ.

Гэвч Диасын унагасан захидлыг газраас авч уншаад тэр байдал нь даруй өөр болов. Захидал Морис Жеральдаар хаягласан бөгөөд “Исидора Коварубио” гэсэн гарын үсэгтэй байжээ.

Луиза мориндоо дөнгөж саяхан хөдөлсөн мексик эр шиг арай гэж мордов.

Каса -Дель-Корво руу буцаж явах замдаа Леон голыг гатлахдаа усан дотор зогсоод ямар нэг хачин гөлөрсөн харцаар ус руу ширтэв. Түүний царайд маш их цөхөрсөн шинж харагдана. Хэрэв энэ цөхрөл нь арай илүүхэн байсан бол Леон голын долгионд үүрд живэх байлаа.

Л. Чоной тулалгдсан нь

Өнөөх шархтай хүнийг өргөт шугуй дундуур зовж шаналан явсаар горхины дэргэд ирэхэд Мехаст бүрэнхий болж, хөх саарал сүүдэр газарт буучихсан байв: Амныхаа цангааг гаргаж аваад зүлгэн дээр тарайн хэвтлээ.

Хөл нь өвдөх боловч тийм ч их биш байв. дэндүү эцэж ядарсандаа болоод хойчийн явдлыг бодсонгүй.

Нөмрөг тасууд үүр өөдөө нисээд явчихав. Тэндээс түр ч атугайсалсандаа санаа нь амарсан сайхь эр дорхиноо унтаад өглөө.

Гэвч удаан унтаж чадсангүй. хөл нь дахин өвдөөд сэрээчихэв. Талын чонын улихаас бус өвчнөөсөө болоод өглөө болтол унтаж чадсангүй.

Эргэн тойронд нь сүүтэлзэх талын чононоос айсангүй. Тэд цөөвөр чоной адилхан үхсэн юмуу эсвэл үхэж байгаа хшн рүү дайрдаг учир шарх нь тийм аюултай бус гэдгийг мэдэж байлаа.

Шөнө нь залхмаар урт юм шиг санагдан, үүр цайж өгөхгүй зовооно. Тэгж тэгж өглөө болсон боловч зовлонг хүнийг баярлуулсангүй. Өглөөний гэгээ тусахтай хамт бас л хар шувуунууд гарч ирээд, чононууд ч явсангүй. Түүний дээгүүр бас л нөмрөг тас эргэлзэн, эргэн тойронд нь талын чононызэвүүн улих сонсогдоно.

Горхи руу мөдөхж очоод дахин сайн залгилж авлаа. Гэдэс нь өлсч зовоох тул идэх юм хайн ийш тийшээ харав.

Ойролцоо нь самрын мод харагдана. Түүний мөчирт самар байвч хүрэхийн аргагүй өндөрт байлаа.

Шархтай хүн зүдэрч шаналан мөлхсөөр модны ёроолд хүрч очив. Тэгээд таягаараа хэдэн самар ёворч, унагаад өлссөнөө жаахан дарлаа.

Одоо тэгээд цаашаа яадаг билээ? Жаахан л хөдөлбөл хөл нь тэсэхийн аргагүй өвдөх тул эндээс явах аргагүй болжээ.

Хөлөө чухам яачихсаныг одоо болтол мэдсэнгүй. Учиргүй хавдан, тэмтэрч үзэхийн аргагүй болжээ. Гэлээ ч өвдөх нь бяцарсан ч юмуу эсвэл булгарснаас зайлаагүй юм шиг байлаа. Аль нь ч байлаа гэсэн хөл дээрээ бостол олон хоног болно. Тэрболтол тэгээд юу хийх хэрэгтэй вэ?

Хүн ирж туслах болов уу гэх горьдлого барга байсангүй. Хоолойгоо сөөтөл хашгиравч хэн ч сонссонгүй. хэдий тийм боловч үе үе бүдэгхэн хашгирна. Энэ бол бүрмөсөн найдвар тасарч цөхрөнгөө барж гүйцээгүйн тэмдэг Юм.

Тэндээ л байгаад байхаас өөр арга байсангүй. Шархтай хүн ингэж бодоод аль болохоор

тэсвэрлэхээр шийдэж зүлгэн дээр тэрийн хэвтэв.

Өвчнөө тэсвэрлэх гэж хамаг хүчээ гаргавч, яаж ч чадалгүй хааяа гиншинэ. Өвчиндөө бүр шаналж гүйцээд эргэн тойрондоо юу болж байгааг үл анзаарна. Түүний дээгүүр тас эргэлдсээр л байв. Гэвч үүнд аль хэдийнээ дасчихаад, зарим нь далавчаараа толгойг нь ширгэх шахуу доор буужирэхэд ч гэсэн тоохгүй байлаа.

Ямар нэг чимээ гарав уу даа? Энэ чинь юу вэ?

Горхины элсэрхэг эргэн дээгүүр жижигхэн хөлийн чимээ гарлаа. Тэр чимээ амьтны тасалданги амьсгалтай давхцан сонсогдоно. Шархтай хүн юу болохыг үзэхээр эргэж харав.

“Аа, чононууд л байна” гэж трэ хүн эргэн дээгүүр хойш урагшаа шиншлэн гүйлдэж байгаа сүрэг чоныг хараад бодлоо.

Энэ мөчийг хүртэл залуу эр эл хулчгар амьтдаас айсангүй, зөвхөн зэвүү нь хүрч үзэн ядаж байжээ. Гэвч тэдний хэрцгий догшин харц, сүрдүүлэнгүй байдлы нь хараад сэрдхийв. Эргэлзэх юм байсангүй. Тэд дайрахад зэхэж байга нь энэ ажээ.

Энэ чононууд жирийн цагт хүн рүү дайрдаггүй хулчгарамьгад бөгөөд харин хүнийг биеэ хамгаалах тэнхэлгүй сул доройг мэдмэгц, цусны үнэр авангуутаа догшрон дайрдаг гэж ярилцдагийг санах. Шархтай хүн аршийн нударгын өргөсөнд биеэ авах юмгүй уруулж, нил цус болсон байв. Чононууд бүгчим агаарт тархсан цусны үнэр аваад улайрчээ. Ямар ч гэсэн чононууд өөрийн нь тасчихаар шийдсэн гэдэгт эргэлзсэнгүй.

Аз болоход бүсэнд нь үлдсэн агнуурын хутганаас өөр зэвсэг тэр хүнд байсангүй. Том, жижиг буу нь үргэж хадуурсан морины нь эмээлийн ганзаганд хоцорчээ.

Залуу эр хутгаа сугалж аваад баруун өвдгөөрөө өвдөглөн өндийж, амиа хамгаалахад зэхэв.

Хэрэв нэг л минут саатсан бол өнгөрөх байжээ. Цусны үнэрт тэсгэлгүй улайран юу ч хийхээс буцахгүй болсон чононууд төлөрхийн хэрцгий зандаа хөтлөгдөн түүн рүү дайрлаа.

Хөл, гар, биес нь зургаан чонон зэрэг зуурав.

Шархтан хүн хамаг хүчээ шавхаж тэднийг сэгсрээд хутгаараа хэд хэд бүлээд авав. Нэг хоёр чоно шархдаад зэрлэгээр гаслан зугадаав. Гэвч бусад нь түүн рүү дайрсаар... Аминд халтай, аймшигт тулаан эхэллээ. Хэд хэдэн чоно үхсэн боловч, тэдгээр үхсэн чоноо хараад бусад нь зогссонгүй. Харин ч улам ширүүн дайрч байх шиг санагдана. Үхдэл овоорно. Чононууд олзоо ноцон авахын тул бие биедээ авирцгаана. Гар дахь хутга нь гялалзсаар гар нь цуцаж сулраад, тэр бүр онож хутгалах нь ховордлоо.

Эцсийн хүчээ шавхан, үхлийн даваан дээр байв....

Энэ агшинд шархтай хүн чанга хашгирав. Энэ нь цөхөрсөндөө бус баярласандаа хашгирсан байжээ. Бас тэгж хашгирахад нь чононууд довтлохоо больсон нь гайхалтай.

Амь тэмцсэн тулалдаан түр намдаж нам жим болов. Ингэж байдал өөрчлөгдсөн шалтгаан нь түүний дуу тавьсанд биш, харин дуу тавихад хүргэсэн зүйлд байв.

Морин төвөргөөн, нохой хуцаж чимээтэй хослон сонсдов.

Шархтай хүн тусламж эрж хашгирсаар байв. Морь тун ойрхон ирж байх шиг, морьтой хүн шархтны орилохыг сонсохгүй байхын аргагүй байв.

Гэвч хариу чимээ алга. Морьтой хүн хажуугаар нь өнгөрч морин туурайн чимээ бүдгэрч эхэллээ... Азгүй тэр шархтан бас дахин цөхөрлөө.

Тэрхэн зуур зориг орсон араатнууд дахин дайрлаа. Дахиад л ширүүн тулаан өрнөв. Хүч тамиргүй болсон залуу эрц эсийн найдлагаа алдаад зөвхөн аяндаа үүсэх хөдөлгөөнөөр биеэ хамгаалж байв.

Гэтэл чононууд гэнэт олзоо орхин зайлав. Тэр хүнд туслах амьтан гарч иржээ. Шархтан ч сэргээд ирэв.

Морьтой хүн шархтны хашгиран гуйхыг хайхраагүй явчихсан боловч нохой тус болохоор иржээ. Их дуутай том нохой бутны цаанаас ухасхийн гарч ирэв.

-Найзминь! Ямар их аз вэ! Найз минь!

Нохой хуцахаа болиод араа соёогоо ярзайлшан айн ухарч буй чононууд руу дайрлаа. Нэгийг нь зуугаад авав. Харх шиг сэгсчихэд нь хормын дараа чоно нуруугаа хугалуулаад тийчилж хэвтлээ. Бас нэгийг багалзууры нь тас хазаад газар хаячихав. Бусад нь айхдаа сүүлээ хавчин, гасалж, гангинасаар зугатав. Тэд цөм балар шугуй дотор нуугдан далд оржээ.

Зовлонт хүн өөр юу ч харсангүй. Хүч тамир нь барагдаж, зөвхөн гараа сунгаж инээмсэглэн аврагчаа тэвэрч, ямар нэг юм шивэгнэн хэлээд муужрав.

Гэвч ухаан алдаад удсангүй сэргэж тохойлдон өндийж эргэн тойрноо ажиглан харлаа. Чонотой үзэлцсэн газраа харахад айдам хүрмээр. Гэвч тэр хүн муужраагүй байсан бол өөр улам ч их аймаар зэвүүн юм үзэх байжээ.

Түүний ухаангүй хэвтэж байх үед ойн чөлөөгөөр морьтой хүн өнгөрчээ. Түүний морь туурайнхаа чиеэгээр талын чононуудыг үргээж, эзэннь туслаач гэсэн гуйлтыг дуулаагүй юм шиг өнгөрчээ. Морьтой хүн дэндүү оройтож ирсэн нь туслах гэж ирсэн хэрэг биш байгаа. Морь нь л ус уух гэж ирсэн бололтой. Унасан морь нь горхи руу орж ус уучихаад огцом эргэж өөд гарч, шархтай хүний хэвтэж байгаа чөлөөн дундуур давхиж, шугуй дотор далд оржээ. Морьтой хүн гулдайн ойчсон хүнийг басл анзаарсангүй, зөвхөн морь нь л чононы үхдэлээс үргэж, хэвтэж байгаа хүнийг хараад тургив.

Тийм том бус биетэй боловч сайхан морь байлаа. Унасан эзний нь хувьд ингэж хэлэх арга байсангүй. Тэр хүн толгойгүй ажээ. Толгой нь байлаа ч гэсэн байвал зохих газартаа биш,

гартаа барьсан мэт эмээлийнх нь урд бүүрэгт өлгөөтэй харагдана.

Харахад нүд хальтрам үзэгдэл. Морь унасан толгойгүй хүнийг ойн чөлөөгөөр өнгөрөхөд нохой түүнийг шугуйн зах хүртэл даган хуцав. Уул нь онхой түүнийг хаа байгаа газар нь дагаж яваа билээ.

Гэвч одоо энэхүү ашиггүй юмыг орхиё гэж бодов бололтой шархтан хүн рүү ирээд хажууд нь хэвтэв.

Яг энэ үед л шархтан ухаан орж урьд нь болсон явдлыг сагналаа.

Нохойг эрхлүүлэн илснээ, цуваараа толгойгоо нарнаас халхлан битүүлж аваад унтлаа.

Өнөөх нохой шархтай хүний хөлд хэвтээд бас л зүүрмэглэв. Гэвч нохой байн байн сэрж, үе үе толгойгоо өргөн ууртайгаар архирч доогуур нисч ирсэн таснуудыг үргээж байв.

Тэр залуу хүн нойхондоо дэмийрч түүний омголтсон уруулаас ямар нэг хачин үгс гарна. Энэ бол бахдам сайхан дурлалын уриа, ямар нэг аллагын тухай учир нь үл ойлгогдох үгс байв.

LI. Бас л согтуу

Эзний нь байхгүй хойгуур хөзөрчид орогнож байгаад гэнэт хаяж явсан өнөөх Аламо дахь буйд овоохойддахин очъё.

Маргаашийн үд болох дөхөж байлаа. Эзэн бас л эргэж ирсэнгүй. Баллибаллахын зарц агсам Фелим л овоохойд гав ганцаараа байв. Согтуу хэвээрээ, шөалан дээр тэрийн хэвтэж байв. Үнэндээ бид түүнийг сүүлчийн удаа харснаас хойш эрүүл болох нь болсон боловч, дахин дарсны бурханд сүсэглэн согтож амжжээ.

Бүгдийг тайлбарлахын тул, өнөөх мөрийтэй тоглогчид овоохойг гэнэт орхиж явсан тэр шөнө бас юу болсныг ярих хэрэгтэй.

Ширээ тойрч суугаад хөзөрдөж байгаа улаан арьстан гурван зэрлэг хүний байдал Фелимийн согтууг унтсанаас илүү гаргажээ.

Эл явдал хэдий инээдтэй ч Фелимд огтхон ч тийм санагдсангүй, харин урилгагүй зочдыг муухай дуугаар орилон угтжээ. Тэгээд цааш юу болсныг сайн мэдэхгүй байв. Зөвхөн нүүр амаа удсан гурван индиан хүн тоглоомоо гэнэт зогсоод хөзрөө шалан дээр хаяж, Фелимийг тойрон хутгаа сугалсныг санаж байв. Тэгтэл гэнэторж ирсэн дөрөв дэх индиан хүний үгийг дуулмагцаа, Фелимийг тэр чигт нь орхиж, овоохойноос санд мэнд гарч оджээ.

Энэ бүх явдал хориодхон хормын дотор болж өнгөрчээ. Фелимийг сэхээ ороход овоохой дотор нэг ч хүн байхгүй болчихсон байв.

Тэр унтаж байна уу, сэрүүн байна уу? Энэ бүхнийг согтуу нүдээр харав уу, зүүдлэв үү? Үнэхээр тийм юм болж өнгөрөв үү? Эсвэл одоо хүртэл түүний санаанд байгаа өнөөх үзэгдэлтэй нь адил ямар нэг сэтгэлд багтамгүй шинэ үзэгдэл юм уу?

Үгүй, энэ бол хий юм нүдэнд харагдсан хэрэг биш. Фелим тэр зэрлэгамьдыг жинхэнэ хүн гэж ташаарахгүй танихаар ойрхноос харжээ. Бас түүнд ойлгогдохгүй хэлээр юм ярьцгааж байхы нь сонсжээ. Тэрнээс гадна шалан дээр орхиод гарсан хөзөр нь хөглөрч байлаа.

Фелим жинхэнэ хөзөр мөн бишийг нь барьж үзье гэж бодсонгүй. Тэр бүр эрүүл байсан ч зүрх нь хүрэхгүй байв. Тэр хачин хөзрүүд хуруухумсы нь түлэхгүй гэдэгт яаж итгэх юм бэ? Чөтгөр шуламсын ч хөзөр юм билүү яаж мэдэх вэ!

Ийнхүү элдэв юм санаанд нь орох боловч ер нь энэ овоохойд үлдвэл аюултай гэдгийг боджээ. Тэр буцаж шунхадсан хүмүүс тоглоомоо үргэлжлүүлэхээр буцаад ирж мэднэ. Тэд зөвхөн хөзрөө орхисон төдийгүй мустангерын хамаг хогшилд гар хүсэнгүй. Үнэндээ тэд ямар нэг чухал юманд яарч гэнэт явсан шигээ бас л гэнэт буцаад ирж юуны магад.

Ирланд хүн ингэж бодоод хөдлөхөөр шийдэж, гэрлээ болгоомжтойхон унтраачихаад овоохойноос сэм гарахдаа босго алхаж төвдсөнгүй. Овоохойны өмнөх нугыг сарны гэрэд тодхон гийгүүлж байв. Өнөөх зэрлэгүүд хаа ч юм ойрхон байж мэднэ... Фелим овоохойн арын хананаас адууны шир хуулж, хоёр сургаагийн завсраар зүтгэж байж гадаа гараад модны

сүүдэр доогуур мөлхөж оров.

Өмнө нь хэдэн бараан юм байхыг Фелим ажиглаад цааш ходоож амжсангүй. Хэдэн адуу амгайвчаа дуугарган, үе үе газар цавчлах нь сонсогдоно. Фелим зогсч, агарын цаана нуугдав.

Энэ бол үнэхээр морьд мөн гэдэгтирланд хүн дорхиноо итгэв. Мустангерын овоохойг тогломын газар болгож хувиргасан өнөөх дөрвөн дайчны морьд мөн нь эргэлзээгүй. Морьд модноос уяатай учир эзэд нь ч ойр байж болзошгүй...

Фелим ингэж бодоод тэндээс эргэж, өөр тийш явах гэлээ. Гэтэл энэ үед ямар нэг хүнийг заналхийлэх хэд хэдэн эр хүний дуу сонсогдоно. Дараа нь айсан тасалданги дуу гарч нохой хуцлаа. Тэгснээ чимээ аниргүй болов. Тэгтэл хэдэн хүн шугуй дундуур амь зулбан гүйж байх шиг болж, гишүү мөчир тас нясхийн хугарч, чимээ аниргүй байдлыг эвдэв.

Фелим чагнасаар л байв. Зугтааж яваа хүмүүс хар сүүдэрт нь Фелимийн зогсч байгаа агарт ойртон айсуй бөйв. Фелимийг дөнгөж модны араар нуугдтал, нөгөө дөрвөн эр хүрч ирээд шууд морьд руугаа гүйлээ.

Хажуугаар нь гүйж өнгөрөхдөө хэдэн үг солилцсоны нь ирланд эр ойлгоогүй ямар ч байсан айж сандарсан өнгө байхы нь мэдлээ. Үхтэлээ сандрах нь бас үүнийг гэрчилнэ. Мэдээж тэд өөрсдий нь үнхэлцгийг нь хагалчих дөхсөн дайснаасаа амь наана, там цаана зугатаж иржээ.

Агарын хажууханд сарны гэрэлд тодхон гийгүүлэгдэх ойн цоорхой байлаа. Тэр дөрөвмориндоо хүрэхийн тул түүгээр өнгөрөх ёстой байв.

Тэгээд сарны зурвас гэрэлд ороход Фелим тэдний нүцгэн улаан нурууг нь сайн харжээ.

Тэд бол Морисын овоохойд байсан өнөөх эрээгүй дөрвөн индиан хүн мөн байжээ.

Дөрвөн морьтой хүн хөндийн цавчим ташгай өөд өгсөн, тал нутаг дундуур хар хурдаараа давхиж, тэдний морин төвөргөөндүүлдахгүй болж эргэж ирэхгүй нь эргэлзээгүй болтол Фелим байрнаасаа хөдөлсөнгүй. Тэгээд нууц байрнаасаа гарч,

-Гэгээн минь! Энэ чинь юу болж байнаа? Тэр чөтгөрүүдэд юу хэрэгтэй болоод энд ирэв? Хэн тэдний хойноос хөөв өө? Тэднийг ямар нэг хүн сайн айлгасан нь илт байна. Өнөөх байж магадгүйяа? Тийм л байж таарна! Би нохой архирахыг сонссон. Ард нь гүйж яьсан байж таарна. Ээ бурхан минь, энэ юу болж байна вэ? Араас нь элдэж яваад гэнэт наашаа эргэх бий дээ гэж дуун алдан хэлэв.

Фелим өнөөх морь унасан хаичн хүнтэй дахин дайралдахаас айгаад бас модны цаагуур нуугдаж зүрх түгшин хүлээсээр тэндээ нэлээд зогслоо.

-Энэ ер яван явсаар Морис гуай л дамшиглаад байгаа байж таарлаа шүү. Тэр наашаа буцаж яваад намайг айлгаж гэж боджээ. Тэгээд биднийг алж юмы нь тонон дээрэмдэх гэсэн улаан арьстнуудыг яг цагий нь олоод айлгачихдаг нь сайн боллоо. Тэр л байгаасай билээ! Хараагүй нэлээд удлаа шүү... Хэр зэрэг хугацаа өнгөрөв? Би зэгсэн их ууснаа санаж байна. гэтэл одоо

юу ч уугаагүй юм шиг л байна. Харин лонх маань индиан нарын нүдэнд торчихоогүй байгаа даа? Тэднийг архинд цагаан арьст биднээс дутахгүй дуртай гэж би дуулсан юм. Бурхан минь хэрэв тэд лонх олчихсон бол лав дусал ч юм үлдээгүй шүү! Очиж шалгах юм байна. Одоо тэднээс айх юм алга. Сүнс сүүдэр ч үгүй арилаад өгсөн.

Фелим нуугдаж байсан газраасаа овоохой руугаа явлаа.

Тэр ойр хавьд хүн байгаа эсэхийг шалгаж байн байн зогссоор их болгоомжтой явав. Фелим сэтгэлээ янд бүрээр тайвшуурлавч, хоёр ч удаа овоохойн хажууд үзэгдсэн, одоо дотор нь байж мэдэх морь унасан толгойгүй хүнтэй дахин дайралдахаас айсан хэвээр л байв.

Гагцхүү, лонхны ёроолоос “балга” юм олдож магадгүй гэсэн итгэл бхйгаагүйсэн бол өглөө болтол овоохойндоо орж чадахгүй байлаа.

Гэвч уух хүсэл нь айсан сэтгэлий нь дийлээд, зүрх алдан байж харанхуй овоохойдоо орлоо. Гэрлээ асаасангүй. Асаахын ч хэрэггүй байжээ. Фелим лонх байдаг газрыг огт андахгүй болохоор түүнийг тэмтэрч олоход тшвэгтэй биш юм. Гэтэл лонх нь байдаг газраа байсангүй.

-Тэднийг чөтгөр аваачаасай! Гэж гомдоллон халаглаад - Тэд бас түүнд хүрчихсэн бололтой шүү! Тэгээгүй бол яагаад байрандаа байхгүй байх вэ? Би тэнд тавьсан юм. Байранд нь тавьснаа бүр сайн мэдэж байна... Нандин эрдэнэ минь чи энд байж байгаа бий хөө? гэж өнөөх тэмтэрч байсан юманд гараа хүрэхэд хэлээд

-Өө өнөө малууд чинь ховх сорчихож шүү! Улаан арьст хулгайч нарыг чөтгөр тамд гал дээо шараасай. Унтаж байгаа хүний архи хулгайлбал яадгийг тэдэнд үзүүлэг! Ээ халаг. Би одоо дахиад л унтахаасөөр яах вэ дээ! Бас тэдний тухай, түүний тухай, өөр юмны тухай бодогдоод балга юмгүйгээр нойр хүрнэ гэж үү? Балга ч юм үлдсэнгүй... Байзаарай! Гэгээн минь! Миний санаанд нэг юм орлоо! Дашмаг дүүрэн юм бий шүү! Би авдар дотор нуучихсан юм. Морис гуайг сүүлийн удаа суурин руу нь явахад нь замдаа ууг гэж бөглөөнд нь тултал дүүргэсэн юм. Гэтэл Морис гуай авч явахаа мартчихсан байсан. Бурхан минь, индианууд түүнд бузар савраа хүргэчихээргүй байх болтугай. Тэгвэл ч би ухаан алдана шүү! Хурай! Гэж Фелим авдар онгичин хэдэн минут чимээгүй байснаа - Мөн ч аз аа! Улаан арьстнууд энэ рүү шагайж харахын сөгөө байсангүй! Дашмаг дүүрэн байна. Үүнд хэн ч гар хүрсэнгүй! гэж дуу алдав.

Энэ баясгалант нээлтийн дараа харанхуй овоохой дотор ирланд хүний хөгжилтэй бүжиг эхэллээ. Тэгээд чимээ аниргүй болж, бөглөө эргүүлэх дуулдсанаа, дашмагаас ирланд эрийн ходоод руу шингэн юм хоржигнох дуу сонсогдлоо. Хэдэн мөчийн дараа тэр чимээ сэтгэл ханан тамшаалах дуугаар солигдов. Энэ хоёр дуу ээлжлэн сонсогдоор сүүлдээ шалан дээр хоосон дашмаг унах нь дуулдав. Тэгээд согтуу хүний хашгирах нь түүний хөлчүүрэн дуулах дууны бадаг, зэрлэг инээлт, улаан арьстны тухай, морь унасан толгойгүй хүний тухай авцалдаагүй үгсээр ээлжлэн солигдож байв. Тохиолдсон аюулын тухай тэр үгс нь ухаан алдталаа согтсон уран илтгэгчийн нажигнасан хурхиралтаар солигдтолоо намуухан намуухан давгагдсаар байлаа.

ЛШ. Сэргэсэн нь

Фелим энэ удаа түрүүчийнхээсээ их унтжээ. Түүний сэрэхэд үд болох дөхөж байв. Фелим өөрөө аяндаа сэрсэнгүй, толгой руугаа хүйтэн ус асгарахад сэргжээ. Энэ нь улаан арьст зэрлэгүүдийг хараад сэргэснээс нь доргүй сэргээжээ.

Зеб Стумп түүнийг хүйтэн усаар шүршсэн байжээ. Анч өвгөн Каса-Дель-Корвоос гараад хагийн дөт замаар Нуэсес голыг чиглэн явжээ. Тэр сайн мэддэг зөрөг замаараа явжээ. Мөр хөөж цаг алдалгүй талыг шууд гатлаад, уншигчдын сайн мэдэх цавчаал замд оров.

Хөгшин анч Луиза Пойндекстерын хэлсэн үг, эрэлд гарсан хүмүүсийн тухай өөрийн бодлыг нэмэрлээд Морис Жеральд аюулд орсныг сайнойлгожээ.

Ийм ч учраас өвгөн анчин эрэлд гарсан улстай дайралдахаас зайлсхийн, тэднээс өмнө Аламо орохыг яаравчилж явав.

Хэрэвгэр бүлэг хүмүүстэй дайралдчихвал хүн алагч гэж тооцогдсон өнөөх мустангерын овоохой руу явах замыг дуртай ч дургүй ч зааж өгөхөд хүрнэ гэж Зеб мэдэж байв.

Цавчаал замын эргэлт дээр хэдэн “журам сахиулагчид” байхыг Зеб харав. Тэд мөр мөшгиж яваа бололтой. Өвгөн анчин өөрөө харагдаагүйдээ л баярлав.

-Чөтгөр аваачаасай нь билээ! гэж хорсон үглээд - Эд нартай энд дайралдаж болохыг яагаад бодсонгүй вэ? Одоо өөр замаар л эргэж явахаас өөр арга алга. Бас нэг бүтэн уаг алдах нь. Алийв хөгшин минь эргээрэй! Чи бидхоёрт аз таарсангүй. Зургаан бээр л илүү явах болж дээ. Гүү минь түргэн хөдөлж үз! Эргээд! За алийв! Гэлээ.

Зеб жолоогоо угзчин, гүүгээ эргүүлээд, буцан цогиулав.

Цавчаал замаас гараад, ойн цоорхойг даган явснаа дахин ширэнгэнд орж, нөгөө Диас гурван нөхрийн хамтаар түрүүн нь явж байсан зөргөөр орлоо. Тэгээд Аламын хөндий хүртэл зогссонгүй явав.

Стумп овоохойны ойролцоо очиж ширэнгэнд моорио уяд хэзээний болгоомжилдог зангаараа цааш явган явлаа.

Мустангийн арьсан хаалга нь хаалттай, гол дундаа онгорхой нүх гаргачихсан байж байв. Энэ яагаад ийм болов?

Улам ч илүү болгоомжлон овоохой руу мярайж очлоо. Гөрөөс мөрдөж явна уу гэлтэй. Тэгээд модон доорхалхлагдсан овоохойг тойрч гараад, ар талынх нь саравчинд гэтэж очоод, сөхөрч суун чимээ чангаж эхэллээ.

Хананы нэг сургааг сугарчихсан, адууны арьсы нь хуу татчихсан учир завсар гарсан харагдав. Зеб түүнийг гайхан харж, учры нь олж амжихаас өмнө овоохой дотроос чанга хурхирах чимээ сонсдов. Фелимээс өөр хэн ч ингэж хурхирахгүй нь мэдээж.

Зеб Стумп цоорхойгоор шагайж үнэхээр шал дээр унтаж байгаа Фелимийг харлаа.

Одоо тэгж болгоомжлох нь илүү зан байв. шууд босч, овоохойг тойрон түгжээгүй хаалгаар нь оров. Фелимийг сэрээхээсээ өмнө, үал дээгүүр хөглөрсөн юмыг сайтар харлаа.

-Замд гарахаар юмаа төхөөрч. Нээрээ, Морис удахгүй эндээс явна гэж

ярьж байсныг санаж байна. Энэ ч унтсан биш% үхтэлээ согтсон юм байна. Архи ханхалж байгаагүй нь! Дуслын төдий юм үлдсэн юм биш байгаа даа! Юу л бол... Өө лонх нь бөглөөгүй, дашмаг нь хоосон хэвтэж байв. Шингэн юм гудрахдаа шохойт тал нутгийн хамаг амьтнаас дутуугүй энэ муу архичныг чөтгөр аваачдаг болоосой!... Испани хэзэр байна, хөөе! ... Багцаараа хөглөрч хэвтэнэ. Энэ муу ирланд хэзрээр юу хийдэг байна? Архи ууж байхдаа л тоглосон байж таарна. Харин тэр хаалгыг хэн нүхэлж, хана нь яагаад онгойчихоо вэ? Сэрээгээд асууя, байз. Фелимээ, Фелим!

Фелим хариу дуугарсангүй.

-Хөөе, Фелимээ, Фелим! Гэж дахин дуудав.

Бас хариу алга. Анч өвгөн дуудахдаа хагас бээрийн цаана сонсогдохоор чанга хашгирсан боловч Фелим амгалан нойрссоор байв.

Зеб согтуу хүнийг хамаг хүчээрээ угзрав. Хариуд нь ямар нэг архирах мэт дуу сонсдоод тэр дорхиноо дахин нужигнатал хурхирав.

-Хэрэв хурхирахгүй байгаа бол үхсэн гэжбодохсон. Гэвч үхтэлээ согтжээ. Яриагүй тэгж. Яаж сэргээх билээ? Сэгсчээд ч нэмэргүй. Чөтгөр ав, харин....

Анч өвгөний харц буланд байгаа хувин дээр туслаа. Тэр хувин дүүрэн устай байв. Фелим горхиноос барьж ирээд аз нь дутахад хэрэглээгүй байжээ. Зеб хувинтай усыг инээмсэглэн аваад, унтаж байгаа хүний уоан нүүр өөд цацчихав.

Санасанхэрэг ч бүтэж, хүйтэн ус Фелимийг эрүүл болгоогүй ч гэсэн ямар ч байсан сэрэж дөнгөв. Ирланд эр орь дуу тавьж, анч өвгөн хөхүүн наргиантай инээв.

Тэгээд эцэст нь хоёулаа тайтгарч, онцтойхон ярилцаж чадахтайгаа боллоо. Фелим өнөөх аюулт явдлаа мартаагүй байсан болохоор Зебийг хараад ёсон бус даажигнасан ч гэлээ баяртай байлаа. Асуулты нь хүэлэлэгүй тультраатан байж чадах чинээгээрээ нөгөө хачин үзэгдэл, ухааны нь авчих дөхсөн явдлыг тодохой ярьж гарлаа.

Зеб, морь унасан толгойгүй хүний тухай хачин жигтэй юмыг анх удаа түүнээс сонслоо.

Инж цайзын ойр хавь, бүх Леоноор тэр хачин дүрсийн тухай хэдийнэ мэдэх болсон ч Зеб энэ сонинг өөртнь яричихаар хүнтэй дайралдаагүй явжээ. Анч өвгөн сууринд үүрээр ирж, Каса-Дель-Корвоос өөр газраар орсонгүй. Зөвхөн Плутон, Луиза Пойндекстер хоёртой л уулзажээ. Гэтэл тэр хоёрын аль нь ч жигтэй хүний тухай сонсоогүй байж. Эзэн ямар нэг юмнаас болоод энэ тухай дурдаагүй бөгөөд, охин нь эцгээсээ өөр хүнтэй уулзаагүй байжээ.

Зеб анхандаа “Толгойгүй хүнийг” хөгшин архичны “Согтуугийн солиорол” хэмээн Фелимийг дооглож байжээ.

Гэвч үнэхээр тийм юм байсан гэж Фелимийг зүтгээд байхаар үзэж харсан, мэдсэнтэйгээ эргэцүүлэн бодлоо.

-Ер юун андуу ташаа байх вэ дээ! Би таныг одоо харж байгаа шигээ л Морис гуайг тийм сайн хараагүй байх гэж үү дээ? Толгойноос нь бусдыг харсан. Гэвч давхихаар завдан морио эргүүлэхэд нь толгойгий нь харсан юм. Тэрнээс гадна мексик серапе, барын арьсан гутлы нь үзсэн. Бас түүний сайхан морийг яагаад танихгүй байх вэ дээ? Тэгээд бас Тара хойноос нь дагаад явчихсан гэж танд хэлээд байна шүү. Дараа нь нохой индиан нар руу архирч байхыг нь би сонссон гэж ирланд ярив.

-Индиан нар гэнэ ээ? хэмээн анч өвгөн итгээгүй байдалтай толгой сэгсрэн дуу алдаад - Испани хөзрөөр тоглодог индианууд уу? лав цагаан арьстан индианууд байх гэв.

-Та тэднийг индиан биш байсан гэж бодож бөайна уу?

-Миний юү гэж бодох нь онц биш. Одоо цэц булалдаж байх цаг алга. Хамаг үзсэн харснаа цааш нь ярь.

Фелимийг яриагаатөгсөхөд Зеб дахин юм асуусангүй. Овоохойноос гарч зүлгэн дээр суув.

Тэр бодлоо цэгцлэхийг хүсчээ. Гэвч битүү юманд тэгж чаддаггүйгээ өөрөө ч хэлдэг хүн. Фелимийн яриа хамаг хэргийг улам самууруулан гэдгийг хэлэх юун. Одоо хүртэл зөвхөн Генри Пойндекстерын алга болсон учрыг олох хэрэгтэй байв. гэтэл одоо энэ зарцын ярьж байгаагаар бол Морис өглөө болохоос өмнө гэртээ эргэж ирэх ёстой байсан мөртөө ирээгүй нь уг байдлыг улам нарийн төвөгтэй болгов.

Морис морь унасан толгойгүй хүний дүрээр гарч ирсэн гэх буюу толгойгоо гартаа барьж явсан гэдэг нь бүр ч таахад бэрх зүйл байв. Энэ нь ямар нэг тоглоом наадам хийсэн зүйл л байжтаарна.

Хүний амины хэрэг гарч суурины иргэдийн тэн хагас нь алуурчийг эрж байгаа энэ эгзэгтэй цагт тийм тоглоом гаргана гэдэг үнэхээр хачин юм. Тэгээд алуурч гэж үзэж байгаа тэр хүн иймэрхүү тоглоно гэдэг санаанд багтамгүй зүйл байв.

Зеб Стумпийн өмнө ямар нэг хачин жигтэй тоохиолдлын ээдрээ буюу чухамдаа ямарнэг давхцаж овооролдсон хэрэг явдлын зураг дэлгэгдэв. Болсон явдал нь тодорхой шалтгаангүй, шалтгаан нь толорхой эх сурвалжгүй, гэмт хэрэг яагаад сэдэгдсэн нь ойлгогдохгүй ажээ.... Ямар нэг үл ойлгогдом, ер бусын битүүлэг явдал байлаа.

Морис Жеральд Луиза Пойндекстер хоёр болзоо тавьж шөнө уулзсан. Үүнийг нь мэдсэн Луизагийн дүүтэй муудалдцсан, Морис тал руу явсан, түүнээс уучлал гуйх гэж Генри хойноос нь явсан энэ бүхэн бол зүй ёсны ойлгомжтой юм. Харин үүнээс цаашлахаар хэрэг явдал будлиантай, зөрөлдөөнтэй байлаа.

Морис Жеральдыг Генри Пойндекстерт талтай байдгийг Зеб Стумп мэднэ. Генри Пойндекстерын тухай Морис олонт ярьдаг байсан боловч хэзээ ч дайсагнасан шинж цухуйлгаагүй бөгөөд харин ч тэр залуугийн сэтгэл санааны сайхан чанарт ямагт бахархдаг байжээ.

Морис тэр залуугийн найз байхаа гэнэт больж, түүнийг алагч болж хувирсан байх гэдэг таамаглал даанч үнэний хувьгүй санагдана. Зеб бүгдийг нүдээрээ харсан цагтаа л зөвхөн итгэх байлаа.

Зеб Стумп ер бишийн саруул ухаантай боловч хагас цаг бодож суугаад ч энэ нарийн түвэгтэй уршигт явдалд оновчтой тайлбар өгч чадсангүй. гагцхүү түүний бодож байгаагаар бол Морисын овоохой руу довтолсон тэр дөрвөн морьтой хүн индиан нар биш гэдэгт л эргэлзэхгүй байв. Тэд хүн алсан хэрэгтэй ямар нэг холбоотой байж болох юм гэж бодов. Харин тэд эзний нь байхгүй хойгууровоохойд орсон нь Стум пийг улам их гунигт таамаглалд оруулав. Нэн хүн алагдаагүй бөгөөд шугуй дотор хоёр хүний хүүр эрэх хэрэгтэй болсон шиг санагджээ.

Анч өвгөн ингэж бодоод гүнээ сүүрс алдав. Тэр өвгөн Морист бараг төрсөн үр шигээ хайртай. Тэгээд Морис Жеральд балар ширэнгэ дотор алагдаад, хүүрий нь тас, хээрийн чонон зулгааж байгаа гэж бодохоос өвгөний сэтгэл зүрх хязгааргүй гашуудан шанална.

Өвгөн хэдий чинээ эргэцүүлэн бодох тусмаа төдий чинээ гүнээ сүүрс алдан байв. Тэгээд энэ зовлонд цаашид тамлагдаж байхын хэрэггүй гэж бодоод, ухасхийн босч хойш урагшаа түргэн түргэн алхангаа өшөө авна хэмээн үглэж явлаа.

Анч өвгөн гашуун зовлондоо тийнхүү автагдаад, хажуугаараа мустангерын нохой гүйж өнгөрөхийг ажигласангүй.

Нохой буцаж ирсэнд Фелим баярлан хашгирахад нь өвгөн эргэж харсан боловч нохойг бас л анзаараагүй бололтой. Харин Фелим гайхан дуу алдаад, өөрийг нь дуудахад бодлоосоо нэг юм салав.

-Фелим юу болов? Могойд хатгуулчихав уу?

-Хөөе, Стумп гуай, Тарыг хараач! Хүзүүнд нь нэг юмуяатай байгааг хараач. Ябахад нь ийм юм байгаагүй. Та үүнийг юу гэж бодож байна?

Нээрээ нохойны хүзүүнд бугын арьсан сураар уясан ямар нэг жижигхэн хуйлаастай юм цухуйж байв.

Зеб агнуурын хутгаа сугалж нохой руу бөхийтөл цаадах нь айж гэдрэг ухарснаа дараа нь түүний гэм зэмгүйг мэдмэгцээ өөр рүүгээ ойртуулав. Тэгээд хүзүүвчий нь огтолж хуйлаастай юмыг задалбал дотор нь нэрийн хуудас байлаа.

Тэр хуудсан дээр улан бэх гэлтэй цусаар бичсэн ямар нэг юм байлаа. Анчид, бүр аглаг нутагт суудаг нь ч гэсэн уншиж чаддаг учир Зеб эл муруй саруй бичгийг зэгсэн уншаад санаа амран,

сүүрс алдаад,

-Фелим ээ, тэр чинь амьд байна! Амьд байна! Энийг хараач... Өө тийм, чи чинь бичиг мэдэхгүй шүү дээ! Надад ном зааж сургасан өвгөн багшдаа баярлаж байна. за тэр ч яах вэ. Тэр маань амьд байна Амьд байна гэв.

-Хэн бэ? Морис гуай юу? Бурхны аврал...

- Боль доо Одоо тэгж залбирч байх зав алга. Намайг гүүгээ авчрах хооронд хөнжил, аргамж хоёр олоод бай. Бушуулж үзээрэй.

ЛШ. Үхдэгийн даваан дээр

Нэг ч минут алдаж болохгүй. Эс тэгвэл хожимдоно шүү гэж анчөвгөн хэлээд хөдлөв. Тэр нэг ч минут алдаж болохгүй гэж туйлын үнэн үг хэлжээ. Анч өвгөний яарч яваа тэр агшинд цусаар зурвас бичсэн өнөөх үйлт хүнийг дахин үхлийн аюул заналхийлж, чононууд дахин бүчиж авав.

Гэвч үүнээс айх юм байсангүй. Түүнээс ч аймаар дайсантай амь өрсөн тулах хэрэг гарсан ажээ.

Дэлбэгэр малгай, цув өмссөн шархтай хүн бол Морис Жеральд мөн гэдэг нь уншигчдад лав аль хэдийн тодорхой болсон байхаа. Тэр хүн чононуудтай тулан, Тарын ачаар эсэн мэнд гарсныхаа дараа одоо жаахан амсхийж болох юм хэмээн боджээ.

Найзынхаа байгаад сэтгэл амарч, үнэнч нохой нь жигүүртнээс ч, дөрвөн хөлт араатнаас ч хамгаална гэдгийг мэдэх учир залуу эр удалгүй гүн нойрондоо дарагджээ.

Тэгээд сэрэхдээ бие нь хөнгөрч өөрийн тухай тухтайхан бодох чадалтай болжээ.

Нохой түүнийг чононоос аварчээ. Дахин дайрлаа ч гэсэн нохойдоо найдаж болох нь эргэлзээгүй байв. Гэвч цаашид юу болох вэ? Гэртээ хүрэхэд нь юугаар ч тус болж чадахгүй. Эндээ байна гэхэд өлсч юмуу, эсвэл шархнаасаа болж үхнэ гэсэн үг.

Шархтай хүн хөл дээрээ босов. Гэвч цэх зогсч чадсангүй. Нуруугаа тэнийлгээд, хоёр гурав алхаж үзэв. Тэгээд дахин хэвгчихэв. Их сульдсанаас толгой нь эргэж байв.

Тийм хүнд үед толгойд нь “Тара гэрт мэдээ хүргэж чадна” гэсэн сайхан бодол орж ирлээ.

-Хэрэв биэнэ нохойг явуулж чадвал даа! гэж нохой руу сорьсон харцаар харж хэлээд - Сайн нөхөр минь нааш ир гэж Морис хэд мэдэхгүй нөхөртөө хандаж үргэлжлүүлэн - Би чамайг шуудан зөөгч болгож, бичиг хүргүүлмээр байна. Чи ойлгож байна уу? Намайг бичтэл хүлээж бай. Тэгээд учры нь сайн хэлж өгнө гэснээ түрүүвчээ уудлан - Нэрийн хуудас байдаг нь яамай даа. Харандаа байхгүй. Энэ ч гайгүй. Бэхийн хувьд хангалттай. Энэ зуун настын өргөсөөр үзэг хийчихье гэв.

Тэр хүүн зуун наст руу мөлхөж очоод урт навчны үзүүрт ёрдойж байгаа өргөснөөс нэгийг таслан авч, түүнийгээ чонын цусанд дүрээд бичиж гарлаа.

Бичиж дуусаад бугын арвсаар хийсэн хэсэг сурны тасархай гаргаж нохойг хүзүүвчлэв. Тэгээд дэлбэгэр малгайныхаа дотроос урж авсан хэсэг хулдаасанд захидлаа нямбай боож, нохойны хүзүүвчээс зүүв.

Одоо шуудан зөөгчийн үүрэг гүйцэтгэгчээр нохойг ятгах ажил үлдэв. Энэ хэцүү хэрэг байжээ. Нохой хэдий ухаантай боловч чин үнэнч байдаг хүнээ яалаа гэж гамшиг зовлонд нь орхих ёстойг огт ойлгосонгүй. Илж таалаад ч, ятгаад нэмэр болсонгүй.

Зөвхөн амий нь аварсан хүн нь худал уурлан зандалч, таягаар цохисон хойно л нохой аргагүйн эрхэнд үгий нь дагаж яваад өглөө.

Хэдий үнэн ч гэсэн Тара өөртэй нь ингэж харьцсаныг тэсвэрлэж чадахгүй, гомдоллон шугуй руу орж, байн байны эзэн рүүгээ эргэж харж явлаа.

Тарыг шугуй дундуур далд ороход Морис өрөвдсөн дуугаар:

-Хөөрхий минь! Түүнийг цохидог маань хамгийн дотно нөхрөө зодсонтой адил боллоо. За яах вэ? дахин уулздаг юм бол ачий нь хариулна. Харин одоо чононы дахин довтлохоос хамгаалах тухай бодох хэрэгтэй. Тэд дахин намайг ганцаараа үлдлээ гэж мэдээд заавал ирнэ гэж ганцаараа ярив.

Юу хийх ёстойгоо мэдэж байлаа. Хажууханд нь дээр дурдсан самрын мод бхйлаа. Бараг зэрэгцээ шахуу хоёр том мөчир газраас дээш зургаа долоон тохой өндөрт байв.

Морис цуваа тайлан газар дэвсээд хутгаар хормойг нь хэд хэд нүхлээд, дараа нь хүзүүнийхээ ороолтыг задалж уртааш нь цуулаад хоёр хэсэг болгов. Дараа нь цуваа мөчрийн хооронд дэлгэж хүзүүнийхээ ороолтны цуулбараар модонд бэхлэн уяж, хүн элбэг даахаар дүүжин ор шиг юм болгов.

Чононууд мод өөд авирч чадахгүй учир энэ дүүжин дээрээ гарч хэвтээд тэднийг ёстой нэг санаа амар харж болно гэдгийг Морис мэдэж байлаа.

Морис , чононууд буцаж ирэх ёстой гэж итгэж байсан болохоор энэ аргыг хэрэглэжээ. Үнэндээ ч төдөлгүй чононууд дахин төглөөс гарч ирлээ. Тэд гэтэн мярааж, нэг хоёр алхаад зогсон, ийш тийш харснаа дахин урашилсаар түрүүчийн тулалдааны газар хүрч ирлээ. Тэд нохой байхгүйг мэдээд тэр дорхиноо сүргээрээ цуглачихав. Морис тэр аймхай амьтдын хорт шунахай шинж байдлыг ажиглаж эхэллээ.

Тэд эхлээд үхсэн нөхдийнхөө хүүрийг, модон дээрээс харж байгаа хүн хорь ч тоолж амжаагүй байхад ховдоглон үмхлэв.

Дараа нь хүн рүү санаатай дөхөн модны ёроолд бөөгнөрлөө. Морис дүүжин ороо өлгөхдөө түүнийг өнгөлөн далдлахыг оролдоогүй бөнөөд нэлээд өндөр учир болгоомжлох хэрэггүй гэж үзжээ.

Дээр нь хүн хэвтсэн бараан цув тодхон харагдана. Цуст хоолонд улам их хорхой нь хүрсэн тэдгээр араатнууд хамар хоншоороо долоосоор модны ёроолд зогсоцгоов. Ой гутам үзэгдэл байлаа.

Чононууд мод өөд үсэрч авирах гэж цоройцолдохыг Морис барга тоосонгүй. Ямар ч аюул аога гэдэгт итгэж байв.

Гэвч урьдаас бодож санаагүй бас нэг аюул байжээ. Чононууд өөрсдийн оролдлогын үр дүнгүй болсныг мэдээд хүндээр амьсгаадан модны ёроолд хэвтээд өгөхөд нь л энэ тухай санав.

Хойд Америкийн тал нутаг, халуун орны ширэнгэд амьдрагч араатнуудын дундаас сайхь Койот хэмээх талын чоно нь хамгийн зальтай амьтан ажээ. Анчид “үүнээс зальтай амьтан байхгүй” гэж ярилцдаг нь оргүй зүйл биш. Үнэг шиг зальтай, жирийн чононоос ч догшин амьтан. Түүнийг гаршуулж болдог авч, өөрийг нь илж буй гарыг хэзээ ч зуугаад авахад бэлэн байна. Түүнийг хүүхэд хүртэл мод бариад айлгаж чадах авч, шархадсан юмуу тамир нь барагдсан хүн рүү дайрахаасаа айхгүй. Ганц нэгээр байхдаа туулай шиг зүрхгүй боловч, сүргээрээ байхдаа юунаас ч үл айна. Өлсөх үедээ зүрхзориг ч гэж хэлж болмоор хэрцгий догшин болно.

Гэвч талын чонын хамгийн аймшигтай нь заль байлаа.

Чононууд хүнд хүрч чадахгүйгээ мэдээд тарж алга болсонгүй. _ Ногоон дээгүүр хэвтэн, төглөөс шинээр нэмэгдсээр бхйв. Олзоо туйлдуулан барьж авахаар шийдсэн нь илэрхий. _ Тэд нэгэнт дүүжин оронд хүрч чадахгүй учир мустангерын санааг зовоох ёсгүй гэж бодогдмоор. Хэрэв юм уумаар санагдаагүйсэн бол санаа зовохгүй байх байлаа.

Болчимгүй юм хийсэндээ өөртөө уурлана. Модон дээр авчирч гарахаасаа өмнө энэ тухай яагаад бодсонгүй вэ? Хажууханд нь горхи байхад ус аваад гарахад түвэггүй байжээ. Зуун настны хомбогор навч байхад саваар ч дутахгүй байлаа.

Гэвч одоо өнгөрчээ. Модны ёроолоор шоржигнохус түүний хорхойг хүргэж уухын тэсгэлгүй хүслэн нь нэмэгдэн, үүнээс болж улам ч цангалаа. Горхинд зөвхөн бүсэлсэн чонон дундуур хүрэх учир, энэ нь зайлшгүй үхэлтэй адилхан хэрэг байлаа. Нохой дахин ирж аминд нь орно гэдэгт барга горьдлого байсангүй. Мөн зурвас нь очих ёстой хүний гарт орно гэдэгт бүр ч итгэсэнгүй. Горьдлогоданч багатай ажээ.

Их цус алдсаны дараа цангахын зовлон нэн хүчтэй байдаг. Цангаж тарчлах нь тэсвэрлэхийн аргагүй байв. Хэдий удаан ингэж зовох хэрэг вэ?

Үүний хажуугаар дэмийрч эхэллээ. Чононуудын тоо арва дахин нэммэгдсэн шиг санагдана. Хэдэн зуу биш, хэдэн мянган чоно, ойн чөлөөнд оволзоно. Тэд улам улам дөхнө. Нүд нь аймаар гялалзана. Улаан хэлнүүд цувны унжсан хэсэгт хүрч түүнийг шүдээрээ татна. Дээшээ цовхроход нь тэдний халуун амьсгал мэдэгдэнэ.

Энэ бүхэн бол өвчний улмаас хий юм үзэгдэж байна гэдгийг Морис сэхээ орох агшиндаа ойлгов. Нөгөө л зуугаад чоно нь түрүүчийн хэвээр ногоон дээр хэвтэн, энэ явдлын төгсгөлийг тайван хүлээж харагдана. Явдлын төгсгөл нь мустангерыг дахин ухаан гарахаас нь өмнө эхлэв. Чононууд гэнэт огло харайн босч нэг нь ч үлдэлгүй төгөл рүү зугаахыг харлаа.

Хий юм нүдэнд харагдав уу? Үгүй ээ, ухаан нь саруул хэвээр байна. Тэднийг юу айлгав?

Морис баярлан хашгирлаа. Тара буцаж ирэв бололтой. Федим ч цуг ирсэн байж мэднэ. Нохой зурвасыг хүргэж амжчихаар цаг нөгрөсөн байлаа. Чононууд хоёр цаг шахуу түүнийг отож хэвтжээ. Морис өндийн, мөчир дээгүүр тэгнээд ойн цоорхойг харав. Нохой нь ч, зарц нь ч алга. Навч нахиа, бут сондуулаас өөр юу ч байсангүй.

Тэр чимээ чагналаа. Ухран зайлсаар байгаа чононуудын улилдахаас өөр чимээ анир алга. Бас хий юм бодогдож байна уу? Тэд юунаас зугатав.

Гэвч тэртэй тэргүй зам чөлөөтэй болжээ. Одоо усанд хүрэхэд аюулгүй. Түүний нүдний өмнө ус мэлтэлзэж, хоржигносон чимээ нь их л сайхан сонсогдоно.

Морис модноос бууж, горхины эрэг рүү гуйвлан явлаа. Тэгээд ус руу тонгойхоосоо өмнө дахин эргэж харав. Үхгэлээ цангасан ч гэлээ, яагаад гэнэт ингэж байдал өөрчлөгдсөний учрыг олох гэснээ мартаж чадахгүй байжээ. Ногоон дотор цоохор барын нуруу гялсхийн харагдлаа. Цоохор бар урт найриахн биеэ эврхүүлээд, ыбут дотроос могой шиг мурилзан гарч ирлээ.

Чононууд энэ амьтнаас зугдасан байжээ.

Тэр араатны санаа ч гэсэн илэрхий байлаа. Бас цусны үнэр аваад, цуст найранд оролцохоор яарч явжээ.

Цоохор бар хүнээс нүдээ салгалгүй, анхадаа алгуур мөлхөн дөхөж байгаад дараа нь үсрэхэд бэлтгэн, хурдан хөдөлж эхлэв.

Модон дээр гараад ашиггүй. Бар бол мод өөд муур шиг авчир чадна гэдгийг Морис мэдэж байю.

Гэвч энэ үед Морис энэ тухай бодсонгүй. Нэг талаас цочирдсондоо, нөгөө талаас ухаан нь элий балай болсондоо бодох чадваргүй болжээ. Хар зөнгөөрөө шууд гол руу харайн орж, ус бүхэлсхийгий өнгөрөхөд сая зогсов.

Хэрэв Морис эргэцүүлэн бодохтой байсан бол энэ нь ямар ч хэрггүйг ойлгох байлаа. Цоохор бар зөвхөн модонд авирахдаа сайн төдийгүй бас халиу шиг усч амьтан ажээ. Усан дотор ч гэсэн хуурай газар байгаатай адил аюултай.

Морис энэ тухай бодсонгүй. Зөвхөн, нарийн горхи түүнийг аварч чадах болов уу гэж бүүр түүр ухамсарлажээ. Цоохор бар усанд тулж ирэн уогнойгоод үсрэхээр зэхэхэд нь бүр найдвар тасрав.

Морис цөхрөнгөө баран хүлээлээ. Биеэ хамгаалах том жижиг буу ч үгүй, хутга ч үгүй, тэр ч байтугай таяг ч байхгүй, ер юу ч үгүй байв. Ингээд улаан тулна гэдэг нь зайлшгүй үхнэ гэсэн үг байлаа.

Цоохор араатныг үсрэхээр зэхэн өндөсхийхийг харсан үйлт хүн муухай орилов.

Энэ чацуу ирвэс дуу алдан чарлаад, үсрэлтэн дундаа амь алдаж усан дотор унав.

Морсиын хашгирсанд хариулах мэт өөр нэгэн дуу шугуйгаас цууриа мэт хангинаж, өмнөхөн нь буун дуу тас хийлээ.

Шугуй дотроос том нохой давхин гарч ирээд цоохор барын далд орсон ус руу үсрэн орлоо.

Аварга том биетэй хүн эрэг тийш түргэн дөхөж ирээд, түүний хойноос өөр давжаахан биетэй хүн баярлан хашгичиж, агаар тэнгэрийг дөжрүүлэв.

Энэ бүх дуу чимээ, үзэгдэл залуу эрд үнэн байдал гэхээсээ илүү хий хоосон юм шиг санагдан, ухаан нь элий балай болж ирэв. Тэгээд юу санаж, юу хийж байгаагаа мэдэхгүй болжээ. Өөрт нь эрхлэн ойртож ирсэн үнэнч нохойгоо багалзуурахыг хүссэн боловч, өөрийн нь уснаас гаргах гэсэн нөхрийнхөө хүчтэй тэврэлтэд гэдрэг татагдав.

Тохиолдсон бүх аюул залуугийн уураг тархины ажиллагаанд сүрхий шалгалт болсон учир тэд хүнд байдлыг тэсвэрлэж чадсангүй. тэр болж бхйгаа явдлыг ухааж ойлгохоо болиод аймшигтайгаар ухаан самуурчээ. Тэгээд халуурч эхэллээ.

LIV. Талын жууз

Зеб Стумп Мористтуслахаар ирээд эрэг дээр гаргасан нь энэ байлаа. Анч өвгөн зурвасыг уншин, заасан загар руу нь аль болох иүргэн очих гэж яарчээ.

Тэгээд Морис руу цоохор бар үсрэх гэж байсан тэр агшинд яг цагтаа ирж амжжээ. Аз болоход Зеб бууны сум тусах газар дөхөж ирсэн байжээ.

Догшин араатны зүрхэндсум туссан боловч түүний үсрэхийг зогсоосонгүй. гэвч энэ нь тэр араатны сүүлчийн үсрэлт байжээ.

Анч өвгөн араатныг нам буудсан эсэхээ үзэхээр ус руу үсрэн ортол түүнийг барсын савар биш, харин дөнгөж сая үхлээс аварсан өнөөх хүний гар базаад авлаа.

Зебийн азаар Морисын хутга эргэн дээр үлдсэн байв. Гэтэл тэр солиорсонхүн аврагчаа багалзуурдан золтой л алчихсангүй. Зеб бугаа чулуудчихаад бүх хүчээ гарган дайралтыг няцаав. Тэр хоёр нэлээд удаан ноцолдож эцэстээ Зеб ирланд залууг сайтар тэвэрч аваад эрэг дээр гаргав.

Гэвч хэрэг явдал үүгээр дууссангүй. Шархтай хүн суларснаа мэдэнгүүт байрнаасаа ухасхийн хөл нь өвдөж зовоохоо байчихсан юм шиг самрун мод руугүйв.

Түүний цуван дээр ирт мэс гялалзаж байгааг анч өвгөн өндөр нурууныхаа ачаар ажиглаж, солиотой хүний санааг гадарлав. Морис хутга руугаа гүйжээ. Зеб хойноос нь гүйж, дахин хав хийтэл тэвэрч аваад, модноос зайлууллаа.

-Бушуулаарай! Фелимээ! Тэр хутгийг нь нуу! Энэ залуу ухаан солиорчихож. Хамаг бие нь халуу оргиж байна. Тэгээд харуулч дэмийрч байна...

Фелим өвгөний хэлдснийг хоромхон зуур гүйцэтгэн мод руу авиран гарч хутгыг авав.

Гэвч тэмцэл бас л төгссөнгүй. Шархтай хүн аврагч руугаа нударга занггидан дайрав. Тэр чанаг хашгирах, занан сүрдүүлж нүд нь муухай гялалзан байв. Тэр хоёр арваад минут ноцолдлоо. Эцэст нь Морис нэгмөсөн тамирдан туйлдаад ногоон дээр лагхийтэл суучихав. Гүнзгий амьсгаадн, давдганаж байсан хөдөлгөөн нь бүрмөсөн зогсч амьдралын нь эцсийн оч унтрах шиг боллоо.

Фелим чанга гиншин орь дуу тавьж эхлэв.

-Мангуу новши минь, бархирахаа боль! Гэж Зеб хашгираад - Ганц наад улих чинь л гол тасадчих дөхөх юм. Муужирсан л хэрэг. Намайг хөх няц болгосны нь үзэхэд огт онцтой юм алга... гээд өвчтөнийг тонгойн сайн харснаа - Ямар ч аюултай шарх алга. Үнэндээ өвдөг нь жигтэйхэн хавдартай ч гэсэн яс нь бүтэн юм байна. Тийм биш бол хөл дээрээ гишгэж чадахгүй. Бусад нь бол маажуулсан төдий л юм байна. Харин хаана ингэж маажуулчихаа вэ? Цоохор бар хүрээгүй байсан. Гэрийн муурын хумсанд л маажуулчихсан юм шиг. Өө, бүгдийг ойлголоо! Цоохор бараас өмнө чонотой үзэлцсэн байх нхь. Тийм аймхай амьтад бас хүн рүү

лайрах зүрх хүрнэ гэж хэн бодох вэ дээ? Гэтэл иймэрхүү эрэмдэг зэрэмдэг хүн рүү дайрдаг байх нь, чөтгөр ав! гэв.

Эзэн нь үхээгүйгээр бархагүй, аминд нь халтай юмгүй байгаад баярласан Фелим муухай орилохоо больж, хуруугаараа инчдэн бүжиж гарсан учир анчин ганцаараа ярьж байв. Баяр хөөр нь Тарад нөлөөлжээ. Тэр нохой, Фелимийн хийж байгаа догшин ирланд бүжигтэй аядан хөдөлж, түүнийг тойрон цовхчиж байв.

Зеб энэ инээдэмт бүжгийг анхаарсангүй. харин өвчтэй хүн рүү дахин өнгийж сайтар хараад аюултай шарх байхгүй мэдэв. Тэгээдбосч газарт хэвэтж байгаа юмнуудыг хянан үзэж эхэллээ. Моисын толгойд байж байгаа дэлбэгэр малгайг хараад хачин бодол төрлөө.

Гаяквиллийн өвсөөр хийсэн “панам” малгай гэж буруу нэрлэгдсэн сайхь малгайг энэ нутагт өргөн хэрэглэнэ. Гэвч ирланд залуу үүнээс шөл өөр хэлбэр маягтай, самбреро хэмээх мексик малгай ихэвчлэн өмсдөгийг анч өвгөн мэддэг байлаа. Морис энэ удаа заншлаа өөрчилсөн байж болох юм.

Гэвч тэр малгайг өөр нэг хүн өмсч явсан шиг Зеб санагджээ.

Өвгөн тонгойн малгайг авсан нь, уг малгай одоогийнхоо эзэнд цэвэр замаар ирж үү гэдгийг шалгах гэсэн хэрэг огт биш байлаа. Тэрээр толгойг нь эргүүлж гүйцсэн эн битүүлэг явдлын нууцыг тайлах гэсэн ганц хүсэлтэй байв.

Малгайны дотор талд уг малгайг хийсэн Шинэ Орлеоны үйлдвэрийн эзний тэмдэг, бас “Генри Пойндекстер” гэж гараар тавьсан үсэг байхыг өвгөн үзлээ.

Одоо цувы нь шинжиж үзэв. Бас л малгайны эзэн хүний цув мөнийг гэрчилсэн тэмдэг түүнийд байхыг Зеб үзлээ.

-Их хачин юм! гэж өвгөн бодлого болон газар ширтсэн хэвээр хэлээд - Малгай, толгой, бусад юм нь ч гэснэ дээ. Малгай нь байвал зохих толгой дээрээ биш, толгой нь байвал зохих газраа биш байдаг! Үнэнийг хэлэхэд, үүнд ямар нэг будлиантай юм байна! хэрэв би энэ залууд цохиулсан зүүн нүднийхээ өвдөхийг мэдрэхгүй байгаасан бол толгой минь мөрөн дээрээ байгаа эсэхэд эргэлзэхсэн гээд Морис руу харж - Одоо энэ хүнээс тайлбар хүлээлтгүй болжээ. Ухаан орсон хойно нь болохоос доо. Гэвч хэзээ ухаан орохыг хэн мэдэх билээ? За яахав гэж хэлээд анч өвгөн хэсэг зуурн дуугүй байснаа үгээ үргэлжлүүлж - Энд байхын хэрэг одоо алга. Овоохойд нь хүргэх хэрэгтэй. Хөдөлж чадахгүй байна гэж бичсэн байсан. Халуурснаасаа болоод л түр зуур хүч орсон хэрэг. Хөлний нь хавгар улам ихэсчихэж. Авч явахаас өөр аргагүй.... гэлээ.

Тэгээд үүнээ яаж биелүүлэхийг бодож байгаа бололтой.

Таратай ярриад завгүй байгаа Фелим руу харснаа

-Энэ бид хоёрын толгойд тэртэй тэргүй юм орно гэж байх биш. Нохой нь өөрөөс нь илүү ухаантай бололтой. За яах вэ. Тэгсэн тэрээгүй хөлсөө гаргаж л таарна. Харин яадагшуухан

юм билээ. дамнуурга дээр тавих хэрэгтэй. Хоёр урт мод, цув буюу Фелимийн авчирсан хөнжлөөр хийж болно. Тиймээ, тэгж л хийе. Ер нь дамнуурга л одоо бидэнд яг хэрэгтэй юм байнагэж бодов.

Ирландыг туслалцуулахаар дуудав.

Уртаараа арван тохой орчим хоёр мод огтолж шулаад түүн дээрээ арай богино хоёр модоор хөндлөвч хийж даруулан холбоод хооронд нь хөнжлөөр холбон дээр нь цув дэвсэв. Өвчтэй хүн ч юмуу согтуу хүнийг авч явж болохоор жирийн дамнуурга бэлэн болох нь тэр.

Мустангер эрүүлээсээ илүү согтуу хүнтэй төсөөтэй, дахин догширч гарахад нь дамнуургатай нь барьж хүлэхэд хүрэв. Энэ бол хоёр хүн дамжулан явж болдог жирийн нэг дамнуургатай адилгүй юм. Хоёр урт модны урд талын үзүүрийг Зебийн гүүнд бэхэлж хойд талын нь хоёр үзүүрийг анчин өвгөний хөлсийн нь гаргаад өгье гэж ам алддаг Фелим барьж явах болжээ. Зеб өөрөө урд талд нь удирдагч хэмээх хөнгөн үүрэг гүйцэтгэн алхав.

Эл аргыг шинэ бүтээл гэж хэлж болохгүй юм. Бехасын өмнөдөд харсан мексик жуузыг Зеб бүдүүлэгдүүхэн маягаар дуурайж хийсэн нь энэ. Ялгаа нь гэвэл жиогийн шүхэр байхгүй байснаас гадна, хөдөлгөөнд хоёр луусны оронд морь, хүн хоёрыг оруулжээ.

Ийнхүү гэнэтгөхөөрсөн жуузаар Морис Жеральд овоохойдоо заларч ирэв.

Энэ хачин цуваа Морисын овоохойд хэрч очиход шөнө болчихсно байв. Анч өвгөний гүжирмэг авч зөөлөн гар, өвчтэй эрийг дамнуурга дээрээс эвтэйхэн өргөж, адууны адсаган орон дээр нь тавилаа.

Морис хаана байгаага ч мэдэхгүй, өөрийнхөө дээрээс бөхийж байгаа найз нараа ч таньсангүй. Түүний догшин ширүүн зан авир дарагдсан боловч ухаан санаа нь төөрөлдсөн хэвээр байв. Халуун нь нэг үеэ бодвол буурчээ.

Өвчтэй хүн дуу тасрахгүй боловч урин зөөлөн асуултад хариу хэлэхгүй, хэллээ ч гэсэн ямар нэг битүүлэг юм ярина. Заримдаа уйтгартай юм бодогдуулмаар аймаар үгс сонсогдоно.

Морисын найз нар түүний шархыг чадах яадхаараа боогоод, өглөө болохыг хүлээхээс өөр юм үлдсэнгүй.

Фелим хажуулж, Зеб өөрөө өвчтэй хүнийг сахиахаар болов.

Фелимийг амиа бодлоо гэж буруушаах аргагүй Зеб хоёул хоёулаа сахиад яах вэ хэмээн түүнийг унт гэж явуулжээ.

Анч өвгөнд энэ талаар нэг бодол байжээ. Өвчтэй хүний дэмий донгосохыг өөрөөсөө ондоо хүнд, Фелимд ч гэсэн сонсгохгүйг бодсон ажээ. Тэгээд Морисын орны хажууд шөнийн турш сууж, хэлсэн үг бүрийг нь сонсч авлаа.

Тэрөвчтэй хүн хайр, сэтгэлийн тангараг тавьж Луизагийн нэгийг байн байн давтан өгүүлж байхыг сонсоод Зеб гайхсангүй.

Гэвч түүний амнаас заримдаа өөр нэр гарч бөйв. Энэ бол Луизагийн дүүгийн нэр байлаа. Ямар нэг утга авцалдаагүй, аймаар үгс тэр нэртэй хоршин хэлэгдэнэ.

Зеб Стумп сонссон бүх зүйлээ урьд мэдэж авсан баримтуудтай харвцуулан үзэж, овоохойд гэрэл орохоос өмнө Генри Пойндекстерыг үхсэн гэдэгт нэгэнт эргэлзэхээ больжээ.

LV. Үймээнтэй өдөр

Ноён Сильвио Мартинес бол америкчууд улс орныг нь эзэлсний дара Техаст үлдсэн мексикийн цөөн баячуулын нэг юм. Тэр бол улс төрийн бодлогыг төдий л сонирхдоггүй, төрөлхийн амгалан тайвныг эрхэмлэдэг, нас нэлээд дээр гарсан хүн тулшинэ байдалд их амархан дасжээ. Шинээр өөр улсын харьяат болсон нь түүний бодлоор бол шинэ оршин суугчдыг ирхээс өмнө улс орныг сүйрүүлж байсан команч нарын довтолгооноос аюулгүй байдлыг нь зэгсэн хангасан хэрэг байлаа.

Үнэндээ зэрлэгүүд бүрэн дарагдаж номхроогүй ч тэдний довтолгоон эрс багасжээ. Энэ бол өнгөрсөн үеийнхтэй харьцуулбал их ололтобайлаа.

Ноён Сильвио бол “ганадеро” буюу их хөлийн малчин юм. Тал тийшээ олон бээр үргэлжилсэн их бэлчээр нутагтай. Үхэр, адуун сүрэг нь хэдэн мянган толгойгоол тоологдоно.

Нэг давхар, урт нарийхан шилтгээн нь орон байр гэж санагдахаасаа илүү шорон гяндан гэж бодогдмоор ажээ. Шилтгээний тал бүрээс малын хашаа саравч хүрээлжээ.

Шилтгээний хөгшин эзэн, гоонь эрийг зожиг тайван амьдралаар амьдарна. Түүнтэй хамт эгч нь байдаг байв.

Зөвхөн Рио-Грандын эргээс сэргэлэн зээ охин нь айлячлан ирэхэд чимээ аниргүй шилтгээний нар нь гардаг юм. Исидора энд ямагт баяр хөөртэй байна. Тэр бүсгүй дуртай цагтаа ирж очдог бөгөөд авгындаа ирээд юу дуртай бүхнээ хийнэ. Түүний хөгжилтэй цовоо байдал өвгөнд таалагдана. Өвгөн өөрөө ч тийм уйтгартай хүн биш байжээ. Тэр хүүхний зан чанар зарим талаараа бусад улс оронд бол эмэгтэй хүнд тохирохгүй мэт санагдаж болмоор боловч хотын захын байшин барилга нь цаг ямагт хана хэрэм болон хувирч, гал голомт нь эзнийхээ цусаар угаагддаг ийм улс оронд бол зүй ёсных билээ.

Ноён Сильвио Мартинес галтай цогтой залуу насаа үргэлжийн аюул түгшүүрийн дунд өнгөрүүлжээ. Тэгээд ч Исидора заримдаа ямар нэг бодлогогүй шахуу зүрх зориг гаргахад нь дургүйцэдэггүйгээр барахгүй таалдаг байлаа.

Өвгөн зээ охиноо өөрийн төрсөн охин шигээ энхрийлэн хайрлана. Түүний өв хөрөнгийг Исидора залгамжилна гэдэгт хэн ч эргэлздэггүй нь мэдээж. Сильвио Мартинесын бүх зарц барлагуудын дунд Исидора нэр хүндтэй болж түүнийг ирээдүйнхээ эзэн гэж үзэцгээдэг байсан нь гайхалтай бишээ. Түүнийг зөвхөн үүний ньтөлөө ч хүндэлч байсан юм бишээ. Түүний эрэмгий зроригтой нь бүхнийг шагшуулан, тэр хавь нутгийн залуусын дунд Исидораг өмөөрч хутга сугалахгүй байх эр ганц ч олдохгүй бизээ.

Мигуэль Диас өөртөө аюул тохиолдох нь гэж байсан нь үнэн үг байлаа. Түүнд ингэж бодох бүрэн үндэс байжээ. Хэрэв Исидора авгынхаа зарц нараасявуулж, Диасыг анхны дайралдсан модонд дүүжилчих гэхэд л түүний нь дорхон нь гүйцэтгэх байлаа.

Диас ойн цоорхойгоос бушуухан зайлахын түүс болсон нь гайхалтай хэрэг биш ажээ.

Дээр хэлсэнчлэн Исидора авгынхаа шилтгээнээс жаран бээрийн зайтай Рио- Грандын орчим амьдардаг боловч, ахындаа байн байн ирэхэд нь саад болдоггүй байлаа. Ийшээ ирэхдээ ямар нэг далдын санаагүй ирлэг байв. Өөрийнх нь эцэг ч зэгсэн баян тул, өв хөрөнгийн талаар боддоггүй байжэ. Авга, эгч хоёртоо үнэхээр сайндаа л ингэж ирдэг байв. Түүнээс гадна нэг голоос нөгөө рүү аялах нь түүнд сайхна санагдаж, ихэвчлэн ямар ч дагуулгүйгээр эл зайг ганцхан өдөрт туулдаг байв.

Исидора сүүлийн үед авгындаа Леон руу улам олон ирдэг болжээ. Техасын амраг садандаа улам ойртсон ханьсаж нас нь явж буйд зовсондоо энэ үү? Аль эсвэл аар юм түүнийг татав уу? Үүнийг Исидорагийн шулуухан зан шиг хариулья. Тэр бүсгүй Морис Жеральдтай дайралдаж магадгүй гэж Леонд ирдэг байжээ. Бүр шуудхан хэлбэл бүсгүй Морист дурлачихсан юмсанжээ. Хэзээ нэгэн цагт нөхөрсөг тус хүргэсэнд нь тэгсэн байж болох л юм. Гэвч тэр үед гаргасан зүрх зориг нь залуу эмэгтэйн сэтгэлийг эзэмджээ гэвэл илүү итгэлтэй болох бизээ. Морис түүнд таалагдах гэсэн ч юм биүү, яаж мэдэх вэ.... Өөрөө үүнийг үгүйсгэдэг ч гэсэн Исидорагийн нүд рүү хээв нэг хайхрамжгүй харах хүн байна гэдэгт итгэхэд бэрхтэй. Морис үнэн хэлсэн байж болох юм. Гэхдээ тэрээр Исидоратой танилцахаасаа өмнө Луиза Пойндекстертэй уулзсан байсан бол энэ нь улам үнэмшилтэй болох байсансан.

Гэлээ ч гэсэн мексик авхайтанд Морис өөрт нь тийм ч хайхрамжгүй биш байдаг гэж бодох үндэс байв.

Исидора амар заяа үзэхээ байжээ. Төрөлхийн түргэн зантай бүсгүй тодорхойгүй байдлыг цаашид тэвчиж чадсангүй. Тэр нь мустангерт сэтгэлтэй болжээ. Тэгээд дурлалаа илэрхийлж, өөрт нь дурладаг эсэхийн хариуг шаардахаар шийдэж Жеральдад болзоо тавьсан боловч тэр хүн болзоондоо ирсэнгүй. Мигуэль Диас саад болжээ.

Мигуэль Диас бидний хооронд орчихлоо шүү! гэж Исидора ойн цоорхойг орхин авгынхаа ордон руу яарч явахдаа бодож байлаа.

Исидора бор морио хар хурдаар нь тавьжээ. Малгайгүй учир сайхан хар гэзэг нь задарч, нуруугий нь дагаж намиран буужээ. Нүд нь сэтгэлхөдлөм тормолзож, хоёр хацар нь улаа бутран гэрэлтэнэ. Гэртээ дөхөж ирээд жолоогоо татлаа. Морь нь хурдаа сааж, ханайтал хатирч байгхаад дараа нь алхалж замын дунд хэрээд зогсов. Харваас бүсгүй эхлээд бодсоноо өөрчилсөн ч юмуу, эсвэл төлөвлөгөөгөө боловчруулахаар зогсов бололтой. Бүсгүй бодлогоширно.

Яагаад ийм байгааг нь бид мэднэ. Мөн юундаа ингэждавхисныг нь өөрийнх нь хэлснээр бид ойлгож байгаа билээ.

"Ер нь түүнийг оролдохгүй байсна нь дээр. Шуугиан дэгдчихнэ. Одоохондоо миний болзооны тухай хэн ч мэдэхгүй байгаа. Ганц гэрч нь би өөрөө... Ээш, Техасын энэ найрсаг хүмүүст бүгдийг ярьж өгөх юмсан. Тэгвэл түүнийг хатуу цээрлүүлэхэд миний ганцхан өчиг л болох нь тэр! За яах вэ, тэр хүн амьд яваг. Тэр өөдгүй амьтан. Гэвч би түүнээс айхгүй. Тэгж баглуулснаас хойш, надад дахин хавьтаж зүрхлэх ч үгүй. Гэгээн минь! Түр зуурч гэсэн

сонирхож явсан минь гайяа! Түүний хүлээсийг сулруулахаар ямар нэг хүн явуулах хэрэгтэй. Миний нууцыг хадгалж чадах хүн гэвэл Бенито даамал л байна. Зоригтой, үнэнч, сайн хүн. Өө. Энэ ирж явна! Өнөө л малаа тоолдгоороо тоолсоор байна”

-Бенито! Бенито!

-Авхай минь, юу хүссэн бол.

-Бенито, найз минь би чамайг нэг тус болооч гэж гуйх гэсэн юм. Чи тус болно биз дээ?

-Таны тушаалыг баяртай биелүүлнэ гээд мексик эр мэхийн ёслов.

-Би тушаал өгөх гээгүй, тусламж гуйх гэсэн юм.

-Авхай би сонсьё.

-Чи гурван замын уулзвар толгойн оройг мэдэх уу?

-Таны авгын амлын хашаа хороог мэддэг шигээ мэднэ.

-Тэгвэл чи тийшээ яв. Тэнд нэг бугуйлаар баглуулсан хүн дайралдана. Түүний хүлгийг тайлаад тавьчих. Дуртай зүг рүүгээ яваг. Хэрэв трэ хүн гэмтсэн байвал аль болохоор туслаарай. Харин хэн чамайг явуулсныг битгий хэлээрэй. Чи түүнийг таньдаг ч байж магадгүй. Таньдаг байсан ч яах вэ. Түүнээс нэг ч юм битгий асуу. Ямар нэг юм асуувал битгий хариулаарай. Зөвхөн хоёр хөл дээр нь босгоод орхичих. Тэгээд тэр дураараа болог. Ойлгов уу?

-Авхай минь, цөм тодорхой байна. таны тушаалыг яв цав биелүүлэх болно.

-Баярлалаа Бенито найз минь. Бас нэг гуйх юм байна. энэ хэргийг ердөө гуравхан хүнээс өөр хэн ч мэдэх ёсгүй. Гурав дахь нь бол чиний очих гэж байгаа хүн. Нөгөө хочры нь чи мэдэж байна.

-Би мэдлээ авхай минь. Таны үг бол надад хууль гээд морио давирав. Ер нь түүний мэргэжлийнхүмүүс явган явна гэж бараг байдаггүй, ганц бээр газрыг ч мориор явдаг ажээ.

-Байзаарай! Би нэг юм мартчихаж! Гэж Исидора хашгираад - Тэнд серапе малгай хоёр минь байгаа. Түүнийг аваад ирээрэй. Би чамайг эндээ хүлээж байна. Эсхүл зам тосч уулзамц гэлээ.

Бенито мэхэсхийн ёслоод явав. Гэтэл дахин түүнийг зогсоож

-Бенито, ер нь би чамтай цуг явья гэж шийдлээ гэв.

Ноён Сильвиогийн даамал нь ирээдүйн эзэн хүүхнийхээ олон занд аль хэдийн дасчихсан байжээ. Тэгээд хэлсний нь даган, хамт явахаар болов.

Бенито түрүүлж, Исидора хойноос нь дагаж явлаа.

Энэ удаа бүсгүйд эзэн нь өмнө нь морилдог дээдсийн заншлыг баримтлахгүй байх үндэс байжээ.

Гэвч Бенито ташаа бодож байжээ. Исидора авхай олон зантайдаа ч түүнийг дагаж яваа биш, өөр ноцтой шалтгаанаас болоод явж байжээ. тэр хүүхэн зөвхөн серапе малгай хоёроо мартсан төдийгүй, бас түүнийг үлэжм эвгүй байдалд оруулсан захидлыг мартчихсан байжээ. Тэрнийг Бенитод мэдэгдэж, бүх юмаа түүнд итгэж болохгүй байлаа.

Энэ зурвас Мигуэль Диастай муудалцсанаас ч илүү шуугиан тарьж болно. Тэгээд зурвасыг олж авах итгэлтэйгээр буцаж яваа нь энэ. Урьд нь энэ тухай боддоггүй мөн тэнэг хүн ээ дээ...

Тэр захидал яагаад Талын Чоно буюу Эль-Койгарт орчихов оо? Зөвхөн Хосегоос л авч болох байв. Тэгэхээр түүний зарц урвагч байх нь ээ? Эсвэл Диас зарцтай дайралдаад захидлы нь хүчээр булааж аваа юу? Аль нь ч байж болох юм.

Диас юу ч хийхээс буцахгшй хүн бөгөөд Хосегийн хувьд итгэлийг эвдэж болох хүн гэж сэжиглэх үндэс ч өмнө нь байжээ.

Исидора довцог толгой өөд өгсөнгөө ийнхүү бодож явав.

Тэгсээр тэр хоёр зорьсон газраа хүрч очлоо. Исидора Бенитотой яг зэрэгцэн ойн чөлөөнд гарч ирэв.

Мигуэль Диас алга болчихсон, ер нь амьд амьтны бараа алга байв. Өнөөх захидал алга байгаа нь Исидорагюунаас ч илүү зовоолоо. Бугуйлын тасархай, малгай серапе нь байж байв. өөр юу ч алга.

-Бенито, чи гэр рүүгээ буц. Тэр хүн мориноос унасан юм. Тэгээд ухаан орж, сэргээд явчихсан бололтой. Юун сайн юм бэ. Харин Энэ бүхнийг чи бид хоёроос өөр хүн мэдэх ёсгүйг бүү март. Ойлгов уу?

-Ойлголоо. Исидора авхай минь.

Бенито явж удалгүй толгодыг давж далд оров.

Исидора ойн чөлаанд ганцаараа үлджээ. Тэр бүсгүй мориноосоо буун харайж, серапеэгээ нөмөрч, малгайгаа өмсөөд бас дахин залуу тайж болон хувирлаа. Тэгээд мориндоо яаралгүй мордов. Түүний сэтгэл аль нэг хол газар луу татагдсан бололтой. Исидораг морин дээрээ гүйцэл мордож амжаагүй байтал Хосе ойн чөлөөнд гарч ирлээ. Бүсгүй түүнээс

-Новш минь, тэр захидал яасан бэ? гэж шулуухан асуув.

-Авхай минь би өгчихсөн.

-Хэнд?

-Би...бууд... буудалд орхичихсон. Ноён Морис тэнд байгаагүй гэж Хосе царай нь цайран, түгдэрч хэлэв.

-Өөдгүй новш, чи худалд хэлж байна! Чи түүнийг Мигуэль Диасад өгсөн байна шүү дээ! Битгий булзааруул! Түүний гарт захидал байхыг би өөрөө харсан.

-Ээ авхай минь өршөөгөөрэй, уучлаарай! Би гэмгүй, би гэм хийгээгүй шүү.

-Хар тэнэг чамайг, өөрийгөө илчлэх чинь энэ. Чиний урвасны шанд ноён Мигуэль Диас хичнээн юм өгсөн бэ?

-Авхай минь би урваагүй. Тэр... тэр... намайг сүдүүлж, зодож байгаад булааж авсан юм. Надад... Надад юу ч өгөөгүй.

-Тэгвэл би чамайг шагнана. Одоо чи надад хэрэггүй. Дуртай тийшээ яв. Харин шангий нь май, май!...

Исидора энэ үгийг арвантаа давтан хэллээ. Тэгж хэлэх тоолонд зарцын дал мөрөн дунд ташуур бууж байв. зарц нь зугтаахыг оролдов. Тэр ч дэмий болов! Исидора хойноосоо хөөхөөр зарц омголон моринд нь гишгүүлчихээсээ айгаад зогсов. Зарцын бараан бие дээр хөх гувруу гүйхэд ташуурдалт сая нэг юм зогслоо.

-За одоо эндээс тонил! Миний нүдэнд бүү үзэгд! Тонил цаашаа!

Зарц айсан муур шиг хар хурдаараа гүйж ойн чөлөөнөөсгарч явахдаа өргөт ширэнгэ дотор нуугдаж гутамшгаа нууж байгаадаа баярлажээ.

Исидора ч ойн чөлөөнд удсангүй. Түүний уур хилэ, гүн гашуудлаар солигдов. Санасан нь бүтээгүйгээр барахгүй, зүрх сэтгэлий нь нууц урвагчийн гарт оржээ. Бүсгүй гэр рүүгээ буцан явлаа.

Шилтгээний эргэн тойрон ямар нэг үймээн болж байв. Тариачин, хоньчин, адуучин, шилтгээний боол, шивэгчин цөмөөрөө ийш тийш гүйлдэнэ. Тэд энд тэндгүй ямар нэг юмны тухай айн хашгиралдана.

Эрэгтэйчүүд нь зэр зэвсэг агсжээ. Хүүхнүүд сөхрөн сууж бурхнаас хамгаалахыг гуйн залбирна.

-Юу болчихоо вэ? гэж Исидора замд нь дайралдсан даамлаас тээнэгэлзэн асуулаа.

-Тал нутгийн нэгтээ хүн алчихаж гэнэ. Саявтар Каса- дель- Корвод нүүжирсэн эзний хүү, америк хүн эндсэн юм байх. Түүнийг индианууд алсан юм гэнээ гэв.

-Индианууд гэнээ!

Ноён Сильвиогийнхны сандарч үймж байсны учир үүдн байжээ. Ямар нэг хүн алагдах нь номхотгомгүй хор шартай энэ оронд гэнэтийн үзэгдэл биш байв. Яадангуяа харийн нэг амекикано алагдахад сүйд болох ч үгүй. Гэвч индианууд үзэгдлээ гэсэн мэдээ бол огт өөр хэрэг юм. Энэ бол их аюул гэсэн үг. Энэ мэдээ Исидорад шал өөр сэтггэдэл төрүүлжээ. тэр зэрлэгүүдээс айсангүй. харин алагдсан хүний нэр л түүний хардлагыг сэдрээжээ. Түүний эгчийг хүн бүгд л ам амандаа гоо сайхан амьтан гэлчдэгийг мэдэж байв. Өөрийн биеэр үүнийг зөвшөөрөхөөс өөр арга байсангүй.

Сайхь зүйрлэшгүй сайхан хүүхнийг Морис Жеральдтай байхыг харсан гэж ярилцдаг байжээ. Хэдэн цаг өнгөрсний дараа шинэ мэдээ тарлаа. Хүн амины хэргийг команчууд биш, Морис Жеральд үйлджээ! Ойр хавьд индианчуудын бараа, сураг байсангүй.

Энэ шинэ мэдээ ноён Сивьвиогийн зарц нарын сэтгэлийг амраасан боловч түүний зээ охины сэтгэлийг зовоожээ. Бүсгүй сууж байх газраа олж ядна. Хагас цагийн дараа Исидора, Обердоферын зочид буудлын хаалганы дэргэд мориноосоо бууж харагдав.

Залуу мексик хүүхэн үл мэдэгдэх шалтгаанаас хэдэн долоо хоногийн өмнөөс “америкчуудын хэлийг” махрангүй оролдож эхэлжээ. Түүний англи үгийн нөөц даанч цөөхөн ч гэлээ алагдсан хүний тухай биш, хүн алагчийн тухай асууж лавлахад хүрэлцэхүйц бололтой ажээ.

Буудлын эзэн бүсгүй хэн болохыг мэдээд асуусан юманд нь ихэд зулгуйдан хариулна. Морис Жеральдын аль хэдийнээ буудлаас явсныг, мөн хүн амины хэрэг хэрхэн гарсан талаар зарим зүйлийг мэдэж авав.

Мексик бүсгүй авгынхаа шилтгээнд их гунигтай буцаж ирлээ. Тэнд бас л үймсээр байлаа.

Дахин үймэлдсэний учир нь инээдтэй санагдах авч сүсэгтэй зарц нар шал өөр бодолтой байв! Нуэсес голын орчим нутагт морь унасан толгойгүй хүн үзэгдсэн тухай байж боломгүй шинэ мэдээ тэд нарыг айлгажээ.

Сайхь мэдээ нь хэдийгээр утгагүй юм шиг санагдавч, эргэлзэх юм байсангүй. Үүний тухай бүх сууринаар мэдсэнээс гадна ноён Сильвиогийн алдуул мал эрж явсан малчид аймшигтай хүнийг өөрсдийн нүдээр харж, эрлээ орхин чөтгөр харсан юм шиг ум хумгүй зугтаажээ.

Тэр гурван малчинхэлснийхээ үнэн гэдэгт андгайлахад бэлэн байлаа. Гэвч тэдний аж сандарсан царай ямар ч андгайнаас илүү үнэнийг хэлээдөгч байв. Үдэш болоход бүх шилтгээнээр аймшигт мэдээ таржээ.

Гэвч хэдийгээр авга ах, эгч нь бүү яваач гэж гуйж гувшсан авч, Рио-Гранд руу буцна гэж шийдсэн зээ охиных нь шийдвэрийг юу Ч ӨӨРЧИЛЖ ЧАДСАНГҮЙ.

Та нутагт түүнийг явах зам дээ хүн алагдсан явдал ч түүнийг сатуулсангүй! Морь унасан толгойгүй хүний тухай цуу түүнийг бүр ч бага зовоож байв.

Ихэнх хүнийг ахйлгаж байгаа тэр зүйл Исидорад зөвхөн сонирхолтой санагдана. !Тэр тусмаа ганцаараа явна. Ноён Сильвио түүнийг зэвсэг бүхий арван хүнээх хамгаалуулан явуулах гэв. Гэвч Исидора эрс татгалзлаа.

Бенитотой хамт явахгүй юм болов уу?

Үгүй, ганцаараа явахыг дээр гэж үзжээ. Тэгж шийдсэн байлаа.

Исидора маргааш өглөө нь амд гарав. Бүсгүй хар үүрээр морджээ. Тэгээд хоёр цаг ч өнгөрөөгүй байхад Рио-Грандын эрэгт оойртож очив.

Тэр яагаад ингэж тойруу замаар явна вэ? Төөрчихсөн вч биш байгаа? Үгүй, төөрснө хүн бол шал өөр байдалтай харагддаг. Царай нь үнэхээр уйтгартай харагдавч, цөхөрсний шинж үл ажиглагдана. Морь нь эзнийхээ залсан зүг итгэлтэй хатируулна.

Исидора төөрөөгүй нь илт. Тэр замаа сайн мэдэж байв... Хэрэв төөрсөн бол түүнд илүү дээр байх байлаа.

LVI. Чөтгөрийг буудав

Өвчтэй хүн шөнийн турш нүд аньсангүй. нэг үе чимээ аниргүй хэвтэж, нэг үе дэмийрч солиорч байлаа. Анч өвгөн шөнөжин түүнээс холдолгүй сууж авцалдаагүй ярианы үг бүрий нь чагнав.

Сонссон зүйл нь Морис Луизад сэтгэлтэй бөгөөд, дүү нь алагджээ гэж бодсоны нь баталж байлаа. Залуу хүү алагдсан өвгөн анчныг гашуудуулсан нь мэдээж ч, өөрт нь мэдэгдсэн бүх баримт сэлтийг нэгтгээд үзвэл сэтгэлий нь айхтар зовоож байв.

Хэрүүл маргаан... малгай... цув... Зебийн бодол ямар нэг харанхуй бүдүүлэг юман дотор байгаа мэт төөрөлджээ. Анч өвгөний саруул ухаан хэзээ ч ийм холион бантантай дайралдаж явсангүй. Зеб Стумп юу ч хийж чадахгүйгээ мэдрэн гаслав.

Тэр урилгагүй зочид ирдэг юмаа гэхэд ямарч байсан шөнө иэрхгүй гэдгийг мэдэх учир хаалга үүд рүү хараа тавьсангүй. Зөвхөн ганц удаа өглөө үүрээр сарны гэгээ үүрийн туяа хоёр нийлэх үеэр гадагш гарав. Гарсны учир нь ширэнгэ дотор тнэж явсан Тара гунигтай, уртаар улихад санаа нь зовжээ. Дараа нь нохой урц руу гүйж ирэв.

Зеб гэрлээ унтраагаад сэмхэн гарч чимээ чагнав. Халуун орны шугуй доторхи шөнийн дуу чимээ намджээ. Тарагийн ульснаас ингэв үү? Нохой яагаад улив?

Анч өвгөн эхлээд овоохойны өмнөх нуга руу, дараа нь ойн зах руу харж, сүүлд нь модны сүүдэр дундуур ажиглав. Гойд юм ч харагдсангүй. Бүх юм байдгаараа л байлаа.

Шөнийн тэнгэрийн өнгөн дээр цохио уйтгартай сүлийнэ. Хоёр талаар нь моддын орой бараантна. Эдгээрийн дунд тавин алхам хяраатай зурвас гэрэл харагдах бөгөөд энэ нь дээд хөндийн зах болохыг өвгөн мэдэж байв. Сарны тунгалаг гэрэл ганганы ирмэгийг тод гэрэлтүүлж тэнгэрийн өнгөн дээр могой явж байсан ч харагдмаар ажээ.

Гэвч тэнд ч юу чбайсангүй.

Гэхдээ ямар нэг чимээ сонсдож байв. Тэр чимээ хөндийн зүгээс, морины тах чулуу мөргөх адил ажээ. Зеб тэгч бодоод чимээг чагнан чих тавилаа.

Дахин чмээ гараагүй ч өвгөн анчин андуурсангүй. Удалгүй модны орой дээгүүр ганганы ирмэг даган гэг морь гараад ирэв.

Энэ нь морьтой хүн байлаа. Морь хүн хоёрын дүр тэнгэрийн наана ялгаран харагдана. Хүний бараа нь эмээлээсээ мөрөө хүртэл харагдаж байв. Мөрөн дээр нв юу ч үзэгдсэнгүй.

Зеб Стмуп нүдээ дахин дахин арчаад харсан боловч яг л өнгөө хэвээрээ харагдана. Зеб наян удаа ингэж харлаа ч гэсэн өмнө нь нөгөө л морь унасан толгой хүний дүр бахь байдгаараа л байх байв.

Эргэлзэхийн аргагүй байлаа. Морь ганганы ирмэгээр итгэлтэй аажуухнаар алхалж, туурайн

чимээ үл сонсдох нь сүүдэр шийн дүрс мэт гулгаж явна уу гэлтэй. Энэ бол түр зуурын хий үзэгдэл биш байв. Зеб түүнийг ямар ч байсан хий үзэгдэл, зэрэглээ биш гэдгийг итгэтлээ зэгсэн сайн харжээ.

Тэр үзэгдэл аажмаар алга болов. Эхлээд морины толгой, цэжжин бие нь далд орж, дараа нь нөгөө аймшигт сүүдэгнэсэн үзэгдэл болох хүний дүрс, дараа нь морины хондлой сүүл нь далд орлоо.

-Иосафат! Гэж анчин дуу алдав. Тэр морь унасан толгойгүй хүнийг далд ороход ингэж гайхсангүй. Тэнд нэг их хачирхах юм ч байсангүй. Ганга руу өгсөж, ургасан моддын цаагуур далд оржээ.

-Иосафат!

Анчин өвгөний амнаас хоёр дахь удаагаа энэ үг гарав. Гэхдээ учиргүй гайхаж, айсан өнгө илэрхий байлаа.

Түүний байгааг хараад л хэр зэрэг сэрдхийсний нь мэдэж болохоор байв. хэдий зүрх зоригтой ч дагжин чичирч, тамхинаас болж хөхөрсөн уруул нь хүртэл цусгүй цайжээ.

Зеб хачин жигтэй үзэгдлээс болж хэл ам нь татчихсан юм шиг хэсэг зуур огт үг дуугүй зогссоноо сүүлд нь

-Чөтгөр ав! гэж нөгөө морьтны сүүл далд сорно газраас халаа салгалгүй хэтээр хэлээд - Ямар ч гэсэн ирландын хэлсэн үнэн юм. Би түүний согтуу нүдэнд тийм юм харагдаж гэж бодож байсан юм! Тэгсэн чинь үгүй юмсанж! Тэр яг л над шиг харж л дээ. Хөөрхий амьтны айсныг гайхах юм алга. Одоо хүртэл өвдөг чичирсээр байна. Бурхан минь! Энэ чинь юу гэгч вэ? Энэ чинь юу гэгч вэ? гэж хэсэг зуур бодсоноо дахин хэлээд - Би учры нь тайлж магадгүйяа. Хэрэв өдөр юмуу эсвэл илүү ойрхон байсан бол сайн харж авахсан. Түүнд ойртож очихыг оролдож яагаад болохгүй байх вэ. Чөтгөр ав, оролдоод үздэг хэрэг. Энэ нь шулмас байлаа ч гэсэн намайг барьж идэхгүй нь лав. Хэрэв энэ үнэхээр чөтгөр бол, сум түүнийг эмээлээс нь ховхолж чадах сэхийг үзье байз. Тэгэхээр юу нь ч байлаа гэсэн энэ муу ёрын юмтай сайн танилцаад үзье гэв.

Анч өвгөн ингэж хэлээд ганга, эрэг өөд очдог нарийн зөрөг рүү явлаа.

Нохойн улихыг сонсоод овоохойноос буугаа авч гарсан учир бцах хэрэг байсангүй.

Хэрэв морь унасан толгойгүй хүн яс махнаас л бүтсэн бол, хэрэв нөгөө ертөнцийнх л биш бол Зеб Стумп дахин уулзахаас айхгүй байлаа. Түүнийг овоохойн үүднээс харахад дээд талын хөндийгөө Аламо руу буудаг хотгор руу яг чиглэн явж байлаа. Зеб яг тэр зөргөөр морь унасан толгойгүй хүнтэй ганганы ирмэг дээр, хэрэвл зүг чигээ өөрчилж, явдлаа түргэсгэхгүй бол дайралдана хэмээн тооцоолж явснаас аль хэр замыг хэдий хугацаанд туулахаа түргэн бодож амжив.

Түүний бодсон яг зөв байв. Толгой нь хөндийтэй зэрэгцээд ирэхийн үед морь унасан

толгойгүй хүний цээжийг харлаа.

Дахин нэг алхнагуут биүх биү нь харагдав. Дахиад нэг алхангуут морь унасан толгойгүйхүний бүх бие ил харагдав.

Зеб түүнийг хараад давхийн зогтусав! Хэрэв өөр хүн байсан бол лав толгойтой үс нь болсон байлаа. Гэлээ ч дараа нь өөрийн нь хүлээснээх Зебийн ар зоо руу өөрийн эрхгүй хүйт даажээ.

Хэдий тийм боловч анчин нааш хүрч ирсэн хэргээ бүтээнэ гэж, хүн шулмас хоёрынчухам аль нь болохыг мэдэж авна гэж хатуу шийдэв.

Цаг алдалгүй буугаа шүүрэн аваад шагайв. Сар тодхон гэрэлтүүлж, морь унасан толгойгүй хүний цээжинд шууд хараалж болохоор ажээ.

Агшин зуур болоход л сум зүрхий нь нэйт сүлбэчихэд бэлэн байв. Гэвч анч өвгөн гэнэт “Хүний аминд хүрчихвэл яана?” гэж бодод буугаа доошлуулан эргэлзсэнээ

-Хүн байж болох юм шүү хэмээн бувтнаад - Хэдий адилгүй чгэсэн... Энэ мексик хувцасны дор толгой байх нь юу л бол. Хүн бол, хэл байх ёстойёо доо. Харин чухам хаана нь вэ гэдийг мэдэхгүй байлаа... Хөөе морьтой хүн! Та үүгээр яасан орой явж байх юм бэ! Толгойгоо хаана мартчихаа вэ? гэж хашгирлаа.

Хариу дуугарсангүй. Зөвхөн морь нь хүний дуу сонсоод тургиснаас хэтэрсэнгүй.

-Хөөе чи аан гэж бай! Кентукки муж улсын өвгөн Зеб Стумп яамтай ярьж байна. Би бол даажигнаж байдаг хүмүүсийн нэг биш. Чиний илбийг тайлбарлуулахын хүсч байна. Аль вэ, хариулаадхаач, эсвэл би буудлаа шүү!

Бас ямар ч харуидуугарсангүй. Зөвхөн Зебийн дуунд дассан бололтой морь нь толгой хаялна.

-Чамайг чөтгөр аваачаасай! Гэж дуу гарахгүй байгааг доромжиллоо хэмээн уурласан анч өвгөн хэлээд - Зургаан хормын дараа хугацаа өгье. Хэрэв энэ хугацаанд хариу хэлэхгүй бол буудна шүү! Зүгээр нэг чихмэл, мануухай бол буудахад гэмтэхгүй. шуламс бол бүр ч яах ч үгүй. Үхсэн хүн болж тоглож байгаа юм бол дэмий зангаасаа болж сум хүртэнэ шүү. за хариу хэл! Гэж өвгөн улам уурсан хашгираад - Чи дуулж байна уу? үгүй юу? Чи дургүй байна уу? За яах вэ! Би буудлаа шүү! Нэг, хоёр, гурав, дөрөв, тав, зургаа.... Гэж тоолов.

Хэрэв цааш тоолсон бол “долооо” хэмээн хэлэх ёстой тэр агшинд буу тасхийн, сум шунгинаад ямар нэг хатуу юманд тугалга пүдхийн орох битүү чимээ гарав.

Буудлага ямар ч үр дүнд хүрсэнгүй. зөвхөн морь үргэн янцгааж, унаж яваа хүн нь өнөө л хэвээрээ ажиг ч үгүй байж байлаа.

Ер нь морь тэгтлээ үргэсэнгүй. Янцгаах нь нэг л доогтой юм шиг санагдав.

Гэвч байрнаасаа ухасхийн давхиж, амьдралдаа гайхаагүйгээрээ гайхсан Зеб амаа ангайн хоцорлоо.

Зеб хэдэн хором өвдөглөсөн чигээрээ хөдөлсөнгүй. Буудахын өмнө зоогоор нь хүйтдаах шиг болж байсан бол одоо бүр хамаг бие нь хөрчих шиг болжээ. Зөвхөн гайхаад зогссонгүй айсандаа хөшчих нь тэр. Анч өвгөн сум нь зүрхэнд юмуу эсвэл вутай ч гэсэн хүний зүрх хаана байлаг ёстой вэ? тэнд л туссан гэж итгэж байв. Хүн байв уу? Үгүй байж хэмээн Зеб бодов. Энэ бодол нь хэрэв морь муу ёрын муухайгаар янцгаан, одоо ч гэсэн хамаг биеийн нь дагжтал чичрүүлчихээгүй бол түүнийг тайвшруулж мэдэх л байлаа. Зеб зугтааж гүйхийг хүссэн боловч чадсангүй. нэг хөлөөрөө өвдөглөсөн хэвээр нөгөө гайхлыг сарны туяа гийгүүлсэн хөндий рүү далд орон ортол мэгдэн харсаар байлаа. Далд орсны нь дараа жаахан тайвширч, овоохой хүрчихээр тэнхээтэй болов.

Урцанд орсны дараа ухаан нь сэргэж, эл хачин явдлын талаар тухтайхан бодож чадахаар болжээ.

Шуламстай дайралдлаа гэсэн бодлоосоо удтал салж чадахгүй байв. Тэгээд сайтар эргэцүүлэн бодоод энэ болж байж боломгүй юм гэдэг дүгнэлтэд хүрлээ. Гэвч өөр нэг тайлбар гаргаад ирж бас чадсангүй. Тэгснээ ихэдтээнэгэлзсэн өнгөөр

-Энэ нь нөгөө ертөнцийнх байна гэдэг юу л бол, сум пидхийтэл бие рүү нь орох дуулдсан. Бүр яах аргагүй биетэй юманд тусна билээ. Уг нь чөтгөр, шуламс бол биегүй байх ёстойсон... За яах вэ! Тархи толгойгоо эргүүлэх хэрэг алга! Нэг бол даавуу чихсэн чихмэл, нэг бол чөтгөр бизээрээгэдэг хоёр зүйл л байна хэмээн өвгөн анч энэ хачин үзэгдлийн учрыг олох гэсэн оролдлогоо орхихоор шийдэв бололтой хэлэв.

Анчныг овоохойд ороход өглөөний гэрэл ч хамаг урцанд орж ирлээ. Фелимийг сэрээж өвчтөнгийг сахиулах цаг болжээ. Ирланд хүн аль хэдийнээ эрүүл саруул болчихоод их унтсандаа буруутлаа гэдгээ жаахан ойлгож уг үүргийг дуртай хүлээж авлаа.

Анч өвгөн туршлагагүй орлогчид халаагаа өгөхөөс өмнө өвчтөний шархыг

өөрөө дахин боож өглөө. Зеб ургалмын эмчлэх чанарыг сайн мэддэг байжээ. Шарх түргэн аниулдаг нэгэн төрлийн аршийн нударгын шүсийг тавьж боолоо. Энэ ургамлын шүүсийг түрхсэнээс хойш нэг хоногийн дараа шарх аньж эхлээд, гурав хоноход бүрэн эдгэрдгийг өвгөн туршлагаараа мэддэг байжээ.

Нутгийн оршин суугчид олонхи хүний адил Зеб аршийн анагаах чадалд итгэдэг бөгөөд, ойр хавьд нь арван эмч байлаа ч гэсэн ганцыг нь ч өвчтөнийг үзүүлэх гэж дуудахгүй хүн байв. Өвгөн Морисын амь насанд ямар ч аюул байхгүй. дор хаяж л шархнаас нь айх юм байхгүй гэж үзэж байв.

-Аюул байсан нь шал өөр юмнаас ажээ.

Зеб Морисын шархыг боож гүйцээд

-За эрхэм Фелим, бид шархыг эмчлэх талаар чадах бүхнээ хийлэ. Харин одоо энэ өвчтэй

хнүийг яаж хооллох тухай бодох хэрэгтэй... Ямар ч идэх юм байхгүй гэж чи хэлсэн байх аа? гэв.

-Стумп гуай минь, үзээд өгье ч гэсэн юу чбайхгүй. Ганц дусал ч архи байхгүй нь бүр ч тусгүй.

-Муу новш чи л бүгдийг нь гударчихаа биз! гэж Зеб ууртай хашгираад - Хэрэв чи байгаагүй бол Морсыг хөл дээрээ босч тэнхэртэл нь балгуулахаар юм байсан. Одоо яанаа? Гэлээ.

-Стумп гуай та намайг дэмий гомдоох юм. Би жижигхэн дашмагтайгаас л уусан. Том лонхтойг нь индианчууд хоосолчихсон юм. Нээрээ шүү!

-Битгий худлаа хэл! Чи л болоод ганцхан дашмагтайг уугаад ойчиж байх гэж үү? Би чиний мангас шиг уудгийг сайн мэднэ. Чи том лонхтойгоос багагүй гударч л дээ.

-Гэгээн минь би тэгээгүй!

-Тэр гэгээнтэйгээ чөтгөр рүүгээ танил! Түүнд чинь тэнэгүүд л итгэдэг юм... За тэр яах вэ, үг олдлоо! Чи л бүх вискийг гударчихсанаас хойш, яах ч арга алга. Түүнийг олох гэж хорин бээр явалтай нь биш. Ойр хавьд ч хаа ч байхгүй. Тэргүйгээр л аргалахаас өөр яах вэ.

-Одоо яах билээ?

-Миний үгийг амаа хамхиад дуугүй сонсч бай. Бид архигүйгээр аргалж болно. Харин хоолгүйгээр байж болохгүй. Энэ өвчтэй хүн маань бүр турж гүйцлээ. Би л хувьдаа цацагт хяруул байтугай чонын мах идэхээс буцахгүйгээр их өлсөж байна. Чи эндээ хоцроод Морсиын дэргэд байж байна. Би гол руу явж үзье. Ямар нэг бууны ам тосодчих юм дайралдаж юу магад.

-Стумп гуай бүү сэтгэл зов. Би юу хэрэгтэй бүхнийг хийнэ. Үнэн голоосоо...

-Дуугүй байх, би хэлж гүйцээгүй байна!

-Би дахин нэг ч үг дуугарахаа байя.

-Амаа хамхиач, тэгээд! Сайн сонсч бай. Тэгэхлээр намайг эзгүй хойгуур энд ямар нэг хүн ирвэл надад мэдэгд. Харин нэг ч хором алдалгүй тэр дор нь л мэдэгдэнэ шүү.

-Та түүнд бүрэн итгэж болно.

-Найдвар алдав аа, сайхан мэдээрэй!

-Найдварыг тань алдахгүй. Харин би яаж танд мэдэгдэх вэ. Стумп гуай? Хэрэв та хол явчихвал миний дуу хүрэхгүй. Тэгэхлээр яах билээ?

-Би тийм холдохгүй байлгүй. Үүрээр гол дээрээс зэрглэг цацагт хяруул буудахаас амархан юмүгүй. Гэвч юмыг яаж мэдэх вэ? гэж Зеб агшин зуур бодсоноо, - Чамд эндээс буу олдох уу?

гар буу ч байсан болно гэж хэлэв.

-Надад аль нь ч байхгүй, цөмий нь эзэн аваад явчихсан. Бодвол сууринд л орхисон байх ёстой.

-Муу юм болж дээ. Үнэндээ чиний дуу надад уудладахгүй байж магадгүй

Зеб босго алхсанаа зог тусаад юм бодсоноо

-Өө оллоо! Нэг юм бодож оллоо! Миний хөгшин гүүг харж байна уу? гэв.

-Стумп гуай минь яалаа гэж харахгүй байх вэ? Харж байна.

-За ямай. Цаана чинь ойн чөлөөний яг захад байгаа аршийн нударгыг харж байна уу?

-Алган дээр байгаа юмшиг харагдаж байна.

-Сайн байна! Одоо тэгвэл аан гэж бай. Хаалгаа харж байгаад хэрэв намайг эзгүйд ямар нэг хүн ирвэл шууд тэр аршийн нударга руу гүйж очоод өргөстэйхөн шиг нэг найлзууры нь огтолж аваад гүүний сүүлэн доогуур хавчуулчихаарай.

-Гэгээн минь яалаа гэж тэр вэ?

-Яах вэ? тайлбарлахаас л биш. Эс тэгвэл чи хамаг юм холион бантан болгочихно. Фелим минь, хэн нэг хүн үүгээр үзэгдвэл би мэдэх хэрэгтэй байна. Би холдохгүй, тэглээ ч гэсэн чиний дууг сонсохгүй байж магадгүй. Тэгэхээр гүү чарлавал дуу нь чинийхээс илүү чанга байх. Мэдэв үү Фелимээ? Захиж хэлсэн бүхнийг хийгээрэй

-Ээ тэгэлгүй яах вэ, хичээе!

-Мэдээтэй байгаарай. Үүнээс эзний чинь амь нас шалтгаалж болох юм шүү.

Анч өвгөн сүүлчийн тушаалаа өгөөд бууцгаа үүрч овоохойгоос гарч явав.

-Энэ чинь тэнэг өвгөн биш юм гэж Фелим анчныг нэлээн хол үгий нь дуулахааргүй газар очсоны дараа хэлээд - Харин яагаад хэн нэг хүн ирвэл эзэнд муу юм болох юм шиг айгаад байгаа юм бол? Тэр бүү хэл үүнээс эзний амь нас шалтгаана гэх юм. Тийм ээ, яг ингэж хэлсэн. Намайг хаалга сайн манаж бай гэсэн. Бүр одоохон хийх хэрэгтэй. Явж харъя байз гээд нуга руу очиж овоохой руу чиглэсэн бүх зөргийг ажиглав. Тэгснээ буцаж ирээд овоохойн үүдэнд харуулын хүн шиг зогслоо.

LVII. Болзсон дохио

Фелим төдий л удаан харуулд зогссонгүй. Арван минут ч болоогүй байтал морин төвөргөөн сонсдож ямар нэг хүн голын эрэг дагаж овоохой руу ойртон айсуй.

Фелимийн зүрх өөрийн эрхгүй цохилоод явчихлаа.

Ойртож яваа морьтой хүнийг ажиглаад ямар зочин болохыг мэдэж чадсангүй. Морин төвөргөөний чимээгээр ганц хүн айсуй нь түүнийг юунаас ч илүү айлгана. Олон морины туурайн чимээ сонссон бол үүнээсээ бага айх байлаа. Хэдийгээр мустангер овоохойд хэвтэж байгааг сайн мэдэж бөйгаа ч гэсэн толгойноос бусад нь эзэнтэй нь их адилхан харагдах нөгөө хүнтэй дахин дайралдхаас айж байв. Эхлээд нуга руу гүйж очоод Зебийн захисныг биелүүлмээр санагджээ. Гэвч айснаасаа болж дороо зоомол юм шиг зогсоод, хөдөлж ч зүрхлэхгүй байв. Гэхдээ дэмий айжээ гэдгээ ирланд хүн удалгүй мэдлээ. Тэр танихгүй хүний толгой нь мөрөн дээрээ байж байлаа.

-Аа тийм байх ёстой, толгой нь мөрөн дээрээ байж байна гэж Фелим тэр морьтой хүнийг модныцаанаас гарч ирээд, ойн чөлөөний цаад захад зогсоход нь хэлээд - Ёстой толгой байна. Бас тэгэхдээ сайхан царайтай юм. Гэвч хөөрхий минь ямар нэгэн юманд сэтгэл дүүрэнгүй яваа бололтой. Эмээ ээжийгээ дөнгөж сая хөдөөлүүлчихээд явж байгаа юм байна гэж бодогдмоор! Жижиг хөлтэй юм... Гэгээн минь энэ чинь эмэгтэй хүн байх шивдээ? гэв.

Фелимийг ганцаараа ярин үглэж байтал үл таних хүн ойртож ирээд дахин зогслоо.

Энэ үед Фелим танихгүй хүнийг хэдийгээр ямар ч сэргэлэн хүнийг андууруулж мэдэхээр эр хүн шиг эмээл дээрээ сууж, эрэгтэй хүний бүрх, серапе өмссөн ч гэлээ эмэгтэй хүн гэж зөв таньснаа мэдэв.

Үнэхээр эмэгтэй хүн байлаа.

Энэ бол Исидора байв.

Фелис тэр мексик хүүхнийг анх удаа үзэж байгаа бөгөөд хүүхэн ч Фелимийг танихгүй ажээ. Түүний царай уйтгартай байна гэ Фелимын харсан нь зөв байжээ. Уйтгартайгаар ч барахгүй, түүний царайд цөхөрсний тэмдэг үзэгдэнэ.

Исидора модны цаанаасгарч ирэхдээ нүд нь ямар нэг юмнаас хйж болгоомжилсон шинжтэй байв. Ойнчөлөөнд гарч ирэхдээ царйа зүс нь баяр баясгалантай болсонгүй, харин цөхөрч, гайхаш тасарсан байдалтай байлаа.

Овоохойг хараад гайхсан нь юу л бол. Исидора урьд нь овоохойг мэддэг байд. Зорьж гарсан газар нь энд байлаа. Овоохойн үүдэнд зогсч байгаа хачин дүрс л түүнийг гайхалд оруулжээ. Уулзах гэж хүсч ирсэн хүн ньбиш байв.

Тэгээд тээнэгэлзсэн байдалтай бүр тулж ирээд

-Би андуураагүй байгаа? Гэж англиар асуугаад, - Уучлаарай, Би... би Дон Морисиог энд байдаг гэж бодсон юм гэв.

-Дон Моришо гэнэ үү? Үгүй. Энд тийм хүн байхгүй. Дон Моришо? Би Баллиаыбалахын ойролцоо байдаг Моришо гэгч ганц хүнийг л танина. Тэр хүнийг Пат Мориш гэдэг юм.

-Дон Морисио. Мо-Рис! Мо-Рис!

-Өө Морис уу! Та миний эзэн Жеральд гуайг асууж байгаа юм биш биз дээ?

-Тийм тийм! Эрхэм Жеральд

-Хэрэв танд ноён Жеральд хэрэгтэй бол яг энэ овоохойд суудаг юм. Чухамдаа гэвэл зэрлэг адууны авдчявсныхаа дараа үүгээр дайрч ирдэг юм. Анхийх л гэж энд түр ирдэг юм. Хэрэв та эртний ирланд нутагт нь байдаг сайхан цайз, шилтгээний нь харсна бол доо! Бас Морис гуайг бодож уйтгарлан байгаа цэнхэр ншдтэй үзэсгэлэн гоо хүүхнийг харсан бол яана! Хөөрхий амьтан Морис гуайг буцаж очихыг хүлээж, хамаг нулимсаа барж суугаа. Ээ, та тэр хүүхнийг үзсэн бол яана!

Фелимийн үгс хэдийгээр ирланд дуудлагатай боловч Исидора уг санаагий нь ойлгожээ. Хардана гэдэг бол сайн хэлмэрч юм. Фелимийг “тэр хүүхэн” гэсэн товчхон үг хэлэхэд Исидора сүүрс алдах мэт гиншээд авав.

-Би ер нь “тэр хүүхэнтэй” уулзах гэсэн юм алга. Би тэр хүнтэй уулзахыг хүсч байна. Тэр хүнгэртээ байна уу? гэж Исидора яаран хэлэв.

-Гэртээ бий юү гэнээ? Сүрхий улаан цайм асуулт байна даа. Тэр хүн гэртээ байна гэж хэлбэл та яах юм бэ?

-Тэгвэл би түүнтэй уулзах гэсэн юм.

-Өө тийм бий! Та хүлээх л болж дээ. Одоо юун зочин хүлээж авахтай манатай. Үзэсгэлэнт авхай минь, зөвхөн эмч юмуу санваартныг л оруулж болно. харин би таныг оруулахгүй.

-Гэвч ноён минь, би тэр хүнтэй уулзах тун чухал хэрэгтэй!

-Үгүй ер... та түүнтэй уулзах хэрэгтэй гэнээ? Тэр ч амжихгүй дэгээ. Фелим О нил сайхан хүүхэн, ялангуяа тан шиг хар нүдтэй хүүхэнд хориг тавих нь ховор. Гэвч болохгүй юмыг бол яах вэ дээ!

-Яагаад болдоггүй юм бэ?

-Шалтгаан хаа мундах вэ! Нэгдүгээрт, тэр одоо зочин гийчнийг, ялангуяа эмэгтэй хүнийг хүлээж авч чадахгүй.

-Яагаад тэр вэ, эрхэм минь?

-Яагаад гэвэл тэр хүн зохих ёсоор хувцаслаагүй байгаа. Өвгөн Зеб биеийн нь ороож өгсөн хуучин даавууг эс оролцуулбал ганцхан цамцтайгаа байна. Чөтгөр аваг! Тэр даавуугаар түүнд цамц, элгэвч, өмд, ер нь бүрэн хувцас очод өгч хүрэхээр юмсан.

-Эрхэм минь, би таны хэлээд байгааг ойлгохгүй юм...

-Үгүй ер, ойлгохгүй байна гэнэ шүү! Битүүнийг орондоо хэвтэж байгаа гэж ойлгогдохооргүй хэвчхлээ гэж үү?

-Одоо орондоо хэвтэж байгаа юм бий! Ямар нэг юм...

-... юм тохиолдоогүй биз гэж та асуух гэж байна уу? Аз дутахад тийм явдал тохиолдсон. Муу юм болох болохдоо бүр олон долоо хоног орондоо хэвтэхээ юм болсон.

-Ээ эрхэм минь тэр өвчтэйбайгаа гэж үү?

-Гол нь яг тийм болчихоод байна даа яая гэх вэ, хонгор минь, үүнийг нуугаад ч яах юм билээ. Намайг хэллээ гээд түүнд сайн ч муу ч юм аль нт ч болохгүй. Өөрийнх нь дэргэд хэллээч гэсэнд дургүйцэхгүй байлгүй.

-Тэгэхээр өвчтэй юм байж. Эрхэм минь тэр юу нвөвдөө вэ, яагаад өвдсөн юм бол хэлж өгөөч?

-Тэгье. Тэгэхдээ би таны зөвхөн ганцхан анхны ганц асуултад хариулж чадна. Тэр шархнаасаа болж өвдсөн. Харин хэн тэгснийг нь бурхан л мэднэ. Түүний хөл өвчтэй. Харин догшин мууртай цуг нэг шуудайд байсан юм шиг хамаг бие нт шарх сорви болчихсон. Пээ, та харсан ч болоосой! Эрүүл газар нэг ч үгүй шүү! Тан ыгарын алган чинээ эрүүл газар ч үлдсэнгүй. Бас тэгээд ухаангүй байгаа нь бүр ч муу байна.

-Ухаангүй гэнээ?

-Яг тийм байгаа. Мал болтлоо согтчихоод, араас нь шилээвэр барьсан хүн хөөгөөд байна гэж санадаг хүн шиг л дэмий донгосоод байна. Балга дарс байвал түүнд сайн эм болмоор шиг санагдах юм. Байхгүйгээс хойш яах вэ дээ! Дашмаг, лонх цөм хоосон. Та ч юм авч яваагүй биз дээ? нэг жаахан агвардиент байвал зүгээр юмсан. Танайхаар тэгж хэлдэг байхаа? Би тэрнээс ч дор юм ууж үзсэн. Тэр хүнд балга юм их тус болохсон. Авхай та үнэнээ хэл л дээ, танд дуслын төдий боловч юм байхгүй юу?

-Байхгүй эрхэм минь, харамсалтай нь дусал ч дарс алга.

-Харамсалтайяа! Морис гуайн өмнөөс харамсаж байна. Архибайсансан бол түүнд туйлын хэрэгтэй байсан санж. Гэвч яая гэх вэ, ингээд л байхаас биш.

-За тэгээд эрхэм минь би түүнтэй уулзаж болохгүй гэж үнэн хэлж байна уу?

-Яриагүй үнэн. Ер нь ч ямар хэрэг байна? Яалаа ч тэр чинь таныг бурал эхээсээ ялагж

чадахгүйгээр байгаа юм чинь. Тэрхүн хүнд шархдаад ухаангүй байна гэж дахин хэлье.

-Тэгэх тусмаа л би түүнтэй уулзах ёстой. Би түүнд тус хүргэж юун магад. Би өртэй юм...

-Өө та түүнд өртэй, түүнийгэжэ төлөх гэж яваа юм уу? Тэгвэл ч шал өөр хэрэг шүү. Тэгэхээр түүнтэй заавал уулзах хэрэг юу байна? Би даамал нь болохоор хамаг хэрэг миний гараар дамждаг юм. Үнэндээ би бичиг мэддэггүй. гэвч гарын үсэгний оронд хэрээс зураад өгч чадна, ингээд л болох нь тэр. Тэр мөнгөө зориглоод надад өгчих. Эзэн түүнийг чинь хоёр дахь удаагаа нэхэхгүй гэдгийг танд амлая. Цагаа олсон юм бол.Бид удахгүй эндээс явна. Тэгэхээр мөнгө хэрэгтэй. Хэрэв мөнгө чинь танд байгаа бол бусад цаас, үзэг, бэхий нь овоохойгоос олж ирье. Нүд ирмэх зуур баримт гаргаад өгье.

-Үгүй, үгүй, үгүй! Би мөнгөний тухай яриагүй. Энэ бол ачийг нь хариулах өглөг байгаа юм.

-Өө, зөвхөн талархал илэрхийлэх юм бий! Энэ бол амархан. Баримт гарын үсэг ч үаардагдахгүй. Гэжч одоо тийм өр төлөх цаг биш. Эзэн яалаа ч гэсэн ойлгохгүй. Ухаан орохоор нь таныг ирээд явсан гэж хэлмц. Тэгээд л өр ширгүй болно.

-Гэхдээ түүнтэй уулзаж болно биз дээ?

-Одоо бллохгүй гэж би танд хэлж байна.

-Гэвч би уулзах ёстой!

-Уулах ёстой гэнэ шүү! намайг харуулд гаргаад, хэнийг ч битгий оруул гэж хатуу тушаал өгсөн юм.

-Энэ надад хамаагүй. Би түүний найз нь юм чинь. Эрхэм Морисын найз байна.

-Үүнийг би яаж мэдэх вэ? Та өөрөө хичнээн сайхан ч гэсэн түүний хортон дайсан бөйхыг хэн мэдэх вэ?

-Үгүй, би заавал уулзах ёстой! Би үүнийг хүсч байна, уулзана чиг!

Исидора ингэж хэлээд мориноосоо буун харайж, овоохойныүүд рүү явлаа.

Тэр хүүхний уурлаж, шийдсэн байдлыг Фелим хараад Зеб Стумпийн зааврыг биелүүлэх цаг болсныг ойлгов.Фелим овоохойд бушуухан орж балт авч гарч ирээд нөгөө урилгагүй зочны хажуугаар гүйхээрээ гарах гэснээ эмэгтэй түүн рүү гар буу чиглүүлсэн байхыг хараад гэнэт зогтусав.

-Сүхээ хая! Заяагүй муу амьтан чи надруу далайх л юм бол үхнэ шүү! гэж Исидора хашгирав.

-Хатагтай минь би таны өөдөөс дайрах гэсэн гэж үү? Хэмээн Фелим айдас нь жаахан тайтгарч хэлээд - Гэгээн дар эх минь Энэ сүхийг таны эсрэг хэрэглэх гэснэ юм биш. Хамаг хутагтаар танд тангараглая!

-Чи үүнийг яах гэж авсан юм бэ? Таюунд ингэж зэвсэглэв? Гэж мексик хэзхэн алдаагаа мэдээд, буугаа доош болгож асуув.

-Тушаал биелүүлэх гэж авсан юм. Тэр харагдаж байгаа аршийн нударгаас огтолж ваах хэрэгтэй байна. Би түүнийг морины сүүл доогуур шургуулах ёстой юм. Та буруушаахгүй биз дээ?

Тэр хачин санааг яаж ойлгохоо Исидора мэдсэнгүй тул дуугарсангүй.

Ирланд эрийнбайж байгаа нв муу юм хийнэ гэж хардахад даанч утгагүй ажээ. Гадаад бүх байдал, хөдөлгөөн, дохиж зангах нь сүрдүүлэхээсээ илүү инээдэмтэй ажээ.

-Дуугүй байх бол зөвшөөрсний тэмдэг. Танд баярлалаа гэж араасаа сум зооглохоосоо айхаа больсон Фелим хэлэв.

Тэгээд нуга руу гүйж очоод өвгөн Зебийн захисныг цөмийг ёсчлон биелүүлжээ. Мексик бүсгүй эхлээд гайхсандаа таг дуугүй болсноо сүүлдээ яриад ч нэмэргүй гэж бодоод дуугарсангүй.

Фелим анчны тушаалыг дөнгөж биелүүлмэгц гүү ч байдгаараа янцгаан туурайгаараа цачвлан, нохой түүнтэй дуугаа авалцан бүх ой тэр чигээрээ ан амьтан, шувуу, хорхой шавьж хүртэл дуу гарган, жирийн нэг хүний яагаад ч гаргамгүй дуу шуугиан нүргэллээ.

Исидора чимээгүй гайхан зогсов. Өөр ч арга байсангүй. Тэр тамын шуугиан гарч байхад учры нь олох асух гэж оролдохын ч хэрэггүй байжээ.

Фелим овоохойны үүдэнд сэтгэл хангалуун байдалтай хүрч ирээд дүрдээ сайн тоглосон жүжигчин шиг байраа эзлэв.

LVIII. Хортой үнсэлт

Энэ зэрлэг концерт арваар минут үргэлжлэв. Гүү, дутуу бүлүүлсэн гахайн торой шиг чарлаж, нохой ч дагаж гаслантай улин хуцаж голын эргээр нэг цуурайтав.

Тэр дуу чимээ бээрийн тэртээ сонсодсоор байв. Зеб Стумп түүнээс хол яваагүй нь мэдээж тул тэр дуу чимээг лав сонссон байж таарна.

Зебийн одоохон ирэхэд эргэлзэх юмгүй болсон Фелим, харуулын үүрэг гүйцэтгэсэн хэвээр ч гэлээ танихгүй эмэгтэй овоохойд орно гэж зүтгэхгүй байх гэж найдан үүдэндээ зогссоор байлаа.

Хэдийгээр мексик бүсгүй батлан өгүүлсэн ч түүнийг муу санаад байгаа байх гэж сэжиглэсэн хэвээр байв. Түүнээс биш Зеб яагаад өөрийгөө дуудаарай гэж тэгтлээ шахаж шаардах билээ.

Фелим өөрөө бол эсэргүүцэл үзүүлэх бодлоо аль хэдий нь орхижээ. Нөгөө гялалзсан гар буу нүдэнд нь харагдсан хэвээр агаад эл хачин эмэгтэйтэй муудалцахыг өчүүхэн ч хүссэнгүй. Орьё гэвэл олон юм ярилгүй оруулчих байлаа.

Гэвч овоохойг бүхэл бүтэн суман цэргээс ч аймгүйгээр шийдэмгий хамгаалж байсан нь Тара байлаа. Нохой урилгагүй зочныг мөн л итгэхгүй байсан бөгөөд хүүхний хөдөлгөөн бүр нь нохойд дайсагнасан шинжтэй санагдана. Тара овоохойны хаалгыг хамгаалан хөндөлдөж Фелимийн яг өмнө зогсоод хурц соёогоо ярзайлгасан нь овоохойл зөвхөн хүүр дээгүүр нь алхан орохоос өөр аргагүй гэдгийг илхэн харуулна.

Гэвч Исидора хүссэнээ биелүүлнэ гэж дахин шаардаж шахсангүй. Энэхэн үед ганц мэдэрч байсан юм нь гайхах гэдэг л байлаа.

Бүсгүй зоомол юм шиг хүлээн зогсов. Тийм ширүүн эхэлсэн явдлын зохих төгсгөлийг хүлээх ёстой нь маргаангүй. айхтар шохоорхсондоо уг үзэгдлийн төгслөлийг тэсвэртэй хүлээв. Урьдын түгшүүр нь оргүй арилжээ. Харсан юм нь айна гэхэд дэндүү инээдтэй, инээднэ гэхээр дэндүү ойлгогдомгүй санагдана.

Нөгөө хачин аашилсан хүний царайд ямар ч тохуу хийсэн зүйлгүй, тун буурьтай харагдана. Тэр хачин эр тоглоогүй нь илт байлаа.

Урт буу гартаа барьсан гандмал джээлтэй том хүн модны завсраар гарч иртэл Исидора гайхаш тасран зогслоо. Тэр хүн гүйхээрээ шууд овоохойг чиглэв.

Бүсгүй танихгүй хүнийг хараад царайд нь сэтгэл түгшсэн нь илрэн, гар бугаа барьж авлаа.

Энэ нь нэг талаар болгоомжилсоных, нөгөө талаар санамсаргүй тэгсэн байжээ. Ер нь овоохой руу алхаж яваа аваргын догшин царайг хараад цэрвэхгүй хүн гэж хэн байх билээ.

Гэлээ ч нөгөө хүн ойн цоорхойд гарч ирэнгээ бүсгүйгээс дутахааргүй гайхсан нь илт байлаа.

Исидораг хараад шүднийхээ завсраар нэг юм дуугарав. Чухам юу гэсний нь одоо хүртэл үргэлжилсээр байгаа дуу шуугиан дундаас олж сонсохын аргагүй байжээ. Зөвхөн хөдөлж аяглах нь найрсаг биш харагдана. Стумп чарласаар байгаа морь руугаа бушуухан очиж хэн ч зүрхлэмээргүйгээр зүрх гарган галзуурсан гүүний сүүлий нь сөхөөд түүнийг ийм удаан зовоож буй тамлалаас нь ангижруулан өргөст мөчрийг авч хаяв.

Бусад амьтан гүүний байдгаараа чарлахад дасан чимээгүй болчихсон учир тэр дороо нам гүм болоод явчихав.

Исидора бас л юу ч ойлгохгүй хэвээр үлдсэн бөгөөд харин овоохойн үүдэнд зогссон инээдэмтэй амьтныг хараад тэр бүдүүн эр ямар нэг тушаал амжилттай биелүүлсний нь таалаа.

Стумпийг овоохой руу сүртэй нь аргагүй эргэхэд Фелимийн маадгар байдал алга болов. Үзэсгэлэнт сайхан хүүхэн дэргэд нь байгаа явдал ч гэсэн өвгөний хараал урсгахыг зогсоосонгүй.

-Ээ тэнэг чамайг, Ирландын мангуу хар! Чи яах гэж намайг нааш нь дуудсан юм бэ? Гучин фунтээс доошгүй том цацагт хяруулыг дөнгөж шагайгаад гох дарж амжаагүй байтал энэ муу гүү чарлаад үргээчихлээ. Одоо өглөөний цай хоолгүй боллоо.

-Үгүй Стумп гуай та өөрөө л надад тушаасан шүү дээ. хэрэв ямар нэг хүн ирвэл...

-Чи яасан маанаг мангуу юм бэ? Тэр чинь эмэгтэй хүнд ямар хамаатай юм бэ? Яасан тэнэг тархи вэ?

-Би үүнийг эмэгтэй хүн гэж яаж мэдэх вэ? Та энэ хүүхнийг морь унаж явахы нь харсан болоосой! Яг л эр хүн шүү.

-Морь унах нь ямар хамаа байсан юм! Мексик хүүхнүүд цөм тэгж явдгийг тэнэг толгой минь урьд нь хараагүй юу? Чи ч ёстой энэ хүүхнээс илүү чавганцтай адилхан амьтан юм. Ухаанаараа бол ч бүр хэдэн арав дахин дутуу. Яг үнэн шүү. Би энэ хүүхнийг хэдэн удаа харж, энүүний тухай бас сонссон юм. Харин юугаа хийж энд ирсний нь мэдэхгүй. Үүнээс өөрөөс нь мэднэ гэж байхгүй. Зөвхөн мексикээрээ л ярина биз. Ер нь би тэр хэлий нь мэддэг ч үгүй. Мэдэхийг ч хүсэхгүй.

-Стумп гуай та эндүүрч байна. Энэ хүүхэн англиар ярьдаг юм... Тийм биз дээ, авхай?

-Англиар тун жаахан мэднэ гэж одоо хүртэл дуугүй чагнаж байсан мексик хүүхэн хэллээ.

-Үгүй ер өө! гэж Зеб дуу алдаад - Намайгаа уучлаарай хатагтай минь. Та англиар жаахан донгосдог юм уу? Тэгэх тусмаа сайн. Тэгэхээр та ямар хэргээр энд ирснээ надад хэлж өгч чадах юм байна. Та төөрсөн юм биш биз дээ?

-Үгүй эрхэм минь.... гэж тэр хүүхэн хэлээд дуугаа хураачихав.

-Тэгэхээр та хаана байгаага мэдэж байх нь ээ?

-Тийм ээ эрхэм минь... Тийм... энэ чинь ноён Морисио Зералийн гэр мөн үү?

-Тиймээ, энэ мөн. Та нэрий нь хэлэх гэж зүдрэх хэрэггүй юм байна... Энэ овоохойг гэр гэж нэрлэхэд бэрх боловч энд л байдаг юм даа. Та овоохойн эзэнтэй уулзах гэж явна уу?

-Өө тиймээ, эрхэм минь! Би үүний тулд ирсэн юм.

-За яахав, надад татгалзах юм алга. Танд ямар нэг хорон санаа байхгүй биз дээ? Гэвч уулзаад ямар ашиг байна. тэр хүн таныг ер ялгаж танихгүй дэгээ.

-Өвчтэй байгаа юм уу? Түүнд муу юм тохиолдоо юу? Энэ дайчин эр энэ тухайнадад хэлсэн юм.

-Тийм ээ. Би тэгж хэлсэн гэж өөрийн нь дайчин эр гэсэнд онц олзуурхсан Фелим бардам ихэмсэг хэлэв.

-Үнэн. Тэр хүн шархадсан юм. Тэгээд яг одоохондоо жаахан дэмийрч байна. Сүрхий юм болоогүй гэж би бодож байна. Одоо удахгүй ухаан орон гэдэгт итгэж болно гэж Зеб хэлэв.

-Ээшэрхэм минь, түүнийг өвчтэй байхад сахиур нь болмоор байна! Бурхныг бодож намайг оруулаач. Би түүнийг асарна. Би түүний үнэнч нөхөр нь байгаа юм.

-За яахав. Үүнд муу юм алга. Өвчтөнийг асрах нь эмэгтэй хүний хийх ажил гэгцгээдэг. Би муу чавганцаа оршуулснаас хойш үүнийг биеэр үзэх бололцоогүй болсон юм. хэрэв тө өвчтөнийг сахихыг хүсч байгаа бол найзын хувьд хичнээн ч сахисан болно. Та биднийг эргэж иртэл түүнтэй хамт байж бай. Орноосоо уначих вий, боолтоо тайлаад хаячих бий харж байгаарай.

-Эрхэм минь та надад итгэ. Би түүнийг чадах ядахаараа харж хамгаална. Харин хэн түүнийг шархдуулсныг хэлж өгөн үү? Индианууд уу? Тэд ойр хавь байхгүй биз дээ? Ямар нэг хүнтэй суудалцсан юм бол уу?

-Авхай минь би энэ тухай танаас илүү мэдэхгүй байна. Тэр лав л чонотой тулалдсан байсан. Харин хөл нь гэмтсэн байсан нь чононоос лав болоогүй. Би түүнийг өчигдөр нар жаргахаас өмнөхөн шугуй дотроос олж ирсэн юм. Тэр бүсэлхийгээрээ татсан усан дотор зогсчихоод танай мексикчүүдийн бар гэж нэрлэдэг цоохор араатан тэр хүн рүү үсрэх гэж байглаа. Гэвч би Морсиыг тэр аюулаас аварсан юм. Түүнээс өмнө юу болсон нь надад нууц. Энэ хэр залуу хүү ухаангүй байгаа болохоор түүнээс юу ч мэдэж авахын арга алга. Ингээд бид хүлээхээсөөр арга алга даа.

-Харин та түүнд ноцтой юм алга гэж үнэхээр итгэж байна уу? Шарх нь аюулгүй юм уу?

-Аюулгүй ээ. Жаахан халуурч солиороод байна. Шархны нь хувьд шалбархай л гэсэн үг. Долоо хоногийн дараа л цоо эрүүл болно.

-Өө, би тэр хүнийг энхрийлэн сувилна!

-Та тунсайхан сэтгэлтэй хүүхэн юм. Гэвч... гэвч.... Зеб эргэлзэж эхлэв. Түүнд гэнэт бас өөр

нэг бодол төржээ. “Энэ бол Морсийг буудлын газар хэвтэж байхад юм явуулаад байсан хүүхэн мөн бололтой. Тэгэхээр энэ хүүхэн Морист дурласан нь эргэлзээгүй хэрэг. Эргэлтгүй дурлажээ. Нөгөөх нь ч бас ялгаагүй. Гэвч Морис нөгөө хүүхнийхээ тухай халуундаа солиорвол, энэ амьтны зүрхийг шимширүүлэх нь тэр. Шөнөжингөө л нөгөөхөө дуудаад хоносон хөөрхий амьтан, сайн сэтгэлтэй бололтой юм. Өрөвдмөөр ч юмаа даа. гэвч мустангер маань хоёуланттай нь суултай биш. Тэгээд америк бүсгүйд унаж үхээд байгаа хүн. Ядаж Морисыг нөгөөхөө солиорч дуудахгүй болтол нь овоохойд оруулахгүй байхаар үгэндээ оруулах хэрэгтэй юм байна” гэж бодов.

Тэгээд Зеб Стумп, тэр тэсч ядаж байгаа мексик хүүхэнд хандаж,

-Үгүй, авхай минв та гэртээ харивал дээр биш байгаа, Бие нь сайжрахаар ирээрэй. Тэр хүн одоо таныг ядахдаа таних ч үгүй. Тэгэхээр энд үлдэж, асарч сувилна гээд юугаа хийхэв. Тийм сүрхий өвдөж үхэх гээд байгаа биш гэж хэлэв.

-Танихгүй ч байсан хамаагүй. юутай ч гэсэн би түүнийг асрах ёстой. Тэр хүнд ямар нэг юм хэрэгтэй байж магадгүй шүү дээ. Би бүгдийг олж өгнө.

-Тийм юм бол үлд дээ гэж ямар нэгэн өөр бодол түүнийг зөөлрүүлэв бололтой Зеб хэлээд - Энэ бол таны хэрэг. Харин яриаг нь бүү анхаараарай. Хүн амины хэрэг энэ тэр гээд элдэв юм... ярих вий. Хүн солиорсон үедээ ихэвчлэн тэгдэг вч. Та бүү айгаарай. Нэг хүүхний тухай мэдэж ярина байх, түүнийг дандаа дурсан санаж байдаг юм.

-Хүүхний тухай гэнээ?

-Тийм ээ хүүхний тухай. Та түүний нэрийг сонсоно.

-Түүний нэрийг гэнээ? Эрхэм минь түүний нэрийгхэн гэдэг юм бэ?

-Бүсгүй дүүгий нь нэр байх ёстой. Тэр дүүгээ л дурсан санадаг гэдэгт би бүр итгээд байгаа юм.

-Стумп гуай та Морис гуайн тухай ярьж байгаа бол би... хэмээн Фелим хажуунаас нь дуугарав.

-Дуугай бай, мангуу минь! Хүний ярианд хөндлөнгөөс бүү оролц. Энэ бол чамд хүртээлгүй хэрэг. Хоёулаа явья гээд хөдлөнгөө ирланд эрийг чангааж "Би чамтай цуг жаахан явмаар байна. Би гол өгсөж яваад нэг хоржигнуурт алаад, тэнд орхисон юм. Хэрэв түүнийг ямар нэг амьтан аваад явчихаагүй бол чи гэртээ аваад ир. юмыг яаж мэдэхэв цацагт хяруул буудаж чадахгүй ч байж магад.

-Хоржигнуурт гэнээ? Та хоржигнуурт могойг хэлж байгаа юмуу?

-Яг тийм!

-Стумп гуай та түүнийг идэх гээгүй биз дээ? Хордож мэднэ шүү

-Чиний мэддэг чиньхэтэрч! Түүнд хор үлдээгүй. Би толгойгий нь хамаг хортой нь хамт огтлоод хаячихсан.

Пөөх! Би өлбөрч үхэж байсан ч тэр муухай юмнаас чинь амандаа хийхгүй.

-Тэгвэл яахав чи л үхнэ биз! Чамайг ид гэж хэн албадсан юм бэ? Би зөвхөн чамаар түүнийг авчруулах л гэсэн юм. За явж юу хэлснийг хий. Тэгэхгүй бол би чиний аманд могойн толгойг хортой шүдтэй нь хамт чихнэ шүү!

-Стумп гуай чинь чин үнэнээ хэлэхэд, би ер таны үгийг зөрчих гээгүй шүү дэ. Таны хэлсэн бүхнийг биелүүлнэ гэж амлая. Би тэр могойг бүтнээр нь залгихад ч бэлэн байна! гэгээн Патрик минь, нүгэлт намайгаа уучлансоёрх!

-Дэмий донгосохоо боль! За явья!

Фелим цааш маргахаа больж анч өвгөнийг дуулгавартай дагаж ой руу явлаа.

Исидора овоохойд орж өвчтэй хэвтэж байгаа хүний орны дээрээс тонгойлоо. Бүсгүй өвчтөний халуун магнай, омголтсон уруулыг нь шуналтай үнсэв. Тэгж байснаа хилэнцэт хорхойд хатгуулсан юм шиг гэнэт татвасхийв.

Хилэнцэт хорхойн хороос ч дор юм түүнийг огло үсрэхэд хүргэжээ. Энэ нь зөвхөн ганц үг, ганц богинохон үг байлаа.

Үүнд гайхах хэрэг юу байх билээ! “За” гэсэн богинохон үгнээс бүх л амьдралын аз жаргал шалтгаалах нь олонтаа бус уу. Мөн ийм богинохон “үгүй” гэдэг үг хичнээн уйтгар гуниг авчирдаг болохыг хэлэх юун.

LIX. Овоохойд уулзсан нь

Мигуэль Диасын хүлгийг тайлж тавьсан тэр өдөр луиза Пойндекстерт гунигтай өдөр байжээ. Тэр бол Луизагийн бүх л амьдралын хамгийн гунигтай өдөр байсан бизээ.

Эхлээд алга болсон дүүгийнхээ төлөө гашуудан гуних сэтгэл нь хайрладаг хүнийхээ төлөө түгшин догдолсон сэтгэлтэй хосолжээ. Гэтэл одоо уй гашуу дээр нь хардах сэтгэл нэмэгдэв.

Уйтгар гуниг, айн түгших, хардах гэдэг ганц зүрхэнд даанч ахадсан хэрэг биш үү?

Луиза Пойндекстер дурласан хүнийхээ урвасныг гэрчилсэн захиаг уншиж байхдаа ийм байдаотайбайлаа.

Үнэндээ захиаг мустангер бичээгүй, бас шууд баримт байгаагүй ч хагартлаа уурласан креол бүсгүй энэ тухай эхлээд бодсонгүй. Захианаас үзвэл Морис Жеральд, мексик хүүхэн хоёрын харьцаа мустангерын ярьснаас нэлээд янаг дотно байлаа. Тэгэхээр Луизаг Морис мэхэлжээ. Хэрэвгийм биш бол хүүхэн сэтгэлийнхээ тухай “сайхан сэтгэлд хоногших нүднийх нь тухай” юунд тийм илэн далангүй бичих билээ? Захидал жирийн нэг нөхөрсөг бус хайр тачъяалын амьсгалаар дүүрэн байлаа.

Тэгээд бас уулзах тухай дурдсан байв! Үнэндээ тэр хүүхэн Морсиыг ирж уулзана уу гэж гуйсан байлаа. Гэвч энэ бол зөвхөн өөртөө итгэсэн хүний маяг биз. захидлын төгсгөл нь гуйсан биш, харин “Хүрээд ир, би хүлээж байя” гэж захирсан өнгөөр дуугасан байлаа.

Луиза сүүлийн мөрийг уншаад захидлыг урагдтал нь базлав. Энэ хөдөлгөөнд зөвхөн хардаад зогсохгүй өшөө авах хүслэн мэдрэгдэж байв.

-За тийм байж, цөмий нь мэдлээ! Гэж унигтай дуугараад - Морис ийм хүсэлтийг анх удаа хүлээж авч байгаа юм биш. Энэ хоёр энд олон удаа уулзсан байх нь. “... Би авгын байшингийн арын толгой дээр байж байя” гэсэн тодорхой бус газар хангалттай байх нь. Тэгэхээр тэнд дандаа уулздаг байх нь гэв.

Гэвч удалгүй уур хорсол нь цөхрөлөөр солигдов. Түүний сэтгэл хөл дор нь үнгэгдэн хэвтэх цаасны өөдөс лугаа адил болжээ. Уйтгартай бодол хамаг овуны нь эзэмдэнэ. Бачимдан учраа олохообайж элдэв муу бодол орж ирнэ. Хартай нутаг Луизанаа санагалзан, тийшээ очиж хамаг гунигаа сүмд суун булшилмаар ч болж ирэв. Энэхүү цөхөрсөн гутралынх нь үед ойр хавьд нь сүм хийд байсан бол, ариун хананд нь толгой хавчуулахын тул эцгийнхээ гэрээс яваад өгчих байлаа. Луизагийн амьдралын хамгийн баргар өдөр энэ байлаа.

Креол хүүхэн удтал уймран догдолж байснаа бага зэрэг тайвширч, сийрэгхэн бодож эхэллээ. Захидлыг дахин уншиж, үг брий нь эргэцүүлэн бодов. Тэгээд түүнд Морис Жеральд сууринд байгаагүй байж болох юм гэдэг нэг горьдлого төржээ. Ингэж бодох нь үнэмшил багатай байв. Болзоо тавиад, сэтгэлтэй хүнээ тийм итгэлтэй хүлээж байсан эмэгтэй хүн үүнийгмэдээгүй байвал хачин хэрэг болох байлаа. Гэлээ ч тэр явна гэж байсан болохоор явчихсан ч байхад үгүй гэх газаргүй.

Өөрийн сэжгийг шалгаж үзнэ гэхэд бардам эзний охин Луиза Пойндекстерт тун хэцүү байсан боловч өөр зам байсангүй. харуй бүрий өтгөрч ирэх үеэр бидэрт мустангаа унасан Луиза суурингийн гудамжаар алхлуулж, хэдхэн цагийн өмнө Исидорагийн бор азарга зогсч байсан буудлын дэргэд ирлээ.

Энэ үдэш сууринд огт хшн амьтангүй байв. Суурингийнхны зарим нь гэмт хэрэгтний ул мөрийг мөшгин явж, зарим нь команч нартай дайтахаар явжээ. Луизагийн болгоомжгүй явлын ганц гэрч нь Обердофер байлаа.

Гэвч буудлын эзэн энэ явдлыг бол буруушаамаар хэрэг гэж үзсэнгүй. Алагдсан залуугийн эгч хэрэг явдлыг сайн дуулж авья гэж бодох нь зүй ёсны хэрэг хэмээн боджээ. Ийм ч учраас ирлээ хэмээн үзсэн байна. Мохоо герман эр ярианы эхэнд Луиза Пойндекстер хэлсэн зүйлийг нь ямар их сэтгэл ханамжтай сонсч буйг сэжиглэсэнгүй. тэгээд ярианыхаа сүүлдсанамсаргүй хавчуулсан үгс нь бүсгүйг ямар их эмзэглүүлснийг ч таасангүй.

Морисын тухай Луиза эхлэн лавлаж байгаа биш, түүнээс өмнө бахс нэг хүүхэн яг тэгж асууж байсныг сонсоод луиза цөхөрч Каса-Дель-Корво руугаа буцлаа.

Бүсгүй шөнөжин дуг хийлгүй амар заяа үзэлгүй тэлчилж хонов. Өчүүхэн зууг дуг хийвч хар дарсан зүүд зовоож байжээ.

Өглөө болоход ч сэтгэл нь тайвширсангүй, гэвч нэг юмыг зориглон хийхээр хатуугаар шийдсэн байлаа. Аламогийн эрэг рүү ганцаар яван гэдэг Луиза Дойндекстерийн хувьд зүй ёсны бүхий л хаягийг зөрчсөн хэрэг байлаа. Гэхдээ л үүнийг л тэр хийхээр шийджээ.

Түүнийг тийшээ явахыг хориглож, торгоох ч хүн байсангүй. Эрлийнхэн шөнөжин яваад эргэж ирээгүй байсан бөгөөд тэдний тухай шилтгээнд ямар чмэдээ ирээгүй байлаа. Залуу креол хүүхэн шилтгээний бүрэн эзэн, өөрийн хэрэг явдлыг толгой мэдэх болжээ. Цөхөрсөн алхам хийхэд нь чухам юу түүнийг түлхэв гэдгийг өөрөө л мэдэж байлаа.

Гэвч үүнийг таахад амархан.

Луиза бол ямар ч юманд итгэлгүй үлдэх хүнбиш байлаа. Хамгийн хүчтэнийг ч эрхэндээ оруулдаг дурлал хүтэртэл түүнийг номхруулж чадсангүй. тэр үнэнийг мэдэх ёстой! Түүнийг аз жаргал ч хүлээж байж магадгүй, эсвэл бүх итгэл найдварыг нь хөсөрдүүлэхээр юм ч байж болно. Тэглээ ч гэсэн эргэлзэн тарчлахаас нь илүү санагджээ.

Луиза өөрийн өрсөлдөгчтэй бараг адилхнаар боджээ.

Луизагийнсанасныг өөрчлөх гэж санахын гарз. Эцгийнх нь үг ч хүртэл түүнийг зогсоож чадахгүй байв.

Үүр гэгээрэхийг луиза эмээл дээрээ угтлаа, Каса-Дель-Корвоос гараад танил зөрөг замаараа тал нутгийг зорив. Танил дотно газраараа өнгөрөхдөө сайхан дурдатгалаасаа болон зүрх нь нэг бус удаа догдолно. Ийм үедээ өөрийг нь ингэж явахад хүргэсэн зовлонгоо таг мартан, сэтгэлтэй хүнтэйгээ уулзах тухай л бодон, түүнийг одоо ч гэсэн бүччихсэн байж мэдэх

дайснаас аврах юмсан гэж мөрөөдөж явав:

Хэдийгээр хайрт хүнийхээ төлөө сэтгэл түгшсэн ч энэ нь хуурч, урвасны нь бодон тарчилж байсан үетэй нь харьцуулахад жаргалтай мөч байлаа. Каса-Дель- Корвоос мустангерын зэлүүд овоохой хүртэл хорин бээрийн зайтай юм. ийм зам европ маягаар морь унаж заншсан хүнд бүхэл бүтэн аялал шиг санадаж болно. гэвч талын оршин суугчид ийм зайг хоёр цагт л туулна. Тэд үнэг юм уу буга хөөж яваа юм шиг л довтолгодог улс. Ийм аялал хөл удаантай морин дээр ч уйтгартай санагдахгүй. гэвч хурдан хөлт бидэрт луна, төрсөн тал дундуураа түргэн замаа туулжээ.

Луиза ядарсан ч одоо цөхрөхөө больж, түүний уйтгартай зүрхэнд найдварын оч гяласхийж эхлэв.

Гэвч овоохойн босго алхангуут тэр нь унтарчээ. Түүний амнаас инших дуу гарч, зүрх нь дэлбэрчих мэт санагдав.

Овоохойд эмэгтэй хүн байж байв!

Залуу креол хүүхэнд бүх юм зовлонтойгоор тодорхой болов. дурлалын захиа бичсэн хүүхэн өмнө нь зогсч байлаа.

Ямар ч байсан уулзацгаажээ. Нөгөө ойн цоорхойд болсон маргаанд гурав дахь хүн Морис Жеральд оролцсон байж болох биш үү? Түүний байгаа нь үүнийг гэрчилж байгаа биш үү? Луиза Морисыг орон джжр битүү боолттой хэвтэж байгааг харж амжжээ. Тиймээ, энэ хүүхэн зурвас бичиж, түүнийг болзоонд дуудсан, Харин одоо дэргэд нь ирчихсэн энхрийхнээр асарч байдаг. Тэгэхээр Морис энэ хүүхнийх гэсэн үг. Энэбодол нь үгээр илэрхийлэн гаргахын аргагүй зовлонтой байв!

Исидорын бодсон зүйл ч түүнээс дутахгүй тодорхой,багагүй шаналгаатай байжээ. Мексик хүүхэн Морисын сэтгэл зүрхэнд өөрийгөө багтаж шингэх газаргүй болжээ гэдгийг хэдийнээ мэдэж байв. Энэ гашуун үнэнийг илтгэсэн өвчтөний авцалдаагүй үгийг дэндүү удаан чагнажээ. Мустангерын зүрхнээс түүнийг шахан зайлуулсан хүүхэн овоохойн босгондээр зогсч байв.

Тэр хоёр хүүхэн улаан нүүрээрээ учирч, өөд өөдөөсөө хараад, нүдэнд нь гал бутран зогсов. Хоёул ав адилхан юм бодож сэтгэл нь шимшрэн, зүрх нь догдолно. Хоёулаа нэг хүнд дурлаж, хоёулаа хардах сэтгэлд тамлагдан зовсон энэ хоёр хажуудаа аль алины нь байгааг мэдэхгүй байгаа өнөөх хүнийхээ дэргэд зогсч байлаа.

Тэр хоёр аль алиныгаа аз заяатай өрсөлдөгч гэж бодож байв. Луиза одоо болтол Исидорагийн чихэнд хангинан сэтгэлий нь тамлаж байгаа, өөрийг нь бол тайвшруулах тэр үгсийг сонсоогүй байлаа. Бие биенээ үзэн ядаж буйгаа гадагш гаргаагүй нь улам ч аймшигтай. Тэр хоёр ганц ч үг сольсонгүй. Тэдний аль нь ч тайлбар шаардсангүй, алинд нь ч тайлбарын хэрэггүй байлаа. Илүү дутуу юм ярихын хэрэггүй үе байдаг. Энэ бол доромжлогдсон сэтгэл зүрхний мөргөлдөөн юм. Тэр харгалдаан нь үзэн ядсан, харц, жигшин ярвайсан уруулаар илэрч байв.

Тэд хоромхон зуур ингэж зогссон хэрэг. Тэгээд Луиаз Пойндекстер эргэж хаалга руу явлаа. Морис Жеральдын овоохойд түүндзай байсангүй.! Исидора ч бас өрсөлдөгчийнхөө хормойг гишгэх шахам гарлаа. Морис Жеральдын овоохойд надад эзлэх байр алга гэсэн ганцхан бодол түүнийг хөөжээ.

Тэр хоёрын аль аль нь зүрхий нь шархлуулсан овоохойгоос аль болохоор хурдан зайлах гэж яарч байх шиг санагдана. Бор морь ойрхон, мустанг хол байжээ. Исидора түрүүлж мордов. Тэгээд Луизагийн хажуугаарөнгөрөхөд Луиза ч аль хэдийн мордчихоод явах гэж байв.

Тэр хоёр дахин бие биеэ харлаа. Хэнийх нь ч харцанд ялан дийлэгчийн шинж байхгүй бөгөөд хэнд нь ч уучилж хүлцсэний шинж алга байлаа. Креол хүүхний харц уйтгар гуниг, уур хилэн, гайхшаар дүүрэн байв. Исидорын хараал хосолсон сүүлчийн хару арга ядсан хорслоор дүүрэн ажээ.

ЛХ. Урвагч

Хэрэв гадаад ертөнцийн үзэгдлийг хүний дотоод сэтгэлтэй харьцуулж болдог бол. Аламо дээгүүр тусах хурц наран мустангерын овоохойгоос гарч байгаа Исидоагийн сэтгэлийн гуниг хоёроос эрс ялгаатай зүйлийг олоход бэрх бизээ.

Цөхөрсөн тачьяадал цээжин дотор нь буцлан, хамгаас хүчтэй нь өшөө авах гэснэ хүслэн байлаа. Энэ нь түүнийгжаахан ч гэсэн тайвшруулж, цөхөрөхөөс нь аварчээ. Өөрөөр даанч тэсэхийн аргагүй зовлонтой байжээ.

Элдэв муу юм бодон модны сүүдэр бараадна. Ганга руу тулж очих үед цэлмэг тэнгэр дээр нь цэлийх нь өөрийг нь дооглоод ч байгаа юм шиг.

Исидора ташлуурын дор очоод зогслоо. Толгой дээр нь агарын аварга бараан мөчирнэвсийнэ. Түүний бараан сүүдэр нарны баясгалант туяаг бодвол Исидорын шаналсан зүрхэнд дөт байлаа. Гэвч үүнээс болж мориныхоо амыг татсан хэрэг биш байв. Түүний толгойд агрын сүүдрээс ч бараан бодол эргэлдэнэ. Үүнийг нь гялалзсан хар нүд, зангидсан хөмсөг, царайны нь хорсч өшсөн байдлаар мэдэж болохоор ажээ.

-Би тэр хүүхнийг яагаад дорнь нухчихсангүй вэ? гэж шивнэснээ буцаад очиход оройтохгүй ч байж магадгүй. гэвч түүнийг аллаа гэхэд юу өөрчлөгдөхөв билээ? Ингэлээ гээд Морисын зүрх сэтгэлийг эргүүлж авахгүй. тэр хүний зүрх сэтгэлийг алдлаа, үүрд алдлаа! Тэр үгсийг чин сэтгэлээсээ хэлж байсан. Зөвхөн тэр хүүхэн л сэтгэлээс нь гарахаа байж. Харин надад өчүүхэн төдий ч найдаврал алга! Үгүй тэр хүн үхэх ёстой! Тэр л намайг зол жаргалгүй болголоо... гэвч би түүнийг алчихвал юу болох ыбол? Амьдрал минь юу болж хувирах вэ? Тэсэшгүй зовлонд учрах болно! гэхдээ одоо ч гэсэн зовж тарчилж байгаа юм биш үү? Би цааш энэ зовлонг тэсвэрлэж чадахгүй нь! Өшөө авхаас өөр сэтгэл тайвшруулах юм алга. Зөвхөн тэр хүүхэн ч төдийгүй, Морис ч үхэх ёстой! Гэвч одоо биш, харин хэний гарт үхэж байгаагаа мэдэх болсон тэр цагт үхэх ёстой. Гэгээн минь өшөө авах хүч чадал хайрлаач! Гэв.

Исидора морио давирч огцом дашгай өөд хурдан өгсөв. Бүсгүй дээд талын цагаан газар гараад, мориоамраасанч үгүй, тал нутаг дундуур хаашаа ч яваагаа мэлэхгүй хар хурдаар давхилаа. Морио залж, шавдуулсан ч үгүй зөвхөн давируулаар давирч байв.

Зөнд нь орхисон морь ирсэн замаара хурдлав. Тэр нь Леон руу очдог зам байлаа. Бүсгүйд бүх юм хамаагүй бололтой, гүн бодолд дарагдан толгой гудайлгаж, ойр орчноо, тэр бүү хэл, мориныхоо давхиж байгаа ч анзаарсангүй. Мөн_ өөдөөс нь цуцварсаар ирж яваа морьтонгуудыг, морь нь тургиснаа зоомол юм шиг зогстол нь анзаарснагүй. Тэгэхэд л тал дундуур явууж буй морьтонгуудыг харужээ. Индианууд уу? Бишээ, зөвхөн арьсны өнгө, эмээл, эмээл дээрээ суусан байдлаар бус, сахал самбаагаар нь цагаан арьстнууд гэдэг нь танигдаж байв. Нүүр нь тоосонд дарагдан мэдэгдэхгүй болжээ.

-Техасынхан байна. Команчуудыг хайж яваа баг бололтой... гэвч энд индиан байхгүй. Хэрэв сууринд үнэн ярьсан бол эндээс холгүй байх ёстой гэж Исидора шивнэлээ.

Мексик хүүхэн тэдэнтэй уулзахыг хүссэнгүй. Өөр цагт бол тэдэнтэй уулзахас зайлсхийхгүй бөгөөд харин уйтгар гунигтай явахдаа тэдний шохоорхсон хару, асуулт шалгалтанд учрахыг бодсонгүй.

Тэднээс нуугдаж амжина. Бүсгүй бутан дунд явж байв. Морьтой хүмүүс түүнийг ажиглаагүй бололтой. Ширэнгэ рүү эргээд орчихвол харагдахгүй өнгөрч болно.

Исидораг тэгж амжаагүй байтал морь нь чанга янцгаав. Хориод морь ч хариу янцгаалаа.

Тэглээ ч гэсэн зайлж болно. Морьтой хүмүүс түүний хойноос заавал хөөнө. гэвч бүсгүйн сайн мэддэг энэ ойн зөрөг замаар хөөгөөд гүйцэнэ гэж үү?

Ингэж бодоод морио эргүүлснээ, рэр дор нь дахин амы нь татан зогсоогоод халз чиглэн ирж яваа морьтонгуудыг тайван хүлээв.

-Жирийн анчдад ахадсан сайхан хувцастай юм. Энэ бол миний нөгөө сонссон... аваар нь толгойлуулсан баг байх нь... Яг тэд байна. Өшөө авах боломж гарт ороод ирэх нь энэ! Бурхны таалал ийм байжээ.

Исидора шугуй руу эргэж орохын оронд задгай газар гарч морьтой хүмүүсийн өмнөөс шийдмэг явлаа. Тэгээд жолоогоо татан, ойртохыг нь хүлээв. Түүний санаанд хорт төлөвлөгөө боловсорчээ.

Минутын дараа гэхэд тал бүрээс нь хүрээлсэн эрлийнхний дунд зогсч байв.

Элдэв янзын зэвсэг агсаж, эрээн мянаараар хувцасласан зуугаад хүн байв. Тэднийг бие биетэй нь адилхан болгосон ганц юм нь гутал хувцсы нь дарсан шороо, ялимгүй үгэнд дурласан шинжтэй ширүүн царай байлаа.

Хэн ч байсан, тэр дундаа эмэгтэй хүн бол бүр ч аймаар ийм хүмүүсийн дунд орсондоо Исидора огтхон ч эмээсэнгүй. Түүнийг ийнхүү эрээ цээргүй тойрсон хүмүүсийг аюултай гэж бодсонгүй. Заримыг төрх байдлаар нь таньжээ. Тэднийг удирдаж яваа бололтой өөрт нь асуулт тавьж байгаа хижээлдүү хүнийг хэн болохы нь тааварлаж байгаа ч гэсэн нэг ч үзээгүй хүн байлаа. Энэ хүн бол алагдсан залуу болоод алагдсаныг нь үзэх, ядахдаа нэрий нь гутаах гэж Исидорагийн хүсээд байгаа өнхөөх хүүхний эцэг бололтой.

Ямар сайхан завшаан бэ!

-Авхай та францаар ярьдаг уу? гэж түүнээс энэ хэлийг ойлгож магадгүй гэж бодсон Вудли Пойндекстер асуулаа.

-Муу ярьдаг. Англиар яривал дээр.

-Англиар гэнээ? Тэгвэл бидэнд бүр ч сайн. Авхайта замдаа ямар нэг хүнтэй дайралдав уу? Ямар нэг морьтой хүн ч юм уу хуарагнасан улсыг ажиж харсан байж магадгүй гэж би хэлж байгаа юм шүү дээ.

Исидора тээнэгэлзсэндээ ч юмуу эсвэл юу хэлэхээ бодон хэсэг дуугүй зогслоо.

Пойдекстер маш эелдэг байдлаар үргэлжлүүлэн асуусан нь

-Таны хаана нутагладгийг асуувал зөвшөөрөхсөн бол уу?

-Эрхэм минь, манайх Рио-Грандад байдаг.

-Та шууд тэндээс ирэв үү?

-Үгүй, Леоноос ирлээ.

-Леоноос гэнээ!

-Энэ өвгөн Мартинес гуайн зээ охин шүү дээ. Мартинес гуайн тариалангийн газар таны эдлэн газартай залгаа бөйдаг юм гэж тэнд байсан хүмүүсийн нэг нь хэлэв.

-Тиймээ, би Сильвио Мартинесын зээ охин байна.

-Та шууд гэрээсээ явж байна уу? Авхай минь, хэрэв ингэж асуусан маань танд тээртэй санагдаж байвал уучлаарай. Бид хэрэгт дурлан ингэж асууж байгаа юм биш. Тун чухал хэрэг болоод тэгж байгаа юм шүү.

-Тимй ээ, би шууд Мартинесын ордноос явж байна. Би авгынхаасаа яг хоёр цагийн өмнө гарсан гэж Исидора Пойндекстерын хэлсэн үгийг сүүлчийн хэсгийг анзааргүй дүр үзүүлж хэлэв.

-Тэгвэл та хүн амины хэрэг гарсан тухай лав сонсоо биз дээ?

-Тийм ээ сонссон. Өчигдөр Сильвио авгын энэ тухай ярилцаж байна лээ.

-Таныг өнөөдөр гарахад чинь сууринд ямар нэг шинэ мэдээ дуулдаагүй биз? Бидний тэндээс авсан мэдээ хуучраад байна. та юм сонсоогүй биз?

-Би зөвхөн алуурчийг хайхаар улс явсан л гэж дуулсан... Тан на юм уу,

-Тийм ээ, билнийг л ярьж байж. Та өөр юм сонсоогүй биз?

-Өө, сонсолгүй яахав. Гэвч эрхмүүд минь дэндүү хачин, бүр та нар дуулаад намайг даажин хийэ байна гэхээр хачин юм сонссон.

-Тэр чинь юу вэ? гэж гоо бүсгүйг ихэд сонирхон ширтсэн хориод морьтон зэрэг асуув.

-Энүүхэн хавьцаа... Ямар нэг морь унасан толгойгүй хүнийг харлаа гэж ярьсан. Бурхан өршөөг! Бидний эндээс ойрхон байх ёстой. Нуэсесийн ойролцоо Рио-Гранд руу зам эргэдэг гармаас холгүй гэж зарц нар ярина билэ.

-Өө, зарц нар хасан юм уу?

-Тиймээ, тэдгурвуулаа л харсан гэж ам шүд алдаад байгаа юм.

Түүний яриаг цаадуул нь тайван сонсч байгаад исидора гайхав. Тэдний дундаас нэг нь ам нээж

-Бид ч гэсэн тэр морь унасан толгойгүй хүнийг харсан_ гэхдээ их холоос харлаа. Харин танай үарц нар ойроос харж, чухам юу болохыг нь ялагж чадааболов уу?

-Ариун дагина үгүй!

-Харин та мэдэхгүй биз?

-Юу гэсэн үг вэ, мэдэхгүй. Би зөвхөн сонссон гэдгээ хэлсэн шүү дээ. Чухам юугий нь хэн мэдэхэв.

Нэг хэсэг цөм бодлогоширон дуугаа хураав.

Дараа нь эзэн ам нээж

-Та энд ямар нэг хүнтэй дайралдаагүй биз?

-Дайралдсан шүү.

-Хэнтэйуулзаа вэ? Бидэнд байдал төрхий нь хэлж өгөөч.

-Нэг хүүхэнтэй дайралдсан.

-Хүүхэн гэнээ? Гэж хэд хэдэн хүн зэрэг дуугарав.

-Тиймээ эрхмүүдээ.

-Ямах хүн бэ?

-Америк хүүхэн.

-Америк хүүхэн ий? Энд үү? Ганцаараа явна уу?

-Тийм ээ.

-Хэн гэгч вэ?

-Би мэдэхгүй.

-Та түүнийг танихгүй юмуу? Ямаршуу янзтай хүүхэн бэ?

-Ямаршуу янзтай юм гэж үү?

-Тиймээ ямар хувцас хунартай юм бэ?

-Морь унахад өмсдөг хувцастай юм билээ.

-Морьтой яваа юмуу?

-Тийм.

-Та тэр хүүхэнтэй хаа дайралдав?

-Эндээс холгүй, шугуйн цаахна талд

-Тэр хүүхэн хаашаа явсан бэ? Тэнд ямар нэг оромж байна уу?

-Ганцхан какале байна.

Пойндекстер багийнхнаас испани хэл мэддэг нэг хүн рүү эргээд

-Хакале гэж юу гэсэн үг вэ? гэж асуухад нь

-Овоохойг тэгж нэрлэдэг юмгэв.

-Тэр хэний овоохой юм бэ?

-Эрхэм мустангер Морисынх.

Хүмүүсийн дунд баярласан чимээ гарлаа. Тэд хоёр хоног, үр дүнгүй, шургуу, цуцалтгүй эрэл хийсний эцэст алуурчийн мөр дээр буулаа.

Мориноосоо буусан хүмүүс дахин мордож, явахад бэлэн болцгоов.

-Бид эрхэм Мартинес авхай танаас олон юм шалгааж зовоохыг хүсэхгүй байна. гэвчтийшээ явдаг замыг та л зааж өгөх болж байна.

-Тэгэхээр миний зам тойруу болох нь дээ... За яах вэ, явцгаая. Хэрэв та нар тийшээ явахаар шийдсэн бол би газарчилна.

Исидора зуугад морьтонг дагуулан ойн зурвас дахин гаталлаа.

Газарч ойн чөлөөнд очоод зогсов. Тэр шугуй Аламо хоёрын хооронд задгай тал цэлийн харагдав.

-Тэртээд байгаа хар толбо шиг юмыг харж байна уу? гэж Исидора асуугаад - Тэр бол майлаасын орой харагдаж байгаа юм. Аламогийн хөндий гэсэн үг. Тиймшээ яв. Тэнд дашгайбий. Түүгээр ганга руу бууна. Буугаад жаахан цааш явгад чинь миний хэлсэн овоохой дайралдана гэв.

Цааш нь заагаад байх юм байсангүй. Тэд зам зааж өгсөн хүнээ бараг мартчихаад, майлаасыг

чиглэн тал дундуур давхилдав.

Тэдний дундаас нэг л хүн байрнаасаа хөдөлсөнгүй. Тэр нь багийг тэргүүлж явсан хүн биш боловч болж байгаа явдлыг түүнээс дутуугүй, ялангуяа эмэгтэй хүний тухай ярихад бүр ч илүү сониохож байсан хүн байв. Исидорын хэлийг төрөлх хэлнээсээ дутуугүй мэддэг ажээ.

-Авхай та тэр хүүхний морийг ажиглав уу? гэж тэр хүн мексик хүүхэнд хандаж бараг аргадсан дуугаар асуулаа.

-Ажиглалгүй яахав! хэн түүнийг ажиглахгүй өнгөрч болох билээ!

-Ямар зүстэй юм бэ?

-Бидэрт мустанг л байна билээ.

-Бидэрт мустанг гэнээ? Бурхан минь! гэж кассий Колхаун дуу алдаад эрлийнхний хойноос давхив.

Ганц Исидора ч биш, бас энэ хүн ч үхлээс айхгүй мөхөшгүй галаар дүрэлзэж байгаа нь тэр мексик хүүхэнд тодорхой байв.

LXI. Газарт буусан сахиулсан тэнгэр

Өрсөлдөгч хүүхэн нь санамсаргүйбайтал бушуухан зугадан зайлсан нь Луиза Пойндекстерт гайхаш төрүүлжээ. Луиза морио давирахад бэлэн байсан боловч хбөдөлсөнгүй, уул явдлыг бодоод тээнэгэлзэж зогсов.

Гэрийн эзэгтэй шиг сууж байсан тэр хүүхнийг луиза ганцхан минутын өмнө овоохой руу шагайхдаа харсан билээ.

Түүний гэнэт зугадсан учир юу вэ? Үзэн ядсан хилэнт харцы нь юугаар тайлбарлахвэ? Тэр хүүхэнд яагаад итгэл найдварын баяр баясгалан, ялан дийлснээ мэдэрсэн шинж байсангүй вэ?

Исидорын хару Луизаг гомдоосонгүй. харин ч нууцгайхан баярлаж байжээ. Тэгээд луиза Пойндекстер тал нутаг дундуур давхин одохын ородн мориноосоо дахин бууж, овоохойд буцаад орлоо.

Мустангерын өвчтэй цонхигор царай, догшноор эргэлдэж байгаа нүдийг хараад, креол хүүхэн гомдсон сэтгэлээ түр мартжээ. Бүсгүй ор өөд гүйхээрээ очоод

-Бурхан минь! Шархтай... Үхэж байна... Хэн ингэчихвээ? Гэж дуу алдав.

Хариуд нь авцалдаагүй ямар нэгэн юм бувтнана.

-Морис! Морис! Дуугараач дээ! Чи намайг танихшүй байна уу? Би Луиза байна! Чиний луиза байна! Чи намайг тэгж дууддаг шүү дээ! Чи энэ нэрийг санаж байна уу?

-Сахиулсан тэнгэрүүд минь та нар ямар үзэсгэлэнтэй юм бэ!... Та нарыг харахад үнэхээр үзэсгэлэн гоо юм. гэвч газарт та нартай тэнцэх хүхүн байхгүй гэж бүү бодоорой. Тэнд олон сайхан хүүхэн бий, гэвч та нараас ч үзэсгэлэнтэй нэг хүнийг би мэднэ! Би гоо үзэсгэлэнгийн л тухай ярьж байна. Буянт сэтгэл бол өөр хэрэг. Үгүй, үгүй энэ тухай бодохгүй байна!

-Морис хайрт Морис минь чи яагаад ингэж ярина вэ? Чи тэнгэрт гараагүй байна шүү дээ. Чи энд надтай, Луизатайгаа хамт байна.

-Би тэнгэрт... тиймээ тэнгэрт байна. хэрэв тэр минь энд байхгүй бол би ч бас энд байхыг хүсэхгүй. Аятайхан газар байж болох юм, гэхдээ тэр минь надтай байхгүйгээс хойш хэрэггүй. Хүүе сахиулсан тэнгэрүүд минь, яагаад намайг бүчээд байна вэ! Хэрэв тэр л энд байвал өөр юу ч надад хэрэггүй. Та нарын үзэсгэлэнтэйг би үгүйсгэхгүй. гэвч нэг нь ч миний хонгорыг гүйцэх үзэсгэлэнтэй гоо биш. Өө, би чөтгөрийг мэднэ. Би талын нутгийнхаа сахиулсан тэнгэрийг л мөрөөдөж сууна.

-Чи түүнийхээ нэрийг санаж байна уу?

Ухаан алдан дэмийрч байгаа хүнээс, хэн ч ийнхүү догдлон хариу хүлээж байгаагүй билээ. луиза түүн рүү тонгойн ширтэж амьсгаа хураан чагнана. Нэр? Нэрий нь гэнэ үү? Та нарын

хэн нэг нь нэр гэж асууваа даа? Өө, саналаа Михаил, Гавриил Азриал гээд цөм эр хүний нэр. Сахиулсан тэнгэрүүд, миний хонгор бол эмэгтэй хүн. Түүний нэрийг...

-Хэн гэдэг юм?

-Луиза... Луиза... Луиза... Би нуугаад яахав, газар дээр болж байгаа бүгдийг та нар мэддэг юм чинь. Та нар түүнийг минь, Луизаг минь мэддэг биз дээ? Та нар мэдэх ёстой. Түүнд над шиг бүх сэтгэлээсээ, үнэн зүрхнээсээ... дурлахгүй байхын аргагүй...

Хайр дурлалын үгс Луизад хэзээ ч ийм баяр бахдалыг төрүүлж байсангүй. Хуайсын сүүдэр дор анх түүнийг эрүүл саруул ухаантай байх үедээ хэлэхи й нь анх сносохдоо ч гэсэн Луизад одоо сонсч байгаа юм шиг ийм их хүчтэй сэтгэгдэл төрүүлээгүй байжээ. Ямар их аз жаргалтай юм бэ? Өвчтэй хүний халуун магнай, хатсан уруулыг энхрий зөөлнөөр үнсэж эхэллээ.

Ялан дийлсний баяраар царай нь гийсэн луиза гараараа зүрхээ дараад цохилтыг нь намдаах гэсэн мэт зогсоно. Бүсгүй хайр дурлалдаа бахархах жаргалтай мөч нь дэндүү хурдан өнгөрчих бий гэж айж байлаа.

Хөөрхий бүсгүйн болгоомжилсон нь зөв байжээ. Овоохойны хаалгаар хүний сүүдэр тусав. Тэгснээ хүн ч өөрөө ороод ирлээ.

Орж ирсэн хүний гаднах байдалд аймаар юм юу ч байсангүй. Царай зүс, хувцас хунар нь сүүлийн хэд хоногт болсон азгүй явдлаас эрс тэс инээд хүрэм харагдана. Эл мангар амьтан нэг гартаа бялт, нөгөөдөө сүүлгийг нь эвэрлэг товчлуурыг харваас хэр зэрэг том болох нь мэдэгдэхүйц аварга могой барьжээ.

Энэ инээдтэй байдал нь овоохойдорж ирэнгүүтээ шинэ зочныг хараад цөхрөн гайхсан гайхлыг нь улам ч нэмэв.

-Бурхан минь! Би зүүдэлж байх шиг байна! Үнэндээ тийм байна! Эрхэм Пойндекстер та энд байна гэж байж боломгүй юм. Ийм юм яаж байж болох вэ! гэв.

-Тийм л байна даа, эрхэм О Нил. Та намайг ийм хурдан мартчихдаг даан ч тусгүй байна даа!

-Таныг мартха гэж үү? Юу гэсэн үг вэ? намайг тэгж зэмлэж болохгүй шүү. Манай ирландхүн гэдэг тийм жудаггүй улс биш. Таны сайхан царайг нэг л харчихвал авсанд ортлоо мартахгүй. Холоос эрээд яахав? Жишээ нь энэ хүн ухаангүй мөртлөө ганцхан таныг л солиорч ярих юм.

Фелим ор руу учиртайхан харлаа. Луизагийн царай баярласнаасаа болж час улайв.

-Энэ чинь юу гэсэн хэрэг вэ? гэж нууцгай хувиралтыг санасан сайхь эр хэлээд - Өнөөх эр эм нь ялгагдахгүй хүн хаачваа? Пойндекстер авхай та тэр бүсгүйтэй дайралдаагүй юу? гэв.

-Дайралдсан.

-Тэгээд тэр хүүхэн хаачив?

-Яваад өгснө.

-Явчихсан гэнэ ээ! Тэр хүүхэн юу хүссэнээ өөрөө ч мэдэхгүй байх нь. Би түүнийг арваадхан минутын өмнө овоохойд орхиод явсан юм. Тэр хүүхэн бүрхээ, бүр эрэгтэй хүн өмсдөг малгайгаа авч, энд удаан баймаар байсан юмсан. Та түүнийг явсан нэв үү? Юун сайн юм бэ? Би түүний явсанд огт харамсахгүй байна. Тийм хүүхнүүдээс холхон байсан нь дээр. Пойндекстер авхай минь, та үнэмшихгүй дээ. тэр хүүхэн миний намалдагт гар буу тулгасан шүү!

-Бурхан минь! Яалаа гэж тэр вэ?

-Овоохойд оруулсангүй л гэж тэгж байхгүй юу. гэвч тэртээ тэргүй орчихсон. Зеб хрч ирээд түүнийг хориглоогүй юм. Эрхэм Жеральд бол миний найз, би түүнийг асарна гэсэн юм гэж хэлж байсан.

-Өө бүүр тэгээ юу. Мөн ч хачин туйлын хачин юм байна даа гэж креол хүүхэн бодлогошрон хэлэв.

-Та зөв хэлж байна. Энд хачин юм их болж байна. гэхдээ таны тухай хэлээгүй шүү. таны энд ирсэнд би их баяртай байна. Эзэн ч баярлана гэдэгт итгэж байна.

-Эрхэм Фелим юу болсныг ярьж өгөөч.

-За яах вэ, авхай минь, тэгвэл та малгайгаа аваад энд жаахан байзнах хэрэгтэй болно доо. Уржигдраас хойш болсон явдлыг цөмий нь ярихад д\лав шөнө болж таарна.

-Энэ хугацаанд ямар ямар хүн энд ирсэн юм бэ?

-Ямар хүн ирсэн бэ гэж үү?

-Нөгөөдөхөөс гадна...

-Нөгөө эр эм нь мэдэгдэхгүй бүсгүйгээс гадна уу?

-Тиймээ, өөр хэн үүгээр үзэгдээ юу?

-Өө энд эсэн бусын хэд хэдэн хүнирсэн хамгийн түрүүнд нэг хүн наашаа ирсэн боловч овоохойд ороогүй. Би түүний тухай танд ярьж зүрхлэхгүй байна. Авхай минь таныг айлгачихаж мэднэ.

-Ярь л даа. Би айхгүй.

-За тэгье, харин би өөрөө учры нь олохгүй байгаа юм. Тэр бол морь унасан мөртөө толгойгүй хүн байсан.

-Толгойгүй гэнээ?

-Морис гуайтай жигтэйхэн адилхан байсан нь хамгийн их гайхмаар. Түүний морийг уначихсан, бас тэгээд мексик нөмөргий нь нөмөрчихсөн байсны нь яана. айсандаа зүрх минь амаараа гарах шахсаныг яана! гэж ирланд эр үргэлжлүүлэв.

-Эрхэм О нил та түүнийг чухам хаана хараа вэ?

-Тэр ганган дээр харсан. Би эзнээ угтахаар гарсан юм. Эзэнтэр өглөө буцаж ирнэ гэж ярьж байсан юм. Анхадаа би түүнийг Морис гуай ирж явна гэж бодлоо. Гэтэл тэр...толгойгүй... дөхөж ирээд минут хяраатай зогссоноо дараа нь галзуу юм шиг давхин одоход Тара араас нь хуцсаар хоёулаа тал дундуур хөөцөлдөн харагдахаа больсон. Тэгээд би овоохойдоо буцаж ирээд үүдээ түгжиж аваа унтахаар хэвтэв. Тэгтэл хачин юм зүүдэлж, уучлаарай мисс, та суухгүй зогсоод л байх юм, ядарч байгаа байлгүй. Та наад гоё бүрхээ аваад авдар сандайлаач, сандал дээрээ сууснаас эвтэйхэн. Суу л даа. Би ярьж дуусаагүй байна.

-Миний төлөө битгий санаа зов. Цааш нь яриач. Тэр морь унасанхачин хүнээс өөр хэн энд ирэн бэ? Тэр ч лав ямар нэг хүн танаар даапаалсан байлгүй дээ.

-Даапаалсан гэж үү? Зеб бас надад тэгж хэлсэн.

-Зеб бас энд ирсэн байх нь ээ?

-Тийм, тэгэхдээ... нөгөөдүүлээс хойш ирсэн.

-Нөгөөдүүлээс гэнээ?

-Тийм ээ авхай. Зеб дөнгөж өчигдөр өглөө ирсэн. Харин нөгөөдүүл урьд шөнө нь манайд орж ирсэн юм. Бүр шөнө орой болсон хойно шүү. Тэгэхэд бми дуг нойрон дундуу байсан юм. Тэд ирээд намайг сэрээсэн.

-“Нөгөөдүүл” гэдэг хэн бэ?

-Индианууп л байхгүй юу даа!

-Индианууд ий?

-Тиймээ! Бүхэл нэг омог шүү! Авхай та бодоод үз л дээ. Би санаандгүй унтаж байтал нэг хүн яг толгой дээр яриад л, хөзөр хувааж байгаа юм шиг цаас шаржигнах сонсогдсон... гэж ярьж байснаа - Гэгээн Патрик минь, бас энэ чинь юу вэ? гэлээ.

-ЮУ?

-ТА Юу ч сонсохгүй байна гэж үү? За бас л ирлээ! Морьдын төвөргөөн сонсдож байна, овоохойд ойрхон байна... гээд Фелим хаалга руу ухасхийнээ

-Гэгээн Патрик, манайхыг морьтой улс бүсэлчихэж. Бүхэл бүтэн мянгат байна. Бас дээрээс нь нэмж ирж байна... нөгөө Зебийн хэлдэг улс бололтой... Түүнд дохио өгч дуудах хэрэгтэй. Ээ бурхан минь! Амжихгүй нь шиг байна гэснээ Фелим црьд нь бэлтгэсэн аршийн нударгын

мөчрийг шүүрч аваад овоохойноос гүйж гарлаа.

-Бурхан минь! Өнөөдүүл чинь байна! Аав яваа, би энд байдаг... юу гэж хэлдэг билээ? Гэгээн дар эх минь намайг шутамшгаас авраач! Гэж креол хүүхэн хэлэв.

Луиза зөнгөөрөө хаалга руу ухасхийж, түүнийг түгжлээ. Гэвч тэр одоо ингэх ашиггүй болохыг мэджээ. Гадаа байгаа тэр улс ийм сааданд торохгүй бизээ. Луиза хананд онгорхой байхыг харав. Зугтаах уу?

Гэтэл нэгэнт хожиджээ. Овоохойны ард морин туурайн чимээ сонсдов. Морьтой хүмүүс овоохойг тал бүрээс нь бүсэлжээ.

Тэртээ тэргүй түүний энд байгаа нь нууж далдлагдахаас өнгөрчээ. Бидэрт сумтанг нь овоохойны дэргэд уяатай байв. Түүнийг танихгүй байхын аргагүй.

Бас тэгээд тэр бүсгүйн зугадахад өөр ямар нэг юм саад болж байв. Хайртай хүний нь аюул нөмөрчихөөд байгаа бөгөөд түүний ухаангүй байгаа нь тус болохгүй. Бүсгүйгээс өөр хэн түүнийг хамгаалж чадах билээ?

"Яах вэ, би сайн нэрээ гутаая. Зөвхөн энэ хүнээс бусад, аав, ээж, найз нөхөд цөмий нь алдъя! Энэ бол миний хувь заяа би нэрээ гутаанч үгүй, энэ хүнд үнэнч хэвээр байна" гэж креол хүүхэн бодлоо.

Тэгээд Луиза тэр өвчтэй хүний төлөө амь насандаа аюул учруулсан ч хамаагүй гэж шийдээд орны нь дэргэдтайван зогслоо.

LXII. Сэтгэл зовоосон хүлээлт

Сутангерын овоохойны дэргэд хэзээ ч морин туурайн чимээ тэгж их нижигнэж байсангүй. дөнгөж баригдсан зэрлэг адуунууд хашаа дүүрэн байхад ч тиймгүй байжээ.

Хаалгаар гүйн гарч ирсэн Фелимийг хэдэн арван хүн хашгиран зогсоолоо.

Нэг хүн бусдаасаа чанга хашгиран, тушааж захирасан дуугаар

-Зогс муу барам! Зугадаад ашиггүй шүү! Нэг л алха юм бол чи байрандаа үүрд хөдлөхгүй үлдэх болно! Чамайг зогс гэж байна шүү! гэв.

Ойн цоорхойн нөгөө захад уяатай байгаа Зеб Стумпын гүү рүү ухасхийсэн ирланд эр зогсохоос өөр арга байсангүй.

-Эрхмүүд минь би огт зугадах гээгүй байна. надад тийм санаа огт төрөөгүй. Бизөвхөн... гэж Фелим тал талаас нь харж байгаа галзуу мэт нүд, түүнийг заналхийлэн тулгасан зэвсгийн дор зогсоод чичирхийлсэн дуугаар хэлэв.

- ... Амжвал зугатах гээ биз дээ? Муугүй санаа байна... Дик Треси нааш ир! Үүнийг хүл! Шелтон чи тусал! Чөтгөр аваачиг! Энэ чинь бидний эрж яваа хүн арай ч биш байх.

-Биш, биш! Энэ биш... Түүний зарц нь...

-Хөөе овоохойн ард байгаа улс сонс! Түүнээс нүд бүү салга. Бид нөгөөдхийг нь хараахан бариагүй байна. Хэнийг ч гаргаж болохгүй... За алив овоохой дотор хэн байна вэ?

-Овоохойд хэн байна гэж та асууж байгаа юм уу?

-Тэнэг минь чи асуусан юманд хариул! Овоохой ДОТОР хэн байна? гэж Треси ирланд хүнийг олсоор ороолгон асуув.

-Бурхан минь. Юун тоглохтой манатай. Тэнд юуны өмнө манай эзэн бий...

-Хаичн юм... Энэ чинь юу болж байна? Луизагийн ... морь байх шив дээ? гэж саяхан ойртож ирсэн Вудли Пойндекстер бидэрт мустангийг харж хэлэв.

-Тийм байна, мөн байна, ахаа гэж түүнтэй хамт хүрч ирсэн Кассий Колхаун хэлэв.

-Сонин юм. Морийг хэн энд авчраа вэ?

-Луиза өөрөө л ирээ биз.

-Дэмий юм ярих юм! Кассий чи тоглоом хийж байна уу?

-Үгүй ахаа, би чин үнэнээсээ хэлж байна.

-Чи миний охиныг энд ирж байсан гэж байгаа юмуу?

-Тэр одоо ч энд байна би үүнд эргэлзэхгүй.

-Байж болшгүй хэрэг!

-Тийшээ хар л даа!

Овоохойны хаалгыг хүчээр онгойлготой эмэгтэй хүн харагдав.

-Бурхан минь миний охин байна!

Пойндекстер мориноосоо буун харайж, овоохой руу яарна явлаа. Араас нь Колхаун явж, хоёулаа овоохдй оров.

-Луиза, энэ чинь юу болж байна вэ? Шархадсан хүн үү? Хэн бэ? Генри юу?

Эзэн хариу сонсохоосоо өмнө Генрийн малгай цув хоёрыг хараад

-Энэ чинь Генри шив дээ! Амьд байна! Бжрхан минь! гэв.

Пойндекстер ор руу ухасхийлээ. Түний баяр баясгалан агшин зуур алга болов. Хүү нь биү байлаа. Эзэн дуу алдан татвасхийв.

Колхаун түүнээс багагүй сэтгэл түгшсэн харагдана. Түүний амнаас айсан дуу гарч, хамаг биеэрээ агжийгаад овоохойноос сэм гарав.

-Ээ тэнгэр минь! Энэ юу гэгч вэ? Луиза чи надад учры нь хэлж өгч чадах уу? гэж эзэн шивнэн хэлэв.

-Үгүй, аав минь би чадахгүй. Би энд ирээд хэдхэн минут болж байна. Энэ хүн намайг ирэхэд л ийм байсан. Ухаангүй дэмийрч байгааг нь та харж байгаа биз дээ.

-А...а... Генри яасан?

-Би юу ч мэдэж авч чадсангүй. намайг орж ирэхэд мистер Жеральд ганцаараа байсан. Зарц нь байхгүй байгаад дөнгөж сая ирлээ. Би түүнээс юм асууж амжсангүй.

-Харин... харин... чи яаж энд ирэв,

-Би гэртээ байж чадсангүй. сураг ажиггүй байх нь надад хэцүү байна. Муу дүү минь... яачихаа бол гэж янз бүрийн юм бодон тарчилж, гав ганцаархнаа байх ямар байх вэ дээ, та бодоод үз л дээ.

Пойндекстер мэгдсэн бөгөөд асуусан шинжтэй харцар охиноо харна.

-Би Генрийг энд байж магадгүйгэж бодсон юм.

-Энд! Тэгээд чи энэ овоохойг хаанаас мэдсэн юм бэ? Хэнээр газарчлуулаа вэ? Чи энд ганцаараа ирээ биз дээ?

-Ааваа, би мэддэг байсан юм_ Өнөөх авд явж миний мустанг хадуурч давхиж байсан өдрийг та санаж байна уу? Мистер Жеральд буцаж явахдаа, өөрийнхөө байдаг газрыг надад зааж өгсөн юм. Би тэгээд олоод очно гэж шийдсэн юм.

Бодлогошрон учрыг олохгүй байсан Пойндекстер өөр нэг юм бодогдон хөмсгөө зангидав. Гэвч юунд санаа нь зовсноо хэлсэнгүй.

-Охин минь, чи болгоомжтой ажил хийж, Хуумгай юм болжээ. Бүүр аюултай юм. Тэнэг юм мэдэхгүй охин шиг загнасан байна. Чи одоо эндээс явах хэрэгтэй. Хурдан яв. Энд охид байх газар биш_ Моринпоо мордоод гэртээ харь. Чамайг хэн нэг нь хүргэж өгөг. Энд тун тааламжгүй хэрэг явдал гарна. Чамайг байлгаж болохгүй За яв.

Эцэг овоохойгоос гарахад охин нь түүний хойноос тун дургүй гарлаа. Мөн л дургүйд хүчгүй гэгчээр морь руугаа дөхөв.

Морьтой хүмүүс овоохойны өмнөх талбайдээр цуглараад яарч адгацгааж байв. Бүгд энд цуглажээ. Колхаун тэдэнд бөйдлыг ярив. Харуул гаргах ч шаардлага байсангүй. тэд хэсэг бусаг бөөгнөрөн зарим нь дуу шуугүй, зархим нь том дуугаар ярилцацгаана. Фелимийн дэргэд олон хүн цугларчээ. Целим газартай хүлэгтэй хэвтэнэ. Түүнээс юм асууж шалгаах боловч харваас түүнд итгэсэнгүй.

Эцэг охин хоёрыг гарч ирэхэд хүмүүс цөм тэдний зүг эргэж харлаа. Юу болсныг мэдэх гэж яарч, цөм дуугүй болцгоов.

Тэдний олонхи нь бүсгүйг таних байв. Хүмүүс нэрийг нь цөм мэдэхээс гадна олон хүн үзэсгэлэн гоогий нь тухай дуулсан байв. Бүгд л энд байхы нь хараад жигтэй их гайхацгаажээ. Алагдсан залуугийн эгч нь алуурчийн гэрт байж шүү!

Одоо хүмүүс гэмт хэргийн эзэн нь мустангер гэдэгт хэзээ хэзээнэс илүү итгэжээ. Овоохой дотроос олдсон малгай, цув хоёрын Тухай, амь өрсөөн тулаанд алуурч өөрөө шархадсан тухайКолхаун мэдээлжээ.

Харин Луиза Пойндекстер яагаад энд ганцаараа хүрч ирвээ? Яагаад түүнийг зарц юм уу гэр орныхны нэг нь дагаж явсангүй вэ?

Тэр нь энд зочин гэдэг нь илт байлаа.

Түүний үеэл ах энэ талаар юу ч хэлсэнгүй. хэлэх ч юм байхгүй байх ёстой. Харин эцэг нь? Түүний түгшсэн царайнаас юу ч тайлбарлаж чадахгүй нь илт ажээ.

Хүмүүс шивэр авир гэгцгээв. Хэн нь ч дуулдахаар ярьсангүй. Эл мугуйд хүмүүс эцгийн сэтгэлийг гомдоохоос айж, цөм тайлбары нь тэсвэрлэн хүлээж байв.

-Луиза мориндоо морд. Чамайг мистер Янси гэрт чинь хүргэж өгнө.

Энэ үгийг дуулсан залуу эзэн Янси өгүүлшгүй баярлав. Тэр бол Кассий Колхауны хуурмаг хувь заяанд атаархагчдын нэг байжээ.

-Би яагаад таныг энд хүлээж болдоггүй юм бэ? Та энд удахгүй биз дээ? гэж бүсгүй асуулаа. Янси сэтгэл нь зовж эхлэв.

-Луиза, би чамайг яваасай гэж хүсч байна. Тэгээд гүйцээ.

Луиза үгэнд нь орсон боловч моринпоо тун дургүй мордов. Дургүйцэж байгаагаа нууя ч гэж бодсонгүй. залуу эзэн баярласнаа, бүсгүй гунигаа арай ядан дарж байлаа. Залуу эзэн түрүүлж Луиза араас нь яаралгүй гэлдрэв.

Янси бүсгүйн уйтгартай байгаад гомдохоосоо илүү харамсаж байв. Тийм их гунигтай юм болсон юм чинь!

Гэвч гуньсны нь шалтгааныг мэдэж байна хэмээн андуурчээ. хэрэв нүд рүү нь сайн эгцэлж харсан бол өнгөрсөндөө уй гашуу болох бус ирээдүйгээсээ айсны нь харж болох байлаа.

Тэднийг модон дундуур орж явахад ойн цоорхойноос хүмүүсийн дуу сонсогдоор байлаа. Гэнэт креол хүүхний царай хувьсхийж, ямар нэг бодол эсвэл найдвар ч юм уу төрсөн мэт гэрэлтэв.

Луиза зогслоо. Хамт яваа хүн нь ч бас зогсохоос аргашгүй болжээ. Бүсгүй

хэсэг зуур чимээгүй байснаа

-Эрхэм Янси, олом маань суларчихаад тун эвгүй байна. та чангалаад өгөөч гэв.

Янси бууж олмы нь үзэхэд түүнээс илүү чангалмааргүй санагджээ. Гэвч бодсоноо хэлсэнгүй, олмыг нь султгаад тэнхээгээрээ чангаллаа.

-Жаахан байзнаарай. Би бууя. Тэгвэл танд эвгэйхэн болно гэж хүүхэн хэлээд, дэмжлэг хүлээлгүйгээр газарт бууж, мустангийнхаа дэргэд зогсов.

- Пойндекстер авхай одоо болсон шиг байна.

-За тэгвэл яамай гэж хэлээд хүүхэн бүүрэгнээс барьснаа - Үнэндээ эндээс ийм түргэн явах харамсалтай л байна. хар хурдаараа давхиж ирсэн болохоор хөөрхий Луна минь амарч амжаагүй. энд жаахан бйазная. Тэр хооронд Луна минь амраг. Амраалгүй буцаж давхина гэдэг хэтэрхий хэрцгий хэрэг болно шүү дээ! гэв.

-Аав тань... таныг...

-Намайг бушуухан харь гэсэн гэж та хэлэх гэж байна уу? За тэр ч яах вэ. намайг тэр догшин ширүүн хүмүүсийн дунд байлгахыг хүсэхгүй байгаа хүн. Ердөө л нэгэнт тэндээс холдсоноос хойш одоо санаа нь зовохгүй... Энд модны сэрүүн сүүдэрт байх яасан сайхан юм бэ! Тал нутагт аагим халуун нар шарж байгаа. Жаахан энд байж морио амрая. Эрхэм Янси, усан

дотор загас яасан сайхан юм бэ! Хараач! Тэр мөнгөлөг хайрстай загасыг харж байна уу?

Залуу эзний сэтгэл ханав. Яагаад бүсгүй өөртэй ньхамт байх гээд байна вэ? Түүний нь хаачих шиг өөрт нь санагджээ. Тэгээд удаан гуйлгуулсангүй.

-Пойндекстер авхай минь, тушаалаа хайрла. Таны хүссэний хэрээр л энд байя гэв.

-Зөвхөн лунаг амартал л байя. Танай эрлийнхнийг хүрч очиход би мориноосоо дөнгөж буугаад байсан юм. Лунаг хараач. хөөрхий амьтан хол газар давхисаандаа ядарч гүйцжээ. Амьсгаадаж байгааг нь.

Луизагийн морь ямар байгааг Янси огтхон ч сонирхсонгүй, харин хамт яваа бүсгүйнхээ хүссэн өчүүхэн зүйлийг боловч биелүүлсэндээ баяртай байв.

Тэд голын эрэг дээр зогсоцгоожээ.

Луиза загасыг ч, бидэрт мустангийг ч хайхрахгүй байгааг ажиглаад залуу хэрэв өөрт нь ялимгүй анхаарал тавьсан бол энэ бүгд ньзөвхөн баярлуулах байлаа. Гэтэл Луиза түүн рүү харах ч үгүй. Хэл үгий нь сонссон ч үгүй. харц нь тэртээ холыг ширтэж овоохойн өмнөх чөлөөний тэндээс гарч байгаа чимээ анирыг чагнаж байв.

Янси өөрийн эрхгүй тэр дуу чимээг чагнав. Овоохойн дэргэд Линчын шүүх эхлэх гэж буйг Янси мэдэж байв.

Модны цаанаас уур уцаартай дуу сонсогдоно. Нэгэнт хайр найргүйгээр шийдсэн өнгө илэрхий. Хоёул чих тавин залуу креол бүсгүй, хөшигний ард тайзан дээр гарахаа хүлээн зогсч буй эмгэнэлт жүжгийн жүжигчин мэт байлаа.

Хэд хэдэн эрэгтэй хүнийг дууг ялган таньж болохор байв. Түүний нэг нь бусдаасаа илүү чанга хашгирна.

Луиза тэр дууг таньжээ. Энэ бол түүний үеэл ах Кассий ярьж байгаа ажээ. Тэр цугларсан оронд ямар нэг юм шахан тулгаж, тэдний хүсэхгүй байгаа нэг юмыг хийлгэхээр болгон итгүүлж байв. Тэгээд түүний яриа төгслөө. Тэрзуур сайшаан зөвшөөрсөн дуу шуугиан гарлаа, нэг хорсон хилэгнэсэн дуу бусдаас чанга сонсодно.

Янси тэр дуу чимээг сонсч байгаад хажуудаа байгаа үзэсгэлэнт сайхан хүүхнийг мартчихжээ. Бүсгүйг байрнаасаа хөдөлж, овоохой руу ухасхийн гүйхэд л сэхээ авчээ.

LXIII. Линчийн шүүх

Залуу креол хүүхнийг байрнаасаа тийнхүү хурдан ухасхийхэд хүргэсэн тэр чанга дуу нь нэгёсондоо цугласан олны шийдвэр, ялын тогтоол байжээ.

Бүсгүйг мустангерын овоохой руу харайхад “дүүжлэх” гэсэн үг чихэнд нь хангинасаар байлаа.

Мөнгөлөг загасыг сонирхож буй дүр албаар үзүүлэхдээ, яг энэ үед овоохойн өмнө юу ыболж байгааг л бодож байжээ. Хэдийгээр ойн чөлөөг мод таглачихсан байсан боловч, тэнд чухам хэн байгааг таамаглан, тэндээс гарах дуугаар чухам юу болж байгааг мэдэж байлаа. Бүсгүйг эмээлээсээ буух тэр мөчид овоохойн өмнө болж байсан зүйлийг товч дурдъя.

Хүмүүс одоо хэсэг хэсгээрээ биш, харин нэг дор дугуйран зогсчээ. Тэдний төв дунд, “журам сахиулагчдын” даргын сүртэй дүр, хажууд нь гураь дөрвөн туслах нь харагдана. Тэнд бас Вудли Пойндекстер, Кассий Колхаун хоёр зэрэгцэн зогсчээ. Харваас, сүүлийн хоёр нь болж байгаа хэрэг явдлын зөвхөн гэрчийн төдий үүрэг гүйцэтгэж байгаа бололтой бөгөөд шийдвэрлэх эрх нь бусад хүмүүс байжээ. Энэ бол хүн алсан хэргийг таслан шийтгэх, Линчийн шүүх гэгч ажээ. “Журам сахиулагчдын” тэргүүн Сэм мэнли яллагч шүүгч болж, хэрэгтэн хоёроос бусад бүх хүн шүүх цуглаанд иргэний төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байв.

Яллагдагч Морис Жеральд, түүний зарц Фелим хоёр байв. Тэр хоёр тойрон зогссон хүмүүсийн дунд гар хөл нь сураар хүлээстэй хэвтэж байлаа. Тэднийг үг ч дуугарах бололцоогүй болгожээ. Фелимийг занан сүрдүүлээд дуугаргахгүй байсан ба эзнийх нь аманд модон бөглөө чихчихсэн байлаа. Ухааншүй дэмийрэн бусдын ярихад саад хийнэ гэж ингэжээ. Чивчиртэл хүлсэн ч хөдөлсөөр байсан учир хоёр хүн Морисын дал мөрнөөс барьж, нэг хүн хөлөн дээр нь суужээ.

Баригдсан хоёр хүний нэгийг хүн алсан хэрэгт яллаж байгаа бөгөөд нөгөөг нь зөвхөн, гэхдээ бас эргэлзээтэйгээр, тэр хэрэгт оролцогч гэж үзжээ.

Зөвхөн зарцы нь байцаав. Түүнд мэдэж байгаа бүхнээ хэлэх болон өөрийгөө хамгаалах юм байвал хэл гэжээ. Эзэнд нь асуулт тавиад ямар ч ашиггүй нь мэдээж. Фелимийн ярианд хүн итгэнэ гэхэд дэндүү үнэмшимгүй бөгөөд хамгийн хүн үнэмшмээргүй зүйл бол морь унасан толгойгүй хүний тухай дурдсан нь харин хамгийн баша эргэлзээ төрүүлэв.

Фелим эл битүүлэг үзэгдлийг тайлбарлаж чадаагүй бөгөөд энэ нь сайхь сүүдэгнэл, хүн алсан хэрэгтэй ямар ч байсан холбоотой юм гэдгийг л баталжээ. Индиануудыг “байцаан шүүх ажлыг будлиантуулах зорилгоор зохиосон нарийн арга заль” гэж үзэцгээжээ.

Шүүх хуралдаан арван минутаас илүү үргэлжлээгүй цугласан хүмүүс хэдийнээ тодорхой санал гаргажээ.

Генри Пойндекстер алагдсан бөгөөд түүний амь үрэгдсэнийг Морис Жеральд хариуцна гэсэн саналд олон хүн бүрмөсөн итгэжээ.

Урьд өмөн илэрсэн бүх зүйлийг дахин хянан хэлэлцэж цэгнэн үзсэн бөгөөд түүн дээр дөнгөж сая овоохой дотроос илэрсэн амь үрэгдсэн хүний малгай цув хоёр шинэ баримт болон нэмэгджээ. Будилж самуурсан Фелимийн ярианд итгэх хүн байсангүй. Өөрөөр яаж ч байх билээ? хамсаатан нь санаанаасаа зохиосон зүйл гэж үзэж байв. зарим нь бүр сонсох ч хүсэл байхгүй “Алуурчийг дүүжил!” гэж тэсч ядан орилолдоно.

Ялын төлөвлөгөөг урьдаас шийдсэн байжтаарлаа. Хэдийгээр энэ нь бугуйл төдийхөн байсан боловч ийм хэрэгт газар хэвтэж байгаа өрөөсөн үзүүртээ гогцоотой аргамж тохирох зүйл байв. хажууханд нь байгаа удамборын ёрдойсон мөчир аятайхан дүүжлүүр болно.

Ихэнх нь дүүжлэх санаатай байв. Зарим нь энэ санаагаа хэлэхдээ хажуугаар нь хараал зүхэл тавина. Яагаад ялын тогтоолыг биелүүлэхгүй байна вэ? Яагаад, Яагаад гэвэл бүх хүн санал нэгдээгүйд хэргийн учир байлаа. Тэнд байгсад цөмөөрөө тогтоолыг зөвшөөрч байсангүй.

Цугларсдын дотор Морисыг цаазлахыг зөвшөөрөөгүй улс байв. Тэд хэдий цөөнх нь боловч “үгүй” гэсэн үгийг шийдвэр төгс хэлцгээж байв.

Тэр цөөнхийн дотор Сэм Менли шүүгч өөрөө оржээ. Түүний дууг дуулдахтай болохын үед цугласанолны зүг хандаж чанга дуугаар

-Иргэд ээ! Шийдвэр гаргах хангалттай баримт нотолгоо бидэнд алга. Хэрэгтэн хүнийг мэдээж ухаан орохоор үг өчгий нь сонсох хэрэгтэй. Одоо энэ хүнээс юм асуугаад ашиггүй гэдгийг та нар харж байна. Энэ учраас шүүхийн шийдвэрийг хойшлуулах санал байна. Тэгээд... гэтэл,

-Ямар санаатай хойшлуулах гэж байгаа юмбэ? гэж Кассий Колхаун чанга дуугаар үгий нь тасалж - Сэм Менли, танд дэмий юм ярих нь хамаагүй байж! Хэрэв тэр гэм зэмгүй алагдсан хүн таны найз юмуу, ах дүү чинь байсан бол арай өөрөөр тунгаан бодох байсан биз. Энэ муу шаарын хийсэн хэргийг нотолоход танд өөр юу хэрэгтэй юм бэ? Нэмэлт баримт нотолгоо хэрэгтэй юм уу? гэв.

-Чухам тийм, ахмад Колхаун гуай.

-Кассий Колхаун, та ямар нэг юм нэмж хэлж чадах уу? гэж хүмүүс дундаас илт ирланд аялгуутай нэгэн хүн асуулаа.

-Байж болох л юм.

-Тэгвэл бидэнтэй түүнээ хуваалцаач.

-Хэр хэмжээнээс хэтэрсэн баримт нотолгоо байгааг бурхан харж байна. Тэр бүү хэл түүнийг өмгөөлж байгаа муусайн нутаг нэгт нүүдэд нь хүртэл... гэхэд нь

-Наад хэлснээ буцаан аваарай! Гэж хэн нэгэн хүн орилоод - Эрхэм Колхаун, та Мисисипид биш Техаст байгаагаа болгоогоорой! Үүнийг санаж яв, эс тэгвэл урт хошуу хүзүү орооно шүү! гэлээ.

-Би хэн нэгнийг гомдоов гэж огтхон ч бодоогүй гэж ирландад дургүй байдгаасаа болж эвгүй байдалд орсноосоо гарахыг хичээсэн Колхаун хэлээд - Эрхмүүдээ! хэмээн үг хэлэх гэжбайгаа мэт цугларсан олны зүг хандан - Одоо энэ хэлэх гэж байгаа зүйлээ би та нарт аль эрт хэлж болох байсан юм. Би ингэхийн хэрэггүй гэж бодож байлаа. Энэ хүн бид хоёрын хооронд юу болж өнгөрснийг та бүхэн цөм сайн мэднэ. Гэхдээ намайг хонзорхог хүн вм гэж битгий бодоорой. Би тийм хүнбиш. хэрэв толгой минь мөрөн дээрээ байна гэдэгт итгэж байгаа шигээ түүнийг хүн алсан гэдэгт итгээгүйсэн бол...

Өөрийн эрхгүй гарч ирсэн өгүүлбэр нь орчны хүмүүсийн дотор хачин сэтгэгдэл төрүүлснийг Колхаун хараад түгдрэв. Өөрөө ч гэсэн эвгүй бхйдалд оржээ. Гэвч үргэлжлүүлэн.

-Хэрэв би үүнд итгээгүйсэн бол харснаа чухам даа гэвэлшөнө байсан болохоор дуулснаа энд хэлэхгүй байхсан билээ гэв.

-Эрхэм Колхаун та юу сонссон юм бэ? гэж шүүгчийн үүрэгтээ эгэн орсон Сэм Мэнли асуугаад - хэрэгтэн хүнтэй таны муудалцсаныг энд байгаа хүн бүхэн мэднэ гэж би санаж байна. Тэр явдал таны өчигт ямар ч холбогдолгүй бөгөөд үүнээс болон хуурамч мэдүүлэг өгөх гэлээ гэж хэн ч таныг зэмлэх гээгүй байна. Та хэзээ, хаана, юу сонссоноо цааш нь ярь л даа гэв.

-Хэрэг явдал болсон цагийн хэлье. Энэ бол үеэл дүүгийн минь алга болдог лхагва гаригийн шөнө болсон хэрэг.

-Лхагва гаригийн шөнө гэнээ? Заа цааш нь ярь.

-Би тасалгаандаа хэдийнээ очоод байлаа. Генрийг ч бас тасалгаандаа орсон гэж бодож байв. Тэсч байхын аргагүй бүгчим, шумуул барьчих гээд унтах аргагүй байлаа. Би босч ороомол навчин тамхи асаагаад тасалгаандаа жаахан татсанаа байшингийн дээвэр дээр гарахаар шийдлээ. Хуучин шилтгээнд хавтгай дээвэр байдгийг та бүхэн мэднэ биз дээ? Тэгээд сэрүүн агаар амьсгалахаар тийшээ гарсан юм. шөнө дунд буюу арай ч түнүнээс эрт ч билүү орондоо удаан хөрвөөсөн болохоор би цаг анзаараагүй болоод санахгүй байна. Би нэг тамхи тагчихаад бас нэгийг гаргаж авах гэж байтал голын тэндээс чимээ гарах сонсогдов. Суурин руу ордог үамын тэндээс л гарах шиг болдов. Хоёр хүний дуу байлаа. Хэрэв тэд тайван ярилцаж байсан бол хоёр хүнийх гэж ялагж чадахгүй байсан юм. гэвч тэд уурлаж уцаарлан, чанга чанга ярилцаж байв. Хэрүүл болж байгаа нь илт байлаа. Би Обердоферын байрнаас буцаж яваа согтуу улс гэж бодоод анзаарсангүй. гэвч лавшруулж чагнаад хоулангийн нь дууг таньж, нэг нь миний үеэл дүү Генри, нөгөө нь энэ алуурчийнх болохыг мэдэв.

-Эрхэм Колхаун цааш яриарай. Бид таны өчгийг урьдаар сонсохыг хүсч байна. харин та дүгнэлтээ сүүлд нь хий.

-Эрхмүүдээ, би үеэл дүүгээ аль хэдийн унтаад өгсөн гэж бодсон вм. Гэтэд дуугий нь сонсоод зэгсэн гайхлаа. Би түүнийг мөнгөж сайн мэдсэн учир тасалгаанд нь ч орж үзээгүй билээ. хэрэлдэж буй хоёрын нөгөөх нь мустангер мөн гэдэг нь надад бүр тодорхой байв. Генри тийм орой болсон хойно гарч явсан нь надад тун хачин санагдсан юм. гэвч баримт бол баримт учир ямар ч ташаарсан юм байсангүй. Тэр хоёр юуны тухай маргалдаж байгааг мэдэх санаатай

чагнасан боловч дуу нь бүдэг бадаг дуулдаж байсан учир чухам юуны тухай ярьж буйг ойлгосонгүй. Зөвхөн мустангерт Генрийн хэлж байсан үгийн өнгийг гадарласан юм. Янз нь мустангер түүнийг эхэлж доромжилсон бололтой байв. дараа нь мустангерын занасан үг тод сонсогдсон. Тэд нэг нэгнийхээ нэрээрчанга дуудахад би бүр эргэлзэхээ больсон. Тийшээ бууж очин учры нь олох хэрэгтэй байсан боловч гэрийн шаахайтай болоод чадаагүй юм. гутлаа өмсч байх хооронд хэдийнээ чимээ гарахаа больсон байв. Генрийг удалгүй гэртээ буцаад ирнэ гэж бодоод хагас цаг шахам хүлээсэн боловч ирсэнгүй. Тэгэхэд ын бу буудал руу очин цайзын танилуудтайгаа дайралдан тэндээ бааранд суучихсан гэж бодоод унтахаар шийдлээ... За эрхмүүд минь мэдсэн бүхнээ та нарт ярьж өглөө. Хөөрхий Генри минь тэрнээс хойш касадель -Корвод буцаж ирээгүй билээ. хэзээ ч тэр орон дээрээ хэвтэхгүй болжээ. Тэр шөнө Генри тал нутгийн аль нэгтэй нь ч юмуу ойд ч юмуу зөвхөн энэ хүний мэдэж байгаа тэр газар хоножээ гэп Колхацн гараараа хэрэгтний зүг заав.

Харин цаадах нь эл аймшигт ялыг огт тоохгүй, тойрсон олны хилэнт харцыг мэдрэх ч үгүй, ншд амаа гялалзуулан ухаангүй хэвтэнэ.

Колхауны барин тавин хэлсэн үг хүмүүсийн ой тойд ягштал орж үгийг үнэн шударгад хэн ч эргэлзсэнгүй. Зэвүүцлийн дуу дахин нүргэлээ.

-Дүүжил!... Дүүжил! Гэж тал бүрээс хашгиралдана. Сэм Менли хүртэл тээнэгэлзэж эхлэх шиг боллоо. Татгалзах хүн улам цөөрчээ. хэдийнээ зуун хүнээс ная нь биш, ерөн хүн дүүжлэхийг шаардана. Хорсч хилэгнэсэн дуу цуурайтна.

Хүмүүс нааш цааш хөдлөн, түгшүүртэй байдал нэмэгдэн нэмэгдсээр.

Нэгэн өөдгүй амьтан сур луу ухасхийв. Тэр Колхаунтай шивнэлдэж аргамж руу дөхөхийг нь хэн ч анзаарсангүй. Бугуйлыг шүүрэн авч бөхийснөө ухаангүй хэвээр байгаа яллагдагчийн хүзүүнд углав.

Хэн ч хориглосонгүй. Сайхь эрийн бүсэнд чинжаал, гар буу гялалзан дураараа загнаж байв. дөнгөж саяхан мустангерын санаж байсан амьтад дундаас өөртэй нь адилхан өөдгүй амьтад туслахаар ухасхийлээ.

Бусад нь болж байгаа явдлыг тайвнаар харан, ихэнх нь цаанаа сайшаасан шинжтэй, заримнэг нь бүр алуурчийг хөөргөн, “Дүүжил, дүүжил!” гэж орилолдоно.

Зарим нэг хүн цочирдон, ганц хоёр нь мустангерыг өрөвдөх боловч, хэн нь ч түүнийг хамгаалахаар зориглон босч чадсангүй. Аргамжны гогцоо хүзүүнд нь углаж нөгөө үзүүрийг нь хэдийнээ удамборын мөчир дээгүүр давуулсан байлаа. Одоохон Морис Жеральд амьдралаас үүрд хагацна.

LXIV. Урьдаас тааварлаагүй саатал

Ойн цоорхойд болж байгаа эмгэнэлт жүжигт оролцогч хүн бүр: “Одоохон Морис Жеральд амьдралаас хагацна” гэж бодож байлаа. Дахиад ганц минут өнгөрөхөд, удамборын мөчирт амьгүй бие нь дүүжлэгдэнэ гэдэгт хэн ч эргэлзсэнгүй.

Гэвч урьдаас тааварлаагүй саатал гарч ирэв. Жүжгийн тайз хэвээрээ авч бас нэг инээдэмт жүжиг тоглочихжээ. Эмгэнэлт жүжигт бүххүн анхаарлаа хандуулж байсан уичр инээдэмт жүжгийг үзэгчид байсангүй.

Гэлээ гол дүрд тоглосон Фелим, гүү хоёр дүрдээ зэгсэн сайн ханджээ. Фелим Исидораг гайхуулсан зүйлээ хийжээ.

Өшөө авахын хүслэнг улам их оргилуулсан Колхауны зоригжуулагч үг бүхний анхаарлыг гол хэрэгтэн рүү татжээ. Зарцы нь хэн ё анзаарсангүй, хэн ч түүнийг хамаатан ньбайгаа юу, үгүй юу гэдгийг бодсонгүй бүгдээрээ л зөвхөн Морис дээр харц тусгаж байлаа.

Нөгөө сайн дурын зандалчдыг аргамж тааруулж байх хооронд Фелимийг бүрмөсөн мартаж, мань эр ч үүний овжин ашиглав.

Фелим зүлгэн дээгүүр өнхөрч байж хүлгээ сулруулж, түүнээс мултарч гараад сэмхэн гулгасаар хүмүүсийн хөл хоорондуур сэмээрхэн мөлхжээ.

Түүний хийэ байгааг хэн ч анзаарсангүй. Сэтгэл нь аймшигтай хөдөлсөн хүмүүс дүүжлүүрийн үүрэг гүйцэтгэгч удамбороос нүд салгалгүй бие биеэ түлхэлцэнэ. Фелим аятайхан учралыг ашиглан амиа аварч, эзнийхээ хувь заяаг гаргуунд нь гаргалаа гэж бодож болмоор байлаа. Үнэндээ ч тэр түүнд вугаар тусалж чадахгүй гэдгээ мэдэж байв. Тэр эзнийгээ хамгаалж хамаг юмаа хэлж гүйцсэн бөгөөд адхин ам ангайвал ямар ч хэрэггүйгээр барахгүй хүмүүсийн уурыг хүргэж мэдэхээр байв.

Түүний зугтаасныг хэн ч урвасна хэрэг гэж хэлж чадахгүй. Биеэ хамгаалах зөн нь л түүнийг түлхжээ гэж хажуугаас нь харсан хүн бодохоор байлаа.

Гэвч тэгж бодвол андуурсан хэрэг байв. Үнэнч зарц эзнээ зөнд нь орхиё гэж огтхон ч бодсонгүй. харин ч Морис Жеральдыг гарцаагүй үхлээс аврахаар дахин оролдоод үзжээ. Ганцаархнаа юу ч хийж чадахгүй гэдгээ мэдэж байв. Бүх найдвар нь Зеб Стумпид байсан бөгөөд ийм ч учраас бидний мэддэг аргаар бушуухан шиг дуудья гэж шийджээ.

Фелим цугларсан олны дундаас мөлхөж гараад модны араар нуугдан хөгшин гүүний идшилж байгаа тэр газар руу сэмхэн дөхлөө. Энд ирсэн улсын морьд ойн захад уяатай байв. Олон морьд түүнтйг таглан Фелим морьдыг ташран явсаар зорьсон газраа мэдэгдэлгүй хүрч амжив.

Гэтэл хамгийн чухал юмаа авч яваагүйгээ мэдлээ. Тэр анх баригдсан газраа аршийннударгын мөчрийг унагаад тэр нь олны хөлд гишгүүлээд өнгөрчээ. Түүнийг очоод авчихья гэхэд даанч аз үзсэн хэрэг болох байв. Түүнд мөчир огтолчихоор хутга ч юмуу, ямар нэг юм байсангүй.

Яахаа мэдэхгүй, гунигт бодолд дарагдан зогслоо. Гэвч хором зуур тэгж зогссон бөгөөд цаг алдаж болохгүй байлаа. Мунгинаж удааширсан минут бүр нь эзний нь амь насанд гай зэтгэр болох билээ. Түүнийг ямар ч байсан аврах хэрэгтэй байв. Тэгж бодоод Фелим өргөст ургамл руу ухасхийж, түүний мөчрөөс нүцгэн гараараа тас татаж авлаа.

Хуруу нь өргөт хатгуулан цус гоожно. Гэвч нэг эхээс хөхөж өссөн хүнийх нь хувь заяаг шийдвэрлэх гэж байгаа тэр үед тиймьяльгүй юмыг анзаарна гэж үү! Ирланд хүн гүү рүү гүйж очоод тангарахыг тоолгүй тамлалт зэвсгээ сүүлэнд нь хавчуулчихав.

Энэ үед ойн чөлөөн дэх үйл ажиллагаа гуримаараа явагдаж байлаа. Аргамжны гогцоог мустангерын хүзүүгээр оруулан сайтар шалгаж нөгөө удамбор дээгүүр тохоостой үзүүрий нь одоохон угзарна гэхээс сайн дурын алуурчдын алга нь загатнана. Тэдний харц байдалд нь шийдсэн шинж илэрхий. Дохио өгөхийг хүлээж байв. Чухамдаа ийм дохиог өгөх эрхтэй хүн байсангүй. Үүнээс болон сатал гарчээ. Хэн ч булай дохиог өгөх хариуцлагыг өөртөө авья гэж бодсонгүй. хэдийгээр бүгдээрээ түүнийг хүн алсан гэдэгт итгэж байсан боловч, захирагчийн үүргийг гүйцэтгэхчиг хүн гарсангүй. Колхаун хүртэл энэ үүргээс зайлсхийж байв.

Энэ нь цөм дутсанаас тэгсэн юм биш. халагдсан ахмад болоод цугларагсдаас олон хүн зориг гаргах л байв. Зохих ёсны үүрэг гүйцэтгэгч байхгүйгээс л ийнхүү саатжээ. Энэ бол ширүүн борооны урьдхан аянга буухын өмнөх нам гүм байлаа.

Чив чимээгүй, бүгд үхэл гээч жихүүдэс хүрэм юмны өмнө байгаагаа мэдэж байв. Ихэнх нь үхэлд хүргэсэн зүйлд оролцсоноо мэдэрч, хэн нь ч үхэл ойрхон байгаад эргэлзсэнгүй. Хүмүүс эл явдлын тайлалыг хүлээн дуугүй зогсоно. гэрч болов. Энэ нь хачин утгагүй зүйл болж, цаазар аваачих явдлыг саатуулчихлаа.

Бүгдээрээ таних Зеб Стумпын хөгшин гүү гэнэт галзуурсан мэт болжээ. Зүлгэн дээгүүр дэвхцэж, тангаран, хахир муухай чарлаж ойн чөлөөг дөжрүүлэв. Зэрэгцэн зогсч байсан морь даган чарлаж, түүний галзуумэт тонгочихыг дууриав.

Овоохойн өмнө байдал илбийн саваагаар дохисон мэт эрс хувираад явчихлаа. Зөвхөн цааз хойшлогдсноор барахгүй нэг хэсэгтээ түүнийг сонирхохоо больчихов. Болсон явдалд ямар ч инээдтэй юм байсангүй. Харин ч бүх хүний царайд түгшүүр тодрон, айж бачимдсан дуу гарав. Буу руугаа гүйх нь гүйж, морь руу гаа гүйх нь морьд ругаа гүйлдэж

- Индианууд! Гэлцэв. Шуугианаас болоод дуулдаагүй ч гэлээ бүх хүний амнаас ингэж дуу алдах сонсодно. Зөвхөн команчуудын довтолгоо л ийм үймээн дэгдээж чадах байлаа. Нэг хэсэгтээ хүмүүс орь дуу тавин ойн цоорхой дундуур ийш тийш гүйлдэн эсвэл айсан царайтай амаа ангайн зогсоно. Олон хүн мориндоо хүчр индианчуудын сумнаас хамгаалан араар нь оров. Цугласан хүмүүсээс цөөхөн хэд нь ийм байдалд орж үзэж бйасан бөгөөд ийм юм үзээгүй ихэнх нь айж сандарцаажээ

Үймээн бүх хүн мориндоо хүрч, тайвширтал үргэлжлэв. Зөвхөн концертыг эхэлсэн хөгийн гүү л янцгаасаар байв.

Тэгэхэд л хүмүүс түгшүүрийн жинхэнэ учрыг олсноос гадна ирланд хүн алга

болсныгмэдэцгээлээ.

Фелим урьдаас болгоомжлон бутны цаагуур нуугдсан нь амий нь аварчээ.

Зэвүү нь хүрсэн хориод хүн буугаа шүүрэн авч Зебийн гүү рүү онилон шшагайв. Гэтэд тэднийг гохоо дарахаас өмнө тэнд ойрхон зогсч байсан хүмүүсийн нэг нь гүүний хүзүүгээр бугуйлдаж дуугүй болгов.

Дахиад нам жим болж хүмүүсийннанхаарал нөгөө хэвтэж буй хэрэгтэн рүү татагдан түрүүчийн адил хилэгнэж эхлэв. Саяын балай явдал тэдэнд инээдэмтэй санагдаагүйгээр барахгүй, харин ч уур хилэнгий нь улам бадраажээ. Зарим нь саяын хуурамч түгшүүрийн үеэр бажга алдсандаа ичнэ. Нөгөө зарим нь үйлдэх хэргээ тасалсанд дургүйцэнэ. Тэд дахин хараал урсган, уурлаж уцаарлаж эхлэв.

Өшөө авахыгхүссэн хүмүүс хэрэгтнийг тойрон хүрээлж, эмгэнэлт жүжиг дахин үргэлжилжээ.

Сайн дурын яргачид аргамжнаас дахин шүүрч, “Одоохон Морис Жеральд амьдралаас хагацна” гэсэн бодол хүн бүрийн сэтгэлд дахин төрлөө.

Аз болоход аймшигт ёслол дахин тасалдав. үхлээс ямар их ялгаатай вэ!

Эмэгтэй хүн! Үзэсгэлэнтэй бүсгүй! Хүмүүсийн толгойд эл бодол харван орж ирсэн боловч хэн ч ярьж түвдсэнгүй. Бүгд хуучин янзаар хөдлөхгүй зогсовч, нүүр царай нь хачин өөрчлөгдөөд явчихлаа. Хамгий бүдүүлэг танхайчууд нь хүртэл урилгагүй зочны гарч ирснийг хэрэгшээжээ. Тэд үймэлдэн сандарч, өөрийнхөө бурууг мэдрэв.

Луиза хүмүүсийн дундуур дув дуугай хэн рүү ч харалгүй өнгөрөөд ногоон дээр тэрийн хэвтэж байгаа хэрэгтний дээрээс бөхийж хоёр гараараа аргамжнаас нь шүүрэн авч, түүнийг алуурчдын гараас мулт татав.

-Техасчууд! Хулчгаруудаа! Гэж хүмүүс рүү харан орилсоноо - Шившиг! Бузар шившиг! Гэж хорсолтойгоор хашгирлаа.

Бүгд эл уурласан зэмлэлээс болж агийх шиг болов.

-Энэ бол та нарынхаар шүүх үү? Хэрэгтэн хүн өөрийгөө цагаатгах ганц ч үг хэлэх бололцоогүй, ямар ч өмгөөлөлт хамгаалалтгүй шүүгдэж байна. Тэгээд та нар үүнийг үнэн мөнийн шүүх гэж нэрлэж байна уу? Техасын үнэн мөний шүүх! Та нар болхүн биш араатнууд! Яргачид! Гэв.

-Энэ чинь юу болж байна вэ? гээд Пойндекстер урагш ухасхийн, охиныхоо гараас шүүрч аваад - Луиза чи солиорч байна! Чи яаж энд ирэв? Би чамайг гэртээ харь гэж хэлсэн биз дээ? Одоохон яв. Өөртөө хүртээлгүй хэрэгт бүү оролц! Гэв.

-Аав минь, энэ чинь надад хүртээлтэй юм!

-Чамд хүртээлтэй гэнээ? Яаж? Өө, нээрээ тийм, энэ бол чиний дүүг алсан хүн!

-Би итгэхгүй, итгэж чадахгүй байна... Энэ бол худлаа! Юунаас болоод гэж тийм муухай юм хийх юм бэ?... Техасчууд чинь, та нар үнэхээр хүн юм бол араатан шиг бүү аашил. Шударга шүүл хэрэгтэй. Тэгээд ... тэгвэл дараа нь... гэхэд нь

-Түүнийг шударгар шүүж байгаа юм гэж олны дундаас хэн нэгнээр заалгасан бололтой нэг янхигар хүн хэлээд - Түүнийг гэм буруутай гэдэгт элгэлзэх юм алга. Дүүг чинь алсан хүн энэ байгаа юм. Ингэж хэлснийг минь уучлаарай, мустангерыг өмөөрч байгаа тань тусгүй байна гэв.

-Зүйтэй! Гэж хэд хэдэн хүн амнийлэв.

-Үнэн мөний шүүш гүйцэтгэгдэх ёстой! Гэж хэн нэг нь шүүхийн сүртэй томъёог хашгирахад нь

-Ёстой, ёстой! Гэж бусад нь цууриа мэт давтав.

-Уучлаарай мисс, бид таныг эндээс холдохыг хүсч байна... Пойндекстер гуай та охиноо явуулбал сайнсан.

-Лу явья! Энд чиний байх газар биш. Чи эндээс явах хэрэгтэй... Чи татгалзаж байна уу? Бурхан минь! Чи миний үгэнд орохоосоо татгалзаж байна уу?... Кассий, чи үүний гараас татан эндээс аваад яваач... Луиза, чи хэрэв өөрөө явахгүй бол бид хүчээр явуулна шүү! За битгий тэнэглэ! Миний үгэнд ор! Зайл!

-Үгүй ээ аав аа! Би явахгүй. Таныг ам тангараг өгөхөөс нааш, энэ улсыг цөмий нь ам тангараг өгөхөөс нааш би явахгүй...

-Авхай минь бид яаж ч хүсээд танд юу ч амлаж чадахгүй. Ер нь тэгээд энэ бол эмэгтэй хүнд хүртээлтэй хэрэг биш. Хүн амины хэрэг гарсныг та мэднэ. Алуурчинд өршөөл байхгүй!

-Өршөөл байхгүй! гэж хэд хэдэн хүний хорсон заналхийлсэн дуу нүргэлэн

-Түүнийг дүүжил! дүүжил! гэгцгээв.

Эмэгтэй хүний байгаа нь хүмүүсийг тогтоохоо нэгэнт больжээ. Энэ бүх явдал гайтай хормыг улам ч түргэсгэсэн байж мэднэ. Одоо мустангерыг ганц Кассий Колхаун үзэж ядаж байсангүй. Мустангийн ангуучны заяатайд атаархахдаа бусад нь ч гэсэн түүнийг үзэн ядаж байв.

Пойндекстерын тушаалаар Кассий Колхаун Луизаг ойн цоорхойгоос авч гарах ч гэж дээ чухамдаа чирч гаргахыг оролдов. Луиза гараас нь мултран, нүдэндээ нулимс гүйлгэн, үзэн ядсан харцаар ширтэн, хүн бусын цаазыг эсэргүүцэн,

-Араатнууд! Яргачид! Гэж хашгирна.

Тэр мултарч чадахгүй, түүнийг хэн ч сонсохгүй байлаа. Түүнийг олны дундаас гаргахад, амь насаа ч золиослоход бэлэн хүндээ туслах найдвар нь тасарна.

Колхаун элдэв муу үг дуулж явав. Луиза түүнийг элдэв муу үгээр булан, үзэн ядаж байлаа.

Өшөөгөө авна гэж итгэсэн нь түүнд ямар ч сэтгэлийнамгаланг өгсөнгүй. Түүний өрсөлдөгч одоохон үхнэ ч гэлээ, үүнээс болж юу өөрчлөгдөх юм бэ? Тэр Луизагийн сэтгэлтэй хүнийг алж чадлаа гэхэд бүсгүй хэзээ ч түүнд дурлахгүй.

LXV. Урьдаас бодоогүй бас нэгэн саатал

Гурав дахь удаагаа аймшигт эмгэнэлт жүжгийн үзэгч, тоглогчид өөрсдийн байрыг дахин эзэллээ.

Удамборын мөчир дамнуулан бугуйлын үзүүрийг дахиншидэж өнөөх хоёр алуурчин үзүүрээс нь шүүрч аваад энэ удаа чивчиртэл нь татлаа.

Гурав дахь удаагаа бүгдийн толгойд “одоохон Морис Жеральд амьдралаас хагацна” гэдэг бодол орж ирэв.

Хайр сэтгэл хүртэл түүнийг аврах чадаогүйгээ харуулав. Тэгвэл өөр ямар хүн түүнийг энэ гай зовлонгоос аврах билээ?

Түүнийг аврах ямар ч боломжгүй бөгөөд хэдийнээ цаг чьүгүй болжээ. үзэгчдийн ширүүн харцанд өршөөх шинж алга, гагцхүү байж ядацгааж байв. Алуурчид ч бас дахин саад тотгор учрахаас айсан мэт яарч байлаа. Тэр аргамжийг мэргэжлийн дадамгай байдлаар хөдөлгөнө.

Цугласан олны шийтгэл гүйцэлдэхэд ганц минут ч хүрэхгүй хугацаа үлджээ.

-За Билл бэлэн болов уу? гэж нэг алуурчин нь харваас дохио хүлээхгүй гэж шийдэв бололтой нөгөөгөөсөө асуулаа.

-Цөм номын ёсоор бэлэн байна. Энэ мууг зүйл дуусгая! Гэж Билл хариу хэллээ.

Аргамж хөдөлсөн боловч хэрэгтний биеийг газраас хөндийрүүлэхээр хүчтэй татагдсангүй. Сур хүзүүгээр нь хөвчирсэн авч толгойг нь жаахан өндийлгөөд л зогсчихов.

Зөвхөн ганц алуурч л аргамжийг татсан ажээ.

-Солиг минь, татаач! Юундаа алмайраад байгаа юм бэ? гэж Билл нөхрийнхөө хөдөлж ядаж байгаад гайхан хашгирав.

Билл ой руу нуруугаа харуулаад зогсч байсан болохоор модны цаанаас хүн гарч ирэхийг харсангүй.

-За алийв! Нэг, хоёр, татаарай! Гэж Билл хашгирлаа.

-Тэгж ярихгүй шүү! гэсэн хүнгэнэсэн дуу гарлаа.

Гартаа буу барьсан өндөрт хүн модны цаанаас гарч ирээд төдхөн шахцалдсан олны дунд зогсов.

-Үгүй ээ, тэгж ярихгүй! гэж өвгөн давган хэлээд газар хэвгэж бөайгаа хүн рүү бөхийж урт бууныхаамыг алуурчид руу чиглүүлээд - Минийхээр бол арай л эрт байна. Ээ, Билл Грифин, чи хэрэв аргамжнаас өчүүхэн төдий ч татвал хар гэдсэндээ үрлэн сум зоолгоно гэж

мэдээрэй. Чиний хододд түнийг арай ч шингээж чадахгүй байх! Золигнууд минв, аргамжаа доош нь тавь! Гэв.

Гүүний зэрлэг янцгаалт ч гэсэн түүний эзэн ЗебСтумпын хүрч ирсэнтэй адил цугласан олны дунд тийм их хүчтэй сэтгэгдэл төрүүлээгүй ажээ. Тэнд байгаа хүмүүс бараг цөмөөрөө түүнийг таньдаг, хүндэтгэдэг, олон хүн түүнээс айдаг байв.

Билл Грифин түүний нөхөр хоёр түүнээс айдаг хүмүүсийн тоонд ордог байжээ.

Зеб Стумпыг: “Больцгоо!” гэж тушаахад тэд аюул тулгарсныг ойлгон аргамжийг тавихад ногоон дээр мурилзан унав.

-Залуус минь, та нар юун дэмий юм сэдсэн улс вэ? Арай өвчтэй хүнийг дүүжлэх гэж байга юм биш биз дээ? Ийм байж болмооргүй юмаа? гэж анчин өвгөн гайхсандаа хэлгүй юм шиг зогсч байгаа олны зүг хандаж хэлэв.

-Бид яг тэгэх гэж байна гэсэн ширүүн дуу гарлаа.

-Яагаад тэгж болдоггүй юм бэ? гэж өөр нэг хүн хэлэв.

-Яагаад болдоггүй юм бэ гэнээ? Техасын иргэнийг шүүхгүйгээр алах эрх та нарт хэн олгосон юм бэ?

-Нэгэнт тийм юм хийсэн хүн, техас хүн биш! Ер нь тэгээд түүнээс гадна түүнийг зүй ёсоор нь шүүсэн юм.

-Ухай! Ухаан мэдээгүй хүнд дүүжлэх ял онооно гэнээ! Юу ч ойлгож мэдрэхгүй байхад нь нөгөө ертөнцөд тонилгох нь ээ! Тэгээд үүнийгээ та нар үнэн мөний шүүх гэж бодож байна уу?

-Тэгээд яагаав? Бид үүнийг гэмт этгээд гэдгийг сайн мэдэж байгаа болохоор тэгэхгүй яах юм бэ? Бид цөм итгэж байгаа юм.

-Итгэж гэнээ? Үгүй ер! Жим Стордас чамтайби ер энэ тухай ярих ч үгүй. Харин Пойндекстер гуай, Сэм Мэнли та хоёр энд болж байгаа зэрлэг явдлыг зөвшөөрнө гэж баймааргүй юм. Энэ бол их бага ч гэсэн хүн амины хэрэг гэж би бодож байна.

-Зеб Стумп, чи бүгдийг мэдэхгүй. Бидэнд тодорхой баримт байгаа юм гэж Сэм Мэнли энэ хэрэгт оролцосоноо цагаатгах гэж хэлэв.

-Чөтгөрийн чинь баримт бол доо! Дэмий хоосон санаанаасаа зохиосон зүйл. Би юу ч сонсохыг хүсэхгүй. Жинхэнэ шүүхийн ажиллагаа явагдахаар бид үүний учрыг олох цаг элбэг гарна. Мэдээж хэн ч үүнийг татгалзахгүй биз дээ? Энэ залуу тэртээ тэргүй зугтааж чадахгүй. Зөвшөөрөхгүй хүн байна уу?

-Зеб Стумп та дэндүү их юм биедээ хүлээж байна шүү гэж Кассий Колхаун татгалзаад - танд энэ ямар хамаатай юм гэдгийг би мэдмээр байна. Алагдсан хүн таны хүү ч, дүү ч тэр бүү хэл

зээ ч биш шүү дээ. Түүнээс бус та өөрөөр л ярих байсан байх. Таныг яагаад энэ хэрэгт оролцоод байгааг мэдэхгүй юм гэв.

-Гэвч би надад хамаатай гэж бодож байна. юуны өмнө хэдийгээр манай нутагт ирээд удаагүй байгаа боловч миний найз, хоёрдугаар Техасын та нутагт ч байгаа гэсэн Зеб Стумп шившигтэй явдлыг тэсвэрлэж чадхагүй.

-Шившигтэй явдал гэнэ ээ! Та үүнийг шившигтэй, өөдгүй явдал гэж байгаа юм уу? Техасчуудаа танарэнэ муу чалчаа амьтнаас айгаад байна гэж үү? Энэ хэргийг төгсгөх цаг боллоо! Алагдсан Генри Пойндекстерын цус, өшөө авахыг уриалан дуудаж байна. сураа баригтун!

-Бариад үз л дээ! хэн зориглосон хүн сурнаас барьж авахаасаа өмнө өнхөрч ойчно гэдгийг тангараглая. Та нар энэ хөөрхий амьтныг дуртайгаараа дүүжилж болно. Тэгэхдээ Зеб Стумп болон та нарын хэд хэд нь хамт газарт амьгүй унахаас нааш дөнгөхгүй. за алийв. Хэн эхэлж суранд хүрэхийг харья.

Огт чимээ аниргүй боллоо. Хүмүүс байрнаасаа хөдөлсөнгүй. нэг талаар уриалгыг хүлээж авахаас эмээн, нөгөө талаар өвгөний сайхан сэтгэл, эрэлхэг зоригийг хүндэтгэж байв. Зеб Стумп энэ аятай нөхцөлийг чадамгай ашиглав.

-Энэ залууг шударгаар шүүх хэрэгтэй гэж шаардаад - Аль вэ, үүнийг сууринд аваачъя. Тэнд шүүг. Энэ залууг тэр бузар хэрэгт оролцсон гэх тодорхой баримт та нарт алга. Би өөрийн нүдээр үзэхээс нааш үүнд итгэх юм бол би өөрөө өөдгүй амьтан больё! Энэ хүн залуу Пойндекстертой ямар харвцаатай байсныг би мэдэж байна. Энэ хүн түүний дайсан байгаагүй, түүний үеэл ахтай ялимгүй сөргөлцсөн ч гэлээ, ямагт залуу хүүг шагшран магтдаг байсан юм гэв.

-Бидний дөнгөж сая дуулаад байгаа юмыг Стумп гуай та мэдэхгүй байна гэж Сэм Мэнли сөргөн асуув.

-Тэр чинь юу юм бэ?

-Таны хэлж байгаагийн эсрэг баримт. Жеральд залуу Пойндекстер хоёрын хооронд дайсангалцал байснаар барахгүй яг тэр шөнө хэрэлдсэн гэдэг нотолгоо байна.

-Сэм Мэнли, хэн үүнийг хэлж байгаа юм бэ?

-Би хэлсэн юм гэж Колхаун% Зебт харагдах гэж урагш гарч хэлэв.

-Өө, Кассий Колхаун та юу? Тэр хоёрын хооронд дайсагнах юм байсныг та мэдэж байгаа юм уу? Та тэднийг маргалдаж байхыг харсан юм уу?

-Зеб Стумп, би ингэж хэлээгүй, түүнээс гадна би таны асуултад огт харуи хэлэх гээгүй байна. Би шаардах эрэхтэй улсад нь л мэдүүлгээ гаргасан. Тэгээд л боллоо. Эрхмүүдээ, гаргасан шийдвэрийг та бүхэн цөм зөвшөөрч байгаа гэж би бодож байна. Энэ мангуу өвгөн яагаад

биднийг хэрэгт оролцож байгааг би ойлгохгүй байна.

- "Мангуу өвгөн гэнээ!" гэж Зеб хашгираад - Та намайг мангуу өвгөн гэж байна уу? Энэ хэлсэн үгээ буцааж авах цаг ирнэ! Гэж Кентуккнутгийн Зебулон Стумп танд хэлж байна! Гэвч цагийн юм цагтаа. Мистер Кассий Колхаун таны ээлж ч ирнэ. Гэхдээ таны бодсоноос урьтаж ирж мэднэ... гэж хэлснээ Зеб, Сем Мэнлид хандаж - Генри Пойндекстер энэ залуу хоёрын муудалцсан гэдэгт би огтхон ч итгэхгүй байна. Мистер Колхану дэмий чаличхаас илүү итгэлтэй баримт нотолгоо гараагүй цагт би ерөөсөө итгэхгүй. Түүний хэлсэн миний мэдэж байгаагаас зөрж байна. Та нар өөрсдөдөө шинэ баримт байна гэв үү? Тэр чинь надад ч бас байна. тэгэхдээ энэ маань битүүлэг хэргийг жаахан тодорхой болгож өгнө гэж санаж байна.

- Ямар баримтууд? Зеб Смумпээ, бид түүний чинь сонсьё гэж Сэм мэнли хэлэв.

- Нэлээд хэдэн юм бий. Юуны өмнө энэ залуу шархадсаныг та нар харж байна. Бие нь сараачигдсан тухай би ярихгүй. Шархадсаны нь үнэр авсан чонон тэгчихээ биз. харин өвдгий нь харцгаа. Энэ бол чонын хийсэн ажил огт биш. Сэм Мэнли чи энэ талаар юу гэж бодож байна?

- Энэ... Тэр энэ хоёрыг үзэлцэж байх үед гарсан шарх гэж залуус үзэж байгаа юм.

- Тэр гэдэг чинь хэн бэ? гэж Зеб эрс асуув.

- Тэр алга болсон хүн.

- Тийм ээ, бид тэгж бодож байгаа юм гэж цугларсан олны дундаас нэг нь хэлээд - Генри Пойндекстер арай ч хурга шиг нухчуулчихгүй гэдгийг бид мэдэж байна. Тэр хоёр зодолдоод мустангер унахдаа өвдгөөрөө чулуу мөргөсөн бололтой. Тэгээд л хавджээ. Түүнээс надна духан дээр нь гар бууны бөгсөөр цохиулсантай адил хөхөрсөн байгаа юм. Бие ньяагаад сараачигдсаныг бид мэдэхгүй, өргөс эсхүл таны хэлдгээр чонын саварт уруулсан ч юм билүү. харин тэр балай амьтан цоохор барын тухай чалчаад байсны нь бид үнэмшээ ч үгүй гэж ярив.

- Та ямар балай хүний тухай ярьж байна? Фелимийг хэлж байна? Тэр хаана байна?

- Толгойгоо хайрлаад зугтаачихсан. Бид энэ хэргийгдуусмагц түүнийг эрнэ. Тэгээд дүүжлүүрийн гогцоо углаад өгхөөр үнэнээ ярьж эхэлнэ.

- Цоохор барын тухайд бол, та нар шинэ юм юу ч олж мэдэхгүй. Тэр бузар амвтныг би өөрийн нүдээр харж түүний савраас энэ залууг ам мөлтөс салгаж авсан юм. гэвч хэргийн учир үүнд биш. Харин Фелим өөр юу ярьсан бэ?

- Ямар нэг индианд нарын тухай унжирсан% түүх дэлгэсэн. Гэвч хэн түүнийг үнэмших юм бэ?

- Тэр чинь надад ч бас тийм юм ярьсан юм даа. Энэ бүхэн үнэний хувьтай л байгаа юм. Индианчуудыг хөзөр тавьж байсан гэж Фелим надад ярьсан. Овоохойны нь шал дээрээс миний олсон багж хөзөр энэ байна харцгаа. Энэ бол испани хөзөр.

Зеб халааснаасаа багж хөзөр гаргаж, Сэм Мэнлид өгөв. хөзөр нь хатныг морь унуулан, гилийг илдээр, цэцгийг алхаар дүрсэлсэн жирийн л мексик хөзөр байв.

-Команчууд хөзрөөр тоглодог гэж хаана дуулсан юм бэ? Энэ ч ёстой дэмий юм байна! гэж индианы тухай өгүүлсэнд элэгдсэн олны дундаас сонсогдов.

-Дэмий юм гэнээ? гэж команч нарт олзлогдоод жил шахам тэдний гарт байж үзсэн нэгэн анч өвгөн эсэргүүцэн хэлээд, Энэ ч дэмий юм байж болох юм. гэхдээ энэ болүнэн зүйл. Тэр зэрлэгүүд ширээний оронд зэрлэг үхрийн шир дээр хөзөр дэлгээд тоглож байхыг би олон үзсэн. Яг л мексик тоглоомоор тоглодог вч. Тэд лав олзлогдогчдоосоо сурч авсан биз. Янз бүрийн омогт нь гурван мянга орчим олзлогдогч байдаг юм чинь. Тэгээд ер нь ямар байлаа ч гэсэн команчууд хөзрөөр тоглодог нь үнэнээс үнэн хэмээн өвгөн үгээ дуусгав.

Ингэж хэлсэнд Зеб Стумп баярлав. Энэ нь хэрэгт тулгагдсан хүнд ашигтай байлаа. Ойр хавь индианууд байсан байна гэлэг баримт хэргийг өөр болгоно. Одоо болтол бүгд команч нар суурингаас хол дээрэм хийж байна хэмээн бодож байжээ.

Зеб, шүүхийн ажиллагааг хойшлуулах нь чухал гэдэгт тэнд байгаа хүмүүсийг итгүүлэх гэж хичээн бушуухан өлгөж аваад

-Энд индиан нар ч юм уу, эсвэл ер нь тэдэнтэй маш төстэй амьтад байжээ... гэснээ - Бурхан минь! Энэ хүүхэн хаанаас давхиад айсуу вэ? гэв.

Энэ агшинд ганганы зүгээс морин туурай тодхон сонсоглоо.

Зеб яагаад яриагаа тасалсан нь бүхэнд тодорхой болов. Ганганы хажуугаар морь хар хурдаараа давхин гарч ирлээ. Унасан хүүхний гэзэг нь задарч, бүрх нь ар шилэн дээрээ бүчиндээ санжигнана. Морь хар хурдаараа давхин, ганганы ирмэгт хүрэн алдсан нь унасан хүн нь амы нь дийлэхгүй байна уу даа гэж бодмоор. Гэвч үгүй байлаа. Бүсгүйн байдлаар бол энэ хурд нь чамлагдсан юм шиг морио байдгаара нь ташуурдан давирна.

Ойн цоорхой дахь хүмүүс гайхаж мэлэрсэн нь түүнийг таниагүйдээ тэгсэн хэрэг биш байлаа. Бүгд харангуугаа танижээ. Энэ зоригтой морьтон бол тэдэнд овоохой хүрэх замыг зааж өгсөн нөгөө бүсгүй байв.

LXVI. Команчуудад хөөгдөв

Исидора ийнхүү гэнэтхэн хачин байдалтай гарч иржээ. Ямар юм үүнийг буцаж ирэхэд хүргэв? Бас тэгээд юунд тэгтлээ галзуу мэт давхиж байна вэ?

Бид түүнийг тайлбарлахын тул, Техасынхантай уулзаж тасалдсан гунигтай бодол болж байсан үе рүү эргэж очих хэрэгтэй.

Исидора Аламогийн эргээс хагируулан холдохдоо хойноосоо хүн мөрдөж байна уу үгүй юу гэж нэг ч удаа эргэн харсангүй. Өшөө авах тухай элдвийг бодсоор замааүргэжлүүлжээ.

Луиза Пойндекстер ч бас овоохойг орхиод явахаар завдаж байсан нь түүнийг тайвшруулсангүй. Эмэгтэй хүний хэрсүү ухаанаар явах гэсний учрыг нь тааварслан ч гэсэн, энэ нь зөвхөн учраа ойлголцоогүй явдал төдийхөн гэдгийг сайн ойлгож байв. Тэгээд Исидора өрсөлдөгч нь өөрийн хувь заяатайг мэдэлгүй адилхан л зовж байна гэж бодохоос бах нь ханаж явлаа.

Эрлийнхэнтэй дайралдах үедээ мексик хүүхэн ийнхүү бодож зэвүүнээр баярлаж байлаа. Тэгээд тэдэнтэй цуг эргэхдээ тэр баяр нь алга болчихов. Луиза түүний явсан замаар буцаж эргэх ёстой боловч, зөргөөр хэн с үзэгдсэнгүй.

Креол бүсгүй бодож байснаа овоохойдүлдэхээр шийдэж, өөрийнх нь мөрөөдөж байсан нөгөө өвчтэй хүнийг одоо асарч байж болох юм.

Исидора өөрийнх нь аз жаргалыг булааж авсан өрсөлдөгчөө шившгий нь тарих мөч холгүй байна гэдэг бодлоор өөрийгөө тайвшруулж явав.

Пойндекстер болон түүний дагалдагчдын тавьсан асуулт Исидорад олон юмыг хэлж өгсөн агаад Колхауны байцаалтын дараа бүх юм тодорхой болжээ. Эрлийнхнийг холдон явсны дараа бүсгүй ширэнгийн захад үлдэн, Леон руу явдаг юм билүү, эсвэл овоохой руу буцан өөрийнх нь ачаар тоглох болсон тэр айхавтар үзэгдэлд гэрч нь болдог юм бил үү хэмээн шийдэж ядан зогслоо.

Исидора модны сүүдэрт, ширэнгийн захад зогсоно. Унасан бор морь нь хамар тачигнуулан, араас нь ганц морьтон харайлгаж яваа, дөнгөж саяхан хөдөлсөн эрлийнхний араас айсан нүдээр хялайж байв. Мустанг яагаад нэг тийшээ, нэг буцаж харайлгаад байгааг ойлгоогүй байж болох юм. Гэхдээ эзэн эмэгтэйнхээ олон занд дасчихсан унаа байжээ.

Бүсгүй Аламогийн эгц эрэг дээр сүглийн байгаа майлсын бараан оройг өөрийн эрхгүй харлаа.

Эрлийнхэн хотгор руу бууж, түүнээс нэгд нэгэнгүй асууж байсан хүн араас нь буухыг харав. Тэр хүний толгой цухалзсаар далд ороход Исидора гав ганцаархнаа нүд алдам талд үлдчих шиг санагдав.

Гэвч тэр андуурчээ.

Нэг хэсэгтээ шийдэж чадахгүй зогсов.

Түүний бодолд жөтөөрхөж болох уу даа. Тэрхариугаа авсан байж болох авч, баярлаад байх юм байсангүй.

Үзэн яддаг эмэгтэйгээ басамжилсан ч гэсэн сэтгэлтэй хүнээ балласан байж болох юм. Хэдийгээр олон юм болж өнгөрсөн ч гэсэн мексик бүсгүй урьдын адил мустангерт сэтгэлтэй хэвээр ажээ.

-Бурхан минь! гэж бүсгүй сэтгэл нь түгшин шивэгнээд - Би ямар хэрэг тарьчихваа? Хэрэв энэхаргис шүүгчид түүнийг гэмт этгээд гэж бодвол юу болж төгсдөг бол? Үхэл! Ээ, би үүнийг хүсэхгүй байна! Зөвхөн тэдний гарт үхэхий нь хүсэхгүй байна! Үгүй ээ, үгүй! Тэдний ширүүн догшин царайтай байсныг яана! Надаар зам заалгаж аваад намайг тэр дороо мартан урагшаа тун шамдамгай ухасхийн давхисан шүү! Тэд Морисыг үхэх ёстой гэж аль эрт шийдчихээд явж байсан байжээ. Тэр бол энэ бүхэнд харь элгийн холын хүн. Хань нөхөдгүй, ор ганцаараа, зөвхөн дайснаар хүрээлэгдсэн... Миний толгойд юу орж ирэв ээ? Намайг хамгийн сүүлд зогсоосон тэр хүн алга болсон залуугийн үеэл биш үү? Одоо л би яагаад шалгаагаад байсны нь учрыг ойлголоо гэв.

Залуу хүүхний уйтгартай харц тал нутаг дундуур мэнэрнэ. Хэдийгээр эрлийнхэн далд орсон ч гэсэн морь нь тогтож ядна. Эзэн нь нэг л сэтгэл догдлоод буйг мэдэрчээ. Морь нь аюулыг түрүүлж мэдрэв. Гэнэт аяархан янцгааж, тэр зүгээс дайсан ойртож буйг заасан мэтшугуйн зүг толгой эргүүлэв.

-Хэн байж болох вэ? Мустангийн байж ядаж буйд сэтгэл зовон Исидора бас эргэн харж, дөнгөж сая явж байсан зөрөг замаа дагуулан ажиглав. Леон руу явсан эл зам, зөвхөн ойрхон зуурын ил харагдах бөгөөд цааш дугуйрч шугуй дундуур шурган далд орсон ажээ. Зам дээр хоёр гурван гуриатсан чоно идчихмээр юм олдож магадгүй хэмээн морьдын мөрийг шиншлэн шогшино. Морь нь үүнээс болж үргээгүй байж таарна. Тэднийг харж байгаа ч гэсэн тоохгүй. Талын чононцорыг дэндүү олон харсаар дасчихсан амьтан. Нэг л өөр юмны үнэр авчээ.

Исидора чих тавьсан боловч одоохондоо сэтгэл түгшмээр юм юу ч байсангүй. Чонын улих чтийм аймшигтай юм биш, тэгээд гэгээн цагаан өдрөөр бүр ч аюулгүй. Өөр юм ч сонсогдсонгүй.

Бодол нь дахин эрүүлийнхэн рүү, ялангуяа түүнийг тэгтлээ шалгаасан хүн рүү шилжив. Юундаа тэгтлээ махран шалгаасны нь бодож байтал морь бодлыг нь тасалдууллаа. Мустанг юундаа тогтож ядан тургиж, урьдынхаасаа чангаар янцгаана вэ?

Түүний хариуд хэд хэдэн морь янцгаасан боловч бодвол шугуй дотор үзэгдэхгүй давхиж байгаа бололтой. Зөвхөн туурайн чимээ сонсдож ирэв.

Тэгээд дахин чимээ аниргүй болов. Тэд нэг бол зогссон, эсвэл алхуулж яваа бололтой.

Исидора эхнийхээр нь бодлоо. Мустангийн янцгаахыг сонсоод, унасан хүмүүс нь морьдоо зогсоолоо гэж бодов. Бүсгүй морио тайвшруулан хүзүү рүү нь алгадаад, чих тавин чагнав. Ширэнгээс бүдэг чимээ сонсон, хэдэн эрэгтэй хүний дууг ялгаж болмоор байлаа.

Тэгснээ тэд дуугарахаа больж чив чимээгүй болов. Ямар ч байлаа гэсэн морьтонгууд тээнэгэлзэн зогсов бололтой.

Исидора үүнд сандарч тэвдсэнгүй.

Рио Гранд руу яваа хүмүүс ч юм уу, эсвэл Техасын эрлийнхний хагас нь байж мэднэ. Морь янцгаахыг сонсоод болгоомжлон зогссон байж. Индианууд дайнд хөдөлчихсөн байхад аргагүй юм.

Гэвч энэ морьтой хүмүүс хэн ч байлаа гэсэн болгоомжтой байх хэрэгтэй гэж бүсгүй бодлоо. Исидора тэгж бодоод хажуу тийшээ зайлж хуайсны дор нуугдлаа. Тжгээд дахин чимээ чагнахад тэдгээр хүмүүс замаар биш, харин шугуй дундуур өөр рүү нь дөхөж ябааг ажиглав. Салж таран өөрийг нь бүслэх маягтай болж байгаа шиг санагдав.

Морьдын бүдэг туурайн чимээ тал талаас нь сонсогдохоор ийнхүү тааварласан хэрэг. Тэд болгоомжилсноосоо ч юмуу мэхлэх гэсэндээ болоод дуу чимээ гаргасангүй. Тэд муу юм санаж байгаа юм биш байгаа?

Яаж ч мэдэхийн арга алга.

Бүсгүйд дайсан бас бий. Тэдний нэг нь дон Мигуэль Диас. Түүнээс гадна комончууд нэгэнт хөдөлснөөс хойш их болгоомжтой байх хэрэгтэй.

Сэтгэл тайван байсан Исидорад морьто йхүмүүсийн байдал туйлын сэжигтэй санагдсан тул сандарч эхлэв. Хэрвэ тэд зрдийн нэг замын улс байсан бол замаар явна уу гэхээс биш, ой шугуй дундуур гэтэн мярайж явахгүйсэн билээ.

Бүсгүй нуугдсан газраа эргэн тойрон харлаа. Хуайсны сэвсгэр навч түүнийг халхлахгүй бөгөөд цаадуул нь ойртож байх шиг байв.

Туурайн чимээгээр, ойртон ирээд одоохон өөрийг нь олох болно гэдэг илт байв.

Исидора морио давирч, дугуйгаас гараад, Аламо тийш тал хөндий дундуур давхин одлоо.

Сум харваад хүрэхгүйгээр гурван зуугаад алхам газар холдон яваад ойртож яваа улс чухам нөхөр дайсан хоёрын хэн болохыг таньжавья гэж шийдлээ.

Хэрэв дайсан байж гэмээнэ нь өөрийг нь техасчуудыгн хамгаалалд аваачиж өгөх хурдан хөлт мустангердаа найдаж байв.

Гэвч хэдийнээ хожимджээ. Морьтонгууд шуйгаас гарч шууд өөрийг нь чиглэн давхив. Бүсгүй хагас эргэн тэдний хагас нүцгэн бие, дайнч мяагаар будсан нүүр, үсэндээ хатгасан галт өдийг харлаа.

-Индианчууд... гэж мексик хүүхэн айн шивгэнээд, морио агар луу чиглүүлж, хар хурдаар нь давхиуллаа.

Мөрөн дээгүүрээ зэрвэс хараад, хэдийнээ тэгнэ гэдгийг мэдэж байсан ч араас нь элдэж байгааг мэдэж авав. Тэд их ойрхон ирсэн бөгөөд нэг гайхмаар нь заншил болсон байлдааны уухайгаа хашгирсангүй.

Тэдний дуу гарахгүй байгаа нь өөрийг нь амьдаар барихыг хүсч байгааг, урьдаас ийнхүү тохиролцсоныг гэрчилнэ.

Исидора үүнээс өмнө индианчуудтай дайралдахаас бараг айдаггүй байжээ. Тэд олон жилийн турш техасынхантай ч, мексикчүүдтэй ч эв найртайгаар аж төрөн байжээ. Гэвч одоо найрамдлын эв нь дуусчээ. Ингээд Исидорад үхэл заналхийлэх нь тэр.

Исидора задгай талаар, морио гуугачин, ташуурдан, давируулдан хар хурдаар нь харайлгана.

Зөвхөн түүний дуу л гарахаас араас нь хөөж явааа улс хий юм шиг ямар ч дуу үл гаргана.

Бүсгүй хоёр дахь удаагаа зэрвэсхэн харав. Тэд дөрвүүлхнээ ажээ. Гэвч ганц хүний эсрэг дөрвөн хүн гэдэг бол тур тусмаа нь эмэгтэй хүний хувьд даанч олон гэсэн үг.

Ганц найдвар нь техасчууд байв.

Исидора агар модны зүг хар хурдаараа давхив.

LXVII. Индиан нар

Индиануудад хөөгдөж яваа хүүхэн агар ургасан ганганд гурван зуугаад алхмын зайтай ойртожирлээ.

Дахин эргэж харлаа.

“Би өнгөрчээ. Аврал алга!” гэж бодов.

Хойноос нь хөөж яваа индианчуудын түрүүчийн хүн эмээлийнхээ бүүрэгнээс бугуйл авч толгой дээгүүрээ эргүүлэв.

Бүсгүйг хотгор руу орж амжихаас өмнө бугуйлын гогцоо хүзүүгээр нь орооно. Тэгээд...

Исидорад нэгэн мэргэн санаа гэнэт төрлөө.

Доошоо буусан хотгорыг бодвол ганга түүндойрхон байлаа.

Эрэг нь овоохойны тэндээс харагддагийг Исидора санав.

Тэгээд бүсгүй гэнэт чигээ өрчилж агар руу явахын оронд шууд эрэг рүү давхилаа.

Хөөж яваа улс нь мэгдсэн боловч бас баярлаж байв. тэд тэндээс газрыг сайн мэддэг учир бүсгүй одоо гараас нь гарахгүй болжээ.

Толгойлогч нь бугуйлаа дахин авлаа. Гэвч амжилтдаа итгэж байсан учир бугуйл хаях гэж яарсангүй.

-Карамба! Дахиад жаахан байзнахад ёроолгүй ганга руу унах нь гэж тэр үглэв.

Гэвч эндүүрчээ! Исидора хавцал руу унасангүй. Мориныхоо амыг огцом татангаа хажуу тийш эргээд ганганы ирмэгтэй тун ойрхон давхихад нь техасчууд харж, Зеб өвгөн “Бурхан минь!” хэмэн дуу алдлаа.

Тэгтэл ч өвгөн анчны дуу алдсанд хариулах мэт зоригтой бүсгүйн цангиасан дуу гарч

-Индианчууд! Индианчууд! Гэх нь сонсдов.

Өмнөд Техаст ирсэн хүн гурвахан хоноход л энэ үгийг ямар ч хэлээр хэлсэн ойлгодог болно. Сайхь түгшүүрийн дохиог хилийн зурвас дагуух гурван мянган бээр газар, гурван зууны турш франц, англи, испани хэлээр “Les indiens”, “Los jndios”, “The indians!” хэмээн орилсоор иржээ.

Доор овоохойн хаалган дээр бөөгнөрөнзогсч байсан хүмүүс сайхь дуу алдахыг сонсов. Тэдэнд орчуулахын хэрэг байсангүй. нөгөө дуу дахин хангинаж,

-Техасчууд минь! Анд нөхдүүд минь авраач! Намайг индианууд хөөж байна! Энүүхэнд ойрхон

явна гэж хашгирав.

Тэр дахин өөр юм хашгирах шиг болсон нь чухам юу гэсний нь ялгахад бэрхтэй ажээ. Гэвч дээд таолын хөндийд юу болж байгаад тайлбар шаардлагагүй болжээ.

Эмэгтэйн араас моддын орой дээгүүр, хар хурлаара давхиж байгаа индиан үзэгдэв. Цэнхэр тэнгэрийн өнгөнд түүний дүрс тов тодорхой танигдана.

Дүүгүүр шиг, толгой дээгүүрээ бугуйлаа эргүүллээ. Тэр бүх анхаарлаа гүйцэж очиход чиглүүлсэн учир эмэгтэйн үгийг анхаарагүй бололтой. Бүсгүй техасчуудаас тусламж гуйн хашгирахдаа мориныхоо амыг татсангүй. Өршөөл гуйн, эцсийнхээ үгийг хэллээ гэж бодож болох ажээ.

Доороос гэнэт буун дуу тасхийж, гар нь гэнэт хүндрэн бугуйлаа алдахдаа сая л андуурснаа мэдэв. Тэгээд ийш тийш гайхан харлаа.

Хөндийд дарийн утаа суунаглаж буйг харж амжив. Индианы байдал шал өөр болоход ганц зэрвэсхэн харахад л хангалттай байв. зуугаад буузэвсэг агссан хүмүүсийг харжээ.

Нөгөө гурав нь ч зэрэг шахуу ажиглажээ.

Дөрвүүл хэлцээтэй юм шиг мориныхоо амыг эргүүлээд, наашаа ирсэн шигээ хурднаар буцаж давхиллаа.

-Яасан гайтай хөөтэй юм болов оо! Гэж Зеб Стумп бугаа дахин цэнэглэнгээ хэлээд - хэрэв бүсгүйд үхлийн аюул тулгараагүй бол би тэднийг нааш нь буулгах байсан юм. Тэгээд олзлон авч, энэ битүүлэг хэрэгтэй холбогдсон ямар нэг юм мэдэж болох байсан юм. гэвч одоо тэд гүйцэгдэхээсээ өнгөрлөө гэв.

Индианчууд үзэгдсэн явдал мустангерын овоохоны хажууд байсан хүмүүсийн зан аашийг шал өөр болголоо.

Морис Жеральдыг алуурч гэж шээж байгаа улс одоо цөөнх нь болов. Цугларсдын хамгийн хүндэтгэлтэй хүмүүс нь түүнийг буруугүй гэжүзэж байв.

Колхаун болоод түүний хань хамсаатан нар байдлын эзэн байхаа больж, Сэм Мэнлийн саналаар шүүхийн ажиллагааг хойшлуулав.

Тэгээд дорхон нь шинэ төлөвлөгөө гаргаж ирэв. хэрэгтнийг сууринд аваачиж, тэнд тус орны хууль зүйн ёсоор шүүх ажиллагааг хуралдуулахаар болжээ.

Харин одоо бол бүх төлөвлөгөөг баллаж, цугларагсдын зан аашийг өөрчилсөн индиануудыг л учры нь олох хэрэгтэй!

Хойноос нь хөөх үү. Мэдээж хэрэг. Гэхдээ хэзээ вэ? Одоо юу?

Тэгж болохгүй гэж болгоможлох сэтгэл хэлнэ. Дөрөвхөн хүний бараа харсан, гэвч тэд дөрвөн зуун хүний толгойн баг байж болох юм.

-Бүсгүйг бидэн рүү бууж ирэхийг хүллэе гэж хулчгаруудын нэг нь зөвлөөд

-Одоо хойноос нь хөөх хэрэггүй болсон. Морин туурайн чимээ гарах шиг, бодвол ташлуур руу бууж явна. Бидэнд зам зааж өгсөн болохоор хаагуур явахаа сайн мэдэж байгаа гэв.

Тэнд байгсдын олонхид эл санал ухаалаг юм шиг санагдав. Тэд хулчгарууд биш ажээ. Гэвч тэдний цөөхөн нь индиануудтай тулалдаж үзсэн бөгөөд, олонхи нь цайзандхудалдаа хийхээр ирсэн индиануудыг л харснаас хэтэрсэнгүй.

Ийнхүү саналыг зөвшөөрсөнгүй. Исидораг бүгд хүлээв.

Бүгд хэдийн морьдынхоо хажууд очсон байв. Зарим нь мексик хүүхэнтэй юм уу эсвэл араас нь команчийн баг цэрэг гараад ирж магадгүй хэмээсэндээ модны араар нуугдана.

Тэр үед Зеб Стумп түр зуур өршөөгдсөн үйлт хүний аманд чихсэнбөглөөг авч, чивчирсэн хүлгий нь тайллаа.

Луиза Пойндекстер энэ бүгдийг хүч гарган анхааралтай ширтэх боловч түүнд тусалсангүй. тэр өөрийнхөө чаддаг бүхнийг арай илэн далангүй гэмээр хийсан билээ. Хүний анхаарлыг дахиж нэг их татаад яахав гэж бодов.

Харин өнөөх ноён Сильвио Мартинесийн зээ охин хааччихав? Бүсгүй одоо хүртэл алга байв. Морины нь төвөргөөн ч сонсогоо байжээ. Овоохой хүртэл шогшуулаад ирэхэд өлхөн хүрэхээр хугацаа өнгөрөв.

Исидора гарч ирэхгүй байгаад хүмүүс гайхаж, сэтгэл зовж, айж эхэллээ. Тэнд байгаа улсын дотор тэр мексик бүсгүйд хэдийнээс сэтгэлтэй олон хүн байлаа _

Түүнийг барьчихлаа гэж үү дээ?

Энэ асуултыг цөмдотроо бодон байв? гэвч хэн нь ч хариулж эс чадна.

Тэр үзэсгэлэнт бүсгүй зэрлэгүүдийг гарт орлоо гэж үү?

Цөм чих тавин чагнана.

Гэвч юу ч сонсогдсонгүй. Моин төвөргөөн ч, хүний хашгирах дуу ч алга, зөвхөн морьдынх нь хазаар зуузай хангир жингэр хийхээс өөр дуу алга.

Техасчуудын сэтгэл зовж эхлэв. Тэднээс ар\врал эржээ. “Техасчууд минь, нөхөд минь авраач!” гэж тэр бүсгүй хашгирсан ажээ.

Тэгээд мустангерын эсрэг хандсан цээж дүүрэн өшөө авахын хүслэн нь одоо улаан арьстнаас өшөө авахад чиглэгджээ.

Сэтгэл хөөрүү, зарим нэг нь цаашид хүлээхийг тэвчсэнгүй. Мориндоо харайн мордож, нэг бол бүсгүйг олж ирнэ эсвэл тэр чигтээдуусна гэж гал цогтойгоор мэдэгдлээ.

Тэднийг хэн ч хориглох юм билээ? Исидораг хөөу явсан хүмүүс тэдний эрээд байгаа бөнөөх алуурч ч байж болох юм. хэн ч тэднийг хорьсонгүй. Тэд Исидораг эрэн, тал нутгийн дээрэмчдийг мөрдөх болно.

Овоохойн дэргэд хэдхэн хүн үлдсэний дотор Зеб Стумп оржээ.

Өвгөн анчин индианчуудыг хөөх хэрэгтэй юу гэдэг саналаа хэлсэнгүй, дуугүй өнгөрөв. Түүний ганц сэтгэл ваих юм нь өвчтөнийг асрах болжээ. Морис ухаан ороогүй хэвээр Мустангерыг золгүй явдалд ороход нь ганц Зеб Стумп үнэнч үлдсэн биш, бас үзэсгэлэн гоо креол хүүхэн, хүний нүднээс элэгсэг дотноо нуусан хэр нь өвчтэй хүнээс нүд салгалгүй харсан хэвээр байлаа.

Өвчтөний толгой дээр мистер Морис хэмээн бөндөгнөх нь будлиудуу, инээдэмтэй Фелим байлаа. Фелим энэ хугацаанд царсан дээр гаран нуугдан сууж, өтгөн мөчрийн цаанаас овоохойны тэнд болж байгаа юмыг чимээгүй ажиглаж байжээ. Тэгээд байдал өөр болсон нь эцэгтээ түүнийг модон дээрээс айлтгүй буух болможтой болгон, Атлантын далайг хамт гаталсан эзнээ сувилж эхэлж байгаа нь энэ.

Дараагийн рэгэ явдал нь Аламогийн эргээс алс тэртээ өрнөх болно. Нэг цагийн дараа овоохой хов хоосон болов. Морис Жеральд энэ өлзийгөө өгсөн овоохой дотор дахин хэзээ ч орохгүй байж ч магадгүй.

LXVIII. Бүтэлгүй аян

Команч нарын эсрэг аян гурав дөрвөн хоногоос илүү хэтэрсэнгүй. Их хөндийн индианчууд ер нь байлдаан хийх гээгүй байжээ. Суурин руу тэдний довтолсон нь зүрх зоригтой хүн болох гэж оролдсон залуу улсын жирийн нэг саваагүйрхэл байв.

Иймэрхүү жижиг довтолгоон нь Техаст ерийн нэг үзэгдэл юм. Ихэвчлэн омгийн удирдагч чюм уу ахмадын зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр хийгдэнэ. Ийм уулгыг анд мордсон залуу дайнчид зөвхөн ангаас гадна өөр олзтой буцаж харихын тул хийх бөгөөд бусад нь энэ явдлын талаар ихэнхдээ бүүр сүүлд нь мэдэх нь бий. Хэрэв тиймгүй бол омгийн тэргүүлэгч нар нь энэ явдлыг зогсоох бөгөөд ийм явдлыг ухаангүйгээр барахгүй бүхөмөгт авултай зүйл гэж үзнэ. Гэлээ ч хэл амгүй аятайхан бүтээчихвэл бүгд сэтгэл ханамжтай үлддэг ажээ.

Энэ удаа залуу команчуудыг Сан-Сабын гүвээ дунд морин цэргийн буучдын анги замаас нь дайрчээ. нөгөөдүүл нь хөөж явсан малаа орхин, өөрсдөө Льяно- Эстакадогийн хавцал руу шурган амь гарчээ.

Ээн үржил шимгүй ийм ухаа дундуур индиануудыг мөрдөн нэхэхэд цэргүүдийг хүнс болно бусад зүйлээр хангахад хэцүү учир аюултай хэрэг байв. Амь үрэгдэгсдийн төрөл садан өшөө авахыг шаардсан боловч залхан цээрлүүлэх анги гаргахад сайн бэлтгэн хэрэгтэй гэж хариу хэлжээ.

Төвийг сахисан бүсээс цааш комагнч нар ухарсан учир цэргүүд хуарандаа буцаж очин, командлалаас ирэх тушаалг хүлээхээс өөраргагүй болжээ.

Нуэсес гол хүртэл хилийн бүсийг хамгаалдаг Инж цайзын цэргүүд хуарандаа буцаж ирээд хаашаа ч хөдлөлгүйгээр индиануудтай дайралдаж болох байж гэдгийг мэдэж аван ихэд гайхав. Байлдаанд гавьяа байгуулахыг хүссэн залуу офицерууд түүний дотор Генкок халагдсандаа байх суух газраа олж ядан байтал Леоны цаад эрэгт индиан үзэгдсэн гэдгийг сонсоод санаастэгэл нь сэрээд ирлээ.

Гэвч өөр нэг сэтгэл гонсойлгосон юм гарсан нь яг энэ өдөр Аламогийн хавиас буцаж ирсэн энгийн хүмүүсийн баг тэнд ямар ч индиан байхгүй гэж мэдэгдсэнд байлаа.

Тэд хэлснээ эд мөрийн баримтаар батлав. Морины дэлээр хийсэн хиймэл үс, ногоон улаанаар будсан тахианы өд, бугын арвсан өмд, чархи, хэдэн лааз будаг байв. Эд бүгдийг хөгшин улиангарын хонголоос олжээ.

Индиануудын эсрэг дайлаар мордох тухай санахын гарз болжээ. Баатарлаг гавьяа байгуулахыг мөрөөдөгчид хөөрсөн сэтгэлээ дарж, тайван амьдралаа үргэлжлүүлэхээс өөр аргагүй болов. Тэгээд ч бас эл зэлүүд ширэнгэд бодол болон, харилцан ярилцмаар сонин нууцлаг үйл явлал гарсан байлаа.

Юуны өмнө тун саяхан урьд үзэгдээгй үзэсгэлэнтэй залуухан бүсгүй энд нүүж иржээ. Дараа нь түүний дүү битүүлэг алга болж алагдсан гэж тооцогдох болов. Цаашилбал морь унасан толгойгүй хүн бий болсон нь бүр ч битүүлэг явдал. Индиан болж зүсээ хувиргасан цагаан

арьстны паян, Генри Пойндекстерыг алсан гэж сэжиглэгдсэн хүн баригдаж, цэргийн гянданд өөрийн ухаангүй хоригдож өайгаа тухай мэдээ зэрэг үлэмж битүүлэг хачин явдлууд гарч иржээ. Залуу офицерууд ч янз бүрийн сонин зүйл нэмэн ярьж, уйтгарлан гансрах цаг гарахгүй байлаа. Хосгүй үзэсгэлэн гоо бүсгүй Исидора Коварубио де Лос-Льяносын нэр яриа болгонд дурсагдана. Тэр нь бүгдийн сэтгэлийг сэрхийлгэсэн битүүлэг явдалтай ямар нэг талаар холбоотой гэсэн үг яриа ч гарчээ.

Аламод болсон хамаг явдал мустангер овоохой дотроо өвчтэй байж байгаад олдсон, хүмүүс түүнийг дүүжлэх гэж шийдсэн, луиза Пойндекстер түүнд нь саад болсон, Зеб Стумп зоригтой хамгаалж өмгөөлсний үрээр хэргийг дахин хянаж үзэх болсон зэрэг энэ бүхэн нь эцэс төгсгөлгүй яриа, таамаг цуу үгийн сайхан шалтаг болжээ.

Гэлээ ч Генри Пойндекстерыг алсан хэрэгт холбогдсон мустангерын буруутай эсэх тухай өрнөсөн маргаан хамгийн их хөгжөөнтэй нь байв.

-Миний бодлоор бол Морис мустангер хүн алж гэмт хэрэг хийх хүн биш гэж ахмад Слоумен гүн ухаантны буурьтай хэлээд - Би үүнийг батлахаар тэр залууг сайн мэддэг гэж бодох юм гэв.

-Хамаг гэрч, баримт түүний эсрэгбайгааг та үгүйсгэж чадахгүй. Түүний гэм буруутай гэдэгт маргах юм бараг алга гэж Кроссмен хэллээ.

Кроссмен тэр ирланд залууд хэзээ ч талтай байсангүй. Бэлтгэгчийн зээ бөгөөд цайзын урдаа барьдаг сайхан хүүхэн нь сайхь адал явдал эрэгч рүү дэндүү шохоорхон ширтэж байх шиг түүнд нэг удаа санагдсан ажээ.

-Тэр гэрч баримтыг хангалттай гэж үзэхгүй байна хэмээн Слоумен хару өчлөө.

-Гэвч залуу Пойндекстер алагдсан гэдэгт эргэлзэх юм байхгүй биз дээ. Энэ бол маргашгүй зүйл. Тэгэхээр хэн түүнийг алсан байх нь вэ? Жеральд тэр залуу хоёрын муудалцаж байхыг сонссон гэж Колхаун тангараглаад байгаа.

-Хэрэв өөрт нь ашигтай бол тэр хүн юу ч гэж тангараглахаас буцахгүй гэж морин цэрэг Генкок ярианд оролцоод - Түүнээс гадна мустангертай түнжин хагарсан нь түүний нотолгоог эргэлзээтэй болгож байна. Тийм биз дээ? гэв.

-Залуу Пойндекстер мустангер хоёрын хооронд маргаан гарсан юм гэж бодъё. Тэглээ гээд ву болох юм бэ? Энэ бол хүн амины хэрэг гарахын нотолгоо болж чадахгүй гэж явган цэргийн офицер үргэлжлэн хэллээ.

-Тэгэхээр та мустангер Пойндекстер хоёрын хооронд ирүүл тулаан болжээ гэж бодож байгаа юм уу?

-Тиймэрхүү юм болсон байж болох юм. Болохоор ч барахгүй тэгсэн байж таарна гэдгийг би үгүйсгэхгүй.

-Гэвч тэр хоёр юунаасаа болж мууцалцдаг билээ? гэж Генкок асуугаад - Мустангер хэдийгээр

Колхауныг шархуудсан боловчзалуу Пойндекстер, мустангертай найзархаг харьцаатай байсан гэж дуулсан юм байна. Тэр хоёр юунаас болж хэрэлдсэн байх билээ? гэв.

-Дэслэгч Генкок ийм асуулт тавьж байгаа хүн нь та шүү гэж Слумен учиртайхан өгүүлээд - Эрэгтэйчүүд нэг юмнаас... өөрөөр муудалцана гэж байдаг юм уу гэлээ.

-Хүүхнээс өөрөөр гэж үү? Хэмээн морин цэрэг хөндлөнгөөс орон - Гэвч ямар хүүхнээс болж муудалцсанаыг би ойлгохгүй байна. залуу Пойндекстерын эгчээс л болж муудалцдаггүй юм бол, өөр хэн байхав дээ гэв.

-Яаж мэдэх вэ! гэж Слоумен дал мөрөө учиртайхан хавчиж хэлэв.

-Ямар утгагүй юм бэ! гэж Кроссмен дуу алдаад зэрлэг адууны анчин хүн Пойндекстер авхайг мөрөөдөж зүрхэлнэ гэж үү? Байжболомгүй хэрэг! Гэв.

-Кроссмен та мөн ч сүрхий язгууртан юм даа! Дурлал гэдэг бүр угаасаа ардчилсан үзэлтэн агаад таны наад нийгмийн тэгш бус байдлын тухай онолыг чинь хайхарч тоохгүй гэдгийг та мэддэггүй юм гэж үү? Энэ нөхцөлд би юу ч нотлох гэж оролдохгүй. Тэр хоёрын маргаан мисс Пойндекстерээс болоогүй байжболно. манай цайзынхыг ярьдаггүй юмаа гэхэд Леоны эргээр үзэсгэлэн төгөлдөр авхайчууд бишгүйдээ л бий.

Кроссмен цаадахийнхаа үгийг гэнэт тасалж, ууртайгаар

-Ахмал Слоумен! Таны бодлыг би гайхаж байна. Манай хүүхнүүд таны энэ хэлж байга ёозгүй юманд баярлах нь юу л бол

-Эрхэм минь ямар ёозгүй юм?

-Тэр хүүхнүүдийн дотроос энэ хүнтэй ярилцах хүүхэн нэг ч бол олдоно гэж та бодож байна гэж үү?

-Алинтай нь? Би хоёр ч хүнийг хэлсэн.

-Слоумен та миний үгийг сайн ойлгож байгаа. Би ч гэсэн таны хэлснийг бас л сайн ойлгож байна. Үнэндээ манай хүүхнүүд энэ хүн алагч гэж сэжиглэгдсэн зальхай морины хулгайчтай нэрхолбогдохдоо маш их сэтгэл ханах болно доо.

-Морис мустангер бол зальхай ч хүн биш, морины хулгай ч биш. манай эмэгтэйчүүдийн нэг нь ч түүнтэй ярихгүй гэж батлаад байгаагийн чинь хувьд бол та андуурч байна. Мистер Кроссмен, би түүнийг сайн мэддэг бөгөөд тэр залуу бол боловсролын хувьд бидний хэнээс ч доророхгүй гэдгийг батална. Манай хүүхнүүд түүнтэй танилцахаас айх хэрэггүй юм. Нэгэнт энэ асуултыг та хөндсөн болохоор хүүхнүүд, үгүй ядахдаа зарим нэг нь түүнээс айэ цэрвэх нь юу л бол гэдгийг нэмээд хэлчихье. Морис мустангер манайхны хүүхнүүд дотор байхдаа үнэхээр буурь сурьтай, даруу төв байдалтай байхыг би олон удаа ажсан юм. Энэ бүхнээс гадна Морис тэр хүүхнүүдийн хэн нэгийг шохоорхоно гэдэгт би тун их эргэлзэж байна.

-Нээрээ тийм гэж үү? Тэгвэл түүний өрсөлдөгч болсон хүн мөн ч азтайяа!

-Магадгүй гэж явган цэргийн ахмад тайвнаар хариу өчив.

-Бас нэг ийм юм байж болох юм даа... хэмээн Генкок эвгүй яриаг орхиё гэсэн бололтой хэлээд - Нөгөө гарсан гээд байгаа хэрүүл маргааны шалтгаан нь одоо хүн болгоны амнаас гарахаа байсан үзэсгэлэнт авхай байж болох юм биш үү! Би тэр хүүхнийг хараагүй, гэвч сонсоод байхад түүнээс болж нэг бус ирүүл тулаан гарах юм байна гэж бодсон шүү гэв.

-Болох л юм гэж ирланд эр бэлтгэгчийн зээд огт хамаагүй гэдэг санал гаргасанд баярласан Кроссмен дуугарав.

Генкок үгээ үргэлжлүүлэн дөнгөж сая сонссон сониноо дуулгаж \энэ яриа команчийн эсрэг дайлаар мордож ирсний дараахан болжээ\

-Тэр хүнийг цэргийн шоронд хийсэн гэнэ. Тэнэг муу зарц нь ч цуг хоригдсон юм байх. Харинхоёр давхар санаа харуул гарга гэж хошууч тушаал өгсөн нь сонин юм. Тэгэхээр энэ юу гэгч болж байна даа% ахмад Слоумен гуай, Та мэдээж бусдаас илүү тайлбардаж чадна даа. тэр хүн шоронгоос орших гэсэн юм биш биз дээ?

-Өөрөө хаана байгаагаа ч мэдэхгүй байгааг нь бодоход, тийм байх боломжгүй юм. Би дөнгөж сая тийшээ очоод ирсэн_ Ухаан нь балартсан хэвээр байна. Толинд харуулдаг юм гэхэд өөрийгөө танихгүй байх.

-Ухаан нь балартсан гэнээ?... Энэ чинь юу гэсэн үг вэ? хэмээн болсон явдлыг нэгд нэгэнгүй сонсоод байгаа Генкок болон бусад офицерууд асуув.

-Тэр хүн их халуурсандаа дэмийрээд байгаа юм

-Үүнээс болж харуул манааг нь чангаллаа гэж үү дээ? хачин жигтэй юм. Хошууч өөрөө л хийрхсэн байж таарлаа.

-Энэ маань хошуучийн эхнэрийн санал, чухамдаа гэвэл тушаал байж болно шүү дээ? Ха-Ха-Ха!

-Гэвч энэ ямар учиртай юм бэ? Мустангерыг манаанаас зугтаана гэж өвгөн маань бодлоо гэж үү дээ?

- Минийхээр болхэргийн учир энд байгаа юм бишээ Хошууч харваас хэн нэгэн хүн тийшээ орчихно гэдгээс л илүү болгоомжлоод байна.

-Үгүй ер, хараач хөөе.

-Тиймээ, Морис мустангерын хувьд хориотой байх нь аюулгүй юм. Суурингаар сэжигтэй хүмүүс хөлхөн, Линчын шүүхийн тухай яриа дахин цухалзаж байна. Азтай л эр юм. Өвгөн анчин түүнийг хамгаалан, бид ч цагийг нь олж буцаж ирлээ. Дахиад нэг өдөр болсон бол Морис Жеральдыг амьд харахгүй байсан юм. Одоо ямар ч байлаа гэсэн хөөрхий амьтан ёс журмын дагуу үнэхээр шүүгдэх болно.

-Хэзээ шүүх юм бэ?

-Ухаан мэдээ ормогц нь

-Бүтэн сар ч хүлээж мэдэх нь байна шүү дээ.

-Хэд хоног юмуу, хэдэн цагийн дараа ч сэргэх юм билүү. Шарх нь тийм айхтар юм биш билээ. Сэтгэл нь дэндүү их догдолсноос ухаан балратсан бололтой. Нэг өдөр л бүх юм өөрчлөгдөж болох юм. Түүнийг ухаан оронгуут нь л нэн даруй шүүхийгшаардаж байгаа хүмүүс байгаа юм. Шархы нь анихыг хүлээхгүй дэгээ.

-Гэмгүй гэдгээ нотолж чадах бол уу? Чадна байх гэж итгэж байна хэмээн Генкок хэлэв.

-Тун итгэлгү юм. Юу болохыг нь харъя л даа гэж Кроссменыг татгалзан хэлэхэд

-Би бол тэгнэ гэдэгт итгэж байна гэж Слумен хэлэхэд хоолйн өнгөнд нь итгэлээс гадна тэгээсэй билээ гэсэн хүсэл оргилсон байлаа.

LXIX. Гашуудал, нууцлал

Каса -Дель-Корво ордонд уй гашуу дал болж байв. Вудли Пойндекстерын гэр бүлийнхний хооронд ямар нэг оньсого таавар мэт битүүлэг харьцаа бий болжээ. Тэд зөвхөн гурвуулхнаа үлдсэн байв. Тэд урьд өмнөхөөсөө улам цөөн уулздаг болж, уулзахдаа нэг л хүйтэн, биеэбарьцгаана. Зөвхөн хоол цай идэж уухдаа бие биеэ харалцан гагцхүү хамгийн чухал юмны тухай л ярилцана.

Эл уйтгар гуниг нь учрыг ойлгож ядах юмгүй бөгөөд тэдний үг дуугүй байгаа нь ч зарим талаар ойлгомжтой.

Хэн ч эргэлзэхээ больсон үхэл, ганц хүү, ор ганц дүүгийнх нь санамсаргүй битүүлэг үхэл эцэгт ньч , эгчид нь ч аюултай цохилт болжээ. Нас барагчийн үеэл ах Кассий Колхауны уйтгар гунигийг ч үүгээр тайлбарлаж болно.

Гэвч хэргийн учир нь зөвхөн үүнд биш байлаа.

Тэд хааяа нэг гэр бүлийн гашуудал зовлонгоо ярихдаа хүртэл яагаад юм бэ бие биенээсээ жихүүцэн биеэ барьцгаадаг болжээ.

Цөмий нь гашуудал зовлонгийн зэрэгцээгээр дор бүрдээ бас ямар нэгэн нууцыг гунигтай бөгөөд тэр нууцаа хэлэхгүй, хэлж ч чадахгүй байлаа.

Хуучин ихэмсэг бардам байдаг зээн одоо гадагш гарахаа больжээ. Тэр нэг тасалгаанаас нөгөө рүү, эсхүл байшингийн гудам дундуур бүтэн цагаар холхин алхална. Хүнд гашуун зовлон нь ихэмсэг баөйдлыг нь эвдэж, зүрх сэтгэлийг нь шархдуулжээ. Гэвч гагцхүү алагдсан хүүгийнхээ төлөө эмгэнэл гашуудал нь өвгөнийг зовоож байгаа төдийгүй, түүний амнаас үе үе гарч байгаа ойлгомжгүй хараалын үгс өөр санааг илчилнэ.

Колхаун хуучин шигээ дандаа л хаашаа ч юм явяхаад, наад хоёрыгоо хоол идэхээр ширээний ард сууж байхад юмуу, эсхүл унтахаар хэвэтж байхад нь ирнэ. Заримдаа бүр үзэгдэхгүй болчихно.

Луиза бараг ихэнх цагаа тасалгаандаа сууж өнгөрөөнө. Үнэндээ зарим үед асотей дээр гарах боловч зөвхөн ямар нэг юм бодсон шинжтэй зогсоно. Тэнд хөх тэнгэрийн дор зогсоод, нас барсан дүүгийнхээ төлөө гашуудаж, хайртай хүнээ алдахаас айж өөрийн нь нэртэй холбогдсон хэрүүлийн тухай тааламжгүй бодол зэрэг зовлонгоо эдлэхэд нь амар байдаг байжээ.

Сүүлчийнх нь сэтгэлийг хамгийн бага зовооно. Морсиын хувьд заяанд л хамгийн ихээр сэтгэл зовно. Эхлээд тэсвэрлэхийн аргагүй байсан алагдсан дүүгийн нь тухай гуниг жаахан дарагдаж эхэлжээ.

Морис Жеральд цэргийн шоронгийн бат бэх хананы цаана хориотой байгааг мэдэж байв.

Гэвч тэр хананы нэвтэршгүй бат бэх нь түүний сэтгэлийг зовоосонгүй. харин хангалттай бөх

бат биш байгаадаа хэмээн айж байв. Луизад ингэх үндэс байжээ. Түүнд аймаарцуу үг сонсогдсон аж.

Шинээр эхлэх Линчын шүүхийн тухай ярилцах болжээ. Энэ удаа шүүгчийн үүргийг Сэм Мэнли биш түүний хүмүүс гүйцэтгэх бөгөөд тэдгээр нь хилийн суурингууд, ялангуяа, цэргийн цайзын орчим элбэг тохиолддог хагуу ширүүн, нэг ёсны дээрэмчид байлаа. Энэ яриа олон хүний гайхшийг төрүүлжээ. Хоригдож байгаа хүнийг яагаад дахин хуульбусаар шүүх болов гэдгийг ойлгоход бэрх байв. Сүүлийн үед гарч ирсэн баримтууд байдлыг өөрчлөгөөгүй бөгөөд ямар ч байсан мустангерыг гэмт этгээд мөн гэж нотлох ямар ч шинэ баримт нотолгоо байхгүй байв.

Хэдийгээр модны хонгилоос олдсон зүйл дөрвөн морьтныг индианууд биш гэдгийг нотолж байсан ч тэднийг Генрийн үхэлд буруутан гэж үзэхэд болохгүй гэхийн аргагүй байлаа.

Тийн байтал хоригдож байгаа хүний эсрэг энэ дайсагнал яагаад бас дахин дүрэлзэв? Энэ бүхэн ихэд жигтэй бөгөөд олон хүний толгой эргүүлжээ. Зөвхөн гуравхан хүн л энэ дайсагналын учрыг ойлгож байгаа буюу эсвэл сэжиглэн таамаглаж байлаа. Энэ бол Зеб Стумп, Луиза Пойндекстер, Кассий Колхаун гурав юм.

Ажигч гярхай анч өвгөн, Мигуэль Диас болог түүний хамсаатнууд гэнэт өөрсдийн ижил холхиогоо алдсан юмнуудтй жигтэйхэн сүлбэлдээд эхлэхийг ажиглажээ. Тэднийг турхирагч нь Кассий Колхаун гэдгийг ч мэдэв.

Зеб Стумп өөрийн сэжиглэлийн тухай залуу креол хүүхэнд мэдэгдэхэд Луиза

уул явдлын чухлыг, ямар уршиг тавьж болохыг ойлгожээ. үүнээс болоод бүсгүйн сэтгэл ихэд түгшиж байлаа.

Бүсгүй шинэ мэдээ сургийг жархай чих тавьж цайз руу ирдэг замыг тэндээс өөрт нь цаазын тогтоол ч юмм уу, амьдралын найдлагыг авчрах элчийг хүлээж байгаа мэт анхааралтай ширтэн харна. Бүсгүй шоронгийн дургэдүүр үзэгдэхийг үл зүрхэлнэ. Хаалганд харуул зогсох бөгөөд эргэн тойронд гэмт хэрэгтний ойролцоо байхдаа бах нь ханаж байдаг улс бүхэнд үзэгддэг хий ажилгүй ангалзсан хүмүүс бөөгнөрнө.

Тэгээд бас хоригдож байгаа хүн нь галзуу, түр зуур ухаагүй болсон хүн учир бүр ч сонирхолтой байжээ.

Хэрэв луиза дүүрсэн хэрэг гэж бодсон бол энэ нь түнүийг хорихоор зүйл биш байлаа. Гэвч аль хэдийнээ хар авсан эцэг нь түүнийг хараанаасаа гаргасангүй. Түүнээс гадна ураг төрлийн нь бас нэг хүн, түүний нэр хүндийг олны өмнө багагүй идэвхтэй хмагаалж байжээ.

Луизад гэртээ суухаас өөр арга байсангүй. Өрөөндөө түгжиж аваад Аламод өвчтөний хажууд байхдаа сонссон үгийг дурсан өөрийгөө тайвшруулахыг хичээн, эсвэл асотей дээр гарч хуайсны дунд өнгөрөөсөн аз жаргалтай мөчөө дурсан, тэгснээ дахин бүгдийн зүрхийг эзэмдсэн тэр хүн дор үзэгдэн, шившиглүүлж шоронд хаягдсаныг тэндээс зөвхөн цаазлуулахаар л гарч ирэх болж ч магадгүй хэмээн гуниглана.

Дөрөв дэх өдрийн нь өглөө Каса-Дель-Корвод, Зеб Стумп ирж, индиан нарын эсрэг явуулсан “анги цайзад эргэж ирлээ” гэсэн мэлээ сонсгосон нь Луизаг ихэд баярлуулжээ. Энэ бол олон зүйлийг хэлсэн хэрэг байв. Баригдсан хүнийг аврахын тулд биш, алахын тулд харуулаас нь булаагаал авчихна гэж одоо айх хэрэггүй болжээ.

-Одоо санаа зовохгүй байж болно гэж Зебитгэлтэй хэлээд - Луиза авхай минь, одоо энэ аюул өнгөрөсөн, би зохих арга хэмжээ авлаа гэв.

-Зеб, ямар арга хэмжээ вэ?

-Юуны өмнө би хошуучийг буцаж ирэхтэй нь зэрэг түүнтэй уулзсан. Тэгэд илэн далангүй ярилцлаа. Би өөрийнхөө мэдэж байгаагийн хэрээр уг явдлыг цөмий нь түүнд ярьж өглөө. Аз болоход мистер Морисынэсрэг юм бодоогүй хуучин шигээ л түүнд талтай байдгаа хэлж байна. Дараа нь энэ америк, мексик болон бусад өөдгүй амьтдын тухай ярилаа. Тэдний дундаас хамгийн хорт этгээд байж мэдэх Диасыг ч хэлэхээ мартаагүй шүү. Тэгж хэлсний үрээр хошууч давхар манаа хамгаалалт гаргахыг тушаалаа.

-Яасан сайн юм бэ! Тэд нараас одоо айхын хэрэггүй боллоо гэж та бодож байна уу?

-Хэрэв Мигуэль Диасын дээрэмчдийн тухай ярьж байгаа бол тийм гэдгийг андгайлсан ч болно. Диас өөрөө эхлээд шоронгоос мултраг, тэгээд харья.

-Юу гэнэ ээ? Диас шоронд орсон гэнэ ээ? Яагаад? Хэзээ? Хаана?

-Луиза авхай, та надад нэг зэрэг гурван асуулт тавьчихлаа. За яах вэ! Таллыг бодож сүүлчийнхнээс нь эхэлье! Тэгэхээр хаана гэж асууж байнаа даа? Энэ нутагт зөвхөн ганц л шорон байдаг юм. Энэ бол цайзын цэргийн шорон гэж хэлэх байна. Диас тэнд бий.

-Түүнтэй цуг...

-Хэнийг хэлж байгааг чинь би мэдэж байна. Тиймээ, та таачихлаа. Тэд нэг тасалгаанд биш ч гэлээ нэг байшинд байгаа. Хооронд нь нимгэн хана бий. Гэхдээ бүх юм нэвт сонсогддог юм. хэрэв тэд хүсэх л юм бол хоорондоо ярьж болно. Тэр мексиктэй хамт гурван ханьхамсаатан нь сууж байгаа. Тэдний хувьд мэдээж, ярих юм олдолгүй яахав.

-Зеб минь, энэ чинь сайхан мэдээ байна. та өчигдөр надад хэлэхдээ, Диасыг өөрөө л...

-Шоронд орох гээд зүтгээд байсан гэж үү. Энэ нв бузгай бүтчихсэн шүү. Эсвэл хэн нэг хүн тусалсан бйх.

-Харин хэзээ яаж орсон нь хэлж өгөөч?

-Ээш та яасан их яарах юм бэ? Жаахан амьсгаагаа дараадхья. Таны хоёр дахь асуудал чинь хэзээ гэж байгаа. Үүнийг хариулахад түвэггүй. Барагцаалбал нэг цаг орчмын өмнө түүний ард шоронгийн хаалга хаагдаж байхыг би харсан. Дараа нь би шууд наашаа ирлээ.

-Харин түүнийг яагаад баривчлагдсаныг та надад хэлээгүй шүү.

-Хараахан амжаагүй л байна, мисс Луиза. Энэ бол их урт түүх болохоор их цаг эзэлнэ. Та түүнийг одоо соносох уу, эсвэл... юуны дараа...

-Юуны дараа гэж Стумп гуай?

-Танд юу гэж хэлье дээ... луиза авхай, би... хөгшин гүүгээ саравчинд аваачсаны дараа л гэж хэлж байгаа царай нь тэр. Гүү мааньэрдэнэ шиш ч юм уу, тиймэрхүү л нэг юм зажилж, жаахан бантангаар хоолойгооо норгохыг хүсч байгаа нь илт байна. Бид хоёр залхатлаа явж явж зөвхөн цагийн өмнө цайзад ирсэн юм.

-Эрхэм Стумп гуай, намайг уучлаарай! Би энэ тухай бодсонгүй... Плутон, чи Стумп гуайн морийг саравчинд аваачаад сайн тэжээгээдэх... Флоринда! Флоринда!... Танд юу захиалах вэ, Стумп гуай?

-Их баярлалаа. Луиза авхай минь миний төлөө битгий санаа зов. Би зөвхөн гүүгээ бодсон юм. Миний хувьд би дахиад хоёр цаг юм идэхгүй байж дөнгөнө. хэрэв танайд мононгахелийн виски маягийн юм байвал над шиг хөгшин хүнд сэтгэлээ засахад ашигтай байхсан.

-Мононгахелийн виски юу? Зөндөө бий. Гэвч түүнээс дээр ямар нэг юм барихыг зөвшөөрнө үү?

-Мононгахелийн вискинээс дээр гэнээ?

-Тийм ээ, Херрес, шампань дарс ч юм уу, эсвэл коньяк уухгүй юу?

-Үгүй, тэр франц дарс надад хэрэггүй. дурладаг нь ууг. Францад амттай дарч байж болно. хэрэв байдаг бол танайд л байгаа гэдэгт би итгэж байна. Гэвч би цэргийн худалдаачныхаас амч үзсэн юм. Хэрэв эм бол ч өөр хэрэг. Матрын гэдсийг ч эргүүлчихэж магадгүй эд дээ. Тэр франц сувс чинь хэрэггүй ээ. Ялангуяа коньяк гэдэг нь бүр ч дэмий. Харин Мононгахелийн эрэг дээрх Литтсбургээс авчирсан цэвэр эрдэнэ-Шишийн шүүс илүүү байж магад

-Флоринда! Флоринда!

Зарц хүүхэнд, өөрий нь яах гэж дуудсаныг хэоэхгүй байж болох юм. Зеб Стумп тэнд байж байгаа нь түүнийг ву гэж дуудсаныг улаан цайм хэлээд өгнө. Зарц хүүхэн тушаал хүлээлгүйгээр гарч, анч өвгөний”эрдэнэ шишийн цэвэр шүүс” гэж нэрлэдэг бөгөөд цуг чанартаа бол хөх тариаг боловсруулж хийсэн архиардүүргэсэн шилэн сав барьсаар минутын дараа эргэж ирэв.

Зеб архи уухыг гуйлгасангүй. Шилэн савгай шингэн юмны гурваны нэг хувь нь тэр дорхиноо алга болов. харин өөрийн эдлэгж байгаа урт удаан ярианы дундуур хоолойгоо норгож байх гэж нөгөө гуравны хоёр хувий нь үлдээжээ.

LXX. "Яв даа Зеб таныг бурхан тэтгэг"

Анч өвгөн юуг ч яаруу тэвдүү хийх дургүй хүн. Архи уухад нь ч энэ харагдана, одоо ч гэсэн бахь байдгаараа архиа яаралгүй шимэн ууна.

Креол хүүхэн түүний өөрөө ярьж эхлэхий нь хүлээлгүй тэсч ядан? Зарцаа явуулчихаад,

-Тэр мексикийг яагаад баривчилсан юм бэ? Эрхэм Зеб минь хэлж өгөөч. Мигуэль Диасыг хэлж байна. Би түүний тухай ямар нэг юм мэддэг шиг санагдаж байна гэв.

-Луиза авхай минь, тэр муухай амьтны ов мэхийг ганц та ч биш, олон хүн мэдэж байгаа юм. Таны дүү... харин энэ тухай одоо ярихгүй. Харин Зеб Стумп түүнийг... нэг хүнтэй холбоо харилцаатай гэдгийг мэдэх ч юм уу эсвэлтун их сэжиглэж байгаа юм. Та миний юу ярих гээд байгааг ойлгож байгаа биз дээ?

-Цааш нь ярь л даа, Стумп гуай.

-За тэгвэл ийм юм. Биднийг Аламогоос буцаж ирсний дараахан индиан нарын хойноос хөөсөн залуус буцаж ирлээ. Ерөөсөө индианууд ыиш байжээ гэдгийг олж мэдсэн билээ. Та үүнийг лав сонссонбайх. Модны хөдийгөөс олдсон баг, өмсгөл бидний өнөөх хясаан дээр гарч ирэхий нь харсан улс улаан арьстан биш байсныг тодорхой нотолж байна. Би овоохойгоос хөзөр олохдоо энэ тухай бодож байсан юм.

-Тэгэхээр шөнө овоохойд орёсон, Фелимийн харсан улс эд байх нь ээ?

-Яриагүй мөн. Энэ бол нөгөө мексикүүд мөн байна.

-Татгэднийг мексикүүд гэж ямар үндсэн дээр хэлж байгаа юм бэ?

-Маш амархан. Би өөрөө үүнд итгэсэн юм. тэр дээрэмчид хаашаа, хаана нуугдсаныг би нэг нэгээр нь мөшгөсөн юм.

Залуу креол хүүхэн өөр юм асуусангүй. Анчны яриа түүнд шинэ найдлага төрүүлж ярианых нь үргэлжлэлийг маш анхааралтай хүлээн, дуугүй зогсч байв.

-Луиза автай та бод л доо. хөзөр, бас тэрчлэн ирланд хүний давтан хэлсэн тэдний үг нь тэдгээрийг мексик хүмүүс юм гэсэн санааг надад төрүүлсэн юм. Үүнд итгэж аваад тэдний чухам хаанаас гарч ирж болохыг амархаан барагцаалан тааварласан юм. Би нутгийн хүмүүсийг сайн мэддэг болохоор тэр дөрвөн хүнийг чухам хэн болохыг нь гаднах тодорхойлолтоор нь гадарлаж байв. Тэдний индиан хувцас намайг хуурч дөнгөөгүй юм. Үүнээс гадна би тэдний нэгд нь тэмдгээ тавьчихсан байлаа.

-Тэмдгээ тавьсан гэнээ? Зеб, яаж?

-Миний буудсаныг санаж байна уу?

-Би таны гохоо дарахыг харсан. Харин хэнийг буудсаны чинь ажиглаагүй. Мод халхлаад байсан юм.

-За тэгэхээр Луизаавхай минь өвгөн Стумп гох дарсан байхад сум нь байны хажуугаар өнгөрнө гэж байдаггүй юм. Би тэр муу нохойг оносноо мэдэж өбайсан юм. Холоос буудсан болоод сум жаахан чалчсан боловч түүнийг шархдуулсан гэдэгт би итгэж байлаа. Би түүний татваганахыг хараад “хэрэв түүний арьсыг цоолоогүй бол би өөрийнхөөрөө солиход бэлэн байна” гэж бодсон юм. Үүний дараа залуучууд эргэж ирээд бидэнд улаан арьстны тухай биш, цагаан арьстны тухай ярилаа. Би тэр индиан нарын чухам хэн болохыг тжн сайн мэдэж байсан бөгөөд тэднийг барьж авч болох байсан боловч тэгээгүй өнгөрсөн юм.

-Яагаад тэр вэ, Стумп гуай? Энэ чинь хөөрхий дүүгий минь алсан улс байжмагадгүй шүү дээ!

...

-Харин тийм болохоор л би тэднийг өдөж сэдээгүй юм. Өөр бас нэг шалтгаан байсан нь намайг эзгүй хойгуур юу ч болж мэднэ гэж айгаад би цайзаас хол явахыг хүсээгүй юм. Та ойлгож байна уу? за тэгээд энэ бүхнээс гадна уг хэргийг туйлд нь хүргэхэд арай эрт байна гэж санах. Би үүнийг алдаагүй хийхийг хүсч байлаа.

-Та тэгээд түүнээ хийгээ юу?

-Хийхээр барах уу! Би цэргүүдийг буцаж ирэхийг хүлээсэн юм. тэгвэл эрхэм Морисыг найдвартай харуул хамгаалалтанд санаа амар орхиж болох байлаа. Зөвхөн үүний дараа би хөгшин гүүгээ эмээллэж аваад, өнөөх баг өмсгөл нуусан газар руу очсон юм. Би залуу нөхдийнхөө тодорхойлсон ёсоор тэр юмыг амархан олжавлаа. Тэднийг нөгөө жулдрай Спенглер дагуулж аваачсан бөгөөд тэд мөрийг гүйцэд ажиглаагүй, надад ч гэсэн зэгсэн хийх юм үлдсэн гэж мэдэж байдаа. Тэгээд ч андуурсангүй. Та нутагт л нэгэн цагт байсан бол ямар ч тэнэг тэр хуурамч команч нарын буцсан мөрийг олж чадах байсан юм. Жирийн нэг худалдаачин ч гэсэн тэдний мөрийг олж чадна. Харин мистер Спенглер л, бусад нь ч гэсэн үүнийг хийж чадсангүй. Хэдийгөөр мөт нь морины туурайд гишгэгдэж баларсан боловч би наадам болгон бүгдийг шалгаж үзлээ. Дөрөвн морины мөрийг нэг бүрчлэн хөөж, саравчинд нь тулгал мөрдлөө.

-За тэгээд дараа нь?

-Дараа нь би хошуучтай ярилцлаа. Хагас цагийн дараа дөрвөн сайхан амьтан шоронгийн торын цаана суув. Толгойлогчий нь урьдаар барьж авсан юм. Тэгээгүй бол тэр зайлж алга болох байлаа. Би Мигуэль Диасад тэмдгээ тавьсан гэж нотолсон маань алдсангүй. Сум баруун гары нь оножээ. Тиймээс ч бугуйлаа алдсан байж.

-Буудуулсан хүн чинь тэр юм уу? гэж Луиза өөрийн эрхгүйасуугаад бодол болон байснаа - Тун хачин юм... гэж өөртэйгээ ярих мэт дуугараад - Би түүнийг шугуйн чөлөөнд харсан юм байна. Эргэлзээгүй тэгжээ. Харин өнөөх мексик хүүхэн Ияасан бэ? өө, үүнд ямар нэг өөдгүй нууц байна даа! гэж хэлээд Луиза анч өвгөнд ойртож - Эрхэм Зеб минь надад хэлээч дээ. Тэр мексик хүүхэн... тэр сеньорита... тэнд байсан тэр хүүхэн... тэднийд дандаа очдог байсан юм уу? гэж асуув.

-Хэнийд? Луиза авхай та хэний тухай асууж байна?

-Мистер Жеральдын

-Дандаа ч байж болох юм, үгүй ч байж болох юм, энэ талаар надад мэдэх юм алга _ Би өөрөө ч тэнд очих нв ховор шүү дээ. Би ер нь тэрүүгээр ан гөрөө хийж явдаггүй. харин заримдаа газар солихын тул түүгээр дайраад гардаг юм. Цацагт хяруул, буга буудахаар түүгээр дайраад гардаг юм. Тэнд ч элбэг байдаг юм. хэрэв та миний бодлыг асууж байгаа бол тэр хүүхэн урьд нь тэнд огт очиж байгаагүй гэж бодож байна. Наад зах нь би энэ тухай юу ч дуулаагүй. Хэрэв осчон бол Фелим лав аль хэдийн донгосох байсан биз. Би харин тэр овоохойд айлчилсан ганц л эмэгтэй хүний тухай сонссон юм.

-Хэн бэ? гэж креол хүүхэн бушуухан асуучихад тэр дорхиноо түүндээ харамсав. Бүсгүй Зебийн учиртай харцыг ажиглаад хацар дээгүүр нь тод улаан туяа татаад, хариу хүлээлгүй үгээ үргэлжлүүлж, - Гэвч энэ нэг их чухал юм биш. Тэгэхээр Зеб та, энэ хүмүүсийг энэ мексикчүүдийг дүүгий минь алсан хэрэгт оролцсон гэж бодож байна уу? гэв.

-Танд үнэнээ хэлэхэд би... юу гэж бодохоо мэдэхгүй байна. та нутагт тийм битүүлэг явдал хэзээ ч тохиолдож байгаагүй юм. заримдаа мексикчүүдийн хийсэн ажил гэж санагдах юм. Заримдаа толгойд өөр бодол орж ирээд, тэр үедээ энэ хэрэгт хэн нэгэн хүний гар оролцжээ гэж бодогдох юм. Би одоохондоо чухам хэн гэдгийг хэлэхгүй.

-Зеб тэр л лав биш, тэр хүн л лав биш шүү!

-Үгүй ээ, энэ бол мустангерын хийсэн хэрэг биш, үүнд тэр ямар ч хамаагүй. хэдийгэр маш олон хүн түүний эсрэг ярьцгааж байгаа боловч би түүнийг гэмгүй гэдэгт агшин зуур ч эргэлзэхгүй.

-Гэлээ ч түүнийгээ яаж баталж нотлох юм бэ? Бүх баримт нотолгоо түний эсрэг байь. Тэгээд хэн ч түүнийг өмгөөлж ганц үг хэлэхийг хүсэхгүй байна.

-Үгүй ээ, тийм ч биш шүү. Би энэ хэргийн учрыг номоор нь тайлбарлаж бас л амжаагүй байна. Цаг байсангүй. Шорон болоод бас бус юмыг нүд салгалгүй харж байлаа. Одоо бол бололцоотой болсон болохоор энэ бололцоог алдахгүй шүү. Пойндекстер авхай минь тал нутаг гэдэг чинв сонирхолтой лут зузаан ном юм шүү. Зөвхөн түүнийг уншиж чадах л хэрэгтэй. Зеб Стумп бичиг үсгийн талаар тэгтлээ айхтар биш ч гэлээ энэ хэцүү зүйлийг эзэмшиж дөнгөсөн хүн. талын ногоон дээгүүр тарчихсан гэрч баримтыг олчихоо мадагүй л юм. Аламогийн эргээс ямар нэг юм мэдэж магадгүй л байх.

-Гэмт хэргийн ямар нэг ул мөрийг олж болно гэж та бодож байна уу?

-Явж бүгдийг сайн судлан шинжиж үзэх хэрэгтэй юм. Ялангуяа мустангерыгцоохор барын савраас гаргасан тэр газрыг сайн үзэх хэрэгтэй байна. Уг нь нь тийшээ эртхэн л явдаг байсан юм. Гэвч яагаад явж чадаагүйгээ танд хэлсэн. Бурхны авралаар энэ хугацаанд бороо орсонгүй. тэгэхлээр долоо хоногийн өмнөм морийг нь өчигдрийнх шиг амархан уншиж болно. Мэдээжээр дуртай хүн бүр таньж чадахгүй. за луиза авхай минь, одоо явах цаг боллоо.

Би цайзад юу болж байгааг дуулгах гэж танайхаар ороод гарья гэж бодсон минь энэ. Цаг газардаж болохгүй. намайг өнөө өглөө мистер Морис дээр орулсан. Түүний байдал овоо сайн, ухаан орж эхэлж байна. Шүүх ажиллагаа явуулахын тул үүнийг хүэлээцгээж байна. гурван хоногийн дараа ч эхэлж магадгүй. Тэгвэл би шүүх эхлэхээс өмнө буцаж ирэх хэрэгтэй.

-Зеб, яв даа таны сайн санааны үйл хэргийг бурхан ивээх болтугай. Түүнийг гэм буруугүй гэсэн баримт нотолгоотой ирээрэй! Би үүний чинь хариуд... амь насы минь аварснаас илүүгээр насан туршдаа баярлаж явна!

LXXI. Хээр морь

Халуун сэтгэлийн үгэнд сэтгэл хөгжсөн анч өвгөн муу гүүнийхээ байгаа саравч руу яаран явлаа. Плутоны гар таталгүй тавьж өгсөн эрдэнэ шишийг гүү нь мэрж байв.

Плутон өөрөө хажууд нь зогсч байлаа. Угийн яриа хөөрөөтэй агтчин негр энэ удаа тун дуу цөөтэй байв. Тэр юунд ч юм цөхөрсөн бололтой.

Түүний байдлыг ойлгоход амархан. Халуун хайрт залуу эзнээ алдсан явдла, түүний бас л чин үнэнч байдаг залуу эзэгтэйн нь уйтгар гуниг, савс л хийвэл загнадаг болсон Флориндын тоомсоргүй доог хийх, одоо өөрийгөө шилтгээний эзэн мэт авч явдаг болсон Кассий Колхаунд өшиглүүлсэн зэрэг энэ бүх явдал хөөрхий негрийг тийн гуниглуулсныг бүрэн тайлж өгнө.

Зеб юм бодоод зав чөлөөгүй байсан учир боолын гунигт царайг анзаарсангүй. Өвгөн яарсандаа гүүгээ ч эрдэнэ шишээр олигтойхон өл залгуулсангүй: Зеб мориныхоо хамраас шүүрэн авч, хазаарлаад сагалдрагалчихаад бушуухан эргүүлж саравчнаас гарахад бэлэн болов.

Тийм амттай тэжээлээсээ хагацах болсон гүү нь цахлахад Зеб Стумп зөрүүд гүүгээ саравчнаас гаргахын тул цулбуурааснь хар тэнхээгээрээ угзчихад хүрэв.

-Үгүй, Стумп гуай, та юунд тэгтэл яараа вэ? хөөрхий гүү чинь бас л өлөн байна. Цадталаа идэг л дээ, муу нь юу байхав гэж Плутон хэллээ.

-Найз минь, надад зав алга. Би хол явна. Зуугаад бээр явах ёстой. Гэтэл хоёр цаг хүрэхгүй хугацаа үлдэж байна.

-Яана гэнээ Стумп гуай! Сుльдаж ойчтолоо давхих хэрэг гарах нь ээ. Та даажигнаагүй биз?

-Үгүй, би тоглоогүй байна.

-Энэ тал нутаг дундуур яахаараа тэгж хурдан давхих болдог нь тун гайхалтай юм! энэ морь нэг шөнийн дотор лав хоёр зуун бээр давхисан бололтой юм.

-Ямар морь?

-Тэр хаалганаас хол хамгийн захад байгаа хээр морь. Колхаун гуайн морь.

-Яагаад тэр морийг хоёр зуун бээр явсан гэж бодож байгаа юм бэ?

-Тэр чинь усан хулгана болтлоо хөлөрчихсөн байсан юм. Услах гээд горхи руу хөтөлж явахад сая гарсан тугал шиг бүдчээд айрай ядан хөдөлж байсан. Ээ, та тэр морины явж эцэжядарсныг үзсэн ч болоосой.

-Плутон хэзээ ийм юм болоо вэ?

-Хэзээ гэнээ? За байз бодоодохье!... Өө нээрээ тийм. ээн бол Генри гуайн алга болдогн тэр шөнө юм байна. Өглөө эрт, нар гараад дөнгөж цаг болж байсан юм байна. Би үүр цүүрээр гараад явчихсан болохоор эхлээз анзаараагүй. дараа нь саравч руу иртэл тэр морь гол гаталсан юм шиг шал ус болчихсон хамаг бие нь хөлс, хөөс цахарсан байсан. Шинэ Флианий морин уралдаанд дөрвөн бээр хурдалчихаад дөнгөж ирсэн юм шиг амьсгаадж байсан.

-Тэр шөнө түүнийг хэнунаж явсан юм бэ?

-Би мэдэхгүй, Стумп гуай. Гэвч Колхаун гуайгаас өөр хэн ч түүнийг унадаггүй юм. тэр ч байтугай хэн ч мордож зүрхэлдэггүй юм.

-Тэгэхээр Колхаун унаж явсан байх нь ээ?

-Би мэдэхгүй. Стумп гуай, би юу ч мэдэхгүй. Ахмад түүнийг аваад гарч байхыг би хараагүй. Тэр морь яаж буцаж ирснийг ч би хараагүй.

-Хэрэв тэр морь усан хулгана болтлоо хөлөрсөн байсан гэж чи үнэн л хэлж байгаа бол ямар нэг хүн түүнийг унасан байж таарна даа.

-Тиймээ, тийм. Хэн нэгэн хүн унасан байсан.

-Плутон чи сонсч бай. Тэр шөнө хээр морийг хэн унаж явсныг үнэхээр мэдэхгүйгэж чамайг үнэн хэлж байна гэж би бодож байна. Харин хэн ингэдэг билээ? Пойндекстер гуай бол миний найз нөхөр гэдгийг ч мэднэ. Тэгээд түүний морийг, ахмад Колхауныхыг ч гэсэн дураараа аваад байхыг би хүсэхгүй байна. тариалангийн газрын негрүүдийн нэг нь тэр хөөрхий адууг сэм авч унаад тал нутаг дундуур хөдлөн гулд давхиа биз. Тийм үү?

-Үгүй ээ, Стумп гуай, негр чинь тэгж бодохгүй байна. тариалангийн газрын боолуудыг энд оруулахыг зөвшөөрдөггүй юм. Тэд энд зүрхэлж ирэхгүй. Ямар ч негр хээр морийг авч гараагүй.

-Чөтгөр аваг, хэн тэгээд унасан байх нь вэ? Харгалзагч байж болноо доо? Чи юу гэж бодож байна?

-Үгүй тэр биш

-За тэгэхээр эзнээс нь өөр хэн ч биш байж таарлан. Хэрэв тийм бол надад санаа зовох юм алга. Эзэн нь өөрийнхөө морийг унаж санасан газар руугаа тамд очсон байлаа ч давхих эрхтэй юм. Энэ бол надад падгүй хэрэг.

-Стумп гуай минь. надад ч бас падгүй. Ээ чааваас, өнөө өглөө миний толгойд энэ тухай орж ирээгүй нь даанч тоогүй!

-Чи энэ тухай яагаад харамсаад байгаа юм бэ? Өнөө өглөө ямар хэрэг гараа вэ?

-Ээш, өнөө өглөөний болсон хэрэг үү? Их золгүй хэрэг дээ! тун золгүй хэрэг шүү!

-Яасан юм бэ, тэгээд?

-Өө, Стумп гуай минь өнөөдөр намайг навс ашигчсэн. Үд өнгөрснөөс хойш нэг цагийн дараа тэгсэн юм.

-Өшигчсэн гэнээ?

-Саравчин дотуур хийстэл өшиглөсөн гээч.

-За мэдлээ. Чи моринд өшиглүүлчихсэнээ хэлэх гэж байгаа юм уу? Аль нь тэгээв?

-Та таасангүй. Морь өшиглөсөн юм биш, энэ бидэртээс бусад бүх морины эзэн Колхаун гуай намайг өшиглөсөн юм.

-Чөтгөр ав, юу боллоо гэж тэр вэ? Найз минь чи мэдээж буруу юм хийгээ л биз.

-Негр түүнд ямар ч муу юм хийгээгүй. тэр шөнө түүний моринд юу тохиолдож тэгтлээ ядарсан юм бэ л гэж ахмадаас асуусан юм. Тэгсэн чинь чамд падгүй хэрэг гэж хэлээд л өшиглөж эхэлснээ дараа нь ташуураар балбаж гарсан. Тэгснээ айлгасан. Намайг энэ тухай хэзээ нэг цагт үг дуугарах юм бол зуу ташуурдана гэж занасан. Намайг мөн ч их хараасан шүү! Колхаун гуайг тийм их ууртай байхыг Плутон ер үзээгүй, энэ насандаа үзээгүй.

-Тэр одоо хаана байна? Өнөөдөр ер харагдахгүй байх чинь. Хээр морь нь энд байгаа болохоор хаашаа ч яваагүй байж таарна.

-Бурхан өршөө, Стумп гуай тэр одоо энд байхгүй. дөнгөж сая яваадөгсөн. тэр сүүлийн өдрүүдэд дандаа л хаашаа ч юм явчихаад эргэж ирэхгүй удаг болсон юм.

-Мориор уу?

-Тиймээ. Одоо бор морьтой яваа. Хээр морио унахаа байчихаж_ Саяын ярьдаг тэр шөнөөс хойш Колхаун гуай хээр морио ганцхан удаа л унасан. Хээр морио амрах гэсэн байж ч болох юм.

Зеб хэсэг зуур юм бодож байснаа

-Плутон, миний хөгшин гүү бас жаахан эрдэнэ шиш идэж өл авбал үнэндээ зүгээр ч юмуу даа. Яаралгүй явахад газар авна гэдэг ч дэмий ч үг биш шүү. Яах вэ, дураараа идэж аваг. Гүүгээ хооллож байх хооронд би ч бас ам хөдөлгөж сууя. Гал тогооны газар руу гүйж очоод идмээр юм олдох нь уу, үзээдхээч. Хэрчим хүйтэн мах, зүсэм талх хоёр байвал өөр юу ч хэрэггүй. Эзэгтэй чинь намайг юм ид гэсэн боловч би оройтчихно гэж айгаад идээгүй юм. Одоо харин гүүгээ хүлээн байх хооронд юм идчихмээр санагдлаа. Зүгээр суухаар идэж суувал арай хөгжилтэй байх гэв. хашаан дундуур гал тогооны газар руу гүйлээ. Стумп саравчинд ганцаараа үлдэв.

Негрийг холдмогц Зебийн царайд нөгөө хайш яаш байдал нь алга болж хэг юманд анхаарлаа төвлөрүүлсэн царайтай болоод явчихав.

Зеб чулуун хавган дээгүүр явсаар хээр гүүний байгаа хорогт хүрэв.

Гүү хамаг бие нь чичрэн, хананд ухасхийн наалдах нь шууд чиглээд ирэхээр нь анчнаас айсан бололтой.

-Тайван бай, тэнэг амьтан! Би чамд ямар ч муу юм хийхгүй. Эзэн шигээ муу зантай амьтан юм. Чимээгүй гэж хэлж байна шүү. Аль вэ тахаа үзүүлээч гэж хэлээд Зеб бөхийн урд хөлий нь өргөхгэж үзэв. Гэвч амжсангүй. Морь ямар нэг юмнаас болгоомжлох мэт гэнэт өшиглөн хуухирав.

-Сэг болмор чамайг! гэж өвгөн ууртай хашгираад - Хором зуур зүгээр зогсч чадахгүй нь уу! Чамайг хорлох гэсэн хүн алга. за аль вэ, тэнэг адгуус минь нааш ир. Би зөвхөн тахыг чинь л үзэх гэсэн юм гэж аядуудуугарав.

Зеб дахин хөлий нь өргөх гэсэн боловч үзүүлсэнгүй.

-Ингэнэ чинээ санасангүй шүү хэмээн Зеб бувтнаад хүнд байдлаас гарах арга хайх мэт эргэн тойрноо хараад - Яах билээ? Негрээр туслуулах гэж дуудаж болохгүй. Тэр энэ тухай юу ч мэдэж болохгүй. Түрэглэх хэрэгтэй. Эс тэгвэл мунгинасаар байтал орж ирээд, юу болж байгааг гадарлачихна. Энэ малыг чөтгөр аваачаасай билээ! хөлий нь яаж харья даа гэснээ арга тасран хэдэн минут хөдлөлгүй зогсов.

-Энэ муу адгуусанд үхээр шингэг! Гэж дахин дуу алдаад - үүнийг дор нь алчихсан!... Аа тийм! Санаанд нэг юм орлоо! Негр л надад битгий садаа болоосой. Флоринда эрхбиш тэрнийг саатуулах байгаа. Зачи нааш ир. Би чамайг номхон зогсооно. Эсвэл багалзууры чинь шахаж ална! Чи энэ хүзүүвчтэй тийм ч их эргэлдэхгүй шүү! гэв.

Зеб ганзган дах бугуйлаа аваад гогцоогий нь хээр морины хүзүүнд шидэж углаад нөгөө үзүүрээс нь татлаа.

Морь хуухиран хоргон дотуур тонгочиж гарла. Гэвч удалгүй тэр хуухиралт нь түүний хамрыннүхнээс арай ядан гарч байгаа исгэрэх чимээ болон хувирлаа.

Одоо Зеб санаа амар дөхөж очихоор болов. Тэр бугуйлын үзүүрийг чивчиртэл нь уяд, туурай бүгдий нь анхааралтай ажиглан харж эхэллээ. туурайн хэлбэр, тах, хадаасны байдал гээд л мөрий нь гаргахад хэрэгтэй бүхнийг ажиглав.

Зөв талын хойд хөлийн туурайг хамгийн сүүлд харснаа гайхаж баярласандаа дуу алдав. Тах нь хоёр дахь хадаасныхаа түүгээр хугарсан байжээ.

-Би чамайг ийм гэдгийг чинь мэдсэнсэн бол төвөг тарин бусдыг нь үзэхгүй байлаа шүү дээ гэж хэлээд - Чиний хэвийг танилгүй яахав. гэвч баттай болгохын тул чамайг авлаа хөө гэснээ ангийн том хутгаа сугалж тал тахны доогуур шургуулан хөшиж хамаг хадаастай нь хамт туурайнааса нь ховхолж аваад хүрэмнийхээ хүлхгэр халаасанд хийчихлээ. Тэгээд бугуйлаа шалмагхан тайлж, хээр морийг уужим амьсгалах бололцоотой болгов.

Минутын дараа Плутон көндөө их идэх юмтай хүрч ирлээ. Царан дээр мононгахелийн вискигэй шил аяга гялалзаж байь. Зеб Плутоны эдгүйд юу болсныг цухуйлгасан ч үгүй, нэн даруй идэж ууж гарлаа.

Харин хамаг бие нь чичирч, ийш тийш хулмалзан зогсч байгаа хээр морийг Плутон хараад түүнд ямар нэг бүтэлгүй юм тохиолдсоныг шууд мэджээ.

-Хүүеэ! Гэж негр дуу алдаад - Энэ морь яаж байна? Танаас айгаад байх шиг байна гэж хэлэв.

-Болох л юм... гэж Зеб хайхрамжгүй байдалтай хэлээд - Надаас жаахан айж байж магадгүй. хөгшин гүүг минь хазаж хайрахаар нь би аргамжаар хэд ороолгосон юм. Энэ л түүнд таалагдсангүй дээ гэв.

Плутон энэ тайлбарт сэтгэл бүрэн ханажээ. Тжэгээд энэ яриа төгслөө.

-Плутон танай мрьдыг хэн тахалдаг вэ? Танайд лав өөрийн төмөрчин бий биз? гэж Зеб дахин ярьж эхэллээ.

-Байлгүй яахав. Шарман Жек тахалдаг... харин Стумп гуай та яагаад ингэж асууж байгаа юм бэ?

-Аа, би муу хөгшин гүүгээ тахлуулах хэрэгтэй байгаа юм. Миний гүүг тахалж өгөхөөс Жек лав дургүйцэхгүй байх даа?

-Мэдээжээр дуртай хийж өгнө.

-Хоёр тахыг аль хэр хугацаанд тахална гэж чи бодож байна?

-Стумп гуай минь огт удаж төдөхгүй. Жекийг тах хийхдээ гарамгай гэлцдэг юм.

-Түүнд бэлэн тах бий болов уу, танай морьдыг тахалснаас хойш удаж байна уу?

-Сүүлчийн удаа тахалснаас хойш долоо хоног өнгөрч байна. хамгийн сүүлд Луиза авхайн бидэрт мустангийг тахалсан юм. гэхдээ түүнд бэлэн тах бий гэж бодож байна Би үүнийг сайн мэдэж байна. Учир нь хээр морийг тахлах ёстой юм. Нэг тах нь хугарчихсан, арваад хонож байна. Хугархайгий нь ховхолж ав гэж Колхаун гуай тушаасан юм. Өнөө өглөөхөн Жек тэгж хэлнэ билээ.

Зеб гэнэт саналаа өөрчлөх мэт эргэж ирэх хүртлээ хойшлуулбал дээр шиг байна. хөгшин гүү минь тэр болтол явчихаж дөнгөнө байх. Тал нутгийн зөм зөөлөн болохоор санаа зовох юмгүй гэв.

Зеб саравчнаас гарч тэнгэр өөд харлаа.

-За, явах цаг боллоо, хором ч алдаж болохгүй. За хонгор минь, одоо боль. Эрдэнэ шишийн оронд энэ төмөр амгайг зуух чинь болж _ За сайн байна!

Ийнхүү Плутон гүү хоёртойгоо ярьж аваад Зеб морио дахин хазаарлаж, хашаанаас хөтлөн гараад мордож жолоогоо хөдөлгөв.

LXXII. Стумп мөр хөөсөн нь

Анч өвгөн Каса-Дель-Корвоос гараад гол өгсөн цайз тийш явлаа. Мөч ч өнгөрөөгүй байтал тэнд хүрчихсэн байв. Зеб мориноосоо бугаад цайзын даргын тасалгааг чиглэн явлаа. Цайзын даргатай уулзахад анч өвгөн зовлонгүй байв. Цэргийнхэн Зеб Стумптэй хүндэтгэлтэй харьцах агаад дуртай цагтаа нууц үггүй, гадны хүнд зориулан ёс зурмыг гүйцэтгэлгүй яваад орчихно. Харуулын цэрэг түүнийг өөр йн хүн шиг оруулав. Жижүүрийн офцертэй мэндэлж, хиа нь ч түүний тухай хошуучид яаралтай мэдэгдэв.

Хошуучийн эхний үгнээс л түүний ирэхийг хүлээж байсан нь илт аж.

-Өө Стумп гуай! Тантай ийм түргэн уулзсандаа баярлаж байна. Энэ хачин хэргийн учрыг олов уу? Ийм хурдан эргэж ирснээр чинь үзвэл сонинтой л байх гэж би тааж байна. хөөрхий мустангерт тус болохямар нэг юм мэдэж ирээ биз дээ? Олон юм түүний эсрэг байгаа ч гэсэн би урьдынхаа адил түүнийг буруугүй гэж үзсэн хэвээрээ л байна. за тэгээд юу мэдэв дээ? гэв.

-Тал руу гарахаасаа өмнө нааш ирэхгүй гэж бодож байснаа юутай ч болсон дайраад гарах хэрэгтэй юм байна гэж шийдлээ. Тантайярилцах гэж ирлээ.

-Зөв юм хийж. Таны хэлэхийг сонсьё.

-Шүүх таслах ажиллагаа эхлэхийг боломжийн хэрээр аль болохоор хойшлуулахыг хүсэх гэсэн юм. хэн нэгэн хүн танаас шаардах боловч, нэгэнт таны мэдэлд байгаа хэрэг болохоор та цааргалж болно гэдгийг би мэдэж байна. үүнийг дуртай хийнэ гэдэгт тань бат итгэж байна.

-Таныхэлдэг зөв. Би өөрийн хүч хүрэх юмаа дуртайяа гүйцэтгэнэ. Гэвч манай улсад тус орныг дайны байдалтай болгосон гэж дуулаагүй цагт цэргийн захиргаа нь иргэнийхдээ захирагддагийг та мэднэ шүү дээ. Энэнээс л бурхан бидний хэлтрүүлэг. Би тогтсон хууль дүрмүүдийг гажуудццлах явдлыг саатуулах эрхтэй боловч хуулийн эсрэг юм хийж чадахгүй.

-Ер нь та хууль зөрчихийн хэрэггүй. Хошууч минь, хуулинд огт харшлах хэргэ биш. Та зөвхөн хуулийг гартаа авч түүнийг өөрсдийн ашиг тусын үүднээс гуйвуулан ашиглах гэсэн улсын эсрэг байх хэрэгтэй. Манай сууринд тийм улс байна. хэрэв тэднийг эс саатуулбал тэд заавал хууль завхруулна. Ялангуяа нэг хүн аюултай, чухам хэн гэдгийг нь ямар ч байсан мэдэж л байна.

-Хэн бэ?

-Хошууч минь танд итгэж болно гэдгийг би мэдэж байна.

-Стумп гуай, энд болж байгаа бүх явдал зөвхөн бид хоёрын хооронд үлдэнэ. Та бодож санаж байгаагаа огт сэтгэл зоволгүй ярь.

-За тэгвэл хүн алсан хүн бол Морис мустангер биш гэж би бодож байна.

-Би ч хэдийнээ тэгж бодож байгааг та мэдэж байгаа. Таны надад хэлэх юм ингээд гүйцээ юу?

-Би өөр ганц нэг юм нэмэн хэлж болмоор байна. гэвч одоохондоо хэлэх хэрэг байна уу даа гэж бодогдох юм. Энэ бол зөвхөн миний таамаглал болохоор алдаатай байж мэднэ. Тэгэхлээр Нуэсесээс буцаж иртлээ энэ тухай ярихгүй байсан минь дээр. Би тэндээс эргэж ирснийхээ дараа одоо мэдэж байгаа бүх юмаа, бас тал нутгаас мэдээ баримт олдвол тэдгээрийг тантай сэтгэл хөхүүн ярилцана.

-Миний хувьд, таны буцаж ирэхийг үнэний төлөө зүтгэж яваагий чинь бодох тусмаа дуртайяа хүлээж байх болно. Гэвч та надаас юу хүсээ вэ?

-Шүүх ажиллагаа эхлэхийг л саатуул, өөр юм хэрэггүй.

-Аль хэр удаан? Шүүх ажиллагаа бол хууль ёсны журмын дагуу явагддаг гэдгийг та мэдэж байгаа. Хэдийгээр миний саналыг дагах боловч тойргийн шүүгчид ямар ч тушаал өгч чадахгүй. гэвч энэ хэргийг дуусгая гэж яарч буй хүмүүс түүдн нөлөө үзүүлчихэж магадгүй.

-Хэний тухайяриад байгааг мэдэж байна. Шүүх ажиллагаа дуусахаас өмнө тэр хүн өөрөө хэрэгтний суудалд суучихаж болох л юм.

-Өө тэр хараач! Та энэ дөрвөн мексик... юу ч хийсэн гэж бодохгүй байгаа хүн юмаа даа?

-Тиймүү, үгүй юу гэдгийг харахаас хэлж чадхагүй л байна. зөвхөн тэр хэрэгт хамссан гэдгийг л мэдэж байна... Та надад гурван хоногийг амлах уу?

-Гурван хоног гэнээ? Юуны тулд тэр билээ?

-Шүүхийн ажиллагааг эхлэхийг гурав хоногоор саатуулах

-Үүнийг чадна гэж бодож байна, Стумп гуай. Түүнийг цэргийнхэн баривчилсан. Хэрэв дээд шүүхээс түүнийг иргэний захиргаанд шилжүүлэхийг шаардлаа ч гэсэн би гурав хоог байлгачихаж чадна. Би танд үүнийг амлая.

-Тантай ярьж байхад хошууч, байлдааны байдал тогтоогдсон болоосой гэж бодох юм! хэдийгээр чөлөөтэй иргэд бидэнд энэ нь таалагддаггүй боловч юм бүгдээс илүү болдог цаг ч бий. Хэрэв та шүүхийг гурав хоног саатуулчихдаг юм бол гэмт хэрэгтний суудал дээр одоо баригдаад байгаа хүн биш, харин өөрийг нь сэжигэлж буйг зүүдлээ чүгүй яваа өөр хүн сууж байж болох л юм. Энэ хүн хэн болхоыг надаас бүү асуу. Харин гурав хоног өгч чадах уу гэдгээ л хэлчих.

-Мистер Стумп бт танд амлая. Намайг халах аюул тулгарлаа ч гэсэн Морис мустангер гурав хоногтоо л сахилгы шоронгоор гарахгүй гэж офицер хүний ёсоор амлая. Буруутай ч бай, үгүй ч бай энэ хугацаанд миний хамгаалалтанд байх болно.

-Хошууч та сайн хүн юм! Би танд яаж баярласнаа хэзээ нэгэнцагт үзүүлэдггүй юм бол үхэж далд орог. Өөр хэлэх юм алга. гагцхүү нууц хадгалахыг танаас гуйя. Миний юу хийж байгааг мэдчихдэг л юм бол саад тотгор учруулах гэж гауар тэнгэр хөмрүүлэхэд бэлэн байгаа улс энд бий.

-Стумп гуай, тэд надаас юу ч болж мэдэхгүй. Та миний үгэнд санаа амар найдажболно.

-Би үүнийг мэдэж байна, хошууч аа, мэдэж байна!

-Сайн санаа санасанд тань баярлалаа! Тан шиг хүн Техаст олон байдаг бол доо!

Анч өвгөн хошуучаас салаад, цэргийн сургуулийн талбай дээр зогсч байгаа хөгшин гүү рүүгээ явлаа.

Суурингаас гараад наашаа ирсэн зам руу эргэв. Пойндекстерын их тариалангийн газрын захаасхолгүй газар хүрээд Зеб Леоны хөндийг орхин дээд тал руу гарахаар хажуу өөд өгсөж эхлэв. Тэгээд ширэнгийн захад хүрээд хуайсны сүүдэрт зогсч юм бодлоо. Анч өвгөн мориноосоо буусан ч үгүй. Эмээл дээрээ суусан хэвээр бөгтийн гүн их бодолд орсон үедэ хардаг шиг өмнөх газраа алмайран ширтэнэ.

-Чөтгөр аваг! Гэж Зебаман дотроо гүвтнэн шглээд - Сонин л юм даа. Тэр шөнө Колхауны морь алга байснаа, усан хулгана болтлоо хөлөрчихөөд эргэж ирсэн байдаг. Энэ юу гэсэн үг вэ? Энэ бузар хэрэгт Колхауны гар оролцоогүй байдаг юм бол надад хараал шингэг. Би ингэж бодож болохоор л байна. гэвч Колхауныг үеэл дүүгээг алсан гэж бодох нь даанч байж боломгүй. Үнэндээ Колхаун ашиг л олж байвал ямар ч муухай хэрэг хийхээс сийхгүй хүн. Харин үеэл дүүгээ алаад ямар ашиг байна? хэрэв шилтгээн Генрид өв болон ирсэн бол бас ойлгож болохсон. Гэтэл тийм биш юм. Өвгөн Пойндекстерт нэг ч акра газар, нэг ч негр зарц одоо үлдээгүй. Би үүнийг сайн мэдэж байна. Бүгдий нь тэр муу дамшиг булааж авсан. Тэгээд яагаад үеэл дүүгээсээ хагацах хэрэгтэй болсон юм бол? Миний олгохгүй байгаа юм энэ л байна. Миний мэдхээр тэд хэзээ муудалцаж байгаагүй. Гэтэл энд мустангер бас оролцож, дараа нь Луизагийн надад ярьдаг хэрүүл гарч, хуурамч индиан нар, мексик хүүхэн, морь унасан толгойгүй хүн гээд л өөр юу болсныг чөтгөр л мэднэ! Иосафат минь! Энэ хэрэгт Техасын хамгийн шилдэг мөрдөн байцаагчийг ч төөрөлүүдүүлнэ... гагцхүү үнэтэй цагийг алдах хэрэггүй. Гарт байгаа энэ хэсэг тахны төмрөөр, эл цуст хэргийн учрыг олж мэдэх л юм. Гэвч хаашаа явах вэ? гээд асуултдаа хариу эрэх мэт эргэн тойрон харлаа.

-Цайз, суурингийн хавиас эрэх ямар ч хэрэггүй юм. хамаг мөр, мал хааж яваа юм шиг л талхлагдчихсан байгаа. Тэгэхээр шууд тал руу Рио-Грандын зам руу явсан нь дээр. Тиймээ тэгсэн нь зөв гэж шийджээ.

Зеб Нуэсесийн эрэгт бээр шахам дөхөж ирээд баруун тийш ихэд тайван урдаас төлөвлөсөн шинжтэй эргэв. Одоо түүний явах зам нь Рио-Гранд руу явсан бүх зөргийг огтлон гарахаар болжээ.

Ийнхүү шийдсэндээ сэтгэл ханам мэт жолоогоо дугтран, ширэнгийн замаар алхуулав.

Өвгөн анчны байдал, царай зүс нь шал ондоон болж ирэв. нөгөө хайнга байдалтай хардаг нь ч алга болж, бөхийсхийн өмнөх өвс ногооганхааралтай ажиглана.

Өвгөн нэг бээр орчим яваад ямар нэг юм харан зогтусан жолоогоо бушуухан татлаа.

Гүүч дуулгавартай зогсов. Зеб буун харайж, урагш хоёр гурав алхаад сөхрөн суув. Тэгээд халааснаасаа тах гаргаж, ногоон дээр тодхон харагдаж байгаа морины мөрөнд түүнийгээ барьж үзлээ.

-Яв цав таарч байна! Хэрэв тийш биш болчөтгөр аваг! Бүр яг гэрэч хэмээн тах мөр хоёрыг нийлүүлснийхээ дараа хэлээд - Урвагчийн, магадгүй алуурчийн мөр энэ байна шүү! гэж хэллээ.

LXXIII. Тал нутгийн бяцхан арал

Тал нутгийн цэлгэр уудам бэлчээрт хоёр гурван зуугаараа сүрэглэн бэлчсэн адуун сүрэг, аянчин жуулчны анхаарлыг өөрийн эрхгүй татан, эл гайхамшигт зургийг бишрэн харж зогсох нь бий. Техасын уугуул нутгийн хүн бол “мустангийн сүрэг байна” гэж дотроо бодоод тэдгээрийн хажуугаар хэнэг ч үгүй өнгөрнө. Харин ганцхан морь идээшилж явахыг Техасын хүн харвал хачин сонин санагдаж гайхаад сүргээсээ тасарсан зэрлэг азарга юмуу, эсхүүл аянаас хоцорсон унаа морь юм бол уу? гэж бодно.

Тал нутгийн хүний туршлагатай нүдэнд тэр морь амархан танигдана. Хэрэв морь толгойдоо хазаартай, нуруундаа эмээлтэй яюж байх юм бол эргэлзэлтгүй юм. Зөвхөн энэ морь эзнээсээ яаж холдож чадаа вэ гэдгийг л бодох хэрэгтэй болно.

Харин тэр морь, дээрээ хүнтэй идшилж явах юм бол түүнийг унасан хүн нь бууж, морио идүүлэхээ мэддэггүй тэнэг толгой, залхуу амьтан гэж бодохоос өөр юмгүй.

Хэрэв тэр морьтой хүн нь тэнэг бүү хэл ямар чтолгойгүй байх юм бол хэдэн мянган таамаглал бий болж тэдгээрийн нэг нь ч үнэний хувьд өчүүхэн төдий ч хүлэргүй нь мэдээж.

Яг тийм морь, хүн хоёр баруун өмнөд Техасын тал нутагт 185... онд үзэгдсэн билээ. Чухам хэдэн оло болох нь тодорхойгүй боловч, энэ нь тавиад онд л байсан юм.

Уг газар орны нь нэлээд тодорхой зааж болно. Энэ бол Риодель-Нуэсес болон Леон голын хооронд хориос хорин таван орчим бээр газрыг эзэлнэ.

Морь унасан толгойгүй хүнийг олон хүн янз бүрийн цаг үед харжээ. Нэгдүгээрт, Генри Пйондекстер бх түүний алуурчийг олохоор эрэлдгарсан улс харжээ. Хоёрдугаарт, Морис мустангерын зарц үзжээ. Гуравдугаарт, Кассий Колхаун шөнө дунд шугуйгаар тэнэж явахдаа харжээ. Дөрөвдүгээрт, тэр шөнө индиан болж зүсээ хувиргасан мексикүүд үзжээ. Хамгийн эцэст, түүний дараа шөнө Зеб Стумп харсан ажээ.

Тэрчлэн өөр газар, өөр нөхцөл байдлын дунд морь унасан толгойгүй хүнийг үзсэн ондоо хэдэн хүнч байлаа. Тэр бол анчин, малчин, харуулын хүмүүс юм. Тэр хачиг жигтэй үзэгдэл хүн бүхний айдсын хүргэж, хүн бүхэнд тайлагдашгүй нууц битүүлэг зүйл байлаа.

Түүний тухай зөвхөн Леонд төдийгүй, алслагдсан хол нутагт ч сэтгэл догдлон ярилцах болжээ. Морь унасан хачин жигтэй хүний тухай цуу үг өмнө зүгт Рио- Грандын эрэг хүртэл, хойд зүгт Сабайлал хүртэл таржээ. Тэр аймшигтай морьтныг хүмүүс үнэхээр үзсэн гэдэгт хэн ч эргэлзэхгүй болжээ. Үүнд эргэлзэх юм бол адаглаад л зүгээр нэг хоосон бодлыг бус, үүний үнэн гэдэгт ам шүд алдахад бэлэн хоёр зуун хүний өчиг мэдүүлгийн хайрхагүй үгүйсгэнэ гэсэн үг байв. Түүний үнэхээр харсныг үгүйсгэх хүн байсангүй. Байгалийн ёсноос гажуу, тийм хачин үзэгдлийг яаж тайлбарлар вэ гэдэг л үлджээ. Их бага боловч үнэний хувьтай, их бага боловч утга учиргүй хэдэн арван янзын таавар таамаглал гарч иржээ. Нэг хэсэг нь “индианы мэх” хэмээн, нөгөө хэсэг нь чихмэл гэлцэн бас зарми нь жинхэнэ хүн, гагцхүү толгойгоо серапе дороо нуусан бөгөөд замаа харж, морио залж явах гэж нүдэндээ тохируулан

хоёр цоорхой гаргажээ гэлцэнэ. Морь унасан толгойгүй хүнийг ёстой чөтгөр гэж шаргуу нотлох хүмүүм ч байлаа.

Энэ битүүлэг үзэгдлийг тайлбарлах гэж оролдохын хажуугаар элдэв нарийн ширийн зүйлийг ч ярилцах болов. зарим хүн толгой ч юмуу тиймэрхүү юм морин дээр нь серапегийн доор байхыг харсан гэнэ. Нөгөө зарим нь толгойгоо гартаа браьчихсан байхы нь харсан гэх бөгөөд хэд хэдэн хүн бүүр алтан хиазаар хөвөөлсөн хар гялгар сомбреро байсан гэж батална.

Түүнээс гадна морь унасан толгойгүй хүний үзэгдэх болсон болон залуу

Пойндекстерын битүүлгээр алуулсан хоёрын хооронд ямар холбоо байгааг олон хүн таах гэж оролдож байв.

Энэ хоёр нууц хоорондоо заавал холбоотой гэж бараг бүгд итгэж байсан боловч чмухам ямар холбоо байна гэдгийг тайлбарлаж чадахгүй байв. Гэтэл энэ нууцыг жаахан ч атугай тодруулж мэдэх хүн бас л халуунтай хэвээр дэмийрсээр байлаа.

Ийм цуу үг дуулсаар бүтэн долоо хоног өнгөрөхөд нөгөө сүүдэгнэсэн морь унасан толгойгүй хүнийг олон удаа харжээ. Тэр заримдаа морины хурдаар тал дундуур давхиж, заримдаа гэлдэрч явдаг ажээ. Морь нь нэг үг зогсч, үргэж цочсон харцаар эргэн тойрныг харан нэг үе бэлчээрийн шимт ногоог шунан зулгаан.а

Энэ оньсого таавар мэт битүүлэг хүний тухай санаанаасаа зохиосон учир утгагүй олон яриа өгүүлэл гарчээ. Тэдгээрийг тоочихын аргагүй бөгөөд тоочихын ч хэрэггүй. гэвч бидний жигтэй хүүрнэлд зэгсэн чухал болох нэгэн учралыг ярих хэрэгтэй байна.

Задгай тал нутгийн дунд гуравдөрвөн акрахэмжээний царсан ой сүглийнэ. Талын уугуул хүн түүнийг аралхан гэж нэрлэх агаад энэ хэсэгхэн модыг тойрсон нүд алдам цэлийх ногоон тэнгэсийг хараад аятайхан зүйрлэжээ гэхээс өөр аргагүй.

Царсан ойгоос холгүйхэн нэгэн морь идшилж явна. Энэ бол толгойгүй хүнд унуулсан өнөөх морь ажээ. Хачин жигтэй хүн нь тэр морины нуруун дээр суусаар л байна. өмссөн хуцвас нь ч, төрх байдал нь ч анх харагдсан цагийнхаасаа огт өөрчлөгдөөгүй мэт ажээ. Судалтай серапе нь цээжин биеий нь халхлан мөр рүү нь унжиж, цоохор арьсан гутал жийсэн хэвээрээ байна.

Толгойгүй хүн морио өвс ногоо зулгаахад нь аятай болгох гэсэн шиг урагшаа жаахан бөхийн суужээ. Гартаа барьсан ч юм шиг, эмээлийн бүүрэгнээс өлгөсөн ч юм шиг жолоо нь өвс идэхэд саад болохгүйгээр урт ажээ.

Толгойгий нь харсан гэж батлаад байгаа хүмүүс үнэн хэлснээр барахгүй, алтан хиазтай хар сомбреротой гэдэг нь үнэн байлаа.

Толгой нь зүүн ташааны нь орчим сабайх агаад эрүү нь бараг өвдгий нь шүргэнэ. Морьтой хүнийг зүүн талаас нь харсна хүн л толгойгий нь үзэж болно.Гэхдээ заримдаа серапегийн

хормойд далд орчихсон байна. Хааяа царайгий нь ч харж болно. Царайны нь төрх цэвэрхэн боловч аймаар ажээ. Хөхөрсөн уруул нь мөхөгдөж, цагаан шүд нь зууулттай ярзайгаад зэвүүн инээмсэглэн хөшжээ.

Гаднаас нь харахад хувирсан юм байхгүй ч гэлээ ямар нэг юм өөрчлөгджээ. Саяхан болтол ганцаар явж байсан авч харин ойрноос хань бараатай болжээ. Тэднийг тийм аятайхан хань гэхэд хэцүү. Тал нутгийн арваад чоно хойноос салахгүй дагаж, үсэрч цовхчиж явна.

Тэр чононууд морийг залхааж байгаа эь эрглээгзй. Тэдний аль нэгий нь дэндүү ойртоход морь хуйхарч тангарч байв. Дээрх хүн нь мөрөн дээгүүрээ эргэлдэж байгаа хар шувууны сүргийг хайхрахгүй байгаа шигээ тэр чононуудыг ч хайхрахгүй байв. Тэр бүү хэл зрригтой нэг нь дэ:эр нь суухад ч хүртэл үргээж гараа хөдөлгөхгүй явна.

Тэр шувуу гурван удаа дээр нь суув. Эхлээд баруун мөрөн дээр нь дараа нь зүүн дээр нь, эцэст нь толгой байх ёстой тэр газар суугаад авав. Гэхдээ удаан суусангүй. Морьтон үүний нь тоохгүй ч гэсэн морь нь хойд хоёр хөл дээрээ цоройн унгалдаж, таснуудыг түр боловч зайлуулна.

Тал нутгийн шимт ногоог нэг үе тайван зулгааж, нэг үе тас, чонын довтолгооныг үл тэсвэрлэн хөөж үргээж байгаа моийн дээр юуг ч тоохгүй толгойгүй хүн царсан ойн дундуур ажажуухан тэнүүчилж явна.

LXXIV. Мөшгөсөн нь

Саяны ярьдаг хачин жигтэй үзэгдэл бол тоглоом ч үгүй хачин аймаар зүйл байлаа. Түүнийг дотор арзганан айж эмээлгүйгээр харахын аргагүй.

Морь унасан толгойгүй хүнийг газар дээрх чоно, тэнгэрт халин нисэх таснаас өөр ямар нэг хүн харсан бол уу?

Тиймээ харсан. Түүнийг, хэнд ч үл тайлагдах энэ нууцыг техасынхан дотроос цор ганцаар, зарим талаар ойлгож эхэлсэг хүн харжээ.

Гэвч түүнд бас л цөм ил тод болоогүй байв. Харин морь унасан толгойгүй хүн бол мануухай чихмэл ч биш, яөтгөр ч биш гэдийг л зөвхөн мэдэж байв. Гэвч тэр аймшигтай морьтныг хараад айхгүй байж чадсангүй. Өөрийнх нь өмнө юу байгааг мэдэж байгаа ч чичрэхгүй байж чадсангүй. Царсан ойн захад модны сүүдэрт зогсоод харж байв.

Хэдийгээр жихүүрхэн айж, үзэгдэж харагдахгүй байхыг хүсэх боловч ямар нэг соронзонгийн хүчинд татагдах мэт морь унасан толгойгүй хүнийг мөшгөн дагав. Түүнээс гадна тэрээр царсан ойд орохоосоо өмнө аймшигтай морьтныг алсаас ажигласан бөгөөд уулзалгүй зугтаачихвал болох л бөайв. гэвч тэгэхийнхээ оронд шууд түүн рүү чиглэн очжээ.

Сайхь хүн үрэмтгий буга хөөж яваа анчин шиг модны араар нуугдан болгоомжтой ойртох агаад ганц ялгаа нь буга хөөж яваа анчин хэзээ ч ингэж айдаггүйд л байлаа. Модон дунд орж аваад, айж байсан ч гэсэн санаа нь амсхийв.

Тэр ямар ч зорилгогүй арваад бээр газрыг туулан, ногоон дээгүүр сэмээрхэн дөхөж, хүн амьтны нүдэнд харагдахгүй гэж бутан дундуур зүтгэх нь юу л бол. Ойн аралханы захаар гэтэж яваад хүний хачин байдлын учрыг ойлгоход түүнийг жаахан ажиглахад л гүйцээ. Түүний хамаг анхаарал морь унасан толгойгүй хүн дээр төвлөрөн, хөдөлж аяглахыг нь няхуур ажин, хөдөлгөөнд нь нийцүүлэн урагшилж байв.

Эхлээд хамгийн гол нь айгаад байна уу гэж санагдмаар байв. Жаахан байзнаад айдас нь тэсэн ядахаар солигдон зоригтойхон хөдөлж эхлэв. Түүний байдал ийнхүү өөрчлөгдсөн нь морь унасан толгойгүй хүн, түүний нуугдсан газар ер ойртож өхөгүйгээс болжээ. Энэ нь мөрдөгчийн эгдүүг хүргэж, өөрийн эрхгүй хараал бувтнахад хүргэжээ. Үнэндээ ч сайхь эр яриандаа хараалыг гар таталгүй хэрэглэдэг нэгэн байв.

-Ээ шулмын хар адгуус чамайг! Ядахдаа хориод алхам ойртвол алдахгүй буудчихаж чадахсан. Одоо буудна гэдэг зөвхөн үргээнэ л гэсэн үг. Тэгээд дахин ийм болмж гарахгүй ч байж мэдэх юм. Чөтгөр ав! Хэрэв ойртуулья гэж бодоогүйсэн бол!

Тэр хүн өөрийнхөө тооцоог шалгах гэсэн мэт морь унасан толгойгүй хүнийг өөрөөс нь тусгаарлаж байгаа газрыг дахин харцаараа багцаалав. Тэр ангийн огтор бугаа гох дарахад бэлэн барьжээ.

-Буудаад дэмий гэж тэр хүн жаахан бодож зогссоноо аман дотроо өгүүлээд - Сум цойлж,

шархдуулсан юмгүй үргээчихнэ. Тэвчиж тэр морийг ойртож ирэхий нь хүлээх хэрэгтэй юм. Хөөтэй хар чононуудыг ээ! Бүх юм тэднээс болчихлоо... Тэднийг салахгүй дагаад байхад морь модноос аль болох хол байхыг бодно. Энэ бол Техасын бүх мустангийн гэм биш зан. Тэднийг чөтгөр аваачаасай!... Түүнийг яаж ийгээд шившүүрдэн дуудаж болохгүй юм бол уу? Дуудахад ирчихгүй байгаа даа?... Юу л бол. Сүүлийн үед хүний дуунаас хөндийрсөн болохоор зөвхөн айлгачих бай. Миний мориноос бас эртүүтийнх шиг бусгах нь лав. Үнэндээ тэр үед сарны гэрэлд бас хойноос нь нохой хөөж явсан л даа. нуруун дээрээ чөтгөр бүү мэд нэг амьтан суулгачихаад зэрлэгшинэ гэдэгт гайхах юм алга. Ийм юм байж болохгүй... болохгүй! Эцсийн эцэст энэ бол хэн нэгний хийсэн ов заль!...

Ингэж хэлээд жолоогоо гэнэт татав. Модны навч нахиа дундуур сайн харж авахын тул бөхийж, царсан ойг алгуур тойрч байгаа морь унасан толгойгүй хачин хүнийг ажигласаар байв.

-Энэ ч түүний морь яриагүй мөн. Эмээл, серапе, цөм түүний юм мөн. Яаж яваад өөр хүнд оччихдог байна аа? гэснээ хэдэн минут чимээгүй байснаа дахин ганцаарьярьж Ивбийн үзэгдэл ч байлаа гэсэн, биш ч гэсэн муу л юм болж байна. Үүнийг хийсэн хүн тэр шөнө юу болсныг цөмийг мэдэж таарна. Хэрэв сум тэнд байгаа бол авах л хэрэгтэй. Тийм юмаар бардамнаж байдаг би ч мөн тэнэг ээ! Өөрийгөө ингэж баллах гэж. Энэ морь ч наашаа ойртож ирэхгүйнв, ой модноос айж байгаа хэрэг. Мустанг задгай талд л итгэлтэй байдаг амьтан. Яая даа? Тэр морь хүний дуу сонсвол таатай байх болов уу? Хэрэв хорин алхамд л дөхөж ирвэл бүх юм номоороо болохсон. Туршаад үзье, чөтгөр ав... гэв.

Тэр хүн ойн захад жаахан дөхөж очоод:

-Ухаалаг минь нааш ир! Сайн морьхон минь нааш ир! гэж дуудаж гарлаа. Тэгж дуудсаны гарз болжээ. Морь ойртоогүйгээр барахгүй бүр үргэн, дуу гарангуут аман дахь өвсөө унагаж, толгой хаялан айсан шинжтэй хуухирав. Хүний дуу түүнийг чоно, таснаас ч илүү айлгав бололтой.

Сумтангийн хувьд хүн, ялангуяа морь унасан хүн бол өшөөт дайсан нь байдаг бөгнөөд тэр дайсныхаа ойртож ирэхийг мэдэрчээ. Ямар хүн, ямарморь байгааг харах гэж зогссон ч үгүй, түүний хувьд дайсан, тэгээд л гүйцээ. Харваас морь унасан хүн ч тэгж бодов бололтой, жолоогоо татаж зогсоосон ч үгүй, өөрөө өөрийгөө мэдэх болсон морь нь талын зүг хурлан давхилаа.

Олзоо алдсан даа уур нь хүрсэн мөшгөгч хараал тавин задгай газар гарч ирлээ.

Буудсан боловч оноогүйдээ, морь унасан толгойгүй хүн аль хэдийн холдоод явчихсанд уурлахдаа дахин хараал урсгаж эхлэв.

LXXV. Мөр хөөв

Зеб Стумп хугархай тахны мөр олсон тэр газраа удаан зогссонгүй. Тахыг мөрний хэвд таруулж үзэхэд зургаахан хором хангалттай байлаа. Тэгээд босч тэр мөрийг дагаж явган явлаа. Хөгшин гүү нь хойноос нэлээн хол, дуулгавартай дагаж явна.

Зеб мөр бүдгэрсэн газар нэг үе алхаагаа аажууруулж% мөр тодхон газар нэг үе түргэн алхсаар бээр гару йявчихлаа.

Эртний хотын үлдэгдлээс шавар хүрд олоод зөвхөн өөрөө ойлгодог дүрс бичгийг уншиж буй хуучны судлалын эрдэмтэн мэт Зеб Стумп талын хөрсөн дээр буй битүүлэг тэмдгүүдийг уншиж явав.

Эрэлдээ бүрэн автсан анчин, орчныхоо юмыг ажиглахгүй мэт санагдана. Эргэн тойронд нь дэлгэгдсэн эх захгүй ногоон талыг үл шохоорхож, дээрээ мэлтийж байгаа ёроолгүй хөх огторгуй өөд эс харан зөвхөн хөл доорхи өвс ногоог анхааралтай ажиглана.

Гэнэт цуурайлсан дуу гарахад Зеб толгой өргөв. Энэ нь алсад буудсан буун дуу баарах мэт сонсогджээ.

Зеб зөнгөөрөө зогсч, хараагаа дээш хандуулсан боловч цэх болсонгүй. Анч өвгөн буун дуу гарсан зүг түргэн зуур харлаа. Бөөрөнхий хэлбэрээ арайхан алдаагүй хөхөвтөр утаа яг царсан арлаханы зурвасын дээгүүр хөх огторгуй өөд алгуур хөөрч байв. Зебийн зогсч байгаа газраас ойн зурвас, бууны дуу, утаа ч гагцхүү анчин хүний туршлагатай нүд, соргог чих л үзэж сонсохоор байлаа. Гэвч Зеб утааг харж, буун дууг сонсжээ.

-Хачин жигтэй юм! гэж Зеб байцааны үр суулгаж байгаа цэцэрлэгч шиг зогссон чигээр өгүүлээд, - Хачин жигтэй юм гэхээс өөр юу ч гэж хэлэх вэ. Тийм газар ан хийе гэсэн бодол хэийн толгойд ордог билээ? Тэнд чинь ямар ч ан амьтан байнгүй, сумны үрлэг л баймаар юм. Би тэндэхийг мэднэ дээ. Тэнд чононоос өөр ямар чөтгөр нь байх вэ... Тэгээд идэш хоол нь ч гэсэн дээ гэснээ хэсэг дуугүй болсоноо - Өө! Суурингаас өөрсдийнх нь ярьдгаар “сонирхон хэсэхээр” гарсан хэн нэг мухлагийн худалдаачин л энэ муусайнаас нухчихаад хожим чонон авласан гэж онгирох гэж байгаа юм. Агнавал агнаж л байг, ямар надад хүртээлтэй юм биш... Хөөш! Ямар нэг юм айсуй! Араас нь чөтгөр хөөж яваа юм шиг морио шамдуулж байна. Өнөө толгойгүй хүн чинь! Гэж дуу алдав.

Анч өвгөн зөв таньжээ. Дарины утаанаас дөнгөж салаад Зебийн зогсч буй газар луу хар хурдаараа давхин айсуй морьтныг танихгүй хэн байх билээ.

Энэ бол морь унасан толгойгүй хүн биеэрээ байв.

Тэр л Зебийг харчихсан өөдөөс нь ирж явна уу гэлтэй айсуй.

Анч өвгөнөөс илүү зүрх зоригтой хүн Тэхасын хязгаар нутагт ховор билээ. Цоохор бар, ирвэс, баавгай, зэрлэг сарлагтай тулалдаанд ч айдаггүй бөгөөд индиануудаас ч зүрх үл алдана. Каланчийн бүхэл бүтэн баг цэрэгтэй дайралдлаа гэхэд ажрахгүй хүн маань сайхь ганц

морьтонг хараад тэвчээт самбаа алджээ.

Зэрлэг тал нутгийн дунд халтай ширүүн амьдралд хатуужсан сайхь цэцэн багшийн шавь Зеб Стумп зарим нэг мухар сүсгээс чөлөөлөгдсөн хүн биш билээ. Ер нь тиймгүй хүн ч хаа байх билээ!

Өвгнө анчин хүнээс ч, араатнаас ч айгаагүй боловч хувилгааны хүчний өмнө зүрх алджээ. Үнэндээ хэн нь ч гэсэн араасаа үхэл дагуулсан мэт сүүдэгнэсэн морьтон өөдөөс нь хар эрчээрээ харайлгаж явахад яаж айхгүй байх билээ. Зеб Стумп зүрх шантарсаар барахгүй, айсандаа чичирч нуугдах газар хайж эхлэв.

Морь унасан толгойгүй хүн өөрийг нь ажиглахаас өмнө хажуугийн бутанд орж нуугдав.

Гэвч эмээлтэйгээ зогсч байгаа гүү нь түүнийг бариад өгчихөж болох юм. Нуугдахаасаа өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа.

-Хэвт! Гэж ярьдаггүй ч гэсэнөөрийн нь хэлснийг сайн мэддэг дөрвөн хөлт нөхөртөө хашгиран хэлээд - Бушуухан хэвт! Эс тэгвэл сүйд боллоо! гэв.

Эднийхээ сүрдүүлгээс айсан мэт гүү тэр дорхиноо урд хоёр хөлөө сөхөрч, дараа нь хойд хөлөө атийгаад зүлгэн дээр хүнд ажлын дараагаар амарч байгаа юм шиг хэвтээд өглөө_.

Зеб морь хоёырг дөнгөж нуугдмагц, морьунасан битүүлэг сонин хүн тэдний дэргэдүүр давхиж өнгөрөв.

Тэр хүн зогсох шинжгүй хар хурдаараа давхиж байгаад Зеб ихэд баярлажээ.

Морь унасан толгойгүй хүн наашаа санамсаргүй явсан болохоос анч өвгөн ч юмуу туранхай гүүгий нь хараад ирсэн хэрэг биш ажээ.

Зеб сүнсээ зайлтал айсан ч гэлээ морь унасан хүнийг далд орохоос өмнө харж амжжээ. Морь Зебийн нуугдасан сөөгт зэрэгцэн ирэхэд дээрх хүний нь серапений хормой салхинд сөхөгдөж, дороос нь анч өвгөний сайн таньдаг хувцас харагджээ. Энэ нь хөх өнгийн хөвөн цаасан нэхмэл эдээр хийсэн энгэртээ хуниастай халхгар том цамц байв. Цамц улаан толбонд будагсан ч хөгшин анчин эл гадуур цамцыг таньж байв.

Гэвч эрүүгээрээ ташаанд нь тулсан нүүр уарайг тэгтлээ сайн ялгасангүй. Үүнд гайхах юм байсангүй. Хүүгийнхээ сайхан царайг байнга энхрийлэн хардаг хайрт ээж нь хүртэл үүнийг одоо танихгүйгээр байлаа. Зеб түүнийг мөн таниагүй ч тааварлаж байв. Морь, эмээл, судалтай серапе, тэнгэрийн өнгөт цамц, бас өмд, тэрчлэн толгой дээрх бүрх энэ бүхэн цөм анч өвгөнд танил байлаа. Эмээл дээрээ цэх суусан биеий нь ч таньжээ. Ойлгомжгүй байдлаар байраа сольсон нь толгой нь энэ хүнийх байх ёстой байв.

Энэ бол зэрвэс харсан хэрэг биш байв. Зеб аймшигт морьтныг сайн харж авчээ. хэдийгээр дахиад өнгөрсөн ч гэлээ хөгншнөөс арваадхан алхмын зайтай гарчээ.

Анч өвгөн холдон явж байгаа морьтой хүнийг үгээр буюу хөдөлгөөнөөр зогсоох гэж

оролдсонгүй. Зөвхөн дараа нь морь унасан зэвүүн хүн хэн болохыг ойлгоод Зеб гунигтайгаар

-Иосафат! Энэ нь яриагүй үнэн юм! Хөөрхий залуу! Хөөрхийеэ! Алагдаж шүү гэж дуу алдав.

LXXVI. Шохойт арал

Зеб Стумп хар гүйхээрээ холдон явж байгаа морьтой хүний хойноос нууц байрнаасаа удаан ажиглаж харав. Тэгээд морьтой хүнийг хуайсан төглийн цаагуур далдормогц анч вөгөн босч, нуруугаа тэнийлгэлээ. Нэг хоёр хором хяраатай цааш юу хийхээ бодон зогсов. Энэ санамсаргүй хачин үзэгдэл түүний бодлыг төөрөлдүүлжээ.

Хугархай тахтай мөрийг цааш хөөх үү? Эсвэл түүнийг орхиод саяны өнгөрдөг моорь унасан толгойгүй хүний хойноос явах хэрэгтэй юу?

Эхнийх нь олон юм нээж өгч болох юм. Хоёр дахь нь түүнээс илүүг мэдүүлэх ч юм шиг.

Морьтонг барьж аваад, яагаад тэнээд байгаагийн нууцыг мэдэж авч болох л юм.

Ийнхүү бодол болж байгаад Зеб нөгөө даринь утаа, талд гарсан буун зууг бараг мартчих дөхлөө.

Гэвч удалгүй ухаан санаа нь цэгцэрч ирлээ.

Анч өвгөн утаа гарсан газар рууэргэн хараад дахин бөгтөсхийн хуайны дор нуугдахад хүргэсэн тийм нэг юмыг ажиж харжээ. Хөгшин гүү нь хэвтсэн хэвээр учир түүний талаар санаа зоволтгүй байж болох байю.

Энэ удаа мөрөн дээрээ толгойтой, жинхэнэ морьтой хүнийг Зеб харлаа.

Тэр хүн хол байсан учир хуайсан дундах анч өвгөний өндөр биеийг ялангуяа хэвтэж бахйгаа гүүгий нь хараагүй бололтой, ямар чбайсан байдлаар нь үзэхэд ажиглаагүй нь илт.

Тэр хүн морин дээрээ бөхийн сууж, өмнөх газраа анхааралтай ширтэж явлаа.

Тэр хүнийяах гэж явааг мэдэхэд түвэггүй юм. Зеб анх харахдаа л тэр хүн морь унасан толгойгүй хүний мөрийг мөшгөж явааг таамаглажээ.

-Үгүй ер өө! Гэж Зеб шивнээд - Би л ганцаараа нууцыг тайдах гэсэн юм биш байжээ. Тэгээд өөр хэн байдаг билээ? гэв.

Зеб тааварлах гэж удаан зүдэрсэнгүй. Мөн шинэхэн, ивилхэн учир морьтой хүн хатируулан ойрхон хүрч ирэхэд анч өвгөн түүнийг зволонгүй ажиглан харж болохоор болов.

-Иосафат! Гэж Зеб аман дотроо өгүүлээд - Би үүнийг яагаад аль эрт тааварласангүй вэ? Хэрэв би ташаараагүй бол зайлшгүй баримт нотолгооны бүх шинжийг олж цуглуулахад тус болох нэг үе олдлоо... Мал минь томоотой хэвтэж бай! Хэрэв хөдлөл л юм бол хоолойгий чинь огтолчихно шүү! гэв.

Зеб гүүндээ ингэж хэлээд дуугүй болж, ногоон хуайсны дунд толгойгоо халхлан саглагар мөчрийнх нь цаанаас ойртон ирж яваа морьтой хүнийг анхааралтай ажиглан харж эхэллээ.

Танихгүй байхын аргагүй хүн айсуй.

Дөнгөж гуч гарч яваа ч нүүрэнд нь мунаг тачаалын арилшгүй мөр хэдийнээ тогтжээ. Түүнийг ямар нэг аймшигтай түгшүүр аль хэдийнээс амар заяа үзүүлэхээ байсан нь илт. Царай нь санаашрангуй харагдана.

Хэрэв өөрийг нь өөдгүй хүн болохыг илчилж буй шалшиг завхайгийн ул мөр байгаагүйсэн бол зэгсэн сайхан царайтай юм гэж хэлж болохоор ажээ.

Хувцас нь? Түүнийг тодруулах хэрэг байна уу даа! хагас цэрэг маягийн цэнхэр цэмбэн хүрмэ, саравчтай малгай, ангийн хутга, хоёр гар буу зүсэн бүс гээд л Кассий Колхаун ахмадын тухай дээр өгүүлхэдэ гарч байсан зүйлс тэр хэвээрээ харагдана.

Тэр хүн биеэрээ байлаа.

Ахмадыг буу зэвсэгтэй болохоор анч өвгөн түүнтэй уулзахаас зайлсхийсэн хэрэг биш байлаа. Хэдийгээр өвгөн анчин түүнддургүй ч гэсэн, чөлөөнд гарсан ахмадын хувьд анчыг дайснаа гэж үзэх ямар ч үндэс байсангүй. Зеб зөвхөн болж байгаа бүхнийг сайтар харж авья гэсэндээ л модны сүүдэрт байгаа бүхнийг зогссон хэвээр үлджээ.

Колхаун морь унасан толгойгүй хүний мөрийг анхааралтай ширтсээр хажуугаар нь өнгөрлөө.

Зеб Стумп байрнаасаа хөдлөлгүй түрүүчийн морьтой хүн далд орсон хуайсны төгөл ахмадыг халхалтал араас нь харсар байв.

Өвгөн анчны толгойд шинэ санаа төрж, бүх байдлыг дахин тунгаан бодох хэрэгтэй болов.

Хэрэв түрүүн нь морь унасан толгойгүй хүний мөрийг хөөхө үндэс байсан бол одоо тэр нь дахин нэг мөрөөр нэмэгджээ.

Зеб удаан ч бодсонгүй. Кассий Колахуны араас явахаар шийдэв. Төхөөрөөд ч байх юм байсангүй. Жолоогоо барьж, хөгшин гүүгээ өгиглөөд авыбал, цаадах нь ч дорхиноо босоод ирэв. Тэгээд Колхауныг далд ормогц залгай тал руу гарахаар зэхэн зогслоо.

Колхауныг далд орсон хойно бол Зеб түнүий хаашаа явсныг төвөггүй мэдэж чадна. Хоёр шинэхэн мөр түүнд бүрэн хангалттай. Тэдгээрийг даган морь унсан толгойгүй хүн ч мю уу морь унасан зүрхгүй хүнтэй дөрөө нийлүүлэн явж байгаа юм шиг итгэлтэй явж чадна.

Өөрийн туршлагадаа найдсан анчин нуугдсан газраасаа гарч Кассий Колхауны мөрөөр орлоо.

Гэвч энэ удаа Зеб андуурчээ. үүнийгээ хоёр морьтны далд орсон хуайсан төглийг өнгөрөөд мэджээ.

Түүнээс цааш морь унасан толгойгүй хүн хэдийнээ яваад өнгөрсөн талын шохойт зурвас үргэлжилжээ.

Колхауныг тариа хадсан талбайд ятуу эрж шиншлэн яваа, үнэг шиг ийш тийш хэрэн явахыг харангуутаа лтаажээ. Ахмад хөөж явсан мөрөө алдчихаад, олох гэж хичээж байгаа ажээ.

Анч өвгөн хуайсны дор нуугдаж Колхауны хөдлөх бүрийг сэм харж байв.

Ахмад оролдоод оролдоод мөрийг олсонгүй. Шохойт талд тэгээд Кассийн Колхаун шиг туршлагагүй мөрдөгч юу ч олж чадахгүй нь мэдээж. Кассий цааш хэд хэд явснаа орхиё гэж шийдэв бололтой морио ууртай давирч Леон голын зүг давхилаа.

Колхауныг дөнгөж далд ормогц Зеб алдагдсан мөрийг олохоор оролдож эхлэв. Хэдмий их туршлагатай ч гэсэн цөхрөн бууж өгөх хэрэгтэй болжээ. Халуун наранд улайдсан шохойт тал нүд сохлом гялбуулж, юу ч ялгаж харахын аргагүй ажээ.

Анч өвгөн яах ч аргагүй болсон учир гэдрэг эргэж өнөөх түр орхисон мөрөө дахин шиншилж үзэхээршийдлээ. Одоо тэр ямар нэгэн сонирхолтой нээлт хүлээж байгаа гэдэгт хэдийнээ бат итгэж байжээ.

Зеб тэр дорхиноо хугархай тахтай мөр лүү очлоо. Өвгөн цаг алдалгүй уул мөрөөр орж түргэн алхлав. Гүү нь түүний хойнооё түрүүчийнх шигээ дагаж явна.

Зеб хөөж яваа тэр мөрөнд нь өөр хоёр морины мөр нийлсэн газар очоод зөвхөн нэг удаа зогсов.

Гурван морины мөр хэсэг газар ойрхон зэрэгцэж явснаа дараа нь дахин ёулжилдэн бие биеэ дарсан байв.

Тэр морьд цөм тахтай ажээ. Анч өвгөн морьдын мөрний хэвийг сайн харж авах гэж зогслоо. Шин эхоёр морины нэг нь америк үүлдрийн морь, нөгөө нь том мустанг гэдэг нь анч өвгөнд тодорхой болжээ. Түүний туурайн хэмжээ америк морины туурайтай бараг адил байв.

Зеб эдгээр морьдыг мэдэж байгаадаа эргэлзсэнгүй. Аль нь түрүүлж ирснийг таая гэж ч зовсонгүй. Өөрөө харж байсан юм шиг цөм ил байлаа. Мустанг нөгөө хорёынхоо түрүүнд явжээ. Ямаршуухан зайтай явсны нь харахан тодорхойлж чадаагүй авч, ямар ч байсан найз нөхөд зугаалахаар явдаг зайнаас хол гэдэг нь илт байв. Америк морь араас нь явж хамгийн сүүлд хугархай тахтай бас л америк морь явсан байв.

Гурван морь цөм үүгээр өнгөрсөн боловч гагцхүү өөр өөр цагт, ганц ганцаараа явсан байв. Зеб Стумп үүнийг бид цагаар хугацааг, халууны шилээр халууныг хэмждэг шиг яг таг амархан тодорхойлжээ.

-Муу биш шүү гэж хэлээд Зеб сэтгэл ханасан байдалтай цааш явж гарлаа.

Хөгшин гүү хойноос нь яаралгүй дагана. Анч өвгөн зогсч доорхи газраа ажиглан хараад - Тэд эндээс салжээ. Америк морь, мустанг хоё хамт өөрөөр хэлбэл нэг зүгт явсан байна. хугархай

тахтай морь тийшээ эргэжээ. Яагаад тэгж явсны нь мэдвэл мөн сониноо. Би тийм ээдрээтэй мөрийг энэ яваа насандаа үзээгүй юм байна. Даниэл Бунаг ч мангартуулж мэдэх мөр байна. Эхлээд алийг нь хөөх вэ? Тэр хоёр мөрний хойноос явья гэтэл хаа хүрэх нь надад тодорхой байгаа юм. Энэ хоёр мөр асгарсан цусны тэнд очсон байх ёстой. Гурав дахь мөр тийшээ очих нь уу, үгүй юу гэдгийг үзье... Хөгшин минь, надтай ойрхон баруун талаар яв. Тэгэхгүй бол өөхий чинь чононууд зооглочихно шүү! гэв.

Анч өвгөн хөгшин гүүндээ ийнхүү-Өөхий нь” сануулаад инээснээ гурав дахь мөр өөд эргэлээ.

Тэр мөр ширэнгэний захаар явж байснаа нөгөө хоёр мөртэйгээ уншигчдын хэдийнээ танил ойн цоорхойн тэнд ойртож ирсэн байв. Түүнээс хоёр зуугаад алхам хяраатай газар ирээд, хугархай тахтай нь хажуу тийш ширэнгэ рүү оржээ. Тэгээд тавиад алхам зайтай газар модноос уяж байсан ормыг Зеб оллоо.

Морь нь энэ газраас цааш хөдлөөгүйбөгөөд эндээс л өөр зүг рүү боловч тал руу буцсан нь илт байлаа.

Харин унаж явсан хнү цааш явган явсан байв. Морь уяж байсан гаүрын тэндэх, ширгэсэн горхины голдрилд хүни йхөлийн мөр тодхон харагдаж байв.

Анч өвгөн эл “саравчинд” хөгшин гүүгээ орхиод өөрөө тэр яарч явсан хүний мөрөөр явлаа. Төдөлгүй хоёр мөр болсны нэг нь урагшаа нөгөө нь буцаж явсан мөр байв. Зеб түрүүчийнхий нь дагалаа. Мөр түүнийг урьд нь цусан шалбааг байсан боловч одоо чоно юу ч үгүй долоочихсон газраас холгүйхэн цавцаал замд аваачихад огт гайхсаншүй. Мөр мэдээж, цусан шалбаагт хүрсэн байх ёстой бөгөөд харин одоо цавцаал зам олонзуун таханд тахлагджээ.

Гэвч Зеб цааш явахаасаа өмнө маш чухал нээлт хийж амжжээ. Тэр сахЛаг бум сөөг дотор нэлээн удаан хүн зогссон бололтой газрыг ажиглав. Тэнд нь өвс ногоо байсангүй. хөвсгөр зөөлөн газар нь гутал ч юмуу шаахайны уланд юу ч үгүй дагтаршжээ. Сайхь улны мөр эндээс цусан шалбааг рууочоод, тэндээс эргэж ирсэн байв. Хошуучийн даргалсан эрүүлчид тэдний замчин Спенлерийн олж үзээгүй нэг юмыг Зеб ойрхон шиг модны мөчир дээрээс олжээ. Энэ нь сумны жийрэг хийсэн бололтой, нэг тал нь шатаж тортогтсон хэсэг цаас байв.

Тэр цаас хуайсны мөчрийн өргөсөнд тээглэж өлгөгджээ.

Өвгөн анчин модны өргөснөөс цаасыг салган авч лужир том алган дээрээ дэлгэв. Үнгэгдэж түлэгдсэн цаасан дээр түүний сайн танил “А. К. К” гэсэн гурван үсгээр эхэлдэг нэг хүний нэр ус, тушаал дурайх авай.

LXXVII. Гинжний өөр нэгэн үе

ЗеБ Стумп цаасан дээрхийг уншиж үзчихээд царайд нь тааламжтай шинж тодорсон нь гайхсанаасаа илүү ажээ.

-Энэ дугтуйны өөдөс чолон юмны тухай өгүүлж байна гэж Зеб аман дотроо хэлээд - Энэнээс чинь дотор нь байснаас нь илүү их юм мэдэж авч болох юм. сумны чигжээ болгож ашиглажээ... за яах вэ, энэ муу өөдгүй амьтныг үзүүлээд өгье! Бүх төвшин хүмүүсийн хэрэглэдэг бугын тосолсон арьсны оронд ийм ёс бусын юм хэрэглэвээс яадгийгмэдэж аваг гээд цаасыг дахин ажиглаж, үргэлжлүүлэн - Эмэгтэй хүний бичиг байна. Энэ хамаагүй хэрэг өөрт нь хаягласан байхад өөрийнх л юм байж таарна. Үүнийг чинь хадгалах хэрэгтэй юми байна! гэв.

Өвгөн ингэж хэлээд хэт хатгалдаг илгэн хавтгаа гаргаж, олсон хэсэг цаасаа түүнд нямбайлан хийв.

-За өвгөн Зебулон Стумп минь гэж тэр дахин өөрөө өөртэйгээ ярьж, - Чи энэ будлиантай хэргийг нэлээн сайн учры нь олж амжих шигн болох чинь вэ. Ямар нэг юм тодорхойгүй үлдэж, аль нэг газар утас шижим ороолдож байвч энэ бол хамаагүй хэрэг. Алагдсан хүн хэн ч байлаа гэсэн тэр нь цусан толбо байсан тэр газар хэвтэж байжээ. Алсан хүн нь хэн ч байлаа гэсэн энэ модны цаана зогсч бай. хэрэв энэ нусгай журнууд баллачихаагүйсэн бол би өөр ямар нэг юм олж амжих л байлаа. Одоо яах ч арга алга, бүх мөр талхлагдчихсан. Энэ чигт цааш явахын ч хэрэг алга. Хэрэв боломж байвал тэр хугарай тахтай морины буцсан мөрийг хөөж эзнээ ан хийсний нь дараа хаана аваачсаныг л мэдэх нь юунаас ч чухал боллоо. Ингээд өвгөн Стумп та савхин гутлын буцсан мөрөөр явах хэрэгтэй болж байна гэлээ.

Ингэж хэлчихээд анчин өвгөн түүнийг цавцаал замд хүргэсэн нөгөө мөрөөр буцаж алхав. Мөр бараг ялгарахгүй авч Зебд түүний хэрэг хэдийнээ байхгүй болсон байв. энэ мөрийг үлдээсэн хүн яв явсаар морь уяатай байсан газар руу эргэж очсоныг Зеб аль эрт ажиг мэдсэн байжээ.

Гэвч нэг газарт мөр салжээ. Замд нь нэвтэршгүй сөөг дайралдсан учир алуурч хэмээн үзэж байгаа хүн тойрч гарсан байв. Дараа нь буцсан мөр анчинг ойн цоорхойд хүргэсний дараа дахин нийлжээ. Анчин ойн цоорхойг сайтар ажиглав.

Түүн дээр гарсан мөр нь ондоон мөр байв. Энэ нь ойн цоорхойг хөндлөн гарсан дагтаршсан жим байв.

Хэдхэн хоногийн өмнө үүгээр тахалсан морьд өнгөрчээ. Тэдний мөр анчны анхаарлыг татна.

Анчин өвгөн ямар өдөр өнгөрснийг төдийгүй, хэдэн цагт өнгөрсний нь ч андахгүй хэлж чадахаар байв. Үүний тул зөвхөн мөрний хэвийг л сайтар харах хэрэгтэй байлаа.

Гэвч энэ удаа бүх юм ил байв. Энэ нь хошууч морин цэрэгтэйгээ цайз руу буцсаны дараа Спенглертэй үлдсэн жижиг багийн морьдын мөр болохыг тэр андсангүй.

Зеб энэ нэмэгдэл эрүүлийн тухай дуулсан бөгөөд Спенглер түүний дагуулууд Генри Пойндекстерын морины буцсан мөрийг нөгөө негр мөрийг олж авсан газар хүртэл нэхэн хөөжээ.

Ихэнх хүнд хоёр дахь удаа энэ мөрөөр хөөх нь илүүц санагдаж болох боловч Зеб Стумп өөр бодолтой байв. Мөр лүү харан шийдэж ядан зогсоноо

-Хэрэв би надад цаг хүрэлцэх үгүйг л мэддэгсэн бол эхлээд энэ мөрийг хөөмөөр байна... гэж амандаа үглэсэнээ - Шинэ сонин юм олдохыг... хэн байг гэхэв. Харин амждаг нв юу л бол. Тэгэхлээр шууд хугархай тахтай мөрийг л оролдсон нь дээр гэв.

Зеб ойн чөлөөнөөс явахаар шийдэн эргэсэнээ дахин шинэ санаа төрж

-Ер нь эцсийн эцэст дуртай цагтаа хугархай тахны мөрийг олно. Хаашаа очсоны нь тэр муу өөдгүй амьтантай дөрөө нийлүүлж явсан юм шиг л мэдэж байна. Каса-Дель-Корвогийн саравчинд л очоо биз. Өөрөө нэгэнт энд байж байгаа мөртлөө энэ мөрийг орхиход даанч харамсалтай байна. Дахиад арьан бээрч явуулчихаж магадгүй. Цаг хүрэх болов , яах бол. Чөигөр ав, ямар ч байсан жаахан яваад үзье! Хөгшин гүү маань буцаж иртэл хүлээж л байг гэв.

Гэхдээ өвгөн тэдний мөрийг хайхарсангүй. Бүх анхаарал нь Генри Пойндекстерын морины мөрөнд татагджээ. Хэдийгээр эрлийн баг сүүлд өнгөрч зарим мөр тахлагдсан боловч анчин тэгтлээ сонирхсон мөрөө зовлонгүй ялгаж байв. Ямар ч нусан жур үүнийг дөнгөнө гэж хэлэхл хүн. Зал уу эзний морь давхиж явсан бол эрлийнхэн алхуулж явжээ.

Зеб Стумп эрлийнхэн нэг ч зогсолгүй, замаас ч хазайлгүй явсныг харж байв. Харин Генри Пойндекстерын морь нэг газар зөргөөс хажуу тийш гарчээ. Энэ нь цавцаал замаар хоёр гурван бээрийн зайтай газар байв.

Давхиж явсан морь зогсоогүй боловч, чоно, ирвэс, цоохор бар юм уу аль нэг араатнаас айсандаа хажуу тийш огло үсэрчээ.

Цааш нь дахиад л давхисан байв.

Спенглерийн баг морь яагаад хажууу тийш огло харайнв гэдгийг мэдэхээр зогсолгүй, шууд замаа хөөсөн байв.

Харин илүү сониучаараа Зеб Стумп тэр хавьцаа саатажтаарав.

Энэ бол өвс ногоогүй бөгөөд чулуугаар дүүрсэн элсэрхэг газар байв. Энэ хэсэг газар дээр хөндлөн сарвайсан мөчиртэй асар том мод сүглийнэ. Модны нэг мөчир тун намхан бөгөөд жим дээгүүр хөндөлдсөн учир морьтой хүн бөхийлгүй шурган гарч болмооргүй ажээ. Зеб Стумп сайтар ажиглан харж эхэллээ. Тэр мөчрийн холтос нь гэмтсэнбайхыг өвгөн харлаа. Тэр холторхой том биш боловч ер нь л ямар нэг хатуу юмтай мөргөлдсөнөөс гарсан нь иэлрхий байв.

-Энэ бол хүний толгой мөргөжээ гэж анчин өвгөн хэлээд

-Мөчрийн энэ талд морьтой хүн явж, харин нөгөө талд нь тэр хүн морин дээрээ байсангүй. хэн ч тийм юманд цохиулчихаад эмээл дээрээ тогтож байна гэж байхгүй гэв. Тэгээд мөчрийн доорх газрыг анхааралтай харж байснаа - Ура! Гэж баяртай хэлээд - Би тэгж бодож байсан юм. Моиноос унасан ором нь энэ байна. За бас энд мөлхөж. Тэр битүүлэг хавдар вунаас болсныг одоо ойлголоо. Амьтны савраас болсон юм биш гэж би мэдсэн юмаа. Чулуу, модонд ч цохиулсан юм биш байсан юм. ийм л юм мөргөж шүү дээ! гэв.

Баярласандаа царай нь гийсэн Зеб цааш хөнгөхнөөр алхлахдаа зөргөөр биш харин эмээлээсээ ховр цохигдсон хүний мөрөөр шалмагхан явлаа.

Зеб жирийн хүнд ажиглахдахгүй байж магадгүй боловч өөрийнх нь хувьд замын тэмдэгт шонгийн бичээс шиг нь илхэн заалтыг барин явав. Нахийсан мөчир, чөдөр өвсний тасархай, хөрсөн дээр гарсан мөр энэ бүхэн нв үүгээр ямар нэг хүн шургаж өнгөрснийг гэрчилж байв. Түүнээс гадна мөрөө харахад энэ хүн мөлхөж явсан нь илтажээ.

Тэгээд Зеб тэр үйлт хүний мөрөөр горхины эрэг хүртэл явлаа. Цаашаа явахын хэрэгцээ байсангүй. Тасархай утас шижимний нэг хэсэг нь залгагдлаа. Бас жаахан болоод бүх баримт түүний гарт орохоор боллоо.

LXXVIII. Морины андалдаа

Цөхрөнгөө барсан Колхаун, морь унасан толгойгүй хнүий мөр алдагдсан шохойт талыг орхихдоо аман дотроо хараал тавьсаар мориныхоо амыг эргүүлэв.

"Цааш явах ямар хэрэг байна? Хаашаа давхиж одсон нь мэдэгдэхгүй байна. Дахиж дайралдах эсэх нь тохиолдлын хэрэг болно биз. Горхины тэнд дахин дайралдаж магадгүй юм даа? Тэглээ гээд ашиг юу байна! Мустанг миний санааг мэдсэн юм шиг яалаа ч гэсэн ойртуулахгүй. зэрлэг мустангаасаа ч сэргэлэн юм. Мэдээж эзэннь л ийм зантай болгож таарлаа. Нэг л эгзэгтэйхэн буудчихад түүний тэнүүчлэх хөг нь өнгөрөхсөн. гэтэж ойртоно гэж харваас болохгүй Юм. Түүнийг задгай талд энэ муу луусаар хөөж гүйцэнэ гэж үү! Хээр морь шандастай ч хурлан нь юу бол. Маргааш шинэ тахтай болчихсон хойно нь туршаад үзэх юм байна... хэрэв мустангийг гүйцэхээр хурдан морь олвол ч гар татах юм алга. Сууринд олдож болох юм биш үү. Хоёр зуу, бүр гурван зуун доллар байсан ч яахав"

Колхаун ийнхүү өөрөөр өөртэйгээ зөвлөнгөө шохойт таыг орхиж явлаа. Түүний барайсан царай талын гялалзсан цагаан өнгөнөөс даанч эрс тэс ажээ. Хамаг бие нь хөлөрч, давирууланд хайр найргүй хатгуулан цус шүүрснийг нь харахад явдалдаа аль хэдийнээ сульдсан морио хайрлалгүй хар хурдаар нь давхиулав.

Цаг ч өнгөрөөгүй байхад тэрээр Каса-Дель-Корвын тариалангийн газартай залгасан хуайсны төгөлд орж ирэв. Энэ нь Колхауны сайн мэддэг өзөр байлаа. өөр моринор энэ жимээр явж байжээ.

Гангаас болж ширгэсэн горхи гаталж яваад, лагтай голдрил дээр гарсан олон тахны мөр дотроос хугархай тахны мөр олж харчихаад их гайхав.

Хуучин , харваас долоо хоногийнөмнө гарсан мөр байлаа. Гэвч Колхаун мөр хэзээ гарсныг тогтоохоор зогссон хэрэг биш байв. Тэрээр өдөр бүр бүү хэл, цагий нь ч хэлж чадах байлаа.

Энэ мөрийг арилгахын тулмориноос буулаа. Үүнийг хийгээгүй нь ч түүн дээр байжээ. Түүний гуглын өсгий хайлсан шавар дээр хэн хугархай тахтай морийг унаж явсныг илчлэн мөрөө үлдээжээ. Хойхон талд энэ баримтыг алдчихааргүй хүн ойртон ирж явлаа.

Халагдсан ахмад морин дээрээ үсрэн мордоод, өөрийн авхаалжтайд ихэд сэтгэл хангалуун цааш явав.

Гэнэт морин төвөргөөн сонсдов. Мод халхлаад морь нь харагдсангүй.

Төвөргөөн улам ойртов. Морины нэг хэмийн алхаагаар хүн унаж явааг таамаглаж болох байв.

Хормын дараа Колхаун өмнө нь Исидора Коварубио де Лос Льянос байхыг харлаа. Цаадах нь Колхауныг харав. Энэ уулзалт их хачин тохиолдол байсан агаад аль алинд нь жоготой юм бодогдуулжээ.

Өөрийн нь үзэн яддаг хүүхэнд Колхаун дурладгийг Исидора саналаа. Колхаун өөрийнхөө

зөвхөн үзэн яддаг төдийгүй, амь насы нь бүрэлгэхээр шийдсэн хүнд Исидораын дурладгийг бас санажээ.

Тэд энэ тухай хагасы нь хүнээс сонссон, хагасы нь өөрсдийн ажиглалт болон хоёр удаа санамсаргүй уулзахдаа төрсөн сэтгэгдлээс мэдэж авчээ. Аль аль нь нөгөөгийнхөө азгүй дурлалыг сайтар мэдэх бөгөөд аль аль нь өөрийнх нь сэтгэлийг цаадах нь мэдэхгүй юм шиг санаж явдаг ажээ.

Ийн нөхцөл байдалд тэд бие биедээ талтай байх нь үгүй байх аа. зөвхөн ашаа авах хүслэн, хардах нь л тэднийг нэгтгэж болох агаад гэвч энэ нь их л өөдгүй холбооболох байв.

Одоог хүртэл Исидора Коварусио де Лос-Льяносыг Кассий Колхаунтай холбох юм юу ч байсангүй.

Тэр хоёр аль аль нь ялангуяа Исидора ийнхүү уулзахаас зайлсхийж чадвал баярлах байв.

Мексик бүсгүй, өрсөлдөгчид нь сэтгэлтэй, оцорсон ахмадад талгүй байх онцгой гойд юм байгаагүй бөгөөд түүнтйн уулзахыг хүсэхгүй өөр шалтгаан байлаа.

Түүнийг улаан арьстнууд хөөж, тэр нь юу болж дууссаныг бүсгүй санаж байв. Түүнийг тусламж гуйж техасчуудыг дуудчихаад гэнэт алга болсныр нь талаар олон таамаглал гарахыг бас мэдэж байв.

Бүсгүй хэнд ч яагаад ингэсний хэлье гэж бодоогүй бөгөөд одоо өөдөөс нь ирж яваа хүн энэ тухай асууна байх гэж сэтгэлтүгшжээ. Золхауны хажуугаар огт хараагүй юм шиг өнгөрөх нь эвгүй учир Исидора толгой дохих төдийхнөөр өнгөрчихье гэж боджээ. Хэрэв огтын санамсаргүй нэгэн санаа төрөөгүйсэн бол Колхаун ч бас тэгэх байв. Огцорсон ахмад мориныхоо амыг ататж, залуу мексик хүүхний замыг хэрэг зогсоод малгайгаа авч бөхийн ялдамхан мэндлүүт ярилаж эхлэхдээ Исидораг эргүүлбэ гэсэндээтэгсэн хэрэг биш байлаа. Исидора хариу ярилцахаас өөр арга байсангүй.

-Хатагтай минь уучлаарай гэж Золхаун бүсгүйг бус морий нь гөлрөн байж хэлээд - таны огт танихгүй хүн ингэж таныг саатуулсан нь зүй бус хэрэг гэдгийг би мэдэж байна... гэв.

-Зүгээр эрхэм минь, уучлал гуйх хэрэггүй. хэрэв би эндүүрээгүй бол хэдийн бид Нуэсесийн та нутаг дугнд уулзсан шүү дээ.

-Тийм. тийм. Та нээрээ хэлж байна гэж тэр уулзалтыг мартчихсан бол илүүд үзэх байсан Колхаун түгдрэн хэлээд - Би тантай энэ тухай ярих гээгүй, харин ганганы ирмэг дээгүүр давхиж цвсныг тань ярих гэсэн юм. Таны гэнэт алга болсонд бид цөм сэтгэл зовсон шүү гэв.

-Эрхэм минь гайхах юу байх вэ? Танарын нэгийн чинв буудёан сум намайг тэр хөөж явсан улсаас чөлөөлсөн юм. Би тэдний буцаад явчихыг хараад, замаа үргэлжлүүлэхээр шийдсэн юм.

Бүсгүйн булзамхай хариулт харваас Колхауныг төдий их гомдоосонгүй. Тэрээр өөрийн сонирхсон сэдвийг ярьж эхлээгүй байсан бөгөөд санаснаа олж авна гэдэг найдьяараа алдаагүй

байлаа.

Чухам юу ярих гээд байгааг нь таахад амархан. Исидорагийн морийг морь мэддэг хүн ч юмуу, хурдан морины хүн шиг ширтэхий нь халт харахад хангалттай.

-Хатагтай минь би өөрийгөө таныг гэнэт алга болсонд гайхаж байсан улсын нэг гэж хэлж байгаа юм биш. Танд тэгээд явчих ямар нэг шалтгаан байжээ гэж бодсон юм. Би таныг ганганы ирмэгдээгүүр дүүлж явахыг харсан болхоор санаа ер зовоогүй шүү. Таны моринд гойд гарамгайг бид бүгдээрээ гайхацгаасан шүү. Харин таны унаж явсан морь ямар сүрхий морь байваа! Тэр чинь давхиж байгаа биш, зүгээр л нисч байгаа юм шиг санагдсан. Хэрэв би эндүүрэгүй бол та одоо тэр морьтойгоо явах шив дээ? Ийм дэмийном асуусанд минь уучлаарай.

-За байз бодъя... Би олон морь унадаг л даа. Тиймээ, би тэр өдөр энэ морийг унаж явсан шиг санаж байна. Тийм, тийм яриагүй үнэн. Энэ намайг тэр улсад яаж барьж өгснийг санаж байна.

-Таныг барьж өгсөн гэнээ? Яаж тэр вэ?

-Бүр хоёр ч удаа гээч. Эхлээд танай эрлийнхнийг ойртож ирэхэд, дараа нь индиан нарт, аа тийм тэднийг индиан биш байсан гэж хожим нь надад хэлсэн юм байна!

-Гэвч энэ морь таныг яахаараа барьж өгдөг болж байна?

-Янцгаагаад л. Уг нь ингэх ёсгүй байсан юм. Ингэж болохгүй гэж их л сургасан юм... За яах вэ. Би Рио-Грандад буцаж очингуутаа үүнийг хаяна. Тэгээд бэлчээртээ гараг!

-Авхай минь уучлаарай! Гэхдээ энэ чинь их гунигтай хэрэг болох нь байна.

-Юу гунигтай гэж?

-Ийм сайн морь дахиж эмээл тохуулахгүй байна гэдэг. Би л бол ийм морьтой болохын тул мөнгө хайрлахгүй дээ.

-Эрхэм та хошигнож байна уу? Үүнд тийм гоц гойд юм юу байна? Зөвхөн бусад мустангийг бодвол бие хараа жаахан сайтай, хурдан л морь доо. Манай аавынд үүнтэй адил таван мянган морь бий. Тэдний олонхи нь үүнээс хурдан сайхан гэдэгт эргэлзэх юмгүй. Энэ морь үнэндээ холын замд шанадастай болохоор нь би унаж яваа юм. Одоо Рио-Гранд руу гэртээ буцаж явна. Тэрнээс биш танд юмуу, шшнийг авах гэж тантай адил хорхойсч байгаа ямар ч хүнд дуртай өгчихнө... Хөдлөхгүй зогсооч, морьтон минь! Чамайг надаас илүү таалж байгаа энэ хүнийг хараач.

Сүүлчийн өгүүлбэрийг эзэнтэйгээ адил яриа дуусгахыг тэсч ядан хүлээж буй мустангад зориулжээ.

Колхаун бол ямар ч байсан энэ яриаг үргэлжлүүлэн, ядахдаа инэгж дуусгахыг хүссэнгүй.

-Хатагтай минь уучлаарай гэж Колхаун ажил хэрэгч царай гарган, нэлээд эрс биш дуугаар хэлээд - хэрэв та бор мустангаа тэгж доогуур үнэлж байгаа бол би өөрийнхөө мориор дуртайяа солихсон. Миний морь танхы шиг сайна биш ч гэсэн техасын олон авгайчуул чамлалтгүй үнэ хаяж байсан юм. Хэдийгээр хурдан хөлгийн нэг биш ч гэлээ таныг гэрт чинь эсэн мэнд хүргэчихээд, хожим ч сайн унаа болно гэж би танд зоригтой амлана гэлээ.

-Эрхэм минь, та юу ярьж байна! гэж Исидора гайхан дуу алдаад - Таны сайхан америк морийг мексикийн мустангераар солих гэж үү? Энэ ч жирийн нэг даапаалсан юм шиг санагдаж байна. Рио-Грандад бол таны моринд гцурав юмуу зургаан мустанг өгнө гэдгийг та мэдэн биз дээ?

Колхаун үүнийг тун сайн мэдэж байжээ. Гэвч тэгэхийн хамт өөрийнх нь морь шиг хэдэн арван мориноос Исидорагийн мустанг илүү хэрэгтэй гэдгийг ч бас ойлгож байв. Энэхүүтал нутгийн унаганы ер бусын хурданг бусдын амнаас сонссоныг тооцоохоо байлаа гэхэд өөрийн нүдээр бэлхнээ харсан юм чинь. Энэ моины төлөө зөвхөн өөрийн унаанаас гадна хичнээн ч мөнгө нэмж өгөхөд бэлэн байв. Аз нь дайрахад бүсгүйн толгойд учрыг нь олж лавлан асуух бодол төрсөнгүй. Исидора шунамхай сэтгэлтэй хүн ч биш, эцгийнх нь морины саравчинд чухамдаа бэлчээрт таван мянгаад адуун сүрэг бэлчээрлэнэ. Ийн ялимгүй гуйлты нь, хэдийгээр танихгүй, тэр бүү хэл дайсан нь ч байж болох байлаа гэсэн юундаа татгалзаад байх билээ!! Бүсгүй татгалзсангүй.

-Эрхэм минь, хэрэв та хошигноогүй юм бол соль л доо гэж Исидора хэлэв.

-Хатагтай минь, би бүр үнэн голоосоо хэлж байна.

-Тэгвэл ав гэж хэлээд Исидора бууж, олмоо тайлж эхлэн- Эмээлтэй нь сольж болохгүй. Таны эмээл надад дэндүү томдоно гэв.

Колхаун баярлахдаа хэлэх үг олсонгүй. Хүүхнийг эмээлээ авахд нь туслах гэж яаран даара нь өөрсийнхөө эмээлийг авав.

Таван минут ч бололгүй морины андалдаа дууслаа. Эмээл хазаар нт хуучин эзэддээ үлдэв.

Энэ бүхэн нь Исидорад тун зугаатай санагдаад, инээдээ арай ядан барьж байлаа.

Харин Колхаун бол өөрөөр хандаж байлаа. Түүний бодсон нь дэндүү ноцтой ажээ.

Тэд “баяртай” гэсэн ердийн үгнээс өөр гоц юм ярилгүй салж явцгаав. Исидора америк морь унаж явлаа. Харин ахмад Золхаун бор мустангаар Каса-Дель-Корво шилтгээн тийм замаа үргэлжлүүлэв.

LXXIX. Ядрахыг мэддэггүй мөрч

Зеб гүүнийхээ уяатай байгаа газар руу эргэж явлаа. Өвгөн шугуйн зам зөргийг сайн мэддэг учир цавцаал зам руу шуудхан явав.

Зеб хугархай тахтай морины мөрийг дахин хөөж морь Каса-Дель-Корвод авч очно гэдэгт бүрэн итгэж байв. Зам Рио-Гранд, Инж цайз хобын хоорондох гарцыг холбосон замын хажуугаар явжээ. Энэ зам нь хүн болгон дуртай газраараа явж байдаг техасын ердийн үзэгдэл болсон, ерөнхий чигий нь гаргасан хагас бээр орчим арган зам ажээ.

Хугархай тахтай морь замын захаар явсан байв. Гэвч Инж цайзаас гурав дөрвөн бээрийн зайтай очоод гэнэт өнцөг гарган Пойндекстерын тариалан байх ёстой газар руу бараг харалгүй, замын шонгоор тэмдэглэгдсэн газраар явж байгаа юм шиг хурдан урагшилна. Хэдийгээр Зеб мориор явахдаа туйлын дургүй хүн ч гэсэн энэ удаа талаар болон төглөөр ядартлаа таваргасандаа болоод аяллаа мориор дуугахаар болжээ. Байсгээд л газар руу хяламхийж явсан нь хугарсан тахны мөрөөр явж өайна уу, үгүй юу гэдгээ шалгасан хэрэг бус, ямар нэг шинэ юм гараад ирж магадгүй хэмээн горьдсоных ажээ.

Тал нутгийн зарим газар нь үлэмж хатуу бөгөөд огт мөр гараагүй байв. Жирийн нэг хүн бол энэ газраар өөрөө хамгийн түрүүнд явж байна гэж санахсан билээ. харин туршлагатай мөрч Зеб Стумп тал нжтгийн чийгтэй зөөлнө хөрсөнд ул мөр хэзээ дахин тодорч харагдахыг төө ч алдахааргүй яг таг мэднэ. Заримдаа мөр алдагдмагц өвгөн анчин жаахан мурийгаад л олчихно.

Пойндекстерын тариалангийн газар руу анч өвгөн болгоомжтой ч гэлээ итгэлтэйгээр дөхөж очлоо. Асотейгийн арсгар хашлага хуайсны орой дээгүүр харагдаж байв. Гжэнэт зам дээр ажиглаж харсан ямар нэг зүйл түүний байдлыг өөрчиллөө. Тэгээд эмээлээсээ буун харайж, уолоо цулбуураа хөгшин гүүнийхээ хүзүүн дээгүүр хаячихаад мөр даган явган явлаа. Эзнийхээ гэнэтийн олон занд хэдийнээ дасал болчихсон бололтой гүү зогссон ч үгүй араас нь гэлдрэв.

Юмны учир мэдэхгүй хүний нүдэнд бол Зебийг мориноосоо яагаад тэгж буусныг ойлгоход хэцүү юм. Энэ нь хүн амьтны мөр хүрээгүй юм шиг харагдмаар газар байлаа. Харин мориноосоо буун хайраисан Зебийн ганцаараа ярих ярианаас юун тухай болохыг мэдэж болох ажээ.

-Түүний мөр! Гэртээ буцаж ирэхээ хэмээн Зеб нам дуугаар донжтой хэлээд мөрийг даган аажуухан алхлаа.

Удалгүй мөр түүнийг төгөлд аваачиж хэдэн минутын дараагаар өвгөн анчин хөншин гүү хоёр нэвтэрч гарахын аргагүй өргөст бут замы нь хаасан мэт гэнэтхэн зогтусав.

Гэвч ийм юм байсангүй. тэдний өмнө цэлийсэн задгай зам зурайна. Үүнээс болж л зогсжээ.

Өмнө нь бараг ширгэсэн шахуу энд тэнд нь жижиг шалбааг л үлдсэн горхины голдрилтой судаг байлаа. Голдрилын шавар дундуур морио хөтөлж явсан хүний мөр гарчээ.

Морины хувьд яарч яваа эзнээ дагаж явнаас өөр юм өайсангүй. харин эзэн нь юу хийгээ вэ? Түүний хөдөлж аягласан нь туршлаггүй хүнийг тэвдүүлмээр ойлгомжгүй ажээ.

Гэвч Зеб Стумп нэг хормоос илүү тэвдсэнгүй.

Тэрээр сайхь хүний санааг бараг тэр дорхиноо тааж

-Хугархай тахны мөрийг л арилгах гэж оролдоо шив дээ! Ямар ч ашиггүй, мистер Колхаун, ямар ч нэмэргүй. Оронд нь та өөрийнхөө мөрийг үлдээчихэж Намайг хуурч дөнгөхгүй ээ. Би мөрөөр чиньтамд очих байсан ч хамаагүй мөрдөнө дөө! гэж бувгналаа.

Анчныг энэ үгээ дуусгаж байх үед нөгөө хүн нь хийдгээ хийчихээд мориндоо мордон цааш явж байжээ.

Зеб арааса нь явган дагав. Харваас Колхаунаас хараа салгахгүй байя гэж хичээсэнгүй. Ахмадын мөрийг алдахгүй гэдэгтээ итгэлтэй байв. Анчин одоо Каса- дель Корвын шилтгээнхүртэл зогсохгүй гэж үзээд тайван алхаж гарлаа.

Гэвч Зеб Стумп эндүүрчээ. Кассий Колхаун, Исидора Коварубио де Лос- Ланостой санамсаргүй уулзсаныг хэн ч урьдчилан харах билээ дээ! гэвч Зеб хэдийгээр гайхсан ч гэсэн мэдэгдэхгүй байж чаджээ. Харин ч бүр улам болгоомжлох болов.

Анч өвгөн эргэж, гүүнийхээ чихэнд нэг юм шивэгнэчихээд хуайсаншугуй дундуур явлаа.

Гүү нь араас нь дуулгавартай чимээгүй дагав. Удалгүй Зеб таг зогсоход гүү нь ч гэсэн сүүдэр нь мэт таг зогсов.

Балар өтгөн ногоон мод хөгжилтэй ярилцаж байгаа хоёр хүнээс анч өвгөнийг тусгаарлаж байв.

Өвгөн өөрийгөө мэдэгдчихээс айн нуугдсан газраасаа гараагүй боловч тэдний яриаг нэгд нэгэнгүй сонсчээ. Тэгээд морио андаалцан солилцтол нь яриаг нь чагнан түүнээс хойш нэлээн удтал байрнаасаа хөдөлсөнгүй. Харин тэр хоёрыг өөр өөрийн замаар салж явмагц Зеб нуугдаж байсан газраасаа ил гарав. Анч өвгөн тэр хоёрын морио сольсон газар очи зогсоод ийш тийг харан

-Иосафат минь! Хоёр чөтгөрийн хооронд холбоо тогтжээ. Хэн нь хожсоныг мэдэх юмсан! Гэж дуу алдав.

LXXX. Хаалга харуулдсан нь

Зеб Стумпыг нөгөө морины андалцааг нөмөр доороос нь ажиглан байсан төглөөс гарч иртэл нэлээд удав. Исидора Колхаун хоёрын бараа тасарсны дараа л төглөөс цухуйв. Тэгээд Зеб чухам хэний нь араас дагахаа шийдэж ядна уу гэлтэй зогсов.

Гэвч энэ нь ерөөсөө тэгсэн хэрэг биш өбайв. Ердийн заншлаараа бүгдийг тунгаах бодохын тулд л зогсжээ. Түүний бүх ухаан санаа дөнгөж сая болж өнгөрсөн морины солинд чиглэгджээ. Тэр Колхауны бүх яриа, гуйлтыг сонссон байв. Энэ нь л Зебийг тэвдүүлэн чухамдаа түүнийг бодолд оруулсан хэрэг. Колхаунд морь солих ямар хэрэг байв аа?

Мексик хүүхний хэлдэг үнэн гэж Зеб мэдэж байлаа. Үнэндээ америк морь бол мустангаас хавьгүй илүү үнэтэй. Тэрчлэн Колхаун бол тийм тэнэг наймаа хийх хүн биш гэдгийг Зеб бас мэдэж байв. Колхаун яагаад тийм алдаатай наймаа хийх болов?

Анч өвгөн эсгий бүрхээ авч өрвийсөн үсээ хоёр дахин илээд, дараа нь эрүүгээ барилан тэндээс л хариу эрж байна уу гэлтэй газар руу ширтлээ.

-Үүнд зөвхөн нэг л тайлбар байж болох юм гэж хэлээд - Бор мустанг, америк мориноос хурдан нь маргаангүй. Мистер Каш чүүнээс нь болоод л шилж авсан хэрэг. Тэгээгүй юм бол ямар чөтгөрөө хийж, Техаст дуртай газраа дөрвөн мустангаар, мексикт бол бүр наймаар солих морио өгөх билээ дээ? Мустангийг хурднаас нь болоод л өгчихөвөөдөө янз нь. Гэвч яагаад?... Өө, хараач хөөш! Би таачих шиг боллоо. Түүнд... хэрэгтэй байж л дээ. Түүнд толгойгүй хүнийг хөөж гүйцэх морь хэрэгтэй. Энэ ч алган дээр тавстан юм шиг илт байна. Би өөрөө харсан. Одоо нөгөөдөх нь л нүдэнд үзэгддэг юм бол мустангаар гүйцнэ гэж найдаж байгаа хүнбайх нь. Колхаун эрэлд гарах нь лав. Одоо каса-Дель Корвод очиж өл залгахаар явжээ. Тэнд удахгүй. Удалгүй түүнийг талд байхыг нь хэн нэг хүн харна. Энэ нь Зебулон Стумп байж таарах вий гэснээ гүү рүүгээ эргэж - За, аль вэ адгуус минь явъя. Гэр рүүгээ явна гэж бодоо юу? Хонгор минь андуурчээ. Чи энд нэг хоёр цаг ч юмуу, магадгүй бүтэн шөнөжингөө чидээшлэх болно. Гэвч зүгээр хөгшин минь. Энд өвс ногоо ихтэй, чамд түүнийг чимхлэх цаг мундахгүй. Гүзээгээ дүүртэл идээшилж ав гэв.

Ингэж хэлээд Зеб морио амгайвчилж, жолоогоо идээшлэхэд нь саад болгохгүйн тул бүүргэндээ өлөгв. Тэгээд түүнийг нуугдаж байсан төгөлдөө орхиж өөрөө Колхауны мөрийг дагалаа. Хоёр зуун алхам хяраатай яваад төгөл дуусан, задгай хөндий үргэлжлэв. Хөндийн нөгөө үзүүрт Каса-Дель Корво шилтгээн харагдана.

Ордны нүүр талын цайвар өнгөн дээр морьтой хүний бараа харагдсанаа удсан ч үгүй хаалганы цаагуур далд орчихов.

Зеб хэн болохыг нь мэдэж байв.

-Би эндээс түүний хэзээ гарч ирэхийг харж болох юм байна гэж бувтнасанаа - Түүнийг өглөө болтол ч хамаагүй отно! Тэгэхээр тэвчих л хэрэгтэй... гэв.

Зеб эхлээд өвдөглөнсуув. Тэгснээ жаахан холбилзон нуруугаараа хуайс налж суулаа. Дараа нь

хэлхгэр халааснаасаа жижиг уут гаргаж ирэв. Тэр дотор нь эрдэнэ шишийн гамбир, том хэрчим гайхайн шарсан мах, үнэрээр нь үзэхэд моногахелийн вискитэй дашмаг байв.

Зеб гамбир, махныхаа талыг идэж, үлдсэний нь уутандаа буцааж хийгээд толгой дээрх мөчирт өлгөлөө. Тэгээд хойноос нь дашмагтайгаасаа нэг сайн балгаж аваад гаансаа нэрэн хоёр гараа элэн дээрээ зөрүүлэн, дахин мод налж Каса-Дель-Корвын хаалганаас нүд салгалгүй ширтэж эхэллээ. Тийнхүү хаалганаас хараа салгалгүй хоёр цаг суулаа.

Шилтгээний хаалгаар эрэгтэй эмэгтэй хүмүүс гарцгааж байв. Хэдий зайтай ч гэсэн тэдний арьсны өнгө, даруухан хувцсаар зарц нар гэдгийг тааж болохоор ажээ. Түүнээс гадна цөм явган явцгааж байв. Харин Зебийн отоож байга хүн гарч ирвэл морьтой л гарч ирэх ёстой байлаа.

Нар ороход Зеб илүү тохиромжтой газар олохоор түр отоогоо когсоов. Хөхөмдөг бүрий бууж ирэхэд Зеб яаралгүй босоод тухтайхан бодох гэсэн шиг мод налав.

"Энэ үнэг шөнө юм уу эсвэл үүрийн өмнөхөн гарч ирж байж бүрэн болох юм. Тал нутгийн аль чигт явахыг би мэдэж авах нь чухал... Гүүгээ чирч явахын хэрэг лага. Энэ надад дараа болно. Тэрнээс гадна сартай шөнө үүнийг негрүүд харчихаж болно. Энд орхисон нь дээр. Аюулгүйгээс гадна идээшилж л байг" гэж өвгөн дотроо бодлоо.

Тэгээд морь руугаа очиж эмээлий нь аваад, морио урт аргамжаар модноос аргамжин, ганзаган дахь хуучин хөнжлөө авч гар дээгүүрээ тохоод Каса-ДельКорвын зүг явлаа.

Тэр нь шөнийн гүйлгүүр сүүдэр өөрийг нь халхалж байхаар нэг үе түргэн, нэг үе удаан алхалж гарав.

Энэ нь илүү болгоомжлол биш байв. Халхлах юмгүй задгайнугыг хөндлөн гарч явсан хэрэг. Энд тэнд ганц хоёр мод байвч дэндүү хол зайтай учир очиж ядаж явтал нь шилтгээнээс, ялангуяа асотей дээрээс амархаан харчихаж болохоор ажээ.

Байсгээд л таг зогсж, бүрэнхий өтгөрөн харанхуйлахыг хүлээнэ. Нөр сүрмөсөн жаргахад Зеб ордноос барагцаалбал хоёр зуун алхам зайтай оччихсон байв. Өвгөн анчин бүхэлшөнийг ч өнгөрөөж магадгүй тэр зорьсон газраа хүрчээ.

Хол бус газар намхан сөөг ургажээ. Зеб түүн доогуур шургаж хэвтээд дахин шилтгээний хаалгыг харуулдаж эхлэв.

Анөчин өвгөн бүхэл шөнийн турш хоёр нүдээ нэг ч удаа зэрэг анилгүй, нэгий нь анисан ч нөгөөхөөр нь хаалгагы харан өнгөрөөв. Түүний маш чухал юм хийж байгааг ер бусынбуурь суурьтай царайнаас нь харж болно.

Анхандаа боолчуудын урцнаас гарч байгаа үе үе инээн хүнгэнэх дуу нэгэн хэвийн сэргэг бөйдлы нь эвдэж байв. Гэвч негрүүд ердийнхөөсөө илүү биеэ барьсан байдалтай байлаа.

Хийлийн уянгалаг дуу, банджо хөгжмийн цоглог ая зэрэг ерийн үед үдэш негрийн сууцнаас гарч байдаг дуу хуур үл сносдоно.

Шилтгээний уйтгартай чимээгүй байдал боолуудад ч нөлөөлжээ. Шөнө дундын үед хүмүүсийн дуу татарч, эргэн тойрны чимээ аниргүйн дунд зөвхөн чонын үргэлжилсэн улилтыг хариулан нохдын хуцах л хааяа сонсогдоно.

Зеб маш хүнд өдрийг өнгөрөөсөн учир нойр нь өөрийн эрхгүй хүрнэ. Тэгээд бүр үүрэглэдгийн даваан дээр босч ногоон дээгүүр биеийнхээ чилээг гарган явав. Дараа нь дахин сууж, бутан дунд шургаад гаансаар нэрлээ. Зеб ордны дааман хаалганаас шөнийн турш нүд салгасангүй. _ гэвч нэг ч удаа онгойлгоогүйг сарны гэрэлд сайн харж байв.

Үүрийн туяа нь нар жаргахын адил анчин өвгөнийг хянах байраа дахин өөрчлөхөд хүргэв. Тэнгэрийн хаячанд нарны туяа дөнгөж тусмагц өвгөн сэм босч хөнжлөө нөмрөн Каса-Дель-Корв руу нуруугаа харуулан үдэш ирсэн замаараа буцаж явлаа.

Дахиад л явдлаа нэг түргэсгэн, нэг удаашруулж, байн байн зогсон, эргэж харж явав.

Тэгээд өчигдөр орой дэргэд нь сууж хооллосон өнөөх модондоо нэгэнт хүрэв. Тэнд түрүүчийн байдлаараа сууж аваад өглөөний хоолоо идэв. Үлдсэн хэсэг мах, эрдэнэшишийн тал гамбир нь тэр дорхиноо алга болов. Дараа нь дашмагт үлдсэн архи ч хоосорлоо.

Зеб тамхиа нэрээд асаах гэснээ хэт, цахиураа гэнэт илгэн уутандаа буцаагаад хйичихэв.

Каса-Дель Корвын саарал хананд өглөөн й хөхөмдөг утаан дунд хар цэг гарч исрэн нь хаалга нээгдсэн хэрэг байлаа.

Яг энэ хоромдшахуу тэндээс давжаа биетэй бор морьтой хүн гарч ирэн хаалга хаагдав.

Зеб үүнийг сонирхсонгүй. зөвхөн эртэч тэр эрийг аль зүгт явахыг л харав. Минут ч болоогүй байтал морь хүн хоёр өөр лүү нь эргэлээ.

Зеб Стумп хүн морь хоёрыг харж цаг алдсангүй. Өөрий нь отож байгаа хүн өнөө л мориороо явж байна гэдэгт эргэлзсэнгүй. Мөн морьтон дахин үүгээр өнгөрнө гэдгий ч тааж байв.

Зеб хөгшин гүү рүүгээ очоод түргэн эмээллээж хэнд ч харагдалгүй ажиглаж болохоор ширэнгийн хэсэг рүү хөтлөн аваачив.

Анч өвгөн нуугдаж аваад морьтой хүний ойртож ирэхийг отон хүлээв. Тэр хүн бол ахмад Кассий Колхаун мөн нэдгийг өвгөн мэдэж байв.

Зеб ахмадыг дөнгөж далд ормогц мориндоо харайн мордож давируулын оронд хутгаараа хатгаад ухасхийв. Өвгөн кассий Колхауны хойноос заавал бараагий нь харах гэлгүй дагаж явав.

Яагаад вэ гэвэл шүүдэрт бүрхэгдсэн өвс ногоо нь мөрч өвгөнд цэвэр цаас шиг, тийм ил тодорхой байлаа. Ийм ч учраас морь нь хатирч давхисан ч өвгөн түүнийг зовлонгүй уншиж

урагшилна.

LXXXI. Уруугаа харсан үзэгдэл

Бор мустангий нь эмээллэж өгсөн Плутаноос өөр ямар нэг хүн өөрий нь харсныг сэжиглээгүй Кассий Колхаун шилтгээнээс тал нутгийн зүг оджээ.

Тэр Зеб Стумпийннуугдан зогсч байгаа газрын хажуугаар өнгөрөхдөө юу ч сэжиглэсэнгүй. Ийм муу гэрэлд хэн ч түүнийг харахгүй гэж боджээ.

Колхаун төгөл дотроос гараад Нуэсесийн эрэг тийш цогиулан, хааяа хатируулж явав. Эхний найман бээр газрыг юу ч сонирхож харалгүй өнгөрөөв. Хааяа нэг холын бараа харсан болоод л зөвхөн урагшаа довтолгоно. Хоёр талругаа харсан ч үгүй. харин төглийн захаас нэлээн хол очсон хойно ганц удаа л эргэж харжээ.

Сэтгэл санаагий нь цаг ямагт амруулахгүй байгаа юмныхаа барааг хараахан хараагүй л явав.

Тэр чухам юу болохыг зөвхөн тэр өөрөө, бас нэг хүн болох Зеб Стумп л мэдэж байлаа.

Хэн нэгэн хүн өөрийнх нь өглөө эрт мордсон зорилгыг таамаглаж байна хэмээх бодол Колхауны толгойд ч орсон ч үгүй.

Хэдийгээр өвгөн анчин зөвхөн өөрийн таамаглал дээр үндэс болгосон боловч, огцорсон ахмад өөрт нь нууцаа итгэн дэлгэсэн мэт түүндээ итгэлтэй байлаа. Колхаун морь унасан толгойгүй хүнийг энэ удаа хөөн гүйцэж магадгүй гэсэн итгэлтэйгээр эрэхээр гарлаа гэдгийг мэдэж байв.

Унасан морь нь техасын буга шиг хурдан давхиж чадах боловч Колхаун амжилтдаа төдий л итгэхгүй байлаа. Морь унасан толгойгүй хүн өнөөдөр түүний нүдэнд харагдахгүй байж ч магадгүй юм. Энэ магадлагааг бодон зам хороож явлаа.

Ийм тодорхойгүй байдал сэтгэлий нь түгшүүлнэ. Гэвч сүүлийн хэд хоногт болсон явдлыг санан чухал итгэл төрнө. Колхаун урьд нь нэг газар эрж явсан юмтайгаа хоёр дахин дайралдсан билээ. Дахиад нэг... дайралдахыг хэн байг гэхэв.

Энэ бол хүн амины хэрэг гарсан гэж үзэж байгаа цавцаал замын эхээс холгүйхэн ойн захын ногооннуга юм.

"Үргэлж тэнд буцаж очоод байдаг нь хачин юм! Чөтгөр шиг хачин! Нөгөө... юугаа яг таг мэдээд байгаа юм шиг. Тэнэг юм! Тэндхийн өвс ногоо нь амт шимтэй, ойролцоо утсай болохоор тэр. За яахав, өнөөдөр бас л урьдынх шигээ тэнд байхад нь уулзана гэж найдъя. Хэрэв эс дайралдвал ширэнгэдотор эрэхээс өөр аргагүй. Энэ маань өдөр ч гэсэн явахад аятайхан биш газар. Ер нь ингэхэд мустангер шоронд аль хэдийнээ орчихоод байгаа хойно би юунаасаа айх вэ? Ямар нотолгоо байга юм бэ? Зөвхөн нэг л хэсэгхэн тугалга. Гэвч би түүнийг үхтэлээ хөөцөлдөж байгаад ч болсон олж авна даа" гэж Колхаун дотроо бодож байлаа.

-Тэнгэр минь! Энэ юу гэгч вэ?

Колхаун сүүлчийн үгээ дуулдахаар хэлээд мустангаа хойд хоёр хөл дээрээ бараг бостол нь жолоогоо татлаа. Тэр нь айснаасаа болоод бүлтэрчих дөхсөн нүдээр амьтныг ширтэнэ.

Гайхах юм байсангүй. Түүний өмнө тодрон гарсан зураг хөмгийг зүрхтэй хүнийг ч мэгдүүлэхээр ажээ.

Тэнгэрийн хаяанднаран яг мандаж байв. Түүний өмнө ойртож яваа төглөөс хөөрсөн хөхөвтөр униар будан суунаглана. Модод нь хөх ягаан хөнгөн манангаар борхэгдэн дээд үзүүр нь номин тэнгэртэй сүлэгдэн нийлжээ.

Энэ манангийн дэвсгэр дээр ч юмуу эсвэл цаад талд нь, хэрэв Колхаун урьд нь хараагүй бол огтхон ч үнэмшмээргүй хөдөлж байгаа дүрс харагдах нь тэр. Энэ бол морь унасан толгойгүй хүн байлаа.

Харин түүнийг тийм байдалтай байхыг Колхаун ч, өөр хэн ч хэзээ ч хараагүй ажээ.! Одоо тэр морьтой хүн шал өөрөөр харагдаж байлаа. Тэр төрх байдлаараа өнөөх л бахь байдаг хэвээрээ боловч биеийн хэмжээ нь арав дахин томорчээ.

Энэ болхүн биш аварга том амьтан бөгөөд морины дүрстэй хэрэм цамхаг мэт өндөр адгуус унажээ.

Бас ч үүгээр зогсохгүй, сүр баар нь хачин тайлбарлахын аргагүй өөр болсон байлаа. Тэр амьтан газар дээгүүр биш, тэнгэр дээгүүр, морь хүн хоёрын хөл нь дээшээ харан явж байв. Морины туурай мананы дээд кахад тодохон харагдахбөгөөд харин хүний дал мөр нь \би толгой нь гэж хэлэх дөхөв\ бараг тэнгэрийн хаяа шүргэн алдаж байв. Мөрөн дээгүүрээ тохсон серапе нь уруу нь харуулсан дүрсэд тохирдог байлаа ч, таталтын хуулиас гадуур тогтож байв. Тэрчлэн морины нь урт сүүл, жолоо цулбуур агаарт яахан тогтож байгаа нь үл ойлгогдоно.

Эхлээдсүүдэгнэл гэмээр энэ аймшигт үзэгдэл яаралгүй алгуур хөдөлж байв. Колхаун айснаасаа болж хөшчихсөн мэт түүнийг харж байлаа.

Гэнэт өөрчлөлт гарч, нөгөө том амьтны бараа хоромхон зуур бүртэлзэн морь нь эргээд хэдийгээр туурай нь тэнгэрийг шүргэж байгаа ч эсрэг зүг рүүгээ цогиулав.

Сүүдэгнэл айсандпаа зугтан одох нь тэр!

Хэрэв бор мустанг нь байгаагүй бол айснаасаа хөшиж орхисон Колхаун байрнаасаа ч хөдлөлгүй, түүнийг явуулчих байлаа. Гэвч мустанг огцом эргэхэд халагдсан ахмад таавартай нүүр нүүрээрээ мөргөлдөх ын тэр.

Талын ногоон дээгүүр явж байгаа туурайны чимээ сонсдов. Колхаун, хэрэв жинхэнэ гэж хэлж болдог юм бол, нөгөө аймшигт сүүдрийг гаргасан жинхэнэ морь унасан хүн өмнө нь байгааг ойлголоо.

-Энэ чинь зэрэглээ байж! Гэж ахмад хэлээд - Би ийм юманд хууртай байдаг мөн ч тэнэг ээ! Би түүнээс л айж шүү дээ! Гэтэл ганц эрж хайж яваа юм маань байдаг! Тэгээд ийм ойрхон

ирчихсэн байдаг. Хэрэв би мэдсэнсэн бол намайг харахаас нь өмнө барьчих байж. За, одоо л элдээд байна даа! Техасын зах хягаар хүрдэг юм ч гэлээ, гүйцэхдээ л гүйцнэ гэв.

Нэгэн зэрэг л гилж, ташуурдаж, давхируулдах нь тэр. Ингээд таван минутын дараа гэхэд талаар хочр морьтон байдгаараа харайлгаж гарлаа. Аль аль нь хурдан хөлөг унажээ. Нэг нь нөгөөгөө хөөнө. Хөөгдөж яваа нь толгойгүй хүн байв. Хөөж яваа нь толгойтойгоор барахгши тэр толгойд нь солиотой бодол эргэлдэж байлаа.

Тэд удаан хөөцөлдсөнгүй. Колхаун яллаа хэмээн баярлаж байлаа... Түний морь илүү хурдан давхина. Давируулдаж ташуурдуулсандаа ч юмуу эсвэл хээр морь нэг их айгаазгүй болоод хүчээ гаргаагүй ч байж болох юм. Бор мустанг хэрээ гүйцэх нь илт болов. Зай багасахын хэрээр Колхаун буугаа зэхэв. Хээр мориог нь буудан, түүнийг хөөхөө үүгээрэцэс болгохыг хүсжээ.

Гэвч тэр алдаж буудахаас айж байлаа. Гашуун туршлагаасаа санамж аван гарцаагүй болгохын тул улам ойртохыг хичээн, гохоо дарсангүй. Ингэж эргэлзэж байхын хооронд хээр морь гэнэт ширэнгэ рүү эргэн давхилаа.

Ахмад тэгнэ чинээ санаагүй явсан учир бас хоцорчихов. Дахиад хагас бээр давхиж байж дахин ойртож авлаа. дэндүү сайн танил, нөгөө цус тунасан газар руу ойртож ирлээ.

Бусад ямар ч нөхцөлд байсан Колхаун тэр газрыг тойрон өнгөрөхийг хичээх байсан авч одоо бол түүний дурсамжийг таягдан ирээдүйн өмнөх айх айдсыг төрүүлсэн цорын ганц зүйлийг л бодож явав. Зөвхөн ёрын морьтонг л гартаа оруулсан цагт тайвшран, нөгөө айлгаад байгаа зүйлээсээ салж болох байлаа. Колхаун морь унасан толгойгүй хүнийг хөөн гүйцэв. Бор мустангийн нь сартганан амьсгаадаж байгаа хамар хээр морины хийсч сөхөгдсөн сүүлэнд ширгэн алдхаар ойрхон очжээ. Ахмадын зүүн гарт буу нь бэлэн зэхээстэй, баруун гарын хуруу нь гохон дээр тавиастай байв. Тэр зөвхөн буудахад аятай газрыг сонгож явлаа.

Бас жаахан байзнасан бол хар хурдаараа давхиж яваа морь суманд хадагдах байв. Гэтэл морь аюулыг мэдсэн юм шиг гэнэт хажуу тийшээ огло харайгаад, мустангийн хамар өөд тангарчихаад чанга унгалдан өөр тийш давхин одов.

Колхаун ч, морь нь ч самгардав. Бор морь цааш явалгүй зогссон боловч хурц давируулын хүчээр дахин хурдлав. Одоо Колхаун морио түрүүчийнхээсээ улам илүү шамдуулах болов.

Гэвч хээр морь зөргөөр давхиахаа болиод төгөл рүү чиглэн явж байгааг ажиглав. Авлалт нь бас дахин үр дүнгүй өнгөрч мэдэхээр болжээ. Колхаун мориныхоо хурдан найдаж байв. Хэрэг иймээр эргэх нь чинээ санаагүй явжээ. Тэд төглийн захаар хөөцөлдөж явсан бөгөөд морь унасан толгойгүй хүн ногоон мөчирт хагас халхлагдаад байлаа. Морины зөвхөн хондлой нь л харагдаж байв. Хөөж яваа хүн түүн рүү нь шагайв.

Бууны амнаас угаа манасхийхийн зэрэгцээ буудах чимээ гарч буугаа дахин шүүрэн авлаа. Утаанаас л гараад ирэв үү гэлтнй ямар нэг бараан юм газарт чимээгүйхэн ойчив. Ойж,

бөмбөрч явснаа яг Колхауны морины хөлийн дор зогсох нь тэр. Зогссон ч гэсэн эрчигнүүр эргэлдэхээ болиод зогсодоох далбилздаг шиг далбилдав.

Бор мустанг хамраа дуугарган гэдрэг ухрав. Колхаун ч айсандаа муухай бахирлаа.

Энд гайхах юм байсангүй. Ногоон дээр хүний толгой хэвтэж байв. Бас тэгээд хатуу дугариг хүрээтэй бүрх малгайтайгий нь яана. Түүнээсээ болоод далбилдаж байжээ. Үхээнц зэвхий өнгөтэй, цус нөж болсон үрчгэр нүүр нь яг Колхаун руу харжээ. Нүд нь хараастай бөгөөд хочр шилэн бөмбөлөг мэт амьгүй гөлийсөн нүд аймаар зэвүүн ширтэнэ. Амирлангуй инээмсэглэн хөшчихсөн мэт хөхөрсөн уруулын завсраар цагаан шүд гялалзана.

Кассий Колхауны харсан юм ийм байлаа. Түүнийг айж дагжин харав. Ер бусын юм харж мэгдсэндээ ч тэр бус, харин чухам юу болсныг сайтар мэдсэндээ тэгжээ. Тэрээр энэхүү таг чиг боловч олныг өгүүлсэн толгойн хажууд удаан зогссонгүй. Колхаун мориныхоо амыг эргүүлж хажуу хавирга руу нь шигдтэл давираад хар хурдаар давхин одов.

Ширэнгийн бутан дундуур шургачин орж байгаа морь цунасан толгойгүй хүний хойноос Колхаун дахин хөөсөнгүй. тал руу эргэн Каса-Дель-Корво руу буцаж давхилаа.

LXXXII. Аймшигтай боодол

Анч өвгөн ширэнгэ төгөл дотрооё гараад ахмадын мөрөөр өөрийн мэдэлд бүтэн өдөр байгаа хүн шиг яаралгүй явав.

Гэвч царайг нь сайн ажиглавал тэсч ядан, сандарч түгшсэн байдал илэрхий. Эмээл дээрээ холбилзон алсыг хүчлэн ширтэнэ.

Зеб Колхауны мөрийг бараг анхаарсангүй. Алдчихгүйн тул зэрвэс харахад л хангалттай байв. Эл мөрөөр гүү нь ганцаархнаа ч яваад байж чадах ажээ.

Гэлээ ч өвгөн анчин мөр тод болохоор аажуурсан хэрэг биш байв. Харин ч Колхауныг хараанаасаа алдахгүй байхыг хичээнэ. Гэвч цаадахдаа харагдчихаад санаснаа биелүүлэхэд нь саад болох байв.

Энэ санасан нь бүхнээс чухал байсан агаад Колхауны хөдөлж байгааг зөвхөн мөрөөр нь л мэдэж болох ажээ.

Хором ч зогсолгүй, аажуухан, болгоомжтой хөдөлсөөр Зеб нөгөө Колхауны зэрэглээ харсан газар хүрч очлоо. Ногоон талтай нийлжээ. Гэвч Зебийн харсан зүйл түүнийг тийм ч багагүй сонирхуулав. Хоёр эгнээ мөрний хоёр дахь нь Колхаунышинэ мориных бөгөөд Зеб түүний нь хэмжиж үзэв.

Эхэнд нь ямар морь өнгөрснийг тааж ядаад байх юм байсангүй. Тэр мөрийг хөгшин гүүнийхээ мөрөөс илүү сайн таньж байв.

-Ямар ч гэсэн энэ золиг чинь түүнийг олж амжжээ гэж Зеб хэлээд мөрийг ажиглан харснаа бодол болон - Гэвч түүнийг хараахан бариад авчихсан гэсэнхэрэг биш. Ер нь тэгээд аяж мэдэх вэ? Мустанг адилахн мустангаа хараад ойртуулчихаж магадгүй. Хэрэв тэгчихсэн байвал... Би юугаа хийж энд зогсоно вэ? Одоо мунгинах цаг биш. Хэрэв Колхаун, морь унасан толгойгүй хүнийг гүйцээд, хэрэгтэйгээ хийчихсэн бол би чинь хоосон авдарт хорогой эрнэ гэгчээр аль ч үгүй хоцорно. Бушуулах хэрэгтэй! Хөгшин минь явъя! Хагас цагийн өмнө үүгээр явж өнгөрсөн тэр бор морийг гүйцэхийг хичээ. Чи тэрнээс доргүй давхидгаа үзүүл. За явъя! Гэж гүүндээ хэлэв.

Анч өвгөн хутгаа хэрэглэсэнгүй гүүнийхээ хажуу руу ганц давируулаараа ёвроход гүү нь ухасхийн хатирлаа. Зеб хухрдан явахыг одоохондоо түүнээс шаардалгүй, түрүүчийнхээ хэвээр болгоомжтой бөөгөөд урагшаа гярхай харж явав.

-Мөр явсан чигээр чухам хаашаа очсоны нь зэгсэн тодруулж чадах л байна гэж анчин өвгөн бодоод - Бүх зам тэнд нийлсэн юм шиг. Хөөрхий өнөөх хүн бас л энэ замаар хэзээ ч эргэж ирэхгүйгээр явсан юм. Яая гэх вэ дээ? Хэрэв түүнийг дахин амьдруулж болдоггүй юм бол амь насы нь бусниулсан бузар этгээдээр амий нь төлүүлэх хэрэгтэй юм. Одоогоор өөрийг нь сэжиглэж буйг мэдээ ч үгүй тэр нэг амьтгнаар... Зогс! Өнөөх чинь! Аа, тэр нь морь унасан толгойгүй хүн байна! Хар хурдаараа давхиж байна. Чөтгөр ав, бор мустанг хээрийг заавал гүйцнэ. Тэд наашаа ирж яваа биш болохоор бид хоёр нуугдаххэрэггүй. Гэвч тайван зогсч бай!

Одоо хөдөлж болохгүй. Тэгвэл биднийг харчихна. Үгүй ерөө! Тоглоомдоо хэтэрхий улайраад яг өмнөө яваа юмнаас өөр юу ч харахгүй байна... Тэгнээ тэр. Би тэгнэ гэж бодсон юм. Шууд цавцаал руу явчихлаа. За гүү минь урагшилья! Гэв.

Зеб Стумп цавцаал замаас нүд салгалгүй явсаар ой руу орлоо.

Хоёр морьтон хөөцөлдсөөр замаар эргэн харагдахгүй болсон ч анчин цавцаал замын голоор явсангүй, хажуугийнх нь сөөг дундуур урагшлав. Тэгэхдээ замыг нэлээд урагш харж байхаар өмнөөс нь хүн ирвэл өөрөө болон гүүгээ харагдуулахгүй байхаар явж яадав. Үнэндээ тэр хэн нэгэнтэй, ялангуяа удалгүй бараагий нь харах хүнтэйгээ уулзана гэж бодолгүй явав.

Буун дуу гарсанд Зеб төдий л их гайхсангүй. Харин ч тэдний хөөлдөж явааг анх харснаасаа эхлээд буудахгүй байгаад нь гайхах шахууявжээ. Буун дугаар ангийн буу болохы нь таньж тэр буу хэнд байх ёстойг ч мэдэж байлаа. Харин буун дуу гарснаас хойш тавхан минут болоод бууны эзэн үхлээс сүнсээ зайлтал айсан юм шиг хар хурлаараа буцан давхиж явааг хараад гайхжээ.

-Ийм түргэн буцаж байдаг гэж Зеб бувтнаснаа - хачин юм... Нэг юм болжээ дээ! аан! Чөтгөрт хөөгдсөн юм шиг харайлгаж явна! Одоо нөгөө толгойгүй хүн нь араас нь хөөж яваа ч байж магадгүй. Өртэй хүн өгч амарна гэдэг дээ. Тийм л юм болоо вий. Үүнийг харахын тул би мөнгөн доллар ч хайрлахгүйсэн_ Ха-Ха.ха! гэв.

Анчин өвгөн аль хэдийнээ эмээлээсээ бууж гүүгээ төгөл рүү лавхан оруулсан нь одоохон хажуугаар нь өнгөрөн зугтааж яваа морьтой хүнд харагдахгүй гэсэн хэрэг байлаа.

Гэвч Колхаун Зебийг яг өмнө нь цавцаал зам дээр зогсч байсан ч анзаарахгүйгээт тийм сандарч тэвдсэн байдалтай давхиж байв.

"Бурхан минь! гэж анч өвгөн ахмадын айу хувирсан царайг хармагц дотроо хэлээд - Түүний хойноос чөтгөр хөөгөөгүй юмаа гэхэд лав сэтгэлд нь буг шүглэчихэж. Би энэ яваа насандаа ийм аймшигтай царай хараагүй. Түүний гэргий болох хүүхнийг өрөвдөж байна. хөөрхий зайлуул, Пойндекстер авхай! Үүнээс мултарч, энэ муу өөдгүй амьтантай суухгүй байж дөнгөдөг л байгаа даа... Ер нь энэ юу болж байнаа? Ямар ч юм хөөж гарч ирэхгүй байхад хар хурдаараа зугадсаар байх юм. Одоо хаашаа явж байгаа нь энэ вэ? Хойноос нь дагах хэрэгтэй" гэж бодов.

-Өө, гэр рүүгээ буцах нь! Гэж Үеб ширэнгэний захад гарч, Колхауныг Каса-Дель корвын тийш давхиж явахыг харж хэлээд бор морийг бараа тасрахад - Гэр рүүгээ буцах нь лав байна! За хөгшин минь хоёулаа нөгөө тийшээ явж, тэнд юу буудсаныг мэдье гэв.

LXXXIII. Хууль сахиулагчид

Морис Жеральд цэргийн шоронд орсноос хойш гурав хоносны дараа халуун нь дарагдаж, дэмийрэхээ зогсоод, дөрөв дэх өдрөө бараг эрүүл болжээ. Тав дахь өдөр нь шүүх ажиллагаа хийхээр тогтсон байв.

Өөр ямар ч газар хүнлэг бус гэж үзэгдэхэр ийнхүү яарах нь гэмт хэрэг үйлдсэн өдөр нь хүнийг шүүгээд, дүүжлээд хаячих нь цөөнгүй байдаг Техас нутагт хамгийн жирийн зүйл байлаа. Хоригдож байгаа хүний олон дайсан ямар нэг далд санаагаар шүүх өдрийг түргэсгэхийг элдвээр оролдож байхад, цөөн хэдэн найз нөхөд нь түүнийг хойшлуулчихаар зүйлийг гаргаж чадахгүй байв.

Суурингийн олонхи нь гэмт хэрэгтнийг үтэр түргэн шүүхийг шаардан

“Алуулсан хүний цус өшөө авахыг нэхэж байна” гэдэг улиг домог болсон өгүүлбэрийг давтацгаана.

Хойшлуулахгүй шүүхийг шаардсан хүмүүст нэгэн санамсаргүй байдал бүр ч дэмжлэг болжээ. Тойргийн ерөнхий шүүгч яг энэ үеэр тойргоо эргэж явсан агаад Инж цайзад энэ долоо хоногт ирэхээрболсон байжээ.

Ийнхүү Морис Жеральдын хэргийг бусад эрүүгийн гэмт хэргүүдийн хамт аль болох түргэн таслах хэрэгтэй болсон аж: Ийнхүү хэн ч татгалзаж, хэн ч хойшлуулахыг гуйсангүй. Шүүх таслах ажиллагааг энэ сарын арван таванд явуулахаар тогтоожээ.

Хэрэгтэн хүн өмгөөлөгч үаардах эрхтэй боловч сууринд өмгөөлөгч байсангүй. Сайхь хил орчмын нутгаар өмгөөлөгч нарнь ихэвчлэн шүүгчдийн хамт явцгаадаг бөгөөд шүүгч нь хараахан ирээгүй байв. Гэвч Сан-Антониогийн нэгэн нэртэй өмгөөлөгч мустангерийг хамгаалахаар сууринд ирсэн байв. Өөрийнхөө санаачилгаар ирсэн гэдгээ мэдэгджээ.

Энэ нь жирийн уужим сэтгэл гаргасан ч всуу эсвэл хэдийгээр эмэгтэй хүнээс их шан авсандаа ирсэн юм гэцгээх боловч конгрессийн сонгуулийн өмнө олныдунд нэр олж авья гэсэн хэрэг байж болох ажээ.

“Бороо нэг л эхэлчихвэл цутгачихна” гэж Техасын тэнгэрийг үнэнээр нь тодорхойлж байдаг үг энэ удаа хууль цаазны хүмүүсийн хувьд тохирмоор болж иржээ.

Шүүхийн өмнөхөн Инжид бас нэг хуульч ирж хэрэгтэнг өмгөөлнө гэдгээ мэдэгдэв.

Тэрээр Сан-Антониогийн өмгөөлөгчөөс илүү хол замыгтуулж хүн амины хэрэгт тулгагдсан хүнтэй нүүр тулан учралын тул Ирландын нийслэлээс гаран Атлантын далайг гаталжээ. Үнэндээ сүүлийн үеийн байдлыг тэр хуульч урьдчилан мэдээгүй явсан бөгөөд өөр хэргээр мустангертай уулзах гэж иржээ. Тэгээд обердофердын буудалд буухад нь түүнд Морис Жеральдыг шоронд сууж байга гэж хэлэхэд нь багагүй гайхжээ. Тэгээд ямархэрэгт тулгагдаад байгаагийг нь дуулаад бүр ч гайхав.

-Юу! Жеральдын удам хүн алсан хэргээр яллагдаад байгаа гэнээ? Баллахын шилтгээн, түнгий үзэсгэлэнт цэнгэлдэх цэцэрлэгийн эзэн хүн шүү! Надад бүх баримт бичиг нь байна! Түүн рүү намайг аваачаадах! Гэж шаардав.

Хэдийгээр Обердорф шинэ суугчаа солиотой гэж сэжиглэсэн боловч ямар ч байсан зарцаасихилгын шоронд хүргэж өгүүлэхээр цуг явуулжээ.

Хэрэв ирланд хуульч солиотой юмаа гэхэд түүний солиоролд зүй тогтолцоо байлаа. Түүнийг хоригдсон хүнтэй уулзахыг зөвшөөрснөөр барахгүй бүр дуртай цагтаа орж гарч байхаар болгожээ.

Тэрээр энэ эрхийг хошуучид зарим нэг баримт сэлт үзүүлэн олж авсан бөгөөд мөн түүнийхээ тусламжаар Сан-Антаниогийн өмгөөлөгчтэй найрсаг харилцаа тогтоожээ.

Ийм эзгэтэй үед ирландын хуульч ирсэн нь цайз, суурин болон ойр хавийн тариалангийн газар ихээхэн хэл яриа дэгдээжээ. Обердофердын баарнд янз бүрийн таамаглал яригдах болж, эзнээс нь дуулсан зарим зүйлс ирландын зочныг сонирхох явдлыг улам ч гааруулжээ.

Гэвч далайн цаанаас ирсэн өмгөөлөгч мэргэжлийнхээ уламжлалд үнэнч хүн байв. Гайхсанаасаа болоод илүү юм хэлчихсэн ялимгүй эндэгдэл эхлээд гаргачихсанаас өөр илүү дутуу юм ярилгүй амаа хамхичихжээ.

Ер нь ч түүнд яриад байх зав байсангүй. Шүүх эхлэхийн өмнөхөн ирсэн болохоор тоотой хэдэн цагийг хоригдсон хүнтэй шоронд ярилцах ч юмуу, эсвэл Сан- Антаниогийн шүүгчтэй уулзан өнгөрөөж байв. Морис Жеральд түүнд ямар нэг аймаар түүх ярьсан гэдэг цуу таржээ. Гэвч хэн ч тодорхой юм сэдсэнгүй цөм л үгэнд дурлан байж ядна.

Энэ түүхийг зөвхөн ганц хүн Зеб Стумп мэдэж байв. хэрэгтэн ч, өмгөөлөгч ч юу ч хэлээгүй ч гэсэн бас өөр нэг хүн мэдэж болох байв.

Зеб үзэгдсэнгүй. Өмгөөлөгч нартай зөвхөн ганц удаа л ярилцжээ. Үүний дараа алга болж, хэн ч түүнийг шоронд ч, сууринд ч харсангүй. Бүгд л Зебийг нөгөө ангаа хөөгөөд явчихжээ гэж боджээ.

Гэвч тэд цөм эндүүрсэн байв. Энэ удаа Зеб ан амьтан эрж ой модоор тэнэж явсан биш, харин морь цнасан толгойгүй хүний авд мордсон байжээ.

LXXXIV. Эелдэг зээ

"Тэнгэрийн ач!" Түүнийг маргааш шүүнэ. Тэр муу бузар адгуусыг энэ хооронд хэн нэг нь барьж амжихгүй байхаа! Ер нь хэзээ ч барьж чадахгүй дэ. Надад айж болгоомжлох юм алга. Тэргүйгээр юу болсныгхэн ч нотолж дөнгөхгүй!

Би өөрөө ямар нэг юм ойлгож байгаа бол намайг ч гэсэн дүүжлэг! Зөвхөн дуг... л ойлгож байна. Ирландын энэ будлианы эзэн энд яах гэж ирсэн юм бол, хачин юм даа? Бас тэр Сан-Антанионих ч гэсэн! Тэднийг хэн яах гэж дуудав? Хэн хөлсий нь төлсөн юмбол? Ер нь ч тэгээд энэ надад ямар хамаатай юм. Би яалаа ч гэсэн айхгүй. Тэд хичнэнч хичээгээд Жеральдаас өөр хэнийг ч сэжиглэж чадахгүй. Бүх баримт нотолгоо түүний эсрэг, цөм түүнд нь итгэж байна. Түүнийг буруутан болохыг хүлээхгүй байхын аргагүй. гагцхүү Зеб Стумп л өөрөөр бодож байгаа даа. Энэ муу хөгшин үнэг ямагт хэрэггүй юманд хошуу дүрж байдаг амьтан! Аль хэдийнээс харагдахаа байлаа. Хаашаа лага болчихов. Анд явсан гэгцгээх юм. Одоо тэгж явдаг цаг биш дээ. хэрэв өнөөхийн хойноос явчихсан бол яана? Тэгээд гэнэт бариад авчихвал яана? Би өөрөө дахиад нэг оролдож үзэх л юм. Гэвч одоо нэгэнт өнгөрчээ. Маргааш орой болоход бүх хэрэг зүйл дуусна. Гэтэл хожим илэрвэл... Чөтгөр аваг, энэ тухай одоо болохын хэрэг юу байна. Зөвхөн одоо л юм бүхэн журам горимоороо байх хэрэгтэй. Дараа нь юу болох нь хамаагүй. Нэгийг дүүжилчихээд сүүлд нь өөр буруутанг эрэх нв гайгүй байлгүй. Ямар нэг сэжигтэй юм илэдгэ юмаа гэхэд тэд дарахыг л бодно. Эс тэгвэл гэмгүй хүн дүүжилсэн хэрэгт орно...

Сэм Мэнли ч эргэлзэхээ больсон шиг байна. Тэр нэгэн шөнө сонссон зүйлээ ярьж өгөөд түүний эргэлзээг арилгасан юм. Үнэндээ би ярьснаасаа бага вюм сонссон чгэсэн энэ мааньболоод л явчихсан. Ер нь ч ирээдүйг бодох юу байна! Луиза түүнтэй уулзаа л биз, тэгээд гүйцээ. Өөр ертөнцөд л уулздаггүй юм биш бол хойшид хэзээ ч уулзахгүй нь лав. гэвч энэ бол өөрөөс нь л шалтгаалах хэрэг... Ер нь яагаа ч үгүй байж болох... Зөвхөн ачийг санаж, талархлаа илэрхийлсэн ч байж болно доо. Үгүй, үгүй! Зөвхөн талархаж явдгаасаа болоод цэцэрлэгийн гүнд болзоот газраа очихоор шөнө дунд орноосоо босох ёсгүй. Луиза түүнд дурлажээ, дурлаж! За яах вэ, дурласан л байг! Тэр хүн хэзээ ч түүний нөхөр болохгүй. Хэрэв зөрүүдлээд л байдаг юм биш бол, хэзээ ч түүнтэй уулзахгүй. Зөрүүдэллээ гэхэд цаадахыгаа буруутахад л нэмэр болно. Хүүхнийг ганц үг хэлэхэд л цаад хүний хүзүүг дүүжлүүрийн гогцоо ороож авна. Хэрэв миний хоёр ч удаа гуйсан өөр нэг үгийг хэлдэггүй л юм бол тэр үгээ хэлэх болно. Гурав дахь удаагаа сүүлчийнх болно доо. Тэгээд л татгалзвал би тэдэнд үзүүлээд өгье! Зөвхөн тэр өөдгүй ирланд дүүжлүүлээд зогсохгүй, түүний амь үрэгдсэний буруутан нь Луиза өөрөө болно. Тэгээд эдлэн газар, орон байр, зарц боолууд цөм...

Колхаун ийнхүү бодол болон байтал гэрийн эзэн орж ирэн бодлы нь тасалдуулах нь тэр.

-Өө, Вудли ах! Та надад яг хэрэг болоод байлаа.

Гутарч цөхрөн дуугаа хураасан Вудли Пойндекстер Каса-Дель Корвынгудам дундуур үг дууугүй сэлгүүцэн явж байв. Тэр зээгийнхээ тасалгаанд ямар ч бодож санасан юмгүй санамсаргүй ороод иржээ.

-Хэрэг болох ий? Яагаад?

Уй гашууд дарагдсан өвгөний дууны өнгөнд ямар нэг дуулгавартай тэр бүү хэл зулгуйдсан шинж тодров. Өөрийнхөө өмнө хоёр зуун боолыг бөхөлзүүлж байдаг эрхэмсэг Пойндекстер одоо ивээн тэтгэгчийнхээ өмнө зогсч байгаа нь энэ. Үнэндээ бол эгчийнх нь хүү өөрийнх нь зээ байлаа. Гэвч ингэлээ гээд хөнгөрсөн юм байсангүй. Өвгөн эзэн Колхауны зан аашийг хэтэрхий сайн мэддэг байв.

-Би тантай лугийн талаар ярилцах гэсэн юм гэж Колхаун хариу өчлөө.

Энэ бол Вудли Пойндекстерын ямагт зайлсхийж байдаг болсон яг тэр сэдэв нь байлаа. Эзэн тэр асуудлыг бодохоосоо ч айдаг бөгөөд ялангуяа түүнийг хэлэлцэх, тэгээд энэ яриаг эхэлж буй хүнтэй ярилцана гэхээс улам ч айх болжээ. Гэлээ ч гайхаж байгаагаа ил гаргасангүй. Ер нь ч гайхсангүй. ийм яриа болохыг хүлээж байжээ.

Колхауны ярианы өнгөнд ямар ч сайн юмны тэмдэг байсангүй. харин ч хүсэл гуйлтаас илүү, шахалт шаардлага гарч ирэв.

-Лугийн талаар гэнээ? Тухайлбал юу юм бэ? гэж Пойндекстер тайван байдал үзүүлэн асуув.

-Тэгэхээр ийм байна гэж Колхаун энэ яриа үүсгэхийг шийдээгэй юм шиг эсвэл тээнэгэлзэж байгаагаа үзүүлэх гэсэн мэт нэлээд түгдрэн хэлээд - Би... би нэг юм хэлэх гэсэн юм гэв.

Энэ байдлыг нь ашиглан өвгөн эзэн

-Би одоохондоо түүний тухай ярихыг хэсэхгүй байна гэв.

Эзэн үүнийг бараг гуйсан маягтай хэлэв.

-За яагаад тэр вэ, ахаа? Гэж хэлсэн нь дургүйцсэн боловч Колхаун асуув.

-Яагаад тэр болохы нь чи өөрөө мэднэ шүү дээ

-Танд хэцүү байгааг би ойлгож байна. хөөрхий Генриа алга болсон. Түүнийг.... Юу гэж үзэж байгаа ч гэлээ тэр эргээд ирж ч мэднэ. Тэгвэл бүх юм сайнаар эргэнэ....

-Хэзээч ирэхгүй Бид түүнийг амьд, үхсэн али н боловч үзэхээс өнгөрсөн. Би хүүгүй боллоо!

-Харин танд охин байна. Тэр охин чинь...

-Охин минь миний нэрийг гутаасан шүү дээ!

-Би түүнд итгэхгүй байна, үгүй...

-Би өөрийнхөө үзэж, дуулсан юмыг яаж өөрөөр тайлбарлах юмбэ? Ямар юм тэр охиныг гав ганцаархны хорин бээрийн тэртээх жирийн нэг морины панзчны овоохой руу очин толгойны нь дэргэд суулгадаг байна аа? Бурхан минь! Тэгээд бас яахаараа миний охин

өөрийнх нь дүүг алсан хүнийг өмгөөлдөг байна аа? Ээ, бурхан минь!

-Нэгдүгээрийн хувьд Луиза хангамжтай тайлбар өгсөн \Гэвч Колхаун өөрөө үүнд итгээгүй байв\ Хоёрдугаар нь бас л ойлгомжтой. Ямар ч хүүхэн яг л тэгэх байсан. Ямар ч байлаа гэсэн Луиза шиг хүүхнүүд тэгж л таарна.

-Түүн шиг нь гэнээ? Үгүй шүү? Эцэг нь болох би хэлж байна! Ээ чааваас чи биний хэлсэнд итгэдэг ч болоосой. Хөөрхий охин минь! Хүү минь үгүй болчихоод байхад, одоо охин минь л цорынганц баяр баясгалан минь юм.

-Таны хүүтэй болох... танд хэдийнээ ойр дотно бөгөөд нас барсан хүүгий чинь орлох гэж хамаг чадлаараа мэрийх хүнтэй болох чинь зөвхөн охиноос чинь л шалтгаална. Вудли ах минь би оньсого ярихыг хүсэхгүй байна. та миний бодлыг мэднэ. Лу миний эхнэр байгаасай гэж би хүсч байна.

Эзэн энэ үгийг сонсоод өчүүхэн төдий гайхсангүй. Чухам тэгж хэлэхий нь хүлээж байжээ. Гэлээ ч царай зүс нь улам барайж эхлэв.

Энэ гэрлэлтийн тухай бодох нь түүнд аятайхан биш гэдэг нь илт байв. Энэ нь хачин санагдаж болох л юм. Пойндекстер сүүлийн үе хүртэл өөр бодолтой байсан бөгөөд үнэндээ нэг бус удаа охиноо зээтэйгэ суучих гэж тун болгоомжтой ятгаж үзжээ.

Пойндекстер Техаст ирэхээсээ өмнө өөрийнхөө зээг сайн мэдээгүй байжээ.

Колхаун эрийн цээнд хүрсэн цагаасаа хэдийгээр Миссипи муж улсын иргэн байсан ч хөгжил зугаа ихтэй шинэ Орлеанд ихэнх цагаа өнгөрүүлсэн байжээ. Луизиан дахь эдлэн газраар нь явдлын далимд ирдэг байв. Гэтэл хожим Луиза өсч үзэсгэлэнтэй сайхан бүсгүй болоход Колхаун байн байн ирж, тэднийхээр удаан айлчидаг болжээ _

Дараа нь Кассий Мексикийн дайнд жил шахам оролцож ахмад цол авчээ. Тэрээр байлдааны гавьяа байгуулсныхаа дараа креол хүүхний сэтгэл зүрхийг булаана гэсэн бат итгэлтэйгээр эх орондоо эргэж иржээ.

Тэр цагаас хойш Колхаун нагац ахынхаа гэрээс бараг холдсонгүй. Тэр хүн залуу бүсгүйн сэтгэлийг булааж яадаагүй юм гэхэд түүний эцгийн хүсэлт зочин болж чадсан бөгөөд учир нь хөгшинд талтай болох итгэлтэй аргыг эзэмшсэн байлаа.

Хэзээ нэг цагт баян чинээлэг хүн байсан газрын эзэн сүүлийн жилүүдэд хурдан хоосорч, цамаан цалгин амьдрал нь өр шир тавихад хүргэжээ. Зээ нь харин ядуу амьтнаас баян хүн болж чаджээ. Тохиолдлоор л ийм болсон хэрэг. Тэгээд тэдний хооронд ажил хэргийн холбоо бий болсон нь зүй ёсны хэрэг. Луизианд бол Пойндекстерыг зээгийнхээ өртөн нь гэж таамаглах хүн бараг байсангүй. Тэнд бүхний хүндэтгэлийг хүлээх учир Колхауны омгорхог зангаа гаргахыг нь бариад байжээ. Зөвхөн Техаст ирсний нь дарагаас л тэдний харилцаа өртөн зээлдүүлэгч хоёрын хооронд гарч ирдэг онцлог шинжтэй болж иржээ. Колхаун Луизаг шамдангуй эргүүлэх болж Луиза ч түүний нь тас түс зөвшөөрөхгүй болоод ирэхээр тэр харьцаа нь улам хурцдав.

Одоо хөгшин эзэн зээгийнхээ зан араншинг улам ч сайн мэдэх бололцоотой болж Каса-Дель-Корвод ирснээс хойш цөхрөл нь өдөр бүр нэмэгдэж байжээ.

Мустангертай Колхауны үзэлцсэн болоод тэр хэргийн төгсгөл нь өвгөн Пойндекстерыг хамтааныхаа хувьд талд нь орох ёстой байсан ч гэлээ зээгээ хүндэтгэх явдлыг нэмэгдүүлсэнгүй.

Зээдээ сайнгүй байхыг нь нэмэгдүүлсэн өөр ч нөхцөл байдал байсан бөгөөд тэр байдлаас болоод хэдийгээр ашиг гарах талтай ч гэсэн эл гэрлэлтийг санаанд нийцэмгүй болгожээ.

-Хэрэв би зөв ойлгож байгаа бол Кассий чи хуримын тухай ярьж байх шив дээ. Гэр бүлийн дотор эмгэнэл учраад байхад энэ тухай бодох цаг юм гэж үү? Хүмүүс ч юу гэж шуугилдах юм билээ!

-Ах та намайг ойлгосонгүй. Би хуримын тухай яриагүй. Өөрөөр хэлбэл одоохон гэрлэх тухай яриагүй байна. Би зөвхөн гэрлэнэ гэдэг ямар нэг итгэлтэй байхыг л хүсч байна. Тэгээд л илүү боломжтой үеийг хүлээхийг зөвшөөрнө.

-Каш би чамайг нэг л... ойлгохгүй байна.

-Миний үгийг сонс. Би танд бүгдийг тайдбарлаж өгье.

-Ярь л даа.

-За тэгэхээр ийм байна. Би гэрлэхээр шийдлээ. Нас минь гуч дөхсөнийг та мэднэ. Хүн ийм насандоо хорвоогоор дэмий тэнэжявахаас залхчихдаг юм. Энэ маань намайг үхтэл залхааж цаашид гон бие, гозон толгой хэвээр явах санаа алга. Одоохондоо түүний ямар ч эргэлзээ төрүүлэхгүйгээр эрс шийдэмгий, тодорхой амлалт хэрэгтэй. Тэгээд энэ бүр эвгүй зүйл, уй гашуу арилахаар хуримын тухай болоод бусад зүйлийн тухай ярьж тохиролцох цаг олдоно.

"Эвгүй явдал" гэсэн үг болон ажил хэргийн чанартай яриа нь хүүдээ гашуудан буй эцгийн чихэнд доромжлолтой сонсогджээ. Эгдүү хөдлөн жигшсэн нь өвгөний хуучин бардам занг сэргээв.

Гэвч энэ нь удсангүй. Нэг талаар газар эдлэн, боол зарц, эд агуурс, нийгмийн байдал нь түүний санаанд орж, нөгөө талаар үхэл мэт санагдах ядуурал санаанд нь оржээ.

Тэглээ ч гэсэн өвгөн эзэн шалчийтлаа бууж өгсөнгүй гэдэг нь түүний хариултаас илт байв.

-Кассий минь, хаа очиж чи зэгсэн ойлгомжтой ярилаа. Гэхдээ охин минь чамд талтай эсэхийг би мэдэхгүй байна. Чи түүнийг эхнэрээ болгож авахыг зөвшөөрнө гэж байна. Харин түүний санал ямар байгаа юм бол доо? Бүх юм үүнээс л шалтгаална гэж би бодож байна.

-Ах минь, энэ бол ерөнхийдөө танаас шалтгаална гэж би бодож байна. Та эцэг нь болохоор түүнийг ятгаж болно.

-Би түүнд итгэхгүй байна. Тэр чинь хүний үгэнд орохоор хүн биш. Чи ч гэсэн дээ Кассий,

үүнийг надаас доргүй мэдэж байгаа шүү дээ.

-Миний мэдэжбайгаа ганц юм, би гэр бүлтэй болохыг хатуу шийдсэн бөгөөд Каса-Дель-Корвын эзэгтэй нь өөр хэн ч биш Луиза л байгаасай гэж хүссэнд байна.

Энэ шазруун үг нь Вудли Пойндекстерын сэтгэлд сэв оруулжээ. Өөрийг нь хойшид Каса-Дель-Корвын эзэн биш гэдгийг анх удаа ойлгуулж байгаа нь энэ. Хэдийгээрүүнийг битүүгээр хэлсэн ч гэлээ өвгөн сайтар ойлгож байв.

Түүнд хөрөнгө зөөр, эдлэн газар, боол зарц, нийгмийн байр суурь нт ядуурч хоосроход хүрвэл яаж зовж зүдрэ, ад үзэгдэж болох нь дахин бодогдов. Ядуурч хоосрох гэдэг хэдийгээр хүү нь болохыг хүсэн өмнө нь зогсч буй зээгээс нь илүү ой гутам биш ч гэлээ аймшигтай санагдана.

Тэгсэн хэлий боловч Вудли Пойндекстер охиныхоо хувь заяаг золиосонд гаргахаар шийдэн Колхаунд ам өглөө.

-Лу!

-Юу вэ? аав аа?

-Чамаас гуйх юм байна.

-Ямар юм бэ, аав аа?

-Үеэл ах Кассий чинь чамд дурладгийг чи мэднэ. Тэр чиний төлөө амиа ч өгөхөөс буцахгүйгээр барахгүй чамтай гэрлэхийг хүсч байна.

-Гэвч би түүнтэй суухыг хүсэхгүй. Үгүй шүү, аав аа! Үхсэн нь дээр! Их санаатай өөдгүй амьтан! Энэ юу болохыг би мэдэж байна. Тэр, танаар өөрийнхөө санааг хэлүүлэх гэж явуулжээ! Зөвхөн түүний гэргий л болохгүйн тулд тал нутаг руу зугадан, талх тариа тарьж, зэрлэг адуу агнахад ч бэлэн байна гэдгийг маань түүнд хэлээрэй. Түүнд үүнийг дуулгаарай.

-Эхлээд сайн бод, охин минь. Чи нэг юм мэдэхгүй л байнаа даа...

-Миний үеэл ах танаас авцаатай гэдгийг үү? Эрхэм аав миньби үүнийг сайн мэднэ. Бас тэгээд та бол Вудли Пойндекстер, би бол таны охин гэдгийг мэдэж байна.

Хөгшин эцгийн бардам зан дахин сэргэж

-Хонгор Луиза минь! Чи ээжтэйгээ мөн ч адилхан юм даа! Гэтэл би чамд эргэлзэж байсан юм шүү. Охин минь намайг уучил! Өнгөрсөн юмыг мартая. Чи өөрийнхөөл сэтгэл зүрхээр бол.

LXXXV. Сайн сэтгэлт садан

Луиза Пойндекстер эцгийнхээ олгосон эрх чөлөөг бүрэн эдэлжээ. Түүнээс хойш нэг цаг ч өнгөрөөгүй байхад бүсгүй Колхаунд эрс таггалзсанаа хэлэв.

Колхаун түүнээс эхнэрээ болохыг гурав дахь улаагаа гуйсан байжээ. Үнэндээ эхний хоёр удаа тоглоом шоглоом болгосон байдлаар тойруулсхийж хэлжээ. Гурав дахь удаагийнх болсүүлчийнх болох ёстой байв. Тэр бүсгүй товчхон “Үгүй” гэснээ улам тодорхой болгож “Хэзээ ч үгүй” гэж нэмж хэлжээ.

Колхаун түүний нь сонсоод гайхсангүй. Нааштай хариу хүлээгээгүй бололтой. Түүний нүүр царайны нэг ч булчин шөрмөс хөдөлсөнгүй. Царай нь зөвхийрч, цөхөрсөн байдал өчүүхэн ч гаргасангүй. Тэрээр үзэсгэлэнт үеэлийнхээ өмнө, олз руугаа үсрэхээрзэхсэн ирвэс шиг зогсоно. “Минут ч бололгүй чи өөрөөр ярина даа” гэж хэлэхийг хүсэх мэт харагдана. Гэвч

-Лу чи тоглож байна уу? гэж асуув.

-Үгүй шүү, сэр. Миний үг танд тоглоом шиг санагдлаа гэж үү дээ?

-Чи огт бодож эргэцүүлэлгүй хариу хэллээ шүү дээ.

-Юу бодох юм бэ?

-Олон юм бодох байсан сан даа.

-Чухам юу вэ?

-Юуны өмнө би чамд яаж дурлаж байдгийг.

Луиза дуугарсангүй.

-Би чамайг хайрладаг гэж Колхаун үгээ үргэлжлүүлэн - Лу би чамд хэн ч, хэзээ ч тэгж дурлаж байгаагүйгээр дурлаж байна. Энэ дурлал маань надтай хамт л үгүй болно. Чамайг үхлээ ч гэсэн энэ сэтгэл арилахгүй гэснээ дуугаа хураахад нь Луиза хариу хэлсэнгүй.

-Миний дурлалын түүхийг яриад яахав! Энэ дурлал бол чамайг үзсэн тэр өдөр... Үгүй шүү чамайг харсан тэр цагаас эхлэн анх дүрэлзсэн юм. Зургаан жилийн өмнө намайг эцгийн чинь гэрт ирснийг санаж байна уу? Мориноосоо дөнгөж буутал, ширээ застал цэцэрлэгээр хамт зугаалья гэж чи намайг урьж билээ. Тэгэхэд чи насанд хүрээгүй охин байсан боловч одоогийнх шигээ ийм үзэсгэлэнтэй байсан юм! Чи гараас минь хөтөлж, өөрийн чинь гарт хүрсэндээ сэтгэл хичнээн их догдлон хөдөлж байгааг минь анзааралгүй, хайр чулуутай нарийн зөргөөр туулайн бөөрийн сүүдэр доогуур дагуулан явж байсан! Тэг сэтгэгдэл насан турш миний ой ухаанд үлдсэн юм. Тэр сэтгэлийг эрин цаг, алс нутаг, тэр бүү хэл... наргиан цэнгээ ч хүртэл арилгаж чадаагүй юм.

Креол бүсгүй сонссон хэвээр боловч нөгөө хайхрамжгүй байдал нь арай л өөр болжээ. Ийм

уран цэцэн, гал халуунаар үнэнээ хэлж байхад сэтгэл ханахгүй бүсгүй байна гэж бараг үгүй биз ээ. хэдийгээр харцанд: нь урамшиж, хөхүүлсэн шинж үгүй боловч өрөвдсөн шинж цухалзан байна. гэвч юу ч хэлсэнгүй.

Колхаун үргэлжлүүлэн

-Тиймээ, Лу энэ бол үнэн. Би янз бүрээр чамайг мартаж гэж оролдсон. Зургаан жил бол зэгсэн урт хугацаа. Миссиппээс Мексик орно гэдэг ч хол зай. Би тийшээ зөвхөн чамайг мартагчын тулд л явсан юм. гэвч энэ тус болсонгүй. Эргэж ирээд наргиан цэнгээн хөөдөг болов. Шинэ орлеаны ганц байдаг юм нь тэр. Миний сэтгэл нөгөө дарахыг хүсээд байгаа юмнаас минь илүү хүчтэй болсон гэж би хэлэхгүй. Хүчтэй болж ч чадаагүй, хөг нь өнгөрсөн юм. Миний гараас ч хөтөлж, намайг хонгор үеэл минь гэж хэлсэн тэр үеэс эхлэн миний сэтгэл жаахан ч гэсэн хувирсныг би санахгүй байна Лу! Хардсанаасаа болоод чамайг алахад ч бэлэн болтлоо өөрийг чинь үзэж ядаж байсан тэр үед л нэг магадгүй.

-Кассий чи яаж ингэж ярьж чадна вэ? Энэ чинь бүдүүлэг явдал. Бүр шал тэнэг явдал!

-Тийм мөртлөө бас үнэхээр хэцүүгий нь яана. Би бүр биеэ барьж ядталаа чамайг хардаж харамласан юм. Цухалдсанаа нууж чадаагүйг чи ч мэдэж бхйгаа.

-Гэвч би юунд буруутай юм бэ, Кассий? Би чамайг хэзээ ч тэгж бодохоор шалтаг гаргаагүй биз дээ?

-Би чиний юу хэлэхийг мэдэж байна. Гүйцээж хэлээд яахав. Би өмнөөс чинь хэлээгүйг чинь гүйцээе: “Өөрт чинь хайртай гэж бодохоор” гэж хэлэхийг хүсээ биз дээ. Би тэгсэн гэж хэлэхгүй гэж Колхаун улам цөхөрсөн маягтай хэлээд - Би чамайг надтай сээтэгнэсэнд чинь буруушаахгүй. Чамд гоо үзэсгэлэнгхайрласан бурхан ч юмуу эсвэл намайг өөр лүү чинь харуулсан чөтгөр л буруутай! Гэв.

-Чиний ярьж байгаа чинь миний сэтгэлийг зөвхөн зовоох л юм. Намайг бяланчилж байна гэж бодохгүй байна. Эргэлзэхийн аргагүй чин санаанаасаа ярилаа. Гэвч Кассий энэ чинь чамд көвхөн ийм юм шиг санагдаж байгаад итгэ. ЧИ өөрийн хибодлоосоо амархан салж чадна. Надаас илүү гоо үзэсгэлэнтэй, ингэж үнэнээ хүлээж байгаад чинь сэтгэл ханах хүүхэн олон байна шүү дээ. Тэдэнтэй ойртож яагаад болдоггүй билээ?

-Яагаад гэнээ? хэмэн Колхаун уйтгартайгаар давтаад - Яасан дэмий асуулт вэ дээ! гэв.

-Би түүнийг чамд давтаад хэлчихье, дэмий үг биш. Би чамд хайргүй, хэзээ чдурлаж чадахгүйгээ чин үнэнээр нь хэлэх ёстой биз дээ.

-Тэгэхээр надтай суухгүй гэсэн үг үү?

-Ёстой утгагүй асуулт байна даа, би чамд хайргүй гэдгээ хэлсэн. Энэ бол хангалттай гэж би санаж байна.

-Харин би чамд дурладаг гэж хэлсэн. Гэвч энэ бол чамайш эхнэрээ болгох гэж хүсдэгий минь

зөвхөн нэгшалтгаан юм. Бас өөр юм ч бий. Чи цөмий нь сонсохыг хүсч байна уу?

Одоо Колхаун гуйж царайчлахаа хэдийнээ больжээ. Дахин ирвэс шиг болж ирэв.

-Чи өөр шалтгаан бий гэж хэлсэн биз дээ? Тэр шалтгаануудаа ооч л доо. Би юунаас айхгүй.

-Өө тийм бий! Чи айхгүй юу? гэж Колхаунинмээсэглэн хэлэв.

-Үгүй ээ, айхгүй. Юунаас айх юм бэ?

-Үнэндээ аавд чинь л гэхээс биш, чамд айх юм байхгүй л дээ.

-Ярь л даа. Аавд хамаарах юм бүхэн надад хамаатай. Би бол түүний охин. Одоо хөөрхий, цорын ганц үр нь... Кассий цааш нь ярь. Түүний толгой дээр ямар гай бөөгнөрч байна вэ?

-Лу, гай биш, түүнээс чинь илүү аймшигтай юм байгаа юм. Яаж ч хичээгээд давж эс чадах бэрхшээл байгаа юм. Ер нь чамд огт мэдэх мэрэггүй вьны тухай чи намайг яриулахад хүргэж байна шүү.

-Өө, тийм үү? Үеэл минь чи эндүүрч байна. Би цөмийг мэднэ. Аав минь өрөндөө баригдсан бөгөөд зээлүдүүлэгч нь чи гэдгийг би мэднэ. Биүүнийг анзаарахгүй байж яаж чадах вэ? Манай орон гэрт биеэ авч яваа ихэмсэг зан чинь, зарцыг байхад ч гэсэн эрээлж цээрлэхгүй үргэлж гаргаж байдаг дээрэнгүй зан ээн бүхэн чинь тэдэнд энэ бүгдийн цаана нэг юм байгааг бэлхэн хэлээд өгч байна. Чи бол Каса-Дель-Корвын эзэн, би үүнийг мэднэ. Гэвч чинамайг захирахгүй.

Ийнхүү зоригтойгоор хариулсан нь Колхауныг мэгдүүлжээ. Түүний найдаж байсан хөзөр нь харваас идэж чадахаа байв. Тэгээд түүгээрээ явахаа болив. Түүний гарт өөр том хөзөр байлаа.

-Нээрээ юу! Гэж доогтойхон хэлснээ - за яая гэхэв, би чиний сэтгэл зүрхийг захирдаггүй юм байж, гэвч ямар ч байсан чиний хувь заяаминий гарт даа. Ямар жигшүүртэй өөдгүй амьтнаас болж надаас татгалзсангы чинь би мэдэж байна... гэв.

-Чи хэний тухай ярьж байна?

-Чи ямар авхаалж муутай юм бэ!

-Тийм ээ. гэвч чи өөрийгөө жигшүүртэй өөдгүй амьтан гэсэн утгаар хэлж байж болох юм. Тэгвэл ч амархан таана шүү. Яг зэгсэн таарах тодорхойлолтбайна.

-Тийм болог гэж ахмад уурандаа хүрэн улаан болсон боловч биеэ барьсаар хэлээд - Нэгэнт чи намайг жигшүүртэй өөдгүй амьтан гэж үзэж байгаа болохоор хэрэв би одоо чамайг яах гэж байгаагаа хэлбэл чиний өмнө нэрээ гутаасан хэрэг болох нь юу л бол.

-Намайг яах ий? Кассий чи дэндүү биеэ тоож. Чинамайг боол шивэгчин шигээ бодон ярьж байна. Аз болоход энэт тийм биш юм!

Колхаун бүсгүйн дургүйцсэн харцанд сүрдээд дуугүй болов.

-Намайг чи яах гээ вэ? Үүнийг сонсоход сонин байна гэж бүсгүй үргэлжлүүлэн хэлэв.

-Би чамд хэлж өгнө.

-Чи намайг дөрвөн зүг, найман зовхист хөөж явуулах, эсвэл сүмд хорихыг хүсч байна уу? Бүр байчихаад... шоронд ч хийж магадгүй юу?

-Сүүлчийнх нь лав чиний санаанд тохирч байгаа байх. Нөгөө нэг юмтай цуг хориход хүрвэл ч бүр...

-Намайг ямар хувь заяа хүлээж байгааг хэлээч дээ, сэр? Би сонсох гэж тэсч яадаж байна гэж Луиза тохуурхсан янзтай хэлэв.

-Битгий яар. Маргааш анхных нь юмыг үзнэ.

-Тийм амархан уу? Хаана үзэхий нь мэдэж болох бол уу?

-Шүүхэд

-Ямар янзаар?

-Тун жирийн байдлаар. Чи шүүгч болоод тангараг өргөсөн арван хоёр хүний өмнө зогсох болно.

-Ахмад Колхаун та дураараа тоглож болно. Гэхдээ таны хурц оюун надад таалагдахгүй байгааг хэлэх хэрэгтэй Юм байна.

-Энд хурц ухаан ямар ч хамаагүй... Би бүр үнэнээсээ ярьж байна. Маргааш шүүх. Мистер Жеральд буюу нөгөө юу... яасан нөхөр чинь чиний дүүг алсан хэргээр шийтгэгдэх болно.

-Энэ бол гүтгэлэг! Морис Жеральд бол...

-... энэ гэмт хэргийг хийгээгүй гэжүү? Үүнийг нотлох хэрэгтэй. Түүний гэм буруутай нь нотлогдоно гэдэгт би эргэлзэхгүй байна. Бас хамгийн ноцтой баримтыг иргэний төлөөлөгчдөд бүр хангалттайгаар чиний амнаас сонсох болно доо.

Креол хүүхэн үргэсэн гөрөөс шиг, үеэлийнхээ өөдөөс гайхаш тасарсан, тэвдсэн дүрлэгэр нүдээр харав.

Луизаг үг ярих сэхээ орохоос өмнө хэдэн хором өнгөрлөө. Бүсгүй гэнэт тээнэгэлзэж, сэжиглэж, айснаасаа болж дуугүй болов.

-Чиний юу хэлэх гэж байгааг би ойлгохгүй байна гэж Луиза эцэст нь хэлээд - Чи намайг шүүхэд дуудна гэж ярьж байх шив дээ. Яагаад тэр вэ? Би бол алагдсан хүний эгч нь үнэн. Гэхдээ би юу ч мэдэхгүй, хүн амьтанд ил бослно зүйлээс өөрЮу ч нэмж хэлж чадхагүй гэв.

-Тийм үү? Үгүй, чи хачин их юм мэднэ. Жишээ нь, хүн амины хэрэг гарсан шөнө Жеральдтай манай цэцэрлэгт болзоо тавьж уулзсаныгаа мэдэж байгаа. Тэгээд тэр нууц уулзалтын үеэр юу болсныг хэн ч чамаас илүү мэдэхгүй. Генри түүний нь яаж саатуулж, зөвхөн эгчий нь төдийгүйбүх гэр бүлий нь нөмөрсөн шившигт явдлыг бодон зэвүүрхсэндээ яаж галзууртлаа уурласныг, эцэст нь тэр буруутай этгээдийг алах гэж дайрсныг, үүнд нь тэр өөдгүй амьтанд маллагдсан эмэгтэй саад хийн өмгөөлснийг чи сайн мэднэ. Тэгээд дараа нь Генри новшийн хойноос тэнэгтэн гүйснийг, яагаад ингэх болчихсоныг хэн ч мэдэхгүй шүү дээ. Үүнийг гэрчлэх хоёрхон хүн байгаа юм.

-Хоёр хүн гэнээ? Хэн хоёр вэ?

Асуулт өөрийн мэдэлгүй гарч ирсэн учир их тайван сонсдов.

Хариулт ч түүнээс дутахгүй ажиггүй байлаа.

Нэг нь Кассий Колхаун, нөгөөх нь луиза Пойндекстер байсан юм.

-Бүсгүй сочсон ч үгүй. Гайхснаа ямраар ч илэрхийлсэнгүй. Урьд нь хэлсэн зүйл нь түүнийг үүнд хэдийнээ бэлдүүлжээ. Зөвхөн өдсөн байдалтай

-Тэгээд? гэж ганц үг дуугарав.

-Тэгээд гэж өөрийн нь хэлсэн үг ямар ч сэтгэгдэл төрүүлээгүйд сандарсан Колхаун давтан хэлээд - Одоо чи намайг ойлгож байгаа биз? гэв.

-Урьдынхаасаа илүү юм ойлгосонгүй.

-Чи надаар бүр тодорхой тайлбарлуулахыг хүсч байна уу?

-Тааллаараа бол.

-Тэгвэл би чамд тайлбарлаж өгье. Луиза, эцгийг чинь үгүйрлээс, чамайг гутамшгаасаврах ганцхан арга байна. Чи юуны тухай ярьж байгаагий минь ойлгож байна уу?

-Ойлгож байх шиг байна.

-Одоо чи надад татгалзахгүй биз?

-Одоо би түрүүчийнхээсээ илүү татгалзана.

-Юу сайхан, дур сайхан_ Тэгэхээр маргааш... Энэ бол дэмий үг биш, маргааш чи өдий хэрд шүүхэд гэрчээр мэдүүлэгч өгнө дөө.

-Шившгийн тагнуул! Миний нүднээс зайл! Бушуу далд орохгүй бол аавыг дуудна шүү!

-Өөртөө битгий түвэг тарь. Хэрэв би чамтай хамт байх нь чамд таалагдахгүй байгаа бол би хойшид тэгэхгүй. Бүгдийг сайн бод. Чи шүүх эхлэхээс өмнө шийдвэрээ өөрчилж ч мэднэ.

Хэрэв тэгвэл чи надад хожимдуулалгүй мэдэгдээрэй. Тавтай нойрсоорой. Би явж чиний тухай бодсоор унтъя.

Колхаун ингэж хэлээд тасалгаа руугаа явлаа. Түүнд баярлаж бахархсан шинж огт алга.

Луиза түүний хөлийн чимээ тасартал чагнав.

Дараа нь одоо болтол түүнийг бариад байсан нөгөө бардам, ууртай санаа нь гэнэт алга болсон мэт түшлэгтэй сандал дээр унаад өгөв. Хоёр гараа цээжиндээ нааж шинээр айснаасаа болж булгилан буй зүрхээ тайвшруулахыг хичээлээ.

LXXXVI. Техасын шүүх

Маргааш өглөө нь боллоо. Атлантын далайн дээгүүр боссон улаан туяа Техасын ширэнгийг гийгүүлнэ.

Түүний улбар туяа Мексикийн булангийн элсэн манхан дундуур нэвтрэн Матагордын булангаас зүүн тийш зуун тавин бээрд орших Инж цайзын тугийг гэрэлтүүлэв.

Өглөөний салхи тугийг дэрвэлзүүлнэ.

Анх удаагаа туг ийм дуулиантай үзэгдлийн дээгүүрдэрвэлзэж байж болох л юм.

Ийм эрт үүрээр сайхь үзэгдэл хэдийнээ эхэлжээ.

Үүрийн анхны гэгээгээр, цайз руу тал бүрээс морьто йхүмүүс чиглэн ирэв. Тэр хоёр гурваараа, заримдаа тав зургуулаа нийлэлдэн ирнэ. Тэд хүрч ирээд шивээ хашаанаас яарсан байдалтай морьдоо уялна. Дараа нь жагсаалын талбай лээр бөөгнөрөн, хоорондоо ярилцан суури руу очиж цөмөөрөө л цувралдан дэн буудал руу очиж баарныхаа лангууны аод зогсч байгаа эзнийх нь амрыг эрнэ.

Энд янз бүрийн үндэстэн ястан цугларчээ. Евродын орон бүхний шахуу төлөөлөгчдийг харж болно. Тэдний олонхи нь индиан нартай байлдаж, цусаар дэвтээгдсэн газар нутгаас нь тэднийг шахан зайлуулж, индианы овоохой байсан газарт дүнзэнурцаа барьсна анхны шилжин суугчдын удам угсааныхан юм. Тэгээд дараа нь Миссипийн эрэг дээр ой мод огтлон амдралаа элээсэн улс ажээ. Цугласан улсын зарим нть эрдэнэ шиш тарьж, нөгөө зарим нь хөвөн тариалан эрхэлж, өмнөд хязгаарынхны олонхи нь чихрийн буюу тамхины аж үйлдвэр эрхлэхээр Техаст нүүж иржээ.

Энд малчин, анчин, мухлагийн эзэн болоод боолын худалдаачин хүртэл бүхий л наймаачидтай дайралдах боловч ихэнхи нь бүр яс махнаасаа газрын эзэд байла. Команч нарын эсрэг аян дайн хийх буюу Рио-Грандын тэртээ рүү дээрэм тонуулд оролцох, мал тамгалах зэрэг ямар ч хэргийг шүүрэн авахаас буцахгүй зөөлөн хоолонд дуртай элдэв амьтад, хууль цаазын мэргэжилтэн, газар хэмжигч, газар дамлан худалдагч нар байв.

Тэдний өмссөн хувцас нь эрхэлсэн ажил шиг нь янз бүр бөгөөд бид тэдний хувцсыг хэдийн тодорхойлон бичсэн билээ. Энэ бол хэдхэн хоногийн өмнө Каса-Дель Корвын хашаанд цугларч байсан тэдгээр хүмүүс мөн бөгөөд ялгаа нь зөвхөн өнөөдөр тэд тоогоор олон байлаа.

Гэвч энэ цуглаан нь түрүүчийнхээсээ бас өөр нэг талаар ялгаатай нь, өнөөдөр эрэгтэйчүүдийн хамт эхнэр, охид, эгч дүү хүүхнүүд хүрэлцэн иржээ. Тэдний зарим нь нарны хурц гэрлээс нүдий нь хамгаалсан нэлмэгэр хүрээтэй бүрх малгайөмсч, морь унажээ. Зарим нь бүхээгт тэрэгний цагаан сарвч дор буюу сүүх тэрэгний сэрсгэр хөшгийн цаана суужээ.

Бүгд тэсч ядан хүлээнэ. Ойр хавиар олон хоног дуулиантайгаар яигдсан шүүх ажиллагааг өнөөдөр эхлэхээр тогтжээ.

Морис мустангер гэж жирийндээ нэрлэдэг Морис Жеральдыг шүүнэ гэж хэлбэл илүү үш болох биз ээ. Тэрчлэн Генри Пойндекстерыгхалсан хэрэгт түүнийг яллаж буйг хэлэхийн ч хэрэггүй биз.

Хүнд ялт хэрэг үйлдсэнд нь ч юмуу эсвэл бараг хэнийг ч мэдэхгүй алуулсан хүн болон алуурч гэж үзэж байгаа этгээдийг сонирхсондоо ийм олон хүн цугласан хэрэг биш байлаа. Увальд тойргийн сайхь дээд шүүх нь энд нэг бус удаа, аулгай зэлгий, луйвар, хүн амины хэрэг тасалж байсан боловч ихэвчлэн хорь гучин хүн цугларах бөгөөд тогтоол гаргахаас нь өмнө тараад явчихдаг байжээ.

Мэдээж цугласан олон нааш ирэхпээ одоо болох шүүх ажиллагаа хараахан тайлагдаагүй зүйлийн учрыг гаргах байх гэж итгэж байжээ.

Мэдээж цугласан олны дотор зөвхөн сониучирхсандаа бус, ял тулгагдаж байгаа хүний хувь заяанд үнэнээсээ зовсон хүмүүс ч байлаа. Мөн тэднээс ч илүү сэтгэл нь шаналан, уймарсан, алагдсан гэж үзэж байгаа залуугийн найз нөхөд, төрөл садан ч байв. Гэвч тэр залуу хараахан алагдсан гэх баримт нотолгоо байхгүй байгааг мартаж болохгүй.

Гэвч үүнд хэн ч эргэлзсэнгүй. Хоорондоо ямар ч хамаагүй нөхцөл байдал гэмт хэрэг үнэхээр үйлдэгдсэн гэж үзэхэд хүргэж байлаа. Бүх хүмүүс л хүн амины хэрэг гарахад байж байсан юм шиг үүнд итгэж байв.

Тэд зөвхөн тодорхой зүйл сонсохыг хүлээж, энэ хэрэг юунаас болж, хэзээ яаж нэгд нэгэнгүй сонсохыг хүсч байв.

Арван цаг болоход, шүүхийн хуралдаан эхлэв.

Цугласна олон дунд онц өөрчлөлт гараагүй бөгөөд зөвхөн хувцасны өнгө нь л арай хурц болж ирэв. Энгийн хувцсан дунд цэргийн дүрэмт хувцас үзэгдэж байв.

Цэргиангийнхан өглөөний тооллогоо дуусгаад, чөлөө цагаа үзэгчдийн дунд өнгөрөөүүлэхээр шийджээ. Морин цэргийнхэн, буучид, явган цэргүүд, суурины оршин суугчид, газрын эзэн, анчин, худалдаачин, танхайчуулдтай зэрэгцэн зогсч, шүүхийн тунхагч, шүүх ажиллагаа эхэлснийг зарлахыг сонсч байв. Тэд шүүгчээс “Бурхан таны сүнсийг өршөөх болтугай” гэдэг эцсийн үгийг хэлэхээс нааш эндээс явахгүй гэж шийджээ.

Цугласан хүмүүсийн хэн нь ч нар орохоос өмөн, үхлийг зөгнөсөн эл аймшигт үгийг сонсоно гэдэгтээ эргэлзсэнгүй.

Харин хэдхэн хүн л ийм юм бүү болоосой гэж хүсч байв. Гэвч ихэнх үзэгчид шүүх ажиллагаа ялаар дуусч, нар орохоос өмнө Морис Жеральд амиа алдана гэдэгт итгэж байлаа.

Шүүх ажиллагаа.

Уншигч та дотор нь ширээтэй, хашлагаар хүрээлэгдсэн өндөр тавцан, хажууд нь лекцийн танхим ч юмуу сүмд байдаг индрийг санагдуулам зүйлийг санаандаа ургуулна биз ээ.

Тэгээд үенгийн арьсан урт нөмрөгтэй шүүгч, хар хувцас, буурам хиймэл үстэй өмгөөлөгч, нарийн бигийн дарга, суравлжлагч, гялалзсан товчтой цэнхэр хувцастай цагдаа, араар нь цухуйх дандаа ч самнаж, угаасан байдаггүй үй олон толгой, нүүрийг харж байгаа байх.

Бас ирсэн хүмүүс нь эелдгээсээ бус ер нь шүүхийн горимыг эвдэхгүй гэсэндээ ихэд биеэ барьсан байдаг биз дээ.

Хэрэв техасын хил дээр байдаг шүүхийн тухай ойлголттой больё гэвэл энэ бүхнийг толгойноосоо авч хаях хэрэгтэй. Энд шүүхийн тусгай байшин гэж байхгүй. Үнэндээ элдэв төрийн хурал цуглаан хийдэг тасалгаа байх агаад түүндээ шүүх хуралдааныг энгүүндээ явуулна. Маш халуун өдөр болох янзтай байсан учир шүүх задгай газар хуралдахаар шийджээ.

Хуралдааныг цацагтай туушингаар чимэглэсэн хөгшин бүдүүн цаср модны сүүдэрт хийж байлаа. Царс жагсаалын талбайн захад бөгөөд сүүдэр нь ногоон дээгүүр хол тусчээ. Түүний дор том ширээ засч, арваад сандал тавьжээ. Ширээн дээр цаас, нагван, галууны өдөн үзэг, хуулийн эмхтгэлийн үнгэгдсэн хоёр боть коньяктай галуун хүзүүт, хэдэн хундага, гаваны ороомол навчин тамхитай хайрцаг, чүдэнз тавьжээ.

Ширээний ард шүүгч сууж байв. Тэр хүн үенгийн арьсан нөмрөг бүү хэл сюртук ч өмссөнгүй. халуунаас болж зөвхөн дотуур цамцтайгаа ажилд орохоор шийдсэн байжээ. Хиймэл үсний оронд өргөн хүрээтэй үйсэн малгай хэлтгий тавьж, талд нь хүртэл татаж зажилсан навчин тамхи зуусан байв. Бусад суудал дээр хувцсаар нь мэргэжлий нь мэдэхийн аргагүй хүмүүс суусан байв. Эдгээр нь шериф, түүний туслах, уайзын дарга, сумангийн хар лам, эмч болон хэлэн офицер байв. Хажууд нь тангарагтан арван хоёр хүн байна. Тэдний зарим нь эв хавгүй зүйж

хийсэн урт сандал дээр, зарим нь зүгээр ногоон дээр суух нь сууж, хэвтэх нь хэвтжээ.

Эдгээр иргэний төлөөлөгч нь английнхтай адилхан техасын шүүхэд заавал байдаг боловч, Техаст тэд нь илүү биеэ даасан английнх шиг шүүгчийн шийдвэрийг сохроор дагадаггүй улс байлаа.

Шүүгчид болоод тангарагтан нарыг тойрон тийм ч амархан гараагд хэлчихийн аргагүй зүсэн зүйлийн хүмүүс шахцалдан зогсоно. Энд бугын арьсаар хийсэн ангийн цамц, халуун өдөр байсан ч нгоосон хөнжлөөр хийэсэн хүрэм, цагаан ёрог цамц, улаан тэрэм болон будаагүй зотонгоор оёсон цамц, морьтой, явган, буучдын цэргийн дүрэмт хувцас зэрэгцөм холилдон, өнгө булаалдана.

Хаа нэг газар мексикүүдийн богино хүрэм, өргөн хүрээт сомбреро үзэгдэнэ.

Ихэнх цуглаанд дотоод тойрогт нь тусгай шилсэн улс зогсдог: Харин энэ удаа шал эсрэг юм

болжээ. Орон нутгийн дээдэс гадна хүрээнд эл байр эзэлжээ. Байдгаараа гоёж гоодсон хүүхнүүд бүхээгт тэргэн дээро зогсохч юм уу эсвэл хүмүүсийн толгой дээгүүр харахын тул өндөрлөж суусан гоёмсог сүүхэн дотор заларна. Тэдний харц шүүгч рүү нь чиглэсэнгүй. Зөвхөн халыг харсан болоод л өнгөрнө. Тэд царснаас холгүйхэн, тангарагтан нарын ойролцоо байгаа гурван хүнийг л ширтэнэ.

Нэг нь сууж, хоёр нь босоо байв. Сууж байгаа нь хэрэгтэн, зогсч байгаа хоёр нь харуул ажээ.

Эхлээд хүн амины хэрэгт зөвхөн Морис Жеральд төдийгүй, Мигуэль Диасыг нөхөдтэй нь хамт бас Фшлим О Нилийг шүүнэ гэж бодож байцгаажээ. Гэвч урьдчилсан мөрдөн байцаалтын явцад мексик эр, түүний гурван нөхөд өөрсдийгөө гэм хийгээгүйг нотолжээ. Тэд индиан нарын хувцас өмссөнөө хүлээсэн байна. Энэ баримт нь аль хэдийнээ нотлогдсон уир өөрөөр яаж ч чадсангүй. Гэвч үүнээ тоглосон юм гэгцгээжээ. Тэгээд ч Генри Пойндекстерыг алга болох шөнө дөрвүүл гэртээ байснаар барахгүй Диас шал согтуу байсан учир тэднийг цааш нь байцаасангүй.

Фелимийн хувьд гэвэл түүнийг хэрэгтний суудалд суулгах шаардлагагүй, харин гэрчийн хувиар хэрэг болно гэж үзжээ. Тэгээд хэрэгтний суудал дээр цугларагсдын ихэнхэд Морис-Мустангер хэмээн алдаршсан Морис Жеральд үлдэх нь энэ.

LXXXVII. Хуурамч гэрч

Тэнд байгаа хүмүүсийн дотроос хэдхэн нь хэрэгтнийг таньдаг байв. Гэвч түүнийг дулаагүй хүн энд цөөхөн байна. Ер нь огт ч байхгүй байж ч болох юм. Түүний нэр саявтархнаас алдаршжээ. Золхаунтай халз тулалдахаас нь өмнө зэрлэг морины сайн ангууч гэж л мэддэг байв.

Бүгд л мустангерыг зүс царайтай, зүрх зориг сайтай, моринд хорхойтой, хүүхнүүдийн сэтгэл зүрхийг татдаг, сайн сэтгэлтэй, ихэнх ирланд хүн шиг хурц яриатай залуу гэж тооцдог байв. Тэр сайн муу зүйлийн алинийг ч хэтрүүлдэггүй хүн байв. Түүний зүрх зориг нь хэтэрнэ гэж ховорхон бөгөөд дэмий хоосон чалчина гэж байдаггүй бахйв. Хэзээд төлөв даруу, үг ярих нь ч цэгцтэй, аяга дарс уусан ч олон юм ярьдаггүй нь ирланд хүнд ховор байдаг чанар байлаа.

Тэр хүн хаанаас ирж, Техаст яах гэж суусан, яагаад адууны ав хийх болсон нь хэнд ч тодорхойгүй ажээ.

Энэ нь түүнийг боловсролтойгоор барахгүй Техаст тэгтлээ тоодоггүй угийн боловсон хүн гэдгийг нь мэдэх хүнд ялангуяа гайхалтай санагдана. Мори с Жеральд өөрийг нь тэр нэгэн шөнө гэм зэмгүй хүний цусыг урсган хүний аминд хүрсэн хэмээн буруутган ширтэж буй олны өмнө зогсч байна.

Энэ ял үнэн юм гэж үү дээ? хэрэв үнэн бол сумтангер үхэх болно.

Үзэгчид ийнхүү бодож байна.

Зарим нэг нь сонирхон, заримы нь учры нь олоогүй янзтай харж байхад ихэнх нь үзэн ядсан байдалтай харна.

Өөр нэгэн хос нүд түүнийг бусдаас шал өөрөөр харна. Тэр харцанд айж түгшсэн, хайрлаж энхрийлсэн, бас ч шантаршгүй хатуу зоригийн шинж илэрхий ажээ.

Шүүх цуглаан онц ёсорхолгүй эхэллээ. Шүүгч үйсэн дэлбэгэр малнайгаа аваад унтарсан тамхиа асаав. Тэгээд тав зургаа сорсноо тамхиа амнаасаа авч ширээний өндөг дээр тавиад:

-Эрхэм тангарагтан нар аа! Та бүхэнд цөмд илэрхий байх гэж санаж байгаа гэмт хэргийг шүүхээр бид энд цуглараад байна. Манай үлэмж хүнтэй иргэний нэгний нь хүү алагджээ. Та нарын өмнө байгаа энэбаригдсан хүн гэмт хэрэгт яллагдаж байна. Миний үүрэг бол шүүх ажиллагааг үнэн мөнөөр явуулж буйг ажиглан хянахад оршино, харин та нар баримт гэрч сэлтийг харьцуулан цэгнээд ялын зөв эсэхийг шийдэх ёстой гэв.

Тэгээд хэрэгтэн хүнд хандан улиг болсон,

-Та гэмтэн гдгээ хүлээж байна уу? гэдэг асууль тавилаа.

-Үгүй гэсэннамдуу боловч эрс хариу сносдов.

Кассий Колхаун болон түүнтэй зэрэгцэн зогсч байсан нүдэнд хүйтэн хэдэн амьтад итгэлгүй маягтай жуумалзана.

Шүүгч юм дуугаралгүй навчин тамхиа авав. Прокурор урьдчилсан хэдэн сануулга хэдснийхээ дараа мэдүүлэг өгүүлхээр гэрч нарыг дуудав.

Эхлэд Франц Обердоферыг дууджээ. Нэр, нас, мэргэжил гэдэг ёс болсон асуултын дараа энэ хэрэгтний талаар юу ч мэдэж байгаагаа ярь гэв.

Оберлоферийн мэдүүлэг урьд ярьсныгаа л давтав. Морис Жеральд мөнгө элбэгтэй байсан бололтой, хамаг өр ширээ нэгмөсөн төлчихөөд, залуу Пойндекстерын алга болдог тэр шөнө өөрийн нь буудлаас явжээ. Урьд ньобердофер түүнд тийм их мөнгө байхыг хараагүй гэнэ. Тэр Нуэсесийн эрэг рүү, гэр рүүгээ зүглэсэн байна. хаашаа явж байгаагаа хэлсэнгүй. Гэвч тэр хоёрын хооронд нөхөрсөг харьцаа байсангүй. Гэвч мустангерыг урц руугаа явлаа гэж зөвхөн бодож байгаа бөгөөд учир нь өмнөх өдөр нь зарц нь эзний нь өөртөө үлдсэнээс бусад хамаг юмы нь луусан дээр ачаад явчихсан байна.

-Тэр өөрөө юу авч явсан бэ?

Гэрч яг та санахгүй байв. Буу байсан гэдгийг шууд хэлж чадсангүй. гэвч мексик маягаар эмээлийнхээ хажууд даруулсан байсан бололтой. Гэлээ ч гэртэй гар буу, ангийн хутга байсныг баттай хэлж чадна. Жеральд өөрөө мексик костюмтай, мөрөн дээгүүрээ судалтайсерапе нөмөрсөн байжээ. Эхлээд өглөө явна гэж байсан хүм маань орой явах болсон нь гэрчид сонин санагджээ.

Тэр оройжингоо буудалд байгаагүй бөгөөд морь нь саравчинд байжээ. Буцаж ирэнгүүтээ л хурдхан шиг тооцоогоо хийгээд яваад өгчээ. Мустангер ихэд сэтгэл хөөрсөн байдалтай яарч агдах боловч согтуу биш байжээ. Дашмагаа дүүргэж авсан нь үнэнтэй ч, буудалд юу ч уусангүй. Гэрч мустангерын цоо эрүүл байсныг андгайлахад ч бэлэн бөгөөд түүний байж байгаа байдлаар нь сэтгэл хөөрснийг йолгожээ. Морио эмээллэж байхдаа ямар нэг юм амандаа үглэн, уурласан юм шиг харагджээ. Мустангер мориндоо хэлээгүй нь лав бөгөөд буудалд ирэхээсээ өмнө болсон явдлыг харамсаж байсан болов уу гэж гэрч боджээ.

Гэрч Жеральдыг хааш явсныг мэдээгүй бөнөөд зөвхөн туурайн чимээгээр суурингаас гараад гол даган мистер Пойндекстерын эдлэн рүү явчихыг сонсжээ. Сүүлийн хэд хоногт түүгээр морьтой явган нааш цааш явж эргэлдэхийг нь харж байжээ.

Обердофероос Генри Пойндекстерын тухай асуув.

Буудалд бараг ирдэггүй учир залууг муухан таньдаг аж. Тэр алга болдог шөнө түүгээр ороод гарчээ. гэрч түүнийг хараад нэг тлааар байнга ирэдэггүй, нөгөө талаар тийм орой явж байгаад нь гайхжээ.

Залуу Пойндекстер буудалд ороогүй бөгөөд зөвхөн баар руу шагайгаад үүднээс эзнийг

дууджээ. Тэр мустангер Жеральдтай уулзахыг хүссэн гэнэ. Тэр ч бас эрүүл, гэхдээ сэтгэл нь хөдөлсөн санагдсан гэнэ. Мустангерыг явчихсаныг дуулаад улам ч сандрах шиг болжээ. Мустангертай зайлшгүй уулзах хэрэгтэй байна гээд аль зүг рүү явсны нь асуужээ. Гэрч түүнд мустангерын явсан зүг болох Рио- Грандыг барьж явахыг зөвлөсөн гэнэ.

Залуу Пойндекстер зам мэднэ гэдгээ хэлээд мустангерыг гүйцье гэж шийдэв бололтой тэр дорхиноо яваад өгчээ.

Дахиад хэд хэдэн асуулт асуугаад обшрдофшрын мэдүүлэг төгсөв.

Түүний мэдүүлэг ерөнхийдөө хэрэгтэнд тус болсонгүй. Ялангуяа Жееральд явах цагаа өөрчилсөн нь сэжиглэлтэй санагджээ.

Хэдийгээр өөрөө цагаан цайлганаар хэрэгтэнд гэмгүй байдгаа хүлээн зөвшөөрсөн хүн хэтрүүлсэн байж болох боловч мустангер сэтгэл нь хөөрөн ууртай харагдсан нь юу ч боллоо гэсэн үзэгчдэд тааламжгүйсэтгэгдэл төрүүлсэн нь олны дунд гарсан дүнгэнэлдэхээс илт байв.

Гэвч Генри Пойндекстер яагаад бас тэгж сэтгэл нь үймэрсэн байдалтай байв? Тэр хүн Жеральдыг гүйцэж очих гэж юунд тэгтлээ яаран, өөрийнхөө заншил болсон зүйлээс ангид, тийм орой болсныг эс хайхран, түүний хойноос явав аа? хэрэв Жеральд залууг гүйцэхээр асууж сурагдсан бол энэ нь илүү ойлгомжтой болох байв. гэлээ ч ийм байлаа ч гэсэн энэ нь хүний аминд хүрсний учрыг тайлбарлаж чадахгүй юм.

Өөр хэд хэдэн гэрч дуудагдав. Гэвч тэдний өчиг мэдүүлэг нь хэрэгтэнд ашигтай болж ирэв. Тэд хүн алсан хэрэгт ял тулгагдаж байгаа хүн Генри Пойндекстер хоёрын хооронд найзархаг харьцаа байсангэж нотлов.

Эцэст нь бүх хэргийг шал өөрөө харуулсан гэрч үг хэллээ. Энэ бол Кассий Колхаун өайв.

Түүний яриа хэргийг шал өөр болгов. Тэр зөвхөн хүн амины хэрэг гарсан шалтгааныг илчилсэн төдийгүй, гэмт хэргийг улам ч хүндрүүлж тавилаа.

Энэ тухай ярих болсондоо харамсч байгаагаа илэрхийлсэн гоёч үгийнхээ дараа Колхаун цэцэрлэгт болсон уулзалтын тухай, муудалцсан тухай болон мустангер явахдаа занаж сүдүүлснийг, араас нь Генри гүйцэж очихоор явсныг ярилаа. Тэгэхдээ тэр залуу яагаад түүний хойноос явах болсон үнэн учрыг, өөрөө тэр шөнө чухам яаснаа ярьсангүй.

Энэ гутамшигтай гэрчлэлт нийтийн гайхшийг төрүүлэв. Шүүгч тангарагтан нар, тэнд цугларсан хүмүүс цөм цочирдон хүмүүс шивэравир гэлцэн дургүйцсэн дуу сонсдов. Уур хилэн мэдүүлэг өгч байгаа хүний бус, харин одоо давхар ялт хэрэг хийсэн хүний эсрэг чиглэжээ Тэд зөвхөн Пойндекстерын хүүг алаад зогсоогүй, охины нь шившгэлжээ.

Энэ аймшигт мэдүүлгийг өгч байх үед сонсогчдын дунд халагласан дуун гарав. Энэ дуу уй гашуудлаасаа болж гутарч гүйцсэн өвгөний цээжнээсгарчээ. Бүгд түүнийг таньж байлаа.

Гэвч хүмүүсийн харц Пойндекстер дээр удаан тогтсонгүй, харин өнгө үзэсгэлэнгээрээ бүхнийг гайхуулсан хүүхний сууж байгаа сүүх тэргэн дээ тусав.

Энэхүү сонирхсон харцыг ойлгож болох юм. Сүүхэнд Луиза Пойндекстер сууж байв.

Чухам өөрийн дураар ирье гэж хүссэндээ энд ирээ юу гэдэг нь сонин байв. Бүх хүн дотроо энэ асуултыг тавин, цугласан олны дунд дахин дургүйцэн дүнгэнэлдэх сонсдов.

Тэд удаан гайхсангүй. Тэдэнд хариулах мэт

-Луиза Пойндекстер! Гэсэн цочмог дуун гарлаа.

LXXXVIII. Аргагүйн эрхэнд гэрх

Дуудлагыг гурав дахиа хэлж амжихаас нь өмнө Луиза Пойндекстер хэдийн сүүх тэрэгний гишгүүрээр бууж явлаа.

Бүсгүй шүүхийн гүйцэтгэгчийн өмнө ирж, гэрчийн байранд очлоо. Ямар ч айсан шинжгүй, зоригтойгоор цугласан олон руу эргэлээ. Түүн рүү цөмөөрөө харна. Зарим нэг нь асуусан шинжтэй цөөхөн хэдэн хүн жигшсэн янзтай, ихэнх нь улаан цайм бахадсан маягтай харна.

Гэвч ганц хүн л бусдаас өөрөөр харна. Түүний харцанд энхрийлж хайрласан, бас ялимгүй түгшсэн шинж илэрхий. Энэ бол хэрэгтэн байлаа. Гэвч бүсгүй түүн рүү ч, өөр бусад руу ч харсангүй. Тэр нь өөрөө байранд нь ирж зогсч байгаа ганц тэр хүнийг л харууштай гэж бодсон мэт. Үеэр ах Кассий Колхауныг харцаараа устгаад хаячихья гэсэн мэт ширтэнэ.

Цаадах нь бэгцийн олны дундуур шурган нуугдав.

-Дүүгээ алга болохын шөнө Пойндекстер авхай та хаана байсан бэ? гэж прокурор асуулаа.

-Гэртээ, эцгийнхээ шилтгээнд байсан.

-Тэр шөнө та цэцэрлэг рүүгээ буусан уу гэж асуухагы зөвшөөрнө үү?

-Тиймээ буусан.

-Цагий нь хэлж гийгүүлэхсэн болов уу?

-Хэрэв андуураагүй л бол шөнө дунд байсан.

-Та ганцаараа байсан уу?

-Үгүй, үргэлж ганцаараа байгаагүй.

-Тэгвэл тантай хамт нэгэн үедээ ямар нэг хүн байсан байх нь ээ?

-Тиймээ.

-Та нэгэнт ийм илэн далангүй байгаа болохоор тэр хүн хэн байсныг мэдээж шүүхэд хэлэхээс татгалзахгүй биз ээ?

-Тэгэхлгүй яахав.

-Түүний нэрийг хэлчихгүй юу?

-Хоёр хүн байсан. Нэг нь миний дүү.

-Гэвч дүүг чинь ирэхээс өмнө тантай хмат хэн нэгэн хүн байсан уу?

-Тийм ээ байсан.

-Бид тэр хүний нэрийг сонсмоор байна. Таны_ татгалзалгүй хэлнэ байх гэж итгэж байна.

-Надад нууж хаах юм алга. Мистер Морис Жеральд байсан юм.

Энэ хариу нь цугласан олны дотор зөвхөн гайхаш төрүүлээд зогссонгүй, зэвүүрхэл, бүр эгдүүцлийг төрүүлэв.

Зөвхөн ганц хүнд, хэрэгтэнд л энэ үг шал өөр сэтгэгдлийг төрүүлжээ. Түүний царайд одоо яллагчаасаа илүү дийлж баярласан шинж илхэн болов.

-Энэ уулзалт санамсаргүй болсон буюу урьдаас болзсон юмуу гэдгийг асуухыг зөвшөөрнө үү?

-Урьдаас болзсон юм.

-Би танд зохимжгүй асуулт тавих боллоо. Уучлаарай Пойндекстер авхай, үүнийг миний үүрэг шаардаж байна. та нарын уулзалтын шинж байдал, шулуухан хэлэбэл зорилго нь ямар байсан бэ?

Луиза түр зуур тээнэгэлзэв. Тэгснээ цэх шулуун болж, эргэн тойрны хүмүүсийг ажиггүй хараад

-Шинж байдал буюу зорилго нь эцсийн эцэстдүндээ л дүн юм. Би юу ч нуух гээгүй байна. Би дурласан хүнтэйгээ, тэр хүн хэдийгээр гэмт хэрэгтний ёсоор энд та нарын өмнө зогсч байгаа боловч одоо ч гэсэн дурласаар байгаа энэ хүнтэйгээ уулзах гэж цэцэрлэг рүү очсон юм... Эрхэм минь, одоо танд хангалттай болоо биз дээ гэж би бодож байна.

-Үгүй, бас дутуу байна гэж прокурор, олны дундаас ориглон гарч байгаа дуу шуугианыг эс хайхран, асуултаа үргэлжлүүлэн - Пойндекстер авхай танд би бас нэг асуулт тавих хэрэгтэй байна. Би тогтсон журмаас жаахан хазайчихлаа, гэлээ ч бид цаг хожих юм. Хэн ч үүнийг буруушаахгүй гэж би бодож байна... Тэгэхээр та өөрийнхөө өмнөүг хэлсэн гэрчийн мэдүүлгийг сонсоо биз дээ. Таны дүү энэ яллагдаж байгаа хүнтэй муудалдцаж салсан нь үнэн үү?

-Үнэн.

Энэ хариулт цугласан олны зэвүүцүүлэн, эгдүүгий нь хүргэв. Хариулт Колхауны мэдүүлгийг нотолжээ. Хүн амины хэргийн өдөөлт тодорхой болов. Үзэгчид гэрчийн хэлэх гэж байгаа тайлбарыг хүлээсэнгүй. “Дүүжил! Яг одоохон дүүжил!” гэсэн дуу цуурайтав.

-Журамтай байхыг хүсье гэж шүүгч амнаасаа навчин тамхиа авах, захирсан дуугаар олны зүг харан хэлэв.

-Дүү минь түүний араас явахдаа огтхон ч уурлаагүй байсан юм. Тэр нь Жеральдыг уучилсан байсан гэж Луиза Пойндекстер асуулт хүлээлгүй, чичрхийлсэн дуугаар үгээ үргэлжлүүлж, - Тэгээд уучлал гуйхаар хойноос нь явсан юм... гэв.

-Би бас нэг юм нэмж хэлэх хэрэгтэй байна гэж Колхаун, шүүхийн тогтоосон журмыг зөрчин, ярианд оролцож - Тэд дараа нь мууцалдсан юм.. Би асотей дээр зогсч байхдаа бүгдийг нь сонссон гэв.

-Эрхэм Колхаун гэж шүүгч түүний үг хэлэхийг болиулаад - Хэрэв прокурор хэрэгтэй гэж үзвэл таныг дахин дуудна. Харин одоохондоо саад хийхгүй байхыг хүсье гэв.

Луиза Пойндекстерээс өөр хэлэн нэмэлт асуулт асуугаад гэрчийн үүргээс чөлөөллөө.

Бүсгүй сүүх рүүгээ буцав. Түүний сэтгэл, зүрх хүнд дарамтанд оржээ. Үнэнийг хэлснээрээ туслах гэсэн тэр хүндээ зөвхөн хор хүргэснийг бүсгүй ойлгожээ. Бүсгүй цугларсан олны дундуур гарахдаа өөр дээр нь зэвүүцсэн харц тусч байгааг мэдэрлээ.

Түүнийг биширдэг хүмүүс шилж авсны нь бодохоос гомджээ. Цэцэрлэгт уулзсанаа ил хүлээсэн нь тэднийг аягүйрхүүлэв. Бүсгүйг зоригтойгоор хамгаалаад байгаа “азтай эрийг” ч хордож, хардахгүй байж чадсангүй.

Колахун дахин дуудагдаж худалд хуурам мэдүүлгээрээ хэрэгтнийг үзэн ядах явдлыг улам дүрэлзүүлэв. Түүний мэдүүлэг нь хуурам ч үнэн юм шиг харагдаж байлаа.

Эгдүүцлийн дуун дахин гарлаа. “Дүүжлэгтүн!” гэж улам шаргуу, улам их хилэнтэйгээр дахин хашгиралдав.

Зүгээр хашгиралдахгүй бүр хөдөлж эхэллээ. Эрчүүд нь хүрмээ тайлан, бүрхээ дээш нь чулуудна.

Бүхээгт тэрэг болон сүүхэд байгаа эмэгтэйчүүд, зөвхөн цохны хөшигний цаана халхлагдсан ганцаас бусад нь хэрэгтний эсрэг хорог санааг хуваалцана. Тэр ганцаар бүсгүй эгдүү нь хөдөлсөн ч гэлээ өөр учиртай байв. Түүний чичрэн байгаа нь айснаасаа бус, харин өөрөө л олныг ийнхүү эгдүүүүлсэндээ болжээ. Энэ хүнд мөчид Луиза, өөрийн чинь мэдүүлэг Морис Жеральдыг алуурч гэдгийг нотолно гэж хэлснийг саналаа.

Шуугиан улам нэмэгдэв. Тэнд ч, энд ч хашгиралдан мустангерыг элдвээр

муулна. Тэдний зорилго нь цугласан олны уур омгийг улам дүрэлзүүлэхэд чиглэсэн байв. Шуугиан нь хашгиралдаан болж хувирав.

Шүүгч Робертсын байдал тогтворгүй болов. Линчын хууль бус ажиллагаа дуртай цагтаа түүний суудлыг эзэлж болохоор байв. Тэгэхэд хүрвэл юу болох вэ? Тэгвэл шүүх ажиллагаа төгсгөх болно. Нэгэнт шийтгэх тогтоол тодорхой хойно зөвхөн түүнийг биелүүлэх л үлджээ. Энэ бол туршлагатай алуучраас нэг их цаг шаардахгүй ажил. Хэдэн минутын дараа л Морис мустангер өөрийн нь толгой дээр сэрийж байгаа царсны мөчирт дүүжлэгдэх болно.

Дур мэдэн шийтгэхийг хүлээж байгаа хүмүүс бараг цөмөөрөө ингэж бодож байлаа.

Гэвч хэрэгтний аз ирэхэд цугларагсдын дунд өөр бодолтой хүмүүс байжээ.

Цэргийн хэсэг хүн шаламгай зөвлөлдөв. Энэ бол цайзын дарга тэргүүтэй офицерууд байв. Тэд хэдэн минутын дараа шийдвэр гаргалаа. Хошуучийн тушаалаар урам татав. Тэгтэл бараг тэр агшинд шивээний цаанаас морин цэргийн дөичн хүнтэй суман, бас төдий тооцоны буучид гарч ирлээ. Тэд дуу шуу гаргалгүй, зөнгөөрөө хийж байгаа юм шиг галуун цуваагаар эгнэж, шүүхийн гишүүдийг гурван талаас нь бүслэв.

Гэнэтийн явдалд цочирдсон цугларагсад шуугин үймэлдэхээ болив. Цугласан олон дуугаа хурааснаар барахгүй томоотой дэгтэй болцгоов. Хошуучийн урьдчилан сэрэмжилсний учрыг бүгд сайн ойлгожээ.

Одоо Линчын шүүхий тухай бодохоос ч хэрэггүй гэдэг нь ил болов. Хууль дахин эрхээ эдлэв. Одоо эргэж ороход нь хэн ё саад хийхээргүй боллоо.

-Иргэдээ! Гэж тэр хүн олны зүг хашгираад - Хуулийн шаардлагад үахирагдах хэрэгтэй! Техас бусад мужаас ялгарах юм бхйгшүй. Энэ тухай хэлэх шаардлага юу байна? Өөрийгөө цагаатгах ганц ч үг хэлүүлээгүй байж хүнийг шууд дүүжилчих юм гэж үү дээ! Энэ бол хууль бус, шударга бус, нэг ёсны аллага болно гэв.

-Тэр чинь тэгээд хүн алаагүй юм уу? залуу Пойндекстерыг ямар болгосонтой адилаар түүнийг тамлах хэрэгтэй гэж Колхауны ойролцоо зогсч байсан танхайчуудын нэг нь хашгирав.

-Энэ нотлогдоогүй байна. Та бүх мэдүүлгийг хараахан сонсоогүй байна. Нөгөө талын гэрч нарын юу ярихыг сонсох хэрэгтэй... Тунхагч! Өмгөөлөх гэрчийг дуудаатах гэв.

Тунхагч Фелим О Нилийг дуудав.

Мустангерын зарцын эв хавгүй хольж хутгасан, зарим газраа үнэн байлалд үл нийцэх яриа эзэндээ тус болох юмаар даанч бага байв.

Сан-Антаниогийн өмгөөлөгч түүнээс аль болох цөөн юм асуухыг хичээж, дараагийн гэрчид илүү найдлага тавьж байлаа.

Хоёр дахь гэрчийг дуудан

-Зеб Ступ! Гэж сонсогдлоо.

Тунхагчийн дуу намдаагүй байхад олны дундаас ханхар том биетэй хүн гарч ирэв. Леоны хамгийн сайн анчин Зеб Стумдыг цам таньж байв.

Зеб урагшаа гуравдөрөв алхаж, гэрчид гаргасан байранд хүрч очив.

Тогтсон горим ёсоор тангараг өргөсний дараа библи хэмээх хөлгөн судрыг үнсүүлхээр ойртууллаа.

Зеб номыг гадна талын тойрогт зогссон хүнд дуулдахаар шовхийтэл нь дуутай үнсэв.

Ёслолын байдлагы тоолгүй инээх сонсдов. Шүүгч чимээ намдахыг шаардсан агаад Зеб ч үүнд туслан, үзэгчдийн царайг хэн нэгнийхнь уруулд инээд байна уу, үгүй ву гэсэн мэт сайтар ажиглав. Хөгшин анчны зан аашийг мэдэхгүй хүнгүй бөгөөд бүгд л доог тохуу хийлгэх хүн биш гэдгийг ойлгож байлаа. Түүний ширүүн харцанд цугларагсад цөм номхрох нь тэр.

Урьдчилсан хэдэн асуултын дараа гэрчийг бүх тойргийг сандралд оруулсан аймшигтай явдлын талаар мэдүүлэг өг гэлээ.

Тэнд байсан хүмүүс амьсгаа дарж, чихээ тавилаа. Бараг цөмөөрөө Зеб Стумп нууцыг тайлна гэдэгт итгэж байлаа.

-За яахав, эрхэм шүүгчээ гэж анч өвгөн, шүүгчийн эгц өөдөөс хараад үгээ хэлж, - Би энэ хэргийн тухай мэдэх бүхнээ ярихад бэлэн байна. гэвч хэрэв та болоод тангарагтан нар эс татгалзвал эхлээд залуугийн тайлбарлахыг сонсох нь дээр гэж би бодож байна. Түүний дараа би ярина. Миний ярих зүйл түүний ярьсныг батлах болно гэж би бодож байна.

-Та ямар залуугийн тухай ярьж байна? гэж шүүгч асуулаа.

-Мэдээжээр мустангерын тухай. Залуу Пойндекстерыг алсан хүн гэж та нарын ял тулгаж байгаа тэр хүний хэлж байна.

-Эцсийнэцэст үнэнийг мэдэх нь бидэнд хамгийн гол нь хэдий боловч энэ чинь тогтоосон журмыг эвдэнэ гэсэн үг хэмээн шүүгч хариулаад - Миний хувьд албан ёснй зүйлийг удиртгал болгох юм алга, харин тангарагтан нар эс татгалзвал таныхаар болог гэв.

Арван хоёр тангарагтан ахлагчаараа зөвшөөрснөө илэрхийлэв. Техас орчмын нутгийнхан ёс журмыг төдийлөн хайхардаггүй учир Зебийн хүсэлт ёсоор боллоо.

LXXXIX. Хэрэгтний мэдүүлэг

Өмгөөлөгчтэйгөө зөвлөсний дараа хэрэгтэнд үг хэлэхийг зөвшөөрөв.

Шүүгчийн дохиогоор урагш гарч ирэхэд харгалзагч нар хойноос нь хоёр алхмын зайтай дагаж явав.

Чив чимээгүй болсныг хэлэх юун. Хүмүүс цөм мустангерээс нүд салгалгүй ширтэнэ. Амьсгаагаа дахан нүглээ наманчлах ч гэж хэлж болох мэдүүлгийн үгнээс нь нэгийг ч гээлгүй сонсох гэж чих тавин чагнацгаажээ.

-Эрхэм шүүгч, тангарагтан нараа! гэж Жеральд үгээ хэлээд - Надад үг хэлэх бололцоо олгосон та бүхэнд би туйлын их баярлаж байна. Энэ эрхийг эдлэнгээ та нарын санаа тавьсныг буруугаар ашиглах гээгүй байна. Та бүхэнд аймшигтай, тэр байтугай тайлбарлахын аргашүй мэт санагдсан энэ дурдагдаад байгаа тэр явдлуудын дэргэд миний ярихзүйл тун жирийн бөгөөд ямар нэг вч ойлгож авахад тус болно гэлдгийг би юуны өмнө хэлэх хэрэгтэй байна. Та бүхний энд сонссон бүхэн, цөм үнэн зөв биш. Мэдүүлгийн зарим нь түүнийг хэлсэн хүний худалдчтай адилхан гүтгэлэг юм гэв. Колхаун тэр харцнаас болж гар буу тулгуулсан юм шиг улам атиран бэгцийв.

-Пойндекстер авхайтай уулзсан минь туйлын үнэн. Энэ сайн санаат бүсгүй үнэнээ илэн далангүй ярьснаараа намайг энд чин үнэнээсээ ярих бололцоотой болголоо. Тэрнээс биш би бүх үнэнийг хэлж зүрхлэхгүй байсан юм. Миний ярих бүх зүйлд итгэхийг гуйя. Бидний сэм уулзсан болоод тэр уулзалтыг цаашид юу болсны нь ярьж чадахаасаа нэгэнт өнгөрсөн тэр хүн тасалдуулсан нь ч үнэн. Бас бид муудалцсан, чухамдаа гэвэл надад уурласан нь үнэн. Гэвч бид дахин муудалцсан гэдэг бол худал гүтгэлэг юм. харин би түүнд зохих ёсоор нь хариу өгөх бололцоотой байсан бол тэр ам шүд алдаад байгаа хүн тэгж гүтгэж зүрхлэхгүй байхсан билээ.

Олны дунд улам бэгцийн нуугдажбайгаа Колхаун дээр хэрэгтний нүд дахин туслаа.

-Харин ч бүр эсрэгээр гэж Жеральд үгээ үргэлжлүүлэн - Дахиад бид уулзахад Генри Пойндекстер миний өмнө буруугаа хүлээсэн юм. Миний хувьд бол би түүнийг нөхөрсгөөр... бүр эелдгээр хайрладаг юм. Түүнд хайргүй байхын аргагүй хүн. Би түүний уурандаа хэлсэн үгийг уучилсан эсэх тлааар эргэлзэх юм байхгүй нь мэдээж. Ингэж эвлэрсэнд нь би үнэн голоосоо баярлаж байгаа...

-Тэгэхээр та хоёр эвлэрсэн юм шив дээ? гэж түр зогссоны нь ашиглан шүүгч асуугаад - Хаана болсон явдал бэ? гэв.

-Хүн амины хэрэг гарсан газраас барагцаалбал дөрөн зуун алхам газар.

Шүүгч босон харайв. Тангарагтан нар ч бослоо. Босоо зогсчбайсан үзэгчид мэл гайхав. Хэн ч хэрэг гарсан гаурын тухай яриагүй бөгөөд тэр бүү хэл гэмт хэрэг гарсныг ч дурдаагүй билээ.

-Та цус тунасан газрыг хэлж байнаа даа? гэж шүүгч тээнэгэлзсэн

байдалтай асуув.

-Би Генри Пойндекстерын алагдсан газрын хэлж байна.

Эдгээр үгс үзэгчдийг улам гайхалд оруулан шуугилдав. Хүмүүсийн шивгэнэлдэх, бөглүү дуу гарах нь сонсогдоно. Бусдаас чанга гингэнэх сонсогдсон нь хүүгээ алдсандаа одоо нэгэнт эргэлзээгүй болсон өвгөн Пойндекстерын цээжнээс гарчээ. Одоог хүртэл өвгөний зүрхэнд Генри амьд байж магадгүй, өвдсөн ч юмуу, индианчуудад баригдсан байж болно гэдэг найдвар байжээ. Энэ үе хүртэл түүний хүүгийн үхсэн тухай тодорхой баримт нотолгоо байгаагүй бөгөөд зөвхөн тохиолдлын болоод төдий л итгэлтэй бус баримт байлаа. Гэвч одоо энэ найдварыг нь хэрэгтний амнаас гарсан үг алга болгожээ.

-Генри Пойндекстерыг үхсэн гэж та итгэж бхйгаа юм шив дээ?

-Яг таг итгэж байна. Хэрэв миний үзсэн юмыг та үзсэн бол өөрийнхөө асуултын хичнээн дэмий болохыг ойлгохсон гэж хэрэгтэн хариу өчив.

-Та хүүрий нь үзсэн юм шив дээ?

-Ийм маягаар байцаахыг би эсэргүүцэх ёстой. Энэ бол хэрэг шийтгэх хэмжээг шууд зөрчиж байгаа хэрэг гэж өмгөөлөгч ярианд хөндлөнгөөс оролцов.

-Манай нутагт бол шүүгч ийм байдал гаргуулахгүйсэн билээ гэж ирланд өмгөөлөгч нэмж хэлээд - Манайд прокурор бол ээлжлэн асуулт тавих үе эхлээгүй байхад ярих эрхгүй байдаг юм гэв.

-Манай улсын хууль ч тийм юм хэмээн шүүгч журам эвдэгч рүү муухай харан хэлээд - Хэрэгтэнта цааш ярьж болно. Таныг ярьж байх хооронд зөвхөн өмгөөлөгч чинь л юм асуух эрхтэй. Үргэлжлүүл. Та хэрэгтэй гэж үзэж байгаа бүх юмаа ярьж болно гэв.

-Би эвлэрсэн тухай болоод хаана эвлэрснээ ярилаа гэж хэрэгтэн үгээ үргэлжлүүлээд - Одоо би чухам тэнд болсон явдлыг тайлбарлах хэрэгтэй. Пойндекстер авхай, түүний дүү бид гурвын яаж салсныг та нар хэдийнээ мэдэж байгаа. Тэднийг орхиод би шууд гол руу үсрэн орсон юм. Нэг талаар нөгөө эрэгт яаж гарахаа ч бодохтой сэтгэл догдолсон байсан бөгөөд нөгөөтэйгүүр цэцэрлэгт яаж ирснээ мэдэгдэхийг хүсээгүй юм. Тэгэх үндэс надад байсан юм. Би гол өгсөн суурингийн чигт явсан. Дулаахан шөнө байсныг та нар санаж байгаа байх. Намайг зочид буудалд хүрч очихоос өмнө хувцас маань бараг хуурай болчихсон байв. Намайг очиход баар онгорхой, эзэн нь лангууныхаа ард зогсч байсан. Энэ оромж миний хувьд тийм ч найрсаг зочломтгой байгаагүй учир шөнийн сэрүүнийг ашиглан шууд л Аламо руу буцахаар шийдсэн юм. Би зарцаа түрүүлж явуулаад өөрөө маргааш өглөө нь явах гэж байлаа. Гэтэл Каса-Дель-Корвод болсон явдал намайг аль болох түргэн явахад хүргэсэн билээ. Обердофертой тооцоо хийчихээд яваад өгсөн...

-Та тооцоо хийсэн, мөнгөө хаанаас авсан бэ? гэж прокурор асуув.

-Би эсэргүүцэж байна гэж өмгөөлөгч нь түүний үгийг таслав.

-Журам нь хаана байна! Гэж ирланд өмгөөлөгч прокурор руу харж хэлээд - Хэрэв манайд ийм юм болсон бол тантай өөрөөр ярихсан билээ гэв.

-Эрхмүүдээ тайван байцгаа! Хэрэгтэн цааш яриг гэж шүүгчзахирсан дуугаар хэлэв.

-Би аажуухан явж байсан. Яарахын ч хэрэг байгаагүй. Миний нойр хүрсэнгүй. Тал нутагт унтах буюу овоохойдоо унтах хоёрын аль нь ч надад ялгаагүй байлаа. Би Аламод үүрээр хүрвэл л болох байлаа. Түүнийгээ ч мэдэж байв. Би бодолдоо дарагдаад эргэж харалгүй явсан. Үнэний нь хэлэхэд хойноос минь хэннэг хүн явах юм гэж санаагүй явсан юм. Ой дундуур хагас бээр хяраатай яваад Рио-Гранд руу явдаг зам дээр хүртэл юу ч анзаарсангүй. замд хүрч явтал миний хойно морин туурайн чимээ гарахыг сонслоо. Би цавцаал замаар дөнгөж эргээл байсан болохоор морьтонг харах арга байсангүй. гэвч тэр хүн морины хатираагааройртож байгааг сонсов. Намайг тэгтлээ сандруулаагүй ч гэсэн, араас гүйцэн ирж байгаа хүн дайсагнасан санаатай ч байж магадгүй юм гэж бодлоо. Тэгээд би тал нутгийн амьдралд индианчуудтай хөрж суудагтаа тогтсон заншлаар сөөг рүү эргэн орж морьтой хүнийг дөхөж ирэхийг хүлээв. Удалгүй нөгөө хүн маань ч гараад ирэв. Танихгүй хүний оронд өмнөхөн нь уурлалцан салсан хүнээ хараад миний гайхсаныг төсөөлөн бод л доо! Би уур хилэнгийн тухай ярихдаа өөрийгөө бус түүнд хамааруулж байна. тэр ямаршуухан байдалтай байсныг би мэдэхгүй байлаа. Тэрхэн үедээ эгчийнхээ дэргэд биеэ барьчихаад, одоо нөгөө доромжлуулсныхаа хариуг авах гэж байж магадгүй яа! Тангарагтан, ноёд оо, би яг ингэж бодсоноо нуугаад байх юм алга. Миний сэтгэл санаа нэгэнт ариун учир нуугдаад байх хэрэггүй гэж бодов. Би түүний эгчтэй сэм уулзсан нь үнэн боловч буруу байхгүй. Би түүнд хамаг сэтгэл зүрхээрээ одоо ч гэсэн дурлаж байгаа шигээ... хамгийн цэвэр, нандин дурлалаар дурласан юм.

Луиза Пойндекстерын сүүх холхон зогсч байсан ч гэсэнбүсгүй мустангерын үг бүрийг сонсон, дутуу буулгасан хөшигний цаанаас нүүрий нь харж байлаа. Хэдийгээг өр зүрхий нь базалсан гуниг байгаа боловч, мустангерын илээр үнэнээ хүлээхийг сонсоод, нүүр нь баяр баясгалангаар гийв. Энэ бол түүний сэтгэлийн илрэл байлаа. Цайсан хацар дээгүүр нь улаан туяа татсан нь ичсэндээ бус, ихэмсгээр ялан дийлснийх ньажээ.

Түүнээ нууя ч гэж бодсонгүй. Харин ч түүнийг хараад байхад одоохон тэрэгнээсээ үсрэн гарч, дүүгий нь алсан хэрэгт яллагдаад байгаа хүнийг тэврэн авч, яллагчдыг нь үзэн ядахад бэлэн байна уу гэж бодмоор.

Уйтгарын сүүдэр царайд нь дахин тодров. Гэвч энэ нь хардсанаас ингэснэ хэрэг бус ажээ. Өвчтөний орны хажууд байхдаа сонссон үгийг сайн санаж байв. Түүнд эргэлзэж болно гэж үү? Тэр хүн эл үгээ одоо ухаан нь элий балай болоогүй байхдаа, үхлийн аюул өөрийг нь заналхийлж байхад давган хэлжээ.

ХС. Хуралдааны гэнэтийн завсарлагаа

Луиза Пойндекстерын сэтгэлийг тэгтлээ баяр баясгалангаар дүүргэсэн мустангерын сүүлчийн үг ихэнх хүмүүст шал ондоон сэтгэгдэл төрүүлжээ.

Хүн гэдэг амьтны нэг сул тал нь энэ. Бид бусдын хайр дурлалыг халаглаж, харамсах нь их байдаг.

Үүнийг тайлбарлахад амархан. Бид дурлалцаж байгаа хоёрыг огтын тоодоггүйгээ мэддэг. Энэ бол үлтоомсорлосон биеэ тоох явдлын улиг болсон хэрэг.

Үзэсгэлэнт креол бүсгүйн гоог тэгтлээ хайхардаггүй нь хүртэл атаархсанаа дарж чадахгүй байв. Түүнд сэтгэлтэй нэг нь мустангерын хэлсэнд, тоглоом ч үгүй учиргүй гомджээ.

Хэрэв хэрэгтэнд өөрийн буруугүйг нотлох өөр баримт байдаггүй юмаа гэхэд, дуугай л өнгөрөөсөн бол ухаалаг хэрэг болох байж. Өөрийн мэдүүлгээр тэр нь зөвхөн гал дээр тос хийнэ гэдэг шиг олон хүний дургүйг хүргэчихжээ.

Цугларагсдын дунд дахин дүнгэнэлдэж, Колхауны хань хамсаатан нар дахин шуугилдлаа. Дургүйцсэн олон Морис Жщральдыг дур мэдэн шийтгэж, яриагий нь дуусгалгүй дүүжлэх нь үү дээ гэлтэй болов.

Гэвч зөвхөн ингэж санагджээ. Хоуушч суман руугаа учиртайхан харав.

-Тайвширцгаа! Гэж шүүгч захирангуй дуугаар шаардлаа.

Чимээ шуугиан дарагдаж хэрэгтэн дахин ярих бололцоотой болов. Тэр нь үгээ үргэлжлүүлэн

-Би Генри Пойндекстерыг таниад сөөгнөөс гарч, мориныхоо амыг татан зогсоов. Нэлээд гэгээтэй байсан учир тэр намайг шууд танив.

Эвгүй уулзалт болох нь гэж хүлээж байсныг хэлэх үү, ингэж бодох үндэстэй байсан гэжби бодож байна, түүний найрсгаар уулзсанд нь би маш их баярлан гайхлаа. Тэр над руу гараа найрсгаар сунгаж, үг дуугарангуугаа л өөрийнхөө хүлцэнгүй биш зан гаргасанд уучлал гуйлаа. Би цагаан санаат залуугийн тэр гарыг хичнээн халууну дотно атгаснаа хэлэх юун! Энэ бол үнэнч нөхрийн гар гэдгийг би мэдэж байь. Түүнээситлүүгээр нэгэн сайхан өдөр энэ гарны эзэн дүү минь болох юм гэж найдан санагалзаж байснаа нуух юун. Би тэгэхэд тэр гарыг сүүлчийн удаа шахуу атгаж байжээ. Сүүчлийн удаагаа, хоёр биедээ тавтай нойрсохыг ерөөгөөд зөргөөр салахдаа түргэхэн шиг атгаад авсан юм. Бид үүрд салж байна гэдгийг би бодсон ч үгүй. Эрхэм тангарагтаннараа! Бид хоёрын хооронд болсон юмны тухай өгүүлж, та нарын цагийг гарздаад яахав. Тэр явдал бол шүүхийн энэ хуралдаанд ямар ч холбогдолгүй юм. Тэгээд бид зэрэгцэж нэлээн яваад сүүлд нь нэг модны ёроолд зогссон. Тэнд навчин тамхиа солилцон татлаа. Тэгээд найзархаг харьцаагаа улам бэхжүүлэхийн тулд малгай, цуваа солилоо. Би энэ заншлыг команч нараас сурсан юм. Би мексик сомбреро малдгай, судалтай серапегаа Генри Пойндекстерт өгч хариуд нь түнүий дэлбэгэр үйсэн малгай цув хоёрыг авсан. Дараа нь бид хоёр салж тэр маань яваад би хоцорсон юм. Би яагаад тэнд хоцорсноо

өөрөө ч сайн ойлгохгүй байна... Тэнд миний хувьд санамсаргүй баярт үйл явдал, эвлэрсэн болохоор тэр газар надад дотно санагдсан байх л даа. Би Аламо руу замаа хөөмөөргүй болоод явчихсан юм. Би жаргалтай байсан бөгөөд модон дотор сайхан байлаа. Би бууж морио уячихаад цуваараа ороож малгайгаа ч авалгүй ногоон дээр хэвтээд өгсөн. Хэдэн хормын дараа би унтчихжээ. Хагасхан цагийн өмнө бол ингэж чадахгүй л бйасан юм. Үүнийг сэтгэл ихэд хөдөлж, хямарсны дараахь сайхан тайвширсны шинж гэж хэлж болно. Гэвч би удаан бөх унтсангүй. Хэдэн минут ч болоогүй байтал буун дуу гарч намайг сэрээв. Үнэндээ тэгж санагдсан ч байж болох учир би бүрмөсөн итгэсэнгүй. Гэвч морины маань байж байгаа нь нэг л биш. Би босон харайж чимээ чагналаа.

Өөр лүү нь буудсан юм шиг чихээ сортолзуулан, хуухирна.

Гэвч өөр юу ч сонсдоогүй бөгөөд мустанг ч тайвширч, хоёулаа эндүүрчээ гэж би бодлоо. Ой дотуур ойролцоо араатан явахыг морь мэдээд, надад буун дуу гэж санагдсан зүйл маань амьтны хөлд гишгэгдсэн гишүүний дуу ч юмуу, эсвэл ширэнгэд дандаа сонсогдож байдаг учры нь олохын аргагүй битүүлэг дуу байгаа юу гэж бодлоо. Би тэгээд энэ тухай бодохоо болиод ногоон дээр хэвтээд адхин унтчихав. Энэ удаад өглөө болтол унтаад зөвхөн ясанд хүртэл хайрсан хүйтэн чийгнээс болж сэрэв. Модны ёроолд байгаад байх нь эвгүй байсан тул би явахаар бэлтгэв. Гэвч буун дуу анх нойрмог байхад сонсодсоноос ч чангаар чихэнд дуугарсаар байв. Тэр дуу Генри Пойндекстер явсан зүгээс гараад бахих шиг санагдав. Энэ маань хий бодлын үр байсан эсхийг бүү мэд, би өөрийн эрхгүй энэ буун дууг түүнтэй холбож, явж юу болсныг мэдье гэсэн хүслээ барьжчадсангүй. Төдий л удаан явсангүй. Бурхан минь! Намайг юу харсан гэж бодноо! Миний өмнө... гэтэл,

-Морь унсан толгойгүй хүн! гэж олны дундаас нэг хүн цөмий нь өөрийн эрхгүй эргэж хартал нь хашгирав.

-Морь унасан толгүй хүн! гэж тавиад хүний дуу цууриа мэт давглаа.

Энэ чинь шүүхийг дамшигласан тоглоом уу?

Хэн ч ингэж бодсонгүй. Энэ үед талаар давхиж яваа морь унасан толгойгүй хүнийг цөм харлаа.

-За тэр айсуй! Тэнд! Тэнд!

-Үгүй, тэр чинь наашаа явж байна! Хараач! Тэр шууд цайз руу давхиж байна!

Нээрээ ч морь унасан толгойгүй хүн чигээрээ давхиж ирлээ. Гэвч хормын дараа модон доор цугласан олны өөдөөс харан гэнэт зогслоо.

Моринд харагдсаг зүйл түүнд таалагдаагүй бололтой. Морь чанга хуухирч, дараа нь хангинатал янгцаагаад, тал нутаг дундуур буцаж давхив.

Хэрэгтний мэдүүлгээр төрсөн их сонирхол шууд үгүй боллоо. Олонхи хүн морь руугаа ухасхийв. Тангарагтан нар ч зүгээр байсангүй, наад зах нь л арван хоёр тангарагтны зургаа нь

морь унасан битүүлэг хүний хойноос хөөх улстай нийлэв.

Тэдний өмнө тохиолдлоор гарч ирсэн битүүлэг морьтонд л хэргийн учир байгаа юм шиг бүхэнд санагджээ.

Араасаа хөөлгөсөн морь ойртож буй морьтонгуудыг харахын тулд зөвхөн түр зуур зогсов. Тэгснээ дороо огцом эргээд чанга янцгаан хар хурдаараа тал ржж давхин одлоо.

Морьтонгууд дуу шуу болон араас нь элдэв.

ХСІ. Ширэнгэ дундуур хөөсөн нь

Морьтонгууд талыг хөндлөн гарч суурингаас арваад бээрийн тэртээ үргэлжлэх ой руу давхилдлаа. Ойд ойртох тусам морьто йхүмүүсийн эгнээ алгуур шингэрч цувж эхлэв. Морьд холын ширүүн давхиа даасангүй сүүлдэн ар араасаа цувжээ.

Ойд цөөхөн хүн ойртож очсоны хоёрхон хүн л ширэнгийн аль хэсэг рүү морь унасан толгойгүй хүний орохыг харж амжжээ.

Бор мустангтай хүн түүнд бусдаас ойрхон явж байв. тэр нь морио галзуутай шавдуулна.

Түүний хойноос хол хоцорсон ч гэлээ хөгшин гүүунасан эсгий бүх тавьсан хууичн хөнжлөөр хийсэн хүрэмтэй өндөр хүн давхиж явна. Унасан эзэн нь гуядахгүй, давирахгүй, гуугалахгүй байхад морь тийм хурдан давхих юм гэж хэн ч бодсонгүй. Тэр хүн илүү хэрцгий арга хэрэглэн хурц хутганы үзүүрээр морины хондлой руу байн байн дүрж явжээ. Хөөцөлдөөний манлайд яваа роёр морьтой хүн бол Кассий Колхаун, Зеб Стумп хоёр байлаа.

Удалгүй тэд ширэнгэ рүү далд орон бусад морьтонгууд бараагий нь алдлаа.

Өтгөн ширэнгэ дундуур гурван морьтой хүн муруйж тахиралдан, амьтны зөргөөр модон дундуур шургалан хойно хойноосоо давхина. Тэд бут сондуул дундуур, аршийн нударгын өргөс, агарын хурц үзүүрт зүүг ч хайхралгүй урагш тэмүүлнэ. Мөчир тас нясхийн хугарч, ийнхүү ухаан зүггү дайрахад нь үргэснэ шувууд дэрхийлдэн муухай дуугарч аюулгүй газар руу ниснэ.

Хуурай мөчир дээр сууж байсан бөөн нөмрөг тас дээшээ тэнгэрт хөөрөв. Иймэрхүү хөөцөлдөөн ямар нэгэн үхлээр дуусна гэдгийг тэд зөнгөөрөө мэдэж байлаа. Жигүүрээ дэлгэсэн хар шувууд морьтонгуудын дээгүүр эргэлдэнэ.

Араасаа элдүүлж яваа морьтон хөөж яваа хоёроосоо илүү ашигтай байдалд байлаа. Тэр замаа өөрөө сонгож, харин нөгөөдүүл нь араас нь явах хэрэгтэй ажээ. Хэдийгээр морьтонгуудын хоорондох зай багасаагүй авч, модон дунд удалгүй бие биеэ харж чадахгүй алдчихав.

Зөвхөн нөмрөг таснуд ч гурвуулангий нь харж байв.

Хойноосоо элдэж яваа улсад харагдахгүй байх нь хөөгдөж яваад бүр ч ашигтай болов. Одоо хар хурдаараа давхиж болох агаад цаадуул нь мөрий нь хөөх гэж цаг алдах болно. Тэд одоохондоо туурайн тачигнах чимээ, мөчир хугарахаар баримжаалж байлаа. Гэвч эхний морьтон цөхөрч эхлэв.

Замын нугачаа бүрт өмнөхөөсөө улам холдож байгаа санагдан туурайн чимээ сонсдохоо аль хэдийнээ больжээ.

-Өөдгүй муу новшийг дээ! гэж Колхаун цөхрөн зангаж хэлээд - Бас зайлчихлаа шүү! Хэрэв

надаас өөр хүн байгаагүйсэн бол ч яая гэхэв! Гэвч энэ удаа би ганцаараа биш байна. нөгөө хөгшин чөтгөр хэдийнээ энд салдархилж явна. Намайг сөөг рүү орж явахад гурван зуун алхам хяраатай явж харагдсан. Түүнээс яаж ийгээд бултчихаж болоагүй л юм байх даа? Үгүй, тэр дэндүү сайн мөрч... Ер нь болох ч юм биш үү! Гэлээ.

Ахмад ингэж хэлээджолоогоо татаж хагас эргээд, дөнгөж саяныхаа явж өнгөрсөн зөрөг зам руу эргэж харав.

Тэр нь дотроо төлөвлөөгөөгөө боловсруулж, түүнээ биелүүлчихээр боломжтой газрыг хайж буй хүний харцаар харна. Тэгээд тулгамдсан байдалтай буугаа шүүрч авлаа. Гэвч хөдөлгөөнд нь мэгдэж алгасан нь илт байв. Эргэлзсэн хэвээр байсан агаад баахан бодож байснаа санаснаасаа ухрахааршийдэв.

-Үгүй, ингэж таарахгүй нь гэж бувтнаад - Миний хойноос даанч олон хүн явж байгаа. Тэдний дунд мөр таних хүн цөөнгүй бий. Тэд хүүрийг заавал олно. Бас бууны дууг ч сонсоно. Үгүй! Ингээд ямар ч ашиггүй гэв.

Ахмад бас хэсэг зуур зогсч чимээ чагнав. Ямар ч чимээ сонсдохгүй бөгөөд зөвхөндээр нь тасын жигүүрээ дэвэх л сонсодно.

"Тиймээ, тэр мэдээжээр энд ирнэ. Бусад нь ийм ойрхон байгаа нв даанч Харамсалтай боллоо! Хэрэв тэд байгаагүй бол намайг танадах хөг нь өнгөрөх байсан юм. Хичнээн амархан шүү!"

Кассий Колхаун, таны бодсон шиг тийм амархан байхгүй! Хэрэв дээгүүр чинь эргэлдэх шувууд хүний хэлээрьярдагсан бол үүнийг чамд хэлээд өгөх байсан юм. Шувууд Зеб Стумдын ойртож байгааг харж байлаа. Гэвч хэнд ч дуулдахааргүй сэмхэн алхана.

"Тэр мөрөө алдчихсан бол мөн сайнсан! Гэж Колхаун үргэлжлүүлэн бодсоноо

-Ямар ч байсан би мөр алдтал нь яваад үзэх хэрэгтэй. Эс тэгвэл хэн нэг тэнэг нь надаас өрсчихөж магад... Би ч бүр дэмий чалчсаар байгаад ийм их цаг алдчихдаг тэнэг амьтан юм! дахиад жаахан удвал хөгшин зөнөг гүйцэж ирээд хамаг юм баллачихна. Чөтгөр аваг, ингэж болохгүй!" гэв.

Колхаун мустангаа давирч ширэнгийн тахиралдсан зөрөг замаар аль

болохоор хурдлав.

Дөнгөж хоёр куун алхам хяраатай явснаа гэнэт зогсон гайхаж баярласандаа дуу алдах нь тэр.

Түүнээс хориод алхам зайтай морь унасан толгойгүй хүн харагдана. Тэр нь эмээлий нь шүргэсэн намхан бутан дунд зогсч байлаа.

Морь толгойгоо гудайлган хуайсны хонохорцог зулгаажбайгаа бололтой.

Колхаунд л лав тэгж санагджээ.

Колхаун буугаа түргэн зуур өргөсөн боловч тэр дорхиноо буулгав. Түүний буудах гэж онилсон морь нь хуайс зулгааж, тайван зогсч байгаа бус харин бутан дунд шургуулсан толгойгоо учир зүггүй хөдөлөж байжээ.

Эмээлийн бүүрэгнээс мултарсан жолоо нь хуайсанд ороолдоод, морь алдуулах гэж тэмүүлж байхыг Колхаун харлаа.

“Ингээд баригддаг байжээ! Бурхны аврал, бурхны аврал!”.

Колхану араас ирж яваа хүнд дуулдуулахгүй гэсэндээ баярласан сэтгэлээ арай ядан барьж дуу гаргалгүй нөгөө битүүлэг, олон хоногоор яс заан хөөж мөрдөж байсан морьтой хүний дэргэд хүрчихсэн байв.

ХСП. Аргагүйдэж буцав

Колхаун морины хазаараас шүүрч авлаа. Морь мултрах гэж оролдсон авч хуайсанд ороолдсон жолоо нь саад болоод зөвхөн бутыг тойрохоос хэтэрсэнгүй. Дээрх хүн нь юу ч анзаарахгүй, олзлогдохоос зугтаая гэж ч оролдсонгүй. Морио эргэлдэхэд нь саад болох ч үгүй эмээл дээрээ хөдлөхгүй сууна. Жаахан тонгочиж байснаа хээр морь яаж ч чадалгүй номхорлоо.

Ялагчийн амнаас баярласан дуу өөрийн эрхгүй гарав. Гэвч нэгэнбодол харван орж ирж дорхиноо дуугай бо лов. Тэр бодсон бүгдээ хараахан хийж амжаагүй байлаа.

Тэр юу бодов оо?

Үүнийг тэр ганцаараа л мэдэж байв. Түүний тал тал тийш хялалзахыг харваас, өөрийнх нь нууцад хэнийг ч оруулахгүй гэсэн нь илэрхий.

Эргэн тойрны бут сөөгийг сайтар харж, чимээ чагнаснаа ажилдаа орлоо.

Түүний байр байдлыг мэдэхгүй хүнд бол хачин гайхмаар зүйлийг хийлээ. Тэр хутгаа сугалж сорь унасан толгойгүй хүний серапег цээж хавьцаа нь сөхөөд зүрх рүү нь хутга шаах гэж байна уу гэлтэй бөхийв. Хутгаа далайн... юу ч түүний нь зогсоохоос өнгөрөв үү гэлтэй....

Гэвч далайсан гараа буулгаж амжсангүй. Ширэнгэ дотроос дуу алдах

сонсдоод нэгэн хүн гарч ирсэн нь Зеб Стумп байлаа.

-Ингэж тоглохоо боль! Хэмээн анчин хашгираад, сөөг дундуур алхан хурдан очоод - Боль гэж хэлж байна шүү! гэв.

-Ямар тоглоом? Гэж ахмад хутгаа сэм нуунгаа сандран асуугаад

-Та юу гэж хашгираад байгаа юм бэ? Энэ мал сөөгөнд ороолдчихож. Тэгээд дахин зугадах вий гэж айсандаа энэ явдлын төгсгөл болгон багалзуурыг нь тас огтлох гэсэн юм гэв.

-Өө тийм бий! Харин би юутай ч гэсэн үүний хоолойг огтлох хэрэггүй гэж үзэж байна. Түүнгүйгээр аргалчихаж болно. Ингэхэд та ямар хоолойны тухай яриад байнаа? Мориных уу?

-Тэгэлгүй яахав.

-Тийм бай. Хүний нь тухайд бол хэн нэгэн хүн аль хэдийнээ ийм мэс засал хийчихсэн юм шүү дээ. Эрхэм Колхаун та энэ талаар юу гэж бодож байна?

-Чөтгөр бүү мэд! Би юу ч ойлгохгүй байна. Надад үүнийг ажиглаж байх зав ч гараагүй байна. Би дөнгөж сая гүйцэжирээд байгаа нь энэ... Бурхан минь гэж тэр айсан дүр үзүүлсэнээ - Энэ чинь үхсэн хүн байна шүү дээ! гэж үргэлжлүүлэв.

-Сүүлчийн үг чинь үнэн байж магад. Мөрөн дээрээ толгойгүй байж амьд байх нь юу л бол.

Энэ даавуун дор юу ч далдлагдаагүй юм шиг байна уу?

-Үгүй. Тэнд юуч байхгүй гэж надад санагдаж байна.

-Жаахан сөхөөдхөөч, харцгаая.

-Би үүнд гар хүрэхийг хүсэхгүй. Тун аймаар зэвүүн харагдаж байна!

-Хачин юмаа! Та минутын өмнөхөн л огтын айхгүй байсан. Гэнэт юу болчихов?

-Юу л даа... гэж Колхаун түгдрэн хэлээд - Би үүнтэй хөөцөлдөж яваад сэтгэл их хөөрчихөж. Маш их уур хүрч, түүний илбийг төгсгөө гэж шийдсэн юм.

-За яах вэ, тэгвэл би өөрөө оролдож үзэхээс... гэж Зеб хэлээд аймшигт дүрст ойртон очиж ажиглаад

-Тиймээ, энэ үнэхээр үхсэн хүний цогцос байна. Үхээд бүр хөшчихөж... Байзаарай! Гэж Зеб серапений хормойг сөхөөд - Өө энэ чинь өнөөх алагдсан гэж шүүхийн хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа залуугийнхүүр байна шүү дээ! Таны үеэл дүү Генри Пойндекстер! Энэ мөн байна! гэв.

- Таны хэлдэг үнэн шиг надад санагдаж байна... Энэ бурхан минь, үнэхээрийн мөн байна!

-Иосафат минь! гэж Зеб гайхсан дүр үзүүлэн үгээ үргэлжлүүлж, Ёстой оньсого шиг юм! Бид энд элдвийн юм бодож цаг гарздахын хэрэггүй. Энэ хүнийг бид эмээл дээрээ байгаа хэвээр нь тийш аваачсан нь хамаагүй дээр. Эмээл дээрээ бэх бат суусан нь илт байна. энэ морийг би мэднэ. Миний гүүний араас дуулгавартай дагана гэж би бодож байна... За ль, хөгшин минь үүнтэй мэндэл. Бүү ай! Чи чинь энэ хуучин танилаа танихгүй байна гэж үү? Үнэндээ түүнд сүүлийн үед амаргүй юм тохиолдсон нь мэдээж. Чиний танихгүй байх аргагүй. Цэвэрлээгүй хичнээнч удав даа! гэв.

Анчны ярьж байхад хээр морь хөгшин гүү хоёр хамраараа шөргөөлцөж, нөхөрсгөөр тургив.

-Би тэгнэ ч гэж бодсон юм! гэж Зее хуайсанд ороолдсон жолоог тайлан хэлээд - Хээр морь миний гүүтэй болохоор бидний хойноос тайван дагана. Юутай ч гэсэ үүний холойг заавал огтлохын хэрэг алга. За, эрхэм Колхаун одоо та бидний хөдлөх цаг болсон юм биш үү? Гэж анч өвгөн, ахмад руу сорьсон харцаар харж хэлээд, - Шүүхийн хуралдаан лав үргэлжилж байгаа. Хэрэв тийм бол мэдээж бид тэнд хэрэгтэй болж таарна. Уг хэргийн учрыг олох эд мөрийн баримт бидэнд байна гэж санагдах юм. Тэгээд мустангер нэг бол дүүжлэгдэнэ, эсвэлцагаадна. За, та буцахад бэлэн байна уу? гэв.

-Өө тэгэлгүй яах вэ! Таны хэлдэг зөв. Бид энд байх хэрэг алга.

Зеб олзлогдогчоо хөтөлсөөр урьдаар хөдлөв. Золхаун хйоноос нь аажуухан, харваас дуртай биш явлаа.

Колхаун замын огцом эргэлт дээр очоод чигээрээ явах уу, эргээд давхих уу гэж эргэлзсэн мэт

жолоогоо татав. Түүний царайд сэтгэл их догдолсон шинж илэрхий байв.

Зеб Стумп ардаа морин төвөргөөн сонсдохгүй болохоор нөгөөгөө зогсчихлоо гэдгийг таав.

Анчин жолоогоо татаж, гүүгээ эргүүлээд ахмад руу асуусан харцаар харав. Өвгөн түүний маш их сандарч тэвдсэн царайг хараад юу болсны нь шууд таалаа.

Тэгээд нэг ч үг дуугаралгүй буугаа мөрнөөсөө авч гартаа бариад морин цэргийн огоцорсон ахмадыг цоо ширтэн зогсов.

Зеб дуугарсангүй. Үгийн хэрэг байсангүй, байдлы нь харахад ч хангалттай байла. “Буцаад үз л дээ!” гэж байгаа нь илэрхий.

Колхаун юу ч ажиглаагүй дүр үзүүлсэн ч үүнийг сайн ойлгож, үг дуугаралгүй замаа хөөв.

Гэвч одоо тэрээр ард явахын аргагүй болжээ. Хөгшин анчинд сэжиг төрөн хойно нь явах шалтаг гаргахад Колхаун дуртай дургүй ч зөвшөөрөхөөс өөр арга байсангүй.

Тэд ой дотуур аажуухан явлаа.

Задгай тал руу ойртсоор эцэст нь гарч ирлээ. Алсад бүүр түүр харагдах юм Колхауны айдсыг дахин ихэсгэв. Дахин жолоогоо татан бодолд орлоо.

Түүний өмнө аймшигтай хоёр зам: хүмүүсийн нүднээс зугтан ширэнгэнд нуугдах, эсвэл өөрийг нь яах ийхийн зуургүй нөмрөн авах шуугианы өмнөөс явах уу гэдэг байв.

Колхаун үзэн яддаг Зеб Стумпээс аравхан минут ч холдож, морь унасан толгойгүй хүнтэй үлдээж өгөх юм бол өөрийнхөө мэдэлд байгаа хамаг юм, тэр ч байтугай хожим өөрийн болгож авна гэж найдсанаа, тэр бүү хэл Луиза Поундекстерыг ч оролцуулаад өгчих байлаа.

Гэвч энэ болможгүй зүйл байв. Зеб Стумп зөөлрөшгүй сэтгэлтэй хүн бөгөөд хэдийгээр Колхаун энэ тухай болохгүйг хичээвч өвгөн анчин түүнийг жинхэнэ олзлогдогч хэмээн үзэж зугтаах гэж оролдвол хээв нэг нуруу руу нь сум зоочихно гэдгийг мэдэрч явлаа.

Гэвч эцсийн эцэст Зеб Стумп юу хэлж, юу хийх вэ? Түүнийг.... Тэгсэн гэдгийг таах нь юу л бол?

Эцсийн эцэст бүх зүйл сайн сайхан өнгөрч магадгүйеэ дээ?

Үнэндээ Зеб Стумп ямар нэг юм хардаж сэжиглэж байв. гэвч үүнээс айхын хэрэг байна уу? нөхөд гэж байхгүй хүмүүс л сэжиглэгдэхээс айдаг. Харин Колхаунд олон найз нөхөд бий. Хэрэв... энэ өчүүхэн түүх нэг юмыг л олчихдоггүй юм бол юу ч түүнийг айлгахгүй. Үүнд магадын хувь аль хэр байна? Арвын эсрэг нэг. Ер нь ч тэгээд буудсан газар хоцорч үлдээгүй нэвг гарч ширэнгэ дотор нэгтгээ нь унасан ч байж болох юм.

Ийнхүү найдсандаа зориг орсон Колхаун тайвшран үнэнээсээ илүүгээр хээв нэг байгаа дүр үзүүлэн тал руу гарч ирлээ. Генри Пойндекстерын хүүртэй хээр морь хөтөлсөн Зеб Стумп

Хөгшин гүүтэйгээ түүний араас явна.

ХСШ. Толгойгүй үхдэл

Үзэгчдийн гуравны хоёр нь, тангарагтан нарын хагас нь битүүлэг морьтны араас хөөгөөд явчихсан учир шүүх ажиллагааг тасалдав. Энэ нь шүүх хуралдаан хойшлогдсон хэрэг биш бөгөөд зүгээр л аргагүйн эрхэнд завсарласан хэрэг байлаа. Иймээс ч дуугүйхэн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ.

Нэг цаг өнгөрөв. Шүүгч энэ хооронд хоёр ороомг навчин тамхиа татаж, зэгсэн олон жүнз коньяк уулаа. Шүүгч, прокурор, өмгөөлөгчид, тангарагтан нар болон явгаар ирсэн үзэгчидтэй энэ тэрийг ярилцана. Ярианы сэдэв гаргах гэж зүдрэх юм байсангүй. Саявтар бий болсон битүүлэг явдлын тухай бүтэн цаг бүү хэл, бүтэн үеийн турш я ярилцаж болохоор ажээ.

Тэнд байсан улс уг битүүлэг хэргийн учрыг олон гэж хөөцөлдөөд явчихсан улсын буцаж ирэхийг тэсч ядан хүлээж байв. Тэдний дотор хоёр дахь явдлыг мэдэхгүй ч гэлээ, нэг дэх явдлыг тайлбарлаад өгөхөөр хүнбайсан нь хэрэгтэн өөрөө байжээ. Түүнд бололцоо олгомогц л яриагаа үргэлжлүүлэх болно.

Харин одоохондоо шүүгчийн тушаал, өмгөөлөгчийн зөвлөснөөр дуугүй л байв.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа хөөцөлдөөнд оролцогчид буцаж ирэв. Тэгэхдээ бөөнөөрөө бус цувж ирцгээжээ.

Бүгд л адилхан юм ярина. Тэдний хэн нь ч урьд мэдэгдэж байсан юман дээр нэмээдхэлчихээр, морь унасан толгойгүй хүнд дөхөж ойртож чадсангүй. Түүний нууц ийнхүү тайлагдаагүй хэвээр үлдэв. Удалгүй нөгөө хөөсөн хүмүүсээс хочр нь эргэж ирээгүй нь мэдэгдлээ. Энэ нь өвгөн анчин, халагдсан ахмад хоёр байв. Тэд бусдаасаа хол түрүүлэн давхижээ. Тэд хөөсөөр л байгаа юм болов уу? Хичээж байгаад бариад авсан ч байж болохл юм.

Тэд морь унсан толгойгүй хүн баригдана гэж найдан, зөвхөн түүний нууц ил болохоор барахгүй, ямар нэг хэмжээгээр хүн амины хэргийн нууц ч сөхөгдөж магадгүй хэмээн итгэцгээжээ.

Бүгд л тал нутгийн зүг ширтэн харцгааж байв. Бүгдээрээ л хөөцөлдөөнд оролцогчдын дотроос хамгийн шаргуу цхочр хүнийг яаж мэдэхэв, морь унасан толгойгүй хүнийг дагуулаад ч юмуу гараад ирнэ гэж найдаж байлаа. Нэг цаг өнгөрөв. Гэтэл тэд нөгөө удтал хүлээсэн олзлогдогчийг дагуулж ирэх нь бүү хэл, өөрсдөө ч үзэгдсэнгүй.

Шүүхийн хуралдааныг цаашид хойшуулаад байх уу гэдэг асуудал гарч ирлээ.

Прокурор хуралдааныг үргэлжлүүлэх гэж зүтгэж байв. Өмгөөлөгч түүнээс дутгуугүйгээр зүтгэн чухал гэрч Зеб Стмупын өчгийг гүйцэд аваагүй байгааг харгалзан хуралдааныг маргааш болтол хойшлуулъя гэж шаардлаа. Хуралдааныг үргэлжлүүлэхийг шаардсан дуу ч гарав.

Орилоо амьтад санасандаа хүрчээ. гэрчийн оролцоогүйгээр явуулж байж болохоор учир шүүхийн хуралдааныг сэргээн явуулахаар шийдлээ. Тэр хүн зохих цагт амжаад ирж ч болох юм. Ирж амждаггүй юм гэхэд шүүхийн хурлын ажиллагааны төгсгөлийгхойшлуулахад хождохгүй.

Шүүгч ингэж шийджээ. Тангарагтан нар түүнийг дэмжив. Цугласна олон ч дэмжжээ.

Хэрэгтнийг дахин дуудлаа. Тэр нь гэнэт тасалдсан өчгөө үргэлжлүүлээ.

Өмгөөлөгч нь Морим Жеральдад хандан

-Та юу харснаа бидэнд ярихаар завдан байсан билээ. Үргэлжлүүл л дээ, бид сонсьё гэв.

-Би ногоон дээр тэрийж хэвтсэн хүнийг үзсэн юм.

-Унтаж байгаа хүнийг үү?

-Тиймээ. Мөнхийн нойроор нойрссон хүнийг.

-Үхсэн хүнийг үү?

-Үхсэнээр барах уу, би дээрээс нь өнгийгөөд толгой нь огтлогдсон байхыг харсан.

-Толгойнь огтлогдсон гэнээ?

-Тиймээ. Би өнгийж харахаасаа өмнө ажиглаагүй байж. Тэр хүн түрүүлгээ харж хэвтээд, толгой нь яг л байдаг газраа байж байсан юм. Малгай нь хүртэл толгой дээрээ байв. Ямар нэг эвгүй юм байгааг би мэдсэн. Боловч түүнийг унтаж байна гэж бодсон. Гар хөл нь мэдээ мэдрэлгүй сарвайчихсан байв. Түүнээс гадна газарт ямар нэг бараан юм байв. Би тэрий нь чухам юу болохы нь өглөөний бүдэг гэрэлд шууд ажиглаагүй юм. Бүр ойртож бөхийхдөө нэг л хачин давсархаг, хүний цусны үнэр авлаа. тэгээд өөрийнхөө өмнө хүүр хэвтэж байна гэдэгт эргэлзэхээ болив. Би хүзүүний нь дагуу цусанд барилцсан гүн шарх байхыг ажиглалаа. Дараа нь толгойгий нь огтолсныг ажиглав...

Сонсч байсан хүмүүс айн дуун тавих нь сонсдов.

-Та тэр хүнийг таньсан уу?

-Танихаар барах уу даа.

-Түүний зүс царайг хараагүй байж таньсан гэж үү?

-Надад түүний царайг харахын хэрэг байгаагүй, өмссөн хувцас нь бүхнийг тодорхой хэлээд өгч байв.

-Ямар хувцас?

-Мөрөн дээрх судалтай серапе, толгой дээрх самбреро малгай хоёр нь. Тэр нь минийх байсан юм. Хэрэв түүнээс өмнөхөн хувцсаа солиогүйсэн бол би өөрийгөө хэвэтж байна гэж бодохоор байв. Энэ бол Генри Пойндекстер байлаа.

Цугларсан олны сэтгэл үймэрсэн шивнээний хажуугаар зүрх шимшрэм дуу гарлаа.

-Ноёнтон, та нааш ярь. Өөрийнхөө илрүүлж амжсан бүхнийг ярь гэж өмгөөлөгч хэлэв.

-Би биенд нь хүрэхэд хүйтэн бүр хөшчихсөн байв. Би түүнийг хэдэн цагийн өмнө үхсэнийг ойлгов. Цус нь нөцрөн бараг хатаад өглөөний бүдэг гэрэлд хав хар харагдаж байв. Үхлийн шалтгааны талаар амархан төөрч болох бйасан бөгөөд толгойгой нь огтлохдоо алжээ гэж бодож болохоор байлаа. Гэвч шөнийн буун дууг санаад биеийн нь аль нэгтэй сумны шарх байх ёстой гэж бодлоо. Би эндүүрсэнгүй. Хүүрийг эргүүлтэл серапед нүх гарсан харагдав. Тэр нүхийг тойрон цус болжээ. Би талийгаачийн серапийг мөхөөд цээжин дээр нь хөхөвтөр хүрэн толбо байхыг үзлээ. Энд сум ьусч гэдгийг тодруулахад бэрх биш байв. Гэв ар талд нь харалдаа шарх байсангүй. Сум нэвгэрч гараагүй биед нь үлдсэн бололтой.

-Та үхлийн шалтгаан нь толгойгий нь огтолсноос бус буудуулснаас гэж бодож байна уу?

-Шарх нь эргэлзээгүй үхлийн аюултай байсан. Хэрэв тэр дороо нам үхээгүй ч гэсэн хэдэн минутын дараа магадгүй хэдэн хормын дараа үхсэн байх.

-Та толгойгий нь огтолсон байсан гэж хэлсэн. Тэр толгой ихбиенээсээ бүр салангид байсан юм уу?

-Их биедэжэ наалдаастай боловч бүр таслагдсан хэвэтж байсан. Тасалснаас хойш толгой, их биенд хэн ч хүрээгүй юмуу гэмээр санагдсан.

-Та, ямар зэвсгээр тэгж цавчсан байх гэж бодож байна?

-Сүхээр юмуу, эсвэл агнуурын хутгаар цавчсан юм шиг санагдсан.

-Хэн яагаад ийм жигшүүртэй хэргийгүйдэж болох вэ гэдэг сэжиг танд төрсөн үү?

-Би их сандарч тулгамдаад тэр үедээ юу ч бодож чадаагүй. Би нүдэндээ итгээгүй юм. Тэгээд жаахан сэхээ орсон хойно би Генри Пойндекстерын алагдсаныг ойлгосон юм. Эхлээд команчууд ингэж гэж бодлоо. Тэгсэн мөртлөө хуйх нь бүтэн, малгай нь хүртэл өмсгөөстэй хэвээр байсан.

-Ийммяагаар та индианууд үүнд оролцоогүй гэж үзэх юм биз дээ?

-Тийм.

-Та өөр ямар нэг хүнийг сэжиглэв үү?

-Тэр үедээ хэнийг ч сэжиглээгүй, Генри Пойндекстерыг дайсагнасан улс энд ч юмуу, ер нь хаана ч бий гэж хэзээ ч дуулаагүй юм. гэвч хожим надад сэжиг төрсөн. Тэр сэжиглэл одоо хүртэл миний сэтгэлээс гараагүй байна. _

-Та түүнийгээ шүүхэд ярина уу.

-Би эсэргүүцэж байна гэж прокурор хөндлөнгөөс хэлээд - хэрэгтний сэжиглэлтэй танилцах сонирхол бидэнд ерөөсөө алга. Хэрэв бид түүний үлэмж “үнэмшмээр” яриаг сонсч байгаа нь хангалттай гэж бодож байна гэв.

- Яах вэ, үргэлжлүүлэг гэж шүүгч шинэнавчин тамхи асаангаа хэлэв.

-Би үзэж харсан юмандаа сандарч тэвдээд, анхадаа яахаа ч мэдсэнгүй. Миний сонссон тэр буун дуугаар санаатайгаар алагдсан гэдэгт би итгэж байлаа. Харин хэн түүнийг буудсан байх нь вэ? Индиан нар биш гэдэгт би эргэлзэхгүй байв. Би ямар нэг тонуулч ингэв үү гэж бодсон юм. Гэвч энэ маань төдий л үнэмшмээр биш санагдсан. Миний мексик серапе бол зуун доллараас доошгүй үнэтэй. Тэгэхлээр дээрэмчин болтүүнийг мэдээжээр авсан байж таарна. Бас тэгээд нэг ч юм хөдлөөгүй, алтан цаг нь хүртэл халаасандаа, хүзүүнд нь цусанд бялдсан зүүлт нь ч байлаа. Энэ бол өшөө хонзонгоор үйлдсэн хэрэг байжээ гэж эцэст нь би дүгнэлт хийсэн юм. залуу Пойндекстер хэн нэг хүнтэй муудалцсан ч юмуу, түүдн дайсан бий гэж сонссон эсэхээ санаж гарлаа. Миний цухаан санаанд юу ч орж ирсэнгүй. Түүнээс гадна алуурчин түүний толгойг огтлох ямар хэрэг байв? Энэ л намайг юунаас ч илүү гайхалд оруулсан юм. Би хэргийн учрыг олохоо болиод юу хийх билээ гэж бодож эхлэв. Түүний дэргэд үлдэх нь ямар ч утгагүй бөгөөд тэнд нь оршуулья гэхэд нэг л эвгүй санагдлаа. Тэгээд нас барсан хүнийг Каса-Дель-Корвод аваачихын тул тусламж гуйхаар уайз руу буцаж очихоор шийдлээ. Гэвч би түүнийг ойд орхиод явбал, чоно олж аваад нөмрөг тастай нийлэн намайг буцаж очихоос өмнө зулгаачих байсан юм. Тэнгэрт аль хэдийнээ тасэргэлдэж байлаа. Харваас тэд түүнийг ажигласан бололтой. Залуугийн хүүр хэдий эвдэрч гэмтсэн ч би түүнээс нь илүү муудуулахад хүргэхийг хүссэнгүй. Нулимс гүйлгэнүүлэн түүнийг харж хайрладаг нүднийхээ тухай ч бодлоо...

ХСIV. Нууц тайлагдав

Хэрэгтэн дуугүй болов. Хэн ч түүнийг яаруулаагүй бөгөөд юу ч асуусангүй. Бүгдээрээ яриа дуусаагүй гэдгийг йолгож байсан бөгөөд тэдний сонирхлыг улам татаж байсан ярианы учгийг таслахыг хүссэнгүй. Шүүгч, тангарагтан нар, тэнд цугларсан хүн цөм хэрэгтнийг нүдсалгалгүй ширтэж, амьсгал даран чагнацгааж байв. Сүртэй нам гүмийн дунд Морис Жеральдын дуу дахин гарч

-Дараа нь хүүрийг нөмрөөтсэй байгаа серапед нь боогоод дээрээс нь цуваараа нөмөргөө гэдэг бодол орж ирлээ. Ийм аргаар ойгоос авахаар хэн нэгэн хүн дагуулан буцаж иртэлтүүнийг араатан амьтнаас хамгаалж болно гэж би найдсан юм. Тэгээд цуваа тайлтал түрүүчийнхээс ухаалаг гэж санагдсан шинэ төлөвлөгөө санаанд орлоо. Цайз руу ганцаараа буцахын ородн талийгаач залуугийн хүүрийг аваад буцъя гэж шийдэв. Эмээл дээрээ хөндлөн тавиад бугуйлаар даруулчихъя гэж бодов. Ингэх санаатай морио авчирч хүүрийг дээр нь ачих гэж байтал Генри Пойндекстерын морь ойр байхыг гэнэт харав. Морь ой ойрхон газар юу ч болоогүй юм шиг тайван идээшилж байлаа. Жолоо цулбуур нь газар чиргүүлдэх учир зрволонгүй брьаж авлаа. Морийг ялангуяа зүлгэн дээр тарайн хэвтэж байгаа эзний нь хүүрийн дэргэд аваачаад номхон байлшах л хэцүү байв. Жолоогий нь амандаа зууж байгаад залуугийн хүүрийг морин дээр гаргаж эмээл дээр нь хөндлөн тавьж дөнгөв. гэвч хэдийнээ хөшиж амжсан хүүр нугарч өгөхгүй холбироод байлаа. Түүнээс гадна аймшигтай ачаа тавьсныг үнэр авсан морь тогтож өгөхгүй байв. Би хэд дахин хий дэмий оролдоод ер яагаад ч болохгүй нь гэдгийг мэдэв. Би больдог ч юм уу гэж байтал толгойд бас нэг сайхан бодол орж ирлээ. Өмнө Америкийн гаучо нарын тухай хэзээ ч биоээ уншсанаа саналаа. Хэн нэг нь үхэх ч юмуу эсвэл талынхаа нэгтээ золгүй тохиолдлын золиос болоход нөхөр нь түүнийг амьд юм шиг эмээл дээр нь даруулж гэрт нь хүргэдгийг санав. Генри Пойндекстерын хүүрийг тэгж авч явж яагаад болдоггүй юм бэ гэж бодов. Би эхлээд талийгаачийг өөрийнх нь моринд унуулах гэж оролдож үзлээ. Гэвч эмээл нь өргөн биш морь нь тайван зогсохгүй учир дахиад л яаж ч чадсангүй. Гэрт хүргэхийн тул морьдоо солихоос өөр арга үлдсэнгүй. Миний морь муухай зан гаргахгүйгээс гадна мексик эмээл нь өргөн болохоор энэ зорилгод сайн тохирно гэдгийг би мэдэж байв. Би талийгаачийг тэр дорхиноо мордуулаад эмээлд суулгаж амжив. Түрүүн саад болоод байсан хөшсөн байдал одоо тус боллоо. Хөлий нь дөрөөлүүлж, гутлыг гарихаар нь сайтар чангалав. Ингээд бугуйлаасаа хэсгийг тасалж хүүрийг ороон даруулж нэг үзүүрий нь урьд бүүрэгнээс, нөгөөгий нь хойд бүүрэгнээс уяж авлаа. Өөр нэг хэсэг бугуйлаар дөрөөг нь савуулахгүйн тул морины гэдсэн доогуур оруулан холбов. Одоо толгойг яахав гэдгээ бодлоо. Толгойг газраас авч малгайгий нь авах гэж оролдов. Гэвч даанч авч болсонгүй. Толгой тун сүрхий хөөж малгай нь барилдан чивчирчээ. Би малгайгий нь унахгүй гэж найдаад сагалдаргааар нь уяа сүвлэн гархинд холбоод толгойг эмээлийн бүүргэнд өлгөв. Үүгээр миний цайз руу явах бэлтгэл ажил дууслаа. Цаг алдалгүй шууд талийгаачийн моринд мордон, морио араасаа дага хэмээн исгэрэв. Миний хээр ийм сургуультай. Ингээд би суурин руу хөдөллөө. Таван минут ч өнгөрөөгүй бхйтал би эмээлээсээ ховх цохигдон тэр дороо ухаан алдсан юм. хэрэв тийм байдалд ороогүйсэн бол би энд та нарын өмнө ямар чбайлаа эгсэн хэрэгтний байдалтай л зогсож байхгүйсэн билээ.

-Эмээлээс ховх цохигдсон гэнээ? Яагаад тэгсэн юм бэ? гэж шүүгч асуув.

-Энэ бол жрийн тохиолдол буюу үнэндээ миний хайхрамжгүйгээс болсон юм. Би хүний морин дээр мордоод жолоогий нь бариагүй явав. Би өөрийнхөө морийг дуу, өвдөг хоёроороо залж дадчихсан учир жолоог тоодоггүй юм. Би тийм юм болно чинээ санасангүй. Биднийг хөдөлж амжаагүй байтал нөгөө морь толгойгоо эргүүлснээ гэнэт нэг юмнаас үргэн хажуу тийш ухасхийгээд галзуу мэт давхив. “нэг юмнаас” гэдэг маань юу болохыг би сайн мэдэж байсан юм. Толгой эргүүлэнгээ хойноо хачин жигтэй хүн явж байхыг харчихжээ. Түүнээс морь бүү хэл хүн хүртэл аймаар байлгүй яахав. Би жолоогоо шүүрэн авах гэсэн боловч намайг жолоонд хүрч амжихаас өмөн морь хэдийнээ галзуу юм шиг давхиж гарлаа. Эхлээд нэг их сэтгэл зовсонгүй. Жолоогий нь татаад л зогсоочих юм бодлоо. Гэвч жолоонд хүрэх амаргүй байлаа.

Жолоо нь урагшаа унжсан учир хүрэхий тул хүзүүн дээгүүр нь бөхийх хэрэгтэй байлаа. Хазаарынхацравч дээрээс барих гэж оролдож байгаад мориныхоо хаашаа давхиж байгааг ажигласангүй. Тэгээд модны мөчир улаан нүүрэн дундуур өвдтөл ороолгоод авахад нв би цавцаал замаар биш, ширэнгэ дундуур давхиж яваагаа мэдлээ. Үүний лдараа хажуу тийшээ харах ч юмуу жолооноос шүүрэх боломж байсангүй. Бүх анхаарал маань эмээлээс ховх татчихаар сарвайсан хуайсны өргөст мөчрөөс замаа буруулахад л чиглэгдлээ. Хэдийгээр нүүр гараа өргөсөнд уруулсан боловч энэ саадтай нэлээд амжилттай тэмцэж явлаа. Гэвч нэг том модны жим таглан хөндлөн сэрвийсэн бүдүүн мөчир доогуур шургаж чадсангүй. Тэр мөчир цээжний харалдаа газар шүргэм тийм анмхан ургажээ. Морь маань өөр нэг юмнаас үргэв бололтой яг доогуур нь давхиж орлоо. Морь хаашаа давхиж одсоныг би санахгүй байна. Та нар лав үүнийг надаас илүү мэднэ байх. Би тэр модны дор өвдгөндөө том хавдартай, толгойдоо том шалбархайтай хэвтэж хоцорсноо л хэлж чадах байна.

Гэхдээ үүнийгээ хоёр цагийн дара ухаан орсон хойноо л мэдсэн юм. Би сэрээд нар дээр хөөрчихсөн, миний дээгүүр хэдэн арван нөмрөг тас эргэлдэж байхыг харлаа.

Тэдний хомхойрон хүзүүгээ сунгахыг харав. Хэнийг олзоо гэж бодож байгаа нь илт.

Энэ үзэгдэл, ам цангаж байгаа хоёр, явах тухай бодолд оруулав. Гэвч явъя гэж шийдээд хөл дээрээ бостол алхаж чадахгүй болсноо мэдлээ. Тэр ч байтугай бараг зогсч чадахгүй шахам байв. Тэр үедээ л лав байрандаа үлдэнэ гэдэг маань үхдэлтэй адилхан санагдлаа. Ийнхүү бодсондоо бүх хүчээ шавхан ус руу дөхөө гэж шийдэв. Ойрхон горхи урсч байх ёстойг санав. Заримдаа дөрвөн хөллөж, заримдаа өөрийн хийсэн таягаа тулж хөдлөх бүрдээ зовж шаналсаар эцэст нь горхинд хүрлээ. Амныхөө цангааг гаргаад хамаг бие тавигдан унтчихжээ. Сэртэл тал бүрээс чонон хүрээлчихсэн байв. Хориос цөөнгүй харагдав. Тэдний хулчгарыг мэдэх учир би эхлээд айсангүй. гэвч удалгүй энэ бодлоо өөрчлөхөд хүрэв. Тэд намайг шархдсаныг мэдчихээд сүргээрээ дайрлаа. Аз болоход надад үлдсэн ганц зэвсэг нь агнуурын хутга байлаа. Хэрэв хутгагүй байсан бол чононд хүү татуулан дуусчих байв. нэг хэсэгтээ би хутгаараа тэд нарыг айлган тав зургааг нь цааш харуулав. Ингэлээ гээд тулалдаан миний хувьд муугаар төгсөв. Цус их алдсанаасаа болж бие сулран нэг азтай учрал гарч ирээгүйсэн бол би тамирдан унахаар болж ирлээ...

Мустангер минут хяраатай яриагаа зогсоход үзэгчид чөлөөтэй амьсгалав.

Морис яриагаа үргэлжлүүлэн

-Үнэнч нохой маань намайг олж авсан юм. Тэр намаайг эрж гэрээсээ зугтсан бололтой. Хэдийгээр дараа нь өөр юм дуулсан ч гэсэн одоо түүнийг ярьж та нарыг чилээгээд яахав. Тийм ч байсан, үгүй ч байсан ч нохой яг цагаа олж намайг аврахаар ирсэн юм. Түүний ойртох чимээгээр чононууд таран зугтаж би аюултай юмнаас аврагдах нь тэр. Дараа нь би дахин унтсан ч юмуу, чухамда ухаан алдчихав. Сэхээ ороод өөрийн байдлыг бодохтойгоо боллоо. Нохой гэрээс ирэн байх ёстой бөгөөд овоохой маань хэдэн бээрийн зайтай байгааг ч, зарц Фелим маань нохойг өмнөхөн нь тийшээ аваачсаныг мэдэж байлаа. Тэгээд санамсаргүй биедээ авч явсан нэрийн хуудсан дээрээ хэдэн үг бичив. Би нохойг шуудан зөөгч болгон зарцдаа хэл хүргүүлэхээр шийдэв. Хэдийгээр зарцаа бичиг мэдэхгүй гэдгийг сайн мэдэж байсан боловч тэр миний хуудсыг хараад уг мэдээг хэнээс ирснийг йолгон уншуулчихаар хүн эрж олно гэдэгт би эргэлзсэнгүй. Цусаараа бичсэн болохоор ингэнэ гэдэгт улам ч итгэлтэй байв. Гээгдүүлж үрэгдүүлэхгүй гэсэндээ малгайны дотроос урж авсан хэсэгт

зурвасаа боогоод Тарагийн хүзүүнд уялаа. Нохойг өөрөөсөө салгаж явуулах хамгийн хэцүү нь байлаа. Эцсийн эцэст нэг юм явж гэртээ очно гэдэгт би итгэж байв. Миний зурвас зохих газартаа хүрсэн байжээ. Үнэндээ би үүингй өчигдөр л мэдсэн юм. Нохойг явснаас хойш би дахин дуг хийгээд сэрэхдээ аймшигтай араатан өмнөө байгааг харав. Энэ нь цоохор бар байв. Бид хоёр тулалдах нь тулалдсан. Гэвч яаж төгссөнийг болон аль зэрэг удсаныг би хэлж чадахгүй байна. үүний тухай миний зоригт аврагч Зеб Стумп та нарт ярьж өгэж. Тэр одоохон буцан ирж та нарт бүгдийн тухай, түүнчлэн миний та нарас илүүгүй мэдэж байгаа олон юмыг ярьж өгнө гэдэгт би итгэж байна. Түүнээс хойш надад санах юм юу ч алга. хар даран, хааяа нэг гайгүй, юм зүүдэлж байсаар зөвхөн уржигдар л ухаан ороод шоронд байгаагаа, хүн амины хэрэгт яллагдаад байгаагаа мэдлээ... Ноёд тангарагтан нар аа, надад өөр нэмж хэлэх юм алга.

Хэрэгтэн яриагаа дуусгахад шүүгч, тангарагтан, үзэгчид “хэрэв үнэн биш гэхэд сайн л бодож олсон байна” гэж дотроо бодов.

Олон хүн хэрэгтэнд итгэн зохиомол зүйл гэсэн бодлоо таягдан хаяв. Ийм энгийн тодорхой яриаг дөнгөж чичрэг өвчнөөс салаад байгаа хүн бодож олж чадахгүй. Ийм түүхийг бодож олногөж яагаад ч баймгүй хэмээн ихэнх нь боджээ.

Хэрэгтний өөрийн өчиг хамгийн ам хэл хурц өмгөөлөгчийн үгээс ч илүү түүнийг цагаатгаж байлаа. Гэвч яалтай ч гэсэн энэ бол зөвхөн үгэн өчиг юм. Түүнийг цагаатгахын тулд бас гэрчийн хэлснийг нотолсон мэдүүлэг хэрэгтэй байв. Тийм олон зүйлийг хэлэх тэр гэрч нь хаана байна? Зеб Стумп хаана байна?

Мянган нүд тэнгэрийн хаяаг ширтэнэ. Таван зуун хүн өвгөн анчныг Кассий Колхаунтай ч юмуу эсвэл түүнгүйгээр, морь унасан толгойгүй хүнтэй ч юмуу, үгүй ч юмуу хамаагүй ирээсэй гэж тэсч ядан хүлээж байв. Учир нь морь унасан толгойгүй хүн одоо оньсого байхаа больжээ. Энд байгаа хүмүүс морь унасан толгойгүй хүний тэнэхэд болохгүй юм юу ч алга гэдгийг мэдэж байв. Льян-Эстакадотой хиллэдэг, тунгалаг уст Леон гол эх авдаг. Рио-Де-Нуэсес гол олоон зуун горхийг өөртөө нэгтгэдэг. Энэхүү баруун өмнөд Техасын оршин суугчид бол ялзрах нь үхлийн зайлшгүй дагуул болдоггүй нутгийн хүмүүс байлаа. Энд

буудуулсан буга чюмуу, талд үхсэн морь, хэрэв л элдэв амьтанд тасдуулчихгүй бол эсвэл газарт булж оршуулаагүй хүний хүүр байлаа гэхэд дөчин найман цагийн дараа л египетийн занданшуулсан хүүртэй адилхан болдог ажээ.

Техасын уур амьсгалын сайхь онцлогийг мэдэхгүй хүн цугларагсад дотор цөөхөн байлаа.

Хэрэв морь унасан толгойгүй хүнийг царсны дор аваад ирдэгюмаа гэхэд Генри Пойндекстерын хүүрэнд ялзарсны ямар ч тэмдэг мэдэгдэхгүй байхад хэн ч гайхахгүй байлаа.

Тэдний тэсч ядаад байгаа нь өөрийн учиртай байв. Тэд шүүх ажиллагааны эхнээс л сэжиг төрөн улам лавширсаар эцсийн эцэст итгэл төржээ.

Бараг хүн бүр мэдүүлэг нь хэрэгтэнг эрх чөлөө юмуу, дүүжлүүрт хүргэх ёстой гэрчийн яриаг сонсохыг хүснэ.

Бүгдээрээ л номин хөх тэнгэрийн хаяа, ширэнгэ ойн оюун ногоон өнгөтэй нийлэн ууссан тэр зүг хүч тавин ширтэж байгаагийн учир энэ ажээ.

ХСV. Сүүлчийн гэрч

Нам гүм чимээгүйн дунд бүтэн арван минутын турш байжядан хүлээцгээв.

Хааяа нэг хэн нэгний нь халаглах дуу л нам гүмийг эвдэнэ. Аль нэгэнд нь байсгээд л тэртээ алсаас ямар нэг бүртгэр юм үзэгдэх шиг санагдана. Тэгэхэд нь олны дотор шуугилдах сонсдож цөмөөрөө л сайн харах гэж өлмий дээрээ өндийнө. Гурван ч удаа худлаа түгшин үймэлдэ.в Хүмүүсийн тэсвэр алдагдан байтал дөрөв дэх удаагаа түрүү түрүүчийнхээс илүү баг итгэлтэйгээр дуу алдах сонсоглоо. Тэндээс тэнгэрийн хаяанд бараан цэг үзэгдэн төдхөн хөдөлж яваа дүрс гэдэг нь ялгарав.

Гурван морьтон талын наранд улайсан униар дундаас тодрон ойртож ирэхэд царсны ёроолд хуран цугларсан улсын дунд баясгалант “Ура” цууриатав.

Тэр гурвын хоёрыг нь танихадтүвэггүй байв. Энэ бол Зеб Стумп, Кассий Колхаун хоёр байлаа. Гурав дахийг нь ч таньж ядаад байх юм байсангүй. Харин дүрсээр нь таньжээ.

Хоёр морьтныг буцаж ирсэнд баяр хүргэсэн дуу шууны дараа ийм удаан нууц, битүүлэг бодол, элдэв цуурхлын бай болж агсан тэдний дагуулыг хараад улам ч дуу шуутай орилолдов.

Хэдийгээр түүнийг тойрсон нууц ил болсон ч түүнээс айхгүй байхын аргагүй.

Бөөн дуу шуу болсноо дахин наам гүм болов. Тэднийг бүр дөхөж иртэл хэн ч дуугаралгүй байснаа тулаад ирмэгц бодол санаагаа чангаар илэрхийлж чадахаа байчихаа юу гэлтэй айсан юм шиг шивнэлдэж эхлэв.

Олон хүн тэдэн рүү ханаран гүйлдэж, гайхсан харцаар цаср хүртэл дагулан харцгаана. Гурван морьтныг хүмүүсийн дэргэд зогсоход тал бүрээс нь бүчин авлаа.

Хоёр нь мориноосоо бууж, гурав дахь нь морин дээрээ үлдэв. Колхаун морио хажуу тийш аваачаад олны дундуур алга болов. Түүний тэнд байгаг одоо хэн ч сонирхохоо больжээ. Бүх харц, бүх бодол морь унасан толгойгүй хүнрүү чиглэгджээ.

Зеб Стумп хөгшин гүүгээ орхиж, толгойгүй хүний морийг зуузайдаж аваад, сүүдэрт нь шүүхийн хуралдаан хийж байгаа царс руу амьгүй эзэнтэй нь хамт аваачив.

-За, шүүгч, тангарагтан арван хоёр нөхдөө, энэ муухай хэргийг нэгэн тийш болгож магадгүй гэрч энэ байна. Үүнээс асууцгаа гэж анч өвгөн тайван захирангуйгаар хэллээ.

“Бурхан минь, тэр маань энэ байна” гэж орилох сонсогдоод өндөр өвгөн гуйвлан урагш гарч, морь унасан толгойгүй хүний дэргэд очив.

Энэ бол эцэг нь байлаа.

Тэртээгээс эмэгтэй хүн ухаан балартаж ойчив уу гэлтэй бачимдан гинших дуугарав. Энэ бол эгч нь байлаа.

Вудли Пойндекстерыг хажуу тийш нь аваачив. Тэр хүн эсэргүүцэхгүй, харваас орчин тойрондоо юу болж байгааг ч ухаарахгүй байгаа бололтой. Түүнийг сүүс тэргэнд аваачиж охинтой нь хамт суулгав.

Гэвч сүүх тэрэг байрнаасаа хөдөлсөнгүй. Луиза Пойндекстер өөрөө морьдоо жолоодож яваа бөгөөд шүүхийн ажиллагаа төгстөл, тогтоол гартал, бүр муугаар төгсдөг юмаа гэхэд цаазлах хүртэл тэндээс явахгүй байлаа.

Гэрчийн байраа эзлэхийг өвгөн анчнаас хүслээ.

Шүүгчийн зөвшөөрснөөр өмгөөлөгч асуулт тавих болов.

Элдэв ёс журамгүйтэх юм байсангүй. Аль хэдийнээ ам тангаргаа өгчихсөн учир түүнээс зөвхөн энэ хэргийн талаар юу мэддэгээ ярихыг хүслээ.

-Би Генри Пойндекстерыг алга болсны маргааш энэ өөдгүй хэгийн тухай анх сонссон юм. намайг ангаас буцаж ирэнгүүт энэ талаар хэлсэн юм. Мустангер хүн алсан хэрэгт холбогдсон гэдгийг дуулав. Морис Жеральд тийм хэрэг хийхгүй гэлгийг би мэдэх учир түүнтэй уулзахаар явлаа. Гэрт нь зөвхөн түүний зарц Фелим ганцаараа байв. Хөөрхий эр янз бүрийн юмнаас сүнсээ гартал айчихсан байсан бөгөөд түүний надад ярьсан зүйлээс би бараг юу ч ойлгож авч чадсангүй. Гэтэл биднийг ярилцаж байх хооронд нохой нь гүйж ирлээ. Нохойны хүзүүнд ямар нэг юм уяастай байсан нь мустангерын нэрийн хуудас байв. Түүн дээр улаан бэх гэмээр шууд цусаар бичсэн үг харагдав. Үүнийг уншсан хүн залууг хаанаас олж болохыг заасан ажээ. Би Фелим, нохой хоёрыг аваав тийүүэ явлаа. Бид мексикчүүпийн бар гэж нэрлэдэг цоохор амьтны савраас мустангерыг яг эгзэгтэй үед нь очиж аварсан юм. Залуу ирланд түүнийг цоохор бар гэж нэрлэж байхыг би сонссон юм байна. Би тэр цоохор муурыг буудаж дорхон нь цааш харуулав. За тэгээд бид мустангерыг овоохойд нь аваачлаа. Өөрөөр алхах ч тэнхээгүй учир түүнийг дамнуурга маягийн юман дээр авч явсан. Бас залуугийн тархи толгой муудчихаад, хавар цагийн цацагт хяруулаас дээргүй байлаа. Тэгээд өөрийг нь эрж явсан бүлэг хүмүүсийг очтол гэртээ хэвтэж байсан юм...

Гэрч мустангерын овоохойд болсон бүх явдлыг ярих эсэхээ бодож түр дуугүй болов. Тэр бүхний тухай чимээгүй байсан нь дээр юмуу гэж бодоод түүгээрээ болов.

Харин энэнь прокурорт таалагдаагүй бололтой шалгааж гарлаа.

Эцсийн эцэст Зеб, Морис Жеральдыг сахилгын шоронд хорих хүртэл юу болсныг ярихаас өөр аргагүй болов.

Зеб өөрийг нь байцааж дууссаны дараа за тэгээд та нар энэ хачин хэргийн талаар мийн юу мэдэх бүхнийг хэлүүллээ. Харин хэний чинь ч толгойд нэг юм асуух санаа орсонгүй. тэгэхээр би өөрөө л нэмэж ярихаас биш Гэв.

-Стумп гуай ярь гэж Снн-Антониос ирсэн өмгөөлөгч дуугарав.

-Тэгэхээр ийм байна. Миний одоо ярих зүйл бол хэрэгтэн хүнд хамаарахаас илүү, түүний

байрыг эзэлбэл зохих тэр хүнд хамаарах юм. Би одоо түүний нэрийг хэлэхгүй. Зөвхөн өөрийнхөө мэдсэн зүйлийг хэлье. Тангарагтан та нар бусды нь тааварлах юм байгаа биз гэв.

Анч өвгөн ярихаа хэсэг зуур зогсоод дэлгэрэнгүй үг хэлэх гэж байгаа юм шиг амьсгаа аван бэлтгэв. Хэн ч түүнд саад болон шавуудах гэсэнгүй. Цөмөөрөнд нь өвгөн хүн амины хэргийн нууцыг нээх юм шиг санагджээ. Морь унасан толгойгүй хүн аль хэдийн нууц биш болсон байв.

-За тэгээд, эрхмүүдээ би сонссон бүгдээсээ, гол нь нүдээрээ үзсэнээсээ хойш залуу Генри Пойндекстер амь үрэгдсэнийг ойлгосон юм. мөнэнэ бузар хэргийг мустангер Морис Жеральд үйлдээгүй гэдгийг би багтай мэдлээ. Тэгэхээр хэн үйлдсэн байх нь вэ? Энэ л асуудал та нарын дотроос олон хүнийг зовоосон шиг намайг зовоож байв. Ирланд залуу буруугүй гэдэгт эргэлзэхээ болиод би хамаг үнэнийг олохоор шийдлээ. Олон юм түүний эсрэг байсныг, чөтгөр ав, би үгүйсгэхгүй. Тэглээ ч гэсэн намайг итгүүлж чадаагүй юм. Би өөрөө тал нутагт мөр хайхаар шийдсэн билээ. Тийшээ очиж, эргэсэн морины мөрийг олно гэдгийг мэдэж байв. Гэвч чөтгөрт алгадуулмар тэнд тал бүрээс ирсэн олон морьдын мөр байв. Хэрэв тиймгүй байсан бол бүх юм амархан бүтчих байлаа. Ялангуяа нэг морины мөрийг би их сонирхов. Ертөнцийн хязгаар хүрсэн ч мөрдөөд байдаг хэрэг гэж шийдэв. Энэ бол тахтай, америк морины мөр байсан. Тахны нь нэг хугарчээ. Тэр тах энэ байна гэв.

Гэрч хүрэмнийхээ гүнзгий халаас руу гараа хийж тэндээс хугархай тах гаргаж ирэв.

Тэгээд шүүгч, тангарагтан, бүх хүмүүст харагдахаар дээш нь өргөв.

-Тэгэхээр эрхэм шүүгч, тангарагтан нараа, хүн амины хэрэг гарсан яг тэр шөнө хугархай тахтай морь тал нутаг дундуух давхиж явжээ. Тэр морь, алагдсан Генри болоод бас хүн амины хэргээр энд яллагдаж байгаа тэр хүний морины мөрөөр явсан байлаа. Морь тэдний араас явж байгаад хэрэг гарсан газраас холгүйхэн зогссон байв. Харин эзэн нь цааш явгаланнөгөө цусан шалбааг байсан газар хүрчээ. Тэр цэс урсгасан хэрэг бол энэ хүний гараар үйлдэгдсэн хэрэг мөн. Яргачин хугархай тахтай мориор явсан байв...

-Цааш нь ярь Стумп гуай. Та үүгээр юу хэлэх гэж байгаагаа тайлбарла гэж шүүгч хэлэв.

-Би ингэж хэлэх гэсэн юм. Миний ярьж байгаа хүн ширэнгэ дотор нуугдаад тэндээс бууджээ. Тэр суманд залуу Пойндекстер амь үрэгдсэн байна.

-Ямар хүн? Тэр чинь хэн бэ? Нэрий нь хэл! Нэрий нь! Гэж хориод хүн зэрэг хашгирав.

-Та бүхэн түүний нэрийг тэндээс олно байх.

-Хаанаас?

-Энэ толгойгүй хүний биенээс. Ийшээ хар л даа гэж гэрч хүүрийг зааж хэлээд үгээ үргэлжлүүлж, - Серапе дээрх цусны толбыг харж байна уу? Тэр толбоны дунд нүх байгааг хар. Харин ар талд нь тийм нүх алга байна. Тэгэхээр сум биед нь тогтчихож гэж би бодож байна. Аль вэ тайлаад үзье гэв.

Хэн ч татгалзсангүй. Тэнд байсан улсын дундаас хоёр гурван хүн урагш гарч ирлээ. Тэдний нэг Сем Мэнли байв. Тэд хүүрнээс серапег болгоомжтой тайлав.

Эргэн тойрон чив чимээгүй болж шивэгнэх дуу ч гарахгүй байв. зөвхөн серапег тайлсны дараа шивнэлдэх дуу гарав. Цээжний орчим нугалаастай хөх цамц хүртэл товчлогдсон ажээ. Мөн оёдлоо дагасан арай тодзураастай тийм өнгийн өмд өвдөгцөө хүртэл харагдана. Цоохор арьсан гуталтай байлаа.

Морины дэлээр сүлжсэн дээсээрбиеийг хоёр ч удаа ороон, үзүүрийг нь эмээлийн бүүрэгт бөхөлсөн байв. Үүний ачаар үхдэл сууж яваа маягтай тогтжээ. Мөн тийм маягаар дөрөөтэй, олом шигээр морины гэдсэн доогуур оруулж даруулсан байна.

Бүх юм хэрэгтний ярьснаар боловч зөвхөн толгой нь байсангүй.

Тэр хаана байна вэ?

Хэн ч үүнийг асуухыг зүрхэлсэнгүй. Зеб Стумпын ярихыг чагнан бүгд л хүүрийг анхааралтай ширтэнэ.

Хүүр хоёр газраар буудагдсаны нэг нь зүрхний дээд талд, нөгөө нь хэвлийн хөндийн дээр цээжинд туссан байв.

Бүгд л доод талын шархыг ширтэнэ. Сумны нүхийг тойроод цус болсноос гадна цамцны нь нимгэн эд цусаар будагдсан байлаа.

Дээд талынх нь шарх гэмээргүй, зөвхөн цамцанд нь жижиг нүх гарсан бөгөөд ямар ч цус байсангүй.

-Энэ хамаагүй гэж Зеб дээрх нүхийг зааж хэлээд - Та нар энд цус байхгүй байгааг хар. Энэ бол сум, үхсэн хойно л үхдэлийг нүхэлснийг гэрчилж байна. Энэ бол мустангерын овоохойны тэндээс ганганд миний буудсан сум. Харин хоёр дахь нь бол өөр хэрэг. Энэ бол үхлийн шалтгаан болсон шарх юм. Хэрэв би андуураагүй бол сумыг та нар эндээс олно гэдэгт итгэж байна. Огтлоод сайн үзэх хэрэгтэй гэв.

Өвгөн анчны саналыг хэн ч татгалзсангүй. харин бүр шүүгч өөрөө сумыг олон тушаал гаргав. Нөгөө дээсийг тайлан гутлы нь сугалж үхдэлийг эмээлээс буулгалаа.

Хүүр их хатууран хөшжээ. Гар хөл нь бүр хөдлөхөө больсон байв. гэлээ ч хатчихсан юмуу гэлтэй хачин хөнгөн, занданшуулсан хүүрний дайтай ажээ!?! Нас барсан залуугийн биеийг газарт их болгоомжтой тавилаа. Сэм Мэнли ерөнхий мэс засалчийн үүрэг гүйцэтгэв. Шүүгчийн заавраар нөгөө цус бялдсан шархыг ойруулан хагалав. Зүүн талын уушгинд нөгөө эрж яваа нь байв. Анчны хурц хутга ямар нэг хатуу юманд тулав. Хорголжин сум байлаа!

Хагалгааг хавиргаар нь уушгинд хийжээ.

Сумыг авч арчаад тангарагтан нарт өгөв.

Хэдийгээр бууны бянтанд зурагдан, хавирга цөм цохихдоо шамшийсан боловч түүн дээр тал сар болон “АКК” гэсэн үгсийг харж болохоор байв. Энэ гурван үсэг ямар их вч өгүүлнэ вэ! түүнийг харж байгаа хүмүүсийндотроос ч зарим нь энэ үгийг урьд нь дуулснаа санав. Нөгөө цоохор бар агнахад хэн ийм тэмдэгтэй сумаар гайхуулж байсныг тэд гэрчилж чадахаар байлаа.

Тэр үед тийнхүү гайхуулж байсан хүн одоо түүнээ харамсч суухаас өөр арга байсангүй.

Гэвч тэр хүн хаана байна?

Энэ асуултыг цугласна олны дотор тавьж эхэллээ.

-Мистер Стумп, та үүнийг юу гэж хэлмээр байна? гэж өмгөөлөгч асуув.

-Энд яриад байх юу байхав энгийн зүйл! Энэ сум залуу эрийг алжээ гэдэг нь ямар ч нусгай журд өдөр шиг илхэн байх ёстой.

-Гэвч та хэн буудсан гэж бодож байна?

-Энэ бол бас л ойлгомжтой хэрэг. Хүн захиан дээрээ нэрээ бичсэн байхад хэн түүнийг явуулаа вэ гэдгийг хэн ч андуурдаггүй шүү дээ. үнэндээ энд гуравхан үсэг байгаа боловч таахад хэцүү биш. Хэнийх болохоо хэлэд өгч байна гэв.

-Би энд гой гойд юм алга гэж бодож байна хэмээн прокурорын хажуугаас ярианд оролцоод - Тэмдэгтэй сум байгаа нь үнэн. Түүн дээрэндхийн нэгэн хүндтэй хүнд нэг бол холбогдож болох, эсвэл холбогдохгүй ч байж мэдэх үсэг байна л даа. Тэр бүү хэл тэр гурван үсэг, тэр сум уг хүнийх юм гэж бодъё. Гэлээ ч энэ юуг ч нотлохгүй. хулгайн буугаар хүн алах явдал бол жирийн явдал. Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Түүнээс гадна таны сэжиглээд байгаа тэр хүн ийм хэрэг яагаад үйлдэх хэрэгтэй байв? Энэ хэний нэрний эхний үсэг болохыг бид цөм мэдэж байна. Тэр хүн ч гэсэн үүнийг өөрийн овог нэрийн толгойн үсэг мөн гэдгийг нуухгүй гэж би итгэж байна. Гэлээ ч энэ маань хараахан юуг ч нотлохгүй. Түүний нэрийг энэ гэмт хэрэгтэй холбочихоор өөр баримт алга гэв.

-Та тэгж бодож байна уу? гэж прокурорын ярьж дуусахыг тэсэн ядан хүлээж байсан Зеб Стумп асуугаад - Харин та үүнийгюу гэхсэн бол? гээд хавтаганаасаа зах нь түлэгдэж, тортогтсон хэсэг цаас гаргаж ирэн - Би үүнийг хүн амины хэрэг гарсан газрын хажуу дахь ширэнгэ дотроос олсон юм гэж анч өвгөн цаасыг тангарагтан нарт өгөнгөө хэлээд - Хуайсны өргөсөнд торж байсан юм. Нөгөө буудсан бууны амнаас л хийсэн тэнд өлгөгджээ. Миний ойлгож байгаагаар бол жийргэвчний оронд хэрэглэсэн дугтуйны хэсэг байгаа юм. Нөгөө суман дээр байгаа эхний гурван үсэгний нэр бүтнээрээ байгаа нь л сонин юм. Эрхэм тангарагтан нар өөрсдөө уншина биз ээ гэв.

Тангарагтны алхагч цаасыг авч дэлгээд “Ахмад Кассий Колхаунд” гэж чангаар уншлаа.

ХСVI. Зугадлаа!

Энэ нэрийг сонгосон нь шүүхийн гишүүдийн дунд гайхаштөрүүлэв. Түүнтэй нэг зэрэг цуглагагсдын дунд ч орилолдох дуу гарав. Энэ бол гайхсан дуу биш байв! Биш ээ, ээн бол илүү их юм хэлсэн дуу байлаа. Энэ бол хэрэгтнийг цагаатгаж, бүр яллагчдын дотроос хамгийн идэвхтэй яллагч байсан хүнийг ялласан дуу байв.

Зеб Стумпын мэдүүлэг Колхауны буруутайг бүрэн нотоллоо. Гэвч түүнээс өмнө бүгд түүнийг сэжиглэн, баримт нотолгоо сөхөгдөх тусам сэжиг нь нэмэгджээ. Одоо бол Морис Жеральд буруугүй, Генри Пойндекстерыг алсан хэрэгт түүнийг шүүх ёсгүй гэдэгт хэн ч эргэлзэхээ больжээ.

Түүнчлэн цөмөөрөө Золхаун хүн алсан этгээд гэдэгт итгэж байв. Гэрч баримтын гинжний сүүлчийн гогцоо нь тэр түлэгдсэн хэсэгхэн цаас байлаа. Хэдийгээр энэнь шууд бус баримт ч гэлээ хүн амины хэрэгт чухам юу хүргэв гэдэг нь нууц хэвээр үлдсэн ч гэлээ хэн гэмт хэргийг хийв гэдэгт эргэлзэх хүн байсангүй.

Тангарагтан нар цөм дугтуйг дамжуулан үзсэний дараа, гэрч бүх юмаа хэлээгүй байна гэсэн учир дахин үг хэлүүллээ. Өвгөн тал нутаг дундуур мөр эрэхэд хүргэсэн сэжиг төрсөн тухайгаа, Колхаун төглөөс буудсан тухай дараа нь морь унасан толгойгүй хүнийг хөөсөн болон морины солио хийсэн тухай ярив. Эцэст нь морь унасан толгойгүй хүнийг барьж авахад болсон явдлын тухай тодорхой дурдлаа.

Үүний дараа хариу хүлээх мэт амсхийв.

Цугласан хүмүүс шүүхийн гишүүд зөвлөлдөхийг хүлээхийг ч хүссэнгүй.

Ингэж цаг алдах нь үнэн мөний шүүх, өөрсөдтэй нь хамт золтой л хууртагтдах дөхсөний гэрч болсон хүмүүст таалагдахгүйгээр барахгүй, одоо эвгүй сэтгэл гаргаснаа мэдрэх, өндөр дуугаар:

-Ирландыг сулла, тэр ямар ч буруугүй! Бидэнд өөр баримт нотолгоо

хэрэггүй! Цөм тодорхой боллоо! Түүнийг тавь! Гэж орилолдов.

Үүнээс дутамгүй шаардлагатай өөр дуу ч гарч:

-Кассий Колхауныг барь! Түүнийг шүүхэд шилжүүл! гэмт хэрэг үйлдсэн этгээд чинь тэр мөн! Тийм учраас л мустангерыг гүтгэж байж! Хэрэв тэр буруугүй бол түүнийгээ нотолж болно. Түүнийг үнэн мөнөөр шүүх боловч гарцаагүй шүүж таарна. Шүүгчээ, таны хэлэхийг сонсьё. Колхауныг ялтны ширээнд суулгах тушаал өгөөч! Буруугүй хүний оронд гэм хийсэн нь суудлаа эзлэг! Гэцгээв. Эхлээд хэдхэн хүн орилолдож байснаа сүүлдээ цуглагагсад цөмөөрөө орилолдоо.

Шүүгч олонхийн шаардлагаас зөрж зүрхэлсэнгүй, тогтоолын журмыг зөрчин Колхауныг шүүхэд дуудав.

Шүүхийн зарлага түүний нэрийг гурав дахин огцом дуудлаа. Хариу алга. Цөм ахмадыг нүдээрээ хайж эхлэв.

Зөвхөн Зеб Стумп л зөв зүг рүү харжээ.

Анчин хээр морьтой хамт зогсч байсан хөгшин гүү рүүгээ гүйв. Тэнд байсан бүр хүний гайхшийг төрүүлэм шалмагаар анч өвгөн мориндоо харайж мордоод царснаас холдож одов.

Түүний зэрэгцээгээртэртээ уяатай байсан морьдын дундпуур хэн нэг хүн явж байгааг цөм харлаа. Тэр хүн өөрийгөө харагдчих вий гэж айсан мэт тун болгоомжтой хөдлөх боловч их түргэнээр зохих газраа хүрч яваа бололтой.

-Өнөөх чинь! Колхаун тэр байна!... гэж хэн нэг нь орилов.

-Зугтах гэж байна шүү! гэж өөр нэг нь хашгирав.

-Түүнийг бариад ав! Барьж аваад нааш нь авчир! гэсэн ширүүн захирангуй өнгийн шүүчгийн дуу тасхийв.

Тушаалаа давтах хэрэг байсангүй! Үгээ хэлж дуусаагүй байхад нь арваад хүн морьд руугаа ухасхийв.

Колхаун захад байсан бор мустангийнхаа дэргэд хэдийнээ хүчрээ. Энэ нь саявтархан морь унасан толгойгүй хүнийг хөөж явсан нөгөө мустанг байлаа. Эмээл хазаартай хэвээрэ ажээ.

Колхаун модны дор үймэлдэн болж түүний хажуугаар орилолдохыг сонсоод харагдсанаа ойлгожээ.

Одоо нуугдаад айхын хэрэггүй учир морин дээрээ үсрэн мордов. Тэгээд эргэж муухай хялалзсанаа тал руу давхилаа. “Түүнийг амьд үхсэн алин боловч барьж ир!” гэсэнд зоригжсон тавин морьтой хүн түүний хойноос давхилаа. Үүнийг хошууч хэлсэн бололтой.

Гэвч хэн хэлсэн нь хамаагүй юм биш үү? Тэр хүмүүст ямар ч албан ёсны тушаал хэрэггүй байлаа. Тэд ялт хэргийг жигшин дургүйцэж, хүндэлж хайрлаж явсан Генри Пойндекстерын өшөөг авахыг хүсч байлаа.

Ахмад амьдралдаа ийм аюулд орж явсангүй, Буэнэ-Вистын дэргэдэх цус бялдсан тулааны талбарт ч, Обордоферын бааранд мустангер түүний чамархайдбуу тулгачихсан байхад ч ийм аюул байсангүй.

Ахмад үүнээ мэдээд ч морио аль байдгаар нь давиран хааяа нэг ар тийшээ хорсолтойгоор хялалзаж явав.

Гэвч түүний нүдэнд цөхөрсний шинж байсангүй. Араас нь хөөж яваа өшөө авагчид найдвары нь таслаагүй байлаа. Тэр найдсаар явав. Тэр хурдан хөлөг унаснаа, өмнө нь ой байгааг мэдэж байлаа.

Үнэндээ аравхан бээр. Арван бээр гэдэг юу гэсэн үг вэ. тэр цагт хорин бээр давхиж байгаа учир хагас цагийн дараа л ширэнгэнд орчихно.

Түүнд энэ санаа зориг орууллаа гэж үү?

Юу л бол. Тэр ширэнгэнд ороод нуугдаж чадахгүйгээ мэдэж байв. Хөөж яваа улсуудын дунд Зеб Стумп тэргүүтэй дор хаяхад арван мөрч яваа билээ.

Тэгвэл түүнийг цөхрөлөөс аварч болох зүйл юу байна? Тэр яагаад гарцаагүй хувь заяандаа захирагдсангүй вэ?

Эсвэл өөрийгөө хамгаалах сохор зөн үү?

Огт үгүй. Генри Пойндекстерын алуурч бол солиотой хүн биш ажээ. Тэрхүү өөрт нь аюултай үнэн мөний шүүхээс зугтаахдаа тэрээр өөрийн хурданхөлт хүлгэнд ч өмнөө байгаа ширэнгэнд ч найдсангүй. ойн цаана хил гэж нэг юм бий. Түүнд л алуурч найджээ.

Чухамдаа хэлбэл тэнд хоёр хил бий. Нэг нь соёл иргэншилтэй хэмээгддэг хочр үндэстнийг тусгаарлах бөгөөд тэдний хооронд гэмт этгээдүүдийг харилцан өгөлцөнө гэжсэн гэрээ бий.

Гэлээ ч байнга тохиолдож байдгаар, алуурч хил даван үндэс угсаа, байраа солин өөрчилж шүүхийг хуурч болох л юм.

Гэвч Колхаун энэ замыг сонгосонгүй. Техас Мексик хоёрын хоорнд дээрх хэлэлцээг ор нэрийн төдий баримталдаг ч гэсэн тэр сайхь зүйлд амь дүйхээс айжээ. Түүний айдас нь ойлгомжтой. Энэ нь аймшигтай ялт хэргээр өөрийгөө шившиглэсэн хүнд дэндүү аюултай тоглоом байв.

Тэр Рио-Гранд тийш давхилаа. Гэвч Мексикийн хилийг давж, тэнд орогнох газар олохын тул биш байлаа. Харин цагаан арьстныг үзэн яддаг команчууд амьдардаг өөр нэг хилийг санажээ. Тэд түүний дайсных нь нэгний цусыг урсгачихсан болохоор нөхөр шигээ угтах болно. Алуурч индианы овоохойд толгой хоргодоод зогсохгүй, хүндлэн зочлуулж цуст хэргээ үргэлжлүүлнэгэж найдаж байв.

Ийм учраас Колхаун аврагдах найдвараа алдсангүй цөхөрч сүйд ч болсонгүй. Хэдийгээр Рио-Грандыг чиглэж байгаа авч ойд ороод Льяно-Эстакадо руу эргэнэ гэж бодож явав.

Тэр энэ аймшигт талаас айсангүй. Өмнө нь байгаа ямар ч золгүй явдал түүний араас заналхийлж байгаа аюултай зүйрлэшгүй байв. Тэр хожим нь эд хөрөнгө, хань нөхөд, боловсон нийгмийн дотрохи байр сууриа алдсандаа харамсч болох л юм. Түүнээс илүүгээр, ухаангүй дурладаг хүнээсээ дахиж бараагий нь харах ч үгүй байж магадгүйгээр салах аюул түүнийг заналхийлнэ.

Гэвч одоо үүнийг хүртэл бодох цаг байсангүй. Энэ өөдгүй эрд хар амь нь дурлалаас илүү үнэтэй ажээ. Тэр өмнө нь амьдрал хүлээж байна гэдэгт итгэж, араас нь үхэл ойртож байгааг мэдэж байлаа.

Алуурч, араб морь шиг хурдан мексик мустангийнхаа байдаг чадлаар давхиулж байв.

Бор мустанг аль хэдийнээ сульдчих болсон байлаа. Өглөөнөөс хориод бээр газрыг давхиулсан чигээр туулжээ. Гэвч сульдсаны ямар ч шинж байсангүй. Тэр нь бусад мустангийн адил хурдаа саалгүй тавь, хэрэгцээ тохиолдвол зуун бээр ч давхиж чадна.

"Морио мексик хүүхний мориор сольсон минь мөн ч азаа!" Хэрэв тэр хүүхний мустанг байгаагүйсэн бол би өдийд царсны баруун сүүдрийн дор шүүгч, тангарагтан нарын өмнө олон хүний цаазаар аваа чгэж шаардахыг сонсон зогсч байхсан" гэж Кассий Колхаун бодно.

Кассий Колхаун энэ аймшигт хувь заяанаас айхаа больж, аюул өнгөрлөө гэсэн бодлоор сэтгэлээ амраажээ. Тэр гэдрэг эргэж морьтой хүмүүс тэртээ хол хоцорсныг харав.

Ахмад урагшаа харав. Хөх ногоон өнгөт талын дээгүүр ойн зурвас бараантан харагдана. Ойд хүрээд амь насаа аврагдана гэдэгт эргэлзсэнгүй.

ХСVШ. Алуурчийн хойноос

Гэмт этгээд зугтаж амжина гэж үү? Колхауныг хар хурдаараа давхихыгхарсан олон хүн ийнхүү айжээ. Гэвч Зеб Стумп араас нь хөөхийг хараад найдвар төрөв. Тэгтэл цэргийн, энгийн нийлсэн зуугаад морьтон ухасхийн давхицгаахад найдвар нь улам л лавширлаа.

Өөр нэгэн хүн, хэдийгээр хамгийн сүүлд хөдөлсөн ч гэлээ энэ нь хурдан хөлт мустангаа унасан Морис Жеральд учир бүгдийг гүйцнэ хэмээн үзэгчид итгэж найдвар нь бүр ч итгэлтэй боллоо.

Тэр цаг алдалгүй түрүүлэхийн тулд толгойгүй хүний унаж явсан хээр мустанг руугаа очлоо.

Хээр морь эзнээ танин баярлан үүрсч өмнөөс нь хатируулсаар ирэв. Хичнээн удаан уулзаагүй ч гэлээ жинхэнэ ёсоор мэндлэлцэж байх зав байсангүй. Баярлан янцгаасны нь хариуд ганц үг хэлээд л ухасхийн мордож жолоогоо шүүрэн авлаа. Өөрт нь бугуйл байхгүй учир ойролцоо зогсч байсан хүнээс бугуйлаа түр хэрэглүүлэхийг гуйв.

Хэн нэг нь түүн рүү дугаргийлан ороосон бугуйлаа шидэнгүүт шүүрэн аваад ухасхийлээ.

Бүгд араас нь харж, хэргийн төгсгөл ямраар дуусахад эргэлзсэнгэй. Гэмт хэрэгтэн зайлж нуугдах хувтгүй ажээ. Түүнийг гүйцэн түрүүхэн нь хуурамч мэдүүлгийг ам мэдэн чалчиж байсан модных нь дор шүүхэд авчрах болно. Хуурамч мэдүүлгээр нь золтой л алуулчихаагүй тэр хүн нь барьж авах болно.

Бүгд л хээр морь талын дундуур харайлган одохыг сэтгэл түгшин харж байлаа!

Хэн нэгэн хүн мөн л талын зүг харах боловч бусадтай адилгүй ажээ. Энэ бол сүүхийн цонхоор ширтэж бөйгаа бүсгүй байлаа.

Жирийн нэг сонирхсондоо ингэж сэтгэл түгшсэнгүй. Түүний уйтгартай нүдэнд мустангерыг харахдаа баяр баясгалан төрж, зугтаагчийг харахдаа өрөвдөх сэтгэл төрж байлаа. Түүний хагас ангайсан уруулаас “Бурхан минь гэмт хэрэгтнийг нигүүлсэн өршөөгөөч” гэсэн залбирал сонсогдоно.

Жагсаалын талбай дээгүүр тархсан олон дотроос Морис ухасхийн гарахдаа сүүлдэж яваа морьтноос хэдэн зуун алхам хоцорсноо харлаа.

Гэвч үүнээс айсангүй. Хурдан хүлэг дээрээ байгаа цагт тийм удаан хоцрохгүй гэдгээ мэдэж байв.

Хээр морь чтүүний найдварыг хөсөрдүүлсэнгүй. Ойлгомжгүй ачаанаасаа салсандаа баярласан юм шиг эзнийхээ өвдөг шүргэхийг мэдэрсэн сайн морь, хүч нь урдын хэвээр

байгаагаа харуулан тал дундуур харайлгав.

Удалгүй Морис урьдаа яваа хүмүүсийг нэг нэгээр нь гүйцэж түрүүлсээр хамгийн урьд нь гарч явав. Дов толгод, зөөлөн ногоо, хурц чулуун дундуур давхисаар эцэст нь бусаднь аль түрүүн Колхауны барааг алдсантайгаа адилаар түүний барааг алдав.

Зөвхөн ганц хүн л түүний барааг алдсангүй. Тэр нь ячаж олоов гэмээр ясан хэдрэг болсон гүү унажээ. Тийм хурдан давхиж байгаагийн учир нь юундаа байна аа? Түүнийг их хачин “давируул” болох байн байн хондлой руу нь хатгах ангийн хутга л урагшлуулж байжээ. Ийнхүү зэрлэгээр морио зовоож яваа хүн нь Зеб Стумп ажээ. Гэвч хөгшин гүүд мустангтай эн зэрэгцэх хүч даанч байсангүй. Зеб үүнийг сайн мэдэж байгаа бөгөөд ганц хүсэх юм нь хээрийг хараанаасаа алдахгүй гэдэгт л байлаа.

Өөр нэг хүн байдгаараа хурдлах хээр морийг харна. Гэвч мөрөн дээгүүрээ харах бөгөөд энэ хүн бол нөгөө зулбаж яваа хүн байв.

Өөрийнхөө аврагдсанд Колхаун итгэж амжсангүй. Эргэн хараад л хээр морийг зэрэгдэглэгдсэн үхдэл биш, түүний хувьд улам ч аюултай морьтон, бүх хүчээрээ баллахыг хичээсэн нөгөө Морис мустангер унаж явааг харлаа. Энэ бол зайлж гарахын аргагүй өшөө авагч болохыш ойлгов.

Зулбагчийн бүх бие арзасхийн дагжив. Түүнд хувь заяатайгаа тэмцэлдэж байгаа тэмулийг үргэлжлүүлэх нь ямар ч утгагүй санагдав. Аврагдах итгэл алдсандаа морио давирахаа болилоо. Гэвч ширэнгэ ойрхон байгааг харж, хүч нь барагдсан морио сүүлчийн чадлаа гарган, ой руу оруулахаар давирлаа.

Өмнөнө цавцаал зам харагдана. Түүгээр хагас бээр давхиад л эргэхэд ширэнгэнд амархан нуугдаж болно.

Тэр энэ газрыг дэндүү сайн мэдлэг байв. Түүнд хэдийнээ тус болоогүй, ус болсон газар энэ удаа бас л муу юм болох болов уу?

Яг тэгэх нь! Тэр үүнийг мэдрэн тэвчээрээ бүрмөсөн алдав. Туурайн чимээ улам ойртон, түүнийг зогсохыг шаардан хашгирч байгаа мустангерын дуу сонсдов.

Тэр эргэж нуугдаж амжихгүй болжээ! Цөхрөн хашгирангуутаа мориныхоо амыг татав. Энэ нь нохойд боорлуулсан цоохор барсны хүрхрээн мэт аргаа барж, үзэн ядсан хүний орилоон байлаа. Хашгирангаа огцом хөдлөн, гал уласхийн утаа гарч огцом дуу гарав. Энэ нь гар буугаар буудсан хэрэг байв.

Гэвч сум нь зорьсон юмаа оносонгүй.

Хариуд нь нарийн саваа агаарт тасхийн, могой харвах шиг боллоо.

Колхаун түүнийг утаан дунд харж амжив.

Гохоо дахин дарах завдал болсонгүйгээр ч барахгүй, бугуйлаас нь зайлж чадсангүй.

Бугуйл мөрийн нь ороож авлаа. “Бууж өг, алуурчаан!” гэж хашгирах дуу сонсдон, хээр морь эргэхийг Колхаун харж, дараагийн агшинд цаазын индрээс ховх татагдах мэт санагджээ.

Үүнээс хойш Колхаун юу ч сонсч, харж, мэдэрсэнгүй. Эмээлээсээ ховх татагдан газар мөргөөд ухаан алджээ.

ХСVШ. Амьд байна

Алуурч газарт гулдайн хэвтэнэ. Гарт нь бугуйлын гоцгоо чивчирчээ. Тэр үхсэн юм шиг харагдана.

Гэвч мустангер энэ нь зөвхөн ухаан балартсан, яаж мэдэхэв тийм дүр үзүүлсэн хэрэг гэдгийг мэдэж байгаа учир эмээлээсээ буусангүй, бугуйлаасаа татсан хэвээр байв.

Эзнийхээ занг мэдэх хээр морь ч хөдлөхгүй зогсч гэдрэг ухрах буюу урагш ухасхийхэд хэзээд бэлэн байв. Буун дуунаар нөмрөг тас үргэн нисч, нүцгэн хүзүүгээ сунган олз хайжэргэлдэнэ.

Эмээл дээр байгаа хүн морио давирахад л тэд хүссэнээ авч болох байлаа.

-Уг нь ингэвэл таарах амьтан л даа гэж мустангер амандаа бувтнаад - Ямар хэрэг өдүүлсний нь бодохоос ч аймшигтай юм. Үеэл дүүгээ алаад толгойгий нь огтолсон байдаг шүү! Ямар ч гэсэн түүний гараар хийгдсэн хэрэг гэхэд эргэлзээлгэ! Харин яагаад ийм хэрэг хийх бослно юм бол? Үүнийг зөвхөн энэ хүн өөрөө л тайлбарлаж чадна... Би тааж ч байна. Тэр түүнд хайртайг би мэднэ, үүнд нь дүү нь саад болсон юм болов уу? Гэвч яаж, яагаад? Энэ бүгдийг зөвхөн энэ хүн л мэднэ гэв.

-Залуу минь чи эндүүрчбайна гэх дуу хажуу талаас гарч,

-Энж бүх асуултыг хариулж чадах хүн байна. Өвгөн Зеб Стумп тус болно. Харин одоо энэ тухай ярих цаг биш, ярьж ч байх газар биш. Бид үүнийг царсны дэргэд аваачих хэрэгтэй. Тэнд зохих шангаа хүртэнэ. Уг нь энэ өөдгүй новшийг бугуйлын үзүүрт л чирэхэд таарахбайсан юм! Энэ маань зүгээр л хэлсэн үг шүү дээ. Генри Пойндекстерын өшөөг бид хоёр аваад яахав. Үүнийг шүүх л мэдэх хэрэг гэж бодож байна гэв.

-Харин бид үүнийг яаж аваачих вэ? Морь нь хэдийн давхиад явчихсан.

-Мистер Жеральдаа, тун амархан. Энэ чинь зөвхөн ухаан балартсан төдий юм. Эсвэл сайнэр баашилж ч байж магад. Хэрэв тэнд явган очиж чадахгүй бол мориор яваг. Миний гүү түүнийг хүргэчихнэ. БИ морин дээр бүүр залхлаа. Бам муу гүүгээ нэлээн залхаачих шиг боллоо. Хэрэв цаадхи чинь тэнэглэхээ зогсохгүй аятайхан суухаа мэдэхгүй байвал түүнийг морин дээр бугын мах шиг тэгнэчихнэ... Байзаа! Цаадах чинь ухаан оржбайх шиг байна. Босоорой найзаа! Гэж Зеб Колхауны заамнаас шүүрэн авч тугтраад

-Таныг бос гэж байна, явцгаая! Таныг хүлээж байна. хэн нэг хүн тантай ярилцахыг хүсч байна.

-Хэн? Хаана? Гэж баривчлагдсан хүн ухаан орсон боловч учрыг ойлгохгүй байдалтай асуугаад, Хэн надтай ярих гээ вэ? гэв.

-Юуны өмнө би ярихгэсэн юм.

-Өө! Энэ чинь Зеб Стумп та юу? Тэгээд өөр...

-Мустангер Морис Жеральд энэ байна. Та түүнтэй урьд нь уулзсан байхаа. Тэр хүн бас л тантай ярилцахыг хүсч байна. Түүнээс гадна цайзын тэнд олон хүн таныг хүлээж байгаа. Тэгэхээр та шавалхан босч, хамт явсан чинь дээр.

Колхаун алгуурхан босов. Түүний гар бугуйлд чанга хүлэгджээ.

-Миний морь хаана байна? гэж тэр тал тал тийш харж хашгирлаа.

-Хаашаа арилсныг чөтгөр бүү мэв. Рио-Гранд тий, гэр рүүгээ буцсан байж магадгүй. Та тэгж их тамласна хойно, хөөрхий амьтан таны солио хийснийг харааж зүхээд, жаахан амсхийхээр төрөлх бэлчээр рүүгээ зугтсан байлгүй.

Колхаун анч өвгөн рүү гайхан харав. Солио гэнээ? Энэ өвгөн түүнийг хүртэл мэджээ?

-За, шүүхийг хүлээлгээд тусгүй. Та бэлэн болов уу? эгж Зеб тэсгэл алдан хэлэв.

-Юунд?

-Нэгдүгээрт мистер Жеральд бид хоёртой хамт буцахад, хоёрдугаарт хамгийн чухал нь шүүхэд очиход

-Шүүх гэнэ ээ? Би шүүхэд очиххэрэгтэй юм уу?

-Тиймээ, мистер Кассийн Колхаун.

-Ямар гэм хийлээ гэж тэр вэ?

-Та өөрийн үеэл дүү Генри Пойндекстерыг алсан хэрэгт яллагдана.

-Энэ бол худлаа! Өөдгүй гүтгэлэг! Түүнийг зүрхэлж хэлсэн хүн бол ёстой нэг... гүтгэлэг шүү!

-Дуугаа тат! Гэж Зеб захирангуйгаар зандраад - Юм ярьж, өөрийгөө битгий зовоо. ХэрэвЗеб Стумп эндүүрээгүй бол танд их юм ярих цаг ирнэ. За, одоо явъя. Шүүх хүлээж байгаа. Тангарагтан нар болоод бас бусад хүмүүс хүлээж байна.

-Би буцахгүй! гэж Колхаун хэгжүүрхэн хариулаад - Надад тушаах эрхийг танд хэн өгсөн юм бэ? Баривчлах эрх танд байна уу? гэхэд нь

-Байлгүй яахав! гэж Зеб үгийн таслан хэлээд - Энэ байна гээд анч өвгөн буунаасаа барьж үгээ үргэлжлүүлэн - Та үүнийг харж байна уу? Тэгэхээр амаа хамхисан чинь дээр. ЯРиаг чинь чагнаж боллоо. Миний гүүг унаад, томоотой явж үз. Эс тэгвэл таныг морин дээр ердийн ачаа шиг даруулахад хүрнэ. Тэглээ яалаа ч та буцаж таарна.

Колхаун хариу хэлсэнгүй. Тэр цөхөрсөн байдаотай нэг үе Зеб Стумп руу, нэг үе Жеральд руу, нэг үе эргэн тойрныг хараад сюртукныхээ халааснаас цухуйж байгаа хоёр дахь гар буу руугаа хялсхийв. Эхнийхий нь бугуйлдахдаа гараасаа алджээ. Буугаа авахыг сэм оролдсон боловч бугуйл саад болохын зэрэгцээгээр өөр рүү нь бууны ам чиглүүлсэн өвгөн Зебсаад болж байв.

-Хөдөлж үзээрэй! Мистер Колхаун моринд мордож үз! Таныг хөгшин гүү

хүлээж байна. Би таныг морд гэж байна шүү! гэв.

Ахмад өвгөний тушаалыг тоглоомон хүн шиг л үг дуугүй дагаж, моринд мордов. Жаахан л эсэргүүцвэл гарцаагүй үхнэ гэдгээ ойлгож байв.

Зеб Стумп гүүний зуузайнаас хөтлөн явлаа.

Мустангер хойноос нь санаашран явна. Тэр барьсан хүнийхээ тухай бодсонгүй, харин сайхан сэтгэл юугаа ч хайрлахгүй байснаараа, зөвхөн үхэл л тас татаж чадах алтан гинжээр зүрхий нь баринтагласан тэр бүсгүйг бодож явав.

ХСІХ. Хоёр буудалт

Шүүх түрүүчийнхээсээ арай бага хугацаагаар хоёр дахь удаагаа гэнэт тасалдсан хуралдаанаа том царс модны дор дахин үргэлжлүүлэв.

Орой болжээ. Жаргаж байгаа нарны гэрэл бүдэг гийгүүлнэ.

Морис Жеральдыг тал бүрээс жигшин ширтэхээ больжээ. Тэрээр бүрмөсөн цагаадан одоо зөвхөн үзэгч болжээ. Хэрэгтний байрыг Кассий Колхаун эзлэв. Цор ганц өөрчлөлт л энэ байлаа. Өнөө л шүүгч, өнөө л тангарагтан нар, өнөө л цугларсан хмүүс байв. Ялгаа нь зөвхөн хэрэгтэн хүнтэй харьцах тэдний харьцаанд оршиж байв.

Түүний гэм буруутай гэдэг нь эргэлзээгүй болжээ. Бүх гэрч баримт илэрхий байв. Хэдийгээр баримтын ихэнх нь шууд бус боловч хүн алсан тухай асуудлыг шийдэхэд зөвхөн ганц цагираг дутуу тасрашгүй гинж болж ирнэ. Юу Кассий Колхауныг хүн алахад хүргэж дара нь толгойгий нь огтлоход хүргэв?

Жеральдын мэдүүлэг хүүрийг шинжлэхэд үнэн нь батлагдав. Цайзын эмч сумын шархнаас болж үхсэний нь дараа толгойг нь огтолсныг тогтоожээ.

Кассий Колхаун яагаад үеэл дүүгээ алав? Яагаад толгойг нь огтлов? Энэ асуултад алуурчаас өөр хэн ч хариулж чадахгүй.

Гэвч алуурч төдөлгүй зохих шангаа авав. Тангарагтан нар “буруутай” гэж тогтжээ. Тэгээд шүүгч дуулган малгайгааавч тогтоолыг сонсохоор үхлийн гунигт тэмдэг болох хар малгай өмсгөхөөр зэхэв.

Ёсыг даган хэрэгтнээр эцсийн үг хэлүүлэх боллоо.

Тэр сочин давхийлээ. Эцсийн үг хэлүүлнэ гэсэн нь түүнд үхлийн дуудлага мэт сонсогджээ. Эргэн тойрныг зэрлэгээр харна. Харцанд нь цөрөхсний шинж илэрхий. Хүн болгоны царай ширүүн, ямар ч өрөвдөж хайрласны шинж алгаажээ.

Түүнийг эцсийн мөч хүртэл дэмжиж байсан хань хамсаатан, хахууль авсан луйварчин нар нь одоо түүнд ямраар ч тумалж чадахаасаа өнгөрчээ. Тэд өрөвдлөө ч ашиггүй. хэдийгээр язгууртай, хөрөнгө чинээлэг боловч ор ганцаарджээ. Түүд найз нөхөд, талтай хүн гэж байсангүй. Алуурчийн тавилан ийм байдаг ажээ.

Тэд хуулийн ёсонд дарагдсан, хаашаа ч гарахын аргагүй гэмт хэрэгтнийг яаж чадах юм билээ.

Түүний нүүр эрс хувиран нөгөө дээрэнгүй бардам зангийх нь оронд аймхай, хулчгар байдал үзэгдэнэ. Үүнд гайхах юм юу байна? Тэр найдваргүй байдалд орж, авсны аман дээр очсоноо, дэндүү аймар үхэл гээчийн өмнө тулснаа мэдэрчээ.

Гэтэл ямар нэг санаа төрөв бололтой гөлөрсөн нүд нь дахин сэргэлээ. Ямар нэг үнэнээ хэлэх гээд байгаа хүний байдалтай болов. Буруугаа хүлээх гээ юм болов уу? Сэтгэлийн дармт болж

байгаа зүйлээ хэлж амрах гээ юу?

Санааг нь таамагласан хүмүүс амьсгал даран зогсоно. Тэр ч байтугай царцаа дэвхрэг хүртэл чимээгүй болсон шигсанагдана. Шүүгчийн дуу гарч чимээ аниргүй байдал эвдэгдлээ.

-Яллагдах ялаасаа хэлтрэхийн тул биеэ цагаатган хэлэх юу байна? гэлээ.

-Юу ч алга. Надад хэлэх юм алга. Шударга шийтгэл байна. Би алах ялыг хүлээнэ гэж хариуллаа.

Тэнд байсан хүмүүс сэтгэл үймрүүлсэн явдлаар дүүрэн бүхэл өдрийн турш одоогийнх шиг ингэж гайхсангүй. Хэрэгтнийдуу чимээгүйн дунд дахин гарлаа. НҮүглээ наманчилах нь гэж бүг хүлээв.

-Генри Пойндекстерыг ширэнгэн дотор буудаж алсан минь туйлын үнэн... гэв.

Хариуд нь дургүйцсэнээсээ илүү айсан дуу тарав. Бас түүний зэрэгцээгээр харамсан гаслах дуу гарсныг алагдсан залуугийн эцгийн нь дуу гэж цөм таньжээ.

Энэ дуу намдсаны дараа хэн чяллагдагчийн ярианд саад болсонгүй.

- Би үхэх ёстой гэдгээ мэдэж байна гэж Колхаун албаар хааш яаш царай гарган хэлээд - таны шийдвэр ч тийм юм. Шүүгч таны царайгаар харвал шийдвэрээ өөрчлөх санаа алга.Намайг үнэний хэлсний дараа өршөөнөө гэж найдах нь утгагүй юм болохсон биз. Би муу хүн байсан болоод ч эргэлзээгүйхатуу шийтгэл хүлээлээ. Гэвч ямар ч байсан би та нарын бодож бхйгаа шиг хорлонтой амьтан биш. Амьдралаас салахдаа ах дүүгээ алсан гэдэг шившгийн тамгатай салахыг хүсэхгүй байна. Тэр миний гарт үрэгдсэн нь үнэн. Намайг юу ийм гэмт хэрэг рүү түлхэв ээ гэж та нар асуух байх. Надад түүнийг алах ямар ч учир байгаагүй.

Үзэгчид дахин үймэлдэн гайхаж, шохоорхон тээнэгэлзэнэ. Гэвч нэг нь дуугарсангүй, хэрэгтний ярианд хэн ч саад хийсэнгүй.

-Та нар гайхаж байна уу? Тайлбарлахад амархан Би түүнийг андуурч алсан юм.

Цугларагсдын дунд гайхсан дуу гарсан боловч Колхауныг үгээ үргэлжлүүлэхэд дахин чив чимээгүй болов.

-Тиймээ, андуурсан юм. Би тэгж андуурснаа мэдээд ямар байдалтай болсноо гаргаж хэлэхэд хэцүү байна. Би андуурснаа хожим мэдсэн юм... Гээд яллуулагч хувь тавилангаа хөнгөлж магадгүй гэж найдан хараагаа дээшлүүлэв. Гэвч хүмүүсийн догшин ширүүн царайд энэрсэн тэмдэг үзсэнгүй.

-Би нэг хүнийг алахыг хүсч байснаа мэлзэхгүй гэж Колхаун хэлээд - Түүний нэрийг чнуухгүй. Энэ байна. Энд миний өмнө зогсч байгаа энэ новш шүү! гэв.

Колхаун Морис Жеральдыг үзэн ядсан харцаар харав. Цаадах нь өөдөөс нь маш тайван бөгөөд огт хайхрамжгүйгээр харна.

-Тиймээ, би үүнийг алах гэсэн юм! Надад үүнийг алах үндэс байсан бөгөөд би тэр тухай ярихгүй. Одоо яриад ч ашиггүй. Би үүнийг алчихлаа гэж бодсон юм. Энэ ирланд нохой үеэл дүүтэй минь малгай, цуваа сольсныг би яаж мэдэх вэ. Бусад нь та нарт тодорхой. Би дайснаа харваад нөхрөө оножээ. Нүгэлтэй мэргэн буудсан бололтой. Хөөрхий Генри мориноос нам ойчсон юм. Тэгээд би улам итгэлтэй болгохын тул хутгаа сугалаад толгойгий нь огтлов. Баларсан муу серапе нь бас намайг хуурчихжээ...

Үзэгчид айсандаа татвасхийн зохих шангий нь өгөхийг шаардан орилолдож дургүйцэн гүнгэнэлдэв.

Одоо хүн амины хэргийн талаар яагаад алах болсон нь ч тодорхой болж Колхаун аймшигт гэмт хэргээ дэлгэрэнгүй тайлбарлаад байх шаардлагагүй боллоо.

-Харин одоо гэж Колхаун хүмүүсийн шуугиан жаал намдахаар хашгираад

-Юу болж өнгөрснийг цөмий нь та нар мэдэж авлаа. гэвч юу болж төгсөх нь та нарт тодорхойгүй байна! Намайг авсны аман дээр зогсч байгаагий минь та нар харж байна. гэвч түүнийг дагуулахаас нааш би тийшээ чинь орохгүй шүү! гэв. Колхауны амьдралдаа хамгийн сүүлчийн удаа хэлж байгаа энэ үгийн утгыг ойлгоход хэцүү бишбайв. дараА нь болсон явдал бүгдийг тайлбарлаад өгөв...

Колхаун үг хэлж байхдаа баруун гараа сюртукныхаа зүүн энгэрт шургуулсан байна. Үгээ дуусгангуугаа гар буугаа шүүрэн авлаа.

Нарны туяанд гялалзах гар буугий нь хүмүүс сайн ажиглаж амжаагүй байтал, хоёр удаа буун дуу гарав.

Хоёр хүн түрүүлгээ харан ойчив. Толгойгоороо бие биеэбараг шүргэн алдаж хөдөлгүй хэвтэнэ. Тэдний нэг нь мустангер Морис Жеральд, нөгөө нь морир цэргийн огцорсон ахмад Кассий Колхаун байв.

Хүмүүс тэднийг тойрон хүрээлж хоёлуаа үхчихлээ гэж бодож байв. Хачин чимээ аниргүйн дунд эмэгтэй хүний зүрх шимшрэм дуу, зүрх нь хагарчихав уу даа гэмээр гаслантайгаар хадлаа.

С. Баяр хөөр

Баяр хөөр!

Тиймээ, яг ийм мэдрэхүйг Луиза, царс модны сүүдэрт, амиа хорлосон хэрэг болж хүн алах нь бүтээгүй, хайртай хүн нь амьд байгааг мэдэнгүүтээ амслаа.

Сүүлийн хэд хоногнийн эмгэнэлт явдлаас болж зүрх сэтгэлий нь шимшрүүлсэн уйтгар гуниг хүртэл баяр баясгаланг нь дарж чадсангүй.

Ингэлээ гэж залуу хүүхнийг хэн буруушаахвэ? Би л лав чадахгүй. Хэрэв чин үнэнээсээ гэвэл та ч бас буруушаахгүй бизээ.

Алуурчийн гар чичирсэнгүй, барьсандаа бууджээ. Үүндээ тэр итгэлтэй байсан бөгөөд ийм биш байсан бол өөрийн чамархайд буугаа тулган гох дарахгүй байлаа. Тэр Морисын зүрхэнд шагайсан бөгөөд хэрэв Луизагийн бэлэг болгон өгсөн гуунд тусаагүйсэн бол шууд зүрхэнд нь тусах байжээ. Зүрхэн талдаа нандигнасан сайхь чамин эд эзнийхээ аминд оржээ.

Өвчнийхөө дараа сайн тэнхрээгүй байсан Морис Жеральдын хувьд эл буудалт уршиггүй өнгөрсөнгүй. Цочирсондоо болоод тархи толгой нь дахин эвгүйрхэж элий балай болж эхэлжээ. Гэвч одоо өвчтэй хүн цусанд улангассан чоно, эргэн тойронд нь нөмрөг тас дээгүүр нь эргэлдсэнширэнгэнд ч биш, овоохойд ч биш арчилгаа сувилгаа байхгүй шоронд ч хэвтэж байгаа биш ажээ.

Ухаан ороод харвал, нойрон дотор нь үзэгдээд байсан хөөрхөн царай хий үзэгдэл бус, түүний дурлалт хүүхэн Луиза Пойндекстер болохыг харжээ.

Одоо өвчтэй хүнийг сувилахад нь хэн ч саад хийсэнгүй.

Эцэг нь хүртэл саад болсонгүй.

Үзсэн зовлон гамшиг нь өвгөн эзний хуурамч бардам занг нуга даржээ. Тэр хүн охиноо Морис Жеральдтай суухад татгалзахаа хэдийн больсон бөгөөд үнэний нь хэлэхэд татгалзах ч юм байсангүй. Түүний хүргэн болох хүн нь жирийн нэг нэр алдаргүй морины ангуучин биш, харин ирландын бээл Морис Жеральд болжээ.

Техаст цол хэргэмийг хэн ч хайхардаггүйгээс гадна Морис өөрөө нэг их тоосонгүй. Гэлээ ч тэр нь ирландын бээлтэн нарт тэр бүр олддоггүй их хөрөнгийг залгамжилсан эзэн болсон бөгөөд цагтаа Вудли Пойндекстер өөрийн зээ Кассийн Колхаунд барьцаанд өгчихсөн эдлэнг худалдаж аваад цаана нь илүү гарахаар хөрөнгөтэй болжээ.

Кассий Колхаун хэдийнээ гэрлэсэн хүн байсан нь мэдэгдсэн агаад хөрөнгө нь Шинэ Орлеанд байдаг хүүд нь шилжжээ.

Луиза Морис Жеральд хоёр хуримаа хийсний дараа Европоор жуулчлав. Тэд Морисын төрсөн нутагт очжээ. Гэвч Техаст Касса-Дель-Корво шилтгээндээ эгэн иржээ.

Ирланд залуугийн төлөө санаашран суудан цэнхэр нүдтэй үзэсгэлэн гоо охин бол Фшлимийн уран санааны үр байжээ. Эсвэл энэ нь салж холдсоны дараа мартагддаг залуу насны сонирхол ч байсан байж болно. Ямар ч байлаа гэсэн Ирландад байх үед Морис Жеральдын залуу гэргийд хардах сэтгэл нэг ч удаа төрсөнгүй.

Зөвхөн ганц удаа л эл шаналгаат хардлага дахин дүрсхийсэн боловч даанч түргэн ор мөргүй замхарчээ. Энэ нь нөхөр нь нэг өдөр үзэсгэлэнт сайхан хүүхэн гар дээрээ тэврээд хүрч иржээ. Тэр хүүхний цээжний шархнаас цус гожгодож байв. хэдийгээр бүсгүй амьд байсан боловч тоотой хэдхэн минут үлджээ. “Хэн ингэчихэв?” гэсэн асуултад бүсгүй зөвхөн “Диас, Диас!” гэж хариуж амжив.

Энэ бол Исидора Коварубио де Лос-Льяносын сүүлчийн үг байлаа.

Исидорын үхэлтэй хамт Луизагийн хардлага ч үхлээ. Тийм явлал түүний сэтгэлийг дахин хэзээ чүймүүлсэнгүй.

Хардлага нь хувь заяагүй бүсгүйг өрөвдөж хамгаалах сэтгэлээр солигджээ. Залуу креол хүүхэн эр нөхрийнхөө хээр мутсангийг эмээллэлцэж өгөөд өөрөө түүнийг алуурчийн араас явуулав. Нөхрий нь бугуйлын гогцоонд Диас хүлүүлчихсэн буцаж ирэхийг хараад Луизагийн бах нь ханажээ.

Гэнэт дуудагдан цугларсан “журам сахиулагчид” түүнийг дорхон ньмодноос дүүжлэхэд өмөөрсөнгүй. Энэ хатуу сэтгэл гэж үү?

Үгүй, энэ бол “Хорыг хороор, өсийг өсөөр” гэдэг балар эртний шударга ёсны хэлбэр юм.

Арван жил өнгөрөв. Энэ хоорнд Техаст, ялангуяа Леон болоод Нуэсесийн сав газрын сууринд их өөрчлөлт гарчээ. Урьд нь нэвтэршгүй балар шугуй байсан газарт тариалангийнгазрууд бий болжээ. Хэзээ нэгэн цагт мустангийн сүрэг бэлчиж байсан зэрлэг тал нутагт хотууд байгуулагджээ.

Одоо та шинэ шинэ хүмүүс, нутаг суурины байгаагүй нэрийг сонсоно.

Харин хуучин Каса-Дель-Корво ордон урьдынхаа нэрийг хадгалсаар байна. Та тэнд хуучин танилуудаа олж уулзана.

Ордны эзэн нь Техасын хамгийн сайхан харчуулын нэгбөгөөд түүний гэргий нь тэр нутгийн хамгийн үзэсгэлэн гоо хүүхнүүдийн нэг юм Аль аль нь залуугаараа ажээ.

Та тэнд язгууртан байрын, буурал үстэй эелдэг яриа хөөрөөтэй өвгөнтэй дайралдах вий. Тэр таныг малын хашаандаа дагуулан очиж, сүргээ үзүүлэн эдлэн газрын бэлчээрт идшилж байгаа адуун сүргийнхээ тухай бахархан ярьж өгнө.

Гэвч тэрхүн, бүгдээс илүү шилтгээний эзэгтэй охиндоо, түүнд наалдаж өвөө гэж дууддаг зургаан балчир амьтнаар бахархана.

Та хэрэв морины хашаа руу шагайж харвал тэнд хуучин танил О Нилийгээ үзнэ. Тэр Каса-Дель-Корвын ахлах адуучны алба түшнэ. Та бас энд хар арьст Плутонтой уулзаж болно. Тэр, одоо зөвхөн хөтчийн үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд сүүх тэрэгний суудал дээр гарч, жолоо барихаас өмнө морь руу харахыг зөвшөөрөх ньховор.

Плутоны эхнэр нь уншигчдын мэдэх Флоринда юм.

Каса -Дель-Корвын хоолны ширээний ард бас нэг танил анчин өвгөн Зеб Стумпын нэрийг сонсоно. Хоолны ширээн дээр зэрлэг цацагт хяруул эсвэл бугын шарсан мах тавимагц энэ бол түүний ангийн хишиг гэж заавал хэлнэ. Ялангуяа үдийн хоол ч юмуу, ширээн дээр дарс тавих үед түүний тухай эцэс төгсгөлгүй яриа хөөрөө эхэлнэ.

Үнэндээ та тэнд Зеб Стумптэй өөртэй нь ховор дайралдана. Тэр хүн ордны хамаг хүнийг орноосоо босоогүй байхад яваад тэднийг унтсан хойно буву унтахаар хэвтсэний дараа эргэж ирдэг ажээ. Гэвч зооринд харагдах том цацагт хяруул ч юмуу, ерөөл бугын мах түүний энд байдгийг гэрчилнэ.

Та Каса-Дель-Корвод байхдаа бараг домог болохоо шахсан битүүлэг түүхийн зах сэжүүрийг лав сонсоно.

Зарц нар тэр түүхийг танд эхнээс нь аваад дуустал цөмий нь ярьж өгөхөөс буцахгүй. Тэгэхдээ зөвхөн шивэгнэн ярина. Түүнийг шилтгээн дотор ярихы нь хориглосон бөгөөд тэр нь шилтгээний эздэд гунигтай дурсамжийг төрүүлдэг ажээ.

Энэ бол морь унасан толгойгүй хүний тухай тууж юм.

Өмнөх үг

Манай нийт уншигчид ялангуяа хүүхэд залуучуудийн унших дуртай номын дотроос адал явдалд, аялал жуулчлалын ном зохиолд томоохон суурь эзэлдэг.

Иймээс ч дээрх сэдвээр гайхамшигт бүтээл туурвисан Даниэл Дефо, Фенимор Купер, Жюль Верний нэрийн хажууд өөрийг “ахмад Майн Рид” хэмээн нэрлэх дуртай английн бичгийн хүн Томас Майн Ридийн нэр ямагт хамт явдаг билээ.

Түүний бүтээлийн дотор гарч байгаа үнэн мөний төлөө авхаалж самбаатайгаар, замд тохиолдох элдэв саад бэрхшээлийг эр зоригийн хүчээр туулж байгаа, юунаас ч буцаж шантардаггүй баатруудыг нь уншигчид хайрлан хүндэлж байдаг нь зүйн хэрэг юм. Худал хуурмаг, атаа хорслыг үнэн цагаан сэтгэл, эр зоригоороо ялан дийлдэг зохиолын баатарт дургүйуншигч хаана ч байхгүй билээ.

Зохиолч Томас Майн Рид 1818 онд Ирландийн санваартны гэрт төржээ. Эцэг нь хүүгээ лам болгохы хүссэн боловч угийн сүжиггүй хүү нь эцэгтэйгээ түнжин хагарч, сэтгэлд нь тохирсон ажлаа өөрөө олохоор шийдсэн ирээдүйн зохиолч 1840 онд төрсөн нутгаа орхин, Америкийг зорьжээ. Түүний эх орон Ирланд нь аль хэдийнээс английн эзмшил гэгдэх болсон боловч, ирландууд тэмцлээ зогссонгүй, хэдийгээр олон хүн төрсөн арлаа аргагүйдэн эгнэгт орхин гадаад гарлаа ч гэсэн, английн дарлалын эсрэг тэмцэж байгаа нууц байгууллагад туслахаар амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл эх оронч хэвээр үлддэг байлаа.

Залуу эр ч нутгаа орхин гарахдаа дарлал мөлжлөгийг үзэн ядаж, түүний эсрэг тэмцэнбоссон хүмүүсийг зүрх сэтгэлдээ хайрлан хүндэлж явжээ. тэгээд 1840 оны нэгдүгээр сард Өмнөдийн газар тариалангийн төв болсон “Шинэ Орлеанд” буужээ. тэр нь есөн шидийн амьтан бужигнасан хөлтэй хот байлаа. залуу эр өл залгахын тулд хөвөнгийн тариаланд ажиллаж, жүжигчин, багш зэрэг ажил хийн, Өмнөд мужууд болсон Мексикээр аялан тэнүүчилж, аглаг тал нутаг, гол мөрнөөр аялж явахдаа хар арьст боол, аглаг хээрийн анчин, Америкт толгой хоргодсон мексикийн улс төрийн дүрвэгсэд, ахуй нөхцөлийнхөө төлөө уулгалан дайрах индиан нар гээд зүсэн зүйлийн хүн амьтантай нүүр учран явсан нь, амьдралын энэ хүү баялаг сэтгэгдэл нь түүний хожмын бүтээлийн барагдашгүй эх булаг болжээ.

1843 оноос Филадельфид суурьшин юм бичиж эхлэн сурважлагч болж, удалгүй сайн сэтгүүлчийн тоонд оржээ. энэ үед нв АНУ- Мексикийн дайн үүсэж залуу ирланд эр цэргийн сурваолжлагчаар явжээ. АНУ-ын засгийн газар Мексикийг уулгалан дайрсан дээрмийн ажиллагаагаа түүний ард түмниг хамгаалсан зорилготой гэж итгүүлэхийг оролдон олон яч хүн тэр хуурамч уриалгад нь итгэж байжээ. Дайн АНУ-ын ялалтаар дусаж Майн Рид ахмад цолтой буцаж иржээ.

1848 онд Европын хувьсгал тэр үеийн тэргүүний хүмүүст Еуропыш ард түмнийг дарла, мөлжлөгөөс чөлөөлж, түүний жишээг бусад улс түмэн ч даган хүн төрлөхтний түүхэнд шинэ эрин үеийг нээх юм гэдэгт итгэж байсан бөгөөд майн Рид ч энэ санааг хуваалцаж байлаа. 1849 онд хэсэг нөхдийн хамт Европийг зүглэн Англид ирсэн боловч хувьсгалын хувь заяа нэгэнт шийдэгдэн дарагдчихсан байлаа. ийнхүү Майн Рид эрх чөлөөний армийн ахмад болж

хувьсгалт үйл явдалд оролцон, өнө удаан амь бөхтэй зууралдсан феодалын байгууллагын үлдэгдлийг Европт устган дарна гэсэн хүсэл нь биелэгдсэнгүй.

1850 оноос Лондонд суурьшив, Учир нь 1848 оны хувьсгалд оролцож байсан олон хүн тэнд амьдарч байсан бөгөөд ихэнх нь найдлагаа хараахан алдаагүй, хувьсгал дахин Европын аль нэг өнцөгт дүрэлзэнэ гэдэгт итгэн, хэрэгтэй үед нь тусалж болох юм гэж найдаж байжээ. Майн Рид ч оросын хааны эсрэг тэмцэлд хүч цуглуулж байсан польшийн хувьсгалчдад туслан, английн ард түмнийг хуурч байгаа “Британий нууц дипломат бодлогыг” хэволэлээр шүүмжлж байлаа. Энэ үеэс мөн зохиолчийн мэргэжлийн ажил болох уран бүтээлээ туурвиж эхэлжээ. Ахны зохиолууд болох “Чөлөөтэй сум”, “Хуйхын ангууч”, “Цагаан удирдагч”, “Квартирон бүсгүй”, “Оцелло баатар,” “Маронууд” нь хэвлэгдэв.

Майн Ридийн зохиолуудын даруу, зоригтой ыаатрууд нь янз бүрийн аюулаар дүүрэн амьдралын хүнд замыг туулан үнэн мөнийн төлөө, хүнч ёсны төлөө тэмцэлдээ үнэнчээр үлддэг нь уншигчдын зүрх сэтгэлийг татан байдаг билээ. тэд элдэв өөдгүй амьтдын хорон санаад өртөхөөс гадна байгалийн гай гамшиг, махчин араатны дайралтанд өртөн сайн нөхөр нохой ч юмуу морины тусламжаар аулаас мултран, дайснуудаа үнэнч шудрагаар ялан дийлж байдаг.

Майн Рид ямагт нийгмийн асуудлыг хөндөн, хар арьстан боолыг чөлөөлөхийн төлөө, цагаан арьстандарлуулж байгаа индиан омгийг хамгаалагч, мөлжүүлж буй мексик, италийн тариачин, францын ажилчдыг талархахгч байлаа.

Зохиолчийн шилдэг бүтээлийн нэгц болох “Морь унасан толгойгүй хүн”ийг 1956 онд анх Д. Лодойдамбын орчуулгаар хэвлэсэн бөгөөд, эл ном одоо ховордсон учир бид уг зохиолыг дахин засаж орчуулан гаргаж байна.

ХЭВЛЭЛИЙН ГАЗАР.

Эх сурвалж

Хөрвүүлсэн phiqstas

И-мэйл: phiqstas@gmail.com

Блог: kindlemn.blogspot.com

Эх үүсвэр: <http://on-toli.com/modules/zohiol/viewcat.php?cid=73>